ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (238)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай*
- *Конвенцид нэгдэн орох тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсад 2000-2004 онд оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Дүрэм батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны нэгдүгээр сарын 4 №1 (2

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Нягтлан бодох бүртгэлийн тухай	(2001-12-13-ны хууль)	1
2.	Конвенцид нэгдэн орох тухай	(2001-12-14-ний хууль)	7
3.	Конвенцид нэгдэн орох тухай	(2001-12-14-ний хууль)	7
4.	Конвенцид нэгдэн орох тухай	(2001-12-14-ний хууль)	7
5.	Конвенцид нэгдэн орох тухай	(2001-12-14-ний хууль)	7
6.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	(2001-12-14-ний хууль)	8
7.	Конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах тухай	(2001-12-14-ний хууль)	8
8.	Гэрээ соёрхон батлах тухай	(2001-12-20-ны хууль)	8
9.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2001-12-27-ны хууль)	8
10.	Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2001-12-28-ны хууль)	9

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

11.	Монгол Улсад 2000-2004 онд оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай	Дугаар 96	9
12.	Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 99	9

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

13.	Дүрэм батлах тухай	Дугаар 263	10

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

14.	Захиргааны хариуцлагын тухай хууль, захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 02	29

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хуль тогтоомж

2.1. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хуль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн сэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх ургыг;

3.1.2. "нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь" гэж мөнгө хүлээн авсан буюу төлсөн ед орлого болон зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх ургыг;

3.1.3. "давхар бичилт" гэж ажил үйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт ийхийг;

3.1.4. "анхан шатны баримт" гэж ажил үйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн олон бусад нотолгоог ;

3.1.5. "журнал" гэж ажил үйлгээг эрэнхий дэвтрийн дансанд шилжүүлэхийн өмнө цаг угацааны дараалаар нь эхэлж бүртэх бичилтийг;

3.1.6. "ерөнхий дэвтэр" гэж аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг бүрдүүлж байгаа дансыг;

3.1.7. "мэргэжлийн нягтлан бодогч" гэж их сургууль, коллежийг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн хүнийг;

3.1.8. "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг.

4 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим

4.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд дараахь зарчмыг баримтална:

4.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх;

4.1.2. санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;

4.1.3. бүртгэл, тайлангийн үзүүлэлт энгийн, тодорхой, ойлгомжтой байх;

4.1.4. бүртгэл, тайлангийн тоо, мэдээг аргачлалын хувьд өнгөрсөн, ирээдүйн тоо, мэдээтэй зэрэгцүүлж болохоор зохиох;

4.1.5. удирдлагын болон зардлын бүртгэлд өөрийн онцлогт тохирсон оновчтой сонголт хэрэглэх;

4.1.6. тасралтгүй байх.

5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн суурь

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.

5.2. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд нягтлан бодох бүртгэлийг мөнгөн сууриар хөтөлж болно.

5.3. Нягтлан бодох бүртгэлээ мөнгөн сууриар хөтөлдөг байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа аккруэл суурьт хөрвүүлэн гаргана.

6 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж

6.1. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгжийг Монгол Улсын мөнгөн төмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

7 дугаар зүйл. Анхан шатны баримт

7.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

7.2. Анхан шатны баримтын загвар, аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн газартай хамтран батална.

7.3. Аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо мөрдөх баримт, маягтыг энэ хуулийн 7.2-т заасан

журамд нийцүүлнэ.

7.4. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.

7.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.

7.6. Анхан шатны баримтыг бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.

8 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

8.2. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлд давхар бичилтийг хэрэглэнэ.

8.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараахь дараалаар гүйцэтгэнэ:

8.3.1. анхан шатны баримт бүрдүүлэх;

8.3.2. журналд бичих ;

8.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;

8.3.4. ажил гүйлгээний мэдээ гаргах ;

8.3.5. тайлан гаргах.

8.4. Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд гарсан алдааг залруулахдаа холбогдох баримт материалыг үндэслэн зөв үзүүлэлтийг бичсэн нэмэлт баримт бүрдүүлэн, залруулга хийсэн болон зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.5. Санхүүгийн тайланд алдаа гарсан тухай аудиторын дүгнэлтийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага зөвшөөрвөл энэ хуулийн 8.4-т заасан журмаар залруулна.

9 дүгээр зүйл. Хөрөнгө, өр төлбөрийг үнэлэх, бүртгэх

9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнг өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсы стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

9.2. Аж ахуйн нэгж, байгууллага гадаа валютаар хийсэн орлого, зарлагыг тухайн ажи гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласа ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлж бүртгэнэ.

9.3. Санхүүгийн тайлан гаргахдаа гадаа валют, түүгээр илэрхийлсэн авлага, өр төлбөрий үлдэгдлийг Монголбанкнаас зарласан, тухай өдрийн ханшийг үндэслэн төгрөгт шилжүүл бүртгэнэ.

9.4. Төрийн өмчит болон төрийн өмчий оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүл дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зэ зээлийн үнийн аль өндөрөөр хийнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн тайлан гаргах ажлын зохион байгуулалт

10 дугаар зүйл. Санхүүгийн тайлангий бүрэлдэхүүн

10.1. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгий тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсы стандартад нийцүүлэн гаргана.

10.2. Санхүүгийн тайлан дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

10.2.1. баланс;

10.2.2. үйл ажиллагааны үр дүнгий тайлан;

10.2.3. өмчийн өөрчлөлтийн тайлан

10.2.4. мөнгөн гүйлгээний тайлан;

10.2.5. шаардлагатай бусад нэмэл тодруулга.

10.3. Аудитаар баталгаажуулсан санхүүгий тайланд аж ахуйн нэгж, байгууллагын үй ажиллагааны үчхал нөлөө үзүүлсэн томоохон үй явдлын тухай тодруулга, тайлбар, аудиторы дүгнэлт, удирдлагын тайланг хавсаргана.

10.4. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгий тайлангаа санхүүгийн жилийн эхнээс өссөн дүнгээр улирал бүр гаргана.

10.5. Санхүүгийн тайланд аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий (ахлах) болон гэрээгээр ажилласа нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга (тэмдэг дарна.

11 дүгээр зүйл. Эд хөрөнгийн тооллого

11.1. Эд хөрөнгийн тооллого хийх зохион
йгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж,
йгуллагын удирдлага хариуцна.

11.2. Эд хөрөнгийн тооллогыг дараахь
иолдолд заавал хийнэ:

11.2.1. жилийн санхүүгийн тайлан
гаргахын өмнө;

11.2.2.эд хөрөнгө хариуцагч болон
хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан
ингидох үед;

11.2.3. эд хөрөнгө дутагдсан, эд
өнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй
с үзсэн үед;

11.2.4. байгалийн гамшиг, гал
ймэр зэрэг гэнэтийн аюулын дараа;

11.2.5. аж ахуйн нэгж, байгууллагыг
эчлэн байгуулсан, татан буулгасан, дампуурсан
с зарласан үед;

11.2.6. хуульд заасан бусад
тохиолдолд.

11.3. Төрийн өмчийн эд хөрөнгийн
эллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
уль, бусад хуульд заасан хугацааны болон
ялшгүй шаардлагатай үед хийнэ.

**12 дугаар зүйл. Санхүүгийн тайланг
шаах**

12.1. Улирлын санхүүгийн тайланг
дитороор шалгуулсан байж болно.

12.2. Харилцагч санхүүгийн байгууллагын
наж хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллагын
нхүүгийн тайланг үндэслэн холбогдох
йгуллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо
йнэ.

12.3. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн
йланг тушаагаагүй бол харилцагч санхүүгийн
йгуллага энэ тухай нийтэд мэдээлнэ.

12.4. Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн
дит хийж баталгаажуулсан жилийн санхүүгийн
йлан болон түүний хураангуйг аудиторын
гнэлтийн хамт хэвлэн нийтэлж, нийтэд тараах
лно.

**13 дугаар зүйл. Тайлангийн жил,
нхүүгийн тайлан тушаах, нэгтгэх хугацаа**

13.1. Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

13.2. Аж ахуйн нэгж, байгууллага улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 20, жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад тушаана.

13.3. Нэгдсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага улирлын тайланг дараа улирлын эхний сарын 25, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад тушаана.

13.4. Аймаг, нийслэлийн санхүүгийн байгууллага харилцагч аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.

14 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн баримт болон тайлангийн хадгалалт

14.1. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архивын тухай хуулийн дагуу хадгална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт

15 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн удирдлагын тогтолцоо

15.1. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар улсын хэмжээнд хангах үүргэтэй.

15.2. Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхтэй:

15.2.1. нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

15.2.2. нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулах;

15.2.3. нийтэр дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журам, заавар, аргачлал, маягт баталж, мөрдүүлэх;

15.2.4. санхүүгийн тайлангийн

мэдээллийн программ хангамжид хяналт тавих;

15.2.5. улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл хийж, судалгаа дүгнэлт гаргах.

15.3. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй, хяналтын асуудлыг эрхлэх газар байна.

15.4. Аймаг, нийслэл, дүүргийн санхүү, бүртгэл, эдийн засгийн алба энэ хуулийн 15.3-т заасан чиг үүргийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлнэ.

15.5. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд нягтлан бодох бүртгэлийн стандартын орон тооны бус хороо /цаашид "хороо" гэх/ байна.

15.6. Хорооны дүрмийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт

16.1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

16.2. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарим стандартыг үндэсний онцлогт тохируулан нэмэлт тодотгол, тайлбар хийж хэрэглэж болно.

17 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт

17.1. Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ.

17.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батална, мөрдөж ажиллана.

17.3. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн нягтлан бодох бүртгэлийн ажлыг мэргэжлийн бүюу мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ.

17.4. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байна.

17.5. Орон тооны нягтлан бодогчгүй аж ахуйн нэгж, байгууллага гэрээний үндсэн дээр нягтлан бодогчоор нягтлан бодох бүртгэл хөтлүүл санхүүгийн тайлан гаргуулж болно.

18 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлий дотоод хяналт

18.1. Нягтлан бодох бүртгэлийн дотоо хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлаг хэрэгжүүлнэ.

18.2. Дотоодын нягтлан бодох бүртгэлий хянан шалгагчийг аж ахуйн нэгж , байгууллагы удирдлага томилж болно.

18.3. Аж ахуйн нэгж, байгууллагы удирдлага нягтлан бодох бүртгэлийн дотоод хянал хариуцсан албан тушаалтны эрх, үүргий тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэртэ тодорхойлно.

19 дүгээр зүйл. Нягтлан бодогчийн эрх үүрэг

19.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтла бодогч нь дараахь эрх, үүрэгтэй байна:

19.1.1. аж ахуйн нэгж, байгууллагы нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгий боловсруулж, батлуулах;

19.1.2. батлагдсан маягт, зааврыг дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагы удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдий цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлы зохион байгуулах;

19.1.3.нягтлан бодох бүртгэлий анхан шатны баримт, холбогдох бусад материалы шаардан гаргуулах;

19.1.4. эд хөрөнгийн тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах;

19.1.5. эд хөрөнгө, өр төлбөрий хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээ бүртгэхгүй байх;

19.1.6. нягтлан бодох бүртгэлий хууль тогтоомжид харшилсан шийдвэрий биелүүлэхээс татгалзах.

19.2. Гэрээгээр үүрэг гүйцэтгэж байгаа нягтлан бодогч энэ хуулийн 19.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

19.3. Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд

энхий (ахлах) нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг на.

19.4. Аж ахуйн нэгж, байгууллагын ирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тоомжид харшлах үйлдэл гүйцэтгэхийг бичгээр ардаж гүйцэтгүүлсэн бол үүнээс үүсэх иуцлагыг нягтлан бодогч хүлээхгүй.

20 дугаар зүйл. Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

20.1. Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд раахь зүйлийг хоригломо:

20.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын тлан бодогч нь албан тушаалаа урвуулан иглах;

20.1.2. өөрийн ажил, үүрэгийн дагуу уд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг эсран гүйцэтгэх;

20.1.3. ажиллаж байгаа болон иллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагынхаа знесийн нууцыг хувийн зорилгоор ашиглах буюу здад мэдээлэх;

20.1.4. хуурамч баримт бүрдүүлэн ил гүйлгээг дансанд бичих;

20.1.5. нягтлан бодох бүртгэлийн римт, данс, санхүүгийн тайланг хууль тогтоомжийг очиж устгах, үрэгдүүлэх, гэмтээх;

20.1.6. энэ хуулийн 8.4-т зааснаас сад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн римт, данс, санхүүгийн тайланг засварлах;

20.1.7. анхан шатны баримт одүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий втэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй йх;

20.1.8. үнэт цаас, түүнтэй адилтгах маягт, баримтыг үрэгдүүлэх.

21 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн сын байцаагч

21.1. Нягтлан бодох бүртгэлийн улийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын өнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын йцаагч байна.

21.2. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий, пах болон улсын байцаагч нь мэргэшсэн нягтлан догч байна.

21.3. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрхийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

21.4. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална.

22 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын нэмэгдэл, урамшуулал

22.1. Мэргэшсэн нягтлан бодогчид сар тутам мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

22.2. Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.

22.3. Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журмыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад

23 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

23.1.1. энэ хуулийн 8.3, 8.4, 20.1-д заасныг зөрчсөн бол бүрүүтай этгээдийг 30000-60000 хүртэл төгрөгөөр торгох;

23.1.2. аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайлан гаргаагүй бол холбогдох албан тушаалтныг 30000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 60000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

23.1.3. санхүүгийн тайлангаа энэ хуулийн 13.2, 13.3, 13.4-т заасан хугацаанд тушаагаагүй албан тушаалтныг 30000-60000 хүртэл төгрөгөөр торгох.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 2002 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас 1974 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Лондон хотноо баталсан Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай Конвенцид нэгдэн орсныг соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас 1974 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Лондон хотноо баталсан Дипломтой далайчдыг бэлтгэх болон зэлжийн ажиллагааны тухай Конвенцид нэгдэн орсныг соёрхо батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас 1972 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Лондон хотноо баталсан Далайд усан онгоцууд мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх Олон улсын дүрмийн тухай Конвенцид нэгдэн орсныг соёрхо батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын далайн байгууллагаас 1973 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Лондон хотноо баталсан Далайг усан онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай Конвенцид нэгдэн орсныг соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1 оны 12 дугаар
ын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, д Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын ронд 2001 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Минск ноо гарын үсэг зурсан Орлого ба хөрөнгийн зарыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар өхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1 оны 12 дугаар
ын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс 2000 оны 9 ээр сарын 7-ны өдөр гарын үсэг зурсан Нэгдсэн дэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг аварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай венцийн Нэмэлт Протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

01 оны 12 дугаар
ын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн нкны хооронд 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр, нгол Улс, Нордикийн хөгжлийн сангийн хооронд 01 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр тус тус йгуулсан Нийгмийн хамгаллын салбарын жлийн хөтөлбөр болон Нийгмийн хамгаллын салбарын зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

01 оны 12 дугаар
ын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн дугаар зүйлд "77.3. Нийтээр амрах баярын өдөр, поо хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон хиолдолд долоо хоногийн ажил, амралтын өдрийг гийн газрын шийдвэрээр зохицуулж болно." гэсэн сэг нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хот

ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "нэг төрбум" гэснийг "таван төрбум" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 96 Улаанбаатар хот

Монгол Улсад 2000-2004 онд оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2000-2004 онд оруулж болох цагаач иргэдийн тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тогтоосугай.

2. Монгол Улсад 2000-2004 онд жил бүр оруулж болох цагаач иргэдийн бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

1/ Оросын Холбооны Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

2/ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

3/ бусад орны харьяат иргэн 40-өөс дээшгүй.

3. Монгол Улсад 2000-2004 онд жил б оруулж болох цагаач иргэдийн байршлыг д дурдсанаар тогтоосугай:

1/ Улаанбаатар хотод 50-а дээшгүй;

2/ Дархан-Уул, Орхон, Сэлэн аймагт тус тус 3-аас дээшгүй;

3/ бусад аймагт 2-оос дээшгүй.

/Гэр бүлээрээ ирсэн цагаач иргэдэд тэдни хамт байршуулах үүдээс энэ тогтоолын 3 дэ заалтын 1, 2, 3-т заасан хязгаарлалт хамааруулахгүй байж болно./

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 99 Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоолоор батлсан хавсралтын "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаатай адилтгах албан тушаалы зэрэглэл"-ийн "ТӨ-УА"-ийн тусгай албан тушаа "Сонгуулийн ерөнхий хорооны дарга", "ТӨVIА"-и тусгай албан тушаалд "Сонгуулийн ерөнхий хороо нарийн бичгийн дарга" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

01 оны 12 дугаар
рын 5-ны өдөр

Дугаар 263

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар йлийн 1дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол сын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-г 1дүгээр хавсралт, " Дулааны эрчим хүч хэрэглэх рэм"-ийг 2 дугаар хавсралт, " Эрчим хүчний шугам пжээг хамгаалах дүрэм"-ийг 3 дугаар хавсралт оор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан" рэм, журам батлах тухай" Засгийн газрын 1996 ы 5 дугаар сарын 18-ны өдрийн 120 дугаар тогтоол, "Цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм батлах тухай " Засгийн газрын 1996 оны 6дугаар сарын 26-ны өдрийн 147 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н. ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б. ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрчим хүчний тухай хуулийг рэгжүүлэхэд цахилгаан эрчим хүч дамжуулах, гээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид амжуулагч", "түгээгч", "хангагч" гэх) болон рэглэгчийн харилцааг зохицуулахад энэхүү рмийн зорилго оршино.

2. Энэ дүрэмд хэрэглэсэн дараахь нэр мъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ **<<эзэмшлийн зааг>>** гэж мжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн хилгаан дамжуулах, түгээх сүлжээг өмчлөлийн юу эзэмшлийн харьяаллаар нь хуваан зааглаж йгаа цэгийг;

2/ **<<хэрэглээг тооцох цэг>>** гэж рэглэгчид түгээсэн цахилгаан эрчим хүчний мжээг тодорхойлох зорилгоор цахилгаан мжуулах, түгээх сүлжээнд тооцооны хэмжих рэгслийг холбосон цэгийг;

3/ **<<тооцооны хэмжих хэрэгсэл>>** гэж хэрэглээг тооцох цэг дээр төлбөрийг тооцох зорилгоор тавьсан цахилгааны тоолуур, чадлын хэмжүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгслийг;

4/ **<<хяналтын хэмжих хэрэгсэл>>** гэж тухайн сонгосон цэг дээр хянах зориулалтаар тавьсан цахилгааны тоолуур, чадлын хэмжүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгслийг;

5/ **<<шууд хохирол>>** гэж цахилгаан хангамж тасалдсанаас болон чанарын үзүүлэлт хэлбэлзсэнээс хэрэглэгчид учирсан бүтээгдэхүүний чанарын гологдол, цахилгаан хэрэгслийн гэмтлийг;

6/ **<<цахилгаан тоног төхөөрөмж>>** гэж цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, хувирган өөрчлөх, дамжуулах, хуваарилах, хэрэглэх төхөөрөмжийг;

7/ **<<хэрэглэгчийн холбогдсон чадал>>** гэж цахилгаан шугам сүлжээнд

холбогдсон хэрэглэгчийн нийт трансформатор болон 1000 В (Вольт)-оос дээш хүчдэлийн цахилгаан хөдөлгүүрийн нийлбэр чадлыг буюу 1000 В хүртэл хүчдэлийн сүлжээнээс авах зөвшөөрөгдсөн чадлыг;

8/ <<**захиалсан дээд чадал**>> гэж нэгдсэн сүлжээний оргил ачааллын үеэр хангагчаас хэрэглэгч авахаар тохирсон чадлын дээд хэмжээг;

9/ <<**цахилгааны бие даасан үүсгүүр**>> гэж цахилгаан эрчим хүчний суурин (хангагчийн) үүсгүүрээс хамааралгүйгээр хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр тэжээх боломжтой үүсгүүрийг.

Хоёр. Хэрэглэгчийг цахилгаан сүлжээнд холбох зөвшөөрөл олгох

3. Дамжуулах, түгээх шугам сүлжээнд шинээр холболт хийх, хэрэглэгчийн холбогдсон чадлыг нэмэгдүүлэх шаардлага гарсан тухай бүрт хэрэглэгч техникийн нөхцөл авна.

4. Хэрэглэгч техникийн нөхцөл авах хүсэлтээ харилцагч түгээгчид эсхүл дамжуулагчид гаргана. Уг хүсэлтэд техникийн нөхцөл авах болсон шаардлага, зээмших, ашиглах газрын байршил болон зөвшөөрөл, цахилгаан хэрэглээний хүчин чадал, цахилгаан хангамжийн зэрэглэлийг тусгана.

5. Дамжуулагч, түгээгч нь хэрэглэгчид техникийн нөхцөл олгохдоо Эрчим хүчний зохицуулах газраас батлан холболтын заавруг баримтлан тухайн нутаг дэвсгэрийн көгжлийн хэтийн төлөв, цахилгаан шугам сүлжээний техникийн боломжийг харгалзана.

6. Техникийн нөхцөл олгоход цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын дүрэм болон дараахь, шаардлагыг баримтлна:

1/ дундын өмчлөлийн орон сууцанд үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй бол 1.3 кВт (киловатт) хүртэл чадалтай 3 фазын цахилгаан тоног төхөөрөмжийг давхарын щитнээс холбох;

Хэрэв чадал нь 1.3–10.0 кВт байвал энэ дүрми 6.2–т заасны дагуу шийдвэрлэнэ.

2/ орон сууцны тэжээлийн кабе хэт ачаалагдахаргүй байвал дундын өмчлөли орон сууцны зоорийн болон нэгдүгээр давхарт 1(кВт хүртэл суурилагдсан нийлбэр хүчин чадалт 3 фазын цахилгаан тоног төхөөрөмжийг тухайн ор сууцны ерөнхий щитний өрөөнд суурилуулана

Хэрэв суурилагдсан нийлбэр хүчин чад нь 10.0 кВт –аас дээш эсхүл 10.0 кВт -аас ба боловч тэжээлийн кабель хэт ачаалагдаха байвал ойролцоох трансформаторын д: өртөөнөөс шугам татаж холбоно.

3/ хэрэглэгчийг 0.4 кВ (киловольт хүчдэлийн шугамнаас холбоход уг шугамын бүх дэд өртөөний трансформаторын чадал хүрэлцэхгүй тохиолдолд тухайн шугам трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх: шаардлагатай зардал (үнийн зөрүү, холбогдо үйлчилгээний төлбөр)-ыг хэрэглэгч хариуца бөгөөд түгээгчийн өмчлөлд хэвээр үлдээх (Хо тосгоны ерөнхий төлөвлөлтийн дагуу байрласа гэр хорооллын газар эзэмших эрх бүхий иргэд: энэ заалт хамаарахгүй.);

4/ суурилагдсан нийлбэр хүчи чадал нь 40.0 кВА–аас дээш байх хэрэглэгч өөрий трансформаторын дэд өртөө барьж байгуулж болн

Хэрэв нутаг дэвсгэрийг цахилгаанаа хангаж байгаа 6 (10) кВ хүчдэлийн гол шугам 35, 110 кВ хүчдэлийн трансформаторын чадал н хүрэлцэхгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргий хэтийн төлөвтэй уялдуулан шийдвэрлэ техникийн нөхцөл олгоно:

5/ хэрэглэгчийн өмчлөлд байга цахилгаан тоног төхөөрөмжөөр дамжуулан өө хэрэглэгчийг сүлжээнд холбох шаардлагатай бо энэ дүрмийн 16.3."е"-д заасны дагуу хангагч н өмчлөгчийн цахилгаан тоног төхөөрөмжөөр эрчи хүч дамжуулсан үйлчилгээний хөлсийг урьдчила тохиролцоно;

6/ гэр хорооллын айл өрхийн 10.

хүртэл суурилагдсан нийлбэр хүчин чадалтай кВ хүчдэлийн 3 фазын цахилгаан тоног өөрөмжийг холбох түгээх сүлжээний асуудлыг ээгч хариуцах.

7. Техникийн нөхцөл авахаар ирүүлсэн ээглэгчийн хүсэлтийг дамжуулагч, түгээгч ээн авснаас хойш 14 хоногийн дотор йдвэрлэнэ. Техникийн нөхцөлд дараахь үдлыг тусгана:

1/ холбох цэг (цахилгаан станц, д өртөө, цахилгаан дамжуулах түгээх шугам), ний хүчдэлийн түвшин, шугамын төрөл;

2/ хэрэглэгчийг шинээр холбох лон хэрэглээ нь нэмэгдсэнтэй холбогдуулан хилгаан шугам сүлжээг өргөтгөх (утасны хөндлөн глолыг ихэсгэх, трансформаторын чадлыг мэгдүүлэх, нэмэлт самбар суурилуулах гэх т) шаардлага;

3/ богино залгааны гүйдлийн мжээ, реле хамгаалалт, автоматик, холбоо, ндийрүүлэг, хэт хүчдэлийн хамгаалалтад тавих ардлага;

4/ реактив чадлын зохицуулалт;

5/ цахилгаан эрчим хүчний тооцоо;

6/ цахилгаан эрчим хүчний чанарыг інах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг гтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ;

7/ цахилгаан тоног төхөөрөмжийн г маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж;

8/ хэрэглэгчийн цахилгаан тоног хөөрөмжид тавих тусгай шаардлага (оруулга ахь хамгаалалт, чухал хэрэглээг автоматаар илүүлэх бэлтгэл тэжээл, аваарийн үед хэрэглэх ахилгааны бие даасан үүсгүүр гэх мэт);

9/ хэрэглэгчийн цахилгаан тоног хөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны эйдал;

10/ хэрэглэгчийн сүлжээнд холбох үсад хэрэглэгчийн жагсаалт, тэдгээрийн хэтийн ачаалал, цахилгаан хэрэглээ.

8. Дамжуулагч, түгээгчээс олгосон холболтын техникийн нөхцөлийг зураг төслийн байгууллага болон хэрэглэгч заавал биелүүлэх үүрэгтэй.

9. Техникийн нөхцөлийн хүчин төгөлдөр байх хугацааг гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааруулан 1-3 жилээр тогтооно.

10. Хэрэглэгч (захиалагч) нь мэргэжлийн байгууллагаар хийгээсэн зураг төслийг барилга-угсралтын ажил эхлэхээс өмнө уг зураг төслийн зохиогчтой хамтран холбогдох дамжуулагч, түгээгчээр хянуулан экспертиз хийлгэнэ.

Дамжуулагч, түгээгч нь зураг төслийн шийдэл, техникийн нөхцөл, цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын болон барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан байдлыг шалгаж, сүлжээнд холбогдох боломжтой эсэхийг зохих үндэслэлтэйгээр зааж 10 хоногийн дотор мэдэгдэнэ. Хэрэв нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол хянах хугацааг нэг сар хүртэл сунгаж болно.

11. Техникийн нөхцөл болон цахилгаан шугам сүлжээнд шинээр холбох зөвшөөрөл авахад захиалагч буюу хэрэглэгч нь холболтын заавраар тогтоосон үйлчилгээний төлбөр төлнө.

12. Техникийн нөхцөлийг үндэслэл муутай олгосноос учирсан хохирлыг уг техникийн нөхцөлийг олгосон этгээд хариуцна.

Гурав. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ

13. Хангагч, хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулна. Хэрэглэгч нь гэрээ байгуулсны дараа цахилгаан эрчим хүч хэрэглэх эрхээр хангагдана.

14. Эрчим хүчний тухай хуулийн 27.3-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах газраас батлагдсан зохицуулалтгүй хангалтаар үйлчлүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан хэрэглэгч зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангалтын аливаар үйлчлүүлэхээ сонгох эрхтэй.

15. Иргэн (айл өрх)-тэй байгуулах цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээнд хэрэглэх эрчим хүчний чанар, үнэ, төлбөр тооцооны журам, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, талуудын болон хангагчийн эрх бүхий ажилтны эрх, үүрэг, хариуцлага, алдангийн хэмжээ, хохирлыг тооцох журам, шаардлагатай бусад асуудлыг тусгана.

16. Аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах цахилгаан эрчим хүчээр хангах тухай гэрээнд дараахь зүйлүүдийг тусгана:

1/ Энэ дүрмийн 15-д зааснаас гадна;

а/хэрэглэгчийн зэрэглэл, зэрэглэлийг хангах техникийн боломж (бэлтгэл тэжээл, бэлтгэл тэжээлийг автоматаар залгагч, цахилгааны бие даасан үүсгүүр);

б/цахилгаан сүлжээнд хэрэглэгчийн холбогдсон чадал, хэрэглэх эрчим хүчний хэмжээ;

в/цахилгааны таслалт, гэмтэл зөрчил, төлбөр тооцооны тухай мэдээллийг хүлээж авах хангагч, хэрэглэгчийн хаяг, утасны дугаар;

г/төлбөр тооцооны хэлбэр;

д/төлбөрийн барьцаа.

2/ Хангагчаас шаардлагатай гэж үзвэл гэрээнд дараахь зүйлийг тусгана:

а/захиалсан дээд чадал;

б/ энэ дүрмийн 47-д заасны дагуу реактив чадлыг зохицуулах график;

в/ цахилгаан тоног төхөөрөмж шуурхай ажиллагааны үйлчилгээ хийх эрх бүх ажилтан /түгээгч ба хэрэглэгч/-тай харилцах жура

3/ Хэрэглэгч дараахь зүйлийг хангагча хянуулан гэрээнд хавсаргасан байна:

а/цахилгаан шугам сүлжээн эзэмшлийн зааг;

б/хэрэглэгчийн эзэмшли цахилгаан сүлжээний бүдүүвч, техникийн өгөгдө

в/хангагчтай зөвшилцс ажиллагааны горим, хамгаалалтын бол автоматикийн хэрэглийн тавил;

г/тооцооны хэмжих хэрэгслий байршил, өгөгдөл;

д/эзэмшлийн заагаас хэрэглэ тооцох цэг хүртэлх шугамын алдагдл тодорхойлох томъёо (гаргалгааны хамт);

е/Эрчим хүчний тухай хуулий 30.1.11–д заасны дагуу хэрэглэгчийн цахилга тоног төхөөрөмжөөр дамжуулан буса хэрэглэгчид цахилгаан эрчим хүч дамжуулс үйлчилгээний төлбөрийн хэмжээ;

Үйлчилгээний төлбөрийг тогтоохдоо тухай хэрэглэгчийн ашиглах цахилгаан тон төхөөрөмжийн элэгдэл хорогдлын шимтгэли хэмжээг баримтална.

4/ Дүрмийн 24-д заасан нөхцөлд өөрчлө орвол хэрэглэгч нь 3 хоногийн дотор зох өөрчлөлтийг тусган хангагчаар хянуулсан байв зохино.

17. Шугам сүлжээний эзэмшлийн зааги цахилгаан тоног төхөөрөмжийн байршил, нэ дугаар, хүчдэл зэргийг тодотгон, гүйцэтгэлий зургийг хийж дараахь байдлаар тогтооно:

1/ агаарын болон кабель шугамы эхний буюу эцсийн холболтоор;

2/ трансформаторын дэд өртөө дэх
мбарын шинийн холболтоор;

3/ трансформаторын гаргалгаан
эрхи холболтоор;

4/ хуваарилах самбарын салгуурын
хөдлөх хэсгийн холболтоор;

5/ ил хуваарилах байгууламжийн
ндлөвч дээрхи холболтоор.

18. Эзэмшлийн заагийн холболтын бүрэн
тэн байдлыг дор дурдсан байдлаар хариуцна:

1/ эзэмшлийн зааг нь агаарын
/гам, ил хуваарилах байгууламжийн хөндлөвч
эр байвал уг хөндлөвч, гол агаарын шугамыг
эмшигч;

2/ эзэмшлийн зааг нь дэд өртөө,
ваарилах самбарын дотор байвал уг дэд өртөө,
мбарыг эзэмшигч;

3/ дундын өмчлөлийн орон сууцны
өнхий щитний тэжээлийн оролт, гараltын
белийн холболтыг түгээгч.

19. Эрчим хүчний зохицуулах газраас эрчим
чний үнэ, тарифт орох өөрчлөлтийн талаар
эчим хүчний тухай хуулийн 27.5-д заасны дагуу
рэглэгчид мэдэгдсэний дараа хангагч, хэрэглэгч
рээндээ өөрчлөлт оруулна. Гэрээнд өөрчлөлт
руулагчий нь өөрчлөгдсөн үнэ тарифыг мөрдөхөөс
ıтгалзах үндэслэл болохгүй.

20. Өмчлөгчтэй байгуулсан батлан даах
рээг үндэслэн хангагч нь өмчлөгчийн байранд үйл
киллагаа явуулж буй хуулийн этгээд, хашаа, орон
/уцанд нь түр оршин суугч иргэнтэй цахилгаан
эчим хүчээр хангах гэрээ байгуулж болно. Хэрэв
йнхүү батлан даах гэрээ байгуулагчий бол
ахилгаан эрчим хүчний хангамжийг өмчлөгчтэй
айгуулсан гэрээгээр зохицуулна.

21. Хангагч нь цахилгаан эрчим хүчээр
хангах тухай гэрээний дагуу хүлээсэн үүргээ
биелүүлэхээс татгалзах эрхгүй.

Дөрөв. Хэрэглэгчийг цахилгаан шугам сүлжээнд холбох

22. Хэрэглэгчийн шинээр барьсан буюу
шинэчилж өөрчилсэн цахилгаан тоног төхөөрөмж
нь цахилгаан тоног төхөөрөмжийн үгсралтын болон
барилгын норм, дүрэм, өгөгдсөн техникийн
нөхцөлийн шаардлагыг бүрэн хангасан байвал
зохино.

23. Захиалагч (ашиглагч) нь холболт хийхийн
өмнө эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам
сүлжээг үгсрах гүйцэтгэгчтэй хамтран шинэ
цахилгаан тоног төхөөрөмжид туршилт, сорилт хийж,
акт, протокол үйлдэнэ. Хангагч, дамжуулагч буюу
түгээгчийн төлөөлөгч дээрхи акт, протоколын дагуу
газар дээр нь шалгаж, цахилгаан эрчим хүчээр
хангах гэрээг шинээр хийсний дараа хангагч
цахилгаан тоног төхөөрөмжийг хүчдэлд залгах
албан ёсны зөвшөөрлийг хэрэглэгчид олгоно.

Дээрхи зөвшөөрлийг үндэслэн дамжуулагч
буюу түгээгч нь хэрэглэгчийн цахилгаан тоног
төхөөрөмжийг сүлжээнд холбож хүчдэлд залгана.

24. Хэрэв хэрэглэгчийн цахилгаан тоног
төхөөрөмжийн үгсралтын ажилд дутуу хийгдсэн
зүйл илрэх буюу энэ дүрмийн 8, 13-т заасан
шаардлага хангагдаагүй байвал сүлжээнд
холбохыг хориглоно.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

25. Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа
цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай

ажиллагаат хангах зорилгоор Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх үүрэгтэй байна:

1/ өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаат хариуцсан ажилтныг томилох;

2/ хангагчаас шалтгаалан цахилгаан эрчим хүч тасалдсан болон чанарын стандартын шаардлага хангаагүй цахилгаан эрчим хүчээр хангасан тохиолдолд хэрэглэгч энэ талаар хангагчид цаг тухайд нь шуурхай мэдэгдэх;

3/ өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, хамгаалах багаж хэрэгсэлд ашиглалтын үеийн үзлэг үйлчилгээ, засвар, урьдчилан сэргийлэх зөлжит туршилтыг зохих норм, дүрмийн дагуу тогтоосон хугацаанд мэргэжлийн байгууллага, ажилтнаар хийлгэх;

4/ хангагчаас зөвшөөрсөн хэрэглэгчийн сүлжээний горим болон реле хамгаалалт, автоматикийн тавил, хугацааг мөрдөх;

5/ цахилгаан тоног төхөөрөмжийн байрыг аваарь ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр эсэргүүцэх хэрэгслээр хангах;

6/ цахилгаан тоног төхөөрөмж хариуцсан ажилтныг хамгаалах багаж хэрэгсэл болон угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааварт, гарын авлагаар хангаж, дүрэм, зааврын мэдлэгийн шалгалт авч, мэргэжлийн зэрэг олгох;

7/ цахилгаан станц, шугам сүлжээнд аваарь гарсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн цахилгаан ачааллыг бууруулах талаар өгсөн дамжуулагч, түгээгч, хангагчийн шийдвэри биелүүлэх;

8/ хяналтын болон ханга байгууллагын шалгалтаар илэрсэн зөрчли арилгах, тавьсан шаардлагыг тогтоосон хугацаа биелүүлэх;

9/ хангагчийн шаардлага ачааллын хэмжилт хийж дүнг мэдээлэх /ахуй хэрэглэгчид хамаарахгүй/;

10/ жил бүрийн 7 дугаар сарын 2 ны дотор дараа жилийн цахилгаан эрчим хүчни хэрэглээний захиалгыг хангагчид гаргаж өгөх;

11/ иргэн өөрийн сууц, гараж, хаша туслах аж ахуйн болон зуслангийн байрн цахилгаан шугам, дотоод холболт, цахилгаа хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галь аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэ хариуцах;

12/ хэвлэл мэдээллийн хэрэгсэ нийтлэгдсэн зохицуулалттай хангалтын төлбөрий тарифаас хангагчтай тооцоо хийх тарифыг сонго

13/ хэрэглэгч нь дараахь нөхцө байдал үүссэн тохиолдолд энэ тухай дамжуулаг түгээгч, хангагчид шуурхай мэдээлж байх:

а/тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон;

б/тэжээлийн шугам таслагдан хүчдэлгүй болсон, цахилгаан гүйдэлд хүн, амьтан нэрвэгдсэ буюу нэрвэгдэх нөхцөл бүрдсэн;

в/хэрэглэгчийн нутаг дэвсгэр, орчин тойрон орших хангагчийн мэдлийн цахилгаан тоно төхөөрөмжид гэмтэл гарсан буюу гарч болзошгү болсон.

14/ Эрчим хүчний шугам сүлжээг гаалах дүрмийг хэрэгжүүлж, өөрийн эзэмшлийн эрт байгаа цахилгаан тоног төхөөрөмжийг гаалах, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, елийн болон агаарын шугамын хамгаалалтын аст газар шороонд болон бусад ажлыг хангагч он эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хийлгэхгүй х;

15/ бусад хэрэглэгчийн цахилгаан гамж тасалдах, учирсан хохирлыг хангагч исөн тохиолдолд буруутай хэрэглэгч уг бөөрийг хангагчид төлөх;

16/ өөрийн эзэмшлийн цахилгаан ам сүлжээ, дамжин нэвтрүүлэх дэд өртөөнд йгаа цахилгаан тоног төхөөрөмжид засвар ыдээ сүлжээнээс таслах, сүлжээнд залгахыг ээгч, хангагч байгууллагын зөвшөөрлөөр цэтгэх;

17/ нутаг дэвсгэртээ байрлаж байгаа цөртөө, хуваарилах байгууламж, шугам сүлжээнд ийгэн залгалт, үзлэг үйлчилгээ, засвар хийхээр эн дамжуулагч, түгээгч, хангагчийн ажилтныг эр ч үед саадгүй оруулах;

18/ төрийн ёслол, олон улсын нжтэй уулзалт, тэмцээн зэрэг арга хэмжээг юрхой хугацаанд зохион явуулах үед цахилгаан нгамжийн найдвартай байдлыг онцгойлон заарах шаардлага гарвал 3–аас доошгүй хоногийн нө хангагчид албан ёсоор мэдэгдэж, ардлагатай арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх;

19/ улирлын шинжтэй ажилладаг силгаан тоног төхөөрөмжид хангачаар үзлэг ажилт хийлгэн шалгуулсны үндсэн дээр ижээнд залгуулах;

Зургаа. Тооцооны хэмжих хэрэгслийн ашиглалт

26. Цахилгаан эрчим хүчний зарцуулалтын ажээг тооцох зорилгоор хэрэглэгч бүрт тооцооны ажих хэрэгсэл тавьсан байна. Цахилгаан эрчим ний зарцуулалтад дотоодын хяналт тавих зорилгоор шаардлагатай нэгж, хэсэг болон цахилгаан тоног төхөөрөмжид хэрэглэгч өөрөө хяналтын хэмжих хэрэгсэл тавьж болно.

27. Актив, реактив цахилгаан эрчим хүчний тооцооны хэмжих хэрэгсэл (тоолуур, хэмжүүрийн трансформатор гэх мэт)-ийг эрх олгогдсон этгээдийн лабораторид засвар, тохируулга хийж, эрх бүхий байгууллага шалгаж битүүмжилсэн байна.

28. Тооцооны хэмжих хэрэгсэл, тэдгээрийн холболтын сүлжээ нь нэг щит, хайрцаг байрласан байвал зохино. Щит буюу хайрцгийг битүүмжилж, өндөрт хөдөлгөөнгүй байрлуулан газардуулсан байна.

29. Хэрэглэгч нь улсын стандарт болон цахилгаан тоног төхөөрөмжийн үгсралтын дүрмийн шаардлага хангасан щит, хайрцаг хэрэглэнэ. Щит, хайрцаг нь дараахь иж бүрдэлтэй байна:

1/ оролтын салгуур;

2/ цахилгаан эрчим хүчний тоолуур;

3/ тоолуурын холболтын цуглуулга;

4/ хэмжүүрийн трансформатор / шаардлагатай бол/;

5/ ачаалалд тохирсон автомат буюу гал хамгаалагч.

30. Тооцооны нэг фазын болон 380 В-ын гурван фазын индукцийн цахилгаан тоолуурт 3 жил, 100 В-ын гурван фазын индукцийн цахилгаан тоолуурт 2 жил, нэг болон гурван фазын электрон тоолуурт 8 жил, нэг болон гурван фазын импульсийн тоолуурт 3 жилд нэг удаа тус тус ээлжит баталгаажуулах шалгалт хийнэ.

31. Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээх байгаа хэмжүүрийн трансформаторыг солих, тооцооны тоолуурыг салгах, тавих ажлыг зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр түгээгч гүйцэтгэнэ.

Тооцооны тоолуурыг сүлжээнээс салгах, холбох үед хэрэглэгчийн төлөөлөгчийг байлцуулна.

32. Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээж байгаа хүчдэлийн трансформаторын салгуурын бариул, түүний холболтын цуглуулга зэргийг байрлуулсан щит, хайрцаг, тоолуурын таглаа зэргийг хангагчийн эрх бүхий ажилтан битүүмжилсэн байна.

33. Хэрэглэгчийг төлбөр тооцооны хэмжих хэрэгслээр хангах, түүнийг баталгаажуулах, засварлах, солих, тоолуурыг холболтын цэгт суурилуулах болон үүнтэй холбогдож гарах зардлыг түгээгч хариуцна.

Шинээр ашиглалтад орох орон сууц, барилга байгууламжийн тоолуурыг барилгын захиалагч, гүйцэтгэгч байгуулага тавина.

34. Тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг уг хэмжих хэрэгслийн эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хариуцна.

35. Хангагч болон хэрэглэгчийн хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбогдон гарсан маргааныг хэмжил зүйн эрх бүхий улсын байцаагч шийдвэрлэнэ.

Долоо. Төлбөр тооцооны журам

36. Тооцооны хэмжих хэрэгслийг дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагт дээр тавина.

Эзэмшлийн заагт дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон яваалтын) дахь алдагдлыг шугам сүлжээг эзэмшигч хүлээнэ.

Ийм алдагдлыг хүлээдэг үндсэн хэрэглэгчийн цахилгаан сүлжээгээр дамжин холбогдсон хэрэглэгч уг алдагдлаас өөрийн хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний хэмжээн ногдох хувийг хариуцна.

Энэ нь айл өрх, иргэдэд хамаарахгүй бөгөө тэдэнд ногдох алдагдлыг хангагч хариуцна.

37. Хангагч, хэрэглэгчийн хооронд хий тооцоог хэмжих хэрэгслийн заалт (буса тохиолдолд энэ дүрмийн 38 дугаар заалт)-ь үндэслэн, мөрдөж байгаа үнэ тарифийн дагу бодно. Хэрэв цахилгаан тоолуур нь гүйдэл б хүчдэлийн трансформатортой дамжин холбогдсо байвал хэрэглэсэн эрчим хүчний хэмжээг тоолууры одоогийн болон өмнөх заалтын ялгавары трансформаторын итгэлцүүрээр үржүүлэ тодорхойлно.

38. Тооцооны хэмжих хэрэгсэл нь эн дүрмийн 27, 32-т заасан шаардлагыг хэрэглэгчий буруугаас шалтгаалан хангаагүй тохиолдол, тооцоо хийхдээ хэрэглэгчид тавьсан чийдэн залгуурын тоог тоолуургүй үед тооцох тарифаа үржүүлж, эсхүл, цахилгаан тоног төхөөрөмжий суурилагдсан чадлыг ажиллавал зохих цаг (сүүлий удаа шалгалт хийснээс хойш тухайн зөрчилий арилгах хүртэлх)-аар үржүүлж тодорхойлно.

39. Тооцооны тоолуур нь энэ дүрмийн 27, 32-т заасан шаардлагыг хангаагүй нь хэрэглэгчээ шалтгаалаагүй, тооцооны хэмжих хэрэгслий шалгаж засварлахаар сүлжээнээс тасалсан тохиолдолд түрүүчийн 3 сард хэрэглэсэн цахилгаа эрчим хүчний дундажийг баримтлан төлбөрий тооцоог хийнэ.

40. Тооцооны тоолуур, бусад хэрэгсэл эвдэрсэн (их бие, шил хагарсан, ороомог шатсан холболт болон байршлыг өөрчилсөн гэх мэт нөхцөлд тэдгээрийг сэргээн засварлах зардлы буруутай этгээд хариуцна.

Тооцооны хэмжих хэрэгслийг сэргээн засварлах, хэвийн ажиллагаанд оруулах ажлы түгээгч, дамжуулагч 7 хоногийн дотор хийх үүрэгтэй.

41. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг хангагч,

рэглэгч хамтран шийдвэрлэж дараа сарын оцоонд тусгана.

42. Хэрэглэгч тухайн байрнаасаа түр буюу ермөсөн нүүсэн, байраа бусдад шилжүүлсэн бол ıэ тухай хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэж, ірэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоог ийж дуусгавар болгоно.

43. Байр, орон сууц, хашаа, газар өмчлөгч, ээмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нүүн илжихдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн оцоогоо хийж дуусган, энэ тухай тодорхойлолтыг ангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн айр, орон сууц, хашаа, газрыг шинээр өмчлөгч, ээмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ıаардаж авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй охиолдолд шинээр өмчлөгч эрчим хүчний ерийг ариуцна.

44. Хангагч нь хэрэглэгчийн цахилгаан эрчим үчний төлбөрийг сард нэгээс доошгүй удаа хянан оощоолж байна. Хэрэглэгч аж ахуйн нэгж, айгууллага, иргэн цахилгаан эрчим хүчний ооцоог урьдчилан төлөх хэлбэрээр хийж болно.

45. Цахилгаан эрчим хүчний тооцоог эрэглэгч буруу гэж үзвэл энэ тухай хангагчид лбан ёсоор мэдэгдэнэ. Хангагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор маргааныг шийдвэрлэнэ. Хэрэглэгч хангагчийн шийдвэрийг ювшөөрөөгүй тохиолдолд шүүхэд хандана.

Найм. Хэрэглэгчийн реактив чадлын зохицуулалт

46. Үйлдвэрлэлийн томоохон (холбогдсон чадал нь 250 кВА ба түүнээс дээш, реактив чадал нь холбогдсон чадлын 10-аас доошгүй хувь байх) хэрэглэгчид реактив тоолуурыг тооцооны зориулалтаар дараахь тохиолдолд тавина:

1/ эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх хэсэгт реактив цахилгаан эрчим хүчний үйлчлэлээр алдагдах бодит цахилгаан эрчим хүчний хэмжээг тодорхойлох;

2/ хэрэглэгчийн конденсатор, синхрон хөдөлгүүрийг хангагчаас тогтоосон горимоор ажиллуулж байгаа эсэхийг хянах.

47. Хэрэглэгч нь конденсатор, синхрон хөдөлгүүрийг дамжуулагч, түгээгчээс олгосон техникийн нөхцөлийн дагуу цахилгаан шугам сүлжээнд суурилуулна.

Тэдгээрийн ажлын горимыг хангагч болон хэрэглэгч зөвшилцөн тогтооно. Эрчим хүчний зохицуулах газраас батлагдсан журмын дагуу уг горимыг мөрдсөн байдлаас хамааруулан хэрэглэгчийг урамшуулах асуудлыг гэрээнд тусгана.

Ес. Хангагчийн эрх үүрэг

48. Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь эрх үүрэгтэй байна:

1/ Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд цахилгаан эрчим хүчний хангамжийг халаалтын улиралд 4 цагаас илүү хугацаагаар таслахгүй байх;

2/ хэрэглэгчийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид Эрчим хүчний тухай хуулийн 32.2–т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;

Цахилгаан эрчим хүчний хэрэглээг нь түдгэлзүүлж болохгүй хэрэглэгчийн жагсаалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

3/ үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчийн өмчлөл, эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам сүлжээнд ноцтой осол гэмтэл гарсан үед Эрчим хүчний тухай хуулийн 6.1.4–т заасан журмыг баримтлан хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хангамжийг зохицуулах;

4/ хангагчийн эрх бүхий ажилтныг томилох.

Хангагчийн эрх бүхий ажилтан Эрчим хүчний

тухай хууль болон эрчим хүчээр хангах гэрээнд тусгагдсан дараахь үүргийг гүйцэтгэнэ:

а/хэрэглэгчийн эрчим хүчний тооцоог сар бүр газар дээр нь шалгаж хянах;

б/хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгах;

в/энэ дүрмийн 48.1-ийг хэрэгжүүлэх;

г/гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох, алданги тооцох, нөхөн тооцоололт хийх;

д/тооцооны хэмжих хэрэгслийн битүүмжлэлийг шалгаж, баталгаажуулаттаас бусад битүүмжлэлийг шинэчлэх, сэргээх.

5/ цахилгаан сүлжээнд холбох, таслах, холболтыг өөрчлөх тухай хэрэглэгчийн захиалгыг хангагч судлан үзэж, техникийн нөхцөлийн шаардлага хангасан гэж үзвэл 3 хоногийн дотор шийдвэрлэн уг ажлыг зохих төлбөртэйгээр гүйцэтгэнэ;

6/ эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлсөн хэрэглэгчид төлсөн эрчим хүчний үнийн тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлэх.

7/ эрчим хүчний тухай хуулийн 32.2-т болон гэрээнд заасначаас өөр нөхцөл, болзол тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлаж болохгүй.

Арав. Хохирлыг тооцох, төлөх

49. Цахилгаан эрчим хүч тасалдсанаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн хохирлыг тогтоохдоо хэрэглэгч дээр тавигдсан өөрөө бичигч хэмжих хэрэгсэл болон түгээгчийн шуурхай ажиллагааны бичлэгийг баримтлан хангагч, хэрэглэгчийн хамтран үйлдсэн актыг үндэс болгоно. Актад цахилгаан эрчим хүч тасалдсан, хэлбэлзсэн он, сар, өдөр, үгацаа, шалтгаан, үйлдвэрлэл, үйлчилгээнд учруулсан шууд хохирлын хэмжээ, хангагч, хэрэглэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаалыг тодорхой бичиж гарын үсэг зурн, хангагч, хэрэглэгчийн холбогдох албан тушаалтнаар баталгаажуулсан байна. Актыг талууд 5 хоногийн дотор хамтран тогтоож, хохирлыг 1 сарын дотор буруутай тал хариуцан төлнө. Аль нэг талын гарын үсэг зураагүй акт нь хохирлыг нөхөн төлөх үндэслэл болохгүй.

50. Цахилгаан эрчим хүчний тасалдла учирсан хохирлыг дор дурдсан тохиолдолд ханга хариуцахгүй:

1/байгалийн гэнэтийн аюул /аянг салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэ тохиолдсон;

2/хангагчтай тохиролцсо горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчи цахилгаан хангамж тасалдсан;

3/Эрчим хүчний тухай хуулий 29.1.2, 32.2-т заасны дагуу хэрэглэгчи цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэ

4/хэрэглэгчийн цахилгаа дамжуулах шугамыг гуравдагч этгээд гэмтээ эрчим хүчээр тасалдуулсан.

Арван нэг. Хяналт, хариуцлага

51. Цахилгаан эрчим хүч хэрэглэ дүрмийн биелэлтэд эрчим хүчний улсы хяналтын байгууллага, улсын байцаагч боло хангагчийн эрх бүхий ажилтан хяналт тавина

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаала байгууллага олон нийтийн хяналт тавина.

52. Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчи зөвшөөрөлгүй буюу тоолуураас гадуу хэрэглэсэн, тоолуурыг эвдэх, тоолууры холболтын бүдүүвчийг өөрчлөх, эргэлтий удаашруулах, зогсоох зэргээр санаатайгаа цахилгаан эрчим хүчийг зүй бусаар ашигласа бол энэ дүрмийн 38 дугаар заалтын дагу нөхөн тооцоололт хийх (сүүлийн удаа шалгал хийснээс илрэх хүртэл хугацаанд)-ээс гадна буруутай хүмүүст Эрчим хүчний тухай хуулий 37.1.5 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэ буюу хуулийн байгууллагад шилжүүлнэ.

53. Хангагч хэрэглэгч талууд хоорондо зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй цахилгаа эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдо маргааныг Эрчим хүчний зохицуулах газа шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвө шүүхэд гомдол гаргана.

уу техникийн нөхцөл авсан бусад эглэгчийг үндсэн хэрэглэгч өөрийн мшлийн тоног төхөөрөмж, шугам сүлжээнд ибуулах үүрэгтэй.

24. Хангагч, хэрэглэгч нь гэрээний элэлтийг уг гэрээнд тогтоосон хугацаанд нэж дулааны эрчим хүчний тасалсан лтгааныг тогтоон шийдвэрлэнэ.

25. Гэрээгээр хүлээсэн хангагчийн гийн биелэлтийг дүгнэхдээ нийлүүлсэн эрчим ний хэмжээ, чанарыг гэрээнд заасан хэмжээ, арын үзүүлэлттэй харьцуулна. Дулаан зөөгч р, усны)-ийн даралт,температурын бэлзлийн зөвшөөрөгдөх хэмжээг гэрээнд сгахдаа техник ашиглалтын дүрмийг римтална.

Дөрөв. Хэрэглэгчийг дулааны шугам сүлжээнд холбох

26. Дулааны тоног төхөөрөмж, шугам лжээний техник ашиглалт, аюулгүй иллагааны дүрэм, зураг төсөл, техникийн хцөлийн шаардлага бүрэн хангагдсан нөхцөлд нээр барьсан буюу өргөтгөл, шинэчлэл хийсэн рилга байгууламжийг дулааны шугам лжээнд холбоно.

27. Барилга байгууламжийг дулааны гам сүлжээнд холбоход хэрэглэгч дор дурдсан аардлагыг хангасан байна:

1/ дамжуулагч, түгээгч, хангагчийн асан хугацаанд бүрэн тухайн шугамд лбогдвол зохих салаа шугамын холболт / олгоог/-ыг хийсэн байх;

2/ дулааны шугам, тоног хөөрөмжид үгаалт, даралтын туршилт хийхдээ лбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчийн леөлөгчийг байлцуулан акт үйлдсэн байх;

3/ шалгаж баталгаажуулсан хянах мжих хэрэгсэл, автомат тохируулагчийг зураг сөлд заасан цэгт тавих;

4/ дулааны шугам, тоног төхөөрөмжийг хэсэгчлэн хүлээн авсан акт, гагнуурын болон далд ажлын акт, техникийн бусад баримт бичгийг бүрдүүлсэн байх;

5/ дулааны шугамын гүйцэтгэлийн зургийг гаргаж 1 хувийг холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид өгөх.

28. Хангагч нь энэ дүрмийн 26, 27-д заасан шаардлагыг хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулж дулааны эрчим хүчээр хангана. Техникийн нөхцөл, хянасан зураг төслийн дагуу бариагүй барилга байгууламжийг дулаанаар хангахгүй.

29. Зам талбайг сэтэлж дулааны шугам тавьсан тохиолдолд тэдгээрийг хэрэглэгчийн зардлаар сэргээн засаж хуучин байдалд нь оруулсны дараа дулааны шугам сүлжээнд холбох зөвшөөрлийг хэрэглэгчид олгоно.

Тав.Хэрэглэгчийн эрх үүрэг

30. Хэрэглэгч Эрчим хүчний тухай хуулийн 32.2; 32.3-т болон энэ дүрмийн 54-56-д зааснаас бусад үндэслэлээр дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй.

31. Өөрийн эзэмшилд байгаа дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаар хангахтай холбогдсон дараахь үүргийг хэрэглэгч хүлээнэ:

1/ дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварыг хариуцах мэргэжлийн ажилтантай байх, тэдгээрийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх. Дулааны тоног төхөөрөмжийн ашиглалт, засварыг мэргэжлийн бус хүнд хариуцуулахыг хориглоно;

2/ дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ажлын зураг төсөл, гүйцэтгэлийн зураг, ашиглалтын паспорт

зэргийг бүрдүүлэн жил бүр баяжилт хийх;

3/ дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их болон урсгал засварыг дамжуулагч, түгээгчийн төв шугамын засвартай уялдуулан хугацаанд нь чанартай хийх;

4/ засвар хийсний дараа хангагчийн төлөөлөгчийг байлцуулан дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээндээ химийн болон механик угаалга, цэвэрлэгээ, даралтын туршилт хийж, илэрсэн гэмтлийг засварлаж хамтарсан акт үйлдэж байх;

5/ дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд тохируулга хийж барилга, орон сууцны өрөө тасалгааг жигд халаах нөхцөлийг хангах;

6/ барилга орон сууцыг халааж байгаа сүлжээний усыг бүрэн хэмжээгээр буулгах тохиолдолд хангагчаас албан ёсны зөвшөөрөл авах. Сүлжээний усыг асгах болон бусад зориулалтаар ашиглахыг хориглоно;

7/ өөрийн эзэмшлийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд хангагчид мэдэгдэж яаралтай засварлах арга хэмжээ авах;

8/ дулаан дамжуулах төв болон зангилаанд эмх цэгцтэй, цэвэр, байгыин гэрэлтүүлэгтэй байлгаж агуулах, орон байрны зориулалтаар ашиглахгүй байх;

9/ дулааны эрчим хүчийг хэмнэх, алдагдлыг хэвийн хэмжээнд байлгах, хувирсан усны бүцалтыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, сүлжээний бүцах усны халууныг бууруулах /эх үүсвэр нь дулаан цахилгааны төв байгаа тохиолдолд/-д чиглэсэн техник зохион байгуулалтын шуурхай арга хэмжээг төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлэх;

10/ дулааны эрчим хүч хэрэглэсэн тооцоог гэрээнд заасан хугацаанд хангагчтай хийж байх;

11/ хяналтын болон хангагчийн байгууллагын шалгалтаар илэрсэн техник ашиглалт, аюулгүй ажиллагааны зөрчлийг арилгах, шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх.

32. Хэрэглэгч ажил үүргээ гүйцэтгэж байгаа эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн төлөөлөгчийг өөрийн эзэмшлийн газарт саадгүй нэвтрүүлж дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээгээ шалгуулах үүрэгтэй.

33. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн газар байрласан дамжуулагч, түгээгч болон бусад хэрэглэгчийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээ хийх бололцоо олгоно.

34. Хангагчтай тооцоо хийдэг тоолуурын бүрэн байдлыг хэрэглэгч хариуцаж гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид, яаралтай мэдэгдэнэ.

35. Хэрэглэгч нь гэрээнд заасан дулааны эрчим хүчийг хугацаандаа авахгүй болсон тухайгаа хангагчид 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

36. Хэрэглэгч Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг мөрдөж ажиллана.

37. Эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтны хийсэн битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Зургаа. Хангагчийн эрх, үүрэг

38. Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь эрх үүрэг хүлээнэ:

1/ Эрчим хүчний тухай хууль, Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг хэрэгжүүлж хэрэглэгчийг

хцөл бүрдүүлээгүй буюу техникийн нөхцөлийн ардлагыг зөрчсөн, зөвшөөрөлгүй барилга йгууламж холбож дулаан авсан;

3/ хангагчаас тооцоолж битүүмжлэн зьсан, тохируулах хэрэгсэл /сопло, шайба/-ийг р мэдэн өөрчлөх буюу авах замаар бусдын лаан хангамжийг доголдуулсан;

4/ тооцооны хэмжүүрт оруулахгүй зүй саар холболт хийж дулаан /уур, ус/ авч игласан;

5/ хэрэглэсэн дулааны болон цаагаагүй хувирсан усны төлбөрийг дараа сарын)-ны дотор төлөөгүй.

55. Улсын байцаагч болон хангагчийн эрх ухий ажилтан хэрэглэгчийн үйл ажиллагааг дгэлзүүлэх тухай шийдвэртээ шалтгааныг одорхой зааж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, олуур болон шаардлагатай бусад хэрэгслийг итүүмжилнэ.

56. Эрчим хүчний хангамж, хэрэглээг нь дгэлзүүлсэн тухай шийдвэрт заасан шалтгааныг эрэглэгч арилгасан тухайгаа хангагчид мэдэгдэж алгуулахаас өмнө уг тоног төхөөрөмж, шугам үлжээг ашиглахыг хориглоно.

Арав.Хохирлыг тооцох, нөхөн төлөх

57. Хангагч нь гэрээний үүргээ зохих ёсоор иелүүлээгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр рчим хүчийг тасалдуулсан тохиолдолд хэрэглэгч нь энэ талаар хангагчид цаг тухайд нь шуурхай мэдэгдэнэ.

58. Дулааны эрчим хүч тасалдсанаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн хохирлыг тогтоохдоо хангагч, хэрэглэгчийн хамтран үйлдсэн актыг үндэс болгоно. Актад дулааны эрчим хүч тасалдсан, хэлбэлзсэн он, сар, өдөр, хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл, үйлчилгээнд учруулсан шууд бөгөөд шууд бус хохирлын хэмжээ, хангагч, хэрэглэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаалыг тодорхой бичиж гарын үсэг зуран, хангагч, хэрэглэгчийн холбогдох албан тушаалтан нар баталгаажуулсан байна. Актыг талууд 5 хоногийн дотор хамтран тогтоож, хохирлыг 2 сарын дотор буруутай тал хариуцан төлнө. Аль нэг талын гарын үсэг зураагүй акт нь хохирлыг нөхөн төлөх үндэслэл болохгүй.

59. Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээг гуравдагч этгээд гэмтээж хохирол учруулсан тохиолдолд /шинээр барилга барих, газар шорооны ажил хийх үед/ хэрэглэгч, хангагч хамтран акт тогтоож буруутай этгээдээр хохирлыг арилгуулах, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай болгох асуудлыг хамтран шийдвэрлэнэ.

60. Чанарыг бууруулан түгээсэн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог тухайн хэрэглэгчийн хянах хэмжих хэрэгслийн заалтаар тогтоож хийнэ.

61. Дулааны эрчим хүчний тасалдлаас учирсан шууд болон шууд бус хохирлыг арилгах талаар дулааны эрчим хүчээр хангах тухай хангагч, хэрэглэгчийн хооронд байгуулах гэрээнд тодорхой тусгасан байна.

62. Хангагч, хэрэглэгч зөвшилцөлд хүрээгүй маргаантай асуудлыг шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.

63. Эрчим хүч ашиглах дүрэм, горим, гэрээг зөрчиж хууль бусаар хэрэглэсэн эрчим хүчний үнийг хэрэглэгч нөхөн төлнө.

64. Дараахь тохиолдолд дулааны эрчим хүч тасалснаас хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй:

1/ байгалийн гэнэтийн аюул /усны үер, гал түймэр, газар хөдлөлт гэх мэт/ тохиолдсон;

2/ хэрэглэгч болон бусад байгууллага, хүмүүсийн буруу үйл ажиллагаанаас үүссэн;

3/ дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлсэн.

Арван нэг. Хяналт, хариуцлага

65. Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн биелэлтэд эрчим хүчний улсын хяналтын байгууллага, түүний байцаагч болон үйлдвэрлэгч, хангагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохих албан тушаалтан хяналт тавина.

66. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, мөрдөж буй үнэ тарифийн үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

67. Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомж дүрмийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхийг үл харгалзан учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ШУГАМ СУЛЖЭЭГ ХАМГААЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмээр эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас тогтоох, түүний хүрээнд ажил, үйлчилгээ явуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2. Эрчим хүчний шугам сүлжээний аюулг ажиллагааг хангах, хүн, амьтан осолдохо урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтъ зурвас тогтооно.

3. Эрчим хүчний шугам сүлжээны хамгаалалтын зурвасыг дор дурдсан нөхцө хэмжээг баримтлан тогтооно:

Хоёр. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас

№	Шугам сүлжээний ангилал	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгуулайж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас хоёр тийш
1	Цахилгаан дамжуулах шугам: а/1кв хүртэл	-	1-1,5 м	-	-	-	-	-
	б/1-20 хүртэл кв	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/35 кв	15 м	4 м	15 м	-	-	-	3 м
	г/110 кв	20 м	5 м	20 м	-	-	-	3 м
	д/220 кв	25 м	6 м	25 м	-	-	-	4 м
	е/330-500 кв	30 м	10 м	30 м	-	-	-	5 м
2.	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3.	Дулааны шугам: а/500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-

4. Дэд станц, хуваарилах байгууламж, ой, риа, ногооны талбайд байрших тохиолдолд түүний гэн тойрон 25 м газарт ой байлгах, ур тариа, төмс, нсний ногоо тариалахыг хориглоно.

5. Аймаг, нийсэл, сум, дүүргийн Засаг дарга ічим хүчний шугам сүлжээ эзэмшигч аж ахуйн ігж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, эрчим хүчний угам сүлжээний зурвасын зураглалыг үндэслэн эрчим хүчний тухай хуулийн 33.2-т заасны дагуу імгаалалтын зурвасыг тогтооно.

6. Усны үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг айгалийн гэнэтийн аюул болон үйлдвэрлэлийн слын улмаас эрчим хүчний шугам сүлжээнд гэмтэл ірсан тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн асаг дарга тэдгээрийг хамгаалах болон гэмтлийг рилгах талаар шаардлагатай дэмжлэг туслалцаа зүүлэх ажлыг шуурхай зохион байгуулна.

7. Хамгаалалтын зурвас дотор барилга айгууламж, орон сууц, гэр, хашаа барих,шугам сүлжээ эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл жиллагаа явуулахыг хориглоно.

8. Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа азарт эрчим хүчний шугам сүлжээ барьж байгуулах айлшгүй шаардлага гарвал түүний улмаас үүдэн арах бүхий л зардлыг шугам сүлжээг бариулж айгаа аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

Гурав. Хамгаалалтын зурваст ажил, үйлчилгээ явуулах

9. Хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, азар шорооны ажил гүйцэтгэхдээ эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг авсан байна.

10. Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11. Эрчим хүчний шугам сүлжээг шилжүүлэх, түүнд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлыг хүсэлт тавьсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцаж, шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг авч түүний хяналтын дор гүйцэтгэнэ.

12. Эзэмшигч байгууллага нь хамгаалалтын зурвас дотор байрласан газар доорхи инженерийн шугам сүлжээний байршлын зураглалыг эрчим хүчний хангагч байгууллагад өгсөн байвал зохино.

13. Хамгаалалтын зурвас дотор газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан сэргээнэ.

14. Хамгаалалтын зурвас дотор тарьсан мод бут нь шугам сүлжээнд хор хохирол, гэмтэл учруулах буюу үзэлг үйлчилгээ хийхэд саад болох тохиолдолд мод, бут эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй.

Дөрөв. Эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигчийн үүрэг

15. Эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/хамгаалалтын зурваст дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг гүйцэтгэх;

2/ автомашины замын дээгүүр дулаан дамжуулах шугам гарсан нөхцөлд тухайн хэсэгт тээврийн хэрэгслийн /ачаатай болон ачаагүй/ өндөр, өргөний хэмжээг заасан тэмдэг санамжийг замын ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран тавих;

3/ ой дундуур цахилгаан дамжуулах шугам гарсан тохиолдолд хамгаалалтын зурвас доторхи

унаги мод, мөчир, гишүүр цэвэрлэж байх;

4/ шугам сүлжээний хамгаалалтын зурвасын байршлын зураглалыг хийх, хамгаалалтын зурвасыг тогтоолгох тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаар гаргуулах;

5/ дулааны шугамыг хөрсний эвдрэлээс үүсч болох гэмтэл, бусад нөлөөлөл, бохирдлоос хамгаалах.

Тав. Дүрмийн биелэлтэд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

16. Энэхүү дүрмийн биелэлтэд аймаг нийсэл, сум, дүүргийн Засаг дарга, эрчим хүчний зохицуулагч болон хяналтын улсын байцаагч, эрчим хүчний шугам сүлжээ эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага өөр өөрийн чиглэлээр хяналт тавина.

17. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Эрчим хүчний тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 02** **Улаанбаатар хот**

Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Ж.Амарсанаа, Ч.Дашням, В.Удвал /илтгэгч/ Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа өргөдөл гаргагч П. Баттогтох, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Долгор нарыг оролцуулан Төрийн ордны Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 16 дугаар хорооны иргэн П.Баттогтох Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "... хууль зааснаар үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" . ... Баривчилсан шалтгаан үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ..." гэсэн заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батлагдсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-д а."**Баривчлах**" гэдэг үг нь эрх зүйн зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн буюу эрх бүхий ямар нэг байгууллагын шийдвэрээр этгээдийг саатуулахыг хэлнэ. б. **"Саатуулагдсан этгээд"** гэдэг үг нь эрх зүйн зөрчил үйлдэж, шийтгүүлснээс бусад хувийн эрх чөлөөгөө хасуулсан аливаа этгээдийг хэлнэ гэсэн заалтуудад **"Баривчлах"** гэдэг ойлголт нь агуулгын хувьд: -тухайн этгээдийг албадан саатуулах буюу цагдан хорихын өмнө эрх зүйн зөрчил үйлдсэн болон үйлдсэн байж болзошгүй этгээдийн чөлөөтэй зорчих, бусадтай чөлөөтэй харьцах зэрэг халдашгүй байх хувийн эрхийг нь хязгаарлаж, эрх бүхий албан тушаалтны хяналтанд

эсон үеэс эхлэн зохих байгууллагад хүргэх ртэлх ажиллагаа юм.

Өөрөөр хэлбэл **"Баривчлах"** ажиллагаа нь одорхой эрх бүхий албан тушаалтны хяналтанд эсон үеэс эхлэн зохих байгууллагад хүргэх ртэлх ажиллагааг хамаарах бөгөөд үүний эраагаар албадан саатуулах, цагдан хорих болон орих шийтгэлүүд тодорхой үе шаттайгаар явагдаг илээ.

Иймд **"Баривчлах"** гэдэг ойлголт нь ийтгэл биш, харин шийтгэх эсэхийг нь хянан алгаж, тодруулахын тулд эрх бүхий байгууллагаас вуулж буй тодорхой төрлийн ажиллагаа пэрхийлж, өөртөө агуулсан ойлголт, нэр томьёо ым. Гэтэл энэ ойлголт нэр томьёог **"шийтгэл"** эмээн буруугаар тайлбарлан ойлгож, салбар уулиудад тусгасан буруу гажуудал оршсоор байна.

Тухайлбал, Монгол Улсын Захиргааны ариуцлагын тухай хуулийн /1992 он/ 4 дүгээр үйлийн 1-д "Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болно:

1.Торгох

2.Эрх хасах

3.Хууль бусаар олсон орлого, эд зүйлийг ураах

4.Баривчлах" гэж заажээ.

Ийнхүү Захиргааны хариуцлагын тухай уульд **"баривчлах"** гэсэн ойлголт, нэр томьёо нь ндсэн агуулга, утга санаанаасаа гажуудаж олонтаа усгагджээ.

-Мөн Захиргааны журмаар албадан өдөлмөр хийлгэх тухай хуульд: /2000 он/ **Баривчлах"** гэдэг нэр томьёог шийтгэл гэсэн хагдахуунаар буруу тодорхойлсон байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд усгагдсан **"баривчлах"** гэдэг ойлголт, нэр томьёоны агуулгыг буруу, гажуудуулж тусгасан хуулиуд болох Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйл, 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйл, 30^1 дүгээр зүйл, 30^2 дугаар зүйл, 30^3 дугаар зүйл, 30^4 дүгээр зүйл, 32 дугаар зүйл, 45 дугаар зүйлүүдэд тусгагдсан **"баривчлах"** гэсэн нэр томьёонууд мөн Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3, 4, 5, 6 дугаар зүйлүүдэд тусгагдсан **"баривчлах"** гэсэн нэр томьёо нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт байгаа нэр томьёо, ойлголтын агуулгыг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн Цэцэд 2001 оны 12 дугаар сарын 6-ны өдөр гаргасан нэмэлт тайлбартаа:

"А/Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйл: Шүүгчийн халдашгүй эрх;

Б/Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйл, Хууль зүйн баталгаа;

В/Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-ын 6, 3-ын 4 дэх хэсгүүд;

Г/Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 10, 13 дугаар зүйл;

Д/Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгүүд;

Е/Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 23 дугаар зүйлүүдээс үзвэл тухайн албан тушаалтнуудыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийн нь нотлох баримттайгаар баривчилсан бол тэр тухай холбогдох байгууллага албан тушаалтанд

нь тодорхой хугацааны дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд зохих эвлүүлэгийг цагдан хорих түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно" гэсэн нийтлэг агуулга илэрч байгаа бөгөөд үүнд баривчлах болон шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах гэдэг ойлголтуудыг өөр өөр агуулгаар тайлбарлажээ.

Иймд Захиргааны хариуцлагын тухай болон Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд заасан "баривчлах шийтгэл" гэсэн нэр томьёо нь дээр дурдсан хуулиудын утга санаатай зөрчилдөж байгаа тодийгүй Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчиж, агуулгын хувьд гажуудуулж байгааг хянан шийдвэрлэх өгөхийг хүсч Захиргааны хариуцлагын тухай хууль болон Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиудад буй дээрх заалт, нэр томьёог хүчингүй болгуулах тухай саналаа дэмжиж байна" гэжээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын даргын 2001 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 204 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Долгор гаргасан тайлбартаа:

"Иргэн П.Баттогтох нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3-т "Хууль заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг Захиргааны хариуцлагын тухай хуульд болон Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд заасан баривчлах шийтгэлийн талаархи зүйл, заалт зөрчиж байгаа гэж үзэж, түүнийг хүчингүй болгуулах хүсэлт гаргажээ.

Иргэн П.Баттогтох Монгол Улсын Үндсэн хуульд заасан "баривчлах" гэсэн нэр томьёог захиргааны шийтгэлийн утгаар хэрэглэж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил мөн гэж үзжээ.

Үүнийг бид дараахь үндэслэлээр Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т заасан заалт нь нэг талаас бусдын эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахыг үүрэг болгосон заалт бөгөөд нэгжих, баривчлах, хорих зэрэг хэлбэрүүд нь хүний эрх чөлөөг хязгаарлах ойлголтуудыг багтааж байна.

- Үүнээс үүдэн "баривчлах" гэсэн нэр томьёог зөвхөн саатуулан баривчлах гэсэн нэр утгаар тайлбарлахаас гадна эрх чөлөөг хязгаарласан захиргааны шийтгэл гэсэн өөр утгаар зарим хуульд хэрэглэснийг буруу гэж үзэн үндэслэлгүй юм.

- Түүнчлэн Үндсэн хуулийн ойлголтыг буса, хуулиар тодруулан тайлбарлаж хэрэглэж байгаа бөгөөд энэ нь тухайн хуулиудад хэрэглэсэн нэр томьёогоор ойлгогдож, тодорхой хуулиудад өөр өөр утгаар хэрэглэгдэхийг ч үгүйсгэхгүй юм.

Иймд Үндсэн хуулийн дээрх зүйл, заалты агуулгын үүднээс авч үзвэл хүний эрх чөлөөг хязгаарлах нэг хэлбэр болж байгаа "баривчлах" гэсэн нэр томьёо нь дээрх өргөн утгыг агуулж байгаа тул дурдсан хуулиудаар тодорхой эхтэздийн саатуулан баривчлах буюу захиргааны журмаар ногдуулж байгаа баривчлан саатуулах шийтгэлийг хэрэглэж байгааг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэхгүй байна.

Харин цаашид хууль хэрэглэхэд хялбар дөхөм болгох, нэр томьёог нэг мөр жигдлэх, боловсронгуй болгох үүднээс анхаарал хандуулах асуудал байхыг үгүйсгэхгүй юм" гэжээ.

Үндсэн хуулийн Цэцийн дунд суудлын ралдаан дээр П.Баттогтох гаргасан тайлбартаа, рх зүйн хувьд "баривчлах" гэдэг ойлголт, нэр мъёо өөр өөр хуулиар янз бүрийн агуулгаар эрхийлэгдэж байгаа нь нэр томъёоны хувьд ндсэн хуулийг зөрчиж байна" Үндсэн хуулийн дсэн агуулга нь "баривчлах" гэдэг үгийн хувьд оцессын үйл ажиллагаа юм" гэжээ. Хуралдааны эцад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, лсын Их Хурлын гишүүн Б.Долгор гаргасан айлбартаа, "Монгол Улсын Үндсэн хуульд хүний рх, эрх чөлөөг хязгаарлах хэлбэрийн нэг нь баривчлах" гэдэг ойлголт юм. Иймээс ерөнхий гтын үүднээс хуулиудад,

1.Тодорхой эттэздийг саатуулж баривчлах;

2.Захиргааны журмаар эрх чөлөөг язгаарлах агуулгаар хуулиудад тусгаж байна. Энэ ь "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн өсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" уулийн 13 дугаар зүйлийг үндэслэл болгож байгаа ом" гэжээ.

ХЯНАВАЛ:

1.Захиргааны хариуцлагын тухай хууль олон захиргааны журмаар албадан хөдөлмөр ийлгэх тухай Монгол Улсын хуульд заасан баривчлах" гэдэг ойлголт нь Монгол Улсын Үндсэн уулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчсөн эх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.Хууль тогтоогч өөрийн эрх хэмжээний үрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт байгаа "баривчлах" гэсэн ойлголтын үндэслэл, журмыг хуульчлан тогтоосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн Арван есдүгээр зүйл, Үндсэн хуулийн Цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн Гучин гуравдугаар зүйлийг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1.Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн "баривчлах" гэсэн ойлголт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-д буй "...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно..." гэсэн заалтыг зөрчеегүй байна.

2.Үндсэн хуулийн Цэцэд Маргаан хянан шалгах тухай хуулийн Гучин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор авч хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД **Ж.АМАРСАНАА**
Ч.ДАШНЯМ
Ц.САРАНТУЯА
В.УДВАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 2 (239)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай*
- *Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны нэгдүгээр сарын 10 №2 (23

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

15. Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2001-12-13-ны хууль) 33
16. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 34
17. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 34

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

18. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 100 34
19. Шинжлэх ухааны ажилтны өдөр бий болгох тухай Дугаар 101 35

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

20. Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай Дугаар 264 35
21. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай Дугаар 265 42
22. Хөтөлбөр батлах тухай Дугаар 266 47
23. Байр шилжүүлэх тухай Дугаар 267 55
24. Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай Дугаар 269 56
25. Үндэсний спортын хоёрдугаар их наадам зохион байгуулах тухай Дугаар 270 56
26. Хөрөнгө гаргах тухай Дугаар 272 56

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 2 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хүчин төгөлдө болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "9.2.15. борлуулсан алт" гэсэн заалт, 11.4.2 дахь заалтын "бусад терлийн" гэсний өмнө "хууль тогтоомжийн дагуу улсын төвлөрсөн төсөвт орох" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6.3 дахь хэсгийн "Алтнаас бусад" гэсний хассугай.

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 17, 18 дахь заалт нэмсүгэй:

"17/ "үндсэн орд" гэж геологийн хувьсал өөрчлөлтийн дунд бүрэлдэн тогтож, анх үүссэн нутуулагтайгаа нэг орон зайд байрлаж байгаа эрдэс баялгийн хуримтлалыг;

18/ "шороон орд" гэж анхлан үүссэн нутуулаг, орон зайнаасаа өөршил, элэгдэл, механик үйл явцын дунд салж сарнин, дахин хуримтлагдаж, үе давхрага байдалтайгаар байгаа эрдэс баялгийн хуримтлалыг."

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шороон ордоос олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь борлуулалтын үнэлгээний 7,5 хувьтай тэнцүү байна" гэсэн 2 дахь өгүүлбэр, мөн зүйлийн 1 дэх хэсэг болон 61 дүгээр зүйлд "төлбөрийг" гэсний дараа "төвлөрсөн болон" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 16 дахь заалтаас "тус тус хэлнэ" гэсний хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр — Дугаар 100 — Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1/Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй уялдуулан Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг өөрчлөн шинэчлэх, Санхүүгийн хяналт шалгалтын тухай хуулийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

1.Дараахь ажлуудыг зохион байгуулж зэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

2/Монгол Улсад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн үндэсний стандартыг холбогдох дүрэм, журам, зааврын хамт 2002 оны эхний улиралд багтаан боловсруулан, баталж, мөрдүүлж эхлэх;

3/2002 оныг улсын хэмжээнд "Бүртгэлийн ажлыг сайжруулах жил" болгон тусгай хөтөлбөр боловсруулж ажиллах;

4/Төсвийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг шинэчилж, тусгайлсан хөтөлбөрийн дагуу санхүү, бүртгэлийн ажилтнуудыг давтан сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

5/нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны улсын гуравдугаар зөвлөгөөнийг 2003 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулж, бүртгэл, эдийн засгийн тулгамдсан асуудлыг авч хэлэлцэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баярцайхан/ -д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 101** **Улаанбаатар хот**

Шинжлэх ухааны ажилтны өдөр бий болгох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Жил бүрийн арваннэгдүгээр сарын дөрөв дэх Ням гарагийг Шинжлэх ухааны ажилтны өдөр болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 264** **Улаанбаатар хот**

Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай

Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ховор амьтны жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-г 2 дугаар хавсралт, "Агнуурын нөөц ашигласны төлбөр, агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ"-г 3 дугаар хавсралт, "Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг хэмжээ"-г 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Ан амьтныг тэжээврээр үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэх зориулалтаар ашиглах журмыг 2001 онд багтаан баталж мөрдүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад зааснаас бусад ан амьтныг агнах, барих, гадаадад гаргах талбар болон хураамжийн хувь хэмжээг тухайн амьтны тархац, экологи-эдийн засгийн ач холбогдол, агнах, барих зориулалтыг харгалзан тухай бүр тогтоож байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад зарим өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 118 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ХОВОР АМЬТНЫ ЖАГСААЛТ
(Монгол, латин нэрээр)

Нэг. ***Хөхтөн***

1.	Аргаль	Ovis ammon
2.	Янгир	Capra sibirica
3.	Хулан	Equus hemionus
4.	Хар сүүлтий	Gazella subgutturosa
5.	Халиун буга	Cervus elaphus
6.	Зэгсний гахай	Sus scrota nigipes
7.	Говийн шилүүс	Felis lynx gobinsis
8.	Хадны суусар	Martes foina
9.	Цоохондой	Felis lybica
10.	Эрээн хүрнэ	Vormela peregusna
11.	Ойн булга	Martes zibellina
12.	Гозоорой зурам	Citellus alaschanicus

Хоёр. ***Шувуу***

1.	Алтайн хойлог	Tetraogallus altaicus
2.	Манхин галуу	Anser albifrons
3.	Хээрийн галуу	Eulabea indica
4.	Хошуу галуу	Cygnopsis cygnoides
5.	Одой галуу	Anser erythropus
6.	Хуруут хун	Cygnus olor
7.	Гунгар хун	Cygnus bewickii
8.	Байгалийн нугас	Anas formosa
9.	Ухаа шумбуур	Aythya baeri
10.	Халзан ангир	Aix galericulata
11.	Ямаан сүүлт	Oxyura leucocephala
12.	Усны бух шувуу	Botaurus strellaris
13.	Цасч дэглий	Egreetta alba
14.	Халбаган хошуут	Platalea leucorodia
15.	Дорнын өрөвтас	Ciconia boyciana
16.	Хар өрөвтас	Ciconia nigra
17.	Хонин тоодог	Ofis tarda
18.	Азийн цууцал	Limnodromus semipalmatus
19.	Хилэн жигүүрт	Himantopus himantopus
20	Эгэл хүрзгэнэ	Steptopelia tirtur
21.	Цагаан шонхор	Falco rusticolus
22.	Амарын шонхор	Falco amurensis

Гурав. ***Загас***

1.	Цагаан амар	Ctenopharyngodon idella
2.	Давх	Hypophthalmicthus molitrix.

Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АН АМЬТНЫ ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/мянган төгрөгөөр

	Ан амьтны нэр	Экологи-эдийн засгийн үнэлгээ
	Нэг. ***Хөхтөн***	
1.	тахь	250,0
2.	хулан	100,0
3.	хавтгай	280,0
4.	аргаль	9000,0
5.	янгир	500,0
6.	халиун буга	500,0
7.	хандгай	280,0
8.	цаа буга (зэрлэг)	150,0
9.	баданга хүдэр	260,0
10.	бор гөрөөс	20,0
11.	зэрлэг гахай	25,0
12.	монгол бөхөн	40,0
13.	хар сүүлтий	300,0
14.	цагаан зээр	6,0
15.	саарал чоно	7,0
16.	үнэг	8,0
17.	хярс	6,0
18.	цоохор ирвэс	500,0
19.	шилүүс	80,0
20.	ойн булга	40,0
21.	суусар	30,0
22.	голын халиу	30,0
23.	минж	80,0
24.	ондатор	6,0
25.	нохой зээх	6,0
26.	мануул	18,0
27.	дорго	35,0
28.	хүрэн баавгай	250,0
29.	мазаалай	350,0
30.	тарвага а/ алтайн	4,0
31.	б/ хээрийн	3,0
32.	туулай, чандага	0,5
33.	илбэнх	0,5
34.	өмхий хүрнэ	2,0
35.	эрээн хүрнэ	2,0
36.	солонго	0,5
37.	үен	0,5
38.	хэрэм	1,0
39.	цоохондой	0,8
40.	гозоорой зурам	0,5
41.	бусад төрлийн зурам	0,3
42.	жирх	0,5
	Хоёр. ***Шувуу***	
1.	гангар хун	50,0
2.	гунгар хун	40,0
3.	хүрүүт хун	40,0
4.	хар, цагаан, цэн тогоруу	50,0
5.	алаг тогоруу	25,0
6.	жороо тоодог	50,0

7.	хонин тоодог	12,0
8.	борцгор хотон	100,0
9.	халбаган хошуут	6,0
10.	хар ба дорнын өрөвтас	10,0
11.	хошуу галуу	0,8
12.	хээрийн галуу	0,8
13.	манхин галуу	0,8
14.	бусад төрлийн галуу	0,7
15.	гургуул	20,0
16.	алтайн хойлог	50,0
17.	байгалийн нугас	1,0
18.	бусад төрлийн нугас болон ус, намгийн шувуу	0,5
19.	ухаа шумбуур	1,0
20.	халзан ангир	1,0
21.	ямаан сүүлт	1,0
22.	усны бух шувуу	1,0
23.	цасч дэглий	1,0
24.	азийн цууцал	1,0
25.	хилэн жигүүрт	1,0
26.	эгэл хүрзгэнэ	1,0
27.	бэгбаатар, ууль, шар шувуу	6,0
28.	бүх төрлийн шонхор	300,0
29.	хур, сойр	0,8
30.	хөтүү, ятуу, хахилаг, ногтруу	0,5
31.	тас, ёл	5,0
32.	бүргэд, сар, харцага	6,0
	*Гуравр. **Загас***	
1.	хилэм: а/ урт нь 1 м-ээс дээш	20,0
	б/ урт нь 1м. хүртэл	15,0
2.	тул: а/ урт нь 1 м-ээс дээш	10,0
	б/ урт нь 1м. хүртэл	3,0
3.	омоль	0,3
4.	дархадын цагаан	0,3
5.	булуу цагаан	0,2
6.	хадран	0,1
7.	зэвэг	0,2
8.	зарам	0,2
9.	жарга	0,1
10.	гутаарь	0,1
11.	цурхай	0,1
12.	цулбуурт	0,08
13.	цагаан амар	1,0
14.	дэвх	1,0
15.	үхэрдэй	1,0
16.	бусад загас	0,05

Тайлбар: Хээлтэгч амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоохдоо тухайн зүйл амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 70 хувиар, төл амьтныг 30 хувиар тус тус тооцно.

Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

/мянган төгрөгөө

Ан амьтны нэр		Агнуурын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ		Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ
		Үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих	Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих	
Нэг. ***Хөхтөн***				
1.	тахь		50,0	
2.	хулан		20,0	
3.	хавтгай		56,0	
4.	аргаль		1800,0	
5.	янгир		100,0	
6.	халиун буга.		100,0	
7.	хандгай		56,0	
8.	цаа буга		30,0	
9.	баданга хүдэр		52,0	
10.	бор гөрөөс		4,0	4,0
11.	зэрлэг гахай		5,0	5,0
12.	бөхөн		8,0	
13.	хар суүлтий		60,0	
14.	цагаан зээр	1,2	1,2	1,8
15.	саарал чоно *		1,4	
16.	үнэг		1,6	2,4
17.	хярс		1,2	1,8
18.	цоохор ирвэс		100,0	
19.	шилүүс		16,0	
20.	ойн булга		8,0	
21.	хадны суусар		6,0	
22.	голын халиу		6,0	
23.	минж		16,0	
24.	ондатор**		1,2	
25.	нохой зээх**		1,2	
26.	мануул**		3,6	
27.	дорго**		7,0	
28.	хүрэн баавгай**		50,0	
29.	мазаалай		70,0	
30.	туулай, чандага**		0,1	
31.	тарвага а/ алтайн	0,8	0,8	0,8
32.	б/ хээрийн	0,6	0,6	0,6
33.	илбэнх**		0,1	
34.	өмхий хүрнэ**		0,4	
35.	эрээн хүрнэ		0,4	
36.	солонго**		0,1	
37.	үен**		0,1	
38.	хэрэм**		0,2	
39.	цоохондой		0,16	
40.	гозоорой зурам		0,1	
41.	бусад төрлийн зурам**		0,06	
42.	жирх**		0,1	
Хоёр. ***Шувуу***				
1.	гангар хун		10,0	

2.	гунгар хүн		8,0	
3.	хуруут хүн		8,0	
4.	хар, цагаан, цэн тогоруу		10,0	
5.	алаг тогоруу		5,0	
6.	жороо тоодог		10,0	
7.	хонин тоодог		2,4	
8.	борцгор хотон		20,0	
9.	халбаган хошуут		1,2	
10.	хар ба хар хошуут өрөвтас		2,0	
11.	хошуу галуу		0,16	
12.	хээрийн галуу		0,16	
13.	манхин галуу		0,16	
14.	одой галуу		0,16	
15.	бусад төрлийн галуу**		0,14	
16.	гургуул		4,0	
17.	хойлог		10,0	
18.	байгалийн нугас		0,2	
19.	бусад төрлийн нугас ба ус, намгийн шувуу		0,1	0.2
20.	ухаа шумбуур		0,2	
21.	халзан ангир		0,2	
22.	ямаан сүүлт		0,2	
23.	усны бүх шувуу		0,2	
24.	цасч дэглий		0,2	
25.	азийн цууцал		0,2	
26.	хилэн жигүүрт		0,2	
27.	эгэл хүрэгэнэ		0,2	
28.	бэгбаатар, ууль, шар шувуу**		1,2	
29.	бүх төрлийн шонхор		60,0	
30.	хур, сойр		0,16	0,32
31.	хөтүү, ятуу, хахилаг, ногтруу		0,1	0,2
32.	тас, ёл		1,0	
33.	бүргэд, сар, харцага		1,2	1,2 /зөвхөн бүргэд/

Тайлбар:

1. *Чоныг ахуйн зориулалтаар төлбөр хураамжгүйгээр агнана.

2. Энэ хавсралтад од (**) тэмдэг тавигдсан ан амьтныг ахуйн зориулалтаар агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийг баримталж тогтооно.

3. Энэ хавсралтын дээрх тэмдэгтэйгээс бусад ан амьтныг Ан амьтны тухай хуульд заасны дагуу агнахыг хориглоно.

4. Энэ хавсралтад нэр дурдаагүй ан амьтныг аливаа зориулалтаар агнах, барих шаардлага гарсан тохиолдолд зориулалтыг нь харгалзан төлбөр, хураамжийн хувь хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5. Үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар загас барихад төлбөрийг килограмм тутамд 30 төгрөгөөр, хураамжийг экологи-эдийн засгийн үнэлгээний 3 хувиар тооцно.

6. Монгол Улсын иргэн болон түс улсад түр буюу байнга оршин сууж буй гадаадын иргэн ахуйн зориулалтаар загас барих 1 удаагийн эрхийн бичгийн үнэ 600 төгрөг болно.

Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭНД ТУСГАЙ ТӨЛБӨРТЭЙГЭЭР АГНУУЛАХ АГНУУРЫН АМЬТНЫ ОЛЗВОРЫН ЖИШИГ ҮНЭ, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

/ам. доллараар

	Ан амьтны нэр	олзворын жишиг үнэ	төлбөр	хураамж
Нэг. ***Хөхтөн***				
1.	Угалз а/ алтайн	20000,0	14000,0	4000.0
	б/ говийн	10000,0	7000,0	2000,0
2.	Тэх а/ алтайн	900,0	550,0	250,0
	б/ говийн	800,0	520,0	200,0
3.	Халиун буга	1300,0	850,0	320,0
4.	Хар сүүлтий	500,0	325,0	125,0
5.	Цагаан зээр	100,0	65,0	25,0
6.	Бор гөрөөс	600,0	400,0	150,0
7.	Зэрлэг гахай	250,0	160,0	65,0
8.	Баавгай	2500,0	1600,0	650,0
9.	Чоно	250,0	160,0	65,0
10.	Шилүүс	2000,0	1300,0	500,0
11.	Үнэг	80,0	50,0	20,0
12.	Хярс	60,0	40,0	15,0
13.	Дорго	80,0	50,0	20,0
14.	Нохой зээх	300,0	200,0	70,0
15.	Мануул	80,0	50,0	20,0
Хоёр. ***Шувуу***				
16.	Хур	100,0	65,0	25,0
17.	Сойр	120,0	75,0	30,0
18.	Ой хээрийн бусад агнуурын шувуу	5,0	3,0	1,0
19.	Галуу	10,0	6,0	2,0
20.	Нугас	4,0	2,0	1,0
Гурав. ***Загас***				
21.	Тул: бариад усанд нь эргүүлж тавих	50,0	35,0	10,0
22.	Тулын олзворыг авч гарах бол:			
	а/ урт нь 1м хүртэл	100,0	65,0	25,0
	б/урт нь 1м-ээс дээш	200,0	130,0	50,0
23.	Бусад агнуурын загас	4,0	2,0	1,0

Жич: Тусгай зориулалтаар ус, намаг, ой, :эрийн агнуурын шувууг агнах, барихад нэг удаад зөвшөөрөгдөх тоо 20 хүртэл, агнуурын бусад загасны тоо 30 хүртэл байхаар тооцно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 265 Улаанбаатар хот

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2001 оны 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цөмийн энергийн комиссыг Ажлын алба, Цацрагийн хяналтын алба, Изотоп төв гэсэн нэгж бүхий бүтэцтэйгээр баталж дэд дарга 1, хариуцлагатай нарийн бичгийн дарга 1 байхаар тогтоосугай.

2. Цөмийн энергийн комиссын орон тоо, цалингийн санг батлаж мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Цөмийн энергийн комиссын дарга А.Цанжид нарт даалгасугай.

3. Цөмийн энергийн комиссын дүрмийг 1 дүгээр хавсралт, Цацрагийн улсын хяналтын дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

4. Цацрагийн судалгаа, хяналтын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, гарааш, улсын хил дээр цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр хангах, Изотоп төвийг улсын онцгой объектын шаардлагад нийцсэн харуул, хамгаалалттай болгох арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн төсөв болон гадаадын техникийн туслалцаатайгаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

5. Цөмийн энергийн комиссыг ажлын байр, цацрагийн судалгаа, хяналтын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, гараашаар хангахыг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цацрагийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 180 дугаар тогтоол, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 215 дугаар тогтоол, "Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 151 дүгээр тогтоолын 1, 2, 4 дүгээр зүйл, "Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2001 оны 265 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Цөмийн энергийн комисс (цаашид "комисс" гэх) нь цөмийн судалгаа, технологийг хөгжүүлэх, цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн бусад үүсгүүр (цаашид "цацрагийн үүсгүүр" гэх)-ийг ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулж, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх Засгийн газрын байгууллага мөн.

2. Комисс нь үйл ажиллагаандаа Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3. Комисс нь цөмийн энерги ашиглах, технологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах асуудлаар гадаад орон болон олон улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4. Оросын Холбооны Улсын Дубна хот дахь олон улсын Цөмийн шинжилгээний нэгдсэн институт (ЦШНИ) дэх Монгол Улсын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.

5. Комисс нь улсын төвлөрсөн төсөв болон бусад эх үүсвэрээр санхүүжинэ.

6. Комисс нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Комиссын удирдлага, зохион байгуулалт

7. Комиссын дарга нь шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

8. Дэд дарга нь комиссын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэшлийн хувьд удирдаж, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна. Дэд дарга нь аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг удирдан явуулна. Комиссын даргын үүрэг, эрх, үүний үүргийг дэд дарга гүйцэтгэнэ.

9. Хариуцлагатай нарийн бичгийн дарга нь хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, гадаад дотоодын байгууллагатай харилцах, зохион байгуулалтын дотоод ажил зэргийг үндсэн үйл ажиллагааг хариуцна.

10. Дэд дарга, хариуцлагатай нарийн бичгийн даргыг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

11. Комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг комиссын дарга батална. Комиссын бүрэлдэхүүнд яам, Засгийн газрын агентлагийн холбогдох албан тушаалтан, цөмийн технологи нэвтрүүлж байгаа байгууллагын төлөөлөгч, комиссын ажилтан орно.

12. Ажлын алба нь цөмийн энерги ашиглах, технологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг гүйцэтгэнэ.

13. Цацрагийн хяналтын алба нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

14. Изотоп төв нь ашиглагдахгүй болсон цацрагийн үүсгүүр болон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

15. Изотоп төв нь үйл ажиллагаагаа комиссын даргын баталсан дүрмийн дагуу явуулна.

16. Комиссын дэргэд цөмийн технологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй орон тооны бус Цацрагийн аюулгүйн зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) ажиллана. Аюулгүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг комиссын дарга батална.

Гурав. Комиссын үүрэг

17. Комисс дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/цөмийн энерги ашиглах, цөмийн ехнологи нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, оулгүй байдлыг хангах бодлого боловсруулж эрх үхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх;

б/цөмийн судалгаа, цацрагийн эмгаалалт, аюулгүй байдалтай холбоотой Монгол лсын олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх жлыг зохион байгуулах, түүний явцад хяналт тавих;

в/цөмийн эрчим хүчийг ашиглах, ацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, үүнийг ашиглах, олборлох, боловсруулах, аяжуулах, импортлох, экспортлох, тээвэрлэх, аягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх йл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж, түсгай өвшөөрөл олгох асуудлыг холбогдох төрийн ахиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх;

г/ашиглагдахгүй болсон цацрагийн үсгүүр болон цацраг идэвхт хаягдлыг улсын эмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, йлшлах үйл ажиллагаог хэрэгжүүлэх;

д/цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах дэд бүтцийг (цаашид "дэд бүтэц" эх) хөгжүүлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авах;

е/Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), Цөмийн шинжилгээний нэгдсэн институт (ЦШНИ) болон Цөмийн шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжил, сургалтын Ази, Номхон далайн бүсийн гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, хамтын ажиллагаог хөгжүүлэх;

ж/гадаад орон олон улсын байгууллагын техник, хамтын ажиллагааны тусламжаар хэрэгжих төслийн талаар холбогдох байгууллагатай хамтран санал боловсруулж, түүнийг ОУАЭА-т дэвшүүлэх, батлагдсан төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

з/цацрагийн үүсгүүртэй ажиллагсдын мэдлэг дадлагыг дээшлүүлэх, тэдгээрийг давтан сургах, тусгай хөтөлбөрийн дагуу нарийн мэргэжлийн болон цацрагийн хамгаалалтын мэргэжилтэн бэлтгэх;

и/цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цацрагтай холбогдсон үйл ажиллагаог олон нийтэд мэдээлэх, сурталчилах;

к/Комисс үйл ажиллагааныхаа тайланг жилд нэг удаа гаргаж Засгийн газарт, төсвийн зарцуулалтын тайланг сар, улирал, жилээр гаргаж Санхүү, эдийн засгийн яаманд тус тус тайлагнаж байна.

Дөрөв. Комиссын эрх

18. Комисс нь дор дурдсан эрхийг эдэлнэ:

а/явуулж байгаа үйл ажиллагааныхаа хүрээнд мөрдөх норм, дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэх;

б/үйл ажиллагааныхаа хүрээнд гэрээ хэлэлцээр байгуулах, судалгаа явуулах, захиалгат төсөл хэрэгжүүлэх, лабораторийг байгуулах, орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулах;

в/үндсэн болон эргэлтийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр олсон орлогыг хууль тогтоомжийн дагуу зарцуулах;

г/холбогдох асуудлаар тогтоол, түшаал гаргаж хэрэжүүлэх, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулах ;

д/олон улсын болон бүсийн хурал, зөвлөлгөөн, сургалтад өөрийн орны холбогдох байгууллагын төлөөлөгч, мэргэжилтнийг оролцуулах, туршлага судлах, эрдэм шинжилгээний бага хурал, зөвлөлгөөн, семинар зохион байгуулах.

Засгийн газрын 2001 оны 265 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЦАЦРАГИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Цацрагийн улсын хяналтын зорилт нь Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавьж, цацрагийн осол болон цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн бусад үүсгүүр (цаашид "цацрагийн үүсгүүр" гэх)-ийн үйлчлэлээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх замаар цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад оршино.

2. Цацрагийн улсын хяналтыг Цөмийн энергийн комиссын Цацрагийн хяналтын алба болон цацрагийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ. Цацрагийн хяналтын алба нь цацрагийн хяналтын чиглэлээр биеэ даасан үйл ажиллагаа явуулна. Шаардлагатай бол зарим яам, газар, байгууллага, аж ахуйн нэгжид цацрагийн хяналтын байцаагчийг ажиллуулж болно.

3. Цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө. Цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь цацрагийн хяналтын албаны дарга байна.

4. Цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

5. Цацрагийн хяналтын алба, улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

6. Цацрагийн хяналтын улсын байцаагч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 7.2-т заасан шаардлагыг хангасан цацрагийн хяналтын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байна.

7. Цацрагийн хяналтын алба, улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Цацрагийн улсын хяналтын үндсэн чиг үүрэг

8. Цацрагийн улсын хяналтыг Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаас гадна дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, холбогдох заавар, журам болон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хянах;

б/цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, цацрагтай ажиллагсдын өртөж байгаа шарлагын тунд хяналт тавьж, шарлагын тунгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

в/үйлдвэрлэл, судалгаа, оношлогоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих;

г/хүрээлэн байгаа орчны болон ахуйн өргөн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшинд хяналт-шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч гүйцэтгэх;

д/улсын хилээр нэвтрүүлэх цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд хяналт тавин цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

е/цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, гарсан ослын шалтгааныг тогтоох, хор уршгийг арилгах, цацрагийн ослын үед ажиллах журам, авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

ж/цацрагийн аюулгүйн стандарт,

ıагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай
ıбогдсон дүрэм, журам, зааврыг холбогдох
йууллагатай хамтран боловсруулж батлуулан,
ргжилтэд хяналт тавих;

з/байгаль орчны хяналт-
ижилгээний сүлжээний орчны цацрагийн
ıлтын цэг сүлжээг арга зүйн удирдлагаар хангах;

и/цацрагийн үүсгүүр бүхий багаж
эргсэл, тоног төхөөрөмжтэй ажиллах болон
ıний байрлуулах байгууллага, аж ахуйн нэгжийн
эих барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө,
энологийн зураг төслийг зохиох, газар сонгох,
ıгээрийг барьж ашиглалтад оруулахад мөрдөх
арагийн аюулгүйн стандарт, дүрмийн биелэлтэд
ıалт тавих;

к/цацрагийн үүсгүүр хэрэглэгч
ıгуулагa, аж ахуйн нэгжид ажиллаж байгаа
ıрагийн хяналтын асуудал хариуцсан
ıргэжилтнийг мэргэжил арга зүйн удирдлагаар
ангах, үйл ажиллагааnд нь хяналт тавих,
ıардлагатай асуудлаар авах арга хэмжээний
ıал боловсруулж шийдвэрлүүлэх.

Гурав. Цацрагийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

9. Цацрагийн улсын хяналтын үндсэн чиг
ргийн дагуу цацрагийн хяналт, шалгалтыг
рэгжүүлэхээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/Цацрагийн хамгаалалт, аюулгүй
йдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны
ıгуу цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхлэх
ıгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийг
ıнаж зөвшөөрөл олгох;

б/цацрагтай холбогдсон үйл
киллагаанд цацрагийн аюулгүй ажиллагаа-
ɵзиметрийн хяналт хийх, дүгнэлт гаргах, хүн амын
эүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөх хүчин зүйлээс
ьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг шуурхай
эилгах арга хэмжээ авах, хяналтын үр дүнг
эдээлэх, сурталчилах;

в/цацрагтай холбогдсон үйл
киллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль
эчинд шууд буюу шууд бус замаар үүсэж болох
эрөг нөлөөллийг илрүүлэх, шалтгааныг тогтоох,
нэ талаар бусад мэргэжлийн хяналтын
байгууллагад мэдээлж, зөрчлийг арилгуулах арга
хэмжээ авах;

г/хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулах;

д/Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, цацрагийн аюулгүйн стандарт, дүрэм, заавар, журмыг боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, олон нийтэд сурталчилах.

10. Улсын байцаагч Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан эрх эдэлнэ:

а/цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын үндэсэн шаардлагудыг хангаагүй болон зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн цацрагтай холбогдсон үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;

б/тогтоосон норм, хэмжээнээс их цацрагийн бохирдолтой хүнсний бүтээгдэхүүн, өрөн хэрэглээний бараа импортлох, экспортлох, худалдаалахыг хориглох, устгах;

в/Монгол Улсын нутаг дэвсгэрт цацрагийн бохирдол бий болсон үед шаардлагатай бол хилийн боомт, аймаг, нийслэл, сум, дүүрэгт иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулах болон бусад арга хэмжээ авах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

г/холбогдох хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг цацрагтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс гаргуулж авах;

д/эрх хэмжээнийхээ хүрээнд үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх;

е/цацрагийн хяналтын чиглэлээр дүгнэлт гаргахад шаардагдах шинжилгээ, судалгаа

явуулах лаборатори, шинжээч томилох, холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаа авах.

Дөрөв. Бусад зүйл

11. Цацрагийн хяналтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

12. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бариг, албан тушаалтан, иргэн нь хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсө тухай гомдлоо Цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчид уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор гаргана. Улсын ерөнхий байцаач гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор түүнийг хянан шийдвэрлэнэ.

13. Улсын байцаагч нь үүрэгт ажлаа зөвөөр ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 266** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сонгодог урлагийг дэмжих "Сонгодог урлаг" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар ханган ажиллахыг Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2001 оны 266 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"СОНГОДОГ УРЛАГ" ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Аливаа улс орны хөгжил дэвшлийн нэг илэрхийлэл бол тухайн орны урлаг, соёл түүний дотор сонгодог урлагийн хөгжил дэвшил, урьян сангийн баяжилт, түүний өвлөн уламжлагдаж байгаа байдал юм.

Монгол Улсад дэлхийн сонгодог урлаг XX зууны эхнээс үндэсэн сууриа тавин хөгжиж ирсэн боловч зах зээлийн тогтолцооны шилжилтийн үед сонгодог урлагийн хөгжилийг эрчимжүүлэх, шинэ уран бүтээл туурвих, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд төрийн цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна.

Сонгодог урлагийг дэмжих хүрээнд манай улсад үндэсний соёлын өвийг дэлхийн соёлын ололттой хослуулж, уран бүтээлийн чанар, хүн аяын соёлын түвшинг дээшлүүлэх, хүүхэд залуучуудад гоо сайхны хүмүүжил олгох, тэдний гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулах нь чухал юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого,үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх нөхцөл бололцоог ханган, хүн амын гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, шинэ уран бүтээл туурвиж ур

ангаа баяжуулан дэлхийн болон өрнө, дорнын онгодог урлагийн хөгжлийн түвшинд хүргэхэд өтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ор дурдсан зорилтуудыг дэвшүүлж байна:

2.2.1. Сонгодог урлагийг төрийн ивээлд авч, үйл ажиллагаа нь дэмжих, үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан уран бүтээлийн чанарыг дээшлүүлэн хөгжүүлэх;

2.2.2. Сонгодог урлагийг сурталчлах, мэргэжлийн жүжигчдийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад орны мэргэжил нэгт уран бүтээлчдээс суралцах, дэлхийн сонгодог уран бүтээлийг эзэмшиж авьяасаа хөгжүүлэх зорилгоор сонгодог урлагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах;

2.2.3. Сонгодог урлагийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, сонгодог урлагийг иргэдийн хүртээл болгох;

2.2.4. Сонгодог дуурь, бүжгийн жүжиг, хөгжмийн бүтээл, концертын талаархи бүртгэл-мэдээлэл, аудио, видео санг бүрдүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг боловсронгуй болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

3.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- сонгодог урлагийг улсаас санхүүжүүлж, урын сан нь баяжуулах, сонгодог урлагийн уран бүтээлчдийн хөдөлмөр, авъяас чадварыг үнэлэх;
- сонгодог урлагийн нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай уран бүтээлч, мэргэжилтэнг өндөр хөгжилтэй орнуудад төлөвлөгөөний үндэсэн дээр бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, давтан сургах;
- сонгодог урлагийг дэмждэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, сурталчлах;
- жүжигчдийн сургуулилт, дасгалын тусгай зориулалт бүхий хувцас, каски, хөгжмийн зэмсэг бусад эд зүйлсийг шинэчлэх, сургалтад зориулсан нот бичлэг хийхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж санхүүжүүлэх.

3.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- сонгодог урлагийн жүжигчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор бүжгийн жүжиг, сонгодог жүжиг, хөгжмийн олон улсын уралдаан, тэмцээнийг өөрийн оронд зохион байгуулах, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох;
- сонгодог урлагийн мэргэжлийн уран бүтээлчдийг гадаад орнуудад зохиогддог дэлхийн болон тив, олон улсын уралдаан, тэмцээнд оролцоход мэргэжлийн болон зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- сонгодог урлагийг сурталчилж хүн амын гоо зүйн хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх, орон нутгийн театр, чуулгыг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх.

3.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт сонгодог урлагийн талаар зохих мэдлэгтэй болгоход чиглэгдсэн асуудлуудыг тусгах;
- сонгодог уран бүтээлийг сурталчлах ажлыг өрөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулах, үзвэрийн график гарган зохицуулах;
- гадаад орны нарийн мэргэжлийн багш, мэргэжилтэнг урьж мэргэжлийн сургуулиудад сургалт явуулах;
- сонгодог урлагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их сургууль, коллежийн сургалтын материаллаг баазыг шинэчлэх, сургалтын уялдаа холбоог бэхжүүлэх;

- мэргэжлийн онцлогоос шалтгаалан эрт тэтгэвэр тогтоолгосон уран бүтээлчдийг ерөнхий боловсролын сургуулиудад дуу хөгжим, урлагийн түүхийн багшаар ажиллуулах талаар арга хэмжээ авах;

3.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- сонгодог бүтээлийн хувцас, тайз, бичлэг, дарамж (клавир), удирдвар (партитура)-ыг хадгалж хамгаалан, тэдгээрийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

- сонгодог бүтээлийг нийтлэх, хэвлүүлэх үйл ажиллагаагаа зохион байгуулах;

- радио, телевизийн хөтөлбөр, нэвтрүүлгийн төлөвлөгөөнд дэлхийн сонгодог урлагийн бүтээлийг оруулах, улсын сан хөмрөг, фондод хадгалж үлдээх;

- гадаад орнуудад өөрийн орны сонгодог бүтээлийг сурталчлах, айлчлан тоглолт хийх, гадаадын байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах;

- дэлхийн соёлын үнэт өв сонгодог урлагийн талаархи сурталчилгааг өргөжүүлэх, түүнтэй уялдсан арга хэмжээг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах.

3.5. Хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дараахь үүрэг хүлээнэ:

Засгийн газар:

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нягт уялдуулах;

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжих.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

- хүн төрөлхтний соёлын үнэт өв сонгодог урлагийн түүх, уламжлал, урлагийн бүтээлийг туурвиж иргэдэд хүргэх зорилгоор тэдгээрийг судлан сурталчлах, өвлөн уламжлуулах, бүтээн туурвих, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

- сонгодог урлагийг хөгжүүлэх стратегийг тодорхойлж, түүнийг үе шаттай хэрэгжүүлэх, сонгодог урлагийг хөгжүүлэх орчинг бүрдүүлэх асуудлыг зохицуулах;

- төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, сонгодог урлагийг дэмжих сонирхогчдын нэгдэл, холбоо, авьяастнуудтай хамтран ажиллах;

- сонгодог урлагийг дэмжиж үр дүнтэй ажил зохион байгуулдаг хамтлаг, нэгдэл, холбоо, авьяастнуудыг урамшуулан дэмжих;

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажилд идэвхтэй оролцох, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Төрийн захиргааны орон нутгийн байгууллагууд:

- хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага /орон нутгийн хэвлэл, мэдээлэл, соёл, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж/, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж удирдлагаар хангаж ажиллах.

Хэвлэл, мэдээллийн байгууллагууд:

- сонгодог урлагтай холбогдох нийтлэл, сурталчилгаа, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн чанарыг

дээшлүүлж арга хэлбэрийг боловсронгуй болгох;

- сонгодог урлагийн уран бүтээлч, авьяастныг дэмжин, тэдний бүтээл, авьяас чадварыг нийтэд сурталчлах.

Дерев. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах үүргийг зөвлөл эрхэлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаг улсын хэмжээнд мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүргийг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгуулагуудын оролцоотойгоор гүйцэтгэнэ.

4.3. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулах үүргийг аймгийн Боловсрол, соёлын төв, нийслэлийн соёлын газар, сонгодог урлагийн талаар сургалт, сурталчилгаа явуулах үүргийг мэргэжлийн урлагийн байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.

4.4. "Сонгодог урлаг хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Зөвлөл нь ажлаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан жилээр төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн IY улиралд Засгийн газарт тайлагнаж байна.

4.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

а/Монгол Улсын соёл, урлагийн талаар гаргасан хууль, тогтоомж болон стратегийн баримт бичиг, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нийцүүлэх;

б/боловсрол, урлаг, соёл, хүүхдийн байгууллагын сургалт болон гоо зүйн хүмүүжлийн үйл ажиллагаагаар дамжуулан сонгодог урлагийг сурталчлах чиглэлээр зохион байгуулах ажлын арга барил, уялдаа холбоог шинэчлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2002-2008 онд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дараахь гурван үндсэн хэсэгт хуваан төлөвлөнө:

-улсын хэмжээнд сонгодог урлагийн мэргэжлийн байгууллага, уран бүтээлчдийн дунд уралдаан, наадам зохион байгуулах;

-дэлхийн шилдэг дуурь симфони бүжгэн жүжигийг найруулан тавих;

-гадаад орны мэргэжил нэгт уран бүтээлчидтэй хамтран тоглож, олон улсын тэмцээн, уралдаанд оролцож, сонгодог урлагийн сурталчилгааг өргөжүүлэх.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн зардлыг Соёл, урлагийн сангаар дамжуулан санхүүжүүлнэ. Сонгодог урлагийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- улсын төвлөрсөн төсөв;
- соёл, урлагийг дэмжих тусгай зориулалт бүхий сан;
- гадаад орон болон олон улсын байгууллагын хөрөнгө;
- гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгө.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

1. Уран бүтээлчдийн сонгодог уран бүтээл туурвих үр чадвар өсч, нийт хүн амын сонгодог урлагийн талаархи мэдлэг дээшилнэ.

2. Сонгодог урлагийн урьн сан баяжиж, дэлхийн сонгодог урлагийн хөгжлийн түвшинд хүрнэ.

3. Сонгодог урлагийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн тогтолцоо бүрдэж сонгодог урлагийг дэмжих дотоод, гадаадын байгууллага, иргэдийн тоо өсч түүнд чиглэсэн тусламж дэмжлэг нэмэгдэнэ.

4. Сонгодог урлагийн төрлүүд болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцох оролцоо нэмэгдэн, өөрийн оронд зохион байгуулах арга хэмжээний зохион байгуулалт боловсронгуй болно.

5. Сонгодог урлагийг хөгжүүлэх, сурталчлах ажлын зохицуулалт боловсронгуй болно.

"СОНГОДОГ УРЛАГ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

а/ БОЛОВСРУУЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Арга хэмжээ	Шаардагдах хөрөнгө /сая, төг/								Хариуцах байгуул-лага	Санхүү-жилтийн эх үүсвэр
		2002	2003	2004	2005	2006	2007	2008	Бүгд		
1	Хүүхэд,залуучуудад сонгодог урлагаар дамжуулан гоо зүйн хүмүүжил олгох асуудлыг эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх /Хүүхэд, залуучуудын сэдэвт бүтээлүүдийг сэргээн тоглох үзвэр зохион байгуулах/	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	70.0	БСШУЯ-ны холбогдох газрууд, мэргэжлийн урлагийн байгуул-лагууд	Соёл урлагийн сан
2.	Орон нутгийн театруудын гэрэл, дууны техникийн шинэчлэх төсөл хэрэгжүүлэх	20.0	20.0	20.0	20.0	20.0	20.0	20.0	140.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТеатр	-"-
3	Сонгодог урлагийн жүжигчдийг бэлтгэж ирсэн уламжлалыг сэргээж, хөрш зэргэлдээ орнуудад групп жүжигчид бэлтгэх асуудлыг судлан шийдвэрлэх	**110.0**	**110.0**	**220.0**	**220.0**	**220.0**	**220.0**	**220.0**	**1320.0**	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, ХБК	Сургал-тын төрийн сан
4	Сонгодог урлагийн академик театрын тайзнаа жилд шинээр туурвигдах уран бүтээлийн хэмжээ, санхүүжилтийн асуудлыг судлан шийдвэрлүүлэх	15.0	17.0	15.0	15.0	15.0	17.0	17.0	111.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ	Улсын төсөв

5	Сонгодог урлагийн төрлөөр болдог тив, дэлхийн болон олон улсын чанартай уралдаан, наадмуудад уран бүтээлчдийг бэлтгэн оролцуулах	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	35.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, СУИС, ХБК	Соёл, урлагийн сан, төсөл
6	Хөгжмийн зэмсгийг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх		20.0		10.0		10.0		40.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, СУИС, ХБК	Улсын төсөв, төсөл
7	Сонгодог хөгжмийн /клавир, партитура/ нот, аудио, видео санг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх,хэрэгжүүлэх	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	28.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ,СУИС, МХЗЭХ,ХБК	Улсын төсөв
8	Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах	20.0	20.0	20.0	20.0	20.0	20.0	20.0	140.0	БСШУЯ-ны СУБЗГ, МУЭХ	Соёл, урлагийн сан
9	Хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг улсын санд худалдаж авах	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	84.0	БСШУЯ-ны СУБЗГ	-"-
10	Улсын циркийн сандал шинэчлэх	10.0							10.0	БСШУЯ-ны СУБЗГ, Улсын цирк	-"-
11	Хүүхэлдэйн театрын засвар хийх	10.0							10.0	БСШУЯ-ны СУБЗГ	-"-
12	Баримтат кино хийх "Түүхийн хүрд"	39.0	39.0	39.0	39.0	39.0	39.0	39.0	273.0	БСШУЯ-ны СУБЗГ, Кино нэгтгэл	-"-
13	Улсын симфони найрал хөг-жимфдийн хувцсыг шинэчлэх	10.0							10.0	БСШУЯ-ны СУБЗГ	-"-
14	Дорнод аймгийн симфони найрал хөгжимчдийн хувцсыг шинэчлэх	5.0							5.0	БСШУЯ-ны СУБЗГ	-"-
					Бүгд				**2.166.0 төгрөг**		

6/ УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ УРАЛДААН ТЭМЦЭЭН

№	Арга хэмжээ	Шаардагдах хөрөнгө /сая,төг/								Хариуцах байгуул-лага	Санхүү-жилт
		2002	2003	2004	2005	2006	2007	2008	Бүгд		
1	Ж.Чулууны нэрэмжит өсвөрийн хөгжимчдийн уралдаан	3.0		3.0		3.0		3.0	12.0	БСШУЯ-ны СУБЗГ,ХБК, МУАНХ	Соёл урлагийн сан
2	Утсан хөгжимчдийн наадам				4.0			4.0	8.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	-"-
3	Төгөлдөр хуурчдын наадам				4.0			4.0	8.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	-"-
4	Учиртай гурван толгой дуурийн шилдэг дүрийн уралдаан		3.5			3.5			7.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, СУИС	-"-
5	Дуурийн шилдэг дуучдын уралдаан			3.0			3.0		6.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, СУИС МУАНХ	-"-
6	Үлээвэр хөгжимчдийн улсын уралдаан	4.0			4.0				8.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	-"-
7	Д.Ж.Пуччинийн нэрэмжит "Монгол хан хүү дуулж байна" олон улсын дуурийн П их наадам		35.0						35.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ	Улсын төсөв
	Бүгд								**84.0 төгрөг**		

в/СУРГАЛТ, СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГААНЫ АРГА ХЭМЖЭЭ

№	Арга хэмжээ	Шаардагдах хөрөнгө /сая,төгрөг/								Хариуцах байгууллага	Санхүүжилт
		2002	2003	2004	2005	2006	2007	2008	Бүгд		
1	Мэргэжлийн уран бүтээлчдийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	35.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	Улсын төсөв
2	Үндэсний телевиз, радиогийн нэвтрүүлэгт сонгодог урлагийг суурьшуулах тогтмол нэвтрүүлэгтэй болох	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	7.0	БСШУЯ-ны СУБЗГ, Монголын үндэсний телевиз, Монголын радио	Соёл, урлагийн сан
3	Сонгодог урлаг өндөр хөгжсөн орнуудаас мэргэжилтэн багш нарыг урьж сургалт семинар зохион байгуулах	4.0		4.0		4.0		4.0	16.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	Улсын төсөв
4	Сонгодог урлаг өндөр хөгжсөн орнуудаас мэргэжилтэн урьж зуны академи сургалт зохион байгуулах		4.0		4.0		4.0		12.0	БСШУЯ-ны СУБЗГ, ХБК, СУАТ, СУИС	-"-
5	Мэргэжлийн судлаачдыг бэлтгэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	14.0	БСШУЯ-ны СУБЗГ, СУАТ, СУИС	Төрийн сургалтын сан
Бүгд									**84.0 төгрөг**		

Засгийн газрын 2001 оны 266 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

"СОНГОДОГ УРЛАГ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
Гишүүд:	-Гадаад хэргийн дэд сайд; -Дэд бүтцийн дэд сайд; -Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Соёл, урлагийн сангийн гүйцэтгэх захирал; -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын дарга; -Сонгодог урлагийн академик театрын ерөнхий захирал; -Улсын филармонийн дарга; -Үндэсний жүжгийн академик театрын дарга; -Соёл, урлагийн их сургуулийн захирал; -Хөгжим бүжгийн коллежийн захирал; -Соёл,урлаг судлалын хүрээлэнгийн захирал; -Монголын урлагийн ажилтны нийгэмлэгүүдийн холбооны хорооны дарга /тохиролцсоноор/; -Монголын хөгжмийн зохиолчдын эвлэлийн хорооны дарга /тохиролцсоноор/;
Нарийн бичгийн дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Театр, дүрслэх урлагийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 267** **Улаанбаатар хот**

Байр шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн 2 дугаар байрны "А" хэсгийг Засгийн газрын 10 дугаар байр болгон "Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудын нэгдсэн байр"-ны зориулалтаар Төр, засгийн, Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын мэдэлд шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн 2 дугаар байрны "А" хэсгийг Засгийн газрын 10 дугаар байр болгосонтой холбогдуулан эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах, ерөнхий эзэмшигчийг томилох, байрны ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Ж.Бадраа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 269 | Улаанбаатар хот

Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3,4 дэх заалт, "Засгийн газарт эрх олгох тухай" 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртлэх хугацаанд хаврын тариалалтад зориулж импортлох үрийн буудай болон хүнсний буудайн гаалийн татварын хувь, хэмжээг тус тус "0" байхаар өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 270 | Улаанбаатар хот

Үндэсний спортын хоёрдугаар их наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний спортын хоёрдугаар их наадмыг 2002 онд улс даяар зохион явуулахаар тогтоосугай.

2. Их наадмыг биеийн тамир, спортыг бүх нийтийн хүртээл болгох, үндэсний уламжлалт наадгай, спортын төрлүүдийг хөгжүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өвлүүлэх, сургах, сурталчлах ажлын хүрээнд өндөр хэмжээнд зохион явуулахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 272 | Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Улсын Их Хурлын 2001 оны 73 дугаар тогтоолын 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах зардалд зориулж Засгийн газрын нөөц хөрөнгөөс 70.0 (далан) сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хариуцлагатай редактор: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3 (240)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Үндэсний аюулгүй байдлын тухай*
- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны нэгдүгээр сарын 17 №3 (240

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

27. Үндэсний аюулгүй байдлын тухай (2001-12-27-ны хууль) 58
28. Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 61
29. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 61
30. Төрийн нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 62
31. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 62
32. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 62
33. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 62
34. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2001-12-27-ны хууль) 63
35. Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 63
36. Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 63
37. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 64
38. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай (2001-12-27-ны хууль) 64

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

39. Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээний тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг бүцаах тухай Дугаар 01 64
40. Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 04 65

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

41. Оюунбилэгийн Пүрэвбаатарт МонголУлсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 98 65
42. ОХУ-ын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 99 65
43. Георгий Михайлович Асеевийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 100 65
44. Ороложавын Отгонсүрэнд МонголУлсын ардын багш цол хүртээх тухай Дугаар 103 66
45. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 104 66
46. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 105 66

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

47. Төрийн ажилтны орон сууц барих тухай Дугаар 268 76

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндэсэн зарчим, үндэсний аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаагүйлдвүүлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж

2.1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндэсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт

3.1. "Үндэсний аюулгүй байдал" гэж /цаашид "үндэсний аюулгүй байдал" гэнэ/ Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

3.2. "Үндэсний язгуур ашиг сонирхол"-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

3.3 "Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ.

3.4. Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

3.4.1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;

3.4.2. нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;

3.4.3. иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;

3.4.4. эдийн засгийн аюулгүй байдал;

3.4.5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;

3.4.6. мэдээллийн аюулгүй байдал;

3.4.7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;

3.4.8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;

3.4.9. экологийн аюулгүй байдал.

4 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндэсэн зарчим

4.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дараахь үндэсэн зарчмыг баримтална:

4.1.1. улс, үндэсний хэсэг язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;

4.1.2. хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

4.1.3. хууль дээдлэх;

4.1.4. нэгдмэл, харилцан уялдуулан зохицуулагдсан байх;

4.1.5. шуурхай, тасралтгүй байх;

4.1.6. бодит мэдээлэлд үндэслэх;

4.1.7. төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх;

4.1.8. үндэсний эв нэгдлийг эрхэмлэх;

4.1.9. нээлттэй байх.

5 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

5.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо

6 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтэц

6.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол

Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ.

6.2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндэсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй.

6.3. Улс төрийн нам, эвсэл, төрийн бус байгууллага, Монгол Улсын иргэн үндэсний аюулгүй байдлыг хангах талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно.

7 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага

7.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд:

7.1.1. Байгаль орчныг хамгаалах албa;
7.1.2. Гаалийн албa;
7.1.3. Дипломат албa;
7.1.4. Иргэний хамгаалалтын албa;
7.1.5. Мэргэжлийн хяналтын албa;
7.1.6. Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
7.1.7. Татварын албa;
7.1.8. Тусгай албa.

7.2. Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоо

8 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрх

8.1. Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална.

8.2. Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Үндэсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ерөнхий удирдлагаар хангаж, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох байгууллагуудын ажилтай танилцаж, чиглэл өгнө.

8.3. Монгол Улсын Засгийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

9 дүгээр зүйл. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын оролцоо

9.1. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс сэрэмжилж, энэ талаар үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулах асуудлаар санал өгнө.

10 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо

10.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

11 дүгээр зүйл. Бүх шатны Засаг дарга нарын оролцоо

11.1. Бүх шатны Засаг дарга үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина.

12 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо

12.1. Төрийн байгууллага, албан тушаалтан үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар тогтоосон журмыг сахин биелүүлэх төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хамгаалах, өөрийн хууль ёсны үүрэгт хамаарах мэдээ баримтыг холбогдох дээд байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

12.2. Төрийн байгууллага, албан тушаалтан

үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар Зөвлөлд санал, хүсэлтээ тавих эрхтэй.

12.3. Төрийн байгууллага, албан тушаалтан үндэсний аюулгүй байдлын холбогдолтой асуудлаар шийдвэр гаргах, аливаа хэлбэрээр байр сууриа илэрхийлэхдээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэ хуулийг үндэс болгоно.

13 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо

13.1. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдлэх үүрэгтэй.

13.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллага, албан тушаалтанд санал, хүсэлтээ тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

14 дүгээр зүйл. Иргэний оролцоо

14.1. Монгол Улсын иргэн үндэсний язгуур ашиг сонирхлоо дээдэлж, хуулиар тогтоосон үүргээ биелүүлэх, төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

14.2. Монгол Улсын иргэн үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй асуудлаар төрийн зохих байгууллага, албан тушаалтанд санал, гомдлоо тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

15 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хэрэгжилтэд хяналт тавих

15.1. Улсын Их Хурал нь өөрийн бүтцийн зохих хэлбэрээр дамжуулан энэ хуулийн биелэлтэд хяналт тавина.

15.2. Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, хэрэгжилтэд хяналт тавина.

15.3. Зөвлөлөөс үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй талаар Улсын Их Хуралд жилд нэгээс доошгүй удаа мэдээлж байна.

15.4. Засгийн газар нь бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого болон энэ хуулийг биелүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавина.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

16 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад баримтлах зарчим

16.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэх, шуурхай, үян хатан байх, харилцан мэдээлэл солилцох, төрийн нууцыг хамгаалах зарчмыг баримтална.

17 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

17.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэн уялдуулан зохицуулах чиг үүргийг Зөвлөл хэрэгжүүлнэ.

17.2. Зөвлөл нь энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.2.1. үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлаар холбогдох байгууллагад чиглэл өгөх;

17.2.2. шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах.

17.3. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, Зөвлөлийн шийдвэр болон түүний гишүүдээс өгсөн чиглэлийн дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлаар Зөвлөлийн нарийн бичгийн дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавина.

17.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргэтэй төрийн байгууллагууд нь хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж, хамтран ажиллах үүрэгтэй.

17.5. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллана.

18 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх ажлын хэсэг

18.1. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл харилцан солилцох, Зөвлөлөөс гарах шийдвэрийн төсөл боловсруулахад туслах болон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдөх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байгныи ажлын хэсгийг дор дурдсанаар Зөвлөлийнн дэргэд байгуулна:

18.1.1. Гадаад бодлогын;

18.1.2. Мэдээллийнн аюулгүй байдлын;

18.1.3. Мэргэжлийнн хяналтын;

18.1.4. Тусгай албадын;

18.1.5. Цэргийнн бодлогын;

18.1.6. Шашны асуудлын;

18.1.7. Эдийн засгийнн бодлогын;

18.1.8. Экологийнн бодлогын.

18.2. Ажлын хэсгүүдийг Зөвлөлийнн нарийн бичгийнн дарга удирдлагаар хангаж, үйл ажиллагаань уялдуулан зохицуулна. Ажлын хэсгүүдийнн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зөвлөлийнн гишүүдийнн саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Олон улсын гэрээ ба үндэсний аюулгүй байдал

19.1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийнн бүрэн бүтэн байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд харш олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахыг хориглоно.

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

20.1. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг зөрчигчид Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

21 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зардлын санхүүжилт

21.1. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарах зардлыг улсын төсөөс санхүүжүүлнэ.

21.2. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зардлыг орон нутгийнн төсөв, төсвийн гадуурх хөрөнгийнн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль" гэснийг "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль", 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7, 8, 9" гэснийг "Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 9, 10, 11, 12, 13, 14" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн "Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль" гэснийг "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль", 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага" гэснийг "Тагнуулын байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн "Монгол Улсын аюулгүй байдал" гэснийг "үндэсний аюулгүй байдал" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн "Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль" гэснийг "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль", 16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсгийн заалтаар" гэснийг "Тагнуулын байгууллагын тухай хуулийн 22, 23, 25, 26 дугаар зүйлийн холбогдох заалтаар" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19.4.1 дэх заалтад дор дурдсан агуулгатай дэд заалтууд нэмсүгэй:

"- тагнуул болон гүйцэтгэх ажлын талаархи хууль тогтоомжийн биелэлт;
- улсын хил хамгаалалт;
- төрийн тусгай хамгаалалт;"

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17.2.1 дэх заалтын "-Монгол Улсын аюулгүй байдлыг хангах бодлого", 19.4.1 дэх заалтын "-Монгол Улсын аюулгүй байдал" гэсэн дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын" гэснийг "Үндэсний" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр — **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1992 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр — **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/ 31[1] дүгээр зүйл:

"31[1] дүгээр зүйл. Хил хамгаалах байгууллагын бэлгэ тэмдэг

Хил хамгаалах байгууллага нь бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх жүрмыг хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2/ 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

"14/ улсын хил хамгаалалтын эрх ашигт хамааралтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил зөрчигчийг эрж олох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах."

2 дугаар зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "цэргийн, инженер техникийн" гэсний дараа "улс төр, дипломатын, эдийн засгийн, тагнуулын" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэр, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"Түүний өргөнийг хил хамгаалах байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно".

2/ 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Улсын хил хамгаалалтыг улс орны хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллага, түүний харъяа тусгай анги, салбарыг хил хамгаалах байгууллага гэнэ.

Улсын хил хамгаалах байгууллага нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай штаб, тагнуул, зэвсэглэл, инженер техник, ар тал, хэрэг бүртгэлт, эмнэлэг, хангалт үйлчилгээ, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон шаардлагатай бусад нэгжтэй байна."

4 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "5 км" гэснийг "15 км", 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын "шийдвэрлэх" гэснийг "шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх ажиллагаа явуулах", 17, 30, 31, 34, 36, 37 дугаар зүйлийн "хилийн цэрэг" гэснийг "хил хамгаалах байгууллага", 36 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "хилийн хороо, суманд" гэснийг "хилийн тусгай анги, салбарт" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр — **Улаанбаатар хот**

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуульд дор дурдсан зүйл нэмсүгэй:

1/ 13[1] дүгээр зүйл:

"13[1] дүгээр зүйл. Хилийн тагнуулын алба

13[1].1. Хилийн тагнуулын алба нь хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаархи тагнуулын мэдээгээр ханган үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ.

13[1].2. Хилийн тагнуулын албаны бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүн батална.

13[1].3. Хилийн тагнуулын албаны дүрмийг хил хамгаалах байгууллагын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батална.

13[1].4. Хилийн тагнуулын алба үйл ажиллагаагаа явуулахдаа энэ хуулийн холбогдох зүйлийг дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "цэргийн тагнуулын байгууллага," гэсний дараа "хилийн тагнуулын алба," гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"9.1.5. Хилийн тагнуулын алба нь хил зөрчих, хилийн бүс, зурваст үүсч болох зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон хилийн дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдийг олж тогтоох, улсын хил хамгаалахад шаардлагатай мэдээллээр хил хамгаалах байгууллага, түүний харьяа анги, салбарын удирдлагыг хангах."

2/ 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"11.6. Хилийн тагнуулын алба хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

"10/ хилийн тагнуулын алба нь эрүүгийн хуулийн 79, 79[1], 172[1] дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар."

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "4" гэсний дараа "10" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр **Дугаар 01** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээний тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Шаравдорж, С.Төмөр, Т.Ганди, Д.Базарсад, Д.Цэвээнжав нарын 2001 оны 3 дугаар сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээний тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг тэдгээрээр зохицуулж байгаа харилцаа нь одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зарим хуулийн зохицуулалттай давхардаж байгаа тул бие даасан хууль гаргах шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид нь буцаасугай.

2. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн

хэм хэмжээний дүрмийн төсөл, Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны дүрмийн төсөл болон шаардлагатай бусад хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж 2002 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороо /Д.Дэмбэрэл/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр **Дугаар 04** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 11 дүгээр тойрогт 2002 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр явуулсан нөхөн сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Бямбажавын Өвгөнхүүгийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 98** **Улаанбаатар хот**

Оюунбилэгийн Пүрэвбаатарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Бөхийн чөлөөт барилдааны төрлөөр дэлхий, тив, олон улсын болон Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, 2001 оны дэлхийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяат нь үнэлж бөхийн чөлөөт барилдааны улсын шигшээ багийн гишүүн, "Алтайн барс" бөхийн клубын тамирчин Оюунбилэгийн Пүрэвбаатарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 99** **Улаанбаатар хот**

ОХУ-ын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын "Итера" группийн ерөнхийлөгч Игорь Викторович Макаров, "Газпром" концернийн удирдах зөвлөлийн орлогч дарга Петр Иванович Родионов, "Итера холдинг" нэгдлийн ерөнхийлөгч Валерий Георгиевич Отчерцов нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 100** **Улаанбаатар хот**

Георгий Михайлович Асеевийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Болгар Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсаас БНБУ-д суугаа элчин сайдын яамны орчуулагч, БНБУ-ын иргэн Георгий Михайлович Асеевийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 103 | Улаанбаатар хот

Оролжавын Отгонсүрэнд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, үр өгөөжийг дээшлүүлэх, их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн үе үеийн багш сурган хүмүүжүүлэгчидийг бэлтгэхэд оруулж байгаа дорвитой хувь нэрийг нь үнэлж Улсын багшийн их сургуулийн физикийн тэнхмийн эрхлэгч Оролжавын Отгонсүрэнд Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 104 | Улаанбаатар хот

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухаан, хуулийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс орноо хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэрийг нь үнэлж дор дурьдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛООР:

1. Цэдэвийн Гүнсэг - Нийслэлийн 48 дугаар сургуулийн бага ангийн багш
2. Гунгаажанцангийн Дашдондог - Ховд аймгийн боловсрол, соёлын төвийн зөвлөх арга зүйч

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР:

1. Лхамсүрэнгийн Жамсран - ШУА-ын Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
2. Цэндийн Хайдав - Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн корпорацийн зөвлөх
3. Дамдинрагчаагийн Цэрэндорж - Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ЦОЛООР:

Сампилын Жалан-Аажав - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 105 | Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Бадамын Лхамсүрэн - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн зөвлөх

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Адуучийн Басхүү - Монголын Чөлөөт бөхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга
2. Түшигүүдолын Дашдэлэг - МАХН-ын дэргэдэх ахмадын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга
3. Дэчингунгаагийн Доржготов - ШУА-ийн

Газар зүйн хүрээлэнгийн захирал

4. Доржийн Доржнамжаа - ШУА-ийн Палентологийн төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

5. Бадамжавын Дуламсүрэн - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Ирвэс" ХХК-ийн тогооч

6. Сандуйн Дуламцэрэн - ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

7. Гомбожавын Жанчив - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэс, түүхий эдийн физик-химийн лабораторийн эрхлэгч

8. Намгарын Лонжид - ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн цэвдэг судлалын лабораторийн зөвлөх

9. Пэлжээгийн Цэвэгмид - Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнстех" корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

10. Ядамсүрэнгийн Цэнд-Аюуш - ХААИС-ийн Биоэкологийн тэнхмийн багш

11. Лувсандоржийн Цэенбазар - УБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Онолтын Аварзад - ШУА-ийн Имформатикийн хүрээлэнгийн эрхлэгч

2. Зулын Адьяа - УБИС-ийн ерөнхий нягтлан бодогч

3. Хорлоогийн Адьяа - Дундговь аймгийн Эд хэрэглэгчдийн хоршоодын холбооны дарга

4. Содвоогийн Адилбиш - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн захирал

5. Норовын Алтансүх - ХААИС-ийн ректор

6.Гомбосүрэнгийн Алтанцэцэг - Үйлдвэр, худалдааны яамны мэргэжилтэн

7.Чүлтэмийн Амарбаатар - Нийслэлийн "Барс групп" төрийн бус байгууллагын тэргүүн

8. Гэлэгбалын Амарбаян - МАХН-ын Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын хорооны дарга

9. Жадамбаагийн Баасандамба - УБИС-ийн Биеийн тамирын дээд сургуулийн гимнастикийн тэнхмийн багш

10. Жамцын Баатар - УБИС-ийн Математик, анализын тэнхмийн эрхлэгч

11. Найдангийн Баатаржав - "Орхон" их сургуулийн хууль зүйн салбарын эрхлэгч

12. Пүрэвдоржийн Баатархүү - Монгол Улсаас БНПУ-д суугаа Элчин сайдын яамны зөвлөх

13.Надмидын Бавуу - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "НИК" ХК- ийн ерөнхий менежер

14. Ёндонгийн Бадамханд - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Наран их дэлгүүр" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

15. Гомбосүрэнгийн Бадарч - ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

16. Доржийн Бадарч - ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

17. Батын Бадайннямба - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэргэлжилтэн

18. Дамбын Базаргүр - ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын эрхлэгч

19.Палаагийн Банди - Нийслэлийн "Өгөөмөр хайрхан" ХЭАА-н ээзэн

20.Чулууны Банзай - Нийслэлийн худалдаа, үйлдвэрийн "Улаанбаатар Импекс" ХК-ийн мэргэлжилтэн

21. Лувсаншаравын Банзрагч - Нийслэлийн худалдаа, үйлдвэрийн "Улаанбаатар Импекс" ХК-ийн ерөнхий менежер

22. Базаррагчаагийн Батбаяр - Үндэсний статистикийн газрын мэргэжилтэн

23. Цэндийн Батбуян - Гадаад хэргийн яамны Бодлого, төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газрын дэд захирал

24. Гүржавын Батбямба - УБИС-ийн Сургалт судалгааны албаны дарга

25. Лундаагийн Батмөнх - БХИС-ийн Физик, математикийн тэнхмийн эрхлэгч

26. Сэрээтэрийн Батмөнх - ШУТИС-ийн Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн захирал, дулааны цахилгаан станцын тэнхмийн эрхлэгч

27. Сэдэдийн Батхуяг - УБИС-ийн Багшийн коллежийн захирал

28. Содномдагвын Батчулуун - УБИС-ийн Дүрслэх урлаг, дизайны тэнхимийн багш

29. Цэвээний Баянсан - Увс аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал

30. Довдойн Баяр - ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

31. Сапогийн Баяраа - ХААИС-ийн Ховд аймаг дахь Алтайн бүсийн салбар сургуулийн багш

32. Наваандоогийн Баясгалан - Шинжлэх ухаан-технологийн мэдээллийн төв корпорацийн номын санч

33. Жүрмэдийн Болд - ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

34. Лувсандоржийн Болд - ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

35. Шаравын Бөххуяг - Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

36. Галсанжамцын Буяннэмэх - МУИС-ийн Гадаад харилцааны дээд сургуулийн франц хэлний багш

37. Мөндгойн Бүрэнжаргал - "ХААН" банкны Завхан аймаг дахь 601 дүгээр салбарын эдийн засагч

38. Лувсандоржийн Бямбаахүү - Завхан аймгийн Отгон сумын дунд сургуулийн зөвлөх багш

39. Билэгтийн Бямбажав - Ургамал хамгаалал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн секторын эрхлэгч

40. Лхүндэвийн Бямбацэрэн - Ховд аймгийн Жаргалант сумын 4 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

41. Түвдэндоржийн Галбаатар - ШУА-ийн дэд ерөнхийлөгч

42. Лантуугийн Галт - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

43. Лодонгийн Галцог - АУИС-ийн Эмгэг анатоми-шүүх эмнэлгийн тэнхимийн эрхлэгч

44. Лувсанцэрэнгийн Гандиймаа - Барилгын коллежийн барилгын инженерийн багш

45. Сурмаагийн Гиймаа - Нийслэлийн 52 дугаар дунд сургуулийн багш

46. Дамдингийн Гомбосүрэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын үйлдвэрлэл, худалдааны "Гангаимпекс" ХК-ийн захирал

47. Даржаагийн Дагийранз - Нийслэлийн "Барилга архитектур" корпорацийн аж ахуйн дарга

48. Бадарчийн Давга - Нийслэлийн 5 дугаар дунд сургуулийн физикийн багш

49. Галсанжамцын Дагмид - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын цахилгааны инженер

50. Ганжуурын Дамдинжав - Барилгын коллежийн мужааны багш

51. Шарын Дашбазар - Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын дунд сургуулийн захирал

52. Соном-Ишийн Дашцэвэл - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн салбарын эрхлэгч

53. Тодын Дашцэрэн - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн "Уурхайчин" соёлын ордны дарга

54. Гончигийн Дамиран - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Монтел" ХК-ийн ерөнхий захирал

55. Миналын Динашхан - Нийслэлийн 73 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

56. Бэгзжавын Дорждан - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын худалдаа, үйлчилгээний "Суварга" ХХК-ийн ахлах нягтлан бодогч

57. Цэдэнжавын Должин - Сэлэнгэ аймгийн Мандал сумын үйлдвэрлэл, худалдааны "Хишигт заяа" ХХК-ийн захирал

58. Чүлтэмийн Дугаржав - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн захирал

59. Жигжидсүрэнгийн Дугаржав - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

60. Бадамжавын Дуламсүрэн - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Ирвэс" ХХК-ийн тогооч

61. Дамдинсүрэнгийн Долгорсүрэн - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолборын 9 дүгээр бага сургуулийн захирал

62. Мягмарын Долгорсүрэн - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Номун далай" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч

63. Цогбадрахын Долзодмаа - Нийслэлийн 48 дугаар дунд сургуулийн газарзүйн багш

64. Ширчингийн Дэмбэрэл - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

65. Цэдэнгийн Ёндон - Үйлдвэрлэл, худалдааны яамны төрийн нарийн бичгийн дарга

66. Ёндонгийн Загдсүрэн - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

67. Намжилын Жадамбаа - ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

68. Луухүүгийн Жамц - УБИС-ийн Сурган хүмүүжүүлэх ухааны тэнхмийн багш

69. Доржийн Жамбал - Орхон аймгийн Баян-Өндөр сумын 8 дугаар дунд сургуулийн математикийн багш

70. Апешийн Калима - Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл

71. Халлиясийн Кекебай - Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

72. Дамдингийн Лхагважав - Нийслэлийн худалдаа, үйлдвэр, үйлчилгээний "Цэцэн хангай" ХХК-ийн захирал

73. Дугарын Лхагвасүрэн - Нийслэлийн 3 дугаар дунд сургуулийн орос хэлний багш

74. Бадрахын Лхамсүрэн - Хөвсгөл аймгийн Эд хэрэглэгчдийн хоршоодын холбооны дарга

75. Анатолий Васильевич Лощенко - ШУТИС-ийн Математикийн сургуулийн багш

76. Ванчингийн Лхамсүрэн - Завхан аймгийн Улиастай сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

77. Жуучингийн Магсаржав - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн дарга

78. Дашийн Мижиддорж - Нийслэлийн 3 дугаар дунд сургуулийн захирал

79. Дарамын Мөнхөө - ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан

80. Дэмбэрэлийн Мөнхөө - УБИС-ийн Ерөнхий химийн тэнхмийн эрхлэгч

81. Гэндэнпилийн Мянганбаяр - Монголын эд хэрэглэгчдийн хоршоодын төв холбооны дарга

82. Содовын Мятавжанцан - Үндэсний татварын ерөнхий газрын улсын ахлах байцаагч

83. Гонгорын Надмид - ШУТИС-ийн Нэхмэлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

84. Балганы Намхайдорж - ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

85. Цагаан-Өвгөний Намсрай - АУИС-ийн Химийн тэнхмийн багш

86. Дэмбэрэлийн Нансалмаа - Нийслэлийн 31 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

87. Раднаабазарын Нарантуяа - ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

88. Дэмбэрэлийн Нацагдорж - Европын хэлний дээд сургуулийн англи хэлний тэнхмийн эрхлэгч

89. Сэнгийн Нацагдорж - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Агро-Амгалан" ХК-ийн зөвлөх

90. Цэдэнжавын Нацагдорж - УБИС-ийн харьяа Архангай аймаг дахь багшийн сургуулийн багш

91. Лувсаншаравын Норолхоосүрэн - Ховд аймгийн Жаргалант сумын 5 дугаар дунд сургуулийн зураг хөдөлмөрийн багш

92. Донёдын Нэргүй - Гадаад хэргийн яамны ахлах бичээч

93. Баасангийн Нэргүй - ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн дэд захирал

94. Пилжээгийн Одонмажиг - ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

95. Жавчивын Октябрь - Худалдаа, үйлдвэрлэлийн дэвд сургуулийн тэнхмийн эрхлэгч

96. Гүнсэнжавын Орсоо - Үндэсний статистикийн газрын мэргэжилтэн

97. Лампирангийн Ооёо - Орхон аймгийн хүүхэлдэйн театр, "Эрдэнэт" чуулгын хөгжмийн багш

98. Гэндэнгийн Очирбат - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн ботаникийн цэцэрлэгийн эрхлэгч

99. Сүрэнжавын Отголжий - Төрийн удирдлагын "Соёмбо" дээд сургуулийн захирал

100. Чулууны Оюунбилэг - Шинжлэх ухаан мэдээллийн төв корпорацийн засварын инженер

101. Дамбадаржаагийн Оюунцэцэг - "Шихихутаг" хууль зүйн дээд сургуулийн захирал

102. Чоёнгийн Пагма - Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасгийн дарга

103. Ойдовын Пүрэвсүрэн - Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын албаны ахлах байцаагч

104. Бадамжавын Равжир - Өмнөговь аймаг дахь Өмнөд говийн улсын түсгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн

105. Магсарын Сайнбаяр - ШУА-ийн Ой, модны эрдэм судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

106. Ганпүрэвийн Самбуу - ХААИС-ийн Мал ах ахуйн тэнхмийн багш

107. Сүрэндоржийн Сандаг - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хот тохижилт, үйлчилгээний албаны дарга

108. Энэбишийн Сандагдорж - Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга

109. Лүндэнгийн Санжжав - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын жолооч

110. Чинбатын Санчир - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

111. Ширчингийн Содном - МУИС-ийн Нийгмийн ухааны факультетийн декан

112. Сайнхүүгийн Сугар - Худалдаа хөгжлийн банкны Дархан-Уул аймаг дахь 803 дугаар салбарын захирал

113.Дамдингийн Сумьяа - МУИС-ийн Биологийн Факультетийн амьтан судлалын тэнхмийн эрхлэгч

114. Хумбуугийн Сүрэнхүү - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн нягглан бодогч

115.Дамдингийн Сүхбаатар - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Чингис хаан цогцолбор" ХХК-ийн тэргүүн дээд захирал

116. Жуурайн Сүхбаатар - Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч

117.Пэрэнлэйн Тогоо - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

118. Равдандоржийн Тогоо - ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

119. Сумьяагийн Тогтох - Өмнөговь аймгийн Хүрмэн сумын худалдаа, үйлчилгээний "Сүхбаатарын зам" ХХК-ийн ерөнхий нягтлах бодогч

120. Дондогийн Төмөрбаатар - ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн цэвдэг, судлалын лабораторийн эрхлэгч

121. Цэрэннадмидын Төрбат - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Бадачи трейд" ХХК-ийн захирал

122. Чүлтэмийн Түмэндэлгэр - УБИС-ийн Багшийн коллежийн тэнхмийн эрхлэгч

123. Гэлэгжамцын Тэгшжаргал - ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн багш

124.Дагвын Уртнасан - Дархан-Уул аймгийн Хонгор сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

125. Цоохорын Уртнасан - ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн социологиийн салбарын эрхлэгч

126. Содовжамцын Хүрэлбаатар - Гадаад хэргийн яамны ажилтан

127.Арьяагийн Хайдав - ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн цахилгаан механикийн тэнхмийн эрхлэгч

128. Лувсангийн Хайсандай - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал

129. Алтангэрэлийн Хайчаа - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын худалдаа, үйлчилгээний "Хөвсгөл хүнс" ХК-ийн захирлын зөвлөх

130.Ёндонгийн Ханд - ШУА-ийн Палеонтологийн төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

131.Даржаагийн Хандмаа - Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Мон- НАБ" ХК-ийн жолооч

132. Баясгалангийн Хишигжаргал - Стандарчилал,хэмжил зүйн үндэсний төвийн эксперт

133. Гончигийн Цог - Улсын татварын ерөнхий газрын улсын ахлах байцаагч

134. Пүрэвийн Цолмон - Нийслэлийн "Агро-Амгалан" ХК-ийн агрономч

135.Цэдэнгийн Цэвэлмаа - УБИС-ийн Орос хэлний тэнхмийн багш

136.Түмэнжээгийн Цэвээн - Нийслэлийн 3 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

137. Норжингийн Цэвээндорж - Улаанбаатар хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал

138. Жамбын Цэвээнжав - ШУТИС-ийн Геологийн сургуулийн нефтийн инженерийн тэнхмийн эрхлэгч

139.Далайн Цэдэнпил - Үндэсний татварын ерөнхий газрын сургалт, мэдээллийн төвийн багш-байцаагч

140.Жигдэнгомбын Цэзэн - СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

141. Чүлтэмийн Цэнд - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн тасгийн дарга

142. Дожоогийн Цэнд-Аюуш - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Сэрүүлэг" ХХК-ийн ерөнхий менежер

143.Гончигийн Цэрэнбалжид - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн сорилын ботаникийн лабораторийн эрхлэгч

144.Сайнхүүгийн Цэрэндаш - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

145.Баянжаргалын Цэрэндорж - ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн багш

146.Уртнасангийн Цэрэндорж - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын малчин

147. Шагдарын Чадраабал - ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн материал, технологийн салбарын эрхлэгч

148. Бадарчийн Чанцал - УБИС-ийн үйлчлэгч

149. Адьяагийн Чибиш - Завхан аймгийн Улиастай сумын "Чандмань-Эрдэнэ" цогцолбор сургуулийн физикийн багш

150. Магваны Чимид - ХААИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

151. Жамбалын Чимэддорж - Ховд аймгийн Жаргалант сумын үйлдвэрлэл, худалдааны "Алтайн зам" ХК-ийн эдийн засагч

152. Лувсангийн Чимэддорж - Нийслэлийн 25 дугаар тусгай сургуулийн захирал

153. Данзангийн Чулуун - ШУТИС-ийн Геологийн сургуулийн захирал

154. Дагвын Чулуунжав - ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн хууль, эрх зүйн салбарын эрхлэгч

155. Цэндийн Шагдар - Хөдөлмөрийн дээд сургуулийн спорт сургалтын төвийн эрхлэгч

156. Жахиягийн Шайзада - Баян-Өлгий аймгийн Гаалийн газрын ахлах нягтлан бодогч

157. Жанцангийн Янжиндулам - Нийслэлийн 5 дугаар дүнд сургуулийн бага ангийн багш

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Агвааны Баасан - ЦЕГ-ын Замын цагдаагийн газрын Тамгын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

2. Дамбын Доржготов - БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн цэргийн стратегийн тэнхмийн эрхлэгч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Пүрэвчоймболын Адилбиш - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Одос Намнан" ХХК-ийн захирал

2. Мажигийн Адьяа - ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан

3. Ойдовын Адьяа - ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга

4. Дэлгэрийн Алтангэрэл - "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨҮГ-ын Эрдэнэт-Хархорины салбарын шугамын монтёр

5. Цэрэндонойн Алтанхуяг - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ундрам" ХХК-ийн захирал

6. Маамуугийн Алтанцэцэг - Олон улсын Монгол судлалын холбооны менежер

7. Намсрайн Амаржаргал - Барилгын коллежийн физикийн багш

8. Далхаагийн Аюубазар - Сүхбаатар

аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

9. Ийшээгийн Аюурзана - Увс аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн мал эмнэлгийн багш

10. Баясгалангийн Баасансүрэн - Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга

11. Чойжамцын Баасансүрэн - Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн түүхин багш

12. Сувдын Бадамгарав - Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Хүжийн гал" ХХК-ийн барилгачин

13. Раваагийн Бадамсүрэн - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын сантехникийн инженер

14. Ёндонжамцын Бадамханд - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш

15. Намсрайжавын Бадамцэрэн - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Хангай импекс" ХХК-ийн захирал

16. Төмөрбаатарын Бадамаа - УБИС-ийн Цэцэрлэгийн багшийн коллежийн ерөнхий эрдмийн тэнхмийн эрхлэгч

17. Лувсанжамцын Бадрах - Нийслэлийн телефон хэрэглэгчийн товчооны ахлах инженер

18. Агитарын Бакей - ХААИС-ийн дэд захирал

19. Бямбажавын Балдан - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч

20. Дэмбэрэлийн Банзрагч - Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын байцаагч

21. Цэдэндамбын Батбаяр - Гадаад хэргийн яамны Бодлого төлөвлөлт, мэдээлэл үнэлгээний газрын дэд захирал

22. Сумьяагийн Батзана - Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн хэлтсийн зөвлөх

23. Гүнэнгийн Батнасан - УБИС-ийн Компьютер, мэдээллийн технологийн факультетийн багш

24. Цэдээнравдангийн Батнасан - Нийслэлийн 51 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

25. Гомбажавын Баттогтох - Төр, Засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Амралт, үйлчилгээний цогцолборын нярав

26. Базарсадын Батхүрэл - Сүхбаатар аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн механикч

27. Базаррагчаагийн Баярсайхан - Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

28. Гунгаасүрэнгийн Болдсайхан - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын слесарьч

29. Жийжиймаагийн Болормаа - Нийслэлийн үйлдвэр, үйлчилгээ, худалдааны "Номин трейд" ХХК-ийн дэлгүүрийн эрхлэгч

30. Монхооройн Борхүүхэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

31. Гүржавын Бөхсуурь - Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга

32. Сампилын Бямбаа - Нийслэлийн 3 дугаар дунд сургуулийн хөдөлмөрийн багш

33. Даваасамбуугийн Бямбадоо - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Номун далай" цогцолбор сургуулийн биологийн багш

34. Домжоогийн Бямбажав - Нийслэлийн 7 дугаар дунд сургуулийн математикийн багш

35. Нанжидын Бямбажав - "Монгол фермер" дээд сургуулийн багш

36. Дагвын Бямбасүрэн - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын үйлчлэгч

37. Шаравын Бямбасүрэн - Санхүү, эдийн засгийн яамны сорьцын улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч

38. Нэмэхжаргалын Будаасүрэн - Увс аймгийн Баруунтуруун сумын дунд сургуулийн дуу хөгжмийн багш

39. Сосорбарамын Галдан - Нийслэлийн 76 дугаар дунд сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш

40. Цэдэвийн Галсанжигмэд - Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны аж ахуй эрхлэгч-тогооч

41. Моломын Ганбаатар - Сүхбаатар аймгийн

Баруун-Урт сумын "Дөрвөлж" ХХК-ийн ахлах операторч

42. Гончигийн Ганболд - Гадаад хэргийн яамны Ази, Америкийн газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга

43. Пэрэнлэйн Ганчимэг - Санхүү, эдийн засгийн яамны орлого, татварын хэлтсийн дарга

44. Даваажавын Гэрэлчулуун - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч

45. Галбадрахын Даваажаргал - Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газрын орлогч дарга

46. Чүлтэмийн Дашдаваа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын худалдаа, үйлчилгээний "Ган Олдох" ХХК-ийн захирал

47. Дэмчигийн Дашзэвэг - Нийслэлийн 48 дугаар сургуулийн физикийн багш

48. Менхжавын Дашзэвэг - Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр дунд сургуулийн тогооч

49. Цэрэнбалжирын Дашзэвэг - ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн ойн нөөц, ой хамгаллын салбарын эрхлэгч

50. Доржийн Дашням - ОХУ-ын Эрхүү хот дахь Монгол Улсын ерөнхий консулын газрын аж ахуйн эрхлэгч-жолооч

51. Чойдогийн Довчин - Дархан-Уул аймгийн Хонгор сумын дунд сургуулийн математикийн багш

52. Жигмэдийн Долгормаа - Дорнод аймгийн Хэрлэн сумын "Зул" ХЭАА-н эзэн

53. Лувсангийн Дондол - Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр дунд сургуулийн багш

54. Цэрэнпилийн Доржсүрэн - Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга

55. Галсандамбын Доржханд - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын багийн Засаг дарга

56. Базарваанийн Дуламрагчаа - Нийслэлийн Сонгино Хайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын эдийн засагч

57. Шархүүгийн Дуламсүрэн - УБИС-ийн Урлал, техникийн факультетийн нарийн бичгийн дарга

58. Сумьяагийн Дэлгэр - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын орлогч

59. Батмөнхийн Дэлгэрцогт - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн цахилгаанчин

60. Пүрэвцэрэнгийн Жавзандорж - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа Амралт, үйлчилгээний цогцолборын аж ахуйн нярав

61. Намчингийн Жамбал - Увс аймгийн Тэс сумын дунд сургуулийн зураг, хөдөлмөрийн багш

62. Дүгэрийн Жаргал - Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн тасгийн дарга

63. Дамдинжавын Жаргалсайхан - Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа Элчин сайдын яамны 1 дүгээр нарийн бичгийн дарга

64. Сэд-Очирын Жаргалсайхан - Удирдлагын академийн ахлах багш

65. Рэнцэндоогийн Жигжид - Гадаад хэргийн яамны Ази, Америкийн газрын зөвлөх

66. Жаргалын Жорсүрэн - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч

67. Гэндэнсүрэнгийн Зина - Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн

68. Тарваагийн Зуннасан - Нийслэлийн 88 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

69. Базарын Ладий - Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

70. Галданжамцын-Лувсандорж - "Шихихутаг" хууль зүйн дээд сургуулийн нягтлан бодогч,эд аж ахуйн нярав

71. Шаараавын Лхамхүү - Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын дунд сургуулийн бага ангийн багш

72. Самдангийн Лхагва - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "БГ- Өлзийтбулаг" ХХК-ийн дэд захирал

73.Мэндбаярын Лэгдэн - ШУА-ийн Сэргээгдэх эрчим хүчний шинжлэх ухаан үйлдвэрлэлийн нэгдлийн төслийн удирдагч

74.Должингийн Мандаа - Хөвсгөл аймгийн Ус суваг, ниитийн аж ахуйн компанийн цэвэр усны шахах станцын машинч

75. Шаравын Мөнхжаргал - ШУА-ийн Хими, хими - технологийн хүрээлэнгийн эрдэм

шинжилгээний тэргүүлэх ажилтан

76. Тангаагийн Мөнхцэцэг - МУИС-ийн Гадаад харилцааны дээд сургуулийн япон хэлний багш

77. Будийн Мөнхтогоо - Санхүү,эдийн засгийн яамны Сорьцын улсын хяналтын албаны лабораторийн химич

78. Сүрэнгийн Мягмардаш - Санхүү,эдийн засгийн яамны төрийн сангийн зарлага, бүртгэл,арга зүйн хэлтсийн дарга

79. Дашбалын Нарангэрэл - Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын дунд сургуулийн бага ангийн багш

80.Дэчингийн Нархажид - Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын консулын хэлтсийн 2 дугаар нарийн бичгийн дарга

81. Ядамын Наранчимэд - Орхон аймаг дахь Монгол -Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн экскаваторын машинч

82. Лхамсүрэнгийн Норжий - Нийслэлийн 48 дугаар сургуулийн бага ангийн багш

83. Цэдэвийн Норжмаа - УБИС-ийн харьяа Архангай аймаг дахь Багшийн коллежийн үйлчлэгч

84. Найдандоржийн Нямжав - Барилгын коллежийн дизайны багш

85. Навааны Нямтогтох - Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дэс түшмэл

86. Цэдэн-Ишийн Нямцэрэн- Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны тогооч-визитийн үйлчлэгч

87. Дашийн Одонгуа - Үйлдвэр, худалдааны яамны мэргэлжилтэн

88.Дамдингийн Олдох - МАХН-ын Ховд аймгийн хорооны дэд дарга

89.Ядамжавын Онгойбор - Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэлжилтэн

90. Рэнцэнсүрэнгийн Оргиохүү - Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын хилийн тасгийн ажилтан

91.Содовын Орхон - БХИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн тэнхмийн эрхлэгч

92. Дэмбэрэлийн Оролмаа - ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

93. Шагдарын Оттон - Хөвсгөл аймгийн Орон сууц, нийтийн аж ахуйн компанийн жолооч

94. Чойсүрэнгийн Отгонбаяр - Нийслэлийн 83 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

95. Хишгээгийн Отгонбаяр - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч

96.Бадарчингийн Оюунбилэг - УБИС-ийн Нийгмийн ухаааны факультетийн нарийн бичгийн дарга

97.Кимийн Оюунчимэг - Дорнод аймгийн Хэрлэн сум дахь шаталсан сургалттай техник-технологийн сургуулийн биеийн тамирын багш

98. Балзангийн Өлзийдэлгэр - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн улсын байцаагч

99. Дашаалайн Өлзийням - Хөвсгөл аймгийн Түнэл сумын дунд сургуулийн түүх газар зүйн багш

100.Нурахметийн Өсөрхан - Дархан-Уул аймгийн худалдаа, үйлчилгээний "Ужим хангай" ХХК-ийн дэд захирал

101.Очирын Пунцагдаш - Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын консулын хэлтсийн 1 дүгээр нарийн бичгийн дарга

102. Цэрэнгомбын Пүрэв - ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

103.Чойсүрэнгийн Пүрэвжал - Дархан-Уул аймгийн худалдааны "Чандмань Ундрах" хоршооны эзэн

104. Балжиннямын Пүрэвдорж - Хөгжим бүжгийн коллежийн монгол хэл, уран зохиолын багш

105.Равжаагийн Сайнжаргал - Увс аймгийн Тэс сумын дунд сургуулийн захирал

106. Риймэдийн Самдан - Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын орлогч

107. Дэмбэрэлийн Сосорбурам - Нийслэлийн "Хүнс трейд" компани /ТӨҮГ/-ийн ерөнхий нягтлан бодогч

108. Батбаярын Сүрэн - Төв аймгийн Сэргэлэн сумын дунд сургуулийн бага ангийн багш

109. Гун-Аагийн Сүрэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын сум дундын шүүхийн ерөнхий шүүгч

110. Дагвын Сүхбаатар - Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын "Тосонцэнгэл" хоршооны малчин

111. Жаарайн Тогооч - Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газрын кассын нярав

112. Дамдингийн Тогтох - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Мандах гэгээ" ХХК-ийн захирал

113. Долгорын Тогтох - Завхан аймгийн Улиастай сумын 3 дугаар дунд сургуулийн багш

114. Жүгдэрийн Тогтох - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 3 дугаар багийн Засаг дарга

115. Пэрэнлэйн Төвсанаа - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын орлогч

116. Дамиранжавын Төмөрбаатар - Ховд аймгийн хянан шалгах хорооны хянан байцаагч

117. Ваанжилын Төмөрсүх - Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын ямны аж ахуйн эрхлэгч-жолооч

118. Гэндэнгийн Ундрал - ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

119. Дандарын Уранбилэг - Дорнод аймгийн Хэрлэн сумын худалдаа, үйлчилгээний "Есөн-Эрдэнэ" ХК-ийн худалдагч

120. Дорлигийн Ургамал - Нийслэлийн 63 дугаар цэцэрлэгийн багш

121. Жамцын Уртнасан - Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Хүжийн гал" ХХК-ийн ерөнхий инженер

122. Лхамсүрэнгийн Уранчимэг - Нийслэлийн 1 дүгээр цэцэрлэгийн багш

123. Санжаагийн Удэнбаярай - Завхан аймгийн Тэс сумын дунд сургуулийн бага ангийн багш

124. Баясгалангийн Хандаа - Нийслэлийн 42 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

125. Дагдангийн Хишигсүрэн - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Хөвсгөл хүнс" ХК-ийн ажилчин

126. Сундуйн Хөгжил - Улаанбаатар төмөр замын Материал, техникийн хангамж, худалдааны албаны харьяа "Ган зам" төвийн ерөнхий нягтлан бодогч

127. Бодоошийн Хөхөөжаргал - Удирдлагын академийн ахлах багш

128. Содномын Цолмон - ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

129. Дуйнсэнсанжаагийн Цэвэлмаа - Завхан аймгийн Улиастай сумын 1 дүгээр дүн, сургуулийн хичээлийн эрхлэгч

130. Луузангийн Цэвэлмаа - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Үүрийн цолмон" ХХК-ийн ерөнхий захирал

131. Дашаагийн Цэдэнбал - Санхүү, эдийн засгийн ямны ахлах мэргэжилтэн

132. Сосорын Цэнд-Аюуш - Санхүү, эдийн засгийн ямны ахлах мэргэжилтэн

133. Цэрэнпилийн Цэндсүрэн - МУИС-ийн Физик, электроникийн сургуулийн дэлхий судлал цаг уурын тэнхмийн туслах ажилтан

134. Сономын Цэндээхүү - Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч

135. Сүхбаатарын Цэрэндолгор - ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн багш

136. Пүрэвийн Цэрэннадмид - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

137. Доржготовын Цэцгээ - Завхан аймгийн Тэс сумын дунд сургуулийн дуу, хөгжмийн багш

138. Сандагийн Цэцгээ - Сүхбаатар аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн нягтлан бодогч

139. Аюушжавын Цэцэгбадам - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Хан бүргэдэй" ХХК-ийн ерөнхий менежер

140. Нямын Цэцэгсүрэн - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын худалдаа, үйлчилгээний "Баян Итгэлт" ХК-ийн худалдагч

141. Гомбын Чимэд - Увс аймгийн Улаангом сумын 3 дугаар дунд сургуулийн зураг, хөдөлмөрийн багш

142. Шагдарсүрэнгийн Чимэдмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

143. Бэх-Очирын Чимидхишиг - Үйлдвэр, худалдааны ямны мэргэжилтэн

144. Сэрсэнгийн Чогсом - Санхүүгийн улсын хяналт шалгалтын газрын улсын байцаагч

145. Алимаагийн Чулуунбат - Үйлдвэр, худалдааны ямны мэргэжилтэн

146. Найдангийн Чулуунгэрэл - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн гагнуурчин

147. Жамбын Чулуунжав - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

148. Нацагийн Цэвэлмаа - Баянхонгор аймгийн Баянцагаан сумын дунд сургуулийн багш

149. Даваагийн Чулуун - Орхон аймгийн Баян-Өндөр сумын 8 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

150. Алимаагийн Чулуунбат - Үйлдвэр, худалдаааны яамны мэргэжилтэн

151. Лхамсүрэнгийн Шийтэв - Нийслэлийн 76 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

152. Пүрэвсүрэнгийн Энхбаяр - Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын зөвлөх

153. Очирын Энхтөр - Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын захирал

154. Очирын Энхцэцэг - Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал

155. Чойндогийн Энэбиш - Үйлдвэр, худалдаааны яамны мэргэжилтэн

156. Алтангэрэлийн Эрдэнэдорж - Газрын тосны хэрэг эрхлэх газрын орлогч дарга

157. Нацагдоржийн Эрдэнэчимэг - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Мөнгөн бүрээ" ББН-ийн захирал

158. Цэрэндоржийн Эрдэнэчулуун - Үйлдвэр, худалдаааны яамны мэргэжилтэн

159. Ашваагийн Янжиндолгор - ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

160. Рэгзэдмаагийн Янжиндулам - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Доржийн Батбаатар - Гал түймэртэй тэмцэх газрын дэд дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | **Дугаар 268** | **Улаанбаатар хот**

Төрийн ажилтны орон сууц барих тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

БНХАУ-ын Засгийн газраас Монголын Засгийн газарт олгохоор шийдвэрлэсэн 45.0 (дөчин таван) сая юанийн бүцалтгүй тусламжийн 38.0 (гучин найман) сая юанийг ашиглан шатахуун импортолж төрийн албан хаагчдад зориулж орон сууц барих санг богино хугацаанд бүрдүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, уг санг ашиглан төрийн албан хаагчдад зориулсан орон сууцыг бариулах ажлыг зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (241)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх Тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *2002 оны хаврын эзлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны нэгдүгээр сарын 26 №4 (241

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

48. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-01-10-ны хууль) 78
49. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-01-10-ны хууль) 78

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

50. Зөвшөөрөл олгох тухай Дугаар 02 78
51. Дүрэм батлах тухай Дугаар 05 78
52. Байнгын хорооны гишүүнээр батлах тухай Дугаар 06 82
53. 2002 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Дугаар 07 82

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

54. Жүгдэрнамжилын Гомбосүрэн, Билгээгийн Дорждэрэм нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 106 83
55. Довдонгийн Чадалбатхуяг, Хүрэлбаатарын Батхүү нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 107 83
56. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай Дугаар 108 83
57. Дипломат цол олгох тухай Дугаар 109 85
58. Ким Жин Сонийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 01 85
59. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 02 86
60. Зарим шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 03 86
61. Зарим шүүгчид зэрэг дэв олгох тухай Дугаар 04 86
62. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 06 86

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

63. Хөтөлбөр батлах тухай Дугаар 260 87
64. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 273 93
65. Хөрөнгө гаргах тухай Дугаар 274 100
66. Төсөл дэмжих тухай Дугаар 275 100
67. Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны нэр, тоог тогтоох тухай Дугаар 276 100
68. Махны үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 277 101
69. Малын өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 280 106
70. Зар мэдээ, журамд нэмэлт оруулах тухай Дугаар 281 108
71. Төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах тухай Дугаар 282 109
72. Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай Дугаар 284 109

Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

73. Гаалийн болон гаалийн тарифын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Дугаар 439 109

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн №1700-MON тэрээний дагуу хэрэгжиж байгаа "Авто зам хөгжүүлэх хоёр дахь төсөл"-ийн хүрээнд гүйцэтгэх зам барилгын ажил болон зээлийн хөрөнгөөр гадаадаас нийлүүлэгдэх зам засвар, арчлалтын машин механизм, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн №1700-MON тэрээний дагуу хэрэгжиж байгаа "Авто зам хөгжүүлэх хоёр дахь төсөл"-ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр гадаадаас нийлүүлэгдэх зам засвар, арчлалтын машин механизм, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр **Дугаар 02** **Улаанбаатар хот**

Зөвшөөрөл олгох тухай

Үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, төсвийн орлогын тодорхой эх үүсвэр бүрдүүлж, зарлага санхүүжилтийг уян хатан шуурхай удирдлагаар хангах үүднээс 2002 оны санхүүгийн жилд 50 тэрбум /тавин тэрбум/ хүртэл төгрөгийн Засгийн газрын бонд гаргаж, нийтэд санал болгон худалдахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр **Дугаар 05** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрмийг хавсралт ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 05 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Их Хурлын ажлын алба нь Тамгын газар байна. Тамгын газар нь Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон дэд, түр хорооны /цаашид "Байнгын болон бусад хороо" гэх/ үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, тэдгээрийг ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй.

2. Тамгын газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана.

3. Тамгын газрын ажлыг Улсын Их Хурлаас томилсон Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/ удирдана. Ерөнхий нарийн бичгийн дарга Тамгын газрын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

4. Тамгын газар үйл ажиллагаагаа явуулахдаа хуулийг дээдлэн хүндэтгэх, ил тод байх, төрийн албаны ёс зүйн зарчмыг баримтална.

5. Тамгын газар Улсын Их Хурлаас батлагдсан төсөвт зардлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

6. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Тамгын газар Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаанд гүйцэтгэх ажлын хэтийн төлөвлөгөөтэй байна. Энэ төлөвлөгөөг Улсын Их Хурлын дарга батална. Жил, улирлын төлөвлөгөөг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

8. Тамгын газар өөрийн үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын Төрийн байгууллатын байгууллагын хороонд жил бүр танилцуулна.

Хоёр.Тамгын газрын үүрэг, эрх

1. Тамгын газар Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу дараахь үндсэн үүрэг гүйцэтгэнэ:

1/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороо, ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

2/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлагдсан хууль, бусад шийдвэрийг хэлбэржүүлэн гаргах, нийтлэх ажиллагаанд зохион байгуулан хэрэгжүүлэх;

3/ Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар Байнгын болон бусад хороо, Улсын Их Хурлаас шаардлагатай гэж үзсэн асуудлаар судалгаа хийж, үр дүнг хүргүүлэх, тодорхой хуулийн хэрэгжилтээр мэдээллийн сан / эх үүсвэрийг/ бүрдүүлэх;

4/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан Байнгын болон бусад хорооны хуралдаан, ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн болгох, чуулганы хэвийн ажиллах нөхцөлийг хангах, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын болон бусад хорооноос гаргасан шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчлах;

5/ хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороо, ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх;

6/ Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах үйл ажиллагаат зохион байгуулж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд санал авах, Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг нэгтгэж Улсын Их Хурлын чуулганд мэдээлэх, шийдвэрлүүлэх, парламентын музейн байгуулах ажиллагаат хангах;

7/ Улсын Их Хурлын гишүүдээс сонгогчидтойгоо уулзах, тэдний санал, хүсэлтийг судлан үзэх ажлыг зохион байгуулахад туслалцаа үзүүлэх;

8/ Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэм, Тамгын газрын шугамаар гадаад орнуудын хууль тогтоох дээд байгууллага, тэдгээрийн Тамгын газар, Олон улсын парламентын холбоо болон олон улсын бусад байгууллагатай харилцах асуудлыг эрхэлж, гадаад оронд айлчлах, гадаадаас ирэх төлөөлөгчийг хүлээн авах бэлтгэл хангах;

9/ Улсын Их Хурлын чуулган, Улсын Их Хурлын гишүүний ажлын зөвлөлгөөний тэмдэглэл хөтлөж, түүнийг ашиглах, хадгалах ажлыг эрхэлж явуулах, Улсын Их Хурал, Тамгын газрын бичиг хэрэг, архивын үйл ажиллагаат хөтлөн явуулах, чуулганаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг олшруулан тараах ажлыг эрхэлэн гүйцэтгэх;

10/ Улсын Их Хурал, Тамгын газарт ашиглагдаж байгаа мэдээллийн хэрэгсэл, компьютерийн гадаад, дотоод сүлжээ, теле сүлжээ, санал хураах систем болон бусад тоног төхөөрөмжийн байнгын найдвартай ажиллагаа, техникийн шинэчлэлийг хангах;

11/ Улсын Их Хурал, Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

12/ Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, ахуй хангамжтай холбоотой асуудлыг судалж шийдвэрлэх;

13/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороо, Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн байгууллага болон иргэдэд мэдээлж, сурталчлах;

14/ Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

15/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан болон Улсын Их Хурлын удирдлагаас өгсөн бусад үүргийг биелүүлэх;

16/ Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан санал, асуулт, асуулгыг нь хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд нь туслалцаа үзүүлэх.

2. Тамгын газар нь дор дурдсан эрх эдэлнэ:

1/ Улсын Их Хурлын үйл ажиллагаанд шаардагдах мэдээ, материал, улс орны нийгэм-эдийн засаг, хөгжлийн хөтөлберт холбогдох танилцуулга, судалгаа, тооцоо, мэргэжлийн албаны дүгнэлтийг бусад байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

2/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хорооноос өгсөн үүрэг, ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан саналын дагуу тодорхой асуудлаар судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулахад мэргэжлийн байгууллага, хүмүүсийг татан оролцуулах;

3/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хорооны даалгавраар хуулийн хэрэгжилтийн явцтай газар дээр нь танилцах;

4/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаат боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Улсын Их Хурлын удирдлага, холбогдох Байнгын болон бусад хороонд танилцуулах;

5/ Улсын Их Хурал үйл ажиллагаагаа явуулахад нь зайлшгүй шаардагдах үйлчилгээ /тухайлбал, техник хэрэгсэл, шуудан холбоо, тээвэр, орон байр зэрэг/-г найдвартай бэлэн байлгах асуудлаар төрийн холбогдох байгууллагуудаас шаардах;

6/ Улсын Их Хурлаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Засгийн газрын ажлын алба, холбогдох бусад төрийн ба төрийн бус байгууллагатай харилцан ажиллах;

7/ хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

Гурав. Тамгын газрын удирдлага

1. Тамгын газар нь Ерөнхий нарийн бичгийн дарга, нэгдүгээр нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргатай байна.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ Тамгын газрын үйл ажиллагаат ерөнхий удирдлагаар хангаж, өдөр тутмын ажлыг уялдуулан зохицуулна;

2/ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан даргалагчид хууль, дэгийн асуудлаар зөвлөх;

3/ Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороодын хуралдааны тэмдэглэл, гаргасан шийдвэрийг эрх зүйн хувьд хэлбэржүүлэх;

4/ Тамгын газрын хүний нөөцийн асуудлаар бодлого боловсруулж, ажилтнуудыг томилох, чөлөөлөх;

5/ Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

6/ Улсын Их Хурлын төсвийн төслийг бэлтгэх, төсвийг зарцуулах;

7/ Тамгын газрын захиргаа, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх;

8/ Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Их Хурлын тамгыг хадгалах.

3. Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь эрхлэх асуудлын хүрээнийаль нэг хэлтсийн даргын үүргийг давхар хариуцна.

4. Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь /цаашид "Нарийн

бичгийн дарга" гэх/ өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтантай Тамгын газрыг төлөөлөн харилцаж болно.

5. Сонгуулиар Улсын Их Хурлын бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нарыг өөрчлөх үндэслэл болохгүй.

6. Нарийн бичгийн дарга нь ажлаа Ерөнхий нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Дөрөв. Тамгын газрын зохион байгуулалт

1. Тамгын газар нь эрхлэх асуудлынхаа хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэх үндэсэн бүтэцтэй байна:

1/ Хуулийн хэлтэс;
2/ Хяналт шалгалтын хэлтэс;
3/ Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэс;
4/ Гадаад харилцааны хэлтэс;
5/ Санхүү, үйлчилгээний хэлтэс.

2. Хэлтсүүдийн харьяалалд дараахь албад ажиллана:

1/ Хуулийн хэлтэст- Хуралдаан зохион байгуулах алба;
2/ Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэст- Улсын Их Хурлын Хэвлэл, мэдээллийн алба;
3/ Санхүү, үйлчилгээний хэлтэст- Техник ашиглалтын алба.

3. Ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан Тамгын газрын үндсэн бүтцэд өөрчлөлт оруулахгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн ажлын нэгж албад байгуулж болно.

4. Хэлтсүүдийн үндсэн чиг үүрэг:

1/ Хуулийн хэлтэс нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль, бусад шийдвэрийн төслийн бүрдлийг хянах, Улсын Их Хурлын гишүүний санаачлах төслийг боловсруулах, Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийг Үндэсэн хууль, бусад хуультай нийцүүлэх, үялдуулах, хууль зүйн дүгнэлт өгөх, энэ асуудлаар Улсын Их Хурал, Байгныи болон бусад хороо, Улсын Их Хурлын удирдлага, гишүүд, ажлын хэсгээс өгсөн үүрэг, тавьсан саналыг хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө, тусламжаа үзүүлэх, нэгдсэн хуралдаан, Байнгын болон бусад хорооны хуралдаанд хууль зүйн болон дэгийн асуудлаар зөвлөх, баталсан хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулга хийж Улсын Их Хуралд танилцуулах, хууль тогтоомжийг системчлэх, лавлагаа, мэдээллээр хангах;

2/ Хяналт шалгалтын хэлтэс нь Улсын Их Хурал, Байнгын болон бусад хорооноос хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд болон улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, Улсын төвлөрсөн төсвийн төсөл, түүний тодотгол, гүйцэтгэл, төрийн мөнгөний болгосны хэлэлцэн батлах, гүйцэтгэлд хяналт тавихад мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, Улсын Их Хурлын гишүүдээс Засгийн газар, бусад байгуллагын эрх баригдад тавих асуулт, асуулгыг боловсруулах, түүний биелэлтэд хяналт тавих, Засгийн газрын мэдээллийг зохион байгуулах;

3/ Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэс нь Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүдийн туслах, бие төлөөлөгч-туслахын хөдөлмөрийн харилцаатай холбогдон гарах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, Улсын Их Хурал, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах, нийтэд мэдээлэх, сурталчлах, Улсын Их Хурлын гишүүдээс иргэдийн өргөдөл, санал, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, мэдээлэл, лавлагаагаар хангах, Улсын Их Хурал, Тамгын газрын бичиг хэрэг, номын сан, архивын үйл ажиллагаат хөтлөн явуулах, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын болон бусад хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах;

4/ Гадаад харилцааны хэлтэс нь Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэм, болон Тамгын газраас гадаад орнуудын хууль тогтоох дээд байгуллага, тэдгээрийн нарийн бичгийн дарга нарын газар, Олон улсын парламентын холбоо, парламентын бүлгүүд, олон улсын бусад байгуллагатай харилцах асуудлыг холбогдох хууль тогтоомж, байгуулсан гэрээ, хэлэлцээр, тохиролцооны үндэсэн дээр зохион байгуулах;

5/ Санхүү, үйлчилгээний хэлтэс нь Улсын Их Хурлын төсвийн төлөвлөгөө, санхүү, төсвийн холбогдолтой асуудлаар Улсын Их Хурал, Тамгын газарт мөрдегдөх эрх зүйн актыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, байгууллагын зөрөнгө, техникийн ашиглалт, тэдгээрийн шинэчлэлийг хариуцах, Улсын Их Хурал хэвийн ажиллах, Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөл, нийгмийн асуудлаар чиглэл боловсруулж хэрэгжүүлэх, Улсын Их Хурал,

Тамгын газрын төсөв, санхүү, тайлан бүртгэл, техник хангамж, аж ахуйн хангалт, үйлчилгээг зохион байгуулах;

5. Тамгын газрын хэлтэс, албаны эрхлэх ажил, тэдгээрийн ажлын зохион байгуулалтын зарчмыг дотоод журмаар нарийвчлан тогтооно. Тамгын газрын дотоод журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

6. Ерөнхий нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд зөвлөх үүрэг бүхий Тамгын газрын удирдлагын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах чиг үүргийг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.

7. Тамгын газрын хэлтэс ажлаа Ерөнхий нарийн бичгийн дарга болон шууд харьяалах Нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

8. Хэлтсийн дарга нь бусад хэлтсийн даргатай ажил төрлийн шууд холбоотой ажиллаж, үйл ажиллагаагаа Ерөнхий нарийн бичгийн дарга, Нарийн бичгийн даргаар уламжлан уялдуулан зохицуулна.

9. Тамгын газарт ажиллаж байгаа албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулыг заасны дагуу төрийн албан тушаалд тавих шаардлага хангасан, төрийн мэргэшсэн албан хаагчид байх бөгөөд төрийн ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын дэг журмыг сахиж, гагцхүү хуулийн хүрээнд ажиллах зарчмыг баримтална.

10. Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

11. Улсын Их Хурлын гишүүний санал, хөдөлмөрийн гэрээг үндэслэн Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч, туслахыг томилж, чөлөөлнө.

12. Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг нь бүтцийн хувьд Тамгын газарт харьяалагдана.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр **Дугаар 06** **Улаанбаатар хот**

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, өөрийн нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Б.Өвгөнхүүг Төрийн байгууллагын болон Төсвийн Байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр **Дугаар 07** **Улаанбаатар хот**

2002 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2002 оны хаврын ээлжит чуулганаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хуулиар хугацаа заагаж хэлэлцэхээр тогтсон дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

2/ Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын санхуу олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын санхаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулыг нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

3/ Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүл мэндийн тухай болон Эмийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4/ Байгаль орчныг хамгаалах тухай, Ан агнуурын тухай, Ойн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/ Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

6/ Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/ Авилгалын эсрэг хуулийн төсөл, Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл;

8/ Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн тайлан;

9/ бусад.

2. Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлгийн шатанд байгаа дараахь хууль, тогтоолын төслийг 2002 оны хаврын ээлжит чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтсугай:

1/ Газрын тухай багц хуулийн төсөл;

2/ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөл;

3/ Зэвсэгт хүчний тухай хуулийн төсөл;

4/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

5/ Батлан хамгаалах тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/ бусад.

3. Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр төсөл санаачлагчдаас санал болгосон болон шаардлагатай гэж үзсэн бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2002 оны 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлбэл энэ оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4. Улсын Их Хурлын 2002 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Д.Батбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 106** **Улаанбаатар хот**

Жүгдэрнамжилын Гомбосүрэн, Билгээгийн Дорждэрэм нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Авхаалж самбаа, хүнлэг сэтгэл гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 2 дугаар багийн малчин Жүгдэрнамжилын Гомбосүрэн, Билгээгийн Дорждэрэм нарыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 107** **Улаанбаатар хот**

Довдонгийн Чадалбатхуяг, Хүрэлбаатарын Батхүү нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг гарган гарган усанд живж буй хүмүүсийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын иргэн Довдонгийн Чадалбатхуяг, Мөрөн сумын "Дэлгэрэмөрөн" цогцолбор сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Хүрэлбаатарын Батхүү нарыг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 108** **Улаанбаатар хот**

Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Нэг. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 6 дугаар заалтыг үндэслэж, "Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн зохицуулагч:

Я. Долгоржав - Ерөнхийлөгчийн улс төрийн бодлогын зөвлөх, дэд доктор, профессор

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

С. Цэдэндамба - ЕТГ-ын албаны дарга, дэд доктор, дэд профессор

Гишүүд:

1. Л.Баасан - "Отгонтэнгэр" их сургуулийн дэд захирал, доктор, профессор
2. С.Батболд - Гадаад харилцааны дэд сайд
3. Х.Гаадан - Өндөр настан
4. Г.Лувсанцэрэн - Буддын судлалын хүрээлэнгийн захирал, дэд доктор, профессор
5. Г. Лхагвасүрэн - Удирдлагын академийн "Эрдэм" сургуулийн захирал, дэд доктор, дэд профессор
6. Г.Маналжав - Нийслэлийн ИТХ-ын Төрүүлэгчдийн нарийн бичгийн дарга
7. Б.Мишигжав - БСШУЯ-ны төрийн нарийн бичгийн дарга
8. Ц.Мөнх-Оргил - Хуулзүй, дотоод хэргийн дэд сайд
9. О.Нигамет - УИХ-ын гишүүн
10. Д. Сугар - УИХ-ын гишүүн
11. Л.Тэрбиш - МУИС-ийн МХСС-ын сургуулийн багш, доктор, дэд профессор
12. Д.Чойжамц - Гандантэгчинлэн хийдийн төрүүн хамба, гавж
13. Г.Чулуунбаатар - УИХ-ын даргын зөвлөх, доктор, дэд профессор
14. Д.Энхбаяр - Сүхбаатар дүүргийн Засаг дарга

Хоёр. Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн шинэчилсэн дүрмийг хавсралт ёсоор батлсугай.

Гурав. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Шашны асуудал эрхэлсэн зөвлөл байгуулах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 26 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 108 дугаар зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөл /энэ дүрэмд цаашид "зөвлөл" гэх/ нь төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааны талаар Монгол Улсын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвлөх үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Шашин, сүм хийдийн талаарх төрийн бодлогын үзэл баримтлал, энэ дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн гишүүд

1. Зөвлөл нь төрийн захиргааны холбогдох төв байгууллагын удирдах албан тушаалтан, шашин судлал, мэдлэг ухаан, соёлын түүхийн асуудлаар мэргэшсэн нэр хүндтэй эрдэмтэн мэргэжилтнүүд хийгээд шашны зан үйл, уламжлалыг сайтар мэдэх ахмад сэхээтэн, лам хувраг, төрийн ажилтнаас бүрдэнэ.

2. Зөвлөлийн гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилж, чөлөөлнө. Зөвлөлийн гишүүд Ерөнхийлөгчийн гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байна.

3. Зөвлөлийн гишүүд зөвлөлийн ажилтай холбогдсон мэдээллийг нууцыг хадгалах үүрэгтэй.

Гурав. Зөвлөлийн эрхлэх ажил

1. Зөвлөл нь шаардлагатай үед дор дурдсан үндсэн чиг хүрээний асуудлуудыг хэлэлцэж санал дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж байна. Үүнд:
- Монголын төр, сүм хийдийн харилцаа,
- Төрөөс шашны талаар баримтлах бодлого,
- Ард түмний эв нэгдлийг хадгалан бататтах үүднээс шашин хоорондын харилцааг зохицуулах,
- Иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэх,
- Шашны байгуулагын гадаад харилцаа
- Монголын төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааны талаархи Монгол Улсын хууль тогтоомжууд, төрийн бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтийн байдал,
- Төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааны тухай хууль, тогтоомжуудыг боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн баримтлах байр суурь, санал санаачилга,
- Ерөнхийлөгчийн шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

2. Зөвлөл нь ажлаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

Дөрөв. Зөвлөлийн хуралдаан, ажлын зохион байгуулалт

1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2. Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонх оролцсон бол түүнийг хүчинтэй гэж үзнэ.

3. Зөвлөлийн хуралдаан нь асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн, олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.

4. Шаардлагатай бол Зөвлөлийн хуралдааныг холбогдох байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан ерөнтгесен бүрэлдэхүүнтэйгээр хийж болно.

5. Тодорхой асуудлаар эрдэмтэн, мэргэжилтнүүдээс ажлын хэсэг байгуулж магадлан шинжилгээ хийлгэсэн дүнг Зөвлөлийн хуралдаанаар сонсож болно.

6. Зөвлөлийн хуралдаанаас дүгнэлт, зөвлөмжийг протоколын хэлбэрээр гаргана.

7. Зөвлөлийн хуралдааны дүгнэлт, зөвлөмжийг Зөвлөлийн зохицуулагч Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.

8. Зөвлөл ажлаа жилээр төлөвлөнө. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг жил бүр хуралдаанаараа хэлэлцэж байна.

9. Зөвлөл лам хувраг, сүсэгтэн олны санаа бодлыг сонсох, төрөөс шашин, сүм хийдийн талаар баримталж байгаа бодлогыг тайлбарлан суртачлах зорилгоор гишүүдээ томилолтоор явуулж ажиллуулах арга хэмжээ авч болно.

10. Зөвлөл төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, шашин, сүм хийдийн талаархи төрийн бодлогын үзэл баримтлалын хэрэгжилт болон эрхлэх хүрээний бусад асуудлаар судлан танилцах ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

11. Төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааны асуудлаар Ерөнхийлөгчөөс УИХ, Засгийн газарт өгөх чиглэл, зөвлөмж, аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга нарт явуулах удирдамж даалгаврын төсөл, санал боловсруулна.

12. Зөвлөл төр, сүм хийдийн харилцааны асуудал эрхэлсэн сайд, аймаг нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн даргатай хуулийн дагуу ажлаа уялдуулан зохицуулна.

13. Зөвлөлөөс төр, сүм хийдийн харилцааны зангилаа чухал асуудлуудаар онол-арга зүйн хурал, хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, эрдэм шинжилгээний байгууллагад тодорхой асуудлаар судалгаа хийх, төсөл боловсруулах захиалга өгч болно.

14. Зөвлөлийн болон ажлын хэсгийн үйл ажиллагаат Зөвлөлийн зохицуулагч зохион байгуулна. Зөвлөлийн бичиг хэргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхэлнэ.

15. Зөвлөлийн зардал, бичиг хэрэг, үйлчилгээг Ерөнхийлөгчийн тамгын газар хариуцна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 12 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 109** **Улаанбаатар хот**

Дипломат цол олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын гадаад харилцааны салбарт үр бүтээлтэй ажиллаж, улс орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэрэнлэйн Үржинлхүндэвт Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр **Дугаар 01** **Улаанбаатар хот**

Ким Жин Сөнийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, монгол иргэдийг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сөүл хотын Сөн Ай эмнэлгийн дотрын тасгийн дарга, мэс засалч эмч Ким Жин Сөнийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр **Дугаар 02** **Улаанбаатар хот**

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Цогоогийн Одончимэгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, өөр албан тушаалд томилох болсон Норовын Лхагвадоржийг Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Гаажидын Дэлгэрбямбыг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр **Дугаар 03** **Улаанбаатар хот**

Зарим шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Гаажидын Дэлгэрбямбыг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Норовын Лхагвадоржийг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчийн, Цэнд-Аюушийн Ичинхорлоог Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Гаажидын Дэлгэрбямбыг Баянхонгор аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Норовын Лхагвадоржийг Хэнтий аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр **Дугаар 04** **Улаанбаатар хот**

Зарим шүүгчид зэрэг дэв олгох тухай

"Шүүхийн тухай" хуулийн 6^2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Монгол Улсын Шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус баримтлан, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Чимидхамын Ганбат, Улсын дээд шүүхийн шүүгч Баасайн Дангаасүрэн, Дамбын Данзандорж, Сандагийн Нямжав, Дуламын Пунцаг, Найдангийн Тербат нарт Монгол Улсын шүүхийн шүүгчийн тэргүүн түшээ зэрэг дэв тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр **Дугаар 06** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Юмбуугийн Сандагийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдинжавын Дашнямыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 260 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт, "Бүх нийтийн англи хэлний боловсролыг дэвшлүүлэхэд хэрэглэх сурах бичиг зохиох, хэвлүүлэх зардал"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. "Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт туссан санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгасугай.

3. "Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэл, бүсийн хэмжээнд харицуан зохион байгуулж, гүйцэтгэлийг нь жил тутам дүгнэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001оны 260 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад харилцаа ихээхэн өргөжиж, манай иргэд, гадаадын байгууллага, иргэдтэй харилцах, хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломж, шаардлага нэмэгдэж байна. Иймээс англи хэлний сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хангамж хүрэлцээ дутмаг, англи хэлний багш нарын хэлний чадвар хангалтгүй, тэдгээрийн 40 орчим хувь нь орос хэлний үндэсэн мэргэжилтэй, англи хэлийг дамжаа болон богино хугацааны сургалтаар эзэмшсэн, орон нутагт англи хэлний багшийн хүрэлцээ, тогтвор суурьшил муу, англи хэлний сургалтын орчин сайн бүрдээгүй зэрэг нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

Энэхүү бодит хэрэгцээнээс үүдэн гадаад хэл, түүний дотор англи хэлийг нийтээр сурах, сургалтын агуулгын стандартыг шинэчлэх, сургалтын иж бүрэн хэрэглэгдэхүүнийг ашиглах, бүх шатны сургуулийн англи хэлний багш нарын мэргэжлийн чадвар, заах аргыг сайжруулах, англи хэлний багш бэлтгэх, орон нутагт англи хэлний багш нарын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, англи хэлний сургалтын таатай орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байгааг үндэс болгон энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2. Бүх шатны сургуулийн англи хэлний сургалтын агуулга, заах арга зүй, сурах бичгийг шинэчлэн боловсронгуй болгох, англи хэлний багш нарын мэргэжил, хэлний болон заах аргын чадварыг сайжруулах, орон нутагт англи хэлний багш нарын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн ажиллах нөхцөлийг сайжруулж, урамшуулллыг бий болгох, иргэдийн англи хэл сурах таатай орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3. Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.1. Англи хэлний сургалтын стандартыг боловсруулан мөрдүүлэх;

3.2. Англи хэлний сургалтын технологийг боловсронгуй болгон, шинэлэг арга, хэлбэрийг сонгон хэрэглэгчлэх, англи хэлний сургалтын төв, кабинетийг шинэчлэх;

3.3. Англи хэлний багш бэлтгэх, тэдний заах арга, мэргэжлийн чадварыг дээшлүүлэх;

3.4. Англи хэлний багш нар орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, багш нарын хүрэлцээг сайжруулах;

3.5. Англи хэлний шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх;

3.6. Англи хэлний сургалтын таатай орчин бүрдүүлэх, бүх нийтийн англи хэлний боловсролыг сайжруулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4.1. Боловсролын хууль тогтоомж, эрхэм зорилго, стратегийн зорилт, хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх.

4.2. Суралцагчдын сонирхол, хэрэгцээнд нийцсэн, уян хатан, нээлттэй байх.

4.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн бодит хэрэгцээнд тулгуурласан байх.

Тав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа

5.1. Англи хэлний сургалтын стандартыг боловсруулан мөрдүүлэх:

5.1.1. Англи хэлний сургалтын агуулгын, орчны, үнэлгээний стандарт боловсруулан мөрдүүлэх;

5.1.2. Англи хэлний сургалтад хамрагдагсдын оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдын ярих, бичих, чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтын идэвхитэй аргуудыг нэвтрүүлэх;

5.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн бодит хэрэгцээг хангасан байх.

5.2. Англи хэлний сургалтын технологийг боловсронгуй болгох:

5.2.1. Англи хэлний сургалтад WEB сурах бичиг, багшийн болон сурагчийн гарын авлага, хуурцаг, аудио хуурцаг зэргийг өргөн хэрэглэх;

5.2.2. Суралцагсдын нас, сэтгэхүйн онцлог, орчны нөхцөлд тохируулан хичээлээс гадуурхи сургалтын хэлбэрүүд, хэсэгчилсэн сургалтыг зохион байгуулах;

5.2.3. Англи хэлний бүх шатны сургалтад өөрийн орны ур чадвар сайтай багш нарын туршлага болон гадаад орны сургалтын шинэлэг арга хэлбэрийг судлан туршиж нэвтрүүлэх;

5.2.4. Англи хэлний мэдлэг чадварыг сайжруулахад чиглэсэн заах аргын болон ур чадварын уралдаан, олимпиад зохион байгуулах;

5.2.5. Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын англи хэлний олимпиад, орон нутгийн хэмжээнд "Англи хэлийг хэн сайн мэдэх вэ" уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулах.

5.3. Англи хэлний багш бэлтгэх, багш нарын мэдлэг, заах аргын чадварыг дээшлүүлэх:

5.3.1. Бүх шатны сургуулийн багш нарын заах арга, мэргэжлийн ур чадвар, хэлний чадварыг сайжруулах чиглэлээр англи хэлний сургалт эрхэлдэг гадаадын байгууллагатай хамтран төвийн болон бүсийн сургалт, семинарыг зохион байгуулах;

5.3.2. Одоо ажиллаж байгаа англи хэлний багш нарын 20-30 хувийг ойрын 4 жилд магистрын сургалтад хамруулах;

5.3.3. Гадаад оронд мэргэжил, хэлний чадварыг дээшлүүлэх, монголд ажиллаж байгаа сайн дурын байгууллагын англи багш нартай хамтран ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;

5.3.4. Багшлах эрх аваагүй боловч багшилж байгаа хүмүүст зориулан англи хэл заах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж үнэмлэх олгох;

5.3.5. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд зайны болон албан бус сургалтын хэлбэрийг өргөнөөр ашиглах;

5.3.6. Гадаад хэлний сургалттай дээд сургууль, Англи хэлний түсгай зориулалтын институтийг түшиглэн англи хэлний багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх эрчимтэй сургалт зохион байгуулах.

5.4. Англи хэлний багш нар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах:

5.4.1. Англи хэлний багш нарыг аймаг, сумдын захиалгаар гэрээгээр сургах, орон нутагт ажиллах багш нарт зохих урамшуулал болгон гурван жил тутам нэг удаа 500,000 төгрөгийн тэтгэлгийг улсын болон орон нутгийн төсвөөс олгож байх;

5.4.2. Англи хэл заах аргын нэгдсэн болон төрөлжсөн сургалтад сумдын багш нарыг өргөн хамруулж, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх;

5.4.3. Орон нутагт ажиллаж байгаа англи хэлний багш нарыг гадаад орон, олон улсын сайн дурын байгууллагын шугамаар ажиллаж байгаа англи багш нартай хамтран ажиллах хүрээг өргөтгөх;

5.4.4. Гадаад оронд мэргэжил дээшлүүлэх, танилцах аялал хийх зэрэг төсөөр хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд сумдын багш нарыг өргөн хамруулах.

5.5. Англи хэлний төрөлжсөн сургалтын тогтолцоо бүрдүүлэх:

5.5.1. Төрийн албан хаагчдад зориулсан англи хэлний эрчимтэй сургалт зохион байгуулах;

5.5.2. Гадаад хэлний тусгайлсан сургалттайгаас бусад бүх шатны сургуульд сургалтын үндсэн программд англи хэлийг оруулахаас гадна, гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулах;

5.5.3. Радио, телевизээр англи хэлний сургалт зохион байгуулах;

5.5.4. Англи хэлийг бие даан сурах, бүх нийтийн англи хэлний боловсролыг сайжруулахад зориулсан гарын авлага, сурах бичиг, аудио болон видео хуурцаг хэвлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.5.5. Олон улсын харилцаа, эдийн засаг, сэтгүүл зүй, аялал жуулчлал, анагаах ухаан, техник технологийн мэргэжлийн чиглэлийн сургалт, түүнчлэн суурь болон сонгон мэргэшүүлэх зарим хичээлийг англи хэлээр заах бэлтгэл хангах;

5.5.6. Англи хэлний сургалт эрхэлдэг дамжааны сургалтын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, сургалтад тавих хяналтыг сайжруулах;

5.5.7. АНУ-ын TOFEL-ийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран англи хэлний мэдлэгийн стандартын түвшин тогтоох, хэлний сургалтад хамрагдагчдад сертификат олгох асуудлыг судлан хэрэгжүүлэх.

5.6. Англи хэлний сургалтын таатай орчин бүрдүүлэх, бүх нийтийн англи хэлний боловсролыг сайжруулах:

5.6.1. Аймаг, сумдын Боловсрол, соёлын төвүүдэд англи хэлний сургалтын төв байгуулж техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн арга зүйгээр хангах;

5.6.2. Англи хэлний сургалтыг зохион байгуулахад хэсэгчилсэн, албан болон албан бус сургалтын хэлбэрийг эрчимтэй зохион байгуулах;

5.6.3. Сургуулиудын англи хэлний сургалтын анги кабинетийг шинэчлэн сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслээр хангах;

5.6.4. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа англи хэлний багш нарын зүгээс бүх нийтийн англи хэлний боловсролыг сайжруулахад чиглэгдсэн англи хэлний төлбөртэй дамжаа хичээллүүлэхийг дэмжих;

5.6.5. Сургалтын орчин бий болгох зорилгоор англи хэлний багш нарт зориулан, зуны улиралд "Англи тосгон" ажиллуулах.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү хөтөлбөрийг 2002-2005 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн

дор дурдсан эх үүсвэрийг ашиглана:

-Багш нарын мэргэжил дээшлүүлэх, хэлний болон заах аргын ур чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааанд нийт 34.2 сая төгөрөг зарцуулна. Эдгээрээс 27.0 сая төгрөгийг улсын төсвөөс, үлдэх 7.2 сая төгрөгийн санхүүжилтийг Монголын нээлттэй нийгэмлэгийн хүрээлэн "СОРОС"-ын сангаас санхүүжүүлнэ;

-Англи хэлний сурах бичиг,сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэн хэвлүүлэхтэй холбогдон гарах нийт 640.0 сая төгөрөг шаардагдахаас 197.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ;

-Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэхэд зориулагдсан сурах бичгийг боловсруулах, хэвлэхэд 77.5 сая төгөрөг шаардагдана. Энэ зардлыг жил жилийн улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ /Хавсралт 3/.

-Англи хэлний сургалтын орчин бүрдүүлэх зорилго бүхий "Англи тосгон" ажиллуулахад багш нарын байр, хоол, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнд зарцуулагдах 39 сая 513 мянган төгрөгийн 25.0 сая төгрөгийг улсын төсвөөс, англи багш нарын ажиллах ажлын хөлс, байр хоолны зардал болох 14 сая 513 мянган төгрөгийг англиин сайн дурын байгууллага, Энхтайвны корпус болон бусад англи хэлний сургалт эрхэлдэг гадны байгууллагаас санхүүжүүлнэ.

-Багш нарын хангамж, хүрээлцээг сайжруулах зорилгоор хөдөө орон нутагт ажиллах багш нарыг урамшуулахад зориулах 40.0 сая төгрөгийн 15 хувийг орон нутаг, үлдсэн хэсэг болох 34.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

-Англи хэлний багш нарын хэлний болон арга зүйн ур чадварыг сайжруулах зорилгоор явагдах сургалтыг гадаадын байгууллагын хандив болон сургалтын төлбөрөөр санхүүжүүлнэ.

-Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх сургалтыг төлбөртэй зохион байгуулна.

-Гадаад оронд мэргэжил дээшлүүлэхэд зарцуулагдах хөрөнгийг хамтран ажиллах гадаадын байгууллагын санхүүжилтээр шийдвэрлэнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

8.1. Англи хэлний сургалтын агуулгын шинэ стандартыг батлан мөрдүүлнэ. Ингэснээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад орчин үеийн техник, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан хэрэгцээтэй мэдээллээ олж ашиглах англи хэлний мэдлэгтэй болсон байна.

8.2. Агуулгын шинэ стандартад нийцүүлэн сурах бичиг, багш болон сурагчийн ажлын, дасгалын дэвтэр, гарын авлага, кассет /web сурах бичиг/ аудио хуурцаг боловсруулж 2002 оны Y ангийн 70.000, 2003 оноос YI-YШ ангийн иж бүрэн сурах бичиг тус бүр 70.000 хувийг ерөнхий боловсролын сургуулийн сургалтад хэрэглэсэн байна.

8.3. Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарын ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалтад 2002-2004 онд орон нутгийн 300 багшийг оролцуулж, жил бүр тодорхой тооны багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

8.4. Жил бүр гэрээ байгуулан 15-20 багшийг сумдад ажиллуулснаар орон нутагт англи хэлний багш нарын хүрэлцээ нэмэгдсэн байна.

8.5. Англи хэлний сургалтын 80-100 иж бүрэн англи кабинетийг байгуулан ажиллуулж бүрэн ашигласан байна.

8.6. Англи хэлний нийт багш нарыг бакалаврын зэрэгтэй болгохоос гадна 20-30 хувийг нь магистрын сургалтад хамруулсан байна.

8.7. Англи хэл заах арга зүйн чиглэлээр мэргэшсэн докторын сургалтад багш нарыг хамруулна.

8.8. Бүх нийтийн англи хэлний мэдлэгийн түвшин нэмэгдэж терийн албан хаагчид болон бусад салбарын мэргэжилтнүүд англи хэлээр харилцах, мэдээлэл авах чадвартай болсон байна.

8.9. Англи хэлний сургалтын орчин бүрдүүлэх зорилгоор "Англи тосгон" ажиллуулснаар хөтөлбөр хэрэгжих явцад багш нарын англи хэлний мэдлэг чадвар сайжран тосгоны үйл ажиллагааг өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хэмжээнд тогтворжуулсан байна.

Засгийн газрын 2001оны 260 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах, хамтран ажиллах байгууллага
Англи хэлний сургалтын төрөлжсөн тогтолцоог бүрдүүлэх	– Хүмүүнлэгийн ухааны их сургууль болон Англи хэлний багш нарын холбоотой хамтран төрийн албан хаагчдын болон иргэдийн дунд англи хэлний сургалтыг зохион байгуулах. – Радио, телевизээр англи хэлний сургалтыг тогтмол зохион байгуулах – Олон улсын харилцаа, эдийн засаг, сэтгүүл зүй, аялал жуулчлал, анагаах ухаан, техникийн чиглэлийн мэргэжлийн болон суурь, сонгон мэргэшүүлэх зарим хичээлийг англи хэлээр заах бэлтгэл хангах, зааж эхлэх. – АНУ-ын TOFEL-ийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох, сертификат олгох, "Англи тосгон" байгуулах.	Хүмүүнлэгийн ухааны их сургууль Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Англи хэлний багш нарын холбоо Радио,телевизийн хэрэг эрхлэх газар Их, дээд сургуулиудын консерциум Хотын боловсролын газар Аймаг, хотын боловсрол төв, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
Англи хэлний сургалтын агуулга, орчны, үнэлгээний стандартыг боловсруулан мөрдүүлэх	– Англи хэлний сургалтын, агуулгын, орчны, үнэлгээний иж бүрэн стандартыг боловсруулан мөрдүүлэх. – Суралцагчдын дунд нас, сэтгэхүй, орчны онцлогт тохирсон сургалтын бусад хэлбэрүүдийг бодитойгоор хэрэгжүүлэх	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Аймаг, хотын боловсрол төв
Англи хэлний багш нарын мэдлэг,чадварыг дээшлүүлэх багш бэлтгэх, давтан сургах, өндөр зэрэглэлтэй багш бэлтгэх	– Бүх шатны сургуулийн багш нарын заах арга, мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр төвийн болон бүсчилсэн сургалт семинарыг зохион байгуулах. – Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн дэргэд Англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх төв байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулах. Энэхүү төвд англи хэлний бакалавр, магистр багш бэлтгэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам МННХ /СОРОС/-ийн сан Хүмүүнлэгийн ухааны их сургууль Аймаг, хотын Боловсрол төв Англи хэлний багш нарын холбоо

	– Багшлах эрх аваагүй боловч багшилж байгаа хүмүүст зориулан англи хэл заах арга зүйн чиглэлээр сертификатын сургалтыг зохион байгуулах.	
Англи хэлний сургалтын таатай орчин бүрдүүлэх.	– Аймаг, хотын боловсрол төвийн дэргэд англи хэлний сургалтын төв байгуулан техник хэрэгслээр хангах – Англи хэлний анги кабинетийг шинэчлэн сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, номын сан зэргийг сургалтад өргөн хэрэглэх	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Аймаг, хотын Боловсроол төв
Англи хэлний багш нарыг хөдөө сумдад ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх дэмжих	– Англи хэлний багш нарыг тухайн сургууль, аймаг, сумтай гэрээ байгуулан хөнгөлөлттэй зээлээр сурган төгсгөж ажиллах боломжийг хангах. – Хөдөө сумдад ажиллах багш нарт урамшуулал олгох замаар дутагдаж байгаа багш нарын тоог бууруулах – Орон нутагт ажиллаж байгаа багш нарыг гадаад орны англи хэлний сургалт эрхэлдэг байгууллагын багш нартай хамтран ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх. – Орон нутагт ажиллаж байгаа англи хэлний багш нарыг гадаад орны багш нарын туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Их дээд сургуулиудын консерциум Аймаг, хотын бүх шатны Засаг даргын Тамгын газар ЭТК Английн сайн дурын байгууллага
Англи хэлний сургалтын хэрэглэгдэхүүн сурах бичиг, сургалтын технологийн шинэлэг арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх	– Англи хэлний агуулгын стандартад нийцсэн WEB сурах бичиг, гарын авлага, аудио хуурцаг зэргийг боловсруулж сургалтад хэрэглэх. – Англи хэлээр суралцагчдын дунд ураалдаан, мэтгэлцээн зохион байгуулж уламжлал болгох. – "Англи хэлийг сайн мэдэх вэ" уралдааныг орон нутагт жил бүр зохион байгуулж амжилттай оролцсон сурагчдыг урамшуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх.	МННХ/СОРОС/-гийн сан Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Англи хэлний багш нарын холбоо

Засгийн газрын 2001оны 260 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

БҮХ НИЙТИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ХЭРЭГЛЭХ СУРАХ БИЧИГ ЗОХИОХ, ХЭВЛҮҮЛЭХ ЗАРДАЛ

/төгрөгөөр/

Сурах бичиг, ангилал	Хэвлэгдэх он	Хэвлэлийн хуудас	Тоо ширхэг	Шаардагдах зардал
Англи хэлний анхан шатны сурах бичиг, хуурцгийн хамт	2002 он	20	5000	20.0 сая
Англи хэлний дунд шатны сурах бичиг	2003 он	20	5000	20.0 сая
Англи хэлний дүрэм	2004 он	10	5000	17.5 сая
Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалтын сурах бичиг	2005 он	20	5000	20.0 сая
Нийт дүн-77сая 500 мянга				

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр **Дугаар 273** **Улаанбаатар хот**

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгалийн гамшгийн аюулыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шат /2001-2005 он/-ны зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөнд туссан зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтын эх үүсвэрийг төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд зохицуулах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

4. Төлөвлөгөөний холбогдох заалтыг өөрийн хариуцсан салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулан хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

БАЙГАЛИЙН ГАМШГИЙН АЮУЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТ /2001-2005 ОН/-НЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн	Хариуцах байгууллага
1.	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах эрх зүй, эдийн засгийн механизмыг тогтолдержүүлэх	1. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох	2002	Гамшгийн удирдлага менежментийн тогтолцоог шинээр бий болгоно	БХЯ
		2. Газрын төлберийн тухай хуульд өөрчлөлт оруулж бэлчээрийн даац, ашиглалтыг тэнцвэржүүлэх бодлогыг эдийн засгийн аргаар зохицуулах	2002-2003	-бэлчээрийн менежмент сайжирч бэлчээрийн талхлагдал багасч цөлжилтийн явцыг сааруулна	БОЯ ХХААЯ СЗЗЯ
		3. МАА-н үйлдвэрлэлийг ган, зуд, бусад байгалийн гамшгаас сэргийлэх, хамгаалах тогтолцоо, гамшгийн мэдээллийн сүлжээ байгуулах, гамшгаас сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлаар санал боловсруулах	2002-2003	-холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр эрхзүйн зохицуулалт бий болгох замаар байгалийн гамшгаас учирдаг хохирлыг бууруулна. Гадаад, дотоодын хандив, тусламжийг зохистой ашигладаг болно	ХХААЯ ХЗДХЯ БОЯ БХЯ
		4. Хот, суурин газрын үерт автаж болзошгүй болон уулын эмзэг экосистемтэй газруудын газар ашиглалтыг хязгаарлах, хамгаалалтад авах журам боловсруулж мөрдүүлэх	2002-2003	-нуур, голын усны түвшин буурах болон экосистемийн доройтолд хүргэж буй хүчин зүйлийг багасгана	БОЯ
		5. Байгалийн гамшгаас хамгаалахад чиглэгдсэн даатгалын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх	2002	-даатгалын тогтолцоо бий болгосноор учирсан хохирлыг богино хугацаанд арилгах боломжтой болно	ХХААЯ СЗЗЯ ХЗДХЯ

		6. Ой, хэзрийн түймрээс хамгаалах зурвас гаргах, ойд арчилгаа цэвэрлэгээний огтлолт хийх зэрэг нормативийг батлан мөрдүүлэх	2002-2003	-нормативийг батлан мөрдүүлснээр ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх нэг нөхцөл бүрдэнэ	ХЗДХЯ БОЯ
		7. Ураг, энергийн агууламж өндөртэй тэжээлийн үргамал тариалах, усалгаатай газар тариалан, хүлэмжийн аж ахуйг эрхлэх зэргээр эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизм бий болгох	2002-2005	-эдийн засгийн салбаруудын байгалиас хараат байдал буурна	ХХААЯ СЭЗЯ
		8. Хил орчмын бүсэд гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах тухай Монгол улс, ОХУ-ын Засгийн газрын хэлэлцээр байгуулах	2002	- хил дамжсан түймрээс сэргийлэх, учруулсан хохирлыг барагдуулах эрх зүйн үндэс бүрдэнэ	ХЗДХЯ БХЯ БОЯ ГХЯ
2.	Байгалийн гамшгаас сэргийлэх, даван туулах зохион байгуулалтын болон ард иргэдийн чадавхийг бэхжүүлэх	1. Гамшгаас урьдчилан сэргийлэх талаар сургалтын материал, зураг хуудас хэвлэн нийтлэх, радио, телевизээр тогтмол нэвтрүүлэг явуулдаг болох	2002-2005	-гамшгаас урьдчилан сэргийлэх талаар ард иргэд тодорхой мэдлэгтэй болж, тэмцэх чадавхи нэмэгдэнэ	БОЯ БХЯ
		2. Байгалийн гамшгийн аюулаас сэргийлэх, гамшгийн үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалахад ард иргэдэд мэдлэг, чадвар олгоход чиглэсэн сургалт,сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлэх	2002-2004	-гамшиг тохиолдсон үед ард иргэдийн авран хамгаалах чадвар дээшилж, эрүүл мэндийн үйлчилгээг тасралтгүй хүргэх бололцоог нэмэгдүүлнэ.	БХЯ ЭМЯ
		3. Байгалийн гамшигтай тэмцэх орон нутгийн хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	2002	-орон нутаг өөрсдийн эдийн засгийн онцлогт тохирсон байгалийн гамшигтай тэмцэх хөтөлбөртэй болно	ХХААЯ БОЯ БХЯ
		4. Байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдийг бүсчилсэн	2002-2005	- тухайн бүс нутагт аливаа төрлийн байгалийн гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээг	БХЯ ХХААЯ

		хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу тухайн нутгийн дэд бүтэц, эдийн засгийн хөгжил, байгалийн бүс, бүслүүрийн нөхцөлийг харгалзан байгуулах		зохион байгуулж тусламжийг шаардлагатай газарт нь шуурхай хүргэх бололцоотой болно	
		5. Байгалийн гамшигтай тэмцэх бүсийн төвүүдэд гамшгийн сургалтын төв байгуулах	2002-2003	- орон нутагт гамшигтай тэмцэх бүх шатны удирдлага, албан тушаалтан, мэргэжлийн байгууллагын аврагчдыг сургаж дадлагажуулах боломж бий болно.	БХЯ
		6. Байгалийн гамшгаас мал сүргийг хамгаалах санг бүх аймаг, суманд байгуулах	2002-2003	- гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах, арилгах боломж олгоно	ХХАА Я СЭЗЯ аймгийн Засаг дарга нар
3.	Байгалийн гамшгийн аюулыг урьдчилан мэдээлэх, үнэлэх шинжлэх ухаан технологийн үндэслэлийг сайжруулах	1. Ган, зудын үнэлгээ хийх журам, хэрэглэх аргачлал боловсруулах	2002	-ган, зудыг бодит байдлаар тогтоох, авах арга хэмжээний түвшинг тогтоож өгөх нөхцөл бүрдэнэ	БОЯ ХХАА Я
		2. Ган, зудыг 6 сараас багагүй хугацааны өмнө урьдчилан мэдээлэх арга, технологи боловсруулж нэвтрүүлэх	2002-2004	-ган, зудыг олон сарын өмнөөс одоогийнхоос илүү нарийвчлалтай урьдчилан мэдээлэх шинэ арга технологи гарснаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж бүрдэж, хохирол буурна	БОЯ
		3. Бэлчээрийн ургац, хэмжээг баг, сум бүрээр тодорхойлсны үндсэн дээр жил бүрийн IX сард багтаан бэлчээрийн даац, багтаамжийг тодорхойлж мал өвөлжилт, хаваржилтыг зохион байгуулах шуурхай төлөвлөгөө гарган мөрдүүлэх	2002-2003	-бэлчээр ашиглалтыг сайжруулах, отор нүүдэл зохион байгуулах зэрэгээр өвөлжилтийн бэлтгэлийг эртнээс хангах үндсэн дээр малын хорогдлыг бууруулах боломж бүрдэнэ	БОЯ ХХАА Я УБОК БХЯ
		4. Байгалийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг бүс нутгийн болон засаг захиргаа, томоохон аж ахуйн нэгжийн хэмжээнд нарийвчлан хийх	2002-2004	- гамшгийн эрсдэлийн үнэлгээг засаг захиргаа, аж ахуйн нэгжийн хэмжээнд нарийвчлан хийснээр аюулаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөө боловсруулах, хохирлыг бууруулах боломж дээшилнэ.	БОЯ БСШУЯ БХЯ

	5. Ус, цаг уурын мэдээ боловсруулах, дамжуулах, цаг агаарын урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээ гаргах техник технологийг боловсронгуй болгож нийтэд зориулсан мэдээний чанарыг дээшлүүлэх	2002-2004	-ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан тооцоолох шинэ объектив арга зүвтрүүлэх, гидродинамик прогнозын загвар, эх мэдээний ангилан боловсруулах шинэ арга зүвтрүүлсний үр дүнд агаар мандлын гарэлтай байгалийн гамшгийг сум бүрийн нутгаар 72 цаг хүртэл хугацааны өмнөөс прогнозлох боломж олдоно	БОЯ
	6.Улаанбаатар-Новосибирский хоорондх хиймэл дагуулын өндөр хурдтай сувг түрээслэх. Улаанбаатар-Бээжингийн хооронд хиймэл дагуулын телеграфын сувгийг телефон сувагт шилжүүлэн цаг уурын холбооны үндсэний төвд хиймэл дагуулын холбоо /VSAT/ тавих	2002	-хиймэл дагуулын холбоонд шилжсэнээр мэдээллийг шуурхай хүлээн авах найдвартай ажилгаанд дэвшил гарч цаг агаарын урьдчилсан мэдээний чанар сайжирна	БОЯ
	7. Цаг уурын холбооны үндсэний төв болон аймгуудын хооронд VSAT-ын холбоонд шилжих	2002-2004	-цаг уурын холбооны үндсэний төв болон орон нутгийн цаг уурын байгууллагуудын хооронд мэдээлэл дамжуулах найдвартай системтэй болж орон нутагт өндөр чанартай урьдчилсан мэдээ зохиох боломж бүрдэнэ	БОЯ
	8. Тоон прогнозын загвар нэвтрүүлэх, мэдээллийн бүрдүүлэлт хийх зорилгоор Ус, цаг уурын хүрээлэнд өндөр хүч чадалтай компьютер суурилуулах, мэдээлэл-боловсруулалт-прогнозын автоматжуулсан технологийн шугам бүрдүүлэх	2001-2005	-цаг агаарыг урьдчилан мэдээлэхэд тоон прогнозын загвар түршин нэвтрүүлснээр цаг агаарын урьдчилсан мэдээны чанар дээшилнэ.	БОЯ
	9. Ус, цаг уур, орчны ажилгаатын улсын сүлжээнд автомат цаг уурын станц ашиглах, дотоодын станц хангамжийн ажлыг үе шаттайгаар сайжруулах	2002-2005	-ус, цаг уурын ажилгаатын сүлжээний хэмжилтийн найдвартай байдал дээшилнэ.	БОЯ УХЯ СЗЗЯ
	10. Мөрөн, Арвайхээр хотуудад цаг	2002-2005	- цаг уурын радар тавигданаар үер усны	БОЯ

		уурын радар тавих		аюулаас найдвартай урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ	
		11. Газар хөдлөл, цэвдэгшил, соронзон судлал, орчны цацраг идэвхжил, таримал болон бэлчээрийн хортон шавьж, озоны хэмжилт, хил дамжсан агаарын бохирдол, агаарын булингаршил, элсний нүүлт, хүчиллэг тунадасны хяналт-шинжилгээний дүнг ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээн дээр боловсруулах.	2002-2004	-дээрх үзэгдлүүдийг нэг төвд төвлөрүүлэн хийснээр улсын хэмжээний нэгдмэл мэдээллийн сан, су лжээ бүрдүүлэхэд чухал алхам болно	БОЯ ХХААЯ БСШУЯ
		12. Бэлчээрийн даацыг шинэчлэн тогтоож төлөв байдлыг үнэлэх	2002-2005	-бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ	ХХААЯ БОЯ БСШУЯ
		13. Монгол орны цөлжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, туушгай тэмцэх арга замыг боловсруулах чиглэлээр судалгааны ажлыг өргөтгөх	2002-2004	- цөлжилтийн өнөөгийн төлөв байдал, газрын доройтлыг шинэчлэн тодорхойлсноор цаашид баримтлах бодлого, авах арга хэмжээний үндэслэл боловсргодоно	БОЯ БСШУЯ
		14. Цаг уурын хөдөлгөөнт радар 1-2-ыг худалдан авч үйлчилгээнд ашиглах	2002-2005	- цаг агаарын богино хугацааны урьдчилан мэдээлэх болон хур тунадсанд зориудаар нөлөөлж ашиглах үйлчилгээнд ахиц гарна	СЗЗЯ БОЯ
		15. Өндөр уулын бүсэд иодот мөнгөний үүсгүүр ашиглан хур тунадас нэмэгдүүлэх туршилт хийх	2002-2004	-үүлэнд зориудаар нөлөөлөх технологи боловсруулж, нэвтрүүлснээр газар тариалан болон бэлчээрийг мөндөр болон гангаас хамгаалах боломж дээшилнэ.	БОЯ БХЯ
		16. Үүлэнд зориуд нөлөөлөх хөдөлгөөнт отрядуудыг зохион байгуулах	2002-2005	-хүн, техник хүрэх бололцоогүй нөхцөлд ойн түймэр унтраах, таримал ургамлыг мөндөөс хамгаалах ажлыг үр ашигтай хэрэгжүүлэх боломж олдоно	БОЯ БХЯ
		17. Химийн хорт бодис хэрэглэдэг томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулын зэргийг	2002-2003	-химийн хортой бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна	БХЯ

		тогтоож, үнэлэх аргачлал зааврыг шинээр боловсруулах			
4.	Байгалийн гамшгийн зарлан мэдээлэх сүлжээг сайжруулах, хөдөөгийн ард иргэдэд мэдээлэл хүргэх үйл явцыг боловсронгуй болгох. Гамшгийн мэдээллийн сан байгуулах	1. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотуудыг байгалийн гамшгийн мэдээллийн дуут дохиололтой болгох.	2002-2003	- гамшиг тохиолдсон үед олон нийтэд шуурхай зарлан мэдээлэх дуут дохиололтой болно.	БХЯ
		2. Радио, телевиз болон интернет зэрэг бусад төрлийн холбоо мэдээллийн сувгаар цаг уурын мэдээ дамжуулах давтамжийг нэмж, агуулгыг сайжруулах	2002-2004	- ард иргэд, ялангуяа хөдөөгийн хөдөлмөрчдийг аливаа аюул гамшгийн талаархи шуурхай мэдээллээр хангах нөхцөл бүрдэнэ	БОЯ ДБЯ
		3. Түймрийн мэдээлэл авах, шуурхай дамжуулах суурин болон зөөврийн радио холбоог Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт суурилуулах	2002-2004	- байгаль орчны болон гал түймэр унтраах үүрэг бүхий байгууллага, салбаруудын хооронд мэдээлэл шуурхай солилцох боломжтой болно	БОЯ БХЯ
		4. Химийн хортой, онц аюултай бодисын импорт хэрэглээний мэдээллийн сан байгуулах ажлыг Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх	2002	-хот, суурин газар тэдийгүй хил хязгаар, орон нутагт химийн хорт бодисын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндэс болно	БОЯ УХЯ ЭМЯ
		5. Байгаль орчны мэдээллийн санг баяжуулж мэдээллийн сүлжээг бэхжүүлэх	2002	-байгалийн гамшгийн мэдээллийн сан байгуулах, олон улсын түвшинд мэдээлэх тогтолцоо бүрдэнэ	БОЯ БХЯ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 274** **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Куба Улсад энэ оны 11 дүгээр сард тохиолдсон байгалийн гамшиг-далайн хар салхины хохирлыг арилгахад зориулж Кубын Засгийн газарт хүмүүнлэгийн тусламж болгон олгох 11.0 /арван нэгэн/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 275** **Улаанбаатар хот**

Төсөл дэмжих тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн мал эмнэлгийн лабораторийн оношлогоо, шинжилгээний чадавхийг сайжруулах тухай заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхийг бэхжүүлэх" төслийг зөвшөөрч дэмжсүгэй.

2. Малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсвийн тодотголоор шүлхий өвчинтэй тэмцэх ажилд төлөвлөсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

3. "Малын гоц халдварт өвчнийг оношлох чадавхийг бэхжүүлэх" төслийг 2002 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлж малын гоц халдварт өвчнийг цаг алдалгүй оношлон тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээд Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 276** **Улаанбаатар хот**

Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны нэр, тоог тогтоох тухай

Ан агнуурын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тусгай зориулалтаар 2002 онд үгалз 80, тэх 280, харсүүлтий 60, халиун буга 45, бор гөрөөс 40, цагаан зээр 100, гахай 10, чоно 150, агнуурын шувуу 1200 хүртэл толгойг агнуулах, мануул 6 толгойг амьдаар нь гадаадад гаргахаар тус тус тогтоосугай.

2. АНУ-ын Лас-Вегас хотноо 2002 оны 3 дугаар сард "Сафари клуб интернэшнл" байгууллагаас зохион байгуулах үгалз агнах эрхийн олон улсын дуудлага худалдаанд Монгол Улсаас үгалз, тэх зэрэг агнуурын зарим амьтан агнах эрхийг дуудлагад оруулах арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 277 | Улаанбаатар хот

Махны үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт тусгагдсан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлуулсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь:

а/төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн эцсийн гүйцэтгэлээр гаргаж дараа оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг үүрэг болгосугай;

б/гахай, шувууны аж ахуй хөгжүүлэхэд чиглэсэн санаачилгыг дэмжиж, энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

в/мах үйлдвэрлэгч болон экспортлогч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг мал эрүүлжүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх зорилгод чиглүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтарч ажилласугай.

3. Хот, суурин газрын хүн амын хэрэгцээг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Мал сүргийг эрүүлжүүлэх, мах боловсруулах үйлдвэрүүдэд техникийн шинэчлэл хийх, бага оврын махны үйлдвэр байгуулах, мал бордох болон мах судлалыг хөгжүүлэх, монгол малын махыг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн боловсруулж экспортлох, үүнтэй уялдуулан орчин үеийн лаборатори бий болгох арга хэмжээ авч тэдгээрт шаардагдах хөрөнгийг дотоодын болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт үүрэг болгосугай.

5. Хөрш зэргэлдээ болон сонирхогч улс орнуудын махны эрэлт хэрэгцээг судлан мах экспортлох хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
Үндсэн зорилт: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд махны экспортыг жил бүр урьд оныхоос 20 хүртэл хувиар нэмэгдүүлж 2004 оны түвшинд 25 мянган тонн мах экспортолно.			
	Нэг. Сайн чанарын мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар:		
1. Мал сүргийг эрүүлжүүлэх	1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх "Хэсэгчилсэн вакцинжуулалт" хийх төсөл хэрэгжүүлэх (11 аймгийн 89 сум хамрагдана.)	ХХААЯ, УМЭГ	2001-2002
	2 ."Малын эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд үхэр сүргийг сүрьеэ, лейкоз, брүцеллёз, адуун сүргийг ям, адууны халдварт цус багасах өвчнөөс эрүүлжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ХХААЯ, УМЭГ	2002-2004
	3. Малын А, Б ангиллын халдварт өвчний гаралт, тархалтын талаар баг, сум, аймаг бүрээр судалгаа явуулсны үндсэн дээр "Малын халдварт өвчингүй сум, баг" шалгаруулж гэрчилгээ олгох	ХХААЯ, УМЭГ	2002-2004
	4. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн баталгаажуулалт, лабораторийн шинжилгээний чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх	ХХААЯ, УМЭГ	2002-2004
	5. Гоц халдварт өвчнийг оношлох лаборатори байгуулах төсөл хэрэгжүүлэх	ХХААЯ, УМЭГ	2002
2. Мал аж ахуйн менежмент, малын чанар, ашиг шимийг сайжруулах	6."Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	ХХААЯ, бусад яамд, аймгийн Засаг дарга	2002-2004
	7.Нутгийн үхрийг махны чиглэлээр хэрэгцээний эрлийзжүүлэг явуулж махны үхэр үржүүлэх, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	ХХААЯ, аймаг, сумдын ЗДТГ	2002-2004
	8. Махны чиглэлийн үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгжийг ерөнхөөр оролцуулах	ХХААЯ	2002-2004

	9. Махны чиглэлийн бордооны аж ахуй байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих	ХХААЯ, мах боловсруулах үйлдвэрүүд	2002-2004
	10. Сэлэнгэ, Казакийн цагаан толгойт, Дорнод талын махны чиглэлийн үхэр, керей, үзэмчин, торгууд, барга үүлдэр, омгийн хониг үржүүлэх ажлыг өргөтгөх, үржлийн хэзлтэгч, хээлтүүлэгч бойжуулах, борлуулах	ХХААЯ, аймаг, сумдын ЗДТГ	2002-2004
	11. Малчдад зориулж мал үржлийн ажил, үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах, мал үржүүлэгчдийг үржил селекцийн мэдээллээр хангах	ХХААЯ	2002-2004
	12. Инженерийн хийцтэй хуучин худгуудыг засч сэлбэх, бага гүнтэй худгийн уст цэг тогтоох замаар бэлчээр усжуулалтыг сайжруулах	ХХААЯ	2002-2004
	13. Говь, тал хээрийн бүсэд шинээр худаг гаргах	ХХААЯ	2002-2004
	14. Үржлийн бүртгэл мэдээллийн сан байгуулах	ХХААЯ	2002
	Хоёр. Дотоод зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх талаар		
3. Мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх	15. Мал, мах худалдан авах, бэлтгэх, тууварлах дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	ХХААЯ, МЭМХ (Мах экспортлогчдын монголын холбоо)	2002-2004
	16. Мал, мах бэлтгэлийн санхүүжилтийг дэмжих	ХХААЯ, СЭЗЯ, Арилжааны банкууд	2002-2004
	17. Нийслэлийн хэрэгцээнд зориулж тодорхой хэмжээний мах бэлтгэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААЯ, СЭЗЯ, Арилжааны банкууд	2002-2004
4. Мал тууврын ажлын зохион байгуулалт, үр дүнг дээшлүүлэх	18. Тууврын замын хил заагийг улсын газрын нэгдсэн санд жил бүр бататган тодруулах: а/тууврын замын усан хангамж, хашаа хороо, бэлчээрийн асуудлыг аймгийн Засаг даргатай хамтран зохицуулах б/тууврын замд малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн үйлчилгээгээр хангах в/тууварч малчдыг ахуйн болон эмнэлгийн үйлчилгээгээр хангах	ХХААЯ, БОЯ, аймаг, сумдын ЗДТГ	2002-2004
	Гурав. Нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр		
5. Мах боловсруулах технологийг сайжруулах	19. Үйлдвэрүүдийн мал нядалгааны технологийн шугамыг орчин үеийн техникийн шаардлагын дагуу үе шаттайгаар шинэчлэн тоноглож эхлэх	ХХААЯ, МЭМХ,мах боловсруулах үйлдвэрүүд	2002-2004

	20. Үхэр, адууны махыг загсааж хөргөн шүлж бүлчингийн бүтэц, тэжээллэг чанараар нь ангилан савлаж шинээр болон хэвлэж хөлдөөсөн байдлаар бэлтгэх технологийг нэвтрүүлэх	МЭМХ, мах боловсруулах үйлдвэрүүд, Хүнс-тех корпорац	2002-2004
	21. Хөрүүрийн аж ахуйн найдвартай ажиллагааг хангах техник зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААЯ, мах боловсруулах үйлдвэрүүд, МЭМХ	2002-2004
	22. Махны үйлдвэрүүдийн лабораторийг шинэчлэх, бэжүүлэх арга хэмжээ авах	МЭМХ, мах боловсруулах үйлдвэрүүд, УМЭГ	2002-2004
	23.Техникийн хамтын ажиллагааны хүрээнд мах судлалын лаборатори байгуулах асуудлыг Франц улсын талд тавьж шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах	ХХААЯ Хүнстех корпорац	2002-2004
	24.Махны олон улсын стандартуудыг үндэсний үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар дотоодын нэгдсэн стандарттай болох	Хүнстех корпорац	2002-2004
	25. Дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг хүнсний болон хүнсний бус зориулалтаар ангилан савлаж экспортлох, дайвар бүтээгдэхүүнийг техник, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар ашиглах, П зэргийн дотор эрхтэнг боловсруулж малын болон ангийн тэжээл үйлдвэрлэж экспортлох	Мах боловсруулах үйлдвэрүүд, Хүнстех корпораци, Монэнзим	2002-2004
	26. Түүхий эдийн нөөцийг түшиглэн махны үйлдвэр хөгжүүлэхэд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, аймгийн төвүүдэд бага оврын мал нядалгааны хөргөлттэй цех байгуулах санаачилгыг хөхиүлэн дэмжих	ХХААЯ, ҮХЯ, СЭЗЯ, Арилжааны банкууд	2002-2004
6. Махны экспортын зах зээлийг өргөсгөх чиглэлээр маркетинг судалгааг тодорхой зах зээлүүдийг сонгон явуулах	27. Монгол малын махыг экологийн цэвэр бүтээгдэхүүн болохыг нотлох чанарын нарийвчилсан үзүүлэлтүүдийг тогтоож баталгаажуулан олон улсын холбогдох байгууллагад бүртгүүлэх	ХХААЯ, МЭМХ, Хүнстех, мах боловсруулах үйлдвэрүүд	2002-2004
	28. Монгол малын махны чанарын давуу талыг гадаад орнуудад сурталчлах материал бэлтгэн олон улсын түвшинд мэдээлж байх	ХХААЯ, МЭМХ, мах боловсруулах үйлдвэрүүд	2002-2004

	29. Махны экспортын шинэ зах зээлийг сонгон олж, тэдгээрийн ариун цэвэр, эрүүл ахуй, чанарын шаардлагыг судлах, гэрээ хэлэлцээр байгуулах	ХХААЯ МЭМХ	2002-2004
	30. Мах үйлдвэрлэл, технологи, эрэлт хэрэгцээ, үнийг байнга судалж мэдээллийн сан бий болгон хэрэглэгчдэд хүргэх	ХХААЯ ҮХЯ, ГХЯ, МЭМХ	2002-2004
	31. Мал бордох сонирхогч улс бүрийн технологийг судалж аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэж байх	ХХААЯ, МЭМХ	2002-2004
	32. Мах импортлох сонирхол бүхий орны аж ахуйн нэгж, байгууллагатай өөрийн орны мах экспортлогч аж ахуйн нэгж, байгууллагыг хамтран ажиллахад зуучлах	ХХААЯ, ҮХЯ	2002-2004
	33. Нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, үйлдвэрүүдийн удирдлага, ажиллагсдын гадаад хэл, маркетингийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах	ХХААЯ, МЭМХ	2002-2004
Дөрөв. Мах үйлдвэрлэлийн ариун цэврийн нөхцөлийг сайжруулах хүрээнд			
7. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	34. Хүнсний хяналтын нэгдсэн лавлагаа лабораторийг байгуулах төсөл боловсруулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах	ХХААЯ	2002-2004
	35. Мах экспортлох боломжтой орнуудтай мал эмнэлгийн гэрээ, хэлэлцээрийг Засгийн газар хооронд байгуулах	ХХААЯ	2002-2004
	36. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах "Эгзэгтэй цэгийн хяналтын систем" (HACCP) хөтлөбрийг хэрэгжүүлж эхлэх	ХХААЯ	2002-2004
	37. Махны хяналтын дүрэм баталж хэрэгжүүлэх	ХХААЯ	2001-2004
Тав. Дэд бүтэц, тээврийг сайжруулах хүрээнд			
8. Гадаадын шинэ зах зээлд гарах тээврийн боломжийг бүрдүүлэх	38. Арабын орнууд, Хятад, Солонгос, Япон зэрэг орнуудад мах экспортлох тээврийн боломжийг судлах, авто зам, агаарын тээврийн чиглэлүүдийг бий болгох	ХХААЯ, ДБЯ	2002-2004
	39. Хөлдөөгчтэй чингэлэгийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	ХХААЯ, СЭЗЯ, мах боловсруулах үйлдвэрүүд	2002-2004
	40. Тээврийн зардал нэмэгдэхэд нөлөөлж байгаа гааль, хилийн үйл ажиллагаатай холбогдсон зардлын асуудлыг судлан шийдвэрлэх	ХХААЯ, УГЕГ, ТЕГ, ХЦУГ, ДБЯ	2002-2004

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 280 Улаанбаатар хот

Малын өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Зарим аймгийн нутагт цас орж хүйтэрснээс шалтгаалан мал өвөлжилт хүндэрч байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалахын сайд, Улсын Байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгах нь:

а/мал өвөлжилтийн байдал хүндэрсэн аймгуудад мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллуулж цагийн байдлыг үнэлж, аймаг, орон нутгаас хэрэгжүүлж байгаа ажилд зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч ажилласугай;

б/цас их орсноос мал өвөлжилт хүндэрсэн аймгуудад өвс, тэжээл тэзвэрлэх, түлш шатахууны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсугай.

2. Улсын нөөцөөс олгосон өвс, тэжээлийг өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад шуурхай хүргэх, үр ашигтай ашиглан малыг хэсэгчлэн тэжээх, зам харгуй гаргах, бололцоотой газарт малчдыг их цаснаас нүүлгэх, өвс тэжээлийг ойрын аймаг, сумаас худалдан авч хангах, отроор өвөлжих байгаа болон өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх зэргэвр дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал өвөлжилтийн байдал хүндэрсэн Баянхонгор, Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай, Архангай аймгийн малчдын хэрэгцээнд зориулан 1, 2 дугаар хавсралтад заасан хүнсний бараа, өвс тэжээлийг улсын нөөцөөс гарган олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан улсын нөөцөөс олгосон хүнсний бараа, өвс тэжээлийг нөхөн бүрдүүлэх эх үүсвэр 554.9 (таван зуун тавин дөрвөн сая, есөн зуун мянга) сая төгрөг болон нөхөн бүрдүүлсэн өвс тэжээлийг улсын нөөцийн цэг, салбарт байршуулах зардлыг тооцож Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2002 оны I улиралд багтаан гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч, улсын нөөцийн хүнсний бараа, өвс тэжээлийг мөн улиралд багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

5. Баянхонгор аймгийн Шинэжинст, Эрдэнэцогт сумд болон Баянхонгор сумын Шаргалжуут баг (тосгон)-ийн хүний эмчийн салбарт улсын нөөцөөс УАЗ-31512 маркийн суудлын автомашин олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд зөвшөөрч, эдгээр машиныг 2002 оны эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтаар олгох түргэн тусламжийн автомашинаас 2002 оны I улиралд Улсын нөөцийн газарт нөхөн нийлүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

6. Өвөлжилт хүндэрч болзошгүй баруун аймгуудын хэрэгцээнд зориулан 1200 тонн хорголжин тэжээлийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор ОХУ-аас импортлон авч 3 дугаар хавсралтад заасан аймгуудад борлуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгаж, импортоор оруулах тэжээлийг худалдан авах үнэ, гаалийн болон нэмэгдсэн ертийн татвар, тээвэрийн зардалд шаардагдах 211.9 (хоёр зуун арван нэгэн сая, есөн зуун мянга) сая төгрөгийг 2002 оны 1 дүгээр сард багтаан төсөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

7. Зарим аймаг илүүдэлтэй байгаа өвсийг цаг хүндэрсэн аймгуудын малчдад худалдах буюу экспортлох, хорголжин тэжээл импортоор авах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

8. Мал өвөлжилт хүндэрсэн болон цаашид хүндэрч болзошгүй аймгуудаас цагийн байдлын мэдээлэл байнга авч, аймгийн Засаг даргын зүгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагааны үр дүнг үнэлж байх, авах арга хэмжээг шуурхай зохицуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001оны 280 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛЧДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛЖ УЛСЫН НӨӨЦӨӨС ГАРГАН ОЛГОХ ХҮНСНИЙ БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төг)	Бүгд үнэ (мян. төг)
1	Гурил	тонн	150	280	42000.0
2	Цагаан будаа	тонн	60	350	21000.0
3	Шар будаа	тонн	10	360	3600.0
4	Хуурай сүү	тонн	10	2600	26000.0
	ДҮН		230		92600.0

Засгийн газрын 2001оны 280 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МАЛ ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН АЙМГУУДЫН МАЛЧДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛЖ УЛСЫН НӨӨЦӨӨС ГАРГАН ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Аймгийн нэр	Нэр төрөл	Нийлүүлэх хэмжээ		Үнэ	
			Тонноор	Боодол (кг)	Нэг бүрийн (төг)	Нийт (мян.төг)
1	Архангай	Өвс	350	15200	1600	24320.0
2	Баянхонгор	Өвс	2700	117400	2200	258280.0
		Тэжээл	500	500000	155	77500.0
3	Баян-Өлгий	Өвс	200	8700	1800	15660.0
		Тэжээл	30	30000	155	4650.0
4	Говь-Алтай	Өвс	550	23900	2000	47800.0
		Тэжээл	5	5000	155	775.0
5	Дорноговь	Өвс	400	17400	1600	27840.0
		Тэжээл	200	200000	90	18000.0
6	Завхан	Өвс	600	26100	2200	57420.0
		Тэжээл	100	100000	155	15500.0
7	Ховд	Өвс	350	15200	2200	33440.0
		Тэжээл	10	10000	155	1550.0
8	Өвөрхангай	Өвс	350	15200	1600	24320.0
9	Өмнөговь	Өвс	900	39100	2200	86020.0
10	Увс	Өвс	250	10900	1400	15260.0
	ДҮН	Өвс	6650	289100		590360.0
		Тэжээл	845	845000		117975.0
		Үнэ				708335.0

Засгийн газрын 2001оны 280 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨСВИЙН ЗӨЭЛӨӨР ОХУ-ААС ИМПОРТООР АВЧ АЙМГУУДАД БОРЛУУЛАХ ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

Аймгийн нэр	Тэжээлийн					Тээвэрлэх зардал			Бүгд үнэ (мян.төг)
	Хэмжээ, тонн	Хилийн үнэ	Гааль, НӨТ	1 тн үнэ	Дүн (мян.төг)	Зай	Тн/км үнэ	Дүн (мян.төг)	
Ховд	300	110000	24200	134200	40260.0	310	90	8370.0	48630.0
Баян-Өлгий	200	110000	24200	134200	26840.0	90	90	1620.0	28460.0
Завхан	200	110000	24200	134200	26840.0	775	90	13950.0	40790.0
Увс	200	110000	24200	134200	26840.0	400	90	7200.0	34040.0
Говь-Алтай	300	110000	24200	134200	40260.0	730	90	19710.0	59970.0
Дүн	1200				161040.0			50850.0	211890.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 281** **Улаанбаатар хот**

Зар мэдээ, журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Худалдаа, хөгжлийн банкны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай" Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Үралдаант шалгаруулалт (тендер)-ын зар мэдээ"-ний "Урьдчилан шалгаруулалтын шалгуур" гэсэн хэсгийн 4-ийн "–төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж," гэсний өмнө "10 хувиас илүү" гэж, мөн тогтоолоор батлагдсан "Үралдаант шалгаруулалт (тендер)-ын журам"-ын 4.1.1 дэх заалтын "4.төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж," гэсний өмнө "10 хувиас илүү" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 282 | Улаанбаатар хот

Төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах тухай

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын дипломат болон албан гадаад паспортыг нууцлал, чанар сайтай хэвлүүлэх, Монгол Улсад нэвтрэх визийн хуудсыг олон улсын шаардлагад нийцүүлэн хэвлүүлэх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт зориулж нийтдээ 415.6 (дөрвөн зуун арван таван сая зургаан зуун мянга) сая төгрөгийг төсвийн хөрөнгөөс эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр Гадаад хэргийн яаманд ашиглуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 284 | Улаанбаатар хот

Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Улсын Их Хурлын 2000 оны 28 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хилийн Цагааннуур, Даян, Асгатын гол, Бургастай, Арц суурь, Тэс, Боршоо, Байтаг, Ярант, Ханх боомтоор 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд орж ирэх буудайн гурилын импортын гаалийн татварын хувь хэмжээг "О" байхаар өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2001 оны 12 дугаар сарын 04-ний өдөр | Дугаар 439 | Улаанбаатар хот

ГААЛИЙН БОЛОН ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Гаалийн болон Гаалийн тарифын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн дөрөв дэх заалт,Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн зургаа дахь хэсгийн зургаа дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд Шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Гаалийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар ойлгон хэрэглэхээр тайлбарласугай.

1.1. Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "...гаалийн хяналтын талбайн хил нь тухайн хэсэгтээ гаалийн хилд тооцогдоно" гэдэгт гаалийн нутаг дэвсгэрт оруулах, гаалийн нутаг дэвсгэрээс гаргах бараа, тээврийн хэрэгсэлд эцсийн бүрдүүлэлт хийж буй хилийн, эсхүл гүний гаалийн байгууллагын гаалийн хяналтын талбайн хилийг ойлгоно.

Гаалийн бүрдүүлэлтийг гүний болон хилийн байгууллага хийсэн тохиолдолд анхны бүрдүүлэлт хийж байгаа гаалийн байгууллагын гаалийн хяналтын талбайн хил нь гаалийн хилд тооцогдохгүй.

1.2. Мөн зүйлийн 1дэх хэсгийн 8дахь заалтын "... гаалийн байгууллагад мэдүүлсэн, эсхүл мэдүүлж байгаа аливаа хүнийг хэлнэ" гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа,тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хүлээн авагч, илгээгч аж ахуйн нэгж байгууллагын итгэмжлэгдсэн этгээд, гаалийн зуучлагч байгууллагын бүртгэгдсэн мэргэлжилтэн зэргийг ойлгоно. Мэдүүлэгч нь 16 насанд хүрсэн Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

1.3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтын "...тарифын бус аргаар хязгаарласан бараа..." гэдэгт тодорхой болзол хангасан,тоон хязгаарлалт, нэмэгдэл татвар тогтоосон,эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр оруулах, гаргах,дамжин өнгөрүүлэхээр хууль,хууль тогтоомж, олон улсын гэрээ,Засгийн газрын шийдвэрт заасан бараг ойлгоно.

1.4. Хуулийн 7[1] дугаар зүйлийн 5, 36 дугаар зүйлийн 6дахь хэсгийн "...амархан гэмтэх..." гэдэгт хадгалалт, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардагддаг,хадгалах хугацаа богино, амархан муудаж,чанараа алддаг хүнсний болон бусад бараа г:

"... аюултай бараа..."-нд физик, хими, биологийн шинж чанараараа байгаль орчин болон хүн, амьтны эрүүл мэнд, үр удамд сөргөөр нөлөөлж, хохирол учруулж болзошгүй цацраг идэвхт бодис,тэсэрч дэрбэрэх зүйлс, нефтийн шингэн бүтээгдэхүүн, хорт болон онцгой хортой химийн бодис, түүний хаягдал, аюултай хог хаягдал зэрэг эд зүйлс хамаарна.

1.5. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн "бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлэх" гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу бичиж, гаалийн холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгөхийг хэлнэ.

1.6. Хуулийн 15,21 дүгээр зүйлд заасан гаалийн нутаг дэвсгэрт, эсхүл хилийн чанадад "...боловсруулах..." гэдэгт түүхий эд, материалыг цэвэршүүлэх, анхан шатны боловсруулалт хийх зэргээр үйлдвэрлэлд ашиглахад бэлэн болгох үйл ажиллагаа, тухайлбал: гуалин, ширийг хилийн чандад гаргаж, боловсруулалт хийж, банз, хөх шир болгож оруулах гэх мэт; "... засвар үйлчилгээ хийх..." гэдэгт барааны эвдэрч гэмтсэн хэсгийг засах, солих, шинэчлэх, эсвэл дутуу хэсгийг нөхөн гүйцэх үйл ажиллагаа; "... бүтээгдэхүүн үйлдвэрлэх ..." гэдэгт тухай аж ахуйн нэгж өөрийн хийсэн гэрээ, хэлцлийн дагуу гаалийн хилээр нэвтрүүлсэн үндсэн түүхий эд материалаар эцсийн, эсхүл хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг тус тус ойлгоно.

1.7. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "... тогтоосон хугацаа ..." гэдэгт тухайн бараг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн төрөл, бараа, тээврийн хэрэгслийг гаргах боомтын зай, явах замаас шалтгаалан тухайн гаалийн байгууллага гаалийн хилээр гарах өдрийг тусгайлан тогтоохыг хэлнэ. Иймхүү тогтоосон хугацааг тээврийн баримт, ачааны манифестэд тэмдэглэнэ.

1.8. Хуулийн 18 дугаар зүйлд заасан "... бараг шилжүүлэн ачих..." гэдэгт гаалийн хилээр оруулж ирсэн бараг гаалийн хяналтын талбайд нэг тээврийн хэрэгслээс өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачихыг ойлгоно. Гаалийн хилээр орох, гаалийн бүрдүүлэлт хийх, шилжүүлэн ачих, гаалийн хилээр гарах үйл ажиллагаа гаалийн нэг байгууллагын хүрээнд хийгдэнэ.

1.9 Энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "Гаалийн шалгалтыг дахин хийх ..." гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтаас гаргахаас өмнө давтан шалгахыг хэлнэ.

1.10. Хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Гаалийн байгууллага нягтлан шалгах шаардлагатай бараа, тээврийн хэрэгслийг саатуулж болно." гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэлд мэргэжлийн байгууллагын

дүгнэлт гаргуулах, шинжилгээ хийлгэх, мэргэжлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, холбогдох байгууллага, албан тушаалтныг гаалийн шалгалтад оролцуулах зэргийг ойлгоно. Тухайлбал; гаалийн бичиг баримтыг засварласан, хуурамчаар үйлдсэн эсэхийг тогтоолгохоор криминалистик шинжилгээнд өгч, дүгнэлт гаргуулах, барааны ангиллыг тодорхойлж чадахгүй эргэлзээтэй байгаа үед гаалийн лабораторид өгч шинжлүүлэх гэх мэт.

1.11. Мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "сахилгын зөрчил удаа дараа гаргасан" гэдгийг хөдөлмөрийн сахилгын болон гаалийн хууль тогтоомжийг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөн байхыг ойлгох ба зөрчил бүрт сахилгын шийтгэл заавар оногдуулсан байхыг шаардахгүй. Харин гаалийн улсын байцаагчаас сахилгын зөрчил гаргасан нь баримтаар тогтоогдсон байвал зохино. Удаа дараа гаргасан зөрчлүүдийн хоорондох хугацаа, өмнөх зөрчилдөө сахилгын шийтгэл хүлээсэн бол нэг жилээс, хүлээгээгүй бол зургаан сараас хэтрэхгүй байна.

1.12. Хуулийн 71, 73, 78 дугаар зүйлд заасан "...хууль бусаар нэвтрүүлсэн..."гэдэгт Монгол Улсын хууль тогтоомж,олон улсын гэрээ,Засгийн газар,эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон журмыг зөрчин гаалийн бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засварлах, гаалийн мэдүүлэгт бичилгүй орхих, эсхүл худал бичих, гаалийн хяналт, шалгалтаас зүүн далдлах, барааны нэр, төрөл, хэлбэр дурс, багтаа бөодлыг өөрчлөх, түүнчлэн гаалийн хяналт,шалгалтаас гадуур, хилийн боомтгүй газраар улсын хил нэвтрүүлсэн зэрэг үйлдэл,эс үйлдэл гэмээрна.

1.13.Хуулийн 71,72,73 дугаар зүйлд заасан"...хураан авах болопцоогүй бол үнийг эргүүлэн авна"гэдэгт тухайн зүйлд заасан зөрчилийн илмаас хураагдах ёстой бараа, түэврийн хэрэгслийг улсын хилээр гаргасан, эсхүл худалдан борлуулсан, бусдад шилжүүлсэн, устсан, анхны зориулалтаар ашиглах боломжгүй болсон зэргээр зөрчил гаргагчийн мэдэлд байхгүй тохиолдолд барааны үнийг зах зээлийн үнээр тооцож,зөрчил гаргагчаас гаргуулан авахыг ойлгоно.

1.14. Хуулийн 73 дугаар зүйлийн 1дэх хэсгийн"...бараг нуувч болгон ашигласан..." гэдэгт бараг хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор мэдүүлсэн бараагаар өнгөлөн далдалсан, зориулалтыг өөрчилсөн, дотор нь эсхүл зай хөндийд нуусан, сав, баглаа, боодолд хольж хийсэн зэрэг үйлдлүүд хамаарна.

Энэ тохиолдолд зөвхөн нуувч болгон ашигласан бараг хураан авна.

1.15. Хуулийн 73 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...тээврийн хэрэгслийг зориудаар тоноглож, нуувч болгон ашигласан..." гэдэгт бараг гаалийн хяналт, шалгалтаас нууж, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийн эд ангид давхар хана, шал, хайрцаг хийсэн, хэлбэр дүрс, зориулалтыг өөрчилсэн, тээврийн хэрэгслийн эд анги зай хөндийг нуувч болгон ашигласан үйлдлийг ойлгоно.

1.16. Мөн зүйлд хэсэгт заасан "... гэм буруутай этгээдийн..." гэдэгт тээврийн хэрэгслийн эзэмшигч эсвэл бусдын автомашиныг жолоодож яваа этгээд тухайн зөрчлийг үйлдсэн, хамтран оролцсон, тээврийн хэрэгслийг тоноглох, нуувч болгон ашиглахыг зөвшөөрсөн, тээврийн хэрэгслийг нь тоноглосон, нуувч болгон ашигласан тухай мэдэж байгаад гаалийн байгууллагад мэдэгдээгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн эзэмшигчийг гэм буруутайд тооцож энэ зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

1.17. Гаалийн байгууллагад мэдүүлэх үүрэгтэй этгээд нь гаалийн удирдах төв байгууллагаас батална маягтын дагуу мэдүүлгээ бичээгүй, эсхүл буруу бичсэн, хуулиар тогтоосон мэдүүлэгчийн үүргээ биелүүлээгүй зэрэг зөрчилийг хуулийн 74 дүгээр зүйлд заасан "... мэдүүлэх журам зөрчсөн ..." гэдэгт хамаарууулна. Харин гаалийн болон бусад албан татвар төлөхөөс сонаатай зайлсхийх зорилгоор гаалийн хилээр нэвтрүүлэх бараг гаалийн мэдүүлэгт зориуд бичихгүй орхих, барааны тоо хэмжээг сонаатайгаар буруулж буруу мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны ангилалыг худал мэдүүлэх зэрэг зөрчил¬нь мөн хуулийн 82 дугаар зүйлд заасназ хариуцлага хүлээлгэх зөрчилд хамаарна.

1.18. Хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх

хэсгийн "гаалийн хяналтанд байгаа бараг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлгөсөн, ачсан, буулгасан, шилжүүлэн ачсан..." гэдэгт гаалийн хяналтын талбай, гаалийн түр агуулах, гаалийн зам, гаалийн баталгаат бүс, татваргүй барааны дэлгүүр зэрэгт байгаа бараг тэндээс нь гаргалгүйгээр хөдөлгөсөн ачсан, буулгасан, шилжүүлэн ачсан зэрэг үйлдлийг ойлгоно.

Хэрэв бараг гаалийн хяналтаас гаргасан байвал гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн эсүүл гаалийн болон бусад албан татвар төлөхөөс зайлсхийсэн зөрчилд хамруулна.

1.19. Хуулийн 87 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... гаалийн бүрдүүлэлтийн явцад мэдүүлэгч нь хүлээн авахаас татгалзсан бараа тээврийн хэрэгсэл..." гэдэгт гэрээнд заасснаас өөр бараа орж ирсэн, тээвэрлэлтийн явцад чанараа алдсан, хугацаа хоцорч ирснээс мэдүүлэгчид шаардлагагүй болсон, татвар төлөхөөс татгалзсан болон өөр бусад шалтгаанаар мэдүүлэгч хүлээн авахаас татгалзаж, энэ тухайгаа бичгээр баталгаажуулан гаалийн хяналтын талбайд үлдээсэн бараа, тээврийн хэрэгслийг хэлнэ.

1.20. Хуулийн 88 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль тогтоомжийн дагуу суутгал хийж, үнэнийг буцаан олгож..." гэдэгт тухайн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хууль тогтоомжийн дагуу зах зээлийн үнээр худалдан борлуулсан үнийн дүнгээс гаалийн болон бусад албан татвар, хураамж, бараа, тээврийн хэрэгслийг түр агуулахад шилжүүлэх, хадгалах, худалдан борлуулахад гарсан бодит зардлыг хассаны зөрүү үнийг буцаан олгохыг ойлгоно.

Хоёр. Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар ойлгон хэрэглэхээр тайлбарласугай.

2.1 Гаалийн тарифын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "гаалийн байгууллага гадаад валютаар тодорхойлсон гаалийг үнийг бараг гаалийн хилээр оруулахад гаалийн эцсийн, гаргахад гаалийн анхны бүрдүүлэлт хийсэн өдрийн гаалийн тооцоонд мөрдөж байгаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшаар үндэсний валютад шилжүүлэн гаалийн болон бусад татварыг тооцон хураах авна" гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ гаалийн байгууллага гадаад валютаар тодорхойлогдсон гаалийн үнийг гаалийн хилээр оруулах бараг гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн байгууллага бичиг баримтын бүрдүүлэлт хийсэн, гаалийн хилээр гарах бараг гаалийн байгууллагад мэдүүлж, анхны бүрдүүлэлт хийсэн өдрийн гаалийн тооцоонд мөрдөж байгаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшаар үндэсний валютад шилжүүлэн тооцох ба гаалийн болон бусад татвар ногдуулахдаа дээр дурдсан өдрүүдэд мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг баримтлана.

2.2 Хуулийн 21 дүгээр зүйлийн 1 хэсгийн 1-д заасан "... үгсарч суурилуулах тоног төхөөрөмж..."-д тээврийн хэрэгслийн нөхцлөөс шалтгаалан эд анги, бүрдэл хэсгээр нь салгаж ачсан боловч технологийн горимын шаардлагын дагуу иж бүрэн комплект болж ашиглагдах тоног төхөөрөмжийн бүрдэл хэсгүүд, эд ангийг хамаарууллна.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **Ч.ГАНБАТ**

ШҮҮГЧ **О.ЗАНДРАА**

Б.ЦОГНЯМ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 5 (242)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Эрүүгийн хууль*
- *Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны хоёрдугаар сарын 6 №5 (242

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

74. Эрүүгийн хууль (2002-1-3-ны хууль) 113

75. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2002-1-3-ны хууль) 170

76. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-1-3-ны хууль) 170

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОРИЛТ, ЗАРЧИМ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт

1.1.Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

1.2.Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно.

2 дугаар зүйл. Эрүүгийн хууль тогтоомж

2.1.Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ.

2.2. Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно.

3 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

3.1.Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно.

3.2.Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

3.3.Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

[1] Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

4 дүгээр зүйл. Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим

4.1. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4.2.Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

5 дугаар зүйл. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим

5.1.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6 дугаар зүйл. Шударга ёсны зарчим

6.1.Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна.

6.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

7 дугаар зүйл. Энэрэнгүй ёсны зарчим

7.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй.

8 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим

8.1.Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ.

8.2.Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.

9 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим

9.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ.

9.2.Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл, журмыг гагцхүү энэ хуулиар тогтооно.

10 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

10.1. Энэ хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

10.2.Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгууллагдсан шүүхээс өөр байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ҮЙЛЧЛЭХ ЦАГ ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭР, ХАМААРАХ ЭТГЭЭД

11 дүгээр зүйл. Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа

11.1.Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэнэ.

11.2.Гэмт хэргийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран тухайн гэмт хэрэг үйлдсэн үеийг гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцно.

12 дугаар зүйл. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэл, журам

12.1.Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон буюу оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.

12.2.Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон буюу оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.

12.3.Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээрүүр ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шүүх үг дээд хэмжээнд нийцүүлэн хасна.

12.4.Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээг багасгасан тохиолдолд урьд нь үүнээс дээрүүр ял шийтгүүлсэн

этгээдийн ялыг шүүх уг доод хэмжээнд нийцүүлэн хасна.

13 дугаар зүйл. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдээд Эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл, журам

13.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

13.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын хэмжилт нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

13.3.Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээд болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол Улсын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харъяалагдахгүй бусад этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл, журам

14.1.Монгол Улсын иргэн, түс улсад байнга оршин суудаг харъяалагүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ гадаад улсад ял шийтгүүлсэн бол Монгол Улсын шүүх түүнд оногдуулсан ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлэх буюу ялаас чөлөөлж болно. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм бурууг нь тооцож болно.

14.3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн албан хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

14.4.Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнд зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

14.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харъяалалгүй хүн тус улсын хилийн гадна Монгол Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлээгүй бол Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.

15 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх

15.1.Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй.

15.2.Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ГЭМТ ХЭРЭГ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ

16 дугаар зүйл. Гэмт хэргийн тухай ойлголт

16.1.Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

16.2.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.

17 дугаар зүйл. Гэмт хэргийн ангилал

17.1.Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг:

17.1.1.хөнгөн;
17.1.2.хүндэвтэр;
17.1.3.хүнд;
17.1.4.онц хүнд гэж ангилна.

17.2.Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл

хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.

17.3.Энэ хуулийн тусгай анги нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүндэтгэн гэмт хэрэг гэнэ.

17.4.Энэ хуулийн тусгай анги нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

17.5.Энэ хуулийн тусгай анги арван жилээс дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих, онцгой тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэнэ.

18 дугаар зүйл. Гэмт хэрэг давтан үйлдэх

18.1.Энэ хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг давтан гэмт хэрэг гэнэ. Энэ хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд давтан гэмт хэрэгт тооцогдоно.

18.2.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй.

19 дүгээр зүйл. Нийлмэл гэмт хэрэг

19.1.Энэ хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байхыг нийлмэл гэмт хэрэг гэнэ. Нийлмэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг бүрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийн тусгай ангийн хоёр буюу түүнээс дээш зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулсан нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхүйг нийлмэл гэмт хэрэгт тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЭТГЭЭД

20 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд

20.1.Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

21 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар

21.1.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд энэ хуулийн тусгай ангийн 91 /Хүнийг санаатай алах/, 96/ Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 126 /Хүчингүй/, 145/ Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146/ Бусдын эд хөрөнгийг булаах/, 147/ Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 153/Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх/, 181.2; 181.3 /Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах /-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

21.3.Арван найман насанд хүрэхийн өмнө анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял шийтгэхгүй хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл түүнд энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

22 дугаар зүйл. Хэрэг хариуцах чадваргүй байдал

22.1.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй, өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Иймэ этгээдэд шүүх энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

22.2.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд

өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Согтуурал буюу мансуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

23.1.Согтуурал буюу мансуурлын байдалд байхдаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй.

23.2.Согтуурал буюу мансуурлын байдалд байхдаа гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүх ял оногдуулахын зэрэгцээ энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

24 дүгээр зүйл. Онц аюултай гэмт хэрэгтэн

24.1. Дараахь этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтэнд тооцно:

24.1.1.урьд нь хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

24.1.2.урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

24.1.3.урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүй боловч онц хүнд гэмт хэрэг давтан үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд;

24.1.4. гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн, энэ хуулийн 36.5-д заасан гэмт бүлэглэлийн гишүүн.

24.2.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэг болон энэ хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсон гэмт хэрэг хамаарахгүй.

24.3.Онц аюултай гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдсэнийг ял хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан энэ хуулийн тусгай ангийн хэм хэмжээг уг этгээд тухайн хэргийг үйлдэхээс өмнө хуульд заасан үндэслэлээр онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон тохиолдолд хэрэглэнэ.

24.4.Шүүх тухайн этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох болсон үндэслэлээ шийтгэх тогтоолд заана.

24.5.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон шүүхийн шийдвэр нь уг этгээд сүүлчийн гэмт хэрэгтээ ялгүй болсон, ялгүйд тооцогдсон үед хүчингүй болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭМ БУРУУ

25 дугаар зүйл. Гэм буруугийн хэлбэр

25.1. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

25.2.Гэм буруу нь санаатай, болгоомжгүй гэсэн хэлбэртэй байна.

25.3.Болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдоно.

26 дугаар зүйл. Гэмт хэрэг санаатай үйлдэх

26.1.Гэмт хэрэг санаатай үйлдэх нь шууд, шууд бус санаатай байна.

26.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж , түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүй, эсхүл учрах боломжтойг урьдчилан мэдсэн атлаа хүсэж үйлдсэн бол гэмт хэрэг шууд санаатай үйлдсэн гэж үзнэ.

26.3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдсэн, уг хор уршгийг хүсээгүй боловч түүнд зориуд хүргэсэн бол гэмт хэрэг шууд бус санаатай үйлдсэн гэж үзнэ.

27 дугаар зүйл. Гэмт хэрэг болгоомжгүй үйлдэх

27.1.Гэмт хэрэг болгоомжгүй үйлдэх нь хөнгөмсгөөр найдсан, эсхүл хайхрамжгүй хандсан байна.

27.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдсэн боловч түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцон үйлдсэн бол хөнгөмсгөөр найдсан гэж үзнэ.

27.3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэн бол хайхрамжгүй хандсан гэж үзнэ.

28 дугаар зүйл. Хор уршиг гэм бурууг үйлдэгээр учруулах

28.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэрэгийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, түүнчлэн учирч болох нийгэмд аюултай хор уршигийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ.

29 дүгээр зүйл. Хохирлын хэмжээг тодорхойлох

29.1.Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг бага бус, тавиас дээш нэг зуун хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг үлэмж, нэг зуун хорин тавааас дээш хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг их, хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг онц их гэж тооцон хохирлын хэмжээг тодорхойлно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ ҮЕ ШАТ

30 дугаар зүйл. Төгссөн болон төгсөөгүй гэмт хэрэг

30.1.Үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан байвал төгссөн гэмт хэрэг гэнэ.

30.2.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх, завдахыг төгсөөгүй гэмт хэрэг гэнэ.

30.3.Төгсөөгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн 31, 32 дугаар зүйлийг журамлан тусгай ангийн зохих зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

31 дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх

31.1.Зэвсэг, хэрэгслийг хайж олсон, шинээр хийсэн, төхөөрч тохируулсан, хамтран оролцогчийг сонгож авсан, гэмт хэрэг үйлдэх талаар үгсэж тохиролцсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэх бусад нөхцөл, боломжийг санаатай бүрдүүлснийг гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн гэж үзнэ.

31.2.Хөнгөн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

32 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр завдах

32.1.Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ.

32.2.Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхүйг бүрэн хийсэн гэж тухайн этгээд ойлгосон боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол төгссөн завдалт гэнэ.

32.3.Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг бүрэн хийгээгүйгээ тухайн этгээд ойлгосон бөгөөд түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол төгссөгүй завдалт гэнэ.

33 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээс сайн дурарааа татгалзах

33.1.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан этгээд гэмт хэргээ туйлд нь хүргэх боломжтойг ойлгож байсан боловч тийнхүү туйлд нь хүргэхээс сайн дурарааа, төгс татгалзсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

33.2.Гэмт хэргээ туйлд нь хүргэхээс сайн дурарааа татгалзахаас өмнө хийсэн үйлдэл, эс үйлдэхүй нь бие даасан өөр гэмт хэргийн шинжийг агуулсан байвал эвэхэн тэр гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ

34 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох

34.1.Гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээд нэгдсэнийг хамтран оролцох гэнэ.

35 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогч

35.1.Захиалагч, зохион байгуулагч, хатгагч, гүйцэтгэгч, хамжигчийг гэмт хэрэгт хамтран оролцогч гэнэ.

35.2.Гэмт хэрэг үйлдүүлэхээр бусдыг хөлсөлсөн этгээдийг захиалагч гэнэ.

35.3.Гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулж, үйл ажиллагаат нь чиглүүлж удирдсан этгээдийг зохион байгуулагч гэнэ.

35.4.Ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээдийг хатгагч гэнэ.

35.5.Гэмт хэргийг гардан үйлдсэн этгээдийг гүйцэтгэгч гэнэ.

35.6.Зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан этгээдийг хамжигч гэнэ.

36 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр

36.1.Гэмт хэрэгт хамтран оролцох нь бүлэглэн гүйцэтгэх, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл гэсэн хэлбэртэй байна.

36.2.Хоёр ба түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэн бол бүлэглэн гүйцэтгэгч гэнэ.

36.3.Гэмт хэрэг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэнэ.

36.4.Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдсэн, тогтвортой бүлгийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.

36.5.Гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, бүтэц, зохион байгуулалт бүхий этгээдүүдийн нэгдлийг гэмт бүлэглэл гэнэ.

37 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага

37.1.Шүүх гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг сонгон хэрэглэхдээ оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг харгалзан энэ хуулийн 35 дугаар зүйлийн зохих хэсгийг журамлан тогтооно.

37.2.Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн удирдагчид энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд ийм бүлэг, бүлэглэл байгуулсаны төлөө болон уг бүлэг, бүлэглэлийн үйлдсэн бүх гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээлгэнэ.

37.3.Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн бусад оролцогчид иймхүү гэмт байгуулагад оролцсоных нь төлөө болон өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

37.4.Захиалагчид түүний захиалсан гэмт хэргийн гүйцэтгэгчид оногдуулсан ялаас доогуур ял оногдуулж болохгүй .

38 дугаар зүйл. Зөрчиж гүйцэтгэх

38.1.Гүйцэтгэгч нь бусад оролцогч мэдээгүй, өөрөөр хэлбэл, түүнтэй тохиролцоогүй гэмт хэрэг үйлдэхийг зөрчиж гүйцэтгэх гэнэ. Зөрчиж гүйцэтгэсэн гэмт хэрэгт бусад хамтран оролцогчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

39 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамаарагсад

39.1.Нуун далдлагч, үл мэдээлэгчийг гэмт хэрэгт хамаарагсад гэнэ.

39.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүний хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг урьдчилан амлахгүйгээр санаатай нуух зэргээр гэмт хэргийн ул мөрийг арилгасан этгээдийг нуун далдлагч гэнэ.

39.3.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаар болон үйлдсэнийг мэдсээр байж зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй этгээдийг үл мэдээлэгч гэнэ.

39.4.Энэ хуулийн тусгай ангид нэрлэж заасан гэмт хэргийг үл мэдээлсэн, нуун далдалсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

40 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалт

40.1.Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгмэд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

40.2.Хүн бүр албан тушаалын байдал, мэргэжил, хуулиар хүлээлгэсэн үүрэг, албаны тусгай бэлтгэлээс хамаарахгүйгээр аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Хамгаалагч нийгмэд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй.

41 дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах

41.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй.

42 дугаар зүйл. Гарцаагүй байдал

42.1.Энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах эрх, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөнд тулгарсан аюулыг зайлуулахын тулд энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж, учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага бөгөөд үг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байсан бол уг үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

43 дугаар зүйл. Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл

43.1.Нийгэмд ашигтай зорилгод хүрэхээр хийсэн үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэлийн үр дүнд энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

43.2.Эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүй хийхүйгээр тухайн зорилгод хүрч чадахгүй байсан бөгөөд эрсдэл хийсэн этгээд энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулахүйн тулд хангалттай арга хэмжээ авсан бол үндэслэл бүхий эрсдэлд тооцно.

43.3.Олон хүний амь насанд гэм хор учруулах, нийтийг хамарсан буюу байгалийн гамшигт үр дагаварт хүргэх аюул бодитой байхад эрсдэл хийснийг үндэслэл бүхий эрсдэлд тооцохгүй.

44 дүгээр зүйл. Тушаал, захирамж биелүүлэх

44.1.Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй. Харин хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

44.2.Илт хууль бус тушаал, захирамж биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Илт хууль бус тушаал, захирамжийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ЗОРИЛГО, ТӨРӨЛ

45 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагын ойлголт, зорилго

45.1.Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хууль заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн.

45.2.Эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хүлээлгэнэ.

45.3.Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн,

нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

46 дугаар зүйл. Ялын төрөл

46.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна:

46.1.1. торгох;

46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

46.1.3. эд хөрөнгө хураах;

46.1.4. албадан ажил хийлгэх;

46.1.5. баривчлах;

46.1.6. хорих;

46.1.7. цаазаар авах.

46.2.Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.

47 дугаар зүйл. Торгох

47.1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ.

47.2.Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгөрөөр тогтооно.

47.3.Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамаарулан шүүх торгох ялыг баривчлах, гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.

47.4. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хоригломо.

48 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах

48.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ.

48.2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дуусан үеэс эхлэн тоолно.

48.3.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг торгох, албадан ажил хийлгэх ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.

49 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах

49.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.

49.2.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана.

49.3.Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

50 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх

50.1.Энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн гийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ.

50.2.Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ.

50.3.Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын хорин дөрвөн цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино.

50.4.Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй.

51 дүгээр зүйл.Баривчлах

51.1.Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ.

51.2.Баривчлах ялыг нэг сараас дүргаан сар

хүртэл хугацаагаар оногдуулна.

51.3.Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй.

51.4.Цэргийн жинхэнэ хугацаат албан хаагчид оногдуулсан баривчлах ялыг сахилгын байранд ганцаарчлан эдлүүлнэ.

52 дугаар зүйл. Хорих

52.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ.

52.2.Хорих ялын үндсэн хугацаа нэгээс арван таван жил хүртэл байна. Хорих ялыг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар оногдуулж болно.

52.3.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй.

52.4.Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.

52.5.Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

52.6.Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

52.7.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

52.8.Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

52.9.Урьд нь хорих ял эдэлж байсан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

52.10.Шүүх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, ялтны хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хорих ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлж буюу чангарууллан өөрчилж болно. Иймхүү шийдвэрлэсэн шалтгааныг шийтгэх тогтоолд заана.

52.11.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно.

53 дугаар зүйл. Цаазаар авах

53.1.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно.

53.2.Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ.

53.3.Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино.

53.4.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.

АРАВДУГААР БҮЛЭГ

ЯЛ ОНОГДУУЛАХ

54 дүгээр зүйл. Ял оногдуулах нийтлэг зарчим

54.1.Шүүх энэ хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд чанд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял оногдуулна.

54.2.Шүүх ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ.

55 дугаар зүйл. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал

55.1.Шүүх ял оногдуулахдаа дор дурдсан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

55.1.1.тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн;

55.1.2. гэмт хэргийн улмаас учрах хор уршгийг зайлуулсан;

55.1.3. гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан;

55.1.4.хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автсан, эсхүл эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлд нь орсноос гэмт хэрэг үйлдсэн;

55.1.5.хохирогчийн хууль бус үйлдлээс болж санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас болон хохирогчийн хэт хайхрамжгүйгээс гэмт хэрэг үйлдсэн;

55.1.6. өөрт нь болон гэр бүлийн гишүүнд нь, түүнчлэн бусад хүмүүст тохиолдсон хүнд нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн;

55.1.7. арван найман насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн;

55.1.8. жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн;

55.1.9. үйлдсэн гэмт хэрэгтээ чин сахаанаас гэмшсэн буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн;

55.1.10.бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид эмнэлгийн болон бусад тусламж үзүүлсэн.

55.2. Энэ хуулийн 55.1-д заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал нь уг хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй.

56 дугаар зүйл. Ял хүндрүүлэх нөхцөл байдал

56.1.Шүүх ял оногдуулахдаа зөвхөн дор дурдсан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

56.1.1. гэмт хэрэг давтан үйлдсэн;

56.1.2. гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн;

56.1.3. эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулсан, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүй хүнээр гэмт хэрэг үйлдүүлсэн;

56.1.4. гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан;

56.1.5. гэмт хэргийг онц харгис хэрцгий аргаар буюу хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн;

56.1.6. жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, биеэ хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

56.1.7. нийтэд учирсан гамшигт байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдсэн;

56.1.8. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаа хүн, түүний ойрын төрөл садангийн хүний эсрэг гэмт хэргийг тэдний гүйцэтгэж байгаа үүрэгтэй нь холбогдуулан үйлдсэн;

56.1.9. нийтэд аюултай аргаар гэмт хэрэг үйлдсэн буюу галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх үйлчилгээтэй галт хэрэгсэл, хорт бодис, эм бэлдмэл, химийн болон биологийн гаралтай бодис ашиглаж гэмт хэрэг үйлдсэн;

56.1.10. согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн;

56.1.11. өөр гэмт хэргийг нуун далдлах буюу үйлдэхэд хялбарчлах зорилгоор үйлдсэн;

56.1.12. шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан буюу ялыг тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн.

56.2.Энэ хуулийн 56.1-д заасан хүндрүүлэх нөхцөл байдал нь уг хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй.

56.3.Шүүх ял оногдуулахдаа энэ хуулийн 56.1-д зааснаас бусад байдлыг ялыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.

57 дугаар зүйл. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял оногдуулах

57.1.Энэ хуулийн тусгай ангийн өөр өөр
үйлд болон нэг зүйлийн тус бүрд нь оногдуулж
олох өөр өөр хэсгүүдэд заасан хоёр буюу түүнээс
ээш гэмт хэрэг үйлдсэн этгээд тэдгээрийн алинд
ь ч ял шийтгүүлээгүй бол шүүх гэмт хэрэг тус бүрд
ь ял оногдуулж, хөнгөн ялыг хүндэд нь багтаах,
сүүл хэрэг тус бүрт оногдуулсан ялыг хамгийн
үнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээний дотор
үгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн
ичлэн эдлэх ялыг тогтооно.

57.2.Шүүх гэм бүруутай этгээдэд ял
ногдуулахдаа энэ хуулийн тусгай ангийн зүйл,
эсэгт заасан нэг буюу хэд хэдэн нэмэгдэл ялыг
ндсэн ялтай нь хамт оногдуулж болно.

57.3.Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө
өр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол
арсны дараа тогтоогдвол түүнд энэ зүйлд заасан
сүрмыг баримтлан ял оногдуулна. Ингэж
ийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор
үрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тоолно.

58 дугаар зүйл. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах

58.1.Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа
үюу оногдуулсан ялыг бүрэн эдэлж дуусахын өмнө
эмт хэрэг шинээр үйлдэж шийтгүүлж байгаа бол
шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан
ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор
ногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу
ларимыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх
ялыг тогтооно.

58.2.Энэ хуулийн 58.1-д заасан журмаар
ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ биечлэн эдлэх
ялын хугацааг тухайн төрлийн ялын энэ хуулиар
огтоосон дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй.

58.3. Албадан ажил хийлгэх, баривчлах
ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил
хийлгэх ялын хорин дөрвөн цагийг баривчлах ялын
нэг хоногтой тэнцүүлж тооцно.

58.4. Албадан ажил хийлгэх, хорих ялыг
хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил хийлгэх
ялын хорин дөрвөн цагийг хорих ялын нэг хоногтой
тэнцүүлж тооцно.

58.5. Баривчлах, хорих ялыг хооронд нь
нэмж нэгтэхдээ баривчлах ялын нэг хоногийг хорих
ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно.

59 дүгээр зүйл.Цагдан хоригдсон хугацааг тооцох

59.1.Шүүх цагдан хоригдсон хугацааг
шүүгдэгчийн ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно.
Гэхдээ гэнданд ял эдлэх хугацаанд цагдан хоригдсон хугацааг оруулж тооцохгүй.

59.2.Цагдан хоригдсон нэг хоногийг албадан ажил хийлгэх ялын хорин дөрвөн цагтай, баривчлах, хорих ялын нэг хоногтой тэнцүүлж ялын хугацаанд оруулж тооцно.

59.3.Цагдан хоригдсон этгээдэд торгох буюу тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан бол цагдан хоригдсон хугацааг харгалзан шүүх уг ялыг хөнгөрүүлэх буюу ял эдэлсэнд тооцож болно.

60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулах

60.1.Шүүх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулахдаа гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, завдалт төгссөн эсэх, бэлтгэсэн буюу завдсан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэргээ түүлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана.

60.2.Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын хоёрны нэгээс хэтрэхгүй байна.

60.3.Гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын гуравны хоёроос хэтрэхгүй байна.

60.4.Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүй.

61 дүгээр зүйл.Тэнсэх

61.1.Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан тохиолдолд түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж, нэгээс таван жилийн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно. Тэнсэгдсэн этгээдэн шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинэээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй.

61.2.Энэ хуулийн 61.1-д заасан журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй.

61.3.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

62 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

62.1.Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Иймэ тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна.

62.2.Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсэн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгуулагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг харааа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно.

62.3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацааны даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана.

62.4.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулсан бол цагдаагийн байгуллагын саналыг үндэслэн шүүх түүнийг ялаас чөлөөлж болно.

62.5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

63 дугаар зүйл. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

63.1.Шүүх анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

63.2.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгуулагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.

63.3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

64 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний төрөл

64.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэнэ:

64.1.1.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;

64.1.2.хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ.

65 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх

65.1.Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хэрэг хариуцах чадвартай байхдаа гэмт хэрэг үйлдсэн боловч шүүхээр хэрэг шийдвэрлэх үед буюу ял эдэлж байхдаа сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд сэтгэцийн эмгэг судлалын ердийн буюу тусгай эмнэлэгт байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

65.2.Шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдан эгтээдэд оношлогооны болон эмчилгээний туршилт хийхийг хориглоно.

66 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах, өөрчлөх, зогсоох

66.1.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн эгтээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно.

66.2.Сэтгэцийн эмгэг судлалын ердийн эмнэлэгт байлгах арга хэмжээг сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэцийн эмнэлэгт байлгах, албадан журмаар эмчлэх шаардлагатай эгтээдэд хэрэглэж болно.

66.3.Сэтгэцийн эмгэг судлалын тусгай эмнэлэгт эмчлүүлэх арга хэмжээг сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан нийгэмд онц аюултай эгтээдэд хэрэглэж болно.

66.4.Тусгай эмнэлэгт байлгаж байгаа эгтээдийг нийгэмд аюултай гэмт хэрэг шинээр үйлдэх боломжгүй, хүч нэмэгдүүлсэн хяналтын нөхцөлд байлгана.

66.5. Шүүх эмчилж байгаа байгууллагын дүгнэлтээр эдгэрсэн буюу өвчний шинж байдал өөрчлөгдсний улмаас уг эгтээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэхийг зогсоохоор шийдвэрлэнэ.

66.6.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг эмчилж байгаа байгууллагын дүгнэлтээр шүүх өөрчилж болно.

66.7.Шүүх уг эгтээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн, мөн тийм арга хэмжээ хэрэглэхийг зогсоосон бол уг эгтээдийг эмчийн хяналтад заавал байлгахаар төрөл, садангийн нь хүнд, эсхүл асран хамгаалагчид нь шилжүүлж болно.

67 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацаг тооцох

67.1.Гэмт хэрэг үйлдсэний дараа буюу ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадварүй болсон эгтээдэд уг өвчнийг эдгэрсний дараа хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй буюу эрүүгийн хариуцлагас чөлөөлөх бусад үндэслэл байхгүй бол шүүх ял оногдуулж болно. Эдгэрсний нь дараа ял оногдуулсан эгтээдийн ялын хугацаанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацаат оруулан тооцно.

68 дугаар зүйл. Архаг архичин буюу мансуурах донтой эгтээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэдэнд харгалзан дэмжигч тогтоох

68.1.Архаг архичин буюу мансуурах донтой эгтээд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх уг эгтээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулахын зэрэгцэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

68.2.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой эгтээдэд шаардлагатай гэж шүүх үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

68.3.Хорих ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой эгтээдийг ял эдлэх хугацаанд нь шаардлагатай гэж үзвэл албадан эмчилж болно.

68.4.Албадан эмчилгээг уг эгтээдийг эмчилж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх зогсооно.

68.5.Согтууруулах ундаа буюу мансуурууллах зүйл хэрэглэж, гэр бүлээ эд хөрөнгийн хүнд байдалд оруулсан эгтээд гэмт хэрэг үйлдсэн буюу уг гэмт хэрэгт нь шүүх хорихоос өөр төрлийн ял оногдуулбал түүний гэр бүлийн гишүүд, төрийн бус байгууллага, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр түүний эрх зүйн чадамжийг хязгаарлах эрхтэй бөгөөд шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн уг эгтээдэд харгалзан дэмжигч тогтооно.

69 дүгээр зүйл. Насанд хүрээгүй эгтээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх

69.1.Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй эгтээдэд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл түүнд дор дурдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно:

69.1.1. зургаан сараас нэг жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах;

69.1.2. арван зургаан насанд хүрсэн этгээд бие даасж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх;

69.1.3. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүний хяналтад өгөх;

69.1.4.хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байгахаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох.

69.2.Насанд хүрээгүй этгээд энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээ авагдсаны дараа засарч хүмүүжихгүй байвал шүүх уг арга хэмжээг насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно.

69.3.Насанд хүрээгүй этгээдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах хугацааг уг этгээдийн зан төлөв, ахуй амьдралын байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан шүүхээс тухай бүр тогтоох эрхтэй боловч арван зургаан насныхаас хэтрүүлж болохгүй.

69.4.Насанд хүрээгүй этгээдийг тогтоосон хугацааны өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас чөлөөлөх асуудлыг тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БОЛОН ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

70 дугаар зүйл. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

70.1.Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дурарааа хэргээ илчилж ирсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

71 дүгээр зүйл. Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

71.1.Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм бурууташ этгээд хохирогчтой сайн дурарааа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

72 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

72.1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:

72.1.1. хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

72.1.2. хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

72.1.3. хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

72.1.4. онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн.

72.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ хуулийн 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг суүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

72.3. Шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.

72.4.Энэ хуульд зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна.

72.5.Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.

73 дугаар зүйл. Цаг үеийн нөхцөл байдал

өрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүгийн эриуцлагаас чөлөөлөх

73.1.Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн гүүдийн хэргийг шүүхээр хянан хэлэлцэх үед цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл нийгэмд аюултай шинж чанараа алдсан бүхүү уг эгүзэд нийгэмд аюулгүй болсон нь тогтоогдвол шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

74 дүгээр зүйл. Хорих ял эдлэхээс угацааанаас нь өмнө тэнсэн суллах

74.1.Хорих ял шийтгүүлсэн ялтан засарч умүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг йлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорлог рилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс угацааанаас нь өмнө тэнсэн суллаж болно.

74.2.Шүүх ялтанг хугацааанаас нь өмнө энсэн суллахдаа эдлээгүй үлдэж байгаа ялын угацаатай тэнцүү хянан харгалзах хугацаа тогтоож, үүнд энэ хуулийн 62.2-т заасан үүрэг үүлээлгэж юлно.

74.3.Ялтан оногдсон ялынхаа дор дурдсан увийг эдэлсэн тохиолдолд энэ хуулийн 74.1, 74.2- заасан журмыг хэрэглэнэ:

74.3.1. хүндэвтэр гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй увийг;

74.3.2. хүнд гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй увийг;

74.3.3.онц хүнд гэмт хэрэгт ногдуулсан хорих ялын тавны дөрөөс доошгүй увийг.

74.4.Цаазаар авах ял шийтгүүлж гчлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр гооцогдсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэж учруулсан кохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд ял эдлэхээс кугацааанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй.

74.5.Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг хорих ял эдлүүлж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

74.6.Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд цагдаагийн байгууллага, цэргийн албан хаагчид цэргийн анги, нэгтгэлийн дарга хяналт тавина.

74.7.Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан явдал нь ялтныг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

74.8.Ялтан хянан харгалзах хугацааны шүүхээс хүлээлгэсэн үүрэг биелүүлэхээс зайлсхийсэн, захиргааны зөрчил гаргаж шийтгэгдсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгож, үлдсэн ялыг эдлүүлэхээр захирамж гаргана.

74.9.Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.

75 дугаар зүйл. Өвчний үчир ялаас чөлөөлөх

75.1.Шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл ойуун ухааны хомсдолтой болсон бүхүү өөр бусад хүнд евчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж бүхүү үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх ялаас чөлөөлнө.

75.2.Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа ялтан сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл ойуун ухааны хомсдолтой болсон бүхүү өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж бүхүү үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх ял эдлэхээс чөлөөлнө.

75.3.Ялтан ял эдлэхэд саад учруулахүйц хүнд өвчнөөр өвчилсөн бол шүүх үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан ялаас чөлөөлж болно.

76 дугаар зүйл. Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх

76.1.Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол ялтны үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй:

76.1.1.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч нэг жил өнгөрсөн;

76.1.2.таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн;

76.1.3.таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн;

76.1.4.арван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван таван жил өнгөрсөн.

76.2.Ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ тохиолдолд ялтан цагдан хоригдсон буюу өөрөө сайн дураараа хэргээ илчлэн ирсэн өдрөөс уг хугацааг сэргээн тоолно.

76.3.Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна.

76.4.Ялтан энэ хуулийн 76.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

76.5.Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн ялтанд энэ зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

77 дугаар зүйл. Өршөөл буюу уучлал үзүүлж ял эдлэхээс чөлөөлөх

77.1.Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлж болно.

77.2. Уучлал үзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ялтанг ял эдлэхээс хэсэгчлэн болон бүрэн чөлөөлж болно.

78 дугаар зүйл. Ялтай байдал

78.1.Ялтан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүнийг ялгүйд тооцох буюу ялгүй болох хүртэл хугацаанд ялтайд тооцогдоно.

78.2. Дор дурдсан этгээд дараахь тохиолдолд ялгүй болно:

78.2.1.тэнсэн хянан харгалзсан, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

78.2.2.хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш нэг жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

78.2.3.хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш таван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

78.2.4.хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш найман жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

78.2.5.онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш арван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй.

78.3.Ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссаны дараа зан байдал, засрал хүмүүжлээрээ үлгэр жишээ байвал шүүх хугацаанаас нь өмнө ялгүйд тооцож болно.

78.4.Энэ хуулиар тогтоосон журмын дагуу ялаас хугацааны өмнө суллагдсан этгээдийн ялгүй болох хугацааг үндсэн ба нэмэгдэл ял эдлэхээс чөлөөлөгдсөн үеэс тоолно.

78.5.Ялаа эдэлж дууссан этгээд ялгүй болох хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл ялгүй болох хугацаа тасрах бөгөөд сүүлчийн гэмт хэрэгт оногдуулсан үндсэн ба нэмэгдэл ялыг эдэлж дууссаны дараа түрүүчийн гэмт хэрэгт ялгүй болох хугацааг хамтатган эхэлж тоолно. Тэгэхдээ аль хүнд ялтай хэрэгтээ ялгүй болох хугацаа дуустал уг этгээд аль алинд нь ялтайд тооцогдоно.

ТУСГАЙ АНГИ

ТАВДУГААР ХЭСЭГ

ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

79 дүгээр зүйл.Эх орноосоо урвах

79.1.Монгол Улсын иргэн төр улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор гадаад улсын тагнуулын албанд элссэн, төрийн нууцыг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн, Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагатай хамтран ажилласан, дайны байдалд буюу дайн бүхий байдал зарласан үед дайсны талд шилжин орсон бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Гадаад улсын тагнуулын албанд элссэн боловч явсан даалгаврыг биелүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын албатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн Монгол Улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

80 дугаар зүйл.Тагнуул хийх

80.1.Гадаад улсын иргэн буюу харьяалалгүй хүн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор төрийн нууц, түүнд хамаарах мэдээ, баримт, бусад зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, тэдгээрийг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

81 дүгээр зүйл.Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах

81.1.Улс төрийн үйл ажиллагаанд нь саад учруулах, Монгол Улсын засаг төрийг бусниулан доройтуулах зорилгоор улс төр, олон нийтийн үйл ажиллагаатай нь холбогдуулан төр, нийгмийн зүтгэлтний бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

81.2.Энэ хуулийн 81.1-д заасан зорилгоор төр, нийгмийн зүтгэлтнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

82 дугаар зүйл.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах

82.1.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулсан бол арван зургаагаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулахад оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө энэ тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

83 дугаар зүйл.Зэвсэгт үймээн дэгдээх

83.1.Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан төрийн тогтолцоог хүчээр өөрчлөх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах зорилгоор зэвсэгт үймээн дэгдээсэн бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

84 дүгээр зүйл.Хорлон сүйтгэх

84.1.Монгол Улсын эдийн засгийн хүчин чадлыг сулруулан доройтуулах зорилгоор үйлдвэр, байгууламж, зам харилцаа, холбооны хэрэгсэл, бусад эд хөрөнгийг тэслэх, дэлбэлэх, галдан шатаах болон бусад аргаар хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хүн, мал, ургамлын гоц халдварт өвчин тараасан, олон хүнийг хордуулсан, түүнчлэн хүн, мал, амьтныг үй олноор нь устгасан бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

85 дугаар зүйл.Хорлон саатуулах

85.1.Монгол Улсын эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадлыг сулруулан доройтуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаг саатуулсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

86 дугаар зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах

86.1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны үзэл номлолоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх зорилгоор ухуулга, сурталчилгаа

явуулсан, ялгаварлан гадуурхаж, эрхийг нь шууд буюу шууд бусаар хязгаарласан буюу давуу байдал тогтоосон бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

87 дугаар зүйл.Төрийн нууц задруулах

87.1.Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн эгтээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

87.2.Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

88 дугаар зүйл.Төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх

88.1.Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, албан үүргийн хувьд мэдсэн эгтээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

89 дүгээр зүйл.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх

89.1.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наяас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

89.2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй.

90 дүгээр зүйл.Улсын хилийн дэглэм зөрчих

90.1.Монгол Улсын хилийн багана, тэмдгийг санаатай устгасан, гэмтээсэн, хилийн шугамыг огтлон гарсан ус, зам, гүүр, холбооны байгууламжийг ашиглах журам болон улсын хилийн дэглэмийг бусад хэлбэрээр ноцтой зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

ЗУРГАДУГААР ХЭСЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах

91.1.Энэ хуулийн 91.2-т заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

91.2.Хүнийг:

91.2.1.шунахайн сэдэлтээр;

91.2.2.танхайн сэдэлтээр;

91.2.3.өс хонзонгоор;

91.2.4 захиалгаар;

91.2.5.хохирогчийн цус, эд, эрхтэнийг ашиглах зорилгоор;

91.2.6.өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор;

91.2.7.уулгалан довтлох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ;

91.2.8.хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэрэг үйлдэхдээ;

91.2.9.онц аюултай гэмт хэрэгтэн;

91.2.10.хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн /энэ хуулийн 93 дугаар зүйл хамаарахгүй/;

91.2.11.бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;

91.2.12.онц харгис хэрцгий аргаар;

91.2.13.нийтэд аюултай аргаар;

91.2.14.хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж;

91.2.15.хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;

91.2.16. хоёр буюу түүнээс олон хүнийг;

91.2.17.албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын

төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

92 дугаар зүйл. Эх нь нярай хүүхдээ алах

92.1.Эх нь сэтгэл санааны гүнзгий хямралын үед нярай хүүхдээ төрөх явцад буюу төрмөгц алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

93 дугаар зүйл. Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах

93.1.Хохирогчид хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон, эсхүл түүний хууль бус бусад үйлдлээс өөрт нь буюу ойр дотных нь хүмүүст хүнд хор уршиг учирсан, учирч болох байснаас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үедээ бусдыг санаатай алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

94 дүгээр зүйл. Бусдыг болгоомжгүй алах

94.1.Бусдыг болгоомжгүй алсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх

95.1.Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

96 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах

96.1.Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан бол таваас дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

96.2.Энэ хэргийг:

96.2.1.танхайн сэдэлтээр;
96.2.2.захиалгаар;
96.2.3.онц аюултай гэмт хэрэгтэн;
96.2.4.давтан;
96.2.5.бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;
96.2.6.онц харгис хэрцгий аргаар;
96.2.7. нийтэд аюултай аргаар;
96.2.8.тохуурхан даажигнаж, зовоон тарчлааж;
96.2.9.хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;
96.2.10. хоёр буюу түүнээс олон хүнийг;
96.2.11.албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан үйлдсэн бол долоогоос дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

97 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах

97.1.Бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

98 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах

98.1.Бусдын бие махбодид удаан хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулсан буюу хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан гэмтэл санаатай учруулсан бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

98.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, уг үйлдэл нь зовоон тарчлаах шинжтэй байсан, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

99 дүгээр зүйл. Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах

99.1.Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

99.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

100 дугаар зүйл. Тарчлаах

100.1.Байнга зодох буюу тарчлаах шинжтэй

бусад үйлдэл хийсэн нь энэ хуулийн 96, 98 дугаар зүйлд заасан хор уршиг учруулагүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

101 дүгээр зүйл. Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах

101.1.Хүний цус, эд, эрхтэнг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

101.2.Энэ хэргийг хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгаар мэдсээр байж, эсхүл эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүний хувьд үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурваас таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

102 дугаар зүйл. Хүний цус, эд, эрхтэнг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах

102.1.Эмч, эмнэлгийн ажилтан хүний цус, эд, эрхтэнг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэсэн, шилжүүлэн суулгасны улмаас хүн өвчилсөн, тахир дутуу болсон, хүний амь хохирсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

103 дугаар зүйл. Бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх, халдаах

103.1.Эмнэлгийн байгууллагаас шаардсаар байтал бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхээс санаатай зайлсхийсэн бол нэг зуугаас өөр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

103.2.Өөрийн биед бэлгийн замын халдварт өвчин байгааг мэдсээр байж хурьцал үйлдэх буюу өөр замаар бусдад халдаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

103.3.Энэ хуулийн 103.2-т заасан хэргийг давтан үйлдсэн, түүнчлэн хоёр буюу түүнээс олон, эсхүл насанд хүрээгүй хүнд бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

104 дүгээр зүйл. Дархлалын олдмол хомсдолын өвчнийг эмчлэхгүй орхих

104.1.Эмч дархлалын олдмол хомсдол өвчин, түүний халдварыг илрүүлсэн, оношилсон тухайгаа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдээгүй, өвчтөн болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид холбогдох зааварчилгаа өгөөгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

104.2.Дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүнд эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэхээс татгалзсан, энэ өвчнөөр өвчилсөн үндэслэлээр эрхийг нь хязгаарласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

105 дугаар зүйл.Дархлалын олдмол хомсдолын өвчин халдаах

105.1.Эмнэлэг, эм хангамжийн болон бусад байгууллагын ажилтан дархлалын олдмол хомсдолын өвчний нян илрүүлэх шинжилгээ хийлгээгүй цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнийг борлуулсаны улмаас тухайн өвчний халдвар бусдад халдаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

105.2.Эмч, эмнэлгийн ажилтан үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас дархлалын олдмол хомсдолын өвчний халдвар бусдад халдаасан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

105.3.Өөрийн биед дархлалын олдмол хомсдолын өвчин байгааг мэдсээр байж хурьцал үйлдэх буюу өөр замаар бусдад халдаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

106 дугаар зүйл. Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх

106.1.Эмч, эмнэлгийн ажилтан өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ хүндэтгэх шаалтгаангүйгээр биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүйгээс евчтөний бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан бол тодорхой албан ташаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөделмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтэнэ.

106.2.Энэ хэргийн улмаас өвчтөн нас барсан буюу түүний бие махбодид хүнд гэмтэл учирсан бол тодорхой албан ташаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

107 дугаар зүйл. Бусдыг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь тусламж үзүүлэхгүй байх

107.1.Бусдыг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь өөртөө болон бусдад хохирол учруулахгүйгээр туслах бололцоо байсан боловч яаралтай тусламж үзүүлээгүй, эсхүл тусламж үзүүлэх шаардлагатайг зохих байгууллагад мэдэгдээгүйгээс гэм хор учирсан бол хоер зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтэнэ.

107.2.Өндөр настан, бага насны, өвчний болон бусад шалтгааны улмаас биеэ хамгаалж чадахгүй хүнийг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь туслах бололцоотой бөгөөд халамжлах үүрэгтэй этгээд тусламж үзүүлээгүй зориуд орхисон, эсхүл түүнийг амь насанд нь аюултай байдалд зориуд оруулсан бол хөделмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

107.3.Энэ хэргийн улмаас хохирогч нас барсан, бусад хүнд хор үрсир учирсан бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЛДАР ХҮНД, НЭР ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

108 дугаар зүйл. Хүн хулгайлах

108.1.Хүн хулгайлсан нь хүн барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

108.2.Энэ хэргийг:

108.2.1.шунахайн сэдэлтээр;

108.2.2.онц аюултай гэмт хэрэгтэн;

108.2.3. давтан;

108.2.4.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

108.2.5.амь биед нь аюултай хүч хэрэглэж;

108.2.6.зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

108.2.7. хоёр буюу түүнээс олон хүнийг;

108.2.8.насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

108.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор үрсир учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

Тайлбар: Хүн хулгайлсан үйлдэл нь бие даасан өөр гэмт хэргийн шинжгүй бөгөөд хулгайлагдсан хүнийг сайн дураараа сулласан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

109 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар хорих

109.1.Хүнийг хууль бусаар хорьсон нь энэ хуульд заасан албан тушаалын болон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, түүнчлэн хүн хулгайлах, барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол хөделмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтэнэ.

109.2.Энэ хэргийг:

109.2.1.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

109.2.2.амь биед нь аюултай хүч хэрэглэж;

109.2.3. зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

109.2.4.хоёр буюу түүнээс олон хүнийг;

109.2.5.насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэнэ.

109.3.Энэ хэргийг зохион байгуулалттай

бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

110 дугаар зүйл. Доромжлох

110.1.Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111 дүгээр зүйл. Гүтгэх

111.1.Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.2.Гүтгэлгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.3.Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112 дугаар зүйл.Хүнийг барьцаалах

112.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс менгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.2.Энэ хэргийг:

112.2.1.шунахайн сэдэлтээр;

112.2.2.онц аюултай гэмт хэрэгтэн;

112.2.3.давтан;

112.2.4. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

112.2.5.барьцаанд байгаа хүний амь биед заналхийлж;

112.2.6.зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

112.2.7.хоёр буюу түүнээс олон хүнийг;

112.2.8.насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл хүний амь хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Барьцаанд байгаа хүнийг сайн дурааваа сулласан этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

113 дугаар зүйл.Хүн худалдах, худалдан авах

113.1.Хүн худалдсан буюу худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2.Энэ хэргийг:

113.2.1.хүний цус, эд, эрхтэнг ашиглаж зорилгоор;

113.2.2.биеийг нь үнэлүүлэх зорилгоор;

113.2.3.давтан;

113.2.4.хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.5.насанд хүрээгүй хүнийг;

113.2.6.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3.Энэ хэргийг байнга үйлдсэн, хүнийг хил давуулан худалдсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

114 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

114.1.Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэж, хууран мэхлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан бол нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл

хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

114.2.Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хоёр зуун нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

114.3.Насанд хүрээгүй хүнийг зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэлд элсүүлсэн, эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг соггуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах

115.1.Насанд хүрээгүй хүнийг соггуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

115.2.Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таван нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

115.3.Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

116 дугаар зүйл.Хүүхэд солих, хууль бусаар үрчлэх

116.1.Хүүхдийг санаатай сольсон, хууль бусаар үрчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таван нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117 дугаар зүйл. Хүүхэд хаях, төөрүүлэх

117.1.Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

117.2.Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

118 дугаар зүйл. Асран хамгаалах үүргээ урвуулах

118.1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ шунахай зорилгоор урвуулан ашигласан, асран хамгаалж байгаа хүнээ хараа хяналтгүй байлгасан, шаардлагатай тусламж үзүүлэлгүй орхисон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөө торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

119 дүгээр зүйл.Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах

119.1.Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах албан үүрэг бүхий этгээд уг үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас хохирогчийн бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учруулсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

119.2.Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

120 дугаар зүйл.Эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх

120.1.Хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

121 дүгээр зүйл. Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх

121.1.Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

122 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх

122.1.Насанд хүрсэн этгээд хохирогчийг арван зургаан насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун дөрөвөн жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

123 дугаар зүйл.Садар самууныг сурталчлах

123.1 Садар самууныг сурталчилсан хэвлэл , ном зохиол , зураг , кино , дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

123.2. Энэ хэрэгт арван зургаан насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

123.3.Энэ хэрэгийг насанд хүрээгүй хүнд хүч хэрэглэж буюу энэ гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд , эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах

124.1.Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

124.2.Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

125 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

125.1.Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгалах чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126 дугаар зүйл. Хүчиндэх

126.1.Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126.2.Энэ хэргийг:

126.2.1.хохирогчийг тохуурхан даажигнаж, зовоон тарчлаах;

126.2.2.хүндэвтэр буюу хүнд гэмтэл учруулж;

126.2.3.давтан;

126.2.4.насанд хүрээгүй хүнийг;

126.2.5.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан, эсхүл бага насны, өөрөөр хэлбэл арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

127 дугаар зүйл. Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх

127.1.Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлсэн бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх,

гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

128 дугаар зүйл. Эмнэлэгийн бус нөхцөлд үр хөндөх

128.1.Эмч эмнэлгийн бус нөхцөлд, түүнчлэн мэргэжлийн бус хүн үр хөндсөн бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

128.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан, бусад хүнд хор урших үчирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

129 дүгээр зүйл.Булш сүйтгэх

129.1.Булш сүйтгэсэн буюу түүнд байсан эд зүйлийг авсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

129.2.Энэ хэргийг давтан, тохуурхан даажигнаж, эсхүл онц жигшүүртэй авирлаж үйлдсэн бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОН БУСАД ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

130 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх

130.1.Иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагааанд саналаатай саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

130.2.Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, санал худалдаж авах зэрэг аргаар үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дагнэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

131 дүгээр зүйл. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах

131.1.Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны гишүүн, бусад албан тушаалтан сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан, сонгогчоос санал нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

132 дугаар зүйл.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих

132.1.Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцоных нь төлөө иргэнийг ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

133 дугаар зүйл.Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих

133.1.Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

134 дүгээр зүйл. Иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх

134.1.Иргэнийг улс төрийн нам, төрийн бус байгууллагад сайн дурарраа эвлэлдэн нэгдсэнтэй төлөө ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, хоёр зуун тавиас гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас

дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

135 дугаар зүйл.Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих

135.1.Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

135.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж, эсхүл тусгай техник хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

136 дугаар зүйл. Хувь хүний нууцыг задруулах

136.1.Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

136 .2.Энэ хэргийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

137 дугаар зүйл.Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих

137.1.Иргэнд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж орон байранд нь хууль бусаар нэвтрэх, дур мэдэн орж суух, орон байрнаас гаргах, нэгжлэг хийх зэргэр орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

137.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

138 дугаар зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчих

138.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ үүргээ биелүүлэхгүйгээс хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

138.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор урших учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

139 дүгээр зүйл. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагааны саад хийх

139.1.Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

139.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

140 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийг зөрчих

140.1.Зохиогчийн бүтээлийг түүний зөвшөөрөлгүйгээр өөрийн нэрээр гаргасан, хууль бусаар хуулбарласан, нийтлүүлсэн, тараасан, борлуулсан, хамтран зохиогч болохоор албадсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

141 дүгээр зүйл. Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг зөрчих

141.1. Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын зохиогч, патент эзэмшигчийн бүтээлийг

үүль бусаар өөрийн нэрээр гаргасан, тараасан, орлуулсан, хамтран өмчлөгч болохоор албадсан эл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас доёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

142 дугаар зүйл.Хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих

142.1.Нийгмийн хэв журам, бусад хүний эрх, эрх чөлөөнд халдахгүйгээр мөргөл үйлдэх, тахил өргөх, хурал хурах зэргээр шашны зан үйл үйлдэх, шашныг сурталчлахад хүч хэрэглэж бүюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эд меңгөөр татах зэргээр саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

143 дугаар зүйл. Шүтэх байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх

143.1.Хүнийг шүтэх байгаа шашнаар нь ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх, хүч хэрэглэж бүюу хүч хэрэглэхээр заналхийлж, бусад хэлбэрээр эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

144 дүгээр зүйл.Шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах

144.1.Шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан бүюу тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

144.2.Энэ хэргийг давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

144.3.Насанд хүрээгүй хүнийг шашны харгис үзэл номлолд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ДОЛДУГААР ХЭСЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

145 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг хулгайлах

145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

145.2.Энэ гэмт хэргийг давтан бүюу бүлэглэж, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж бүюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

145.3.Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан бүюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл тавааc дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

145.4.Энэ хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа, эсхүл бүлаах, дээрэмдэх, уялгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагчтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

146 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг булаах

146.1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс

гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

146.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, бусдын амь насанд аюулгүй хүч хэрэглэж, нийтэд учирсан гамшигт байдал, хохирогчийн эд хөрөнгөө хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж, урьд энэ хэрэгт шийтгүүлж байсан этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан таваас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

146.3.Энэ хэргийг урьд нь дээрэмдэх, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, эсхүл урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун далан таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

146.4.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагч бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх

147.1. Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147.2. Энэ хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, эсхүл эвдсэг, эвдсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол наймаас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагч бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан бол зэ хөрөнгийг хураах арваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах

148.1. Бусдын эд хөрөнгө, эсхүл түүний өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуу тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2.Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3.Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагч бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол зэ хөрөнгийг хураах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149 дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх

149.1.Өмчлөгч, эд хөрөнгийг итгэмхлэгдэн хариуцаж буюу хамгаалж байгаа этгээдэд болон тэдний ойр дотны хүмүүст хүч хэрэглэх, нэр хүндийг нь гутаасан мэдээ баримт тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар заналхийлж эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг шилжүүлэн өгсөхийг шаардсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн их хэмжээний эд хөрөнгө авахаар далайлган сүрдүүлсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149.3.Энэ хэргийг урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл

йлдсэн, түүнчлэн онц их хэмжээний эд хөрөнгө вахаар далайлган сүрдүүлсэн бол таваас дээш рван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авших, үрэгдүүлэх

150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсэн, эсхүл албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж бусдын эд өрөнгийг авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

150.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

150.3.Энэ хэргийн улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

151 дүгээр зүйл. Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших

151.1.Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгийг завшсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

152 дугаар зүйл. Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших

152.1.Бусдын хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгө, малыг завшсан буюу үрэгдүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх

153.1.Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.2.Энэ гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор хүршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

154 дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгө хамгаалахад хайнга хандах

154.1.Хууль болон гэрээгээр бусдын эд хөрөнгийг хамгаалах үүрэг хүлээсэн этгээд үүг үүрэгтэй хайнга хандсаны улмаас тухайн эд хөрөнгө их хэмжээтэйгээр үрэгдсэн буюу гэмтсэн нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

154.2.Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол хоёр зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

155 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах

155.1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

155.2.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр борлуулах зорилгоор авсан буюу борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

АЖ АХУЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

156 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж зөрчих

156.1.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр банк нээсэн, банкны үйл

ажиллагаа хууль бусаар явуулсны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156.2.Банкны байгууллагын ажилтан шунахайн буюу хувийн ашиг сонирхлын үүднээс банкны болон мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157 дугаар зүйл. Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох

157.1.Албан тушаалтан банкны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлж албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцсоны улмаас банкны төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учруулсан бол эд хөрөнгийг хураж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158 дугаар зүйл.Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчих

158.1.Үнэт цаас гаргах, гүйлгээнд оруулах, худалдах, арилжих, түүгээр төлбөр тооцоо хийх, брокер, диллерийн үйл ажиллагаа явуулах журмыг зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэ хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэ үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц и хэмжээний хохирол учирсан бол тодорхой алба тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг тава жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

159 дүгээр зүйл. Аудитын тухай хуул тогтоомж зөрчих

159.1.Хуулийн этгээд, хувираа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн үйл ажиллагаа шалгаж баталгаажуулах, дүгнэлт гаргах талаа тогтоосон аудитын үйл ажиллагааны журмы санаатай зөрчсөний улмаас бусдад их хэмжээни хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доо хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахи нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөө торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэ хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

159.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэн үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад он их хэмжээний хохирол учирсан бол тодорхой алба тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхий гурван жил хүртэл хугацаагаар хасч, таван жи хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

160 дугаар зүйл. Эрдэнэсийн сангий тухай хууль тогтоомж зөрчих

160.1.Төрийн эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас их хэмжээний хохирол учирсан нь эн хуулийн 155 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол хоёр зуун тавин нэгээс таван зуун ца хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхү хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

161 дүгээр зүйл. Хориглосон үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа эрхлэх

161.1.Хууль тогтоомжоор хориглосон, тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ худалдаар дур мэдэн их хэмжээтэйгээр эрхэлсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

161.2.Энэ хэргийг урьд нь энэ хэрэгт

шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ эргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах, таваас дээш арван жил ртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

162 дугаар зүйл. Үйлдвэрлэл, үйлчилгээ, удалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах

162.1.Банкнаас зээл авах, татвар төлөхөөс айлсхийх, хууль бус орлого олох, хориглосон буюу тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэхийн тулд зохиомол аж ахуйн нэгж байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наян нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

162.2.Энэ хэргийг давтан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний орлого олсон бол зэ хөрөнгийг хураах, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

163 дугаар зүйл. Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах

163.1.Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос таваь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

163.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хураах, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

163.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хураж, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

164 дүгээр зүйл. Санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулах

164.1.Шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр аж ахуйн нэгж, байгууллага, банкны санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээ баримтыг хууль бусаар олж авсан, ашигласан, задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

164.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

165 дугаар зүйл. Санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах

165.1.Аж ахуйн нэгжийг түүний эзэн буюу эрх баригч шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр санаатайгаар төлбөрийн чадваргүй болгосны улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

165.2.Аж ахуйн нэгжийг түүний эзэн буюу эрх баригч шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр санаатайгаар зээлийн ёр төлөхийг хойшлуулах, түүнийг төлөх нөхцөлийг көнгөрүүлэх, зээлийн өрийн хүүг багасгах, эсхүл төлөхгүй байхын тулд төлбөрийн чадваргүй болсон гэж харилцагч талд мэдэгдэх, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргах зэргээр зохиомлоор дампуурсан мэт дүр эсгэсэн этгээдийн албан тушаалтан, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх

166.1.Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориудаар бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу ураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл онц их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол эд хөрөнгийг хураж, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

167 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчих

167.1.Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих хууль тогтоомжид заасан жүрмыг зөрчсөн, татварын хяналт шалгалтад саад учруулсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

168 дугаар зүйл.Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах

168.1.Өөрийн болон гадаад улсын ижил нэр төрлийн бүтээгдэхүүний барааны тэмдгийг хуурамчаар үйлдсэн, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

169 дүгээр зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх

169.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан бууру жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэн өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргэр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

169.2.Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажилгаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

170 дугаар зүйл. Хууль бусаар шан харамж авах

170.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан албан үүргийн дагуу ажи гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргэ далимдуула хясан боогдуулах замаар удаа дараа буюу и хэмжээний шан харамж авсан нь албан тушаалы гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаа эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жи хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсни доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахи нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөө торгох, гурваас дээш зургаан сар хүртэ хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171 дүгээр зүйл. Гологдол буюу чана муутай бүтээгдэхүүн худалдах

171.1.Аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, эр баригч, албан тушаалтан заавал мөрдөх улсы стандартад нийцээгүй, чанарын баталгаажуулал хийлгээгүй, гологдол, чанар муутай, иж бүрдэ дутуу бүтээгдэхүүнийг удаа дараа буюу и хэмжээтэйгээр худалдсан, худалдаанд гаргасан бо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэ зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээни төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан са хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

171.2.Энэ хэргийн улмаас бусдад и хэмжээний хохирол учирсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албада ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171.3.Энэ хэргийн улмаас хүний амь на хохирсон, бусад хүнд хор урших учирсан бол тавааc дээш найман жил хүртэл хугацаагаар хорих я шийтгэнэ.

172 дугаар зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах

172.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллага, иргэн эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг удаа дараа буюу их хэмжээтэйгээр худалдсан, худалдаанд гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

172.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор урших учирсан бол тавааc дээш найман жил хүртэл хугацаагаар хорих я шийтгэнэ.

173 дугаар зүйл. Согтууруулах ундаа хориглосон зүйлээр бэлтгэх

173.1.Согтууруулах ундаа хүнсний

эриулалтын бус зүйлээр их хэмжээтэйгээр элтгэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг авин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй энцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас эээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял ийтгэнэ.

174 дүгээр зүйл. Чанар муутай барилга ариулах, ашиглалтад оруулах

174.1.Барилга барьж байгаа аж ахуйн нэгж, айгуулагын ээнэ, эрх баригч, түүнчлэн барилгын анарт хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан анар муутай, дутуу болон батлагдсан зураг төсөлд охироогүй барилга бариулсан буюу ашиглалтад үлээлгэн өгсний улмаас их хэмжээний хохирол чирсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг үртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл аван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

174.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас охирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол одорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа ивуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар асах буюу хасахгүйгээр таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175 дугаар зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх

175.1.Хориглосон буюу хязгаарласан эд зүйл, ховор амьтан, түүнчлэн их хэмжээний валют, валютын үнэт зүйл, эрдэнэс, эрдэс, түүнчлэн байгалийн төрлийг улсын хилээр хууль бусаар хил нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

175.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн, түүнчлэн түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтан, үргамлын үндэс, үнэт олдвор, археологийн ба палентологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн онц их хэмжээтэйгээр үйлдсэн бол эд хөрөнгийг хураж, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах

176.1.Монгол Улсад төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж борлуулсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.3. Энэ хэргийг зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураж арваас дээш арван таван жил хүртэл хорих ял шийтгэнэ.

НАЙМДУГААР ХЭСЭГ

НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХҮН АМЬН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

177 дугаар зүйл. Зандалчлах

177.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахад шуud буюу шууд бус нөлөөлөх зорилгоор, олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн нийтэд аюултай хүч хэрэглэсэн буюу хэрэглэхээр заналхийлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

177.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэлтгэхэд идэвхтэй оролцсон боловч гэмт үйлдэл

эхлэхээс өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсүл энэ үйлдлийг таслан зогсооход идэвхтэй оролцсон бөгөөд түүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжүүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

178 дугаар зүйл. Зандалчлах тухай санаатай худал мэдээлэх

178.1. Зандалчлах тухай санаатай худал мэдээлсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

179 дүгээр зүйл. Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох

179.1.Түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

180 дугаар зүйл. Уулгалан довтлох

180.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уулгалан довтлох зорилгоор зохион байгуулалттай, зэвсэг бүхий бүлэг байгуулсан, түүнчлэн энэ бүлэгт элссэн буюу энэ бүлгийн довтолгоонд оролцсон бол арван нэгээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181 дүгээр зүйл.Танхайрах

181.1.Олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналандийлж, нийгмийн хэв жүрмыг бүдүүлгээр зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.2.Энэ хэргийг:

181.2.1. догшин авирлаж;

181.2.2.нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэж;

181.2.3. урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд;

181.2.4.давтан;

181.2.5.бүлэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.3.Энэ хэргийг онц ачуултай гэмт хэрэгтэн, түүнчлэн эзвсэг, эзвсгийн чанартай буса, зүйл хэрэглэж үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

182 дугаар зүйл. Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах, түүнд оролцох

182.1.Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлд элссэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

182.2.Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэх зорилгоор зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулсан, түүнийг удирдсан, үйл ажиллагаанд нь оролцсон бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

182.3.Энэ хуулийн 182.2-д заасан хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол эд хөрөнгийг хураж арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

183 дугаар зүйл. Ачуулгүй ажиллагаанд журам зөрчих

183.1.Уул, уурхай, барилга, түүнчлэн тэсэрч дэлбэрэх ачуул гарч болзошгүй үйлдвэр бусад аж ахуйн нэгж, байгууллагад ачуулгүй ажиллагаанд журам зөрчсөний улмаас хүний амь нас хохирсон бусад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

184 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах

184.1.Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

184.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх

185.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, айлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг /уль бусаар хийж бэлтгэсэн, хадгалсан, авч явсан, орлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод эмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй энцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс /рван сар хүртэл хугацаагаар баривчлах ял ийтгэнэ.

185.2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан гсэж тохиролцсон болон зохион байгуулаттай үлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл галт зэвсэг, айлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг уль бусаар үйлдвэрлэсэн бол хоёроос таван жил үртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт эрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодисыг зохих өөшөөрөлгүй хадгалж байгаад зохих байгуулагад айн дураараа авчирч өгсөн этгээдийг эрүүгийн ариуцлагаас чөлөөлнө.

186 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны алт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах

186.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, айлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг ;улгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, авших зэргээр хууль бусаар олж авсан бол өдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

186.2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан /гсэж тохиролцсон болон зохион байгуулаттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн уг зүйлийг албан эжлын хувьд ашиглах буюу хамгаалахаар ятгэмжлэгдэн хариуцсан этгээд үйлдсэн бол өдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял ийтгэнэ.

187 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хамгаалах үүрэгт ажилдаа хайнга хандах

187.1.Галт зэвсгийг хайхрамжгүй хадгалж бусдад ашиглах боломж олгосноос хүний амь нас хохирсон, бусад хүнд хор урших учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

187.2.Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн этгээд уг үүрэгтэя хайхрамжгүй хандсаны улмаас хулгайлагдсан буюу устгагдсан, эсхүл энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

188 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх

188.1.Галт зэвсэг, байлдааны галт хэрэгслийг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

188.2.Хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

188.3.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл их хэмжээтэйгээр, түүнчлэн албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

188.4.Энэ хэргийг зохион байгуулаттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

189 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих

189.1.Аж ахуйн нэгж, байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг хүлээсэн этгээд галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөнөөс их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

189.2.Энэ хэргийн улмаас хүний амь хохирсон, бусад хүнд хор уршиг, онц их хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

190 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг буртгэх, хадгалах, ашиглах,тээвэрлэх, илгээх журам зөрчих

190.1.Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг буртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журмыг зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

190.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

191 дүгээр зүйл.Түргэн шатамхай болон идэмхий бодисыг хууль бусаар илгээх

191.1.Түргэн шатамхай болон идэмхий бодисыг шуудан, тээшээр илгээсний улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЬН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах

192.1.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.2.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.3.Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг:

192.3.1. онц их хэмжээгээр;

192.3.2.насанд хүрээгүй хүн оролцуулж;

192.3.3.онц аюултай гэмт хэрэгтэн;

192.3.4.давтан;

192.3.5.урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

193 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих

193.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээрийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, буртгэх, худалдах, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, устгах журмыг зөрчсөн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил

хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёр
ууагаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан
ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар
хорих ял шийтгэнэ.

194 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах

194.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

194.2.Энэ хэргийг:

194.2.1. их буюу онц их хэмжээгээр;

194.2.2.мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглаж;

194.2.3.урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд;

194.2.4.давтан;

194.2.5.бүлэглэж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

195 дугаар зүйл. Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хураж авах

195.1.Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьсан, ургуулсан, хураж авсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196 дүгээр зүйл. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах

196.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх байр байгуулсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196.2.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

197 дугаар зүйл. Хууль бусаар эмчлэх

197.1.Эмчийн мэргэжлийн бус этгээд эмчилгээ эрхэлсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавин нэг дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

197.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

198 дугаар зүйл. Хууль бусаар эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх

198.1.Эмийн сангийн үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм, бэлдмэлийг их хэмжээгээр борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

198.2.Энэ хэргийн улмаас хүний амь хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

199 дүгээр зүйл. Тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих

199.1.Ариун цэвэр-эрүүл ахуй, дархлаажуулалтын талаар тогтоосон болон тахалтай тэмцэх журам зөрчсөнөөс, эсхүл дархлаажуулалтаас хүндэтгэх шалтгаангүйгээр зайлсхийснээс тахал болон гоц халдварт бусад өвчин тархсан буюу тархаж болох байсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

200 дугаар зүйл. Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах

200.1.Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, олгох, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих

ял шийтгэнэ.

200.2.Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

200.3.Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

201 дүгээр зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах

201.1.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний бие махбодийг хөнгөн буюу хүндэвтэр гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

201.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

202 дугаар зүйл. Агаарын тухай хууль тогтоомж зөрчих

202.1.Агаарыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор бохирдуулсны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих

203.1.Хориотой үед, хориглосон газарт болон хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, ангахыг хориглосон ан амьтанг зохих эвөшөөрөлгүйгээр агнасан, барьсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203.2.Нэн ховор ан амьтан агнасан, барьсан, хууль бусаар түүний үр төл, түүхий эдийн зүйлийг улсын хилээр гаргасан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

204 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих

204.1. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

204.2.Уулын үйлдвэр болон газар доорх байгууламж ашиглалтад оруулах, түүнийг ашиглах явцад, түүнчлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

204.3.Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

205 дугаар зүйл. Байгаль орчныг бохирдуулах

205.1.Аюултай болон бусад хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулсны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

205.2.Аюултай хог хаягдлыг улсын хилээр

нэвтрүүлсэн бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

206 дугаар зүйл. Химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих

206.1.Үйлдвэрлэлийн хортой хог хаягдал, цацраг идэвхт, биологийн болон химийн бодисыг цэвэрлэх, тээвэрлэх, булшлах талаар тогтоосон журмыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан бөгөөд учирч болох байсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

207 дугаар зүйл. Газар эвдэх, гэмтээх, бохирдуулах

207.1.Химийн бодис, бордоог хадгалах, ашиглах, тээвэрлэх журам зөрчсөн болон үйлдвэр, аж ахуйн хортой хог хаягдлаар газрыг бохирдуулсан, хөрсийг гэмтээсний улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан бөгөөд учирч болох байсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

208 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж зөрчих

208.1.Усны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ан амьтан, шувуу, загас олноор үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209 дүгээр зүйл. Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих

209.1.Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчсөний улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

210 дугаар зүйл. Байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах

210.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад орсон байгалийн объектыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

211 дүгээр зүйл. Ойн тухай хууль тогтоомж зөрчих

211.1.Зохих зөвшөөрөлгүйгээр ойд үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэсэн, онцгой бүсийн ой, ногоон бүсийн болон хориотой зурвасын ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулснаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

211.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

212 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих

212.1.Нэн ховор ургамлыг хууль бусаар түүж бэлтгэсэн, улсын хилээр гаргасны улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих

213.1.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан нь энэ хуулийн 84, 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213.2.Гал болон түүрэн шатамхай зүйлтэй болгоомжгүй харьцсаны улмаас түймэр гарч хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, их хэмжээний хохирол учирсан бол хөөр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213.3.Ойн түймэр санаатай тавьсны улмаас ой, бэлчээрийг устгасан, хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, их буюу онц их хэмжээний

хохирол учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

214 дүгээр зүйл. Ашигт малтмалын хайгуул хийх, олборлох журам зөрчих

214.1.Тусгай зөвшөөрөлгүй эзгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

214.2.Тусгай зөвшөөрөлгүй эзгээд ашигт малтмалыг их буюу онц их хэмжээгээр олборлосон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих

215.1.Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

215.2.Энэ хэргийг согтуугаар үйлдсэн, хүний бие махбодид хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

215.3.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг дөрвөн жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан "жолооч "гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд, "тээврийн хэрэгсэл" гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн бусад механикжсан тээврийн хэрэгслийг тус тус ойлгоно.

216 дугаар зүйл. Зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхих

216.1. Жолооч осол гаргасныхаа дараа хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлээгүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй, эсхүл хэргийн газраас зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217 дугаар зүйл. Төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих

217.1.Төмөр зам, усан болон агаарын тээврийн байгууллагын ажилтан тухайн төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217.3.Энэ хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

218 дугаар зүйл. Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг чанаргүй засварлах, ашиглалтанд оруулах

218.1.Тээврийн хэрэгслийн холбоо, дохиоллын болон бусад тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, засвар хариуцсан ажилтан тэдгээрийг чанар муутай засварласан буюу ашиглалтанд оруулсны улмаас осол гарч хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

218.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

218.3. Энэ хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

219 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх

219.1.Тээврийн хэрэгслийн холбоо, дохиоллын болон бусад тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол нэг зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

219.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

220 дугаар зүйл. Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах

220.1.Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй ажиллагаат албаны хувьд хариуцсан ажилтан илт бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргасан, жолоодох эрхийн үнэмлэхгүй этгээдээр машин жолоодуулсны улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

220.2.Энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүнд гэмтэл учирсан, хүний амь нас хохирсон, түүнчлэн онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

221 дүгээр зүйл. Согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах

221.1.Тээврийн байгууллагын ашиглалт хариуцсан ажилтан согтуурсан буюу мансуурсан этгээд гэдгийг мэдсээр байж тээврийн хэрэгсэл жолоодуулсны улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

221.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, хүний бие махбодид хүнд гэмтэл, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

222 дугаар зүйл. Жолоогоо бусдад шилжүүлэх

222.1.Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд согтуурсан, мансуурсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээдэд жолоогоо шилжүүлсний улмаас хүний бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох буюу нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

222.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, хүний бие махбодид хүнд гэмтэл, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

223 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах

223.1.Авто тээврийн хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгоүйгээр авч зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

223.2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, түүнчлэн хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

223.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих

224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисэх ирэх буюу Монгол Улсаас нисэх гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шалтгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

224.2.Энэ хэргийн улмаас агаарын хөлөг осолдсон, сүйрсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

225 дугаар зүйл. Агаарын хөлөг авч зугтаах

225.1.Нислэгт буюу газарт байгаа агаарын хөлгийг авч зугтаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

225.2.Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл хөлгийг авч зугтаах зорилгоор эзэлж авсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

225.3.Энэ хэргийг давтан, эсхүл олон хүний амь насанд аюултай арга, зэвсэг хэрэглэж буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

КОМПЬЮТЕРИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

226 дугаар зүйл. Компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх

226.1.Компьютер, компьютерийн программ, түүний төхөөрөмжийг санаатайгаар өөрчилсэн, эвдсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, мэдээллийн сүлжээг сүйтгэсний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

226.2.Энэ хэргийг шунахайн сэдэлтээр, түүнчлэн урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг буюу албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

227 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авах

227.1.Компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа болон дамжуулж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарласан, бусад аргаар олж авсан буюу авахыг завдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

227.2.Энэ хэргийг шунахайн сэдэлтээр, түүнчлэн урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

228 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, борлуулах

228.1.Компьютер, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ болон техник хэрэгслийг бэлтгэсэн буюу борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

229 дүгээр зүйл. Нянтай программ зохион бүтээх, ашиглах, тараах

229.1. Компьютерийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, хаах, өөрчлөх болон хуулбарлах зорилгоор компьютерийн программ зохион бүтээх, программд өөрчлөлт оруулах, нянтай программыг тусгайлан зохион бүтээх, түүнийг мэдсээр байж ашигласан, тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

229.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ЕСДҮГЭЭР ХЭСЭГ

ЗАХИРГААНЫ ЖУРАМ, ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЛБАН ТУШААЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ЗАХИРГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

230 дугаар зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх

230.1 . Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь буюу олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь эсэргүүцсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

230.2.Энэ хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, түүнчлэн хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нааас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230.3.Энэ хэргийн улмаас төрийн албан

хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл учирсан бол хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230.4.Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол нэг зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох

231.1. Төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас нэг зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ хуулийн 230, 231 дүгээр зүйлд заасан Төрийн албан хаагч гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

232 дугаар зүйл. Олон нийтийн сонгуульт үүргээ биелүүлж байгаа иргэнийг заналхийлэх буюу түүнд хүч хэрэглэх

232.1.Албаны болон олон нийтийн үйл ажиллагаанд нь таслан зогсоох буюу түүний шинж чанарыг өөрчлөх зорилгоор олон нийтийн сонгуультан, түүнчлэн гэмт хэрэг болон эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсооход оролцож байгаа иргэнийг алах, бие махбодид нь гэмтэл учруулахаар заналхийлсэн, хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гаван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

232.2.Энэ хэргийн улмаас олон нийтийн сонгуультан болон иргэний журамт үүргээ биелүүлж байгаа иргэний бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

233 дугаар зүйл. Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах

233.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, түүнчлэн тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний үнэмлэх, гадаад паспорт, хувийн бусад баримт бичиг ашиглах буюу бусдад ашиглуулах зорилгоор хуурамчаар үйлдсэн, ашигласан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

233.2.Хуурамч баримт бичиг ашиглаж аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд үлэмж хэмжээний хохирол учруулсан, эсхүл энэ хэргийг байнга үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

234 дүгээр зүйл. Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хулгайлах, устгах, гэмтээх, нуух

234.1.Өс хонзонгийн болон хувийн бусад сэдэлтээр иргэний үнэмлэх, гадаад паспорт, хувийн бусад чухал баримт бичгийг хулгайлсан, устгасан, хуурамчаар үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

234.2.Шунахайн болон хувийн бусад сэдэлтээр аж ахуйн нэгж, байгууллагын мэдэлд байгаа баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хулгайлсан, устгасан, гэмтээсэн, нуусан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин

нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

234.3.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

235 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих

235.1. Төрийн архивын сан хөмрөгт орсон архивын баримт бичгийг хууль бусаар худалдсан, шилжүүлсэн, дамжуулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

236 дугаар зүйл.Дураарааа аашлах

236.1.Дураарааа аашлах, өөрөөр хэлбэл өөртөө үнэхээр байгаа буюу байна гэж үзсэн, эсхүл бусадтай маргаж байхдаа хуулиар тогтоосон жүрмыг зөрчиж эрхээ дураарааа хэрэгжүүлснээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

237 дугаар зүйл.Цэргийн татлагаас зайлсхийх

237.1.Бие эрхтэндээ гэмтэл учруулах, оргон зайлах, худал өвчлөх, хуурамч баримт бичиг үйлдэх, залилан мэхлэх зэргэр цэргийн жинхэнэ албаны эзлэхит татлагаас зайлсхийсэн бол нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

237.2.Монгол Улсын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд дайчилгаагаар татагдахаас зайлсхийсэн бол нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

237.3.Энэ хуулийн 237.2-т заасан хэргийг дайны буюу дайн бухий байдал зарласан үед үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

238 дугаар зүйл. Дайны буюу дайн бухий байдал зарласан үед албан журмын үүргээ биелүүлэхээс зайлсхийх

238.1.Дайны буюу дайн бухий байдал зарласан үед хөдөлмөрийн дайчилгаа болон албан журмын бусад үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

239 дүгээр зүйл. Төрийн дайчилгаанаас зайлсхийх

239.1.Байгалийн гэнэтийн аюул, хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрээс эсэргүүцэх, улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон дайчилгаанаас санаатайгаар зайлсхийсэн, саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

240 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зөрчис журам зөрчих

240.1.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад байх эрхийн баримт бичиггүй буюу хүчингүй баримт бичгээр оршин суусан, бүртүүлэх, хаягийн бүртгэл хийлгэх, шилжин суурьших, оршин суух газраа сонгох талаар тогтоосон журам зөрчсөн, эсхүл оршин суух, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх журам зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

241 дүгээр зүйл. Улаан загалмайн тэмдэг, нэрийг хууль бусаар ашиглах

241.1.Улаан загалмайн тэмдэг, нэрийг хууль бусаар ашигласнаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг

нэг зуун нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

242 дугаар зүйл. Холбооны шугам хамгаалах журам зөрчих

242.1.Холбооны шугам хамгаалах журмыг санаатай зөрчсөний улмаас харилцаа холбооны байгууллагын хэвийн үйл ажиллагаа тасалдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх буюу гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

243 дугаар зүйл. Мөрийтэй тоглох

243.1.Хуулиар хориглосон мөрийтэй тоглоом /казино/ тоглосон, түүнийг зохион байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

243.2.Энэ хэрэгийг давтан үйлдсэн бол эд хөрөнгийг хураж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

244 дүгээр зүйл. Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах

244.1.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас битүүмжилсэн эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

245 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулах

245.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

245.2.Энэ хэрэгийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

246 дугаар зүйл. Гэмт хэргийг үл мэдээлэх

246.1.Энэ хуулийн тусгай ангийн 91/Хүнийг санаатай алах/, 98/Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 108/Хүн хулгайлах/, 112/Хүнийг барьцаалах/, 126.2; 126.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх/, 145.2; 145.3; 145.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146.2; 146.3; 146.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах /, 148.2; 148.3; 148.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх/, 150.2; 150.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх /, 147/Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/ , 176/Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 177/Зандалчлах/, 225/Агаарын хөлөг авч зугатаах/, 268.2; 269.2; 270.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хэзээ хахууль авах, өгөх, зуучлах / -т заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс ная дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

246.2.Энэ хуулийн тусгай ангийн 79/Эх орноосоо урвах/, 80/Тагнуул хийх/, 81/Төр, ниймгийн эүтгэлтний амь биед халдах/, 82/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хүйвалдаан зохион байгуулах/,

84/Хорлон сүйтгэх/, 85/Хорлон саатуулах/ дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

247 дугаар зүйл. Гэмт хэргийг нуун далдлах

247.1.Энэ хуулийн тусгай ангийн 91/Хүнийг санаатай алах/, 98/Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 108/Хүн хулгайлах/, 112/Хүнийг барьцаалах/, 126.2; 126.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх/, 145.2; 145.3; 145.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146.2; 146.3; 146.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах/, 148.2; 148.3; 148.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх/, 150.2; 150.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх/, 147/Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 176/Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 177/Зандалчлах/, 225/Агаарын хөлөг авч зугатаах/, 268.2; 269.2; 270.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хэзээ хахууль авах, өгөх, зуучлах/-т заасан гэмт хэргийг урьдчилан амлалгүйгээр нуун далдалсан бол гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

247.2. Энэ хуулийн тусгай ангийн 79/Эх орноосоо урвах/, 80/Тагнуул хийх/, 81/Төр, нийгмийн эсрэгтэлтий амь биед халдах/, 82/Терийн эрх мэдлийг хууль бусаар авах хүйвалдаан зохион байгуулах/, 84/Хорлон сүйтгэх/, 85/Хорлон саатуулах/, 188/Хар тамхи, мансуурууллах болон хордуулах бодис, галт зэвсэг, байлдаанны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх/ дүгаар зүйлд заасан гэмт хэргийг урьдаас амлалгүйгээр нуун далдалсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

248 дугаар зүйл. Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх

248.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

248.2. Илт гэм буруугүй хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулсан, сэжигтнээр тооцсон, яллагдагчаар татсан, ял шийтгэсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчид их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

249 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар баривчлах

249.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт хууль бусаар хүнийг баривчилсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

250 дугаар зүйл. Шүүхээс хууль бус шийдвэр гаргах

250.1.Шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт хууль бус шийдвэр гаргасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

250.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

251 дүгээр зүйл. Мэдүүлэг өгөхийг албадах

251.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан доожингах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

251.2.Энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр тавааc дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

252 дугаар зүйл. Зориуд худал мэдээлэх

252.1.Хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж зориуд худал мэдээлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

252. 2.Энэ хэргийг шунахайн болон хувийн бусад сэдэлтээр үйлдсэн, эсхүл хүнийг хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт холбогдуулж буюу ялгах нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлж худал мэдээлсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

253 дугаар зүйл. Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх

253.1.Иргэний шүүн таслах ажиллагааnд оролцогчид, түүнчлэн шүүгч нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

253.2.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эмгөөлөгч, прокурор, шүүгч эрүүгийн хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

253.3.Энэ хуулийн 253.2-т заасан албан тушаалтан хүнд, онц хүнд гэмт хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

254 дүгээр зүйл. Худал мэдүүлэг өгөх

254.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхэд гэрч, хохирогч зориуд худал мэдүүлэг өгсөн, шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан, орчуулагч зориуд худал орчуулсан, хэлмэрч зориуд худал хэлмэрчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

254.2.Энэ хэргийг шунахайн болон хувийн бусад сэдэлтээр үйлдсэн, эсхүл хүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулж буюу нотлох баримт хуурамчаар бүрдүүлж, хуурамч мэдүүлэг өгсөн, түүнчлэн энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

255 дугаар зүйл. Гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс, шинжээч дүгнэлт гаргахаас татгалзах, зайлсхийх

255.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхэд гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс, шинжээч дүгнэлт гаргахаас хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн, түүнчлэн гэрч, хохирогчийг дуудагдан ирэхэд буюу үнэн зөв мэдүүлэг өгөхэд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

256 дугаар зүйл. Гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх

256.1.Хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн, шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин

нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

256.2.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тааваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

257 дугаар зүйл. Мөрдөн байцаалтын мэдээ баримтыг задруулах

257.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тааваас тавь дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх

258.1.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тааваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

258.2.Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай бууруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бүсдад шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос дээш дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

258.3.Энэ хэргийг гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

259 дүгээр зүйл. Шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэх

259.1.Хэргийг хянан хэлэлцэх шийдвэр гаргах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулж шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тааваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

260 дугаар зүйл. Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух

260.1.Хуулийн байгуулагаас дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд санаатай үрэгдүүлсэн, нуусан, бүсдад шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тааваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

261 дүгээр зүйл. Шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох

261.1.Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан шүүх, цагдан хорих, хорих ангиас оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

261.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл харуул манаанд зэвсэг, хүч хэрэглэж буюу хорих ангийн барилга байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмжийг эвдэж оргосон бол тааваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

262 дугаар зүйл. Хорих ял эдлэхээс зайлсхийх

262.1.Түр чөлөөгөөр явсан ялтан тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хорих ангидаа буцаж ирэлгүй ял эдлэхээс зайлсхийсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах

263.1.Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласнь улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

263.2.Энэ хэргийг давтан үйлдсэн,уг хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг хамаарууллна.

264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх

264.1.Төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

264.2.Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах

265.1.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль тогтоомж, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуун нэгээс дөрвөн зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

265.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх , үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамаарууллна.

266 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх

266.1.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан албан үүргийн хувьд хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх мэдлээ илтэд хэтрүүлсний улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

266.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл түүний улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих

267.1.Албан тушаалтан бус эзгээд төрийн болон төрийн бус байгуллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр барьж үйл ажиллагаа явуулсан нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжгүй, энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний ашиг олсон, эсхүл бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

268 дугаар зүйл. Хэзл хахууль авах

268.1.Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268.2.Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахууллийн хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хахууль авсан бол эд хөрөнгийг хураауж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх

269.1.Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

269.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахууллийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгуллагад сайн дураараа илчлж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах

270.1.Хээл хахууль өгч авахад зуучилсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

270.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахууллийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгуллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

271 дүгээр зүйл. Албан тушаалтан хуурамч баримт бичиг үйлдэх

271.1.Албан тушаалтан баримт бичиг зориуд худал мэдээ оруулсан, худал бичсэн, засвар оруулсан буюу он, сар, өдрийг өөрчилсөн, түүнчлэн баримт бичиг зориуд хуурамчаар үйлдсэн буюу үйлдэж олгосон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

272 дугаар зүйл. Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах

272.1.Албан тушаалтан хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

272.2.Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

273.1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

273.1.2.зах зээлийн дунджаас

дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан;

273.1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, менгенийг эргэлтийг саатуулсан;

273.1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

273.1.5. төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дундажаас доогуур үнээр борлуулсан;

273.1.6.улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үсгралтад шаардлага хангагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртүйг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

273.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ЕСДҮГЭЭР ХЭСЭГ

ЦЭРГИЙН ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ЦЭРГИЙН АЛБАНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

274 дүгээр зүйл. Цэргийн гэмт хэргийн ойлголт

274.1. Монгол Улсын иргэн зэвсэгт хүчин, бусад цэрэгт, цэргийн үүрэгтэн дайчилгаа, сургууль, цугларалтын үед цэргийн алба хаах талаар хуулиар тогтоосон журмыг зөрчиж энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн бол цэргийн гэмт хэрэг гэнэ.

274.2.Цэргийн албан хаагч гэдэгт зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн хамаарна.

274.3.Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, гал сөнөөгч, хорих байгууллагын албан хаагч энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

274.4.Энэ хуулийн 274 дүгээр зүйлд дурдаагүй этгээд цэргийн гэмт хэрэгт хамтран оролцсон бол энэ хуулийн 35 дугаар зүйлийг журамлан энэ хуулийн зохих зүйл, хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

274.5.Дайны байдалд буюу дайн бүхий байдал зарласан үед цэргийн алба хаах талаар тогтоосон журам зөрчсөн гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлагыг тухайн үед батлагдсан Монгол Улсын хуулиар тогтооно.

275 дугаар зүйл.Захирагчийн тушаал биелүүлэхгүй байх

275.1.Цэргийн дүрмийн дагуу өгсөн захирагчийн тушаалыг захирагдагч биелүүлэхгүйн улмаас цэргийн албаны ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

275.2.Энэ хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

275.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

276 дугаар зүйл. Захирагчийг заналхийлэх, эсэргүүцэх, хүч хэрэглэх

276.1.Цэргийн албаны үйл ажиллагааг хууль, дүрмийн дагуу явуулсантай нь холбогдуулан захирагчаа зодсон, хүч хэрэглэн эсэргүүцсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, бие махбодид нь хөнгөн гэмтэл учруулсан, албан үүргийг нь зөрчүүлэхээр албадсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

276.2.Энэ хэргийг зэвсэг хэрэглэж буюу бүлэглэн үйлдсэн, захирагчийн бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

276.3.Энэ хэргийн улмаас захирагчийн бие махбодид хүнд гэмтэл, их буюу онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл дайны байдалд шилжсэн

буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

277 дугаар зүйл. Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх

277.1.Цэргийн дүрмийн бус байдлаар харьцаж захирагч нь захирагдагчаа зодсон, хүч хэрэглэсэн, бие махбодид хөнгөн гэмтэл учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

277.2.Энэ хэргийн улмаас захирагдагчийн бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан, эсхүл хэд хэдэн захирагдагчийг зодсон буюу хэрцгий догшин авиржаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

277.3.Энэ хэргийг зэвсэг хэрэглэж үйлдсэн, эсхүл захирагдагчийн бие махбодид хүнд гэмтэл, түүнчлэн их хэмжээний хохирол учруулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

278 дугаар зүйл. Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих

278.1.Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцан зодолдох буюу бусад байдлаар хүч хэрэглэн хэн нэгэндээ хөнгөн гэмтэл учруулсан бол нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

278.2.Энэ хэргийг хоёр буюу түүнээс дээш цэргийн албан хаагчийн эсрэг үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

278.3.Энэ хэргийг бүлэглэж буюу зэвсэг хэрэглэж үйлдсэн, эсхүл хүний бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

279 дүгээр зүйл. Цэргийн албанаас оргон зайлах

279.1.Цэргийн хугацаат болон гэрээт албан хаагч цэргийн албанаас зайлсхийх зорилгоор цэргийн анги, салбар, алба хааж байгаа газраа дүрэм мэдэн орхиж явсан, эсхүл албан томилолт, амралтын чөлөө дууссан буюу эмнэлгээс гарсны дараа эргэж ирэхгүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

279.2.Офицер, ахлагч оргон зайлсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

279.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол таваас дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

280 дугаар зүйл. Биедээ гэмтэл учруулах буюу өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх

280.1.Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч өөрийн биед гэмтэл учруулах, худал өвчлөх, хуурамч баримт бичиг үйлдэж ашиглах зэргээр хууран мэхэлж цэргийн албанаас зайлсхийлсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

280.2.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

281 дүгээр зүйл. Цэргийн эд хөрөнгийг болон байлдааны галт хэрэгслийг зарах, үрэгдүүлэх, завших

281.1.Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч өөрт нь хэрэглүүлэхээр тавьж олгосон цэргийн хувцас, хэрэгсэл, эд зүйлийг бусдад худалдах, арилжих, бэлэглэх, барьцаанд өгөх зэргээр завшсан, эсхүл тэдгээрийг арчилж хамгаалах, хэрэглэх үүргээ биелүүлэгүйгээс их хэмжээтэйгээр гэмтээсэн, устгасан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

281.2.Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч өөрт нь итгэмжлэн хариуцуулсан байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг завшсан, үрэгдүүлсэн, гэгдүүлсэн, эсхүл цэргийн техник, тоног төхөөрөмж, тээврийн болон бусад зөөвөрлөх хэрэгсэл буюу цэргийн эд хөрөнгийг харж хамгаалах үүргээ биелүүлэгүйгээс уг эд хөрөнгө их хэмжээтэйгээр устсан, гэмтсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

281.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282 дугаар зүйл. Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх

282.1.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тэсвэрийн болон зөөвөрлөх хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж болон бусад эд хөрөнгийг санаатай устгасан, гэмтээсэн нь хорлон сүйтгэх гэмт хэргийн шинжгүй бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол тавааc дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол долоогоос дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

283 дугаар зүйл. Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих

283.1.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх болон орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл, эд зүйл, цацраг идэвхт бодистой харьцах журам зөрчсөнөөс хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

283.2.Энэ хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан, хүний амь нас хохирсон бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

284 дүгээр зүйл. Байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих

284.1.Байлдааны тусгай зориулалтын болон цэргийн тээврийн машин жолоодох, ашиглах журам зөрчсөний улмаас хүний бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

284.2.Энэ хэргийг согтуугаар үйлдсэн,энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, эсхүл хүний бие махбодид хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч, хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

284.3.Энэ хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тавааc дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

285 дугаар зүйл. Байлдааны болон сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих

285.1.Байлдааны болон сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх талаар тогтоосон журам зөрчсөний улмаас их хэмжээний хохирол учрах бодит нөхцөл бүрдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

285.2.Энэ хэргийн улмаас онгоц сүйрсэн, хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

286 дугаар зүйл. Байлдааны жижүүр хийх журам зөрчих

286.1.Гадаад улсын цэргийн халдлагыг цаг тухайд нь илрүүлэх үүрэг бүхий байлдааны жижүүр хийх журмыг зөрчсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

286.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

286.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол зургаагаас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

287 дугаар зүйл. Дотоод албаны журам зөрчих

287.1.Цэргийн анги, нэгтгэлийн хоногийн манааны /харуулаас гадна/ үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч дотоод албаны журам зөрчсөний улмаас их хэмжээний хохирол учирсан бол гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

287.2.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

288 дугаар зүйл. Харуулын албаны журам зөрчих

288.1.Харуулын албаны журам, түүний дагуу гарсан захирагчийн тушаал, захирамжийг зөрчсөний улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

288.2.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

289 дүгээр зүйл. Хилийн алба хаах журам зөрчих

289.1.Монгол Улсын хил хамгаалах манааны бүрэлдэхүүнд орсон цэргийн албан хаагч

хил хамгаалах хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмыг зөрчсөнөөс бага бус хохирол учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

289.2.Энэ хэргийг хилийн цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

289.3.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

290 дүгээр зүйл. Цэргийн анги, нэгттэлийг дайсанд буулгаж өгөх, орхих

290.1.Захирагч цэргийн анги, нэгттэлийг санаатайгаар дайсанд буулгаж өгсөн, дайны талбарт буюу байлдааны байдалд анги, нэгттэлийг удирдлагагүй орхисон, байлдааны байдал шаардаагүй байхад бэхлэлт, байлдааны техник, бусад хэрэгслийг дайсны мэдэлд орхиж явсан бол арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

291 дүгээр зүйл. Байлдааны талбарыг дур мэдэн орхих, дайсантай зэвсэг барьж байлдахаас зайлсхийх

291.1.Цэргийн албан хаагч дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед байлдааны талбарыг айсан буюу шантарсны улмаас дур мэдэн орхиж явсан, даргын тушаалгүйгээр ухарсан, дайсантай зэвсэг барьж байлдахаас зайлсхийсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

292 дугаар зүйл. Сайн дурарааа дайсанд бууж өгч олзлогдох

292.1. Цэргийн албан хаагч айсан буюу шантарсны улмаас дайсанд сайн дураар бууж өгсөн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

292.2.Энэ хэргийг дээд тушаалын буюу ахлах офицер үйлдсэн бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

293 дугаар зүйл. Байлдааны талбарт тонуул хийх

293.1.Байлдааны талбарт алагдсан, шархадсан хүмүүсийн эд зүйлийг тоносон бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

294 дүгээр зүйл. Эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэх, хэрэгжүүлэхгүй байх

294.1.Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

294.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

294.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

295 дугаар зүйл. Албандаа хайнга хандах

295.1. Захирагч албандаа хайнга хандсаны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

295.2.Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

295.3.Энэ хэргийг дайны байдалд шилжсэн буюу дайн бүхий байдал зарласан үед үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

296 дугаар зүйл. Байлдааны талбарт улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах

296.1.Зохих эрхгүй этгээд байлдааны талбарт Улаан загалмайн байгууллагын далбаа, тэмдэг, нүүлгэн зайлуулах эмнэлгийн тээврийн хэрэгслийн бүдгийн өнгийг ашигласан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРАВДУГААР ХЭСЭГ

ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХ ТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ГУЧДУГААР БҮЛЭГ

ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

297 дугаар зүйл. Зэвсэгт мөргөлдөөн гаргах

297.1.Улс хоорондын буюу бүс нутгийг хамарсан зэвсэгт мөргөлдөөн үүсгэсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

298 дугаар зүйл. Дайныг сурталчлах, уриалах

298.1.Олон нийтийн дунд дайн явуулахыг сурталчилсан, дайнд уриалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

298.2.Энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах замаар буюу төрийн албан хаагч үйлдсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

299 дүгээр зүйл. Хориглосон арга хэрэгслээр дайн хийх

299.1.Олзлогдогсод, энгийн хүн амтай харгис хэрцгий харьцсан, хүн амыг оршин суугаа нутгаас нь албадан зайлуулсан, эзлэгдсэн нутагт түүх соёлын үнэт зүйлийг тонон дээрэмдсэн, эзэсэгт мөргөлдөөний үеэр Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон арга хэрэгсэл хэрэглэсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

299.2 Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон хүн амыг үй олноор нь хөнөөх, устгах зэвсэг хэрэгсэл хэрэглэсэн бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

300 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг бүтээх, олж авах, тараах

300.1. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсэг олж авсан, бүтээсэн, тараасан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

301 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох

301.1.Дайн өдөөх, улс хоорондын харилцааг хурцатгах зорилгоор олон улсын хамгаалалтад байдаг гадаад улсын төлөөлөгч, олон улсын байгууллагын ажилтан, түүнчлэн тэдний албан өрөө, орон байр, тээврийн хэрэгсэлд халдан довтолсон бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

301.2.Энэ хэргийг үйлдэхдээ олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийг алсан, барьцаалсан, эд хөрөнгийг нь их хэмжээгээр эмтээсэн, устгасан бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлд дурдсан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс гэдэгт гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын гадаад худалдааны байгууллагын ажилтнууд, дипломат элч, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад өөрийн улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хамаарна. Дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан өрөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна.

302 дугаар зүйл.Төрлөөр устгах

302.1.Үндэс, угсаа, арьсны өнгө болон хүн ам, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, бие махбодид нь хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг нь бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устаж үгүй болохоор хүрэгсэн бол хориос хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

303 дугаар зүйл. Хөлсний цэрэг ашиглах

303.1.Зэвсэгт мөргөлдөөн, дайны үйл ажиллагаанд гадаад улсын хөлсний цэрэг ашиглаган буюу түүнийг сургаж бэлтгэсэн, санхүүжүүлсэн, бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

303.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

303.3.Хөлсний цэрэг зэвсэгт мөргөлдөөн, дайны үйл ажиллагаанд оролцон бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

304 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах

304.1.Амьтны аймаг, ургамлын төрөл зүйлийг бөөнөөр нь гэмтээсэн, устгасан, агаар мандал, усны нөөцийг хордуулсан буюу бусад хэлбэрээр байгалийн тэнцлийг алдагдуулж байгалийн гамшигт хүргэсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

БУСАД ЗҮЙЛ

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

305 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

305.1. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр — **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон хэрэгт 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас нь чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон хэргийн хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаат хэрэгсэхгүй болгосугай.

3 дугаар зүйл. 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад заасснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын доод, дээд хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүхийн магадлалаар Эрүүгийн хуулийн заалтад нийцүүлэх арга хэмжээг авсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасснаар ялаас чөлөөлөгдсөн, түүнчлэн Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон хэрэгт шийтгүүлж ялаа эдэлж дууссан, хугацаанаас өмнө суллагдсан хүмүүсийг ялгүйд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан ажиллагаат 2002 оны 10 дугаар сарын 1-ний дотор, 3 дугаар зүйлд заасан ажиллагаат 12 дугаар сарын 1-ний дотор багтаан хэрэгжүүлэхийг Монгол Улсын дээд шүүх / Ч.Ганбат/, Улсын ерөнхий прокурор /М.Алтанхуяг/, Хууль зүй, дотоод хэргийн яам /Ц.Нямдорж/-д даалгасугай.

6 дугаар зүйл. Бусад хууль тогтоомжийг Эрүүгийн хуульд нийцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар / Н.Энхбаяр/-т даалгасугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр — **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйл:

"19 дүгээр зүйл Тогтвортой байдлын гэрээ

1. Монгол Улсад 2.0 сая ам. доллар буюу түүнтэй тэнцэх төгрөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж татварын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг байгуулж болно.

2. Тогтвортой байдлын гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газар батална. Энэхүү гэрээний загвар нь тодорхой хугацаанд татварын тогтвортой нөхцөлийг хангах бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, гэрээг цуцлах үндэслэл, хэрэгжүүлэх хугацааны тухай нөхцөлийг агуулсан байна.

3. Гадаадын хөрөнгө оруулагчийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2.0-10.0 сая ам. доллар буюу түүнтэй тэнцэх төгрөг байхаар бол тогтвортой байдлын гэрээг 10 жил, 10.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөөс дээш байхаар бол 15 жилээр тус тус байгуулна.

4. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дампуурууллагүй, эрх бүхий байгууллагаас үйл ажиллагаа нь зогсоогоогүй, талууд харилцан тохиролцож хэлэлцээрийг цуцлаагүй байхад гадаадын хөрөнгө оруулагч өөрөө санаачлан тогтвортой байдлын гэрээнд заасан хугацаанаас өмнө үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд уг хөрөнгө оруулагчид татварын болон бусад чөлөөлөлт, хөнгөлөлтөөр олгосон хөрөнгийг нөхөн төлүүлнэ."

2/ 20 дугаар зүйл:

"20 дугаар зүйл. Тогтвортой байдлын гэрээ байгуулах

1. Тогтвортой байдлын гэрээ байгуулахыг хүссэн хөрөнгө оруулагч энэ тухай өргөдөл, гэрээний төслийг татварын бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2. Татварын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг өргөдөл, гэрээний төслийг хүлээн авснаас хойш ажлын 14 өдөрт багтаан хянаж, нэмэлт тодруулга хийх шаардлагагүй гэж үзвэл өргөдөл гаргасан этгээдтэй гэрээ байгуулна.

Хэрэв нэмэлт, тодруулга хийх шаардлагатай бол энэ тухай өргөдөл гаргагч этгээдэд ажлын 7 өдрийн дотор мэдэгдэнэ.

3. Тогтвортой байдлын гэрээний тухай мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ."

3/ 3 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

"4."хөрөнгө оруулалтын гэрээ" гэж хуулийн этгээд байгуулахгүйгээр тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан концесс, бүтээгдэхүүн хуваах тухай, маркетинг, менежмент, санхүүгийн түрээс (лизинг)-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлцлийг хэлнэ;

5/"нэг цэгийн үйлчилгээ" гэж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар буртгүүлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, лицензи, гэрчилгээ авах, дугнэлт, үнэлгээ хийлгэх тухай өргөдөл, холбогдох баримт бичгийг нэг дор хүлээн авч, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх иж бүрэн үйлчилгээг."

4/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа дууссан, хөрөнгө оруулагч гэрээгээ цуцалсан, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд гэрээг буртгэлээс хасч гэрчилгээг хүчингүй болсонд тооцно."

5/ 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

" 2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар, хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжүүлэгчид үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль[1], Газлийн тарифын тухай хууль[2], Нэмэгдсэн өртийн албан татварын тухай хууль[3], Онцгой албан татварын хууль[4], Газрын тухай хууль[5]-иар зохицуулна."

6/ 6 дугаар зүйлийн 5, 6 дахь заалт:

"5/ маркетинг, менежментийн гэрээ байгуулах;

6/ санхүүгийн түрээс (лизинг)-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх."

2 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "тогтоомж," гэсний дараа "концесс, бүтээгдэхүүн хуваах"; 16 дугаар зүйлийн 1,2; 17 дугаар зүйлийн 1,2,3,4,5; 18 дугаар зүйлийн 1; 21 дугээр зүйлийн 1, 3, 5, 6; 22 дугаар зүйлийн 1,2,3; 23 дугаар зүйл; 24 дугээр зүйлийн 1,3 дахь хэсэг; 25 дугаар зүйл; 24 дугээр зүйлийн 2 дахь хэсгийн " гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэсний дараа " гадаадын хуулийн этгээдийн салбар" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дор дурдсан зүйл, хэсэг, заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 14 дүгээр зүйл:

"14 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

1. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхтэй:

1/ гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг эдийн засаг, ниигмийг хөгжүүлэх нэгдсэн зорилттой уялдуулан боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2/ гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих;

3/ гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх салбар, чиглэлийн талаар санал боловсруулах.

2. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхтэй:

1/ гадаадын хөрөнгө оруулалтын талаархи бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

2/гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог судлах, гадаад суртачилгааны ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, төслийн тендерт гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах;

3/ гадаадын хөрөнгө оруулагчдад "нэг цэг"-ийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх;

4/ гадаадын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах;

5/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар нэгж, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг хянан шийдвэрлэх;

6/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарын үйл ажиллагаат түр буюу бүрмөсөн зогсоох;

7/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад заасан зарим үйлчилгээг төлбертэй гүйцэтгэнэ."

2/ 15 дугаар зүйл:

"15 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбар, хөрөнгө оруулалтын гэрээг буртгэх

1. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гэрчилгээ авсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарыг Үндэсний татварын ерөнхий газар улсын буртгэлд буртгэнэ.

2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж

[1] "Төрийн мэдээлэл", 1993 он, №1
[2] "Төрийн мэдээлэл", 1996 он, №9
[3] "Төрийн мэдээлэл", 1998 он, №2
[4] "Төрийн мэдээлэл", 1993 он, №2
[5] "Төрийн мэдээлэл", 1995 он, №2

ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарын гэрээ, дүрэмд оруулсан өөрчлөлтийг гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсний дагуу Үндэсний татварын ерөнхий газар бүртгэнэ.

3. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулалтын гэрээг бүртгүүлэх тухай өргөдөл, хөрөнгө оруулалтын гэрээний нотариатаар батлагдсан хуулбарыг үндэслэн бүртгэж, холбогдох гэрчилгээг өргөдөл хүлээн авснаас хойш жилын 10 өдрийн дотор олгоно."

3/ 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгийн 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ."

4/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхээр хөрөнгө оруулагчдаас оруулах зөвхөн хөрөнгө, оюуны үнэт зүйлсийг чөлөөтэй хөрвөх валютаар болон төгрөгөөр үнэлгээний адил зарчим баримтлан хөрөнгө оруулагчид харилцан тохиролцож үнэлнэ. Хэрэв хөрөнгө оруулагч шаардлагатай гэж үзвэл үг үнэлгээг хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий дотоодын болон гадаадын мэргэжлийн байгууллагаар хийлгэж болно."

5/ 6 дугаар зүйлийн 3 дахь заалт:

"3/ гадаадын хөрөнгө оруулагч тус улсын аж ахуйн нэгжийн нөгөл хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авах замаар шууд хөрөнгө оруулалт хийх;"

6/ 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ дараахь орлого, ашиг, төлбөрөө гадаадад саадгүй гүйвуулах:

а/ өөрт нөгдох хувь нийлүүлэгчийн орлого, хувьцааны нөгдол ашиг;

б/ эд хөрөнгө, үнэт цаас борлуулсан, эд хөрөнгийн эрхээ бусдад шилжүүлсэн, хөрөнгө оруулалтын гэрээ дуусгавар болсон болон аж ахуйн нэгж татан буугдсаны дараа өөрт нь ногдох орлого;

в/ үндэсэн өр, хүү болон бусад адилтгах төлбөр;

г/ дайчлан гаргуулсан зд хөрөнгийн нөхөн төлбөр;

д/ хууль тогтоомжийн дагуу олсон бусад орлого"

7/ 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

"2/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах, гадаадын хуулийн этгээдийн салбар нээн ажилуулах тухай гэрээ, дүрэм, хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;"

8/ 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь өгүүлбэр:

"Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна."

4 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газарт" гэсний өмнө "гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага," гэж нэмсүгэй.

5 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн гуравдугаар бүлгийн нэрийг " Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарын үйл ажиллагаа"; 16 дугаар зүйлийн нэрийг "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарын үйл ажиллагаагаа зогсоох"; 17 дугаар зүйлийн нэрийг "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарыг татан буулгах"; 21 дүгээр зүйлийн нэрийг "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарт газар ашиглуулах"; 1 дүгээр зүйлийн "гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдсон" гэснийг "гадаадын хөрөнгө оруулалтын холбогдолтой"; 22 дугаар зүйлийн 3, 25 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгийн "нэгжийн " гэснийг "нэгж" гэж, 18 дугаар зүйлийн 1, 21 дүгээр зүйлийн 1,3,5, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "нэгжид" гэснийг "нэгж" гэж, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "нэгжийг" гэснийг "нэгж" гэж, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын татварын ерөнхий газар" гэснийг "Үндэсний татварын ерөнхий газар"; 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "дүрмийн сан" гэснийг "өөрийн хөрөнгөд"; 24 дүгээр зүйлийн гарчиг; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "хангамжийн" гэснийг "хамгааллын" гэж тус тус өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс "нийгэмчлэх,", 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс "дүрмийн сан"; 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс "Аж ахуйн нэгжийн тухай" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (243)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Эрүүгийн байцаан шийтгэх хууль*
- *Хууль хүчингүй болсонд тооцох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны хоёрдугаар сарын 12 №6 (243)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

77. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002-01-10-ны хууль) 173

78. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-01-10-ны хууль) 256

79. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-01-10-ны хууль) 256

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаат явуулахтай холбогдон үүсэх харилцаат зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад Үндсэн хуулийг[1] удирдлага болгож, энэ хуулийг баримтална.

2.2. Энэ хуулиар тогтоосон журмыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч дагаж биелүүлнэ.

3 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана.

3.2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаат явуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баримтална.

3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлгөт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хууль гадаадын иргэн, харъяалалгүй хүнд үйлчлэх

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харъяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт

[1] *Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа энэ хуульд заасан журмыг баримтална.

4.2. Дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа гадаадын иргэн өөрөө хүссэн, эсхүл зөвшөөрсөн тохиолдолд энэ хуульд заасан журмыг баримтлан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болно.

4.3.Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээдэд холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаар уламжлан хүснэ.

5 дугаар зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. "байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч" гэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийг;

5.1.2. "хэрэг бүртгэх албаны дарга" гэж хэрэг бүртгэлт явуулах байгууллагын газар, хэлтэс, тасгийн дарга, түүний орлогчийг;

5.1.3. "хэрэг бүртгэгч" гэж хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий албан тушаалтныг;

5.1.4. "мөрдөн байцаах албаны дарга" гэж мөрдөн байцаалт явуулах байгууллагын мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга, түүний орлогчийг;

5.1.5. "мөрдөн байцаагч" гэж мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг;

5.1.6."талууд"гэж шүүх хуралдаанд тэгш эрхтэйгээр мэтгэлцэнд оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээдийг;

5.1.7. "яллах тал" гэж прокурорыг;

5.1.8. "өмгөөлөх тал" гэж шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг;

5.1.9. "оролцогч" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогч, түүний төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг;

5.1.10. "бусад оролцогч" гэж гэрч, шинжээч, мэргэжилтэн, хөндлөнгийн гэрч, орчуулагч, хэлмэрч , шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг;

5.1.11. "гэр бүлийн гишүүн" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг;

5.1.12."үр хүүхэд" гэж төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач, зээ, гуч, жичийг;

5.1.13."хууль ёсны төлөөлөгч" гэж хуулийн дагуу тогтоогдсон, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;

5.1.14."төрөл, садангийн хүн" гэж нэг гэр бүлд хамт амьдардагчуй эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач, зээ, гуч, жич, төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

5.1.15. "шүүх" гэж Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг;

5.1.16. "анхан шатны шүүх" гэж эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг;

5.1.17. "давж заалдах шатны шүүх" гэж эрүүгийн хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх аймаг, нийслэлийн шүүхийг;

5.1.18. "хяналтын шатны шүүх" гэж Улсын дээд шүүхийг;

5.1.19. "шүүгч" гэж бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийг;

5.1.20."прокурор" гэж бүх шатны прокурорын газрын прокурорыг;

5.1.21. "цагаатгах тогтоол" гэж шүүгдэгчийн гэм буруугүйг нотолсон шүүхийн шийдвэрийг;

5.1.22. "шийтгэх тогтоол" гэж шүүгдэгчийг гэм буруутайг нотолж, түүнд ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг;

5.1.23. "магадлал" гэж давж заалдах шатны журмаар хэрэгийг хянан шийдвэрлэсэн гаргасан шүүхийн шийдвэрийг;

5.1.24. "тогтоол" гэж Улсын дээд шүүхээс анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг хянаад гаргасан шийдвэр; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос гаргасан яллах дүгнэлтээс

бусад шийдвэр; эрүүгийн хэргийг шийдвэрлэхтэй холбогдуулж гаргасан цагаатгах, шийтгэх тогтоолоос бусад шүүхийн шийдвэрийг;

5.1.25. "шүүгчийн захирамж" гэж эрүүгийн хэргийг шийдвэрлэхтэй холбогдуулж гаргасан цагаатгах, шийтгэх тогтоолоос бусад шүүгч дангаараа гаргасан шийдвэрийг;

5.1.26. "прокурорын дүгнэлт" гэж прокуророос шүүх хуралдаан дээр гаргасан саналыг;

5.1.27."шөнийн цаг" гэж тухайн өдрийн 22 цагаас дараа өдрийн 06 цаг хүртэлх хугацааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчим

6 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт

6.1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино.

7 дугаар зүйл. Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур сэжигтнээр тооцож, яллагдагчаар татаж, ял шийтгэж болохгүй

7.1. Энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур хэнийг ч сэжигтнээр тооцож, яллагдагчаар татаж, ял шийтгэж болохгүй.

8 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хууль ёсны байх

8.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Үндэсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.

8.2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ.

8.3. Шүүх нь Үндэсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэхгүй.

8.4. Шүүх хэрэглэж байгаа хууль нь Үндэсэн хуульд нийцээгүй байна гэж үзвэл тухайн хэргийн байцаан шийтгэх ажиллагааг тудгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал гаргах ба Улсын дээд шүүх нь уг саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндэсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана.

9 дүгээр зүйл. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх

9.1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Хүний халдашгүй байх эрхийг хангах

10.1. Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчилж болохгүй.

10.2. Прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч шинжилгээ хийлгэхээр эмнэлгийн байгууллагад байлгах, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч цагдан хорихыг хориглоно.

10.3. Прокурор нь хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлж байгаа буюу эмнэлгийн байгууллагад байгаа, эсхүл хууль болон шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа этгээдийг нэн даруй суллах үүрэгтэй.

10.4. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.

10.5. Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна.

11 дүгээр зүйл. Иргэний орон байрны халдашгүй байдлыг хангах

11.1. Иргэний орон байр нь халдашгүй байна.

11.2. Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэн ч иргэний орон байранд оршин суугчийн зөвшөөрөлгүй нэвтрэн орох эрхгүй.

11.3. Орон байранд хийх нэгжлэгийг прокурорын зөвшөөрлөөр энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хамгаалах

12.1. Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд

заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.

13 дугаар зүйл. Гэм буруугүйд тооцох

13.1. Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.

13.2. Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль[2] болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

14.1. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

15 дугаар зүйл. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах

15.1. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

15.2. Албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

16 дугаар зүйл. Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох

16.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг ялаах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй.

16.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардах эрхгүй.

16.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно.

16.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдээс нь түүний эсрэг мэдүүлэг өгөхийг шаардахыг хориглоно.

16.5. Энэ хуулийн 16.4-т заасан этгээд өөрөө мэдүүлэг өгөх хүсэлт гаргавал түүнд мэдүүлэг өгөхээс татгалзах эрхтэйг нь тайлбарласны эцэст Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийг сануулан мэдүүлэг авна.

17 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагаат талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах

17.1. Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана.

17.2. Шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээнэ.

17.3. Өмгөөлөгч нь шүүгдэгчийг өмгөөлөхийн тулд хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ.

17.4. Талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна.

18 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн өмгөөлүүлэх эрхийг хангах

18.1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй.

18.2. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүрэгтэй.

19 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэл, бичиг

19.1. Байцаан шийтгэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна.

19.2. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх бүюу мэдэх хэл, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдана.

[2] *Монгол Улсын Эрүүгийн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.*

20 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах эрх

20.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт эн хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үндэслэл

21 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа заавал явуулах

21.1. Гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд гэмт хэрэг гарсан байдал, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд хууль заасан бүхий л арга хэмжээ авах үүрэгтэй.

21.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь байцаан шийтгэх ажиллагааны бүрэн эрхээ аль нэг байгууллага, албан тушаалтнаас харааг бусаар, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх

22.1. Эрүүгийн хэргийг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах, шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг илрүүлж, түүнийг арилгуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

23 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох иргэний эрх

23.1. Хохирогч нас барсан буюу насанд хүрээгүй, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл зоригоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь энэ хуульд заасан журмын дагуу байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхтэй.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан этгээд нь байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед гаргасан гомдлоосоо татгалзах эрхтэй.

24 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдлууд

24.1. Дор дурдсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхгүй бөгөөд хэрэв үүсгэсэн бол прокурор, шүүгч хэргийг энэ хуульд заасны дагуу хэрэгсэхгүй болгоно:

24.1.1.гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй;

24.1.2. хөөн хэлэлцэх хугацаа дууссан;

24.1.3. гэмт хэрэгт холбогдсон этгээд нас барсан /нас барсан хүнийг цагаатгах эсхүл бусад хүмүүст холбогдох нөхцөл байдал шинээр илэрснээс уг хэргийг сэргээн хэлэлцэх явдал үүнд хамаарахгүй/;

24.1.4. тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа.

24.2. Эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад энэ хуулийн 24.1.1-д заасан нөхцөл байдал илэрвэл шүүх шүүн таслах ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана.

24.3. Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр хэрэг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, түүний өмгөөлөгч, энэ хуулийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэг хэрэгсэхгүй болгосныг яллагдагчийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах ба шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ердийн журмаар явуулж, гэмт хэрэгт холбогдсон этгээд гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэнэ.

24.4. Энэ хуулийн 24.1-д заасны дагуу эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай хохирогчид мэдэгдэх ба хохирогч уг шийдвэрийн талаар энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

25 дугаар зүйл. Хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрснээр хэргийг хэрэгсэхгүй болгох

25.1. Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагаас, эсхүл бусад шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй ба энэ тохиолдолд хэргийг шүүхэд шилжүүлж шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах төрийн байгууллага, албан тушаалтан

26 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт явуулах айгууллага

26.1. Дараахь байгууллага, албан ушаалтан дор дурдсан хөнгөн, хүндэвтэр хэрэгт эрэг бүртгэлт явуулна:

26.1.1. хилийн тагнуулын лба -Эрүүгийн хуулийн 89/Хууль бусаар Монгол лсын хил нэвтрэх/, 90/Улсын хилийн дэглэм өрчих/, 175/Эд зүйлийг хууль бусаар хил эвтрүүлэх/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт;

26.1.2. цагдаагийн айгууллага -энэ хуулийн 26.1.1-д зааснаас бусад өнгөн, хүндэвтэр хэрэгт харьяалал аргалзахгүйгээр.

26.2.Монгол Улсын хилийн гадна байгаа тус лсын төрийн далбаа мандуулсан усан онгоцны хмад, агаарын хөлгийн багийн дарга тухайн усан нгоц, агаарын хөлөг аялж яваа үед, түүнчлэн Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат өлөөлөгчийн газрын эзэмшил нутагт гарсан гэмт эрэгт тухайн газрын консулын асуудал эрхэлсэн жилтан энэ хуулийн 172 дугаар зүйлд заасан ойшлуулшгүй ажиллагааг явуулна.

27 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах айгууллага

27.1.Тагнуулын ерөнхий газрын мөрдөн айцаагч:

-Эрүүгийн хуулийн 79/Эх орноосоо урвах/, 80/Тагнуул хийх/, 81/Төр, нийгмийн зүтгэлтэний амь биед халдах/, 82/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах/, 83/Зэвсэгт үймээн дэгдээх/, 84/Хорлон сүйтгэх/, 85/Хорлон саатуулах/, 86/Үндэсний эв нэгдлийг бусниулах/, 87/Төрийн нууц задруулах/, 88/Төрийн нууц мэдээ, баримт бичиг, биет зүйлийг үрэгдүүлэх/, 89/Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх/, 133/Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих/, 175/Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/, 224.2/Олон улсын нислэгийн журам зөрчих/, 297/Зэвсэгт мөргөлдөөн гаргах/, 300/Үй олноор нь хөнөөх зэвсэг бүтээх, олж авах, тараах/, 301/Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох, 302/Төрлөөр устгах/, 303., 303.2/ Хөлсний цэрэг ашиглах/;

- Тагнуулын ерөнхий газрын ажилтны хийж байгаа гүйцэтгэх ажилтай холбогдсон -Эрүүгийн хуулийн 263/Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264/Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

27.2. Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

27.3. Мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч нь энэ хуулийн 27.1-д зааснаас бусад хүнд, онц хүнд хэрэгт болон Эрүүгийн хуулийн 92/Эх нь нярай хүүхдээ алах/, 93/Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах/, 94/ Бусдыг болгоомжгүй алах/, 101/Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах/, 102/Хүний цус, эд, эрхтэнг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах/, 106.2/Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх/, 124.2, 124.3/Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах/, 145.2/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 148.2/Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх/, 149.2/Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх/, 150.2/Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх/, 154.2/Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах/, 156.1, 156.2/Банкны тухай хууль тогтоомж зөрчих/, 157/Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу хэтрүүлж оролцох/, 158/Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчих/, 159/Аудитийн тухай хууль тогтоомж зөрчих/, 161.1/Хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх/, 163.1, 163.2/Хууль бусаар олж авсан эд хөрөнгө, мөнгийг ашиглах-угаах/, 164/Санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулах/, 165.2/Санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах/, 169.2/ Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх/, 171.2/ Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах/, 172.2/Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах/, 175.2/Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/, 176.1/ Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 185.1, 185.2/Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар олж авах, хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх/, 188.1/Хар тамхи,

мансууруулах буюу хордуулах бодис, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/, 196.1/ Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах/, 197.2/Хууль бусаар эмчлэх/, 198.2/Хууль бусаар эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх/, 205/Байгаль орчныг бохирдуулах/, 217.2/Төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих/, 225.1/ Агаарын хөлөг авч зугтаах/, 226/Компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх/, 229/Нянтай программ зохион бүтээх, ашиглах, тараах/, 243/Мөрийтэй тоглох/, 263/Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264/Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265/Төрийн бус байгуулагад, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266/Төрийн бус байгуулагад, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 268.1/Хэвэл хахууль авах/, 272.2/Албан тушаалтан албан тушаалдаа хайгча хандах/, 273.2/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 294.1/ Эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэх, хэрэгжүүлэхгүй байх/, 295.1/Албандаа хайгча хандах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна.

28 дугаар зүйл. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч

28.1. Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хэрэг бүртгэгч, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулж, анх хэргийг шалгаж эхэлсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч түүнийг шалгаж дуусгах үүрэг хүлээнэ.

28.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

28.2.1. эрүүгийн хэрэг үүсгэх;

28.2.2. эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох саналаа прокурорт гаргах;

28.2.3 хэргийн газарт үзлэг хийх, зураглал үйлдэх, дууны болон дүрс бичлэг хийх;

28.2.4.сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаар тогтоох, шинжээч томилох, хөндлөнгийн гэрчээр оролцуулах;

28.2.5. энэ хуулийн 62.1.1-62.1.4-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг авах;

28.2.6. баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах, түүнийг өөрчлөх саналыг прокурорт тавих;

28.2.7. энэ хуулийн 72 дугаар зүйлд заасан албадлагын бусад арга хэмжээ авах;

28.2.8. эд мөрийн баримт болон бусад нотлох баримт цуглуулах, энэ хуулийн 28.2.4-т заасан болон хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл өгч болох бусад этгээдийг байцаах, нүүрэлдүүлэх байцаах, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх;

28.2.9. эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах;

28.2.10. үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө битүүмжлэх буюу хамгаалах арга хэмжээ авах;

28.2.11. энэ хуулийн заалтыг ягштал баримтлан яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах замаар хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шаардлагатай бүх арга хэмжээ авах;

28.2.12. прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүх асуудлыг бие даан шийдвэрлэж, гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох эцсийн хариуцлага хүлээх;

28.2.13. энэ хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд прокуророос өгсөн даалгаврыг заавал биелүүлэх, эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт тайлбар гаргах;

28.2.14. гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд зайлшгүй хийвэл зохих гүйцэтгэх ажлыг эрх бүхий байгууллагад даалгавар бичиж гүйцэтгүүлэх;

28.2.15. өөр орон нутагт байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, түүнчлэн гүйцэтгэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ тухай даалгаврыг бичгээр гаргах ба түүнийг хүлээн авсан хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулах байгууллага заасан хугацаанд заавал биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар хүргүүлэх.

28.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас тодорхой хэргийг шалгах явцад энэ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гаргасан тогтоолыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.

29 дүгээр зүйл. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ

29.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны

арга гэмт хэргийг шалгах үед дор дурдсан эрх дэлнэ:

29.1.1 хэрэг бүртгэлт, мөрдөн айцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон эргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэрэг, үүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар уурхай зохицуулалт хийх;

29.1.2. хэрэг бүртгэх, мөрдөн айцаалт явуулах үүргийг нэг буюу хэд хэдэн хэрэг үртгэгч, мөрдөн байцаагчид даалгах;

29.1.3. хэргийг нэг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас нөгөө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид шилжүүлэх;

29.1.4. шаардлагатай гэж үзвэл эргийн материалтай биечлэн танилцах, байцаан лийтгэх тодорхой ажиллагаанд оролцох, хэрэг үртгэгч, мөрдөн байцаагчид бичгээр үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

29.1.5. шаардлагатай тохиолдолд эрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг биечлэн явуулж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн эрх эдлэх.

30 дугаар зүйл. Прокурор

30.1. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн эрэгжиж байгаад хянаалт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцоно.

30.2. Прокурор байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо энэ хуулийн 193, 195 дугаар зүйлд заасан болон хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

31 дүгээр зүйл. Шүүх

31.1. Эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагааг гагцхүү Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

32 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн

32.1.Хэрэг бүртгэлт явуулсан хэргийг шүүгч даангаар, мөрдөн байцаалт явуулсан хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр анхан шатны журмаар сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шийдвэрлэнэ.

32.2. Хэрэг эдэрээ төвөгтэйн улмаас шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх шаардлагатай гэж үзвэл шүүгч энэ тухай саналаа гаргаж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүх бүрэлдэхүүнийг томилж болно.

32.3. Аймаг, нийслэлийн шүүх давж заалдах шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

32.4. Улсын дээд шүүх нь хуулиар харьяалуулсан тохиолдолд хэргийг анхан шатны журмаар, анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй хэргийг талуудын гомдлоор хянаалтын журмаар 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр тус тус хянан шийдвэрлэнэ.

32.5. Хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүх хэргийг нийт шүүгчдийн дийлэнх олонхийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

32.6. Эрүүгийн анхан шатны, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч, эсхүл түүний томилсон шүүгч даргална.

33 дугаар зүйл Шүүхийн бүрэн эрх

33.1. Шүүх нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1. шүүгдэгчийн гэм бурууг тогтоож, түүнд ял оногдуулах;

33.1.2.шүүгдэгч гэм буруутай нь тогтоогдохгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгох, цагаатгах;

33.1.3. сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгчид баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах;

33.1.4. эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэх.

34 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг

34.1. Иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих, нотлох баримтыг судалж үнэлсний үндэсэн дээр шүүгдэгчийн гэм бууруу, түүнд оногдуулах ялын талаар саналаа бичгээр гаргах эрхтэй.

34.2. Шүүх анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд хүнд, онц хүнд гэмт хэрэгт 3, энэ хуулийн 32.2-т заасны дагуу хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд 2, бусад хэрэгт 1 иргэдийн төлөөлөгчийг тус тус оролцуулна.

34.3. Иргэдийн төлөөлөгчид санал зөрсөн тохиолдолд саналаа тус тусдаа гаргаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Өөрийн болон төлөөлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалж байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч

35 дугаар зүйл. Сэжигтэн

35.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан эрүүгийн сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана:

35.1.1. уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;

35.1.2. гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан;

35.1.3. уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэрэгийн үл мөр тодорхой илэрч олдсон;

35.1.4. уг этгээд хэргээ илчлэн ирсэн;

35.1.5. гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

35.2. Сэжигтэн нь дор дурдсан эрх эдэлнэ :

35.2.1. ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх;

35.2.2. өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах;

35.2.3. баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;

35.2.4. мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;

35.2.5. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

35.2.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

35.2.7. өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч авах;

35.2.8.өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах;

35.2.9. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох;

35.2.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

35.2.11. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх.

35.3.Сэжигтэн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүйгээ болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.

35.4.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэргэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ.

36 дугаар зүйл. Яллагдагч

36.1. Энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж ял сонсгосон этгээдийг яллагдагч гэнэ.

36.2. Шүүхэд шилжсэн яллагдагчийн шүүгдэгч, шүүгдэгчийн хувьд шийтгэх тогтоол гарсан бол ялтан гэж тус тус нэрлэнэ.

36.3. Яллагдагч нь дор дурдсан эрх эдэлнэ:

36.3.1. ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх;

36.3.2. яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах;

36.3.3. өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч авах;

36.3.4. өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах;

36.3.5. сонсгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргах;

36.3.6. мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;

36.3.7. баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;

36.3.8. өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах;

36.3.9.шүүх хуралдаанд оролцох;

36.3.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч,

шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

36.3.11. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагааны гомдол гаргах;

36.3.12. шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах;

36.3.13. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

36.3.14. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр өөрийн болон өмгөөлөгч, төлөөлөгчийнхөө хүсэлтээр хийлгэж байгаа байцаан шийтгэх тодорхой ажиллагааны оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай хүсэлт гаргах;

36.3.15. шүүх хуралдааны эцсийн үг хэлэх;

36.3.16. шүүхийн шийдвэрт гомдол гаргах;

36.3.17. бусад эрхээ шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар өгөх;

36.3.18. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх.

36.4. Яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн гэм бурууг үгүйсгэх болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.

36.5. Яллагдагч нь дараахь үүрэг хүлээнэ:

36.5.1. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт хүрэлцэн ирэх;

36.5.2. биед үзлэг хийх, шинжилгээ хийхээр эмнэлгийн байгууллагад шилжүүлэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол болон байцаан шийтгэх ажиллагааны явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан бусад шийдвэрийг биелүүлэхэд саад хийхгүй байх;

36.5.3. шүүх хуралдааны дэгийг сахих.

37 дугаар зүйл. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч

37.1. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.

37.2. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч байцаан шийтгэх ажиллагаанд энэ хуулийн 364-377 дугаар зүйлд заасан журмын дагуу оролцоно.

38 дугаар зүйл. Өмгөөлөгч

38.1. Хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдийг өмгөөлөгч гэнэ.

38.2. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно.

38.3. Гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй.

38.4. Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй.

39 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг сонгон авах, солих

39.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно.

39.2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авч болно.

39.3.Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно.

39.4.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон авааг үл түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй.

39.5. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол өөр өмгөөлөгч сонгон авна.

40 дүгээр зүйл. Өмгөөлөгчийг заавал оролцуулах

40.1. Дор дурдсан сэжигтэн,

яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд оролцуулна:

40.1.1. хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;

40.1.2. насанд хүрээгүй;

40.1.3. монгол хэл мэддэггүй;

40.1.4. цаазаар авах ялаар шийтгэгдэж болох;

40.1.5. хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч.

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон авааруй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй.

41 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг

41.1. Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

41.2. Хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн үүргээс татгалзах, хууль бусаар нотлох баримт цуглуулах эрхгүй.

41.3. Өмгөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:

41.3.1. хэрэгт оролцох үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчтой ганцаарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, асуулт тавих;

41.3.2. энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулан хавтаст хэрэгт тусгуулах;

41.3.3. хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих;

41.3.4. өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад этгээдэд аль ч үе, асуулт тавих;

41.3.5. өөрийн байлцсан байцаа шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж засвар оруулах тухай саналаа бичгээр гаргах;

41.3.6. өөрсдийнх нь зөвшөөрснөө иргэн, хуулийн этгээдээс тайлбар, баримт бичиг тодорхойлолт гаргуулж авах;

41.3.7. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шүүгч иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

41.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах;

41.3.9. шүүх хуралдаанд оролцох;

41.3.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа шийдвэрт гомдол гаргах;

41.3.11. өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхэд шийдвэрлэхэд хүсэлтээрээ байлцаж, шүүхэд санал гаргах;

41.3.12. давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хүсэлтээрээ оролцох.

42 дугаар зүйл. Хохирогч

42.1. Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ.

42.2. Иргэн, хуулийн этгээдийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

42.3. Хохирогч, түүний төлөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:

42.3.1. өмгөөлөгч авах /энэ заалт нь төлөөлөгч өмгөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй/;

42.3.2. баримт сэлт гаргаж өгөх;

42.3.3. нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;

42.3.4. шүүх хуралдаанд оролцох;

42.3.5. шүүгдэгч, гэрч, шинжээчид

суулт тавих;

42.3.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

42.3.7. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

42.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах;

42.3.9. гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

42.3.10. цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах;

42.3.11. бусад эрүгэндээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж гайлбар гаргах;

42.3.12. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах.

42.4. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол энэ зүйлд заасан эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүн эдэлнэ.

42.5. Хохирогч нь дараахь үүрэг хүлээнэ :

42.5.1. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудсанаар ирэх;

42.5.2. хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;

42.5.3. өөрт илэрхий болсон хэргийн талаархи баримт сэлтийг задруулахгүй байх;

42.5.4. шүүх хуралдаан болон байцаан шийтгэх ажиллагааны жүрмыг сахих.

42.6. Хохирогч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

43 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэгч

43.1. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.

43.2. Иргэний нэхэмжлэгчийг тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

43.3. Иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгчнь дараахь эрх эдэлнэ:

43.3.1. хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт гаргаж өгөх;

43.3.2. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд өөрийн нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авахыг хүсэх;

43.3.3. шүүх хуралдаанд оролцох;

43.3.4. гаргасан нэхэмжлэлээ дэмжих, татгалзах;

43.3.5. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах;

43.3.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

43.3.7. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

43.3.8. шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.

43.4. Иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлтэй холбогдсон өөрт байгаа баримт сэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шаардсанаар гаргаж өгөх үүрэгтэй.

44 дүгээр зүйл. Иргэний хариуцагч

44.1. Иргэний хариуцагчаар насанд хүрээгүй ялпагдагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг хууль ёсоор хариуцвал зохих хуулийн этгээдийг татан оролцуулж болно.

44.2. Иргэний хариуцагчаар татах тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

44.3. Иргэний хариуцагч, түүний төлөөлөгчнь дараахь эрх эдэлнэ:

44.3.1. нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй байх;

44.3.2. нэхэмжлэлийн талаар тайлбар өгөх;

44.3.3. баримт сэлт, хүсэлт гаргах;

44.3.4. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусан үед хэргийн иргэний

нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах;

44.3.5. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, ирэгдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

44.3.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа шийдвэрт гомдол гаргах;

44.3.7. шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогч

45 дугаар зүйл. Гэрч

45.1. Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тухайн хэрэгт холбогдолгүй хүнийг гэрч гэнэ.

45.2. Гэрчийг энэ хуулийн 143 дугаар зүйлд заасан журмаар дуудаж байцаана.

45.3. Дараахь хүмүүсийг гэрчээр байцааж болохгүй:

45.3.1. тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч;

45.3.2. өмгөөлөх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгч;

45.3.3. өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон.

45.4. Гэрч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

45.5. Гэрч нь дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр цагдаагийн байгууллага албадан ирүүлнэ.

45.6. Гэрч санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45.7. Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.

46 дугаар зүйл. Шинжээч

46.1. Шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулахын тулд зохих байгууллагын шинжээч, тусгай мэдлэг бүхий, тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээдийг шинжээчээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоолоор, шүүгч захирамжаар томилно.

46.2 Шинжээч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж, тавигдсан асуултын дагуу дүгнэлт гаргана.

46.3 Шинжээч нь тавигдсан асуулт түүний тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн буюу ирүүлсэн баримт сэлт нь дүгнэлт гаргахад дутагдалтай байвал дүгнэлт гаргах боломжгүй тухайгаа шинжилгээ хийлгэхээр даалгасан байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

46.4. Шинжээч нь дараахь эрх эдэлнэ:

46.4.1. хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй нь танилцах;

46.4.2. дүгнэлт гаргахад хэрэгцүэтэй нэмэгдэл баримт сэлт ирүүлэхийг хүсэх;

46.4.3. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн зөвшөөрөлтэйгээр хүмүүсийг байцаахад бө мөрдөн байцаалт, шүүхийн бусад ажиллагаа явуулахад байлцах, байцаагдаж байгаа хүмүүст шинжилгээтэй холбогдох асуулт тавих.

46.5. Шинжээч нь дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр цагдаагийн байгууллага албадан ирүүлнэ.

46.6. Шинжээч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дүгнэлт гаргахаас татгалзах буюу зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

47 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч

47.1. Энэ хуулийн 19.2-т заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч,

прокурор, шүүх нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилох тухай шийдвэр гаргаж уг этгээдэд танилцуулна.

47.2. Орчуулагч, хэлмэрч нь дуудсан цагт ирж орчуулах, хэлмэрчлүүлэхээр даалгасан үүргийг бүрэн, зөв биелүүлэх үүрэгтэй.

47.3. Орчуулагч, хэлмэрч санаатайгаар худал орчуулсан, хэлмэрчилсэн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

47.4. Энэ зүйлд заасан журам нь хэлгүй, дүлий хүний дохиог мэддэг хэлмэрчид нэг адил хамаарна.

48 дугаар зүйл. Хөндлөнгийн гэрч

48.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр байцаан шийтгэх тодорхой ажиллагааны явц, үр дүнг баталгаажуулахаар тухайн ажиллагаанд оролцсон иргэнийг хөндлөнгийн гэрч гэнэ.

48.2. Хөндлөнгийн гэрч нь тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээд байна.

48.3. Хөндлөнгийн гэрч нь өөрийнхөө оролцсон байцаан шийтгэх ажиллагааны талаар гомдол гаргах, байцаан шийтгэх ажиллагаанд тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай санал гаргах эрхтэй.

48.4. Хөндлөнгийн гэрч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирэх, байцаан шийтгэх ажиллагааны жүрмыг сахиж, нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэлүүд, таттагдан гаргах

49 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл

49.1. Шүүгч эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараахь үндэслэл байвал оролцож болохгүй:

49.1.1. гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчийн хувиар хэрэгт оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;

49.1.2. хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч буюу тэдний төлөөлөгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл шүүгдэгчийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн төрөл, садан, түүнчлэн улсын яллагч, өмгөөлөгч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн төрөл, садан байвал;

49.1.3. тухайн хэрэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, хөндлөнгийн гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол;

49.1.4. өөрөө шууд буюу шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

49.2. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх байгаа шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой шүүгч оролцож болохгүй.

49.3. Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн уг хэргийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орж болохгүй.

50 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

50.1. Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх, түүнчлэн түүний оролцоотойгоор хэргийг хэрэгсэхгүй болгохоор гарсан шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бол анхан шатны журмаар дахин хэрэг хэлэлцэхэд оролцож болохгүй.

50.2. Давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны болон хяналтын журмаар хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гаргасан магадлалыг хүчингүй болгосон бол давж заалдах шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.

50.3. Хяналтын журмаар хэрэг хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гаргасан тогтоолыг хүчингүй болгосон бол хяналтын шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.

50.4. Энэ хуулийн 50.2, 50.3 нь Улсын дээд шүүхийн шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанд оролцоход хамаарахгүй.

51 дүгээр зүйл. Шүүгчийг татгалзан гаргах

51.1. Энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд заасан үндэслэл байвал шүүгч өөрөө татгалзан гарах үүрэгтэй ба энэхүү үндэслэлээр улсын яллагч, өмгөөлөгч, шүүгдэгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болно.

51.2. Татгалзан гаргах асуудлыг шүүхийн хэлэлцүүлэг эхлэхээс өмнө шийдвэрлэх боловч шүүхийн хэлэлцүүлэг эхэлснээс хойш татгалзан гаргах үндэслэл мэдэгдвэл уг хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохын өмнө гаргаж болно.

52 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх журам

52.1. Шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг тухайн шүүгчийг байцлуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх боловч татгалзагдаж байгаа шүүгч нь бусад шүүгчид уг асуудлын талаар шүүх хуралдааны танхимд тайлбар гаргах эрхтэй.

52.2. Татгалзан гаргах тухай хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзагдсанд тооцно.

52.3. Шүүх бүрэлдэхүүний олонхийг татгалзсан хүсэлт нь үндэслэлтэй гэж үзвэл уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

52.4. Хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзвал шүүгч шүүх хуралдааныг хойшлуулж, уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

52.5. Энэ хуулийн 52.2 – 52.4-т заасан үндэслэлээр гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй.

53 дугаар зүйл. Прокурорыг татгалзан гаргах

53.1. Энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал прокурор байцаан шийтгэх ажиллагааны оролцож болохгүй.

53.2. Татгалзан гарах үндэслэл байвал байцаан шийтгэх ажиллагаанд оролцохоос прокурор өөрөө татгалзан гарах үүрэгтэй ба энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч прокурорыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болно.

53.3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад прокурорыг татгалзан гаргах тухай хүсэлт гарвал дээд шатны прокурор, шүүх хуралдааны үед татгалзан гаргах тухай хүсэлт гарвал хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

53.4. Энэ хуулийн 53.3-т заасны дагуу гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй.

54 дүгээр зүйл. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг татгалзан гаргах

54.1. Энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны оролцож болохгүй.

54.2. Татгалзан гарах үндэслэл байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч өөрөө татгалзан гарах үүрэгтэй ба энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болно.

54.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг прокурор шийдвэрлэх бөгөөд энэ нь эцсийн шийдвэр байна.

55 дугаар зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах

55.1. Энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд дурдсан журам шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэг адил хамаарах боловч тухайн шүүх хуралдаанд урьд нь нарийн бичгийн даргаар оролцож байсан явдал нь түүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.

55.2. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх ба энэ шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй.

56 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах

56.1. Энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэл, түүнчлэн орчуулга хийж, хэлмэрчилж болохгүй бусад байдал илэрвэл орчуулагч, хэлмэрч байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохгүй.

56.2. Энэ хуулийн 56.1-д заасан ндэслэлээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, рокурор, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний эхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч рчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах тухай үсэлт гаргаж болно.

56.3. Тухайн хэрэгт урьд нь орчуулагч, элмэрчээр ролцож байсан явдал татгалзан гаргах ндэслэл болохгүй.

56.4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, харин шүүх хуралдаан дээр татгалзан аргах тухай хүсэлт гаргасан бол шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх ба тэдгээрийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй.

57 дугаар зүйл. Шинжээчээр оролцож болохгүй байдал

57.1. Шинжээч дор дурдсан тохиолдолд байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохгүй:

57.1.1. энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал;

57.1.2. шинжээч нь албан тушаалын болон бусад талаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрхшээлд байгаа бол;

57.1.3. шинжээчээс энэ хэргийн талаар хийсэн шалгалтын материал нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болсон бол.

57.2. Дахин шинжилгээ хийлгэхэд урьд нь дүгнэлт гаргасан шинжээч оролцож болохгүй.

57.3. Шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг энэ хуулийн 56.4-т заасан журмаар шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР ХЭСЭГ
БАЙЦААН ШИЙТГЭХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

НАЙМДУГААР БҮЛЭГ
Сэжигтнийг баривчлах

58 дугаар зүйл. Сэжигтнийг баривчлах үндэслэл

58.1. Сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх ангалттай баримт байгаа бол түүнийг баривчилна.

59 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчлах журам

59.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна.

59.2. Тогтоолд баривчилсан үндэслэл, шалтгаан, газар, хугацаа /цаг, минут заасан/, биед нь хийсэн үзлэгийн үр дүн, түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хугацаат тусгана.

59.3. Тогтоолыг сэжигтэнд танилцуулах ба түүнд энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, түүний дотор өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг нь тайлбарлаж өгөх ба энэ тухай тэмдэглэлд тусгана.

59.4. Тэмдэглэлд түүнийг хөтөлсөн болон баривчлагдсан этгээд гарын үсэг зурна.

59.5. Хойшлуулшгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ.

59.6. Шүүх тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор баривчлагдаж байгаа этгээдийг цагдан хорих эсвэл өөрөл буюу суллах үүрэгтэй.

59.7. Баривчлагдсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцно.

59.8. Баривчилсан хугацааг сэжигтэнд тогтоол танилцуулсан үеэс эхлэн тоолно.

60 дугаар зүйл. Сэжигтнийг суллах

60.1. Дор дурдсан тохиолдолд шүүгч захирамж гарган сэжигтнийг суллана:

60.1.1. гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй;

60.1.2. баривчлагдсан этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлгүй бол;

60.1.3. энэ хуулийн 58 дугаар зүйлийг зөрчиж баривчилсан.

60.2. Баривчилснаас хойш 72 цаг дуусч, тухайн этгээдийг цагдан хорих шүүгчийн шийдвэр

ирэгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид мэдэгдэж, баривчлах байрны дарга түүнийг суллана.

60.3. Сэжигтнийг суллахдаа түүнийг ямар үндэслэлээр, хэзээ, хаана, хэний шийдвэрээр баривчилсан, хэзээ, хэний шийдвэрээр сулласан тухай магадлагаа олгоно.

61 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх

61.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгаа 2 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэ гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчи нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжий баривчлагдсан эгээдэд олгоно.

61.2. Баривчлагдсан этгээд нь гадаа улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д зааса хугацааны дотор гадаад харилцааны асууда эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчий газарт мэдэгдэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
Таслан сэргийлэх арга хэмжээ

62 дугаар зүйл.Таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл

62.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтоохоо саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол түүнд дараахь таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгийг нь авч болно:

62.1.1. оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах;

62.1.2. батлан даалтад өгөх;

62.1.3. эд хөрөнгө барьцаалах;

62.1.4. цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх;

62.1.5. цагдан хорих.

62.2. Таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүгч авна.

63 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ авахад анхаарвал зохих байдлууд

63.1. Таслан сэргийлэх ямар арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх гэмт хэргийн ангилал, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдал, түүний эрхэлсэн ажил, албан тушаал, нас, эрүүл мэнд, гэр бүлийн болон бусад байдлыг харгалзана.

64 дүгээр зүйл. Гадагш явж болохгүй тухай баталгаа авах

64.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс байнга буюу түр оршин суугаа газраасаа хэрэ бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхий зөвшөөрөлгүйгээр гадагш явахгүй ба дуудсан цаг ирэх тухай баталгаат бичгээр гаргуулж авна.

65 дугаар зүйл. Батлан даалт

65.1. Батлан даалт гэж байнг оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмө эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчий үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэ иргэнээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг төлө томоотой байлгах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүхийн дуудсан цагт ирүүлж байхы хариуцаж, бичгээр үүрэг авахыг хэлнэ.

65.2. Батлан даагч нь хоёрос доошгүй байна.

65.3. Ямар хэргийн учир таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, сэжигтэн яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлбал хүлээлгэх хариуцлагын тухай батлан даагчид мэдэгдэнэ.

65.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлбал батлан даагчид энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан торгууль оногдуулж, оргосон этгээдийг эрэн сурвалжлахад гарсан бүх зардлы нөхөн төлүүлнэ.

65.5. Торгууль оногдуулах, эрэн сурвалжилсны зардал төлүүлэх талаар шүүгч захирамж, шүүх тогтоол гаргана.

66 дугаар зүйл. Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх

66.1. Гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа буюу яллагдаж байгаа цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх гэдэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг төлөв

эмоотой байлгах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт ирүүлж байх алдар цэргийн анги байгууллагын удирдлагаас нь үрэг хүлээхийг хэлнэ.

66.2. Ямар хэргийн үчир таслан сэргийлэх нь арга хэмжээ авагдсан болохыг цэргийн ангийн дирдлагад мэдэгдэнэ.

67 дугаар зүйл. Эд хөрөнгө барьцаалах

67.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт саадгүй ирж байхыг эжигтэн , яллагдагч, шүүгдэгч өөрөө баталж, эсүүл үүнийг ирүүлж байх үүргийг бусад хүн, байгууллага үүлээж мөнгө, бусад үнэ бүхий зүйлийг тусгай дансанд шилжүүлэх буюу бэлнээр өгөхийг эд өрөнгө барьцаалах гэнэ.

67.2. Эд хөрөнгө барьцаалсан тухай баримт йлдэж, хуулбарыг барьцаа өгөгчид болон таслан эргийлэх арга хэмжээ авагдаж байгаа эгээдэд ардуулна.

67.3. Барьцаааны хэмжээг гэмт хэргийн нгилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үвийн болон эд хөрөнгийн байдлыг харгалзан оогооно.

67.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь эрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй айлсхийвэл барьцаалсан эд хөрөнгийг шүүгчийн ахирамжаар улсын орлого болгоно.

68 дугаар зүйл. Цагдан хорих

68.1. Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт эрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтоохоос саад учрулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно.

68.2. Дараахь нөхцөл байдал байвал хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж болно:

68.2.1. өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн;

68.2.2. хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсүүл оргон зайлсан.

68.3. Цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна.

68.4. Энэ хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан журмын дагуу баривчлагдсан сэжигтнийг цагдан хорих бол тогтоолыг баривчлах хугацаа дуусахаас 6 цагийн өмнө шүүхэд хүргүүлсэн байна.

68.5. Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн, яллагдагчийг дахин цагдан хорих саналыг зөвхөн цагдан хорих шинэ үндэслэл, шалтгаан бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ.

68.6. Шүүгдэгчийг цагдан хорих үндэслэл байвал шүүх үүрэг хэмжээг хэрэглэж болно.

68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон эгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, саданги хүн, эсүүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ.

68.8. Энэ хуулийн 68.2-т заасан үндэслэлийн аль нэг нь байвал жирэмсэн эмэгтэйг эмнэлгийн байгууллагын хяналтан дор цагдан хорьж болно.

68.9. Хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй этгээд, жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй этгээд, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд энэ хуулийн 68.2-т заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хориглоно.

69 дүгээр зүйл. Цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журам

69.1. Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хүртэл хоног байна.

69.2. Яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар хүртэл байна.

69.3. Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хэргийн төвөгтэй байдлыг харгалзан цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх уг хугацааг сунгах боловч хорьж мөрдөх хугацаа 24 сараас хэтэрч болохгүй.

69.4. Эрүүгийн хуулийн 81.2/Тер, ниймийн зүтгэлтний эмь биед халдах/, 84 /Хорлон сүйтгэх/, 91.2/Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 177.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах/, 302/Төрөөр устгах/ дугаар зүйлд заасан хэргийн яллагдагчийг энэ хуулийн 69.3-т зааснаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл

хугацаагаар нэмж сунгаж болно.

69.5. Мөрдөн байцаагч хорьж мөрдөх хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ.

69.6. Шүүгч цагдан хорих хугацааг сунгах тухай саналыг 72 цагийн дотор хянаж тогтоолыг батлах буюу татгалзана.

69.7. Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

69.8. Шүүхээс нэмж мөрдөн байцаалгахаар буцаасан хэрэгийн яллагдагчийг цаашид хорьж мөрдөх хугацааг энэ хуулийн 69.2-т заасан хугацаанд оруулж тооцно.

69.9. Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх шатанд яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа дуусвал тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаагаар захирамж гарган сунгаж болно.

70 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох, өөрчлөх

70.1. Гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзаж үрьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох буюу чангатгаж, хөнгөрүүлж болно.

70.2. Таслан сэргийлэх арга хэмжээ хүчингүй болгох, өөрчлөх асуудлыг хэрэг бүртгэх мөрдөн байцаагчийн саналыг харгалзан зөвхөн шийдвэрийг гаргасан буюу түүний үйл ажиллагаа хянаалт тавих эрх бүхий дээд шатны прокурорт тогтоолоор, эсхүл шүүгчийн батламжаар, уг хэрэг шүүхэд шилжсэн бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар тус тус шийдвэрлэнэ.

70.3. Баривчлах, цагдан хорихоос бусад прокурорын шийдвэрээр авсан таслан сэргийлэх арга хэмжээг гагцхүү тухайн прокурор буюу дээд шатны прокурор хүчингүй болгож, өөрчилж болно.

71 дүгээр зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ хууль ёсны эсэхэд тавих хяналт

71.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас авсан таслан сэргийлэх арга хэмжээ нь хууль ёсны үндэслэлтэй эсэхэд прокурор хяналт тавина.

71.2.Сэжигтэн, яллагдагчид цагдан хоригоос бусад таслан сэргийлэх арга хэмжээ авах, нэгэн авсан арга хэмжээг хүчингүй болгох, өөрчлөх шаардлагатай бол уг хэргийн ажиллагаанд хяналт тавьж байгаа, эсхүл дээд шатны прокурор тогтоолоор гаргаж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ
Байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ

72 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ авах үндэслэл

72.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх журмыг хангах зорилгоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид дараахь байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ авах эрхтэй:

72.1.1. дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах;

72.1.2. албадан ирүүлэх;

72.1.3. албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх;

72.1.4. эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг нь хязгаарлах;

72.1.5. торгууль оногдуулах.

72.2. Энэ хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь хохирогч, гэрч болон бусад оролцогчид дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах, албадан ирүүлэх торгууль оногдуулах албадлагын арга хэмжээ авах эрхтэй.

73 дугаар зүйл. Дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах

73.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авааг нөхцөлд, түүнчлэн гэрч, хохирогч байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэг шийдвэрлэхэд хүрэлцэн ирэхгүй гэх хангалттай үндэслэл байгаа буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дуудахад хүрэлцэн ирээгүй бол уг этгээдээр дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг бичгээр авахуулах ба тухайн этгээд оршин суугаа газрын хаягаа өөрчилсөн тохиолдолд нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ.

74 дүгээр зүйл. Албадан ирүүлэх

74.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч түүнчлэн гэрч, хохирогч, шинжээч нь дуудсан үед

үндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг үртэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гарган албадан ирүүлнэ.

74.2. Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд эрийн цагт албадан ирүүлэхийг хориглоно.

74.3. 14 насанд хүрээгүй этгээд, жирэмсэн этэй, хүнд өвчний үчир ирж чадахгүй этгээдийг албадан ирүүлэхийг хориглоно.

74.4. Хүнд өвчтэй эсэхийг эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор тогтооно.

74.5. Албадан ирүүлэх ажиллагаа хэрэг үртэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн даалгаснаар цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

75 дугаар зүйл. Албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх

75.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч албан үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх нь хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд сөрөг өлөө үзүүлж болзошгүй үндэслэл байвал хэрэг бүртэгч, мөрдөн байцаагч нь прокурорын эвшөөрөлтэйгээр, шүүх, прокурор нь тэднийг албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх эрхтэй.

75.2. Албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлэх шийдвэрийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эсрэг гаргасан албан байгууллагад хүргүүлэх бөгөөд байгууллагын удирдлага уг шийдвэрийг 3 хоногийн дотор хэрэгжүүлж, энэ тухай хариу мэдэгдэнэ.

75.3. Энэ хуулийн 75.1-д заасан арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй бол шийдвэр гаргасан албан тушаалтан түүнийг хүчингүй болгож, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

76 дугаар зүйл. Эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах

76.1. Иргэний нэхэмжлэл, эд хөрөнгө хамгаалах шийдвэрийг хангахын тулд шүүх, прокурор, түүнчлэн хэрэг бүртэгч, мөрдөн байцаагч нь прокурорын эвшөөрөлтэйгээр тогтоол гаргаж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн эд хөрөнгийн хариуцлага хүлээх этгээдийн эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болно.

76.2. Эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлахдаа өмчлөгч буюу эзэмшигчээс эд хөрөнгөө бусдад шилжүүлэхгүй байх, шаардлагатай тохиолдолд ашиглахгүй байх үүрэг авахуулах, эсхүл тухайн эд хөрөнгийг гаргуулан авч хадгална.

76.3. Хуульд зааснаар төлбөрт гаргуулж болохгүй эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болохгүй.

76.4. Эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах арга хэмжээ авахдаа эд хөрөнгийн үнэлгээний мэргэжилтнийг оролцуулж болно.

76.5. Банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болно.

77 дугаар зүйл. Торгууль

77.1. Байцаан шийтгэх ажиллагааны болон шүүх хуралдааны журмыг зөрчсөн тохиолдолд хохирогч, гэрч, орчуулагч, хэлмэрч болон холбогдох бусад этгээдэд энэ хуулийн 78 дугаар зүйлд заасан журмын дагуу торгууль оногдуулна.

77.2. Мөнгөн торгуулийн хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг байх бөгөөд түүнийг улсын төсөвт оруулна.

78 дугаар зүйл. Торгууль оногдуулах журам

78.1. Энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан тохиолдолд шүүхийн шатанд торгуулийг шүүх оногдуулна.

78.2. Шүүхийн өмнөх шатанд зөрчил гаргасан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч зөрчлийн тухай тэмдэглэл үйлдсэний дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга торгууль оногдуулна.

78.3. Энэ хуулийн 78.2-т заасан тэмдэглэлд түүнийг хэзээ, хаана, хэн үйлдсэн, зөрчил гаргагчийн биеийн байцаалт, зөрчил гаргасан байдал, зөрчилд торгууль оногдуулах тухай заалт, зөрчил гаргагчийн тайлбарыг бичиж, тэмдэглэл хөтөлсөн этгээд болон зөрчил гаргагч гарын үсэг зурах ба зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ
НОТЛОХ БАРИМТ, НОТЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нотлох баримт

79 дүгээр зүйл. Нотлох баримт

79.1. Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар

энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэнэ.

79.2. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно.

79.3. Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална.

79.4. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

79.5. Нэргүй захидал болон мэдээлэл нь дангаараа нотлох баримт болохгүй.

80 дугаар зүйл. Хэргийн талаар нотолбол зохих асуудлууд

80.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад дор дурдсан асуудлуудыг нотолно:

80.1.1. гэмт хэрэг гарсан байдал / гэмт хэргийг хэдийд, хаана, яаж үйлдсэн болон бусад байдал/;

80.1.2. уг гэмт хэргийг хэн үйлдсэн;

80.1.3. гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр;

80.1.4. яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдал, түүнд хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүд;

80.1.5. гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ;

80.1.6. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл.

81 дүгээр зүйл. Сэжигтний мэдүүлэг

81.1. Сэжигтэн нь сэжигтнээр тооцогдсон болон таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан үндэслэл, түүнчлэн хэргийн талаар өөрийн мэдэж байгаа зүйлийн тухай мэдүүлэг өгөх эрхтэй.

81.2. Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаарда: түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг н гутаан доромжлохыг хориглоно.

82 дугаар зүйл. Яллагдагчийн мэдүүлэг

82.1. Яллагдагч сонссон ялын талаарх үндэслэл, түүнчлэн хэргийн талаар өөрийн мэдэ: байгаа зүйл, хэрэгт цугларсан нотлох баримты талаар мэдүүлэг өгөх эрхтэй.

82.2. Яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэ нь гагцхүү хэрэгт байгаа бусад нотлох баримтаа батлагдвал яллах үндэслэл болно.

82.3. Яллагдагчаас мэдүүлэг өгөхий шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэ төрийг нь гутаан доромжлохыг хориглоно.

83 дугаар зүйл. Хохирогчийн мэдүүлэг

83.1. Хохирогч нь хэрэг бүртгэгч, мөрдө байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлж тавьсан асуултад хариулт өгөх үүрэгтэй.

83.2. Хохирогч мэдүүлгийнхээ э сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох барим болохгүй.

84 дүгээр зүйл. Гэрчийн мэдүүлэг

84.1. Гэрч нь хэргийг нотлоход хамааралтай бүхий л байдал, түүний дотор сэжигтэн, яллагдагч шүүгдэгч, хохирогчийн хувийн байдал, түүнчлэн түүнтэй ямар харилцаатай болох тухай асуудлаар үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

84.2. Гэрч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй

85 дугаар зүйл. Шинжээчийн дүгнэлт

85.1. Шинжээч хийсэн шинжилгээгээ үндэслэн тусгай мэдлэгийнхээ хүрээнд өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж, түүнийгээ өөрөө хариуцна.

85.2. Шинжилгээ хийлгэхээр хэд хэдэн шинжээчийг томилсон бол тэд нь дүгнэлт гаргахаас өмнө хоорондоо зөвлөж, санал нэгтэй байвал дүгнэлтэд бүгдээрээ гарын үсэг зурна.

85.3. Шинжээчид өөр хоорондоо санал зөрвөл шинжээч санал зөрсөн асуудлаар тусгай саналаа гаргаж, дүгнэлтэд хавсаргана.

85.4. Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх заавал

ıримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг вшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал хино.

86 дугаар зүйл. Эд мөрийн баримт, үнийг хадгалах

86.1. Эд мөрийн баримтад гэмт хэрэг лдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэргийн мөр үлдсэн зүйл, түүнчлэн гэмт үйлдлийн замаар ıсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад зүйлс, баримт ıчиг болон гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит айдлыг тогтоох, гэмт этгээдийг олох, эсхүл ıжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үйсгэх буюу хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий ıсад эд зүйлийг тооцно.

86.2. Эд мөрийн баримтыг үзлэгийн ıмдэглэлд тодорхой бичиж, хэрэгт хадгалах ба рэл зураг, дүрс бичлэг авч, хэрэг бүртгэгч, мөрдөн айцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр хэрэгт авсаргана.

86.3. Эд мөрийн баримтыг хэмжээний хувьд ıюу бусад шалтгаанаар эрүүгийн хэрэгт хадгалах эхцөлгүй бол гэрэл зураг, дүрс бичлэг авсны дараа ацдаж битүүмжлээд хэрэг бүртгэгч, мөрдөн айцаагч, прокурор, шүүхийн шийдвэрээр хуульд аасан журмын дагуу тусгай газар хадгалж, энэ ıхай баримтыг хэрэгт хавсаргана.

86.4. Хэргийг нэг газраас нөгөөд ıилжүүлэхэд хэмжээний хувьд буюу бусад ıалтгаанаар эд мөрийн баримтыг уг хэрэгт авсаргах боломжүй бол түүнийг шүүхийн шийдвэр артал хуульд заасан журмын дагуу хадгалж, энэ ıхай баримтыг хэрэгт хавсаргана.

87 дугаар зүйл. Эд мөрийн баримтыг адгалах хугацаа

87.1. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин өгөлдөр болох хүртэл, эсхүл хэргийг хэрэгсэхгүй олгосон тогтоол, захирамжийг давж заалдах угацаа дуустал эд мөрийн баримтыг хадгална.

87.2. Эд зүйлийн эзэмшлийн талаар гарсан аргааныг иргэний журмаар шийдвэрлэвэл зохих айсан бол эд мөрийн баримтыг шүүхийн шийдвэр уулийн хүчин төгөлдөр болтол хадгална.

87.3. Түргэн муудах буюу гэмтэх эд мөрийн аримтыг эзэмшигчид нь буцааж өгөх боломжгүй өхцөлд хэрэгцээний нь дагуу зохих байгууллагад ıилжүүлэн өгөх ба эзэмшигчид нь адил төрөл, анарын эд зүйлийг олгох буюу эсхүл үнийг төлнө.

88 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ

88.1. Прокурор хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, шүүх цагаатгах, шийтгэх тогтоол гаргахдаа эд мөрийн баримтыг дараахь байдлаар шийдвэрлэнэ:

88.1.1. яллагдагч гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгслийг хураан авч зохих байгууллагад шилжүүлэх буюу устгах;

88.1.2. гүйлгээнд хориглосон эд зүйлийг зохих байгууллагад шилжүүлэх буюу устгах;

88.1.3. цаашид ашиглаж болохгүй эд зүйлийг устгах ба хэрэв сонирхогч этгээд буюу байгууллагаас хүсвэл өгөх;

88.1.4. гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь эгүүлэн олгох бөгөөд хэрэв эзэмшигчийг тогтоох боломжгүй бол улсын орлого болгох;

88.1.5. эд зүйлийн эзэмшлийн талаар маргаан гарвал иргэний журмаар шийдвэрлэх;

88.1.6. энэ хуулийн 24.1.2, 24.1.3-д заасан үндэслэлээр прокуророос хэргийг хэрэгсэхгүй болгосон бол гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийн тухай асуудлыг шүүх шийдвэрлэх;

88.1.7. эд мөрийн баримт болох баримт бичгийг хэрэгт нь уг хэргийг хадгалах хугацаа дуустал үлдээх, эсхүл хууль ёсны эзэмшигчид нь буцаан өгч, хуулбарыг хэрэгт хавсаргах.

89 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэл

89.1. Үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд зүйлийг хураан авах, баривчлах, таньж олуулах үед тогтоогдсон байдал, баримтыг гэрчилж байгаа бөгөөд энэ хуульд заасан журмаар үйлдсэн тэмдэглэл нь нотлох баримтын эх сурвалж болно.

90 дүгээр зүйл. Баримт бичиг

90.1. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичиг эрүүгийн хэрэгт ач холбогдолтой байвал тэр нь нотлох баримтын эх сурвалж болно.

90.2. Баримт бичиг нь энэ хуулийн 86 дугаар

зүйлд заасан шинжтэй байвал эд мөрийн баримт болно.

90.3. Энэ хуулийн 93 дугаар зүйлд заасн дагуу олж авсан, гаргаж өгсөн соронзон болон дүр бичлэг, гэрэл зураг нь баримт бичигт хамаарна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ
Нотлох ажиллагаа

91 дүгээр зүйл. Нотлох ажиллагаа

91.1. Нотлох ажиллагаа нь хэргийг хуулийн дагуу, шударга, үндэслэлтэйгээр хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тогтоохын тулд нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагаанаас бүрдэнэ.

91.2. Яллагдагч гэм буруутай эсэх, түүнд ял оногдуулах үндэслэл байгаа эсэхийг нотлох үүргийг улсын яллагч хүлээнэ.

92 дугаар зүйл. Нотлох баримтыг цуглуулах

92.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад байцаах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, хураан авах, үзлэг, нэгжлэг хийх, туршилт, шинжилгээ болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулна.

92.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь талуудын хүсэлт болон өөрийн санаачилгаар энэ хуульд заасан журмын дагуу мэдүүлэг авах, дүгнэлт гаргуулахаар шинжээч томилох, үзлэг, нэгжлэг хийх болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах, байгууллага, албан тушаалтан, иргэнээс болон гүйцэтгэх ажил эрхэлж байгаа байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримт, баримт сэлтийг гаргуулан авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар шалгалт, үзлэг хийлгүүлэхийг шаардах эрхтэй.

92.3. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, улсын яллагч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч болон иргэн, байгууллага баримт сэлт гарган өгч болно.

92.4. Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.

93 дугаар зүйл. Нотлох баримтыг бэхжүүлэх

93.1. Хэрэгт цугларсан эд мөрий баримт, баримт сэлт, мэдээллийг хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын ажиллагааны болон шүү хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ.

93.2. Тэмдэглэл үйлдэх үүргий хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэр бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүү хуралдааны явцад шүүх хуралдааны нарийн бичгий дарга хүлээнэ.

93.3. Нотлох баримты бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцэ мэдээллийг тусгасан соронзон болон дүрс бичл хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөө хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн байцаа шийтгэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргы хэрэглэнэ.

94 дүгээр зүйл. Нотлох баримтыг шалга

94.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүх нь цугларсан нотлох баримтыг бү талаас нь, бодит байдлаар нь хянаж үзэх үүрэгтэй

94.2. Хэрэгт авагдсан нотлох баримты харьцуулан шинжлэн судлах, бусад нотло баримттай харьцуулах, шинэ нотлох баримты цуглуулах, нотлох баримтын эх сурвалжий магадлах аргаар нотлох баримтыг шалгана.

95 дугаар зүйл. Нотлох баримтыг үнэлэ

95.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүх нь тухайн хэрэгт хамааралтай хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлж авсан бү нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ.

95.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүх нь хууль болон эрх зүйн ухамсры удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

95.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

95.4. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл

баримтыг дахин нотлох шаардлагагүй ба энэ заалт шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээн шалгахад хамаарахгүй.

ТАВДУГААР ХЭСЭГ
ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ БУСАД НИЙТЛЭГ НӨХЦӨЛ

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ
Байцаан шийтгэх ажиллагааны хугацаа, зардал

96 дугаар зүйл. Хугацаа тоолох

96.1. Хугацааг цаг, хоног, сар, жилээр тоолно.

96.2. Хугацааг тоолоход уг хугацаа эхэлсэн цаг, хоногийг тооцоонд оруулахгүй.

96.3. Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь сүүлчийн хоногийн 24 цагт дуусна. Хугацааг сараар тоолоход сүүлчийн сарын мөн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв энэ сард тохирох өдөр байхгүй бол мөн сарын эцсийн хоног хугацаа дуусна. Хугацааг жилээр тоолоход хугацаа нь дараа оны тухайн сарын тухайн өдөр дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараачийн ажлын эхний өдрөөр тоолно.

96.4. Хугацаа дуусахын өмнө гомдол, бусад баримт бичгийг шүүданд, эсхүл хорих байгууллагын захиргаанд албан ёсоор өгсөн байвал хугацаа хэтэрсэнд тооцохгүй.

97 дугаар зүйл. Хугацааг сунгах

97.1. Энэ хуулиар тогтоосон хугацааг энэ хуульд заасан журмаар сунгаж болно.

98 дугаар зүйл. Хэтэрсэн хугацааг сэргээх

98.1.Хугацаа хэтэрсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай бөгөөд түүнийг сонирхогч этгээдээс сэргээлгэхийг хүсвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар энэ хуульд заасны дагуу сэргээнэ.

98.2.Хэтэрсэн хугацааг сэргээх, шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхийг татгалзсан тухай тогтоол, захирамжид гомдол гаргаж болохгүй.

98.3. Давж заалдах гомдлыг тогтоосон хугацаанаас хэтрүүлж гаргасан байвал түүнтэй холбогдох шийдвэрийг сонирхогч этгээдийн хүсэлтээр хэтэрсэн хугацааг сэргээх тухай асуудлыг шийдвэрлэх хүртэл биелүүлэхийг түдгэлзүүлж болно.

99 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны зардал

99.1. Байцаан шийтгэх ажиллагааны зардалнь дор дурдсан зардлаас бүрдэнэ:

99.1.1. хохирогч, түүний төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, мэргэжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчид төлсөн зардал;

99.1.2. эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, шинжлүүлэхэд гарсан зардал;

99.1.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарсан зардал;

99.1.4. өмгөөлөгчид төлсөн зардал;

99.1.5. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнчлэн шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарсан зардал;

99.1.6. байцаан шийтгэх ажиллагаатай холбогдож гарсан бусад зардал.

100 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны нөхөн төлүүлэх зардлын хэмжээг тодорхойлох

100.1. Байцаан шийтгэх ажиллагааны нөхөн төлүүлэх зардлыг дараахь журмаар тодорхойлно:

100.1.1. хохирогч, түүний төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, мэргэжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчид олгох тэтгэвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр, мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хугацаанд хохирогч, шинжээч, гэрч, хөндлөнгийн гэрч хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөлсний дундаж хэмжээгээр;

100.1.2. мэргэжилтэн, шинжээч, орчуулагч,

хэлмэрчийн ажлын хөлсийг харилцан тохиролцсоны үндсэн дээр; /Харин эрхэлсэн ажлын хувиар уг үүргийг биелүүлсэн бол үүнд хамаарахгүй/;

100.1.3. энэ хуулийн 99.1.3, 99.1.5-д заасан зардлыг гарсан бодит зардлын хэмжээгээр.

101 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны зардлыг гаргуулах

101.1. Шүүгдэгч гэм буруутай болохыг тогтоовол шүүх түүнээс байцаан шийтгэх ажиллагааны зардлыг гаргуулах эрхтэй.

101.2. Хэд хэдэн шүүгдэгч гэм буруутай болох нь тогтоогдвол байцаан шийтгэх ажиллагааны зардлын хэмжээг хүн нэг бүрийн гэм буруу, хариуцлагын хэр хэмжээ, эд хөрөнгийн байдлыг харгалзан шүүх хуваарилж тогтооно.

101.3 Уг хэргийг энэ хуулийн 24.1.1.-д зааснаар хэрэгсэхгүй болгосон буюу шүүгдэгчийг цагаатгасан, түүнчлэн шийтгэгдсэн этгээд эд хөрөнгөгүй болох нь тогтоогдвол байцаан шийтгэх ажиллагааны зардлыг төр хариуцна.

101.4. Шүүгдэгчийн гэм буруу тогтоогдсон боловч Эрүүгийн хуульд зааснаар ялаас чөлөөлөх тохиолдолд шүүх түүнээс зардлыг гаргуулах эрхтэй.

101.5. Хохирогч яллагдагчтай харилцан эвлэрснээр уг хэргийг хэрэгсэхгүй болгосон байвал шүүхийн зардлыг тэдний аль нэгээс буюу хоёр талаас шүүх гаргуулах эрхтэй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Хүсэлт, гомдол гаргах

102 дугаар зүйл. Хүсэлт гаргах эрх

102.1. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх болон шүүгчид гаргах эрхтэй.

103 дугаар зүйл. Хүсэлт гаргах журам

103.1. Хүсэлтийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болно.

103.2. Хүсэлтэд тогтоолгох үйл явдал, явуулах байцаан шийтгэх ажиллагаа, гаргуулах шийдвэрийн тухай тодорхой дурдана.

103.3. Бичгээр гаргасан хүсэлтийг хэрэгт хавсаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгана.

103.4. Хүсэлтийг хангаагүй явдал нь байцаан шийтгэх ажиллагааны тухайн болон өөр үе шатанд түүнийг дахин гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

104 дүгээр зүйл. Хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацаа

104.1. Хүсэлтийг боломжтой бол шууд, боломжгүй бол түүнийг гаргаснаас нь хойш 5 хоногийн дотор хангах эсэхийг шийдвэрлэнэ.

105 дугаар зүйл. Хүсэлтийг хангах

105.1. Хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор тогтоох, оролцогч болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол түүнийг хангах ба бусад тохиолдолд хэрэгсэхгүй болгоно.

105.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хүсэлтийг бүрэн болон хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай үндэслэл бүхий тогтоол, захирамжийг гаргах ба түүнд энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

106 дугаар зүйл. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрх

106.1. Байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, түүнчлэн уг ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол иргэн, хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагаанд энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

107 дугаар зүйл. Гомдол гаргах журам

107.1. Гомдлыг хуульд заасны дагуу хянан үзэж шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

107.2. Гомдлыг амаар буюу бичгээр гаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, гомдол гаргагч гарын үсэг зурна.

108 дугаар зүйл. Баривчлагдсан буюу

цагдан хоригдсон этгээдийн гомдлыг шилжүүлэх

108.1. Гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд хэрэг буруугаа, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд гомдол гаргасан бол баривчлах болон цагдан хорих байрны захиргаа 24 цагийн дотор хаягаар нь хүргүүлэх үүрэгтэй.

109 дүгээр зүйл. Гомдол гаргах хугацаа

109.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагааны талаархи гомдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болно.

109.2. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол энэ хуульд заасан хугацаанд гомдол гаргаж болно.

110 дугаар зүйл. Гомдол гаргасантай холбогдуулан шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх

110.1. Гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан албан тушаалтан, байгууллагын шийдвэрийн биелэлтийг гомдлыг шийдвэрлэж дуусах хүртлэх хугацаанд түр түдгэлзүүлж болно.

111 дүгээр зүйл. Гомдлыг хянан шийдвэрлэх нийтлэг журам

111.1. Энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан албан тушаалтны талаар гаргасан гомдлыг түүний шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан хянах ба түүнд дурдсан үндэслэлийг тал бүрээс нь хянаж шаардлагатай бол нэмэлт баримт, тайлбар авах эрхтэй.

111.2. Гомдлыг хянаж байгаа албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол гаргагчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй.

111.3. Хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас гомдол гаргагчийн эд хөрөнгө, сэтгэл санаа, бие эрхтэнд хохирол учирсан бол энэ хуульд заасан жүрмын дагуу хохирлоо арилгуулахаар хандах эрхтэй болохыг нь түүнд тайлбарлан өгнө.

112 дугаар зүйл. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хянах

112.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гаргах гомдлыг эдгээр албадын удирдлага, эсхүл хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаархи гомдлыг дээд шатны прокурорт гаргана.

112.2. Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 72 цагийн дотор, нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 7 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

112.3. Гомдлыг хянасан албан тушаалтан энэ хуулийн 106 дугаар зүйлд заасан албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргана.

112.4. Гомдол гаргагчид гомдлыг хэрэгсэн шийдвэрлэсэн ба уг шийдвэрт дахин гомдол гаргах эрхтэйг тайлбарлан өгнө.

112.5. Гомдлыг хүлээн авахаас татгалзахдаа үндэслэлийг заавал дурдсан байна.

113 дугаар зүйл. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үед гаргасан шүүх, шүүгчийн шийдвэрт гомдол гаргах

113.1. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үед гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, магадлалын талаар дээд шатны шүүхэд бичгээр гомдол гаргах ба түүнийг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ.

113.2. Шүүгдэгчийг эмнэлгийн байгууллагад шилжүүлсэн буюу албадлагын бусад арга хэмжээ авсан бол шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй.

113.3. Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах тухай шүүхийн шийдвэр эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь зөрчиж байна гэж үзвэл сонирхогч аливаа этгээд тухайн шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

113.4. Шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүнээр гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг дээд шатны шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.

113.5. Гомдол гаргагч нь гомдлыг хянан шийдвэрлэхэд оролцох эрхтэй ба түүний хүрэлцэн ирээгүй нь гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй. Гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээд нь өөрийн санал, үндэслэлийг хэлэх, шаардлагатай баримт бичгийг гаргаж танилцуулах эрхтэй.

113.6. Шүүх бүрэлдэхүүн, шүүгч гомдлыг хянан шийдвэрлэзд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

113.6.1. гомдлыг хангаж, шүүхийн шийдвэрийг өөрчлөх;

113.6.2. гомдлыг хангахгүй орхих.

113.7. Гомдлыг хянан шийдвэрлэсэн гаргасан шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжид дахин гомдол гаргахгүй.

113.8. Гомдол гаргагч шүүхэд хүрэлцэн ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

114 дүгээр зүйл. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гомдол гаргах

114.1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг хүчингүй болгох, өөрчлөх талаар гаргасан шүүхийн шийдвэрт тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид, түүний эзгүйд томилсон шүүгчид гомдол гаргаж болно.

114.2. Гомдлыг Ерөнхий шүүгч эсхүл түүний томилсон шүүгч 48 цагийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацаанд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр үйлчилнэ.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл

115 дугаар зүйл. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл

115.1. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.

115.2. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын төмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

115.3. Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдэхээс өмнө хэргийг хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.

116 дугаар зүйл Нэхэмжлэл гаргах

116.1. Иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг үүсгэснээс эхлэн шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд гаргаж болно.

116.2. Энэ хуулийн 116.1-д заасан хугацаанд эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргаагүй, эсхүл гаргасан нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол түүнийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй.

117 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэгчээр тогтоох

117.1. Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэдэнд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг нь тайлбарлана.

117.2. Нэхэмжлэл гаргасан этгээдийг энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан журмын дагуу иргэний нэхэмжлэгчээр тогтоох тухай шийдвэр гаргаж, энэ хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлана.

118 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзах

118.1. Энэ хуулийн 117 дугаар зүйлд заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нь нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.

118.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

119 дүгээр зүйл. Иргэний хариуцагчаар татах

119.1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хариуцах этгээдийг тогтоосны дараа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх холбогдох этгээдийг энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан журмын дагуу иргэний хариуцагчаар татах тогтоол гаргаж хариуцагч, түүний төлөөлөгчид танилцуулж эрх, үүргийг нь тайлбарлаж өгнө.

120 дугаар зүйл. Хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцөлийг тогтоосон журмыг хэрэглэх

120.1. Эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл

гаргасан бол хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцөлийг Монгол Улсын Иргэний хууль[3], Хөдөлмөрийн тухай хууль[4] болон бусад хуулиар тодорхойлно.

120.2. Хууль тогтоомжид заасан бол олон улсын гэрээ, гадаад улсын хуулийн хэм хэмжээг хэрэглэж болно.

121 дүгээр зүйл. Нэхэмжлэлээс татгалзах

121.1. Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.

121.2. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүрттэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах бөгөөд ба хэрэв бичгээр гаргасан бол хэрэгт хавсаргана.

121.3. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.

121.4. Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.

121.5. Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох бөгөөд энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

122 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэр

122.1. Шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн хангах, эсхүл нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэхээс татгалзах тухай шийдвэрийг гаргана.

122.2. Шүүх цагаатгах тогтоол гаргахдаа:

122.2.1. гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй буюу шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно;

122.2.2. шүүгдэгчийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс түүнийг цагаатгасан бол нэхэмжлэлийг авч хэлэлцэхгүй орхино.

122.3. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад тооцоог бүрэн хийх боломжгүй бөгөөд энэ нь гэм бурууг шийдвэрлэхэд нөлөөлөхгүй бол эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэж, нэхэмжлэлээ иргэний журмаар гаргахыг нэхэмжлэгчид мэдэгдэнэ.

122.4. Энэ хуулийн 122.3-т заасны дагуу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар гаргасан нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

123 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах

123.1. Шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн хэргийг нэгттэх, тусгаарлах

124 дүгээр зүйл. Эрүүгийн хэргийг нэгттэх

124.1. Хэд хэдэн этгээд нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн урьдаас үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэргийг нуун дарагдуулсан буюу мөдээлээгүй хэрэгт яллагдаж байгаа этгээдүүдийн хэргийг нэгттэнэ.

124.2. Эрүүгийн хэргийг нэгттэхдээ хөнгөнийг нь хүндэвтэрт, хүндэвтэрийг нь хүндэд, хүндийг нь онц хүндэд нэгттэнэ.

124.3. Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед нэгттэж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

125 дугаар зүйл Эрүүгийн хэргийг тусгаарлах

125.1. Зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор шинжлэх, зөв шийдвэрлэхэд саад болохгүй бол уг хэргийг тусгаарлаж болно.

125.2. Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед тусгаарлаж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

[3] Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[4] Хөдөлмөрийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

ЗУРГАДУГААР ХЭСЭГ
ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ
Үзлэг, мөрдөн байцаалтын туршилт

126 дугаар зүйл. Үзлэг хийх үндэслэл

126.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэрэг гарсан байдал, хэргийн үл мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэг гарсан газар болон эд зүйл, баримт бичигт үзлэг хийнэ.

126.2. Хойшлуулшгүй тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө үзлэг хийж болно.

127 дугаар зүйл. Үзлэг хийх журам

127.1. Үзлэг хийхэд хөндлөнгийн 2 гэрч байлцуулна.

127.2. Хөндлөнгийн гэрч байлцуулах боломжгүй тохиолдолд үзлэгийг түүний оролцоогүйгээр явуулж, явц, үр дүнг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлнэ.

127.3. Онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт прокурор заавал оролцоно.

127.4. Үзлэг хийхэд яллагдагч, сэжигтэн, хохирогч, гэрчийг оролцуулж болно.

127.5. Үзлэг хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг урьж болно.

127.6. Үзлэг хийхэд хэмжих, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, соронзон болон дүрс бичлэг хийх, үл мөрний хэв, хуулбар авах ажлыг хийж болно.

127.7. Үзлэгийн үед шинээр олдсон эд зүйл, баримт бичигт газар дээр нь тусгайлан үзлэг хийнэ.

127.8. Эд зүйл, баримт бичигт үзлэг хийхэд удаан хугацаа шаардагдах буюу бусад үндэслэл байвал үзлэгийг хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газар хийнэ.

127.9. Шаардлагатай гэж үзсэн эд зүйлийг анхны шинж байдлыг алдагдуулахгүйгээр хураах авна.

127.10. Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлд хийх үзлэгийг энэ хуулийн 136 дугаар зүйлд зааснаар гүйцэтгэнэ.

128 дугаар зүйл. Цогцост үзлэг хийх

128.1. Цогцост үзлэг хийхэд шүүх эмнэлгийн шинжээчийг, хэрэв боломжгүй бол өөр их эмчийг оролцуулна.

128.2. Цогцсыг оршуулсан газраас нь гаргах үзлэг хийх тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулах ба үг аажиллагаа гүйцэтгэхэд шүүх-эмнэлгийн шинжээч, хөндлөнгийн гэрчийг байлцуулна.

129 дүгээр зүйл. Хүний биед үзлэг хийх

129.1. Яллагдагч, сэжигтэн, гэрч буюу хохирогчийн биед гэмт хэргийн үл мөр, эсүл онцлог тэмдэг байгаа эсэхийг илрүүлж бэжүүлэхийн тулд түүний биед үзлэг хийж болно.

129.2. Хүний биед үзлэг хийх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол гаргах ба түүнийг холбогдох этгээд заавал биелүүлнэ.

129.3. Хүний биед үзлэг хийхэд шаардлагатай бол их эмчийг оролцуулна.

129.4. Хүний биед үзлэг хийх ажиллагаа гүйцэтгэхэд уг эттэздийг нүүгэлгэх шаардлага гарвал ижил хүйсийн хөндлөнгийн гэрч байлцуулна.

129.5. Нүүгэлгэх ажиллагаанд эсрэг хүйсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг оролцуулж болохгүй ба энэ тохиолдолд ижил хүйсийн өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, их эмч, хөндлөнгийн гэрчүүдийг байлцуулан үзлэг хийнэ.

129.6. Үзлэг хийхдээ тухайн этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаах, түүний эрүүл мэндэд аюултай арга хэрэглэхийг хориглоно.

130 дугаар зүйл. Үзлэгийн тэмдэглэл

130.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу үзлэг хийсэн тухай тэмдэглэл үйлдэнэ.

130.2. Тэмдэглэлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн бүх ажиллагаа, үзлэгийн явц, илэрсэн болон хурааж авсан, битүүмжилсэн эд зүйл, цаг агаарын нөхцөл, хэрэглэсэн техник хэрэгсэл, лац, эд мөрийн баримт, хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг хэрхэн хадгалсан, шийдвэрлэсэн, эхэлсэн, дууссан цаг хугацаа зэргийг дэс дараалалаар нь нэг бүрчлэн тодорхой бичнэ.

131 дүгээр зүйл. Туршилт хийх

131.1. Хэрэгт ач холбогдолтой тодорхой нөхцөл байдал, үйл явдлыг сэргээн дүрслэх шаардлагатай бол туршилт хийж болно.

131.2. Туршилт хийхэд хөндлөнгийн хоёр гэрчийг байцуулах ба шаардлагатай бол сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч, түүнчлэн уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг оролцуулж болно.

131.3. Туршилтыг хүний нэр төр, алдар хүндийг гутаах буюу эрүүл мэндэд хохирол учруулахгүй нөхцөлд явуулах ба түүний явц, үр дүнг бэхжүүлэхдээ хэмжих, зураг авах, гар зураг үйлдэх, соронзон болон дүрс бичлэг хийх зэрэг арга хэрэглэж болно.

131.4. Туршилт хийсэн тухай тэмдэглэлийг энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу үйлдэх ба энэ хуулийн 130 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ
Хураан авах, нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх, шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг хураан авах

132 дугаар зүйл. Хураан авах, нэгжлэг хийх үндэслэл

132.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг зээмшигчээс нь хураан авна.

132.2. Төрийн нууц агуулсан баримт бичгийг гагцхүү прокурорын зөвшөөрөлтэйгээр, зохих байгууллагын удирдлагад мэдэгдсэний үндэсн дээр хураан авна.

132.3. Эрэн сурвалжилж байгаа этгээд нуугдаж байгаа буюу гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд зүйл, түүнчлэн цогцос, хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бусад зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг олж илрүүлэхээр нэгжлэг хийнэ.

133 дугаар зүйл. Хураан авах, нэгжлэг хийх журам

133.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хураан авах, нэгжлэг хийх тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулах ба уг ажиллагаа эхлэхийн өмнө холбогдох этгээдэд үншиж сонсгоно.

133.2. Хойшлуулшгүй тохиолдолд хураан авах, нэгжлэг хийх ажиллагааг шууд, эсхүл шөнийн цагаар гүйцэтгэж, энэ тухайгаа 24 цагийн дотор прокурорт мэдэгдэнэ.

133.3. Хураан авах, нэгжлэг хийх ажиллагаанд саад учруулбал албадан гүйцэтгэнэ.

133.4. Хураан авах, нэгжлэг хийх үед хуулиар хамгаалагдсан нууц баримт бичиг, бусад зүйл илэрвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч түүнийг задруулахгүй байх арга хэмжээ авна.

133.5. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь нэгжлэг хийж байгаа газарт байсан болон орж ирсэн хүмүүсийг нэгжлэг дуустал тэр газраас явах, бие биетэйгээ харилцахыг хоригломо.

134 дүгээр зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх

134.1. Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний төлөө эд материалын харилцлага хүлээвэл зохих хүмүүсийн эд хөрөнгийг битүүмжлэх үүрэгтэй.

134.2. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийхтэй хамтатгах, эсхүл тусад нь хийж болно.

134.3. Эд хөрөнгө битүүмжлэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулна.

134.4. Битүүмжилж байгаа эд хөрөнгийг бүртгэж данслах ажиллагааг хөндлөнгийн гэрч, бусад хүмүүсийг байлцуулан энэ хуулийн 133, 137 дугаар зүйлд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

134.5. Сэжигтэн, яллагдагч, түүний асрамжид байгаа хүмүүсийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй ба тэдгээрийн жагсаалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай[5] хуульд заасны дагуу тогтооно.

134.6. Битүүмжилсэн эд хөрөнгийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолоор уг хөрөнгийг зээмшигч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн болон бусад боломжтой этгээдэд хадгалуулахаар өгч, эд хөрөнгийг бүрэн бүтэн

[5] *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.*

байлгах хариуцлагыг тайлбарлан өгч энэ тухай гарын үсэг авна.

134.7. Шаардлагатай тохиолдолд битүүмжилсэн эд хөрөнгийг түр хураан авч болно.

134.8. Битүүмжилсэн эд хөрөнгийг хадгалах, бүрэн бүтэн байлгах асуудлыг энэ хуулийн 134.6-д заасны дагуу шийдвэрлэх боломжгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага хариуцна.

134.9. Мөнгөн хадгаламжийг төлөх төлбөрийн хэмжээгээр битүүмжилж, байгууллагын санхүүгийн дансны гүйлгээ хийхийг зогсооно.

134.10. Энэ арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй болсон бол эд хөрөнгө битүүмжлэх урьд гаргасан тогтоолыг хүчингүй болгоно.

135 дугаар зүйл. Биед нэгжлэг хийх

135.1. Хүний биед нэгжлэг хийхэд энэ хуулийн 132, 133, 137 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

135.2. Дараахь үндэслэл байвал тогтоол гаргахгүйгээр хүний биед нэгжлэг хийж болно:

135.2.1.баривчлах, цагдан хорих арга хэмжээ авахад;

135.2.2. хураан авах болон нэгжлэг хийж байгаа орон байр, бусад газар байсан этгээд хэрэгт холбогдол бүхий эд зүйл, баримт бичиг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал.

135.3. Биед нэгжлэг хийхэд ижил хүйсийн хүн байвал зохих бөгөөд энэ зарчим хөндлөнгийн гэрчид нэгэн адил хамаарна.

136 дугаар зүйл. Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийх

136.1. Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан-цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийхийг прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

136.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийх тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий тогтоол гарган прокуророор батлуулсны дараа холбогдох ажиллагаа явуулах ба хөндлөнгийн гэрчийг байлцуулна.

136.3. Энэ зүйлд заасан арга хэмжээ цаашид хэрэглэх шаардлагагүй болсон бол уры гаргасан тогтоолыг хүчингүй болгоно.

137 дугаар зүйл. Хураан авах, нэгжлэ хийхэд байлцах хүмүүс

137.1. Хураан авах, нэгжлэг хийхэд хөндлөнгийн гэрч, эд зүйл, бичиг баримта хураалгаж байгаа буюу нэгжүүлж байгаа этгээд эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн өмгөөлөгчийн аль нэгийг заавал байлцуулна.

137.2. Аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа орон байранд нэгжлэг хийх, эд зүйл хураан авахад үг байгууллагын төлөөлөгчий байлцуулна.

137.3. Эд зүйлээ хураалгаж буюу нэгжүүлж байгаа этгээд, хөндлөнгийн гэрч, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гүйцэтгэж байгаа бүх ажиллагаанд байлцах бөгөөд тухайн ажиллагааны талаар тэмдэглэлд тусгавал зохих санал, хүсэлт гаргах эрхтэй.

138 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичгийг хурааж авах

138.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хураан авах, нэгжлэг хийх үед олдсон гагцхүү хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг хураан авна.

138.2. Гүйлгээнд оруулахыг хориглосон эд зүйл, баримт бичгийг хэрэгт холбогдолтой эсэхийг үл харгалзан хураана.

138.3. Хурааж авч байгаа эд зүйл, баримт бичгийг хөндлөнгийн гэрч болон бусад байлцсан хүмүүст үзүүлэн, хэрэв шаардлагатай бол уг зүйлийг хураан авсан, нэгжлэг хийсэн газар нь битүүмжилнэ.

139 дүгээр зүйл. Дипломат төлөөлөгчийн албан болон орон байранд нэгжлэг хийх, хураан авах

139.1. Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшиж байгаа албан байр, түүнчлэн дипломат төлөөлөгчийн газрын гишүүн, түүний гэр бүлийн хүмүүсийн сууж байгаа орон байранд нэгжлэг хийх, хураан авах явдлыг дипломат төлөөлөгчийн хүсэлтээр буюу түүний зөвшөөрснөөр хийж болно.

139.2. Хураан авах, нэгжлэг хийх тухай хүсэлтийг дипломат төлөөлөгчөөс Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Улсын

ерөнхий прокурорын газарт тавина.

139.3. Энэ хуулийн 139.1-д заасан ажиллагаа явуулахад прокурор ба Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчийг заавал байлцуулна.

140 дүгээр зүйл. Хураан авсан, нэгжлэг хийсэн, эд хөрөнгө битүүмжилсэн тухай тэмдэглэл

140.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан хураан авсан, нэгжлэг хийсэн, эд хөрөнгө битүүмжилсэн тухай тэмдэглэл үйлдэнэ.

140.2. Хураан авсан буюу битүүмжлэн өгсөн эд зүйл, баримт бичигт тусгай бүртгэл хийсэн байвал түүнийг тэмдэглэлд хавсаргана.

140.3. Хураан авах, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх тухай тэмдэглэлд тухайн ажиллагаа явуулахад байлцсан хүмүүст энэ хуулийн 137.3-т заасан эрхийг тайлбарлан өгсөн тухай ба тэднээс гаргасан хүсэлтийг бичнэ.

140.4. Хураан авсан эд зүйл, баримт бичгийг зохих этгээд сайн дураараа өгсөн буюу албадан гаргуулж авсан, уг зүйлүүд хаанаас ямар байдлаар олдсоныг тэмдэглэлд тусгана.

140.5. Хурааж авсан бүх эд зүйл, баримт бичиг, түүнчлэн бүртгэсэн эд хөрөнгийн тоо чанар, их, бага, хүнд, хөнгөний хэмжээ, нэг бүрийн онцлох шинж тэмдгийг тэмдэглэл буюу түүний хавсралтад нарийвчлан тодорхойлж, бололцоо байвал үнийн дүнг бичнэ.

140.6. Хураан авах, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх үед нэгжүүлж байгаа болон бусад этгээдээс эд зүйл, баримт бичгийг устгах буюу нуухыг оролдсон, эсхүл бусад эсэргүүцэл үзүүлсэн бол тэр тухай болон түүнийг таслан зогсоох талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас ямар арга хэмжээ авсныг тэмдэглэлд тусгана.

141 дүгээр зүйл. Тэмдэглэлийн хуулбарыг гардуулан өгөх

141.1. Тэмдэглэлийн хуулбарыг эд зүйл, баримт бичгээ хураалгасан, нэгжүүлсэн буюу эд хөрөнгөө битүүмжлүүлсэн этгээд, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгчийн аль нэгэнд заавал гардуулан өгч гарын үсэг зуруулна.

141.2. Хураан авах, нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн орон байранд гүйцэтгэсэн бол тэмдэглэлийн хуулбарыг түүний зохих албан тушаалтанд заавал гардуулан өгч гарын үсэг зуруулна.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
Байцаах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, мэдүүлгийг шалгах

142 дугаар зүйл. Байцаалт явуулах газар, цаг хугацаа

142.1. Байцаалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж байгаа газарт явуулах ба шаардлагатай бол байцаагдаж байгаа этгээдийн байгаа газарт явуулж болно.

142.2. Байцаалтыг 4 цагаас илүүгүй хугацаагаар тасралтгүй явуулах ба түүнээс илүү хугацаагаар явуулах бол 1 цагийн завсарлага олгох бөгөөд нэг удаагийн байцаалт нийт 8 цагаас хэтэрч болохгүй.

143 дугаар зүйл. Байцаалтад дуудах

143.1. Гэрч, хохирогч, түүнчлэн гадуур байгаа сэжигтэн, яллагдагчийг зарлан дуудах хуудсаар дуудна.

143.2. Зарлан дуудах хуудсанд хэнийг, ямар зорилгоор, хаана, хэзээ ирүүлэхээр дуудаж байгаа тухай дурдахаас гадна дуудсан хугацаанд ирээгүйн төлөө хүлээлгэх хариуцлагыг тусгасан байна.

143.3. Зарлан дуудах хуудсыг дуудагдаж байгаа этгээдэд, тухайн этгээд байхгүй бол гэр бүлийнх нь насанд хүрсэн аль нэг гишүүнд, түүнийг байхгүй тохиолдолд сум, баг, хорооны Засаг дарга, албан байгууллагынх нь захиргаанд хүлээлгэн өгч гарын үсэг авна.

143.4. Байцаагдах этгээдийг мэдээлэл, холбооны хэрэгслийг ашиглан дуудаж болно.

143.5. Байцаагдах этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд түүнийг энэ хуульд заасны дагуу албадан ирүүлнэ.

143.6. Цагдан хоригдсон этгээдийг байгаа газарт нь, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад ирүүлж байцаана.

143.7. Насанд хүрээгүй гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийг эцэг, эх, түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудна.

144 дүгээр зүйл. Байцаалт явуулах нийтлэг журам

144.1. Байцаалтын эхэнд байцаагдах этгээдийн биеийн байцаалтыг авна.

144.2. Байцаалтад дуудагдсан этгээдэд ямар зорилгоор байцаах гэж байгаар урьдчилан тайлбарлан өгч, эрх, үүргийг нь танилцуулж тэмдэглэлд тусгана.

144.3. Гэрч, хохирогчоор дуудагдан байцаагдаж байгаа этгээдэд санаатай худал мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс зайлсхийвэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан бичгээр сануулна.

144.4. Байцаагдаж байгаа этгээд тухайн хэргийн талаар мэдэх зүйлээ ярихаас байцаалт эхэлнэ.

144.5. Байцаагдаж байгаа этгээд хэргийн талаар ярьж дууссаны дараа түүний мэдүүлгээс тодруулахаар асуулт тавьж болно.

144.6. Байцаагдаж байгаа этгээдийг хөтөлж буюу тулгаж асуухыг хориглоно.

144.7. Байцаагдаж байгаа этгээд тоо болон санахад төвөгтэй бусад зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болох ба тэдгээрийг тэмдэглэлд тусгах буюу хавсаргаж болно.

144.8. Байцаагдаж байгаа этгээдэд эд мөрийн баримт, бичиг баримт, бусад нотлох баримтыг үзүүлэх буюу бусад этгээдээс өгсөн байцаалтын тэмдэглэлийг танилцуулж, тэдгээрийн талаар тайлбар авч болно.

145 дугаар зүйл. Насанд хүрээгүй гэрчийг байцаах

145.1. Насанд хүрээгүй гэрчийг байцаахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгөх ба харин мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахыг хориглоно.

145.2. Насанд хүрээгүй гэрчийг байцаахдаа түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, түүнчлэн суурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч энэ тухай тэмдэглэлд тусгана.

145.3. Байцаалтад оролцож байгаа хүмүүс насанд хүрээгүй гэрчид асуулт тавьж болох боловч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч дээр дурдсан хүмүүсээс тавсан асуултад хариу өгүүлэхгүй байх эрхтэй бөгөөд харин уг асуултыг тэмдэглэлд тусгана.

145.4. Байцаалт дуусмагц мэдүүлэг зөв бичигдсэнийг баталж байцаалтад байсан хүнээр гарын үсэг зуруулна.

146 дугаар зүйл. Байцаалтын тэмдэглэл

146.1. Байцаалтын тэмдэглэлийг энэ хуулийн 153, 202 дугаар зүйлийн шаардлагын дагуу үйлдэнэ.

146.2. Мэдүүлгийг нэгдүгээр бие дээр тавьсан асуулт, хариултын дагуу үгчлэн бичнэ.

146.3. Байцаалт дуусмагц тэмдэглэлийг байцаагдсан этгээдээр уншуулах буюу өөрөө зөвшөөрвөл уншиж өгөх ба тухайн этгээд нэмэлт, засвар оруулахыг шаардвал түүнийг тэмдэглэлд заавал бичнэ.

146.4. Байцаагдсан этгээд мэдүүлгийг өөрөө уншсан, эсхүл түүнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уншиж өгсөн алин болохыг тэмдэглэлд тусгана.

146.5. Байцаагдсан этгээдийн үйлдсэн зураглал, хүснэгт, зургийг хэрэгт хавсаргаж энэ тухай тэмдэглэлд тусгана.

146.6. Байцаагдсан этгээд тэмдэглэлтэй танилцаад мэдүүлэг зөв бичсэнийг баталж энэ тухай тэмдэглэлд гарын үсэг зурна.

146.7. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай байвал байцаагдсан этгээд хуудасны нүүр тус бүрт гарын үсэг зурна.

146.8. Байцаагдсан этгээд хүсвэл түүнд мэдүүлгээ өөрөө бичих бололцоо олгож, энэ тухай тэмдэглэлд тэмдэглэнэ.

146.9. Тэмдэглэлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, байцаалтад байлцсан бусад хүмүүс гарын үсэг зурна.

146.10.Байцаалтыг орчуулагч, хэлмэрчийн оролцоотойгоор явуулсан бол тэмдэглэлийг энэ хуулийн 191 дүгээр зүйлд дурдсан жүрмын дагуу үйлдэнэ.

147 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг байцаах журам

147.1. Гэрч, хохирогчийг байцаахдаа энэ хуулийн 144 дүгээр зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

147.2. Нэг хэрэгт дуудагдсан гэрч, хохирогчийг тус тусад нь байцаах ба өөр хоорондоо харилцахгүй байлгах арга хэмжээ авна.

147.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байцаалт явуулахын өмнө гэрч, хохирогчийн биеийн байцаалтыг шалгаж, түүнд эрх, үүргийг нь тайлбарлан, мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулж, тэмдэглэлд тусган гарын үсэг зуруулна.

147.4. Гэрч, хохирогч нь өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг тэдний байдлыг хүндүүлж болох тухай мэдүүлэг өгехгүй байх эрхтэйг нь тайлбарлан өгөх бөгөөд энэ эрхээ эдлэхгүй гэвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатай худал мэдүүлэг өгвөл хариуцлага хүлээлгэх тухай сануулна.

148 дугаар зүйл. Насанд хүрээгүй хохирогчийг байцаах

148.1.Насанд хүрээгүй хохирогчийг энэ хуулийн 145 дугаар зүйлд заасан журмын дагуу байцаана.

149 дүгээр зүйл. Нүүрэлдүүлэн байцаах

149.1. Гаргасан мэдүүлэгт нь ноцтой зөрөө байвал сэжигтэн, яллагдагчаас бусад урьд байцаагдсан этгээдүүдийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нүүрэлдүүлж байцаах эрхтэй.

149.2. Гэрч, хохирогч, шинжээчийг нүүрэлдүүлж байцаахаас өмнө мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай тэдэнд урьдчилан сануулж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

149.3. Нүүрэлдүүлж байцаах ажиллагааг эхлэхдээ тухайн этгээдүүд бие биеэ таних эсэх, хоорондоо ямар харилцаатай болохыг асуух, дараа нь тодруулах гэж байгаа зүйлийнхээ талаар мэдүүлэг гаргуулж, улмаар байцаагдаж байгаа этгээд тус бүрт асуулт тавьж болно.

149.4. Нүүрэлдэж байгаа этгээдүүд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр бие биедээ асуулт тавьж болно.

149.5. Нүүрэлдүүлж байцаах үед гаргасан мэдүүлэг нь урьдах мэдүүлгээс зөрөөтэй байвал нүүрэлдэх үеийн мэдүүлгийг тэмдэглэлд бичсэний дараа урьд гаргасан мэдүүлгийг үншин сонсгож тайлбар авна.

149.6. Тэмдэглэлд нүүрэлдүүлж байцаасан этгээдүүдийн мэдүүлгийг гаргасан дэс дараалlaар бичих ба байцаагдсан этгээдүүд өөрийн гаргасан мэдүүлгийн хуудасны нүүр тус бүрт гарын үсэг зурна.

150 дугаар зүйл. Таньж олуулах

150.1. Шаардлагатай бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хүн, мал, амьтан, эд зүйлийг гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаар таньж олуулж болно.

150.2. Хүн, мал, амьтан, эд зүйлийг ямар байдалтай байхад үзсэн, ямар шинж тэмдэг, онцлогоор таньж болохыг таньж олох гэж байгаа хүнээс урьдчилан асууж энэ тухай тэмдэглэлийн эхэнд тусгана.

151 дүгээр зүйл. Таньж олуулах журам

151.1. Танигдах гэж байгаа этгээдийг түүнтэй гаднах байдлаараа адил төстэй гурваас доошгүй бусад хүмүүсийн хамтаар таньж олох гэж байгаа хүнд харуулна.

151.2. Таньж олуулахын өмнө танигдах гэж байгаа этгээдийг бусад хүмүүсийн дотор дуртай байрлалаа эзлэхийг хэлж, тэмдэглэлд тусгана.

151.3. Уг хүнийг биеэр харуулах бололцоогүй байвал түүний гэрэл зургийг гурваас доошгүй гэрэл зургийн дотроос таньж олуулж болно.

151.4. Таниулах мал, амьтан, эд зүйлийг бусад адил төрлийн мал, амьтан, эд зүйлийн хамт үзүүлнэ.

151.5. Таньж олох гэж байгаа хүн нь гэрч буюу хохирогч байвал тэдэнд мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай урьдчилан сануулж, тэмдэглэлд тусгана.

151.6. Мэдүүлэгтээ дурдсан хүн, мал, амьтан, эд зүйлийг зааж өгөхийг таньж олох гэж байгаа хүнээс шаардах бөгөөд ингэхдээ бусдыг ялгаварлан гадуурхах, хүний хэтлэх буюу сануулах асуулт тавихыг хориглоно.

151.7. Таньж олох гэж байгаа хүн харуулсан хүн, мал, амьтан, эд зүйлийн аль нэгийг мөн гэж заавал ямар шинж тэмдэг, онцлогоор нь таньсаныг тайлбарлуулж тэмдэглэлд тусгана.

151.8. Таньж олуулах ажиллагаанд хөндлөнгийн 2-оос доошгүй гэрч байлцуулна.

151.9. Таньж олох гэж байгаа этгээд өөрөө хүсвэл танигдаж байгаа хүнд мэдэгдэхгүйгээр таньж олох боломж олгоно.

152 дугаар зүйл. Таньж олуулах

ажиллагааны тэмдэглэл

152.1. Таньж олуулах ажиллагааны тэмдэглэлийг энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу үйлдэнэ.

152.2. Тэмдэглэлд таньж олох гэж байгаа хүний биеийн байцаалт, таниулж байгаа хүн, мал, амьтан, эд зүйлийн тухай болон таньж олж байгаа этгээдийн мэдүүлгийг дэс дараалаар нь үгчлэн бичнэ.

153 дугаар зүйл. Мэдүүлгийг газар дээр нь шалгах

153.1. Шинэ нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгахын тулд, түүнчлэн урьд өгсөн мэдүүлгийнь үнэн зөвийг харьцуулан тогтоохын тулд сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогчийн өгсөн мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно.

153.2. Энэ хуулийн 153.1-д заасан ажиллагааны үед мэдүүлгээ шалгуулж байгаа этгээд нь хэрэгтэй ач холбогдол бүхий зарим тухайлсан зүйл, бичиг баримт, үл мөрийг зааж, тодорхой үйлдлийг хийж үзүүлэх, шинжлэн судлаж байгаа үйл баримтад аль нэгэн зүйл ямар үүрэгтэй байсан, үйл явдал болсон газрын байдал яаж өөрчлөгдсөн тухай зааж урьд өгсөн мэдүүлгээ газар дээр нь тодорхой болгон дэлгэрүүлэн тайлбарлана.

153.3. Мэдүүлгийг газар дээр нь шалгаж байхад хөндлөнгөөс оролцох, хөтлөх буюу сануулах асуулт тавихыг хориглоно.

153.4. Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаанд хөндлөнгийн 2 гэрч, шаардлагатай бол мэргэжилтнийг оролцуулан гүйцэтгэнэ.

153.5. Нэг дор, нэг газар дээр, хэд хэдэн этгээдийн мэдүүлгийг нэгэн зэрэг газар дээр нь шалгахыг хориглоно.

153.6. Мэдүүлгийг үндэслэн, эсхүл өөрийн болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн санаачилгаар мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа хийнэ.

153.7. Мэдүүлгээ шалгуулж байгаа этгээдээс эхэлж чөлөөтэйгээр ярьж, үйлдлээ үзүүлсний дараа асуулт тавьж болно.

153.8. Мэдүүлгийг газар дээр нь шалгах үед гэрэл зураг авах, соронзон болон дүрс бичлэг, зураглал, хэмжилт хийж тэмдэглэлд тусгаж болно.

153.9. Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааны үед энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу тэмдэглэл үйлдэнэ.

154 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзах, гарын үсэг зурах боломжгүй байдлыг батлах

154.1. Сэжигтэн, яллагдагч, гэрч, болон бусад этгээд байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай тусгайлан тэмдэглэл хийж гарын үсэг зурна.

154.2. Гарын үсгээ зурахаас татгалзаж байгаа этгээдэд татгалзсан үндэслэлээ тайлбарлах боломж олгох ба энэхүү тайлбарыг тэмдэглэлд тусгаж өөрөөр нь гарын үсэг зуруулна.

154.3. Сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч нь бие эрхтний согог болон эрүүл мэндийн бусад шалтгаанаар тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гадны бусад хүнийг урин ирүүлж байцаагдсан этгээдийн зөвшөөрснөөр нэрийн өмнөөс нь тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

154.4. Хөндлөнгийн гэрч, бусад этгээд оролцсон байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал тэдгээр нь тусгайлсан тэмдэглэлд нэг адил гарын үсэг зурна.

ХОРЬДУГААР БҮЛЭГ
Шинжилгээ хийх

155 дугаар зүйл. Шинжилгээ хийлгэх журам

155.1. Шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэр тухай тогтоол гаргаж, түүндээ шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжээчийн нэр, шинжилгээ хийх хугацаа, шинжээчид тавих асуулт, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн зүй зүйлийг тодорхойлон бичнэ.

155.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид шинжилгээ хийлгэх тухай тогтоолыг танилцуулж, энэ хуулийн 157 дугаар зүйлд заасан эрхийг нь тайлбарлаж өгөх ба энэ тухай тэмдэглэл үйлдэж, өөрөө болон холбогдох этгээдээр гарын үсэг зуруулна.

155.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шинжилгээ хийх үед байлцах

рхтэй.

155.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч этгэцийн өвчний улмаас байдлыг ойлгох чадваргүй байгаа бол шүүх сэтгэцийн шинжилгээ хийлгэх тухай гогоол, шинжээчийн дүгнэлтийг түүнд анилцуулахгүй байж болно.

155.5. Хууль хэрэглэх, хуулийн зүйл, хэсэг, аалтыг тайлбарлуулах асуудлаар шинжээч омилохыг хориглоно.

156 дугаар зүйл. Шинжилгээ заавал хийлгэх

156.1. Дор дурдсан тохиолдолд шинжилгээ заавал хийлгэнэ :

156.1.1. гадны нөлөөллөөр буюу сэжигтэй байдлаар нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;

156.1.2. бие махбодид учирсан гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоох;

156.1.3. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэргийнхээ үйлдлийг тайлбарлах, түүнийг хариуцах чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

156.1.4. гэрч, хохирогч нь хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитойгоор тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

156.1.5. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай баримт бичиг байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох явдал хэрэгт ач холбогдолтой байвал;

156.1.6. онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох.

157 дугаар зүйл. Шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх

157.1. Шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч дор дурдсан эрх эдэлнэ:

157.1.1. шинжээчийг татгалзан гаргах хүсэлт гаргах;

157.1.2. шинжээчид нэмэлт асуулт тавих;

157.1.3. шинжээчид нэмэлт баримт бичиг өгөх, тэр талаар тайлбар гаргах;

157.1.4.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрөлтэйгээр шинжилгээ хийхэд байлцах;

157.1.5. шинжээчийн дүгнэлттэй танилцах.

157.2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн энэ хуулийн 157.1-д заасан хүсэлтийг хангах нь үндэслэлтэй гэж үзвэл шинжээч томилсон тогтоолыг өөрчлөх, түүнд нэмэлт оруулж болно.

157.3. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол тэр тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж, түүнийгээ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчид сонсгон гарын үсэг зуруулна.

158 дугаар зүйл. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх

158.1. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжээчийг өөрөө томилох бөгөөд шинжилгээний байгууллага нь шинжээчийн ажилласан байдал, мэргэшсэн чиглэлийг дурдсан нэрсийн жагсаалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон, шүүх, прокурорын байгууллагад урьдчилан хүргүүлсэн байна.

158.2. Шинжилгээ хийлгэж байгаа этгээд нь шинжээчид энэ хуулийн 46 дугаар зүйлд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгч, дүгнэлт гаргахаас татгалзах буюу зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргавал түүнд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

159 дүгээр зүйл. Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх

159.1. Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжээч томилох эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол гаргасны дараа шинжилгээ хийхээр томилогдож байгаа шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой мэргэжил харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана.

159.2. Энэ хуулийн 159.1-д заасан ажиллагаа явуулсны эцэст харшлах шалтгаан байхгүй гэж үзвэл шинжээчид шинжилгээ хийлгэх тухай тогтоолыг гардуулан өгч, түүнд энэ хуулийн 46 дугаар зүйлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулж, тогтоолд гарын үсэг зуруулна.

159.3. Шинжээч шинжилгээний явцад ямар нэгэн хүсэлт гаргавал түүнийг томилсон этгээд энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу

тэмдэглэл үйлдэх үүрэгтэй.

160 дугаар зүйл. Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах

160.1. Хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх харьцуулан шинжлэхэд шаардлагатай гарын үсгийн буюу бусад хэв, хэлбэрийг сэжигтэн, яллагдагчаас авах эрхтэй ба энэ тухай тогтоол гаргана.

160.2. Гэмт хэрэг гарсан газар, эсхүл эд мөрийн баримтад гэрч, хохирогчийн үл мөр үлдсэн байж болзошгүй үндэслэл байвал харьцуулан шинжлэхээр тэдгээс гарын үсгийн болон бусад хэв, хэлбэр авч болно.

160.3. Хэв, хэлбэр авах ажиллагаат шаардлагатай бол үр хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтнийг оролцуулан гүйцэтгэж болно.

160.4. Хэв, хэлбэр авах ажиллагааны тэмдэглэлийг энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу үйлдэнэ.

161 дүгээр зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эмнэлгийн байгууллагад шилжүүлэх

161.1. Шүүх-эмнэлгийн, эсхүл сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргахын тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг тодорхой хугацаанд эмнэлэгт байлгаж ажиглалт хийх шаардлагатай бол шинжээч томилох эрх бүхий этгээд энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж хэрэгжүүлнэ.

161.2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй сэжигтэн, яллагдагчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт шилжүүлэх бол прокурорын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

161.3. Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оролцуулан тооцно.

162 дугаар зүйл. Шинжээчийн дүгнэлтийн агуулга

162.1. Шинжээч зохих шинжилгээ хийсний дараа дүгнэлт гаргана.

162.2. Дүгнэлтэд шинжилгээг хэзээ, хаана, хэн, /овог, нэр, боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол, албан тушаал/ юуг үндэслэж хийсэн, шинжилгээ хийхэд хэн байлцсан, шинжээч ямар эд зүйл ашигласан, ямар шинжилгээ хийсэн, шинжээчид ямар асуулт тавигдсан, түүнд өгсөн хариулт, түүний үндэслэлийг асуулт тус бүрээр бичнэ.

162.3. Шинжилгээ хийж байх үед шинжээч үг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй ч байсан өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй.

162.4. Дүгнэлтийг бичгээр гаргаж шинжээч гарын үсэг зурах ба хэд хэдэн шинжээч дүгнэлт гаргахад оролцож нэгдсэн саналд хүрсэн бол нэг дүгнэлтэд, санал зөрсөн бол саналаа дүгнэлтэд хавсаргана.

163 дугаар зүйл. Шинжээчийг байцаах

163.1. Хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх гаргасан дүгнэлтийг нь тайлбарлуулах буюу тодруулах зорилгоор шинжээчийг байцааж болно.

163.2. Шинжээч хариултыг өөрөө бичиж өгөх эрхтэй ба түүнийг байцаасан тэмдэглэлийг энэ хуулийн 146, 202 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэнэ.

164 дүгээр зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид шинжээчийн дүгнэлтийг танилцуулах

164.1. Шинжээчийн дүгнэлт, эсхүл дүгнэлт гаргах боломжгүйг мэдэгдсэн түүний тайлбар, түүнчлэн шинжээчийг байцаасан тэмдэглэлийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид танилцуулах бөгөөд тэдгээр нь дүгнэлт, тайлбарыг татгалзах, тайлбар өгөх, түүнчлэн шинжээчид асуулт тавих, нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэхийг хүсэх эрхтэй.

164.2. Шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлгийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид танилцуулсан болон энэ үед тэдгээрээс тавсан асуудал, түүнчлэн эрх, үүргийг нь тайлбарласан тухайг тэдний байцаасан тэмдэглэлд тусгана.

165 дугаар зүйл. Нэмэлт ба дахин шинжилгээ хийх

165.1. Дүгнэлт тодорхойгүй буюу бүрэн биш, эсхүл шинжлэн судалсан асуудалтай холбогдсон шинэ зүйлийн талаар шинжилгээ хийлгэх нөхцөл байдал бий болбол нэмж шинжилгээ хийлгэхээр уг шинжээч буюу өөр шинжээчид даалгаж болно.

165.2. Шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй буюу зөв болох нь эргэлзээтэй байвал дахин шинжилгээ хийлгэхээр өөр шинжээчид даалгаж болно.

165.3. Энэ хуулийн 165.1, 165.2-т зааснаар нэмэлт ба дахин шинжилгээ хийхэд энэ хуулийн 155-157, 160, 162 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

НАЙМДУГААР ХЭСЭГ
ШҮҮХИЙН ӨМНӨХ БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл

166 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл

166.1. Дараахь үндэслэлийн аль нэг нь байгаа бөгөөд байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал үүсээгүй, гэмт хэрэг гарсныг хангалттай нотлох баримт байвал эрүүгийн хэрэг үүсгэнэ:

166.1.1. гэмт хэрэг гарсан талаар иргэн гомдол гаргасан буюу мэдээлсэн;

166.1.2. гэмт хэрэг гарсан талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн;

166.1.3. гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн;

166.1.4. хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг өөрсдөө шууд илрүүлсэн;

166.1.5.гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримт байгаа.

167 дугаар зүйл. Иргэн гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл гаргах

167.1. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг иргэн амаар буюу бичгээр гаргаж болно.

167.2. Амаар шууд буюу холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан гаргасан гомдлыг тэмдэглэл үйлдэж хүлээн авах бөгөөд түүнд тэмдэглэл үйлдсэн хүн гарын үсэг зурна.

167.3. Бичгээр гаргасан гомдолд гомдол гаргагч гарын үсэг зурсан байна.

167.4. Санаатайгаар худал мэдээлбэл хүлээлгэх хариуцлагын талаар гомдол гаргагчид тайлбарлан өгч, энэ тухайгаа тэмдэглэлд тусган гомдол гаргагчаар гарын үсэг зуруулна.

168 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх

168.1. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан гэмт хэргийн талаархи мэдээллийг бичгээр өгөх бөгөөд түүнд холбогдох баримт, материалыг хавсаргах болно.

169 дүгээр зүйл. Хэргээ илчлэн мэдээлэх

169.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн хэргээ сайн дурарааг хүлээсэн мэдээллийг бичгээр болон амаар гаргаж болно.

170 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг заавал хүлээж авах

170.1. Гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хэрэг буртгэх, мөрдөн байцаах албаны дарга, эсхүл хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь заавал хүлээн авах үүрэгтэй.

170.2. Мэдээллийг хүлээн авахдаа санаатайгаар худал мэдээлбэл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхийг мэдээлэл өгөгчид сануулна.

170.3. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас хууль бусаар татгалзсан тохиолдолд энэ хуулийн 107 дугаар зүйлд заасан журмын дагуу прокурорт гомдол гаргаж болно.

171 дүгээр зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол , мэдээллийг хянан үзэх хугацаа

171.1. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

171.2. Нэмэлт тайлбар, баримт бичиг, бусад материал гаргуулж авах, хэргийн газарт үзлэг хийх шаардлагатай бол энэхүү хугацааг хэрэг буртгэх, мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгаж болно.

172 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гаргах шийдвэр

172.1. Гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хянан үзсэн болон гэмт хэргийн шинж тэмдгийг шууд өөрөө илрүүлсэн тохиолдол бүрт хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч, прокурор дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ:

172.1.1. эрүүгийн хэрэг үүсгэх;

172.1.2. эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргах, татгалзах;

172.1.3. гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлэх.

172.2. Гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлэх тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэргийг таслан зогсоох болон гэмт хэргийн үл мөрийг бэхжүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

172.3. Гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаагийн байгууллагын ажилтан эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхийн тулд дараахь хойшлуулшгүй ажиллагаа явуулж болно:

172.3.1. хүний нэр хаягийг тодруулах зорилгоор баримт бичгийг үзэж шалгах;

172.3.2. хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх;

172.3.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх;

172.3.4. хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгслийг саатуулах, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хураж авах;

172.3.5. шүүх эмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хуруугын хээ, ул мөрний хэв авах;

172.3.6. иргэн, албан тушаалтнаас тайлбар гаргуулах;

172.3.7. нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох;

172.3.8. гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгуллага, иргэний орон байранд нэвтрэн орох;

172.3.9. согтуурууулах ундаа, мансуурууулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах;

172.3.10.гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийг энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан үндэслэлээр баривчлах.

172.4. Энэ хуулийн 172.3.2, 172.3.5, 172.3.8-д заасан ажиллагааг гагцхүү энэ хуульд заасан журмаар явуулна.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн хэрэг үүсгэх журам

173 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх журам

173.1. Энэ хуулийн 166 дугаар зүйлд заасан эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, энэ тухай тогтоол гаргана.

173.2. Тогтоолд гэмт хэргийг хэзээ, хаана үйлдсэн, ямар хэрэг үйлдэгдсэн, хэрэг үүсгэсэн үндэслэл, Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн, түүнчлэн уг хэргийг цааш хэрхэх тухай заана.

173.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэсэн бол тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулж, эрүүгийн хэргийн дугаар авна.

173.4. Эрүүгийн хэрэг үүсгэхийн зэрэгцээгээр гэмт хэргийг таслан зогсоох, түүнчлэн гэмт хэргийн үл мөрийг хамгаалж, хойшлуулшгүй ажиллагаа явуулна.

174 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэсний дараа явуулах ажиллагаа

174.1. Эрүүгийн хэрэг үүсгэх тухай тогтоол гаргасны дараа дараахь ажиллагаа явуулна:

174.1.1 прокурор хэргийг бүртгэн, эрүүгийн хэргийн дугаар олгож хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын аль нэгэнд мөрдүүлэхээр харъяаллын дагуу шилжүүлэх;

174.1.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага байцаан шийтгэх ажиллагаа явуулж эхлэх.

175 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах

175.1. Гомдол, мэдээллийг хянах явцад эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байхгүй, эсхүл байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргана.

175.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай саналаа бичгээр гаргаж, хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.

175.3. Эрүүгийн хэрэг үүсгэхийг татгалзсан

гоггоолыг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй.

176 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд тавих хяналт

176.1. Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд прокурор хяналт тавина.

176.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хууль зүйн үндэслэл, баримтгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн байвал прокурор өөрийн гоггоолоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гоггоолыг хүчингүй болгох буюу хэрэв байцаан шийтгэх ажиллагаа хийгдсэн байвал хэргийг хэрэгсэхгүй болгоно.

176.3. Эрүүгийн хэрэг үүсгэхийг үндэслэлгүйгээр татгалзсан байвал дээд шатны прокурор өөрийн гоггоолоор уг гоггоолыг хүчингүй болгож, эрүүгийн хэрэг үүсгэн харъяаллын дагуу шилжүүлнэ.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ
Хэрэг бүртгэлтийн ажиллагаа

177 дугаар зүйл. Хэрэг бүртгэх ажиллагаа явуулах

177.1. Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр хэрэгт хэрэг бүртгэгч энэ хуульд заасан харъяаллын дагуу хэрэг бүртгэлт явуулна.

177.2. Тухайн хэрэг мөрдөн байцаалтын, эсхүл хэрэг бүртгэх өөр албаны харъяалалтай бол нэн яаралтай харъяаллын дагуу шилжүүлнэ.

178 дугаар зүйл. Хэрэг бүртгэх ажиллагааг явуулах хугацаа

178.1. Хэрэг бүртгэх ажиллагааг дараахь хугацааны явуулна:

178.1.1. хөнгөн гэмт хэрэгт 14 хоног;

178.1.2. хүндэвтэр гэмт хэрэгт 30 хоног.

178.2. Хэрэг бүртгэлтийн нэмэлт ажиллагаа хийх зайлшгүй шаардлага гарвал прокурор хугацаог 15 хоног хүртэл сунгана.

178.3. Шүүхээс хэргийг хэрэг бүртгэлтэд буцаасан тохиолдолд прокурор нэмэлт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах хугацааг 15 хоногийн хугацаагаар гоггооно.

179 дүгээр зүйл. Хэрэг бүртгэх ажиллагааг дуусгах

179.1. Хэрэг бүртгэх ажиллагааг явуулж дууссаны дараа хэрэг бүртгэгч хэргийг прокурорт шилжүүлэх тухай гоггоол үйлдэх ба түүнд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдийн тухай болон хэрэг бүртгэлтийн үед гоггоогдсон бусад нөхцөл байдлыг тусгана.

179.2. Хэргийг прокурорт шилжүүлэх үед энэ хуулийн есдүгээр бүлэгт заасан жүрмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

179.3. Хэргийг иргэд, байгууллагын гомдол, мэдээллээр үүсгэсэн бол хэрэг бүртгэх ажиллагааг дуусгаж, хэргийг прокурорт шилжүүлсэн тухай тэдэнд мэдэгдэнэ.

ХОРИН ДӨРӨВДУГЭЭР БҮЛЭГ
Мөрдөн байцаалт явуулах

180 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах газар

180.1. Мөрдөн байцаалтыг уг гэмт хэрэг гарсан газар явуулна.

180.2.Мөрдөн байцаалтыг түргэн шуурхай, бүрэн гүйцэд хийхийн тулд гэмт хэрэг илэрсэн буюу сэжигтэн, яллагдагч болон гэрч, хохирогчийн олонхи байгаа газарт мөрдөн байцаалт явуулж болно.

180.3. Мөрдөн байцаагч уг хэрэг харъяаллын биш болохыг гоггоомогц байцаан шийтгэх хойшлуулшгүй ажиллагааг гүйцэтгэж, хэргийг харъяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт явуулна.

180.4 Хэргийн харъяаллын тухай асуудлыг мөрдөн байцаалт эхэлсэн газрын прокурор шийдвэрлэнэ.

180.5. Өөр газарт байцаан шийтгэх болон эрэн сурвалжлах тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол мөрдөн байцаагч өөрөө, эсхүл тухайн газрыг харьяалах хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад даалгавар өгч гүйцэтгүүлэх эрхтэй бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан заасан хугацаанд нь заавал биелүүлэх үүрэгтэй.

181 дүгээр зүйл. Мөрдөн байцаалтыг эхлэх

181.1. Мөрдөн байцаалтыг гагцхүү эрүүгийн хэрэг үүсгэсний дараа энэ хуульд заасан журмаар явуулна.

181.2. Мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хүлээж авсны дараа мөрдөн байцаах ажиллагаат нэн даруй эхлэх үүрэгтэй бөгөөд мөрдөн байцаалт явуулах тухай тогтоол үйлдэнэ.

181.3. Эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаалт явуулах ажиллагаа нэгэн зэрэг хийгдэж байгаа бол энэ тухай нэг тогтоол гаргана.

182 дугаар зүйл. Мөрдөн байцаалт явуулах хугацаа

182.1. Мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар байна.

182.2. Энэ хуулийн 182.1-д заасан хугацаат эрүүгийн хэрэг үүсгэснээс эхлэн хэргийг прокурорт шилжүүлэх, эсхүл хэрэгсэхгүй болгох хүртэлх үеийг оролцуулан тоолно.

182.3. Энэ хуульд заасан журмын дагуу хэргийг түдгэлзүүлсэн хугацаа нь мөрдөн байцаалт явуулах хугацаанд тооцогдохгүй.

182.4. Тухайн хэрэг нь олон сэжигтэн, яллагдагчтай буюу олон үйлдэлтэй, эсхүл алслагдсан газарт шалгалт хийх шаардлагатай, түүнчлэн шүүх - няггүлан бодох бүртгэлийн болон бусад нарийн төвөгтэй шинжилгээ хийх, дахин болон нэмэлт шинжилгээ хийлгүүлэх зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацаат цаашид хэрэгт хяналт тавьж байгаа прокурор 2 сар хүртэл, сум буюу сум дундын, дүүргийн ахлах прокурор, дагнасан прокурорын орлогч 5 сар хүртэл, аймаг, нийслэлийн болон дагнасан прокурор 9 сар хүртэл, Улсын ерөнхий прокурорын туслах, орлогч тус бүр 3 сар хүртэл хугацаагаар нэмж сунгана. Хэргийн мөрдөн байцаалтын хугацаат цаашид сунгах асуудлыг Улсын ерөнхий прокурор шийдвэрлэнэ.

182.5. Прокурор мөрдөн байцаалт явуулах хугацаат сунгахдаа урьдах хугацаанд хийгдсэн ажиллагаа, хугацаа сунгах үндэслэл, цаашид хийх байцаан шийтгэх ажиллагаат харгалзана.

182.6. Шүүхээс нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцаасан, түүнчлэн тэдгэлзүүлсэн буюу хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн бол мөрдөн байцаалт явуулах хугацааг уг ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор 1 сар хүртэл хугацаагаар тогтоож, цаашид сунгах асуудлыг ердийн журмаар гүйцэтгэнэ.

182.7. Мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж, хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө зохих прокурорт явуулна.

183 дугаар зүйл. Мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах

183.1. Ээдрээ төвөгтэй болон ихээхэн хэмжээний ажиллагаа бүхий хэргийн мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулж болох ба түүнийг мөрдөн байцаах албаны дарга томилж тогтоол гаргана.

183.2. Тогтоолд бүх мөрдөн байцаагчид, түүний дотор хэсгийн ахлагч- мөрдөн байцаагчийг томилсон тухай заана.

183.3. Тогтоолыг сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах ба тэдгээр нь аль ч мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй.

184 дүгээр зүйл. Мөрдөн байцаалтын хэсгийн ахлагч-мөрдөн байцаагчийн эрх, үүрэг

184.1. Мөрдөн байцаалтын хэсгийн ахлагч-мөрдөн байцаагч нь хэргийг өөрийн ажиллагаанд авч мөрдөн байцаалтын хэсгийн ажлыг зохион байгуулах ба бусад мөрдөн байцаагчийн ажиллагааг удирдана.

184.2. Хэргийг нэгтгэх, тусгаарлах, тэдгэлзүүлэх, сэргээх, хэрэгсэхгүй болгох, тэрчлэн мөрдөн байцаалтын хугацаат сунгах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг зөвхөн хэсгийн ахлагч гаргана.

184.3. Яллах дүгнэлт үйлдүүлэх болон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авахуулахаар прокурорт шилжүүлэх тухай тогтоолыг зөвхөн хэсгийн ахлагч үйлдэнэ.

184.4. Хэсгийн ахлагч өөрөө бие даан болон бусад мөрдөн байцаагчтай хамтран мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах болон хэргийн талаар шийдвэр гаргах эрхтэй.

185 дугаар зүйл. Мөрдөн байцаалтыг дуусгах

185.1. Мөрдөн байцаагч яллагдагчид яллах дүгнэлт үйлдүүлэхээр саналыг прокурорт тавьсан, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргасныг мөрдөн байцаалт дуусгавар болно.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ерөнхий нөхцөл

186 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах нийтлэг журам

186.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд шөнийн цагаар явуулахыг хориглоно.

186.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахдаа гэмт хэргийн ул мөрийг илрүүлэх, түүнийг буулган авах, бэхжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэл бүхий арга, техник хэрэгслийг ашиглаж болно.

186.3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахдаа хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон бусад хууль бус арга хэрэгсэл хэрэглэх, түүнчлэн оролцогчийн амь насанд аюултай байдал бий болгохыг хориглоно.

187 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид эрхийг нь заавал тайлбарлан өгөх ба түүнийг хангах

187.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогч бусад этгээдэд тэдгээрийн эрх, үүрэг болон үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагааны явцад эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

188 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах

188.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх сэжигтэн, яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

188.1.1. баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн асрах хүнгүй бага насны хүүхэд, өндөр настай эцэг, эх болон бусад асруулагчийг харгалзан дэмжүүлэхээр төрөл садны буюу бусад хүмүүст, эсхүл зохих байгууллагад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шилжүүлэн өгөх;

188.1.2. баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эзэнгүй үлдсэн эд хөрөнгө, орон сууцыг хамгаалуулах арга хэмжээ авах.

188.2. Энэ хуулийн 188.1-д заасны дагуу авагдсан арга хэмжээг цагдан хоригдсон этгээдэд мэдэгдэнэ.

189 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг задруулахыг хориглох

189.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно.

189.2. Шаардлагатай үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг задруулж болохгүй тухай гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч, мөрдөн байцаалт явуулахад байлцсан бусад хүмүүст урьдчилан мэдэгдэж, хэрэв үүнийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэхийг сануулж тэднээс гарын үсэг авна.

190 дүгээр зүйл. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ

190.1. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана.

190.2. Хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй.

191 дүгээр зүйл. Орчуулагч, хэлмэрчийг оролцуулах

191.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан тохиолдолд мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахдаа орчуулагч, хэлмэрчийг оролцуулна.

191.2. Орчуулагч, хэлмэрчид түүний эрх, үүргийг тайлбарлан санаатайгаар худал орчуулах буюу хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэр тухайгаа мөрдөн байцаалтын зохих ажиллагаа явуулсан тэмдэглэлд тэмдэглэж, орчуулагч, хэлмэрчээр гарын үсэг зуруулна.

192 дугаар зүйл. Хөндлөнгийн гэрчийг оролцуулах

192.1. Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах, түүнчлэн энэ хуульд хөндлөнгийн гэрч оролцуулахаар заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бусад ажиллагаа явуулахад 2-оос доошгүй хөндлөнгийн гэрчийг заавал оролцуулна.

192.2. Хөндлөнгийн гэрчүүдийн оролцоотойгоор хийгдвэл зохих хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдахын өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан тэдний эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

192.3. Хөндлөнгийн гэрч өөрийнхөө оролцоотойгоор хийгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдсан байдал, түүний агуулга, дүнг баталж өгөх үүрэгтэй.

192.4. Хөндлөнгийн гэрч өөрийнхөө оролцоотойгоор хийгдсэн ажиллагааны талаар тэмдэглэлд засвар оруулахыг шаардах эрхтэй.

193 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх

193.1. Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль хэрхэн биелж байгаад хяналт тавихдаа прокурор дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

193.1.1. эрүүгийн хэрэг үүсгэсэн нь хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянаж үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж үзвэл тогтоолыг хүчингүй болгох;

193.1.2.гэмт хэргийн шинж тэмдгийг өөрөө илрүүлсэн бол эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргаж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах;

193.1.3. гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалган шийдвэрлэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;

193.1.4. хэргийн оролцогч гомдол, хүсэлт гаргасан бол түүнийг хянан шийдвэрлэхийн тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгаа хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагаас татаж хянах, үүний үндсэн дээр байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах даалгаврыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид өгч биелэлтэд хяналт тавих;

193.1.5. гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор хийгдэж байга гүйцэтгэх ажилд хууль тогтоомжоор олгосон бүрэ эрхийн хүрээнд хяналт тавих;

193.1.6. шаардлагатай гэж үзвэ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас байцаа шийтгэх тодорхой ажиллагаа явуулахад биечлэ оролцох;

193.1.7. энэ хуульд заасны дагу мөрдөн шалгах ажиллагаа явуулах;

193.1.8. энэ хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаа явуулах байцаан шийтгэх тодорхой ажиллагаань зөвшөөрлийг өгөх;

193.1.9. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацааг сунгах;

193.1.10. сэжигтэн, яллагдагчий хорьж мөрдөх, уг хугацааг сунгах саналыг шүүхэд тавих;

193.1.11.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, доод шатны прокурорыг татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх;

193.1.12. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажиллагаа, шийдвэрийн талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

193.1.13. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулийн шаардлагыг биелүүлэх талаар бичгээр заалт өгч хэргийг буцаах;

193.1.14. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх, хэрэгсэхгүй болгох талаар гарсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг шийдвэрлэх;

193.1.15. эрүүгийн хэрэг үндэслэлгүйгээр үүсгэсэн, нэгтгэсэн, тусгаарласан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож цаашид хэрхэхийг шийдвэрлэх;

193.1.16 энэ хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг батлах;

193.1.17. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, доод шатны прокурорын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох;

193.1.18. нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаах;

193.1.19. хэрэг бүртгэлт, мөрдөн

йцаалтын ажиллагааны үед хууль зөрчсөн хэрэг
ртэгч, мөрдөн байцаагчийг тухайн хэргийг цаашид
рдүүлэхийг зогсоох;

193.1.20. хэргийг шүүхэд шилжүүлэх;

193.1.21. хэрэг бүртгэлт, мөрдөн
йцаалтын болон хяналтын ажилд шаардлагатай
здээ судалгаа, баримт бичгийг аль ч байгуллага,
ибан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах,
ізар дээр нь танилцах, мэргэжлийн дүгнэлт
згадлагаа гаргуулах;

193.1.22. хэрэг бүртгэлт, мөрдөн
айцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн
рэгжиж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд
здгээрийн ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн
алгах, шаардлагатай хэрэг материалыг татаж
янах;

193.1.23. хэрэг бүртгэлт, мөрдөн
айцаалтын хэвийн ажиллагаат хангах, уг
жиллагаанд илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулах
алаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах
айгууллагын захиргаанд шаардлага тавих;

193.1.24. хэрэг бүртгэлт, мөрдөн
айцаалт явуулах байгууллагын захиргааналх хэрэг
үртэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар
эргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа
сэхийг хянах, зөрчсөн тушаал шийдвэрт
сэргүүцэл бичих;

193.1.25. хэрэг шалгах харьяалал
эгтоох;

193.1.26. эрүүгийн хэргийн хавтаст
эргийг архивт хадгалах;

193.1.27. энэ хуульд заасан бусад бүрэн
рх.

194 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн
айцаалтын ажиллагаанд хяналт тавьж байгаа
рокурорын шийдвэрийг заавал биелүүлэх

194.1. Энэ хуульд заасан журмын дагуу өгсөн прокурорын шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч заавал биелүүлэх үүрэгтэй.

194.2. Прокурорын шийдвэрийн талаар дээд шатны прокурорт гаргасан гомдол нь энэ хуулийн 28.2.13 -д заасснаас бусад тохиолдолд түүнийг биелүүлэх явдлыг зогсоохгүй.

195 дугаар зүйл. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах

195.1. Энэ хуулийн 357.1.1, 357.1.2-т заасан нөхцөл байдал илэрсэн, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих явцад хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэргэлээтэй, мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа хуульд заасан үндэслэлээр, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийг биечлэн байцаах, шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилтыг давтан хийх зэргээр мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

195.2. Мөрдөн шалгах ажиллагаат хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын аль ч шатанд явуулж болно.

195.3. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй; хуулийгноцтойгоор зөрчсөн нь тогтоогдвол тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоож, өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид хэргийг шилжүүлэхийг хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад даалгах ба түүнийг заавал биелүүлнэ.

195.4. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийг үндэслэлгүйгээр түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон нь тогтоогдвол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад шилжүүлнэ.

195.5. Прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан бүхий л нотлох баримтыг хэрэгт хавсаргана.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Яллагдагчаар татах, яллагдагчийг байцаах

196 дугаар зүйл. Яллагдагчаар татах

196.1. Тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэнэ.

196.2. Яллагдагчаар татах тухай тогтоолд уг тогтоолыг хэзээ, хаана, хэн үйлдсэн, яллагдагчаар татагдаж байгаа этгээдийн овог, эцгийн нэр, нэр, уг этгээд Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт заасан хэрэгт яллагдаж байгаа, уг хэргийг хэзээ, хаана үйлдсэн болон бусад ямар байдал тогтоогдсоныг бичнэ.

196.3. Яллагдагч нь Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйлд заагдсан гэмт хэрэгт яллагдаж байгаа бол яллагдагчаар татах тухай тогтоолд яллагдагч ямар тодорхой хэргүүдэд яллагдаж байгаар Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг нэг

бүрээр заана.

197 дугаар зүйл. Яллагдагчийг дуудах

197.1. Гадуур байгаа яллагдагч нь дуудсан цагт ирэх үүрэгтэй.

197.2. Яллагдагчийг энэ хуулийн 198 дугаар зүйлд заасан журмаар дуудан ирүүлнэ.

197.3. Яллагдагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлнэ.

197.4. Яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан, оршин суух тодорхой хаяггүй бол түүнийг урьдчилан дуудахгүйгээр албадан ирүүлж болно.

197.5. Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд яллагдагчийг шөнийн цагт албадан ирүүлж болохгүй.

198 дугаар зүйл. Яллагдагчийг дуудах журам

198.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч яллагдагчийг зарлан дуудах хуудсаар дуудна.

198.2. Зарлан дуудах хуудсанд хэнийг хэн, хаана, хэдийд ирүүлэхээр дуудаж байгаа, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй бол хэрхэх тухайг дурдсан байна.

198.3. Зарлан дуудах хуудсыг яллагдагчид гардуулан өгч, цагийг тэмдэглэн гарын үсэг зуруулна.

198.4. Яллагдагч түр хугацаагаар байхгүй байвал зарлан дуудах хуудсыг түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга, байгууллагын захиргааны аль нэгэнд өгч, гарын үсэг зуруулна.

198.5. Яллагдагчийг утас, цахилгаан, мэдээллийн бусад хэрэгслээр дуудан ирүүлж болно.

198.6. Цагдан хоригдож байгаа яллагдагчийг байгаа газарт нь, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах газарт ирүүлж байцаана.

199 дүгээр зүйл. Яллагдагчаар татах тухай тогтоолыг сонсгох

199.1. Яллагдагчаар татах тухай тогтоол гармагц түүнийг яллагдагчид нэн даруй сонсгоно.

199.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч яллагдагчийн биеийн байцаалтыг шалгаж түүнд яллагдагчаар татсан тухай тогтоолыг уншиж сонсгож, сонгосон ялын агуулгыг танилцуулж хэзээ ял сонгосныг уг тогтоолд тэмдэглэж, гарын үсэг зуруулна.

199.3. Яллагдагч гарын үсэг зурахаас татгалзвал тогтоолд энэ тухай тэмдэглэнэ.

200 дугаар зүйл. Яллагдагчийн эрхийг тайлбарлан өгөх

200.1. Яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсны дараа энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан эрхийг яллагдагчид тайлбарлан өгч тэр тухай анхны байцаалтын тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.

201 дүгээр зүйл. Яллагдагчийг байцаах журам

201.1. Яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсны дараа яллагдагчийг нэн даруй байцаана.

201.2. Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд яллагдагчийг өдрийн цагаар байцаана.

201.3. Яллагдагчдыг тус тусад нь байцаах бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нэг хэрэгт дуудагдсан яллагдагчдыг өөр хоорондоо харилцахгүй байгаа арга хэмжээ авна.

201.4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь байцаалтыг эхэлсний дараа уг хэргийн талаар мэдүүлэг өгөхийг яллагдагчид мэдэгдэнэ.

201.5. Яллагдагчийн мэдүүлгийг сонссоны дараа түүнд асуулт тавьж болно.

202 дугаар зүйл. Яллагдагчийг байцаасан тэмдэглэл

202.1. Байцаалт бүрт тэмдэглэл үйлдэж, түүнд байцаалтыг хэзээ, хаана, хэнээс явуулсныг дурдана.

202.2. Яллагдагчаар татсаны дараахь анхны байцаалтад яллагдагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, газар, аль улсын иргэн болох, үндэс, угсаа, боловсрол, ажлын газар, албан тушаал буюу эрхэлсэн ажил, оршин суугаа газар, гэр бүлийн байдал, урьд шийтгэгдэж байсан эсэх, түүнчлэн хэргийн байдлаас шаардлагатай бусад зүйлүүдийг тодруулан асууж тэмдэглэлд тусгана.

202.3. Яллагдагчийн мэдүүлгийг тэмдэглэлд нэгдүгээр биеийн төлөөний үгээр үгчлэн бичиж, яллагдагчид танилцан асуулт, түүний

ариултыг тодорхой тусгана.

202.4. Байцаалт дуусмагц яллагдагчид эмдэглэлийг уншуулахаар өгөх буюу түүний үсэлтээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уншин гч энэ тухай тэмдэглэл хийнэ.

202.5. Яллагдагч тэмдэглэлд өөрийн өгсөн мэдүүлгийн дагуу нэмэлт, засвар оруулахыг шаардах эрхтэй ба уг нэмэлт, засварыг тэмдэглэлд аавал бичнэ.

202.6. Тэмдэглэлд яллагдагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, түүнчлэн байцаалтад ролцсон бусад хүмүүс гарын үсэг зурах ба хэд эдэн хуудастай бол яллагдагч хуудасны нүүр бүрт арын үсэг зурна.

202.7. Тэмдэглэлд хийсэн бүх нэмэлт, засварыг яллагдагч ба хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гарын үсэг зурж батална.

202.8. Байцаалтыг орчуулагч, хэлмэрчийн ролцоотойгоор явуулсан бол түүнд эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулсан, түүнчлэн яллагдагчид орчуулагч, хэлмэрчийг татгалзах эрхийг нь таниулж өгснийг тэмдэглэлд тусгаж, орчуулагч, хэлмэрчээр гарын үсэг зуруулна.

202.9. Орчуулагч, хэлмэрч тэмдэглэлийн хуудасны нүүр бүрт нь ба тэмдэглэлд бүхэлд нь гарын үсэг зурна.

202.10. Байцаалтын тэмдэглэлийг өөр хэл дээр бичгээр орчуулсан бол түүний хуудасны нүүр бүрт ба бүхэлд нь орчуулагч болон яллагдагч гарын үсэг зурсан байвал зохино.

203 дугаар зүйл. Яллагдагч мэдүүлгээ өөрөө бичих

203.1. Яллагдагч хүсвэл мэдүүлгээ өөрөө бичиж болно.

203.2. Яллагдагч бичгээр мэдүүлэг өгсний дараа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч түүнд нэмэлт асуулт тавьж болно.

204 дүгээр зүйл. Сонсгосон ялыг өөрчлөх буюу нэмэх

204.1. Мөрдөн байцаалтын үед сонсгосон ялыг өөрчлөх буюу түүнд нэмэлт оруулах үндэслэл гарвал прокурор яллагдагчид энэ хуулийн 199, 201 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу шинээр ял сонсгох бөгөөд шинээр сонсгосон ялын талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байцаалт явуулах үүрэгтэй.

204.2. Сонсгосон ялын аль нэг хэсэг нь нотлогдохгүй байвал прокурор тэр хэсгийг тогтоолоор хэрэгсэхгүй болгож яллагдагчид мэдэгдэнэ.

ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх

205 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл, хугацаа

205.1.Прокурор дор дурдсан үндэслэл байвал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлнэ:

205.1.1. яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй;

205.1.2. сэжигтэн, яллагдагч оргон зайлсан, эсхүл байгаа газар нь мэдэгдэхгүй байвал;

205.1.3. сэжигтэн, яллагдагч хаана байгаа нь тодорхой боловч түүний дипломат дархан эрхийг хязгаарлаагүй, эсхүл өөр улс хүлээлгэн өгөөгүй байгаа бол;

205.1.4. зайлшгүй шаардлагатай гэрч, хохирогч байхгүй тохиолдолд;

205.1.5. сэжигтэн, яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол;

205.1.6.тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;

205.1.7. өөр хэргийг шийдвэрлэхгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжгүй бол.

205.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийн байхгүйд гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

205.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцааалтыг түдгэлзүүлэх тухай саналаа бичгээр гаргаж, хэргийн хамт

прокурорт 3 хоногийн дотор хүргүүлнэ.

205.4. Хоёр буюу хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх сэжигтэн, яллагдагчид хамаарахгүй байвал зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлан түдгэлзүүлж болно.

205.5. Энэ хуулийн 205.1.1, 205.1.2-т заасан тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг уг хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хугацаа дуусахад түдгэлзүүлнэ.

205.6. Энэ хуулийн 205.1.4-т зааснаас бусад тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг уг хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хугацаа дуусахын өмнө түдгэлзүүлж болно.

205.7. Түдгэлзүүлсэн хэргийг эрүүгийн хариуцлагад татаж болох хугацаа дуусмагц хэрэгсэгчүй болгоно.

206 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагчийн эрэн сурвалжлах

206.1. Сэжигтэн, яллагдагч орогн зайлсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах арга хэмжээг авна.

206.2. Хэрэг бүртгэч, мөрдөн байцаагч прокурор эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгаж, энэ тухай тогтоол гаргана.

207 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг сэргээн явуулах

207.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл арилсан буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа сэжигтэн, яллагдагчийн байхгүйд нэмж хийх шаардлагатай байвал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг прокурорын тогтоолоор сэргээн явуулна.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ
Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох

208 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл

208.1. Дор дурдсан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно:

208.1.1. энэ хуулийн 24.1.1-24.1.4-д заасан тохиолдолд;

208.1.2. нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагаат хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй байвал;

208.1.3. энэ хуулийн 25.1-д заасан гэмт хэргийн хохирогч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрсэн бол.

208.2. Хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл нь нийт сэжигтэн, яллагдагчид хамаарахгүй байвал тухайн сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлаж хэрэгсэхгүй болгоно.

208.3. Энэ хуулийн 208.1.2.-т зааснаар хэрэгсэхгүй болгосон хэргийн талаархи нотлох баримт Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд дурдсан хугацааны дотор шинээр илэрвэл уг хэргийг сэргээн шалгаж болно.

209 дүгээр зүйл. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох журам

209.1. Прокурор өөрөө болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол гаргана.

209.2. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолд эд мөрийн баримт, таслан сэргийлэх арга хэмжээ, битүүмжилсэн эд хөрөнгө хэрхэхийг шийдвэрлэнэ.

209.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийг хэрэгсэхгүй болгох тухай саналаа бичгээр гаргаж, хэргийн материалын хамт 3 хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.

209.4. Хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолыг сэжигтэн, яллагдагч, хохирогчид мэдэгдэж, гомдол гаргах журмыг тайлбарлан өгнө.

209.5. Хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолыг мэдэгдсэн өдрөөс хойш хохирогч болон холбогдох бусад этгээд 7 хоногийн дотор прокурорт гомдол гаргаж болно.

210 дугаар зүйл. Сэтгэцийн өвчтэй буюу эдгэршгүй хүнд өвчтэй яллагдагчид холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох

210.1. Яллагдагч гэмт хэрэг үйлдэх үедээ, эсхүл үйлдсэнийхээ дараа сэтгэцийн буюу эдгэршгүй хүнд өвчнөөр өвчилсөн бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай саналаа бичгээр гаргаж, хэргийн материалын хамт 3 хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.

210.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн

айцаагч шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 210. - д заасан этгээдэд эмнэлгийн чанартай лбадлагын арга хэмжээ авахуулах саналаа рокурорт уламжилна.

210.3. Прокурор энэ хуулийн 210. 1- д заасан этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын рга хэмжээ хэрэглэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа шүүхэд тавина.

211 дүгээр зүйл. Хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх

211.1. Энэ хуулийн 210 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй бол дээд шатны прокурор хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг сэргээнэ.

211.2. Хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх явдлыг хөөн хэлэлцэх хугацааны дотор гүйцэтгэж болно.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгах

212 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах

212.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүх ажиллагааг хийж дуусан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цуглarсан гэж үзвэл энэ тухай яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.

212.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, тэдний өмгөөлөгчид хэргийн бүх материалыг, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчид хэргийн зөвхөн иргэний нэхэмжлэлд холбогдох хэсгийг танилцуулна.

212.3. Яллагдагчийн болон хохирогчийн өмгөөлөгч хүсвэл түүнд хэрэгт авагдсан эд мөрийн баримт, соронзон болон дүрс бичлэгийг танилцуулж болно.

212.4. Энэ хуулийн 212.2-т заасан оролцогчид хэргийн материал танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэх ба түүнд хэнд ямар материал танилцуулсан, оролцогч ямар хүсэлт гаргасан зэргийг тусгана.

212.5. Хэргийн материалтай танилцах үед бичгээр хүсэлт гаргасан бол хэрэгт хавсаргана.

212.6. Хэргийн материалтай танилцах үед энэ хуулийн 212.2-т заасан оролцогчоос гаргасан хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүлээн авч хангах, эсхүл хэрэгсэхгүй болгож энэ тухай тогтоол гаргана.

212.7. Хэргийн материалтай энэ хуулийн 212.2-т заасан оролцогч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас тогтоосон хугацаанд танилцах ба хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийн материалтай танилцах боломжийг бүрдүүлнэ.

212.8. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол прокурорт гомдол гаргаж болно.

213 дугаар зүйл. Хэргийг прокурорт шилжүүлэх

213.1. Энэ хуулийн 212 дугаар зүйлд заасан ажиллагаа хийгдсэний дараа хэргийг прокурорт шилжүүлнэ.

214 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд

214.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас шилжүүлсэн хэргийн талаар прокурор дор дурдсан асуудлыг хянах үүрэгтэй:

214.1.1. гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэх;

214.1.2. хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байгаа эсэх;

214.1.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг бүрэн, бодитой явуулсан эсэх;

214.1.4. сонсгосон ял нь хэрэгт байгаа нотлох баримтад үндэслэгдсэн эсэх;

214.1.5. сонсгосон ял нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар тогтоосон бүх гэмт хэргийг хамарч чадсан эсэх;

214.1.6. гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;

214.1.7.Эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг зөв хэрэглэсэн эсэх;

214.1.8. таслан сэргийлэх арга хэмжээг зөв хэрэглэсэн эсэх;

214.1.9. иргэний нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авсан эсэх;

214.1.10.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх.

215 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэгийн талаар прокуророос гаргах шийдвэр

215.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэхүү хугацааг 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

215.2. Прокурор хэргийг хянаж үзээд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

215.2.1. хөнгөн болон мөрдөн байцаалтын тусгай харьяалалтайгаас бусад хүндэвтэр гэмт хэрэгт яллагдагчаар татсан тогтоолыг баталж, хэргийг шүүхэд шилжүүлэх;

215.2.2. тусгай харьяалалтай хүндэвтэр гэмт хэрэгт болон хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх;

215.2.3. нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах;

215.2.4. энэ хуулийн 208 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох;

215.2.5. хэргийг түдгэлзүүлэх;

215.2.6. хэргийг харьяалалын дагуу шилжүүлэх.

215.3. Яллах дүгнэлт үйлдэх хугацаа нь 10 хоног байна. Энэ хугацааг дээд шатны прокурор 14 хоногоор сунгаж болно.

216 дугаар зүйл. Прокурор яллагдагчаар татсан тогтоол батлах буюу яллах дүгнэлт үйлдэх үед урьд сонсгосон ялыг өөрчлөх

216.1. Яллагдагчаар татсан тогтоол батлах буюу яллах дүгнэлт үйлдэх үед прокурор урьд сонсгосон ялын заримыг хүчингүй болгох, түүнчлэн хөнгөн ялтай хууль хэрэглэх эрхтэй.

216.2. Ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаараа урьд сонсгосон ялаас онцын ялгаатай болгож өөрчлөх шаардлагатай бол прокурор хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахгүйгээр шинээр ял сонсгож байцаалгах эрхтэй.

217 дугаар зүйл. Прокурор таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх хүчингүй болгох

217.1. Энэ хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлсэн хэргийг хянаж явцад прокурор урьд авсан цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

218 дугаар зүйл. Яллах дүгнэлт

218.1. Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох хэсэг, хавсралтаас бүрдэнэ.

218.2. Тэмдэглэх хэсэгт яллагдагчийн овог, эцгийн нэр, нэр, түүний үйлдсэн хэргийн товч агуулга, арга, сэдэлт, санаа, зорилго, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай зарим нотлох баримт зэргийг дурдана.

218.3. Тогтоох хэсэгт яллагдагчийн үйлдсэн хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл, хэсэгт тохирох, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай санал, шүүхийн харьяалал, яллах дүгнэлт үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, зэрэг дэв, үйлдсэн он, сар, өдрийг бичнэ.

218.4. Яллах дүгнэлтийн хавсралтад дор дурдсан зүйлийг заана:

218.4.1. таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх, түүний хугацаа;

218.4.2. эд мөрийн баримт, битүүмжилсэн эд хөрөнгийн талаархи тодорхойлолт;

218.4.3. иргэний нэхэмжлэл, түүнийг хангах талаар авсан арга хэмжээ;

218.4.4. шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулбал зохих гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч болон бусад оролцогчын талаархи санал.

219 дүгээр зүйл. Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх

219.1. Прокурор яллагдагчаар татах тогтоолыг батлах буюу яллах дүгнэлт үйлдэн, хэргийг харьяаллын дагуу шүүхэд шилжүүлж, энэ тухай яллагдагчид мэдэгдэнэ.

219.2. Хэргийг шүүхэд шилжүүлсний дараа хэргийн талаар гарсан хүсэлт, гомдлыг шүүхэд шууд шилжүүлнэ.

НАЙМДУГААР ХЭСЭГ
ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

ГУЧДУГААР БҮЛЭГ
Шүүхийн харъяалал

220 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн шүүхийн харъяалал

220.1. Хуульд тусгайлан зааснаас бусад эрүүгийн бүх хэргийг сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

221 дүгээр зүйл. Хэргийн нутаг дэвсгэрийн харъяалал

221.1. Хэргийг уг хэрэг гарсан газрыг харъяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

221.2. Гэмт хэрэг нэг шүүхийн харъяалах газар эхэлж, нөгөө шүүхийн харъяалах газарт төгссөн бол төгссөн газрын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.

221.3. Гэмт хэрэг гарсан газрыг тогтоох бололцоогүй, эсхүл хэрэг өөр өөр газруудад үйлдэгдсэн байвал уг хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж дууссан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

221.4. Адил эрхтэй хэд хэдэн шүүхэд харъяалагдах хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

222 дугаар зүйл. Хэргийг харъяаллын дагуу шилжүүлэх

222.1. Хэрэг тухайн шүүхэд харъяалагдахгүй байвал шүүгчийн захирамжаар харьяалах шүүхэд шилжүүлнэ.

222.2. Уг хэрэг адил эрх бүхий өөр шүүхэд харъяалагдах нь шүүх хуралдааны үед мэдэгдсэн бөгөөд хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтоохоо нөлөөлөхөөргүй байвал шүүх хуралдааныг үргэлжлүүлж хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.

223 дугаар зүйл. Хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэх

223.1. Хэргийг цаг тухайд нь түргэн шуурхай шийдвэрлэхийн тулд адил эрх бүхий нэг шүүхээс нөгөө шүүхэд шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэхээс өмнө шилжүүлж болно.

223.2. Хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн танхимын Тэргүүн шүүгчийн захирамжаар, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, түүнчлэн өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүхийн харъяалал тогтоон шилжүүлнэ.

223.3. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй бол дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар зохих шатны өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд олонхи шүүгч нь оролцож байгаа шүүхээр хэргийг хянан шийдвэрлүүлнэ.

224 дүгээр зүйл. Харъяаллын талаар маргаж болохгүй

224.1. Харъяаллын талаар шүүхүүд хоорондоо маргаж болохгүй ба энэ хуулийн 222, 223 дугаар зүйлд заасан журмаар шилжиж ирсэн хэргийг хүлээн авсан шүүх түүнийг заавал хянан шийдвэрлэнэ.

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа

225 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

225.1.Шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

225.1.1. яллагдагчийг шүүхэд шилжүүлэх;

225.1.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах;

225.1.3. хэргийг түдгэлзүүлэх;

225.1.4. хэргийг харъяалах шүүхэд нь шилжүүлэх.

225.2. Шүүгч дээрх асуудлыг шийдвэрлэхдээ захирамж гаргах ба түүнд дараахь зүйлийг тусгана:

225.2.1. захирамжийг хэзээ, хаана

гаргасан;

225.2.2. захирамж гаргасан шүүгчийн нэр;

225.2.3. захирамж гаргах үндэслэл.

225.3. Захирамжийг хэрэг шүүхэд ирснээс хойш 15 хоногийн дотор гаргана.

225.4. Энэ хуулийн 225.3-т заасан хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг сунгаж болно.

226 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд шийдвэрлэвэл зохих асуудал

226.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ шүүгч дараахь асуудлыг тодруулсан байна:

226.1.1. хэрэг уг шүүхэд харьяалагдах эсэх;

226.1.2. хэргийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэх;

226.1.3. яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох эсэх;

226.1.4. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүх хуралдааныг явуулж болохгүй байдалд хүргэх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийгноцтой зөрчсөн явдал байгаа эсэх.

227 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед гаргасан хүсэлтийг хянаж хэлэлцэх

227.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх үед шүүгч нь таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, иргэний нэхэмжлэл хангах арга хэмжээ авах талаар улсын яллагч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчөөс гаргасан хүсэлтийг хянаж үзэх үүрэгтэй.

227.2. Шүүгч хүсэлт гаргасан хүмүүсээс тайлбар авч болох ба түүнийг хэрэзн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэнэ.

227.3. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргаж болохгүй боловч хүсэлт гаргагч шүүх хуралдаан дээр түүнийг дахин гаргаж болно.

228 дугаар зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх

228.1. Шүүгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд энэ хуульд заасан байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын эрхийг бүрэн хангасан, шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхэд саад болох зүйл байхгүй гэж үзвэл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдааны товыг зарлана.

228.2. Захирамжид дараахь асуудлыг тусгана:

228.2.1 шүүх хуралдааныг хэзээ хаана хийх;

228.2.2. шүүх хуралдааныг шүүгч дангаар, эсхүл хамтран шийдвэрлэх эсэх;

228.2.3. шүүх хуралдаанд өмгөөлөгч оролцох эсэх;

228.2.4. шүүх хуралдаанд бусад этгээдийг оролцуулах эсэх;

228.2.5. шүүх хуралдааныг хаалттай хийх эсэх;

228.2.6. яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг хэдийд гардуулах.

228.3. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамжид яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний тухай тусгана.

228.4. Шүүх хуралдааны товыг гурваас доошгүй хоногийн өмнө шүүх талуудад мэдэгдэнэ.

229 дүгээр зүйл. Хэргийг түдгэлзүүлэх

229.1. Шүүгч дараахь тохиолдолд хэргийг түдгэлзүүлнэ:

229.1.1. яллагдагч оргон зайлсан, эсхүл хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа бол;

229.1.2. яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн байгуулагын тодорхойлотоор нотлогдсон бол;

229.1.3. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;

229.1.4. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор тухайн шүүхээс Улсын дээд шүүхэд хандсан бол;

229.1.5. тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандсан бол.

229.2. Энэ хуулийн 240.2, 247.1-2-т зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийг прокурорт буцаана.

230 дугаар зүйл. Хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах

230.1. Дор дурдсан тохиолдолд хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана:

230.1.1. хэргийг буруу нэгтгэсэн, ялгаарласан бол;

230.1.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд шүүхийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол;

230.1.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад энэ хуулийг зөрчсөн бол;

230.1.4. улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзвэл.

230.2.Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан бол прокурор уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан эсэргүүцэл бичих эрхтэй.

231 дүгээр зүйл. Яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг гардуулах

231.1. Шүүх яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг зарлан дуудах хуудасны хамт шүүгдэгчид гардуулан өгнө.

231.2. Яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг шүүгдэгчид гардуулан өгснөөс хойш 3 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй.

231.3. Шүүгдэгч монгол хэл мэддэггүй бол энэ зүйлд заасан баримт бичгийг түүний эх хэл буюу мэддэг хэл дээр орчуулан гардуулж өгнө.

232 дугаар зүйл. Шүүх хуралдаанд дуудах

232.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай захирамжид заасан оролцогчийг шүүх хуралдаанд дуудан ирүүлэх, шүүх хуралдаанд бэлтгэх бусад арга хэмжээг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

232.2. Шүүхийн зарлан дуудах хуудас хүлээн аваад ирээгүй оролцогч болон гэрч, шинжээчийг албадан ирүүлэх тухай шүүгчийн захирамжийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

232.3. Цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг товлосон хугацаанд шүүхэд ирүүлэхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна.

233 дугаар зүйл. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх хугацаа

233.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл

234 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах

234.1. Анхан шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ хэргийн бүх нотлох баримтыг шинжлэн судлах арга хэмжээ авна.

234.2. Шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

234.3. Шүүгч хэлэлцэж эхэлсэн хэргийг дуусгалгүйгээр өөр хэрэг хэлэлцэж болохгүй.

235 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

235.1. Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

235.2. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

236 дугаар зүйл. Хэргийг шүүх хуралдаанд хэлэлцэж байхад шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй байх

236.1. Хэргийг шүүхийн нэг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.

236.2. Шүүгчийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд үргэлжлэн оролцох боломжгүй болсон бол өөр шүүгч томилж хэрэг хэлэлцэх ажиллагааг эхнээс нь шинээр явуулна.

237 дугаар зүйл. Шүүх хуралдаан даргалагч

237.1. Шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч,

эсхүл түүний томилсон шүүгч даргална.

237.2. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг гагцхүү тухайн хэрэгт холбогдолтой асуудлыг хянан шийдвэрлэхэд чиглүүлж, хэргийг бүх талаас нь бүрэн, бодитойгоор шинжлэн судалж, үнэн байдлыг тогтоохын тулд хуульд заасан арга хэмжээг авна.

237.3. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.

238 дугаар зүйл. Шүүх хуралдааны ажиллагаанд оролцогч талууд тэгш эрхтэй байх

238.1. Улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч хүсэлт, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэхэд оролцох, үг хэлэх талаар тэгш эрх эдэлнэ.

239 дүгээр зүйл. Прокурор шүүх хуралдааны ажиллагаанд оролцох

239.1. Прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, нотлох баримтыг шинжлэх, шүүх хуралдааны явцад гарсан асуудлын талаар санал гаргах, шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, ялын төрөл, хэмжээ, хорих ял эдлүүлэх дэглэмийн болон бусад асуудлын талаарх дүгнэлтээ шүүхэд гаргана.

239.2. Улсын яллагч хуулийн шаардлага ба хэргийн бүх байдлыг үндэслэсэн өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон яллана.

239.3. Хэрэг ээдрээ төвөгтэй буюу олон шүүгдэгчтэй бол шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож болно.

239.4. Улсын яллагч дор дурдсан тохиолдолд шүүгдэгчийг яллахаас татгалзаж, саналаа бичгээр гаргана:

239.4.1.шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзсэн;

239.4.2.хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шаардлагатай гэж үзсэн.

239.5. Улсын яллагч шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө яллахаас татгалзаж болно.

239.6. Төрийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах буюу гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй.

240 дүгээр зүйл. Шүүгдэгч шүүх хуралдааны ажиллагаанд оролцох

240.1. Анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаар хэрэг хэлэлцэхэд шүүгдэгчийг оролцуулна.

240.2. Шүүгдэгч нь Монгол Улсын хилийн гадна байгаа бөгөөд шүүхэд хүрэлцэн ирэхээс зайлсхийсэн бол хэргийг түүний байхгүйд хэлэлцэж болно.

240.3. Энэ хуулийн 240.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч ирээгүй бол хэрэг хэлэлцэх ажиллагаа хойшлуулна.

240.4. Шүүх нь ирээгүй шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнд таслан сэргийлэх арга хэмжээ авах, эсхүл урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эрхтэй.

241 дүгээр зүйл. Шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгч оролцох

241.1. Өмгөөлөгч нотлох баримт шинжлэхэд оролцох, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар санал гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын тухай болон шүүгдэгчид оногдуулах ялын талаар саналаа хэлнэ.

241.2. Өмгөөлөгч ирээгүй бөгөөд түүнийг солих боломжгүй бол хэрэг хэлэлцэх ажиллагаа хойшлуулна.

241.3. Өмгөөлөгчийг солих асуудлыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

241.4. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болно.

242 дугаар зүйл. Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүйн холбогдол

242.1. Шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

242.2. Прокурор, өмгөөлөгч шүүх хуралдаанд цаашид оролцох боломжгүй бол тэдгээрийг сольж болох бөгөөд энэ тохиолдолд хэрэг хэлэлцэх ажиллагаг эхнээс нь шинээр явуулах ба тэдгээрт хэргийн бүх материалтай танилцах бололцоо олгоно.

242.3. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол энэ хуулийн 242.1 дэх заалт хамаарахгүй.

243 дугаар зүйл. Хохирогч ирээгүйн холбогдол

243.1. Шүүх хуралдаанд хохирогч, түүний өмгөөлөгч ирээгүй бол түүний оролцоогүйгээр хэргийн бүх байдлыг бүрэн тогтоож, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бололцоотой эсэхийг шүүх тодруулж, хэргийг хэлэлцэх, эсүүл хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэнэ.

244 дүгээр зүйл. Иргэний нэхэмжлэгч, хариуцагч ирээгүйн холбогдол

244.1. Шүүх иргэний нэхэмжлэгчийн хүсэлтээр, түүний оролцоогүйгээр хэргийг хэлэлцэж болно.

244.2. Иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдний төлөөлөгч зарлан дуудах хуудас авсан атлаа шүүх хуралдаанд ирээгүй явдал иргэний нэхэмжлэлийн талаар шийдвэр гаргахад саад болохгүй.

245 дугаар зүйл. Шүүх хуралдаанд гэрч, шинжээч ирээгүйн холбогдол

245.1. Шүүх хуралдаанд гэрч, шинжээч ирээгүй бол тэдний оролцоогүйгээр хэрэг хэлэлцэж болох эсэхийг улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгчөөс асууж, хэрэг хэлэлцэх ажиллагаат үргэлжлүүлэх буюу хойшлуулах тухай тогтоол, захирамж гаргана.

246 дугаар зүйл. Шүүх хуралдааны ажиллагааны хэмжээ хязгаар

246.1. Шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана.

246.2. Шүүх сонгосон ялыг хөнгөрүүлэх эрхтэй.

247 дугаар зүйл. Шүүх хэргийг түдгэлзүүлэх

247.1. Шүүгдэгч шүүхээс оргон зайлсан, түүний байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа, түүнчлэн сэтгэцийн болон өөр хүнд өвчний улмаас шүүхэд ирэх бололцоогүй болсон нь шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол шүүх тэр шүүгдэгчийн хувьд түүнийг олдтол буюу эдгэртэл хэргийг түдгэлзүүлж, бусад шүүгдэгчийн хувьд шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ.

247.2. Бусад шүүгдэгчид холбогдох хэргийг тусгаарлан хэлэлцэх нь хэргийн бодит үнэнийг тогтооход бэрхшээл учруулах бол хэрэг хэлэлцэх бүх ажиллагааг түдгэлзүүлнэ.

247.3. Оргон зайлсан шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар цагдаагийн байгууллагад гүйцэтгүүлэхээр даалгана.

248 дугаар зүйл. Шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгох

248.1. Дор дурдсан тохиолдолд шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгоно:

248.1.1. энэ хуулийн 24.1.1 - 24.1.4 - д заасан байдал тогтоогдвол;

248.1.2. энэ хуулийн 208.1.2, 208.1.3 - т заасан үндэслэл байвал;

248.1.3. улсын яллагч энэ хуулийн 239.4.1-д заасан үндэслэлээр яллахаас татгалзсан бол.

249 дүгээр зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлэх

249.1. Шүүх хуралдааны үед шүүх нь шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

250 дугаар зүйл. Шүүх хуралдаанаас тогтоол, захирамж гаргах журам

250.1. Шүүх хуралдааны явцад шийдвэрлэх байгаа бүх асуудлаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

250.2. Шүүх хуралдааныг хаалттай явуулах, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, хэрэгсэхгүй болгох, таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, шүүх хуралдаанд оролцогчийг татгалзан гаргах, шинжилгээ хийлгэх тухай асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

250.3. Энэ хуулийн 250.2-т зааснаас бусад асуудлыг шүүгчид зөвлөлдөх тасалгааны орохоос өмнө шийдвэрлэх ба түүнийг шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ.

250.4. Шүүх хуралдааны үед гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үншин сонсгоно.

251 дүгээр зүйл. Шүүх хуралдааны дэг

251.1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг танхимд орж ирэхэд шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босч, шүүхэд хүндэтгэл үзүүлнэ.

251.2. Шүүх хуралдаанд оролцогчид шүүхэд

хандаж мэдүүлэг өгөх, үг хэлэхдээ суудлаасаа босно.

251.3. Шүүх хуралдаанд оролцогч нь өвчтэй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.

251.4. Шүүх хуралдаанд оролцогч болон шүүх хуралдааны танхимд байгаа бусад иргэд шүүх хуралдааны дэг сахих талаар хуралдаан даргалагчаас гаргасан шийдвэрт захирагдана.

251.5. Насанд хүрээгүй этгээдийг шүүх дуудаагүй бол шүүх хуралдаанд оруулахгүй.

251.6. Улсын яллагч, өмгөөлөгч, бусад оролцогчид шүүхийн тогтоол уншиж сонсгоод байлцана.

252 дугаар зүйл. Шүүх хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

252.1. Шүүх хуралдааны үед шүүгдэгч хуралдааны дэг зөрчсөн, түүнчлэн хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдаагүй бол түүнийг хуралдааны танхимаас зайлуулах тухай урьдчилан сануулах бөгөөд дахин ийм зөрчил гаргавал түүнийг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хуралдааны танхимаас зайлуулж, зөвхөн тогтоолыг уншиж сонсгоход байлцуулна.

252.2. Улсын яллагч, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч шүүх хуралдааны дэг зөрчсөн буюу хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдаагүй бол тэдэнд сануулга өгөх ба дахин ийм зөрчил гаргавал энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан хэмжээний торгууль оногдуулна.

252.3. Шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүмүүс энэ хуулийн 252.1-д заасан зөрчил гаргавал хуралдаан даргалагчийн шийдвэрээр тэдний шүүх хуралдааны танхимаас зайлуулж, энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан хэмжээний торгууль оногдуулна.

253 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

253.1. Шүүх хуралдааны үед шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 253.2-т заасан журмын дагуу тэмдэглэл үйлдэх ба түүнд засвар оруулах тухай саналыг энэ хуулийн 253.6-253.9-д заасан журмын дагуу гаргаж шийдвэрлэнэ.

253.2. Шүүх хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн ба дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, нарийн бичгийн дарга, орчуулагч, хэлмэрч, улсын яллагч, өмгөөлөгч шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, түүнчлэн шүүхэд дуудагдан ирсэн бусад хүмүүсийн овог, эцгийн нэр нэр, хэлэлцүүж байгаа хэрэг, шүүгдэгчийн биеийн байцаалт, авсан таслан сэргийлэх арга хэмжээ шүүхийн ажиллагаа явагдсан дэс дараалал, шүүх хуралдаанд оролцогчийн өргөдөл, хүсэлт зөвлөдөх тасалгаанд оролгүйгээр гаргасан шийдвэр, зөвлөдөх тасалгаанд ямар тогтоол захирамж гаргасан, шүүх хуралдаанд оролцогчийн эрх, үүргийг тайлбарласан тухай, мэдүүлгийн тодорхой агуулга, шүүх хуралдааны явцад үзлэг нотлох баримт цуглуулах талаар хийсэн бусад ажиллагааны үр дүн, шүүх хуралдаанд оролцогчоос шүүх хуралдааны тэмдэглэлд бичихийг хүссэн зүйл, шүүх хуралдааны дэг зөрчсөн бол хэн, яаж зөрчсөн, шүүх хуралдааны шүүмжлэл болон шүүгдэгчийн эцсийн үгийн товч утга, тогтоолын уншин сонсгосон ба түүнийг давж заалдах журмын тайлбарласан тухайг шүүх хуралдааны тэмдэглэлд бичнэ.

253.3. Цаазаар авах ял оногдуулсан бол уучлал хүсэх эрхтэй болохыг шүүгдэгчид тайлбарлаж өгснийг тэмдэглэнэ.

253.4. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүх хуралдааны явцад үйлдэх бөгөөд түүнийг шүүх хуралдаан дуусснаас хойш 3 хоногийн дотор дуусгаж гарын үсэг зуруулна.

253.5. Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурах ба бүх өөрчлөлт, засвар, нэмэлтийг тэмдэглэнэ.

253.6. Улсын яллагч, өмгөөлөгч, шүүгдэгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч тэмдэглэлд гарын үсэг зурсан хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга хамтран хянаад зөвшөөрвөл түүний зөв болохыг баталж шүүх хуралдааны тэмдэглэлд хавсаргах ба зөвшөөрөхгүй бол энэ асуудлыг шүүх хуралдаанд оролцон улсын яллагч, өмгөөлөгчийг байлцуулан шийдвэрлэнэ.

253.8. Шүүх хуралдааны тэмдэглэлд өгсөн саналыг хэлэлцэхэд шаардлагатай бол санал өгсөн хүнийг байлцуулна.

253.9. Шүүх хуралдааны тэмдэглэлд бичигдээгүй шүүх хуралдааны ажиллагаа нотлох баримтын ач холбогдлоо алдана.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шүүх хуралдааныг эхлэх

254 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээх

254.1. Шүүх хуралдаан даргалагч нь хэргийг хянан шийдвэрлэхээр товлосон цагтаа шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгаа зарлана.

255 дугаар зүйл. Шүүх хуралдаанд оролцогчдын ирцийг шалгах

255.1. Улсын яллагч, өмгөөлөгч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, орчуулагч, хэлмэрч, гэрч, шинжээч шүүхэд дуудагдсан бусад хүмүүс хүрэлцэн ирсэн эсэхийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга илтгэж, ирээгүй хүмүүсийн шалтгааныг мэдэгдэнэ.

256 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрчид түүний үүргийг тайлбарлах

256.1. Орчуулагч, хэлмэрч нь хуралдаанд оролцож байгаа монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий хүний мэдүүлэг, хүсэлтийг шүүхэд; шүүх хуралдаан дээр гарсан мэдүүлэг, хүсэлт, уншсан баримт бичиг, түүнчлэн шүүх хуралдаан даргалагчийн болон шүүхийн шийдэрийг орчуулуулж буюу хэлмэрчлүүлж байгаа хүнд орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй бөгөөд хуульд заасан тохиолдолд шүүх хуралдаан даргалагч түүнд тайлбарлаж өгнө.

256.2. Санаатайгаар худал орчуулах буюу хэлмэрчилбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг орчуулагч, хэлмэрчид урьдчилан сануулж, шүүх хуралдааныг тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

257 дугаар зүйл. Гэрчүүдийг шүүх хуралдааныг танхимаас гаргах

257.1. Гэрчийн мэдүүлгийг сонсох хүртэл түүнийг шүүх хуралдааныг танхимаас гаргана.

257.2. Шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдаанд мэдүүлэг өгсөн гэрчийг мэдүүлэг өгөөгүй гэрчтэй уялзуулахгүй байлгах арга хэмжээ авна.

258 дугаар зүйл. Шүүгдэгчид яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг цаг тухайд нь өгсөн эсэхийг шалгах

258.1. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн газар, он, сар, өдөр, иргэний харъяалал, оршин суугаа газар, эрхэлсэн ажил, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, урьд ял шийтгүүлсэн эсэхийг тодруулж яллагдагчаар татсан тогтоол, яллах дүгнэлтийн хуулбарыг хэдийд авсныг асууна.

258.2. Яллагдагчаар татсан тогтоол, эсхүл яллах дүгнэлтийг энэ хуулийн 231.2-т заасан хугацаанд өгөөгүй бол хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулна.

259 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүнийг зарлах, татгалзан гаргах эрхтэй болохыг тайлбарлах

259.1. Шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлаж, улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр хэн, хэн оролцож байгааг мэдэгдэж, шүүгдэгч ба татгалзан гаргах хүсэлт гаргах эрх бүхий бусад оролцогчид энэ хуульд заасны дагуу хүсэлт гаргах эрхтэй болохыг тайлбарлан өгнө.

259.2. Энэ хуулийн 259.1-д заасан шүүх хуралдаанд оролцогч татгалзан гаргах хүсэлт гаргавал түүнийг энэ хуулийн долдугаар бүлгэт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

260 дугаар зүйл. Шүүх хуралдаанд оролцогчид түүний эрх, үүргийг тайлбарлах

260.1. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч нарт энэ хуулийн 36, 42-44, 46-д заасан эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

260.2. Шүүх хуралдаанд оролцогчдын хэн нэг нь ирээгүй бол шүүх хуралдааныг ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг энэ хуулийн 240-245 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шүүхийн хэлэлцүүлэг

261 дүгээр зүйл. Нотлох баримт шинжлэх

261.1.Шүүхийн хэлэлцүүлэгт нотлох баримтыг шинжлэхдээ эхлээд яллах, дараа нь цагаатгах болон бусад баримтыг шинжлэх дараллыг баримтална.

261.2.Яллах баримтыг нотлох үүргийг улсын

яллагч, шүүгдэгчийн байдлыг хөнгөрүүлэх, цагаатгах баримтыг нотлох үүргийг өмгөөлөгч, шүүгдэгч тус тус хүлээнэ.

261.3. Шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй.

262 дугаар зүйл.Шүүхийн хэлэлцүүлгийг эхлэх

262.1. Шүүхийн хэлэлцүүлэг улсын яллагч яллах дүгнэлт унших сонсгохоос эхэлнэ.

262.2. Хуралдаан даргалагч нь шүүгдэгч нэг бүрээс яллах дүгнэлт ойлгогдож байгаа эсэхийг асуух, хэрэв шаардлагатай байвал шүүгдэгчид яллах дүгнэлтийн утгыг улсын яллагчаар тайлбарлуулан өгнө.

263 дугаар зүйл. Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох

263.1. Улсын яллагч яллах дүгнэлт сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч хэргийн талаар мэдүүлэг өгөх эсэхийг асуух хэрэв зөвшөөрвөл түүний мэдүүлгийг авна.

263.2. Шүүгдэгч мэдүүлэг өгсний дараа түүнд эхэлж улсын яллагч, дараа нь өмгөөлөгч асуулт тавих ба шүүгч байцаалтын аль ч үед, иргэдийн төлөөлөгч, талууд, оролцогч шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүгдэгчид асуулт тавьж болно.

263.3. Хэргийн үнэнийг тогтооход онцгой ач холбогдолтой бол шүүгдэгчийг бусад шүүгдэгчийн оролцоогүйгээр сонсож болох ба үүнийг гагцхүү шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэж болно.

263.4. Энэ хуулийн 263. 3-т заасны дагуу шүүгдэгчийг сонссон бол байгаагүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа шүүх хуралдаан даргалагч түүний эзгүйд гаргасан мэдүүлгийн утгыг танилцуулж, өөрийн нь байхгүйд сонссон шүүгдэгчид асуулт тавих бололцоог түүнд олгоно.

263.5. Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлгийн ямар ч үед нэмж мэдүүлэг өгч болно.

264 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед шүүгдэгчийн гаргасан мэдүүлгийг унших сонсгох

264.1. Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэхийн тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед шүүгдэгчийн гаргасан мэдүүлгийг талуудын саналаар дор дурдсан тохиолдолд шүүх хуралдаанд уншиж сонсгоно:

264.1.1. урьд гаргасан мэдүүлэг нь шүүх хуралдаан дээр гаргаж байгаа мэдүүлгээс ноцтой зөрсөн;

264.1.2. шүүгдэгч шүүх хуралдаанд мэдүүлэг гаргахаас татгалзсан;

264.1.3. хэргийг шүүгдэгчийн байхгүйд хэлэлцэж байгаа.

264.2. Энэ хуулийн 264.1-д заасан журам нь шүүгдэгчээс шүүхэд урьд гаргасан мэдүүлгийг уншихад нэгэн адил хамаарна.

265 дугаар зүйл. Хохирогчийн мэдүүлгийг сонсох

265.1. Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсч дууссаны дараа энэ хуулийн 267, 269 дүгээр зүйлд заасан журмын дагуу хохирогчийн мэдүүлгийг сонсоно.

266 дугаар зүйл. Гэрчийн мэдүүлгийг сонсох

266.1. Хохирогчийн мэдүүлгийг сонссоны дараа энэ хуулийн 267, 269 дүгээр зүйлд заасан журмын дагуу гэрчийн мэдүүлгийг сонсоно.

266.2. Шүүх хуралдаан даргалагч гэрчийн мэдүүлгийг сонсохын өмнө түүний биеийн байцаалт, шүүгдэгч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тодруулж, хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэх үүргийг тайлбарлан, мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай гэрчид сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

266.3. Шүүх хуралдаан даргалагч нь насанд хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан өгөх ба харин мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай сануулж болохгүй.

267 дугаар зүйл. Гэрчийн мэдүүлгийг сонсох журам

267.1. Энэ хуулийн 266 дугаар зүйлд заасан ажиллагаа хийдсэнийг дараа гэрчүүд мэдүүлэг өгөх ба тэдгээрийг тус тусад нь сонсоно.

267.2. Гэрчид түүнийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан этгээд тэргүүн ээлжинд асуулт тавина.

267.3. Энэ хуулийн 267.2-т заасан этгээд

асуулт тавьсны дараа гэрчид яллах болон өмгөөлөх талын оролцогч шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр асуулт тавина.

267.4. Хэрэгт холбогдолгүй асуулт тавихыг шүүх хуралдаан даргалагч хориглоно.

267.5. Шүүгч өөрийн үзэмжээр, харин иргэдийн төлөөлөгч, талууд, оролцогч шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед гэрчид асуулт тавина.

267.6. Шүүх улсын яллагч, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, түүнчлэн бусад оролцогчийн хүсэлтээр гэрчүүдийг нүүрэлдүүлэн байцааж болно.

267.7. Мэдүүлэг өгсөн гэрчүүд шүүх хуралдааны танхимд үлдэх бөгөөд шүүхийн хэлэлцүүлэг дуустал шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр гарч болохгүй.

267.8. Шүүх хуралдаан даргалагч нь улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчийн саналыг сонссоны дараа мэдүүлгийг нь сонссон гэрчийг шүүхийн хэлэлцүүлэг дуусахаас өмнө шүүх хуралдааны танхимаас гарч явахыг зөвшөөрч болно.

268 дугаар зүйл. Гэрч тэмдэглэл, баримт бичиг ашиглах

268.1. Гэрч шүүх хуралдаанд мэдүүлэг өгсөхдээ тэмдэглэл ашиглаж болно.

268.2. Өөрийнхөө мэдүүлэгтэй холбогдох баримт бичиг уншихыг гэрчид зөвшөөрөх бөгөөд уг баримт бичгээ шүүхэд өгнө.

269 дүгээр зүйл. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсох

269.1. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсоход энэ хуулийн 267 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

269.2. Шүүх насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсоход түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж болох ба тэдгээр нь шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр гэрчид асуулт тавьж болно.

269.3. Хэргийн бодит үнэнийг тогтоохоо ач холбогдолтой бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шүүгдэгчийг хуралдааны танхимаас гаргасны дараа насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсож, улмаар түүнийг танхимд орж ирсний дараа гэрч, хохирогчийн мэдүүлгийг танилцуулж, түүнд гэрч, хохирогчид асуулт тавих бололцоо олгоно.

269.4. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг цаашид байлгах шаардлагагүй бол түүнийг мэдүүлгийг нь сонссоны дараа шүүх хуралдааны танхимаас гаргана.

270 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрч, хохирогчийн гаргасан мэдүүлгийг уншиж сонгох

270.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрч, хохирогчийн гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс ноцтой зөрсөн, түүнчлэн гэрч, хохирогч шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед тэдний гаргасан мэдүүлгийг уншиж сонсгоно.

271 дүгээр зүйл. Шүүх хуралдааны үед шинжилгээ хийлгэх

271.1. Шүүх хуралдааны үед хэрэгт холбогдолтой зүйлийг шинжлэхэд шинжээч оролцоно.

271.2. Шинжээч дүгнэлт өгөхөд ач холбогдол бүхий байдлын талаар шүүгдэгч, хохирогч, гэрчид асуулт тавьж болно.

271.3. Шинжээч дүгнэлт өгөхөд ач холбогдол бүхий байдлыг тодруулмагц шүүх хуралдаан даргалагч нь иргэдийн төлөөлөгч, талууд, оролцогч асуулт байвал шинжээчид бичгээр өгч болохыг мэдэгдэж, шинжээчид тавьсан асуултыг уншин сонсгож, түүний талаар улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөх талын саналыг сонсгоно.

271.4. Энэ хуулийн 271.2, 271.3-т заасан ажиллагаа хийгдсэний дараа шүүх хариулт өгөх асуултыг тодорхойлж, шинжээч дүгнэлт гаргах ажилд орно.

271.5. Шинжээч дүгнэлтээ бичгээр өгөх бөгөөд түүнийг шүүх хуралдаан дээр уншин сонсгож, асуултын хамтаар тухайн хэрэгт хавсаргана.

271.6. Шинжээчид тавигдсан асуултад хамаарагдаагүй болон түүний эрх хэмжээнд багтах бөгөөд хэрэгт холбогдолтой байдлын талаар тогтоогдсон зүйлийг шинжээч өөрийн дүгнэлтэд оруулах эрхтэй.

272 дугаар зүйл. Шинжээчид асуулт тавих

272.1. Шинжээч гаргасан дүгнэлтээ уншиж сонсгосны дараа түүнийг тайлбарлуулах буюу тодруулахаар шинжээчид асуулт тавьж болно.

272.2. Асуултыг эхлээд улсын яллагч, өмгөөлөгч шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр тавина.

272.3. Шүүгч өөрийн үзэмжээр, харин улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед шинжээчид асуулт тавих эрхтэй.

273 дугаар зүйл. Шинжилгээг нэмж буюу дахин хийлгэх

273.1. Энэ хуулийн 165 дугаар зүйлд заасан тохиолдолд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шинжилгээг нэмж буюу дахин хийлгэж болно.

273.2. Нэмж буюу дахин шинжилгээ хийлгэхэд энэ хуулийн 271, 272 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

274 дүгээр зүйл. Эд мөрийн баримтад үзлэг хийх

274.1. Шүүх хуралдааны үед эд мөрийн баримтад шүүх үзлэг хийж, уг эд мөрийн баримтыг талууд, гэрч, шинжээч, бусад оролцогчид үзүүлж танилцуулна.

274.2. Эд мөрийн баримтыг үзэж танилцсан оролцогч үзлэгтэй холбогдуулан ямар нэг байдлыг тодруулах саналыг шүүхэд тавьж болно.

274.3. Шүүх хуралдаанд ирүүлэх болоцлоогуй эд мөрийн баримтад үзлэг хийх шаардлагатай байвал энэ тухай тэмдэглэлд тусгаж, эд мөрийн баримт байгаа газарт шүүх бүрэлдэхүүнээрээ очиж үзлэг хийнэ.

275 дугаар зүйл. Баримт бичигт үзлэг хийх, түүнийг уншин сонсгох

275.1.Шүүх хуралдаанд оролцогчдын хүсэлтээр хэрэгт авагдсан баримт бичигт үзлэг хийх ба түүнийг уншин сонсгож болно.

276 дугаар зүйл. Газар, орон байранд үзлэг хийх

276.1. Шүүх бүрэлдэхүүн шаардлагатай бол хэрэг гарсан болон бусад газар, орон байранд талууд, гэрч, шинжээч, бусад оролцогчийг байлцуулан үзлэг хийж болно.

276.2. Үзлэг хийх газар ирмэгц шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдаан үргэлжилж байгааг зарлаж үзлэг хийх ба шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчид үзлэг хийх явдалтай холбогдсон асуулт тавьж болно.

276.3. Үзлэгт оролцогчид хэргийн байдлыг тодруулахад ач холбогдолтой гэж үзсэн бүх зүйлийг шүүхэд анхаарууулж болно.

277 дугаар зүйл. Туршилт хийх

277.1. Хэрэгт авагдсан баримтыг шинжлэх буюу нотлохын тулд ямар нэг үйл явдал, үйлдэл, бусад байдлыг сэргээн дүрслэх шаардлагатай байвал шүүх талуудын хүсэлтээр туршилт хийж болно.

277.2. Туршилтыг талууд, гэрч, шинжээч, бусад оролцогчийг байлцуулан хийнэ.

277.3. Туршилтыг энэ хуулийн 131 дүгээр зүйлд заасан журмаар явуулна.

278 дугаар зүйл. Шүүхийн хэлэлцүүлгийг дуусгах

278.1. Нотлох баримтыг шинжилсний дараа талууд, оролцогчдоос шүүхийн хэлэлцүүлэгт нэмж гаргах санал байгаа эсэхийг шүүх хуралдаан даргалагч асуух тийм санал гаргавал түүнийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

278.2. Энэ хуулийн 278.1-д заасан ажиллагаа хийгдсэний дараа шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн хэлэлцүүлэг дуусаныг мэдэгдэнэ.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Шүүх хуралдааны шүүмжлэл, шүүгдэгчийн эцсийн үг

279 дүгээр зүйл. Шүүх хуралдааны шүүмжлэлийн агуулга ба журам

279.1. Шүүхийн хэлэлцүүлэг дууссаны дараа шүүмжлэл сонсоно.

279.2.Шүүх хуралдааны шүүмжлэл нь улсын яллагч, өмгөөлөгч, хэрэв шүүх хуралдаанд өмгөөлөгч оролцоогүй бол шүүгдэгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчийн хэлэх үгээс бүрдэнэ.

279.3. Шүүмжлэл явуулах этгээд энэ хуулийн 279.2-т заасан дэс дараалаар үг хэлнэ.

279.4. Шүүх хуралдааны шүүмжлэлд оролцогч нь шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг иш татах эрхгүй.

279.5. Шүүмжлэлийг цагаар хязгаарлаж

болохгүй боловч оролцогч хэлэлцэж байгаа хэрэгт холбогдолгүй зүйл яривал шүүх хуралдаан даргалагч зогсооно.

279.6. Шүүх хуралдааныг шүүмжлэлд оролцогчид үг хэлж дууссаны дараа тэд шүүмжлэлд яригдсан зүйлийн талаар тус бүр нэг удаа тайлбар хэлж болох ба хамгийн эцэст үг хэлэх эрх шүүгдэгч, түүний өмгөөлөгчид олгогдоно.

280 дугаар зүйл. Шүүгдэгчийн эцсийн үг

280.1. Шүүх хуралдааныг шүүмжлэл дууссаны дараа эцсийн үг хэлэхийг хуралдаан даргалагч шүүгдэгчид мэдэгдэх ба иймхүү үг хэлж байхад шүүгдэгчид асуулт тавьж болохгүй.

280.2. Шүүгдэгчээс хэлэх эцсийн үгийг цагаар хязгаарлаж болохгүй.

281 дүгээр зүйл. Шүүхийн хэлэлцүүлгийг дахин эхлэх

281.1. Шүүгдэгчийн эцсийн үгэнд хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал илэрвэл шүүх нь талуудын хүсэлтээр шүүхийн хэлэлцүүлгийг сэргээн явуулна.

281.2. Шүүхийн хэлэлцүүлгийг дахин явуулсны дараа шүүх хуралдааныг шүүмжлэлийг дахин явуулах ба шүүгдэгчид эцсийн үг хэлэх боломж олгоно.

282 дугаар зүйл. Тогтоол гаргахаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох

282.1. Шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ.

ГУЧИН ТАВДУГААР БҮЛЭГ
Тогтоол гаргах

283 дугаар зүйл. Монгол Улсын нэрийн өмнөөс тогтоол гаргах

283.1. Шүүх Монгол Улсын нэрийн өмнөөс тогтоол гаргана.

284 дүгээр зүйл. Тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байх

284.1. Шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байна.

284.2. Хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуульд үндэслэн гаргасан тогтоолыг хууль ёсны гэж үзнэ.

284.3. Шүүхэд гаргасан нотлох баримтыг шүүх хуралдаанд тэл бүрээс нь бүрэн, бодитой шинжилсэний үндсэн дээр гаргасан тогтоолыг үндэслэлтэй гэж үзнэ.

285 дугаар зүйл. Шүүгчдийн зөвлөлгөөний нууц

285.1. Шүүх тогтоолыг зөвлөлдөх тасалгаанд үйлдэнэ.

285.2. Шүүгчид зөвлөлдөж байгаа үед зөвлөлдөх тасалгаанд үг хэргийг хэлэлцсэн шүүх бүрэлдэхүүнээс өөр хүмүүс байж болохгүй.

285.3. Шүүгчдийг зөвлөлдөх үед хэлэлцсэн зүйлийг задруулж болохгүй.

286 дугаар зүйл. Шүүхийн тогтоол гаргах үед шийдвэрлэвэл зохих асуудал

286.1. Шүүх тогтоол гаргах үед зөвлөлдөх тасалгаанд дор дурдсан асуудлыг шийдвэрлэнэ:

286.1.1. шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн эсэх;

286.1.2. уг хэрэгт гэмт хэргийн бүрэлдэхүүн байсан эсэх, хэрэв байгаа бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт заагдсан;

286.1.3. энэ гэмт хэрэгт шүүгдэгч гэм буруутай эсэх;

286.1.4. хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх нөхцөл байдал байгаа эсэх;

286.1.5. шүүгдэгчид ял оногдуулах үндэслэлтэй эсэх;

286.1.6. шүүгдэгчид ямар ял оногдуулбал зохих, түүнийг эдлүүлэх эсэх;

286.1.7. иргэний нэхэмжлэлийг хангах эсэх, хэрэв хангавал хэнд, ямар хэмжээгээр олгох, түүнчлэн иргэний нэхэмжлэл гаргаагүй бол эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх эсэх;

286.1.8.шүүгдэгчид хорих ял оногдуулах бол ямар дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх;

286.1.9. эд мөрийн баримтыг хэрхэх;

286.1.10. байцаан шийтгэх ажиллагааны зардлыг хэнээс, ямар хэмжээгээр гаргуулах;

286.1.11. шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэх.

286.2. Шүүгдэгч хэд, хэдэн гэмт хэрэгт яллагдаж байгаа бол асуудлыг гэмт хэрэг нэг бүрээр шийдвэрлэнэ.

286.3. Гэмт хэргийг хэд, хэдэн шүүгдэгч үйлдсэн бол асуудлыг шүүгдэгч нэг бүр дээр шийдвэрлэнэ.

287 дугаар зүйл. Шүүгдэгчийн сэтгэцийн өвчний тухай асуудлыг хэлэлцэх

287.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын буюу шүүх хуралдааны үед шүүгдэгчийн сэтгэцийн өвчний тухай асуудал гарсан бол түүнийг шүүх тогтоол гаргахдаа дахин хэлэлцэнэ.

287.2. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн өвтэй байсан, эсхүл үйлдснийхээ дараа уг өвчнөөр өвчилсөн гэж үзвэл энэ хуулийн дөчин гуравдугаар бүлэгт дурдсан журмаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

288 дугаар зүйл. Хэргийг хамтран шийдвэрлэх үед зөвлөлдөх журам

288.1. Шүүх хэргийг бүрэлдэхүүнээр шийдвэрлэж байгаа бол тогтоол гаргахын өмнө шүүгчид зөвлөлгөөн хийнэ.

288.2. Шүүх хуралдаан даргалагч нь шүүгчдийн зөвлөлгөөнийг удирдаж, шүүхээр шийдвэрлүүлэх асуудлыг энэ хуулийн 286, 287 дугаар зүйлд заасан журмын дагуу тавина.

288.3. Шүүгчдийн зөвлөлгөөнд зөвшөөрсөн буюу татгалзсан хариу авахаар асуудал нэг бүрээр санал авна.

288.4. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр шүүгч санал өгөхөөс түдгэлзэх эрхгүй.

288.5. Шүүгчдийн зөвлөлгөөнд шүүх хуралдаан даргалагч нь саналаа хамгийн сүүлд гаргах бөгөөд асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

289 дүгээр зүйл. Тусгай санал

289.1. Шүүгч тусгай саналтай байвал түүнийгээ зөвлөлдөх тасалгаанд бичгээр гаргана.

289.2. Тусгай саналыг тогтоол уншиж сонсгоход зарлахгүй бөгөөд харин хэрэгт хавсаргана.

290 дүгээр зүйл. Шүүхийн тогтоолын хэлбэр

290.1. Шүүхийн тогтоол нь шийтгэх буюу цагаатгах хэлбэртэй байна.

290.2. Шүүхийн тогтоол нь таамаглалд үндэслэж болохгүй.

290.3. Шүүх хуралдааны үед шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана.

290.4. Гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, эсхүл шүүгдэгчийн холбогдсон үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй буюу шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана.

291 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол гаргах үед иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэх

291.1. Шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг түүний үндэслэл, хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан бүгдийг буюу хэсэгчлэн ханагах, эсхүл хэрэгсэхгүй болгоно.

291.2. Шүүх цагаатгах тогтоол гаргахдаа дараахь зүйлийг шийдвэрлэнэ:

291.2.1.гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй буюу шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;

291.2.2.шүүгдэгчийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс түүнийг цагаатгасан бол нэхэмжлэлийг авч хэлэлцэхгүй орхих.

291.3. Хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр иргэний нэхэмжлэлийн тодорхой тооцоо гарах болоцлоогүй тохиолдолд шүүх иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг зааж, түүний хэмжээний тухай асуудлыг иргэний журмаар шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

292 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон буюу хэлэлцээгүй орхисны холбогдол

292.1. Хэрэг хэлэлцэх үед иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгч иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлийг дахин гаргах эрхээ алдана.

292.2. Иргэний нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол нэхэмжлэгч түүнийг иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэх журмаар дахин гаргах эрхтэй.

293 дугаар зүйл. Иргэний нэхэмжлэлийг хангах

293.1. Иргэний нэхэмжлэлийг хангасан бөгөөд түүнийг хангах талаар урьд нь арга хэмжээ авааагүй бол шүүх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно.

293.2. Иргэний нэхэмжлэл гараагүй боловч гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан гэж үзвэл шүүх шийтгэх тогтоол гаргахдаа цаашид иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг заана.

294 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол үйлдэх

294.1. Энэ хуулийн 286, 287 дугаар зүйлд заасан асуудлыг шийдвэрлэмэгц шүүх тогтоол үйлдэнэ.

294.2. Шүүхийн тогтоол нь тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх бөгөөд удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.

294.3. Шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчдийн аль нэг нь тогтоолыг бичиж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

294.4. Тусгай саналтай шүүгч нэгэн адил гарын үсэг зурна.

294.5. Тогтоолд засвар оруулсан бол тайлбар хийж, тогтоолыг үншин сонсгохоос өмнө уг тайлбарт шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд гарын үсэг зурна.

295 дугаар зүйл. Тогтоолын удиртгал хэсэг

295.1. Тогтоолын удиртгал хэсэгт дараахь зүйлийг заана:

295.1.1. Монгол Улсын нэрийн өмнөөс тогтоолыг гаргасан;

295.1.2. тогтоолыг хэзээ, хаана гаргасан;

295.1.3. тогтоол гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч, нарийн бичгийн дарга, улсын яллагч, өмгөөлөгч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч, хэлмэрч;

295.1.4. шүүгдэгчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн газар, он, сар, өдөр, түүний оршин суугаа болон ажлын газар, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, урьд ял шийтгүүлсэн эсэх, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээ;

295.1.5. шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт хамаарах.

296 дугаар зүйл. Тогтоолын тодорхойлох хэсэг

296.1. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримт, шүүхээс бусад нотлох баримтыг няцаан гүйцэгсэн үндэслэл, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлж байгаа нөхцөл байдал, хэргийн заримыг хэрэгсэхгүй болгож байгаа бол түүний үндэслэл, түүнчлэн урьд сонсогсон ялыг шүүхээс өөрчилсөн бол түүний үндэслэл, шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол шалтгааныг тодорхойлно.

296.2. Хэрэгт хэд хэдэн шүүгдэгч оролцож байгаа бол энэ хуулийн 296.1-д заасан байдлыг шүүгдэгч тус бүрээр тодорхойлно.

296.3. Цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн хэргийн агуулга, шүүхээс хэргийн талаар тогтоосон байдал, шүүгдэгчийг цагаатгах үндэслэл болж байгаа нотлох баримт, яллах үндэслэл болж байсан нотлох баримтыг шүүх ямар үчраас үгүйсгэж байгаа үндэслэлийг тодорхойлох ба шүүгдэгчийг гэмт бурууг үйлдсэн эргэлзээ төрүүлэх зүйлийг оруулж болохгүй.

296.4. Шийтгэх ба цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт иргэний нэхэмжлэл буюу гэмт хэрэгээс учирсан эд хөрөнгийн хохирлын талаар шүүхээс гаргасан шийдвэрийн үндэслэлийг дурдана.

297 дугаар зүйл. Тогтоолын тогтоох хэсэг

297.1. Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт дараахь зүйлийг заана:

297.1.1.шүүгдэгч Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт дурдсан гэмт хэрэг үйлдсэн;

297.1.2. нотлогдсон гэмт хэрэг нэг бүрт нь шүүгдэгчид оногдуулсан ялын төрөл, хэмжээ, Эрүүгийн хуулийн 57, 58 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон жинхэнэ эдэлбэл зохих ялын хэмжээ, хэрэв хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол шийтгэгдсэн

эгээдийг хянах үүргийг хэнд хариуцуулсан, хорих ял шийтгүүлсэн ялтны ял эдлэх дэглэм;

297.1.4. шүүгдэгч нь тогтоол гарахын өмнө цагдан хоригдож байсан бол урьдчилан хоригдсон хугацааг тооцсон тухай шийдвэр;

297.1.5. шийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх тухай шийдвэр.

297.2. Шүүгдэгчийг онц аюултай гэмт хэрэгтэнд тооцон бол энэ тухай шийтгэх тогтоолд заана.

297.3. Шүүгдэгч Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан ял сонссон бол түүний аль хэсэгт нь цагаатгагдаж, аль хэсэгт нь шийтгүүлснийг шийтгэх тогтоолд нэг бүрчлэн заана.

297.4. Шүүгдэгч ял эдлэхээс чөлөөлөгдсөн бол энэ тухай заана.

297.5. Шийтгэх тогтоолыг биелүүлэхэд шүүхээс оногдуулсан ялын төрөл ба хэмжээний талаар ямар нэгэн эргэлзээ төрөхгүйгээр бичигдсэн байвал зохино.

297.6. Цагаатгах тогтоолын тогтоох хэсэгт дараахь зүйлийг заана:

297.6.1. шүүгдэгчийг цагаатгасан гухай;

297.6.2. таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байсан бол түүнийг хүчингүй болгосон тухай заалт;

297.6.3. иргэний нэхэмжлэл ба эд өрөнгө хураах болзошгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авагдсан бол түүнийг хүчингүй болгосон тухай заалт.

298 дугаар зүйл. Тогтоолын тогтоох хэсэгт шийдвэрлэвэл зохих бусад асуудал

298.1. Шийтгэх ба цагаатгах тогтоолын тогтоох хэсэгт энэ хуулийн 297 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан зүйлийг тусгана:

298.1.1. гаргасан иргэний нэхэмжлэлийн талаар буюу хохирлыг төлүүлэх тухай шийдвэр;

298.1.2. эд мөрийн баримтыг хэрхэх тухай шийдвэр;

298.1.3. байцаан шийтгэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай заалт;

298.1.4. тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих журам.

299 дүгээр зүйл. Шүүхийн тогтоолыг уншиж сонсгох

299.1. Шүүхийн тогтоолд гарын үсэг зурсны дараа шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааны танхимд орж, шүүх хуралдаан даргалагч шүүхийн тогтоолыг уншиж сонсгоно.

299.2. Шүүгдэгч болон шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс шүүхийн тогтоолыг босч сонсоно.

299.3. Шүүгдэгч монгол хэл мэддэггүй бол уг тогтоолыг уншиж сонсгосны дараа орчуулагч, хэлмэрч шүүгдэгчийн эх хэл буюу түүний мэддэг хэл дээр орчуулж буюу хэлмэрчилж өгнө.

300 дугаар зүйл. Цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллах

300.1. Шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, барьцаалах, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимаас суллана.

301 дүгээр зүйл. Шийтгэх ба цагаатгах тогтоол хүчин төгөлдөр болох

301.1. Шийтгэх ба цагаатгах тогтоол уншиж сонсогмогц хуулийн хүчин төгөлдөр болно.

302 дугаар зүйл. Шийтгэх ба цагаатгах тогтоолын хуулбарыг гардуулан өгөх

302.1. Шийтгэх ба цагаатгах тогтоолыг уншин сонсгосноос хойш 7 хоногийн дотор уг тогтоолын хувийг прокурор, шийтгүүлсэн буюу цагаатгагдсан этгээд, хохирогчид гардуулж өгнө.

302.2. Шийтгэгдсэн буюу цагаатгагдсан этгээд, хохирогч монгол хэл мэддэггүй бол шийтгэх ба цагаатгах тогтоолыг уг этгээдийн эх хэл буюу мэддэг хэл дээр орчуулж өгнө.

302.3. Шүүх нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчид тогтоолыг давж заалдах хугацаа дуусахаас өмнө танилцуулах арга хэмжээ авна.

ЕСДҮГЭЭР ХЭСЭГ
ШҮҮХИЙН ТОГТООЛ, ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖИД ДАВЖ ЗААЛДАХ, ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ГОМДОЛ ГАРГАХ, ЭСЭРГҮҮЦЭЛ БИЧИХ

ГУЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ
Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих

303 дугаар зүйл. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд

303.1. Ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч эсэргүүцэл бичих эрхтэй.

303.2. Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч шүүхийн тогтоолын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

303.3. Цагаатгагдсан этгээд шүүхийн тогтоолын цагаатгасан шалтгаан, үндэслэлд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

304 дүгээр зүйл. Шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих

304.1. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд түүнийг гардаж авсан буюу танилцуулснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлийг аймаг, нийслэлийн шүүхэд гаргана.

304.2. Энэ хуулийн 304.1-д заасан хугацааны дотор хэргийг шүүхээс шаардан авч болохгүй.

304.3. Давж заалдах гомдол, эсэргүүцлийг тогтоол гаргасан шүүхээр дамжуулан өгнө.

305 дугаар зүйл. Гомдол, эсэргүүцэл бичигдсэн тухай мэдэгдэх

305.1. Анхан шатны шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн бол энэ хуулийн 303 дугаар зүйлд дурдсан эрх бүхий этгээдэд шүүх мэдэгдэж, тайлбарыг бичгээр авч болно.

305.2. Анхан шатны шүүхийн тогтоолд гаргасан давж заалдах гомдол, эсэргүүцлийн талаархи тайлбарыг хэрэгт хавсаргана.

306 дугаар зүйл. Гомдол, эсэргүүцэл бичсэний холбогдол

306.1. Анхан шатны шүүхийн тогтоолд гомдол, эсэргүүцэл бичсэн тохиолдолд энэ тухай талуудад мэдэгдэн энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан хугацаа дуусмагц, гомдол, эсэргүүцлийн хамт хэргийн материалыг аймаг, нийслэлийн шүүхэд хүргүүлэх ба тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

306.2 Энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан хугацаа хэтрүүлж гаргасан гомдол, эсэргүүцлийг шүүх хүлээн авахгүй.

306.3. Шүүхийн тогтоолд гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн этгээд давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан эхлэхийн өмнө өөрийнхөө гомдол, эсэргүүцлийг, түүнчлэн дээд шатны прокурор нь доод шатныхаа прокурорын бичсэн эсэргүүцлийг буцаан авах эрхтэй.

306.4. Давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол түүний шалтгаан, нотолгоог зааж хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтийг тогтоол гаргасан шүүхэд гаргаж болно.

306.5. Хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг шүүгчийн захирамжаар шийдвэрлэх бөгөөд шүүгч тайлбар авахын тулд хүсэлт гаргасан этгээдийг дуудах эрхтэй.

306.6. Хэтэрсэн хугацааг сэргээсэн бол энэ тухай захирамжийг хэрэгт хавсаргаж гомдол, эсэргүүцлийн хамт аймаг, нийслэлийн шүүхэд хүргүүлнэ.

306.7. Хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол шүүгчийн захирамжид гомдол, эсэргүүцлийг ердийн журмаар гаргаж болох бөгөөд дээд шатны шүүх хэтэрсэн хугацааг сэргээн, хэргийг гомдол, эсэргүүцлийн дагуу хянан хэлэлцэх эрхтэй.

307 дугаар зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдлууд

307.1. Энэ хуулийн 222, 223, 227, 228, 229, 230, 240, 247, 249, 250, 252, 260, 263, 264, 269, 271, 274, 288, 341, 374, 375, 376 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичиж болохгүй.

308 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ, хязгаар

308.1. Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ шүүхийн тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хэрэгт байгаа материалыг үндэслэн хянана.

308.2. Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүй ба бусад шүүгдэгчийн талаар давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр бүх шүүгдэгчийн хэргийг бүхэлд нь хянаж үзнэ.

ГУЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ
Давж заалдах шатны шүүхийн ажиллагаа

309 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхэд хэргийг хянан хэлэлцэх хугацаа

309.1. Давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцэлтэй хэргийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хянан хэлэлцэнэ.

309.2. Энэ хуулийн 309.1-д заасан хугацаанд хэргийг хянан хэлэлцэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар 30 хүртэл хоногоор сунгаж болно.

309.3. Хэрэг хянан хэлэлцэх товыг 3 хоногийн өмнө зарлана.

310 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүх хуралдаан даргалагчийг томилох

310.1. Давж заалдах шатны шүүхэд ирсэн гомдол, эсэргүүцэлтэй хэргийг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч, шүүх хуралдаан даргалагчийг томилж хэргийг түүнд шилжүүлнэ.

311 дүгээр зүйл. Прокурор, өмгөөлөгч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох

311.1. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба ийм хүсэлт гаргасан бол заавал оролцуулна.

311.2. Энэ хуулийн 311.1-д зааснаас бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүй нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй.

312 дугаар зүйл. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд оролцох хүсэд хүмүүс

312.1. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шийтгүүлсэн хүүю цагаатгагдсан этгээд, хохирогч, түүнчлэн өргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өлөөлөгч оролцох эрхтэй ба тэд шүүх хуралдаанд рээгүй явдал нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй.

312.2. Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан ялтныг шүүх хуралдаанд оролцуулж болно.

313 дугаар зүйл. Давж заалдах шатанд хэрэг хэлэлцэх журам

313.1. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хэлэлцэх тухай зарлана.

313.2.Шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас шүүх хуралдааны ирцийг танилцуулсны дараа шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон хүрэлцэн ирсэн прокурор, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг танилцуулж, хэргийн оролцогчдод татгалзан гаргах хүсэлт байгаа эсэхийг асуух ба тийм хүсэлт байгаа бол энэ хуульд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

313.3. Энэ хуулийн 313.2-т заасан ажиллагааны дараа шүүхийн аль нэг шүүгч хэргийн талаар илтгэх бөгөөд түүнд хэргийн агуулга, гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг дурдана.

313.4.Шүүгч илтгэж дуусмагц давж заалдагч гомдол, эсэргүүцлээ тайлбарлах ба дараа нь шүүх нотлох баримтыг шинжлэн судлах, хуралдаанд оролцогчийн тайлбарыг сонсох, улмаар прокурорын дүгнэлт, шийтгэгдсэн буюу цагаатгагдсан этгээд, тэдний өмгөөлөгчийн нэмэлт тайлбарыг сонсож, магадлал гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

313.5. Шүүх хуралдааны дэг, түүнийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг энэ хуулийн 251, 252 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

314 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх хуралдааны тэмдэглэл

314.1. Оролцогчид давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцож байгаа бол нарийн

бичгийн дарга энэ хуулийн 253.2-т заасан журмыг баримтлан тэмдэглэл үйлдэх ба түүнийг хэрэгт заавал хавсаргана.

314.2. Шүүх хуралдааны тэмдэглэлд засвар оруулах саналыг энэ хуулийн 253.6 - 253.8-д заасан журмаар гаргах ба хэлэлцэнэ.

314.3. Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаанд оролцогчийг тэмдэглэлтэй танилцах бололцоогоор хангах үүрэгтэй.

315 дугаар зүйл. Магадлал гаргах

315.1. Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцээд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

315.1.1. давж заалдах гомдол буюу эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, тогтоолыг хэвээр үлдээх;

315.1.2. тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах;

315.1.3. тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох;

315.1.4. тогтоолд өөрчлөлт оруулах.

315.2. Шүүх магадлал гаргахдаа энэ хуулийн 313, 317 дугаар зүйлийн шаардлагыг удирдлага болгох ба түүнийг шүүх хуралдаан даргалагч үншиж сонсгоно.

316 дугаар зүйл. Цагаатгах тогтоолыг хүчингүй болгох үндэслэл

316.1. Давж заалдах шатны шүүх цагаатгах тогтоолыг прокурорын эсэргүүцэл буюу хохирогч, түүний төлөөлөгчийн болон үндэслэлийг эс зөвшөөрсөн цагаатгагдсан этгээдийн гомдлоор хүчингүй болгож болно.

317 дугаар зүйл. Тогтоол хүчингүй болгох , өөрчлөх үндэслэл

317.1. Дор дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал давж заалдах шатны шүүх тогтоолыг хүчингүй болгох буюу өөрчилнө:

317.1.1. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэг явуулахад нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн;

317.1.2. тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй;

317.1.3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн;

317.1.4. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бөгөөд шүүгдэгчид хүнд ялтай хууль хэрэглэх шаардлагатай бол.

318 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн

318.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа тогтоол гаргахад чухал ач холбогдолтой байж болох байдлыг тодруулалгүй орхигдуулсан байвал нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн гэж үзнэ.

318.2. Энэ хуулийн 318.1-д зааснаас гадна дараахь тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг нэг талыг барьсан буюу гүйцэд биш гэж үзнэ:

318.2.1. хэрэгт чухал ач холбогдол бүхий мэдүүлэг өгч болох хүмүүсийг байцаагаагүй, эсхүл зайлшгүй хийвэл зохих шинжилгээ хийлгээгүй, түүнчлэн хэрэгт чухал ач холбогдол бүхий баримт бичиг, эд мөрийн баримтыг шаардан гаргуулж авааагүй;

318.2.2. яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг бүрэн гүйцэд тогтоогоогүй;

318.2.3. урьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэгт буцаасан захирамж, тогтоолын заалтыг биелүүлээгүй.

319 дүгээр зүйл. Тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй

319.1. Дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь байвал тогтоолд дурдсан шүүхийн дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй гэж үзнэ:

319.1.1. дүгнэлт нь шүүх хуралдаанаар хэлэлцсэн нотлох баримтаар нотлогдохгүй байвал;

319.1.2. дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох байдлыг шүүх анхааран үзэлгүй орхигдуулсан бол;

319.1.3. дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгий бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй бол;

319.1.4. дүгнэлт нь шийтгүүлсэн бүх цагаатсан этгээдийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх, Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх, ялыг зөв оногдуулахад нөлөөлсөн буюу нөлөөлж болох ноцтой зөрүүтэй байвал.

320 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчих

320.1. Хэрэг хэлэлцэхэд оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хасах буюу хязгаарлах замаар, эсхүл бусад хэлбэрээр шүүхээс хэргийг бүх талаар хэлэлцэх явдалд саад болж, хууль ёсны ба үндэслэл бүхий тогтоол гаргахад сөргөөр нөлөөлсөн буюу нөлөөлж болохуйцаар энэ хуулийн шаардлагыг зөрчсөн бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн гэж үзнэ.

Дор дурдсан тохиолдолд тогтоолыг заавал хүчингүй болгоно:

320.1.1. шүүх хууль бус бүрэлдэхүүнтэйгээр тогтоол гаргасан;

320.1.2. хуульд зааснаар шүүгдэгчийг заавал байлцуулбал зохих байтал түүний оролцоогүйгээр хэргийг шийдвэрлэсэн;

320.1.3. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор хангаагүй;

320.1.4. зөвлөлдөх тасалгаанд болсон шүүгчдийн зөвлөлгөөний нууцыг задруулсан;

320.1.5. тогтоолд шүүгчийн хэн нэг нь гарын үсэг зураагүй;

320.1.6. хэрэгт шүүх хуралдааны гэмдэглэл байгаагүй;

320.1.7.шүүх хуралдаанд иргэдийн өлөөлөгч заавал оролцуулах хуулийн заалт өрчсөн.

321 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх

321.1. Дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь байвал Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ:

321.1.1 шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй;

321.1.2. хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн;

321.1.3. хуулийг жинхэнэ агуулгаас эрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн.

322 дугаар зүйл. Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт,мөрдөн байцаалт, шүүхэд буцаах

322.1. Давж заалдах шатны шүүх хэргийг буцаахдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны ажиллагааны бүхам аль шатанд шилжүүлж байгааг магадлалдаа хаана.

322.2. Хэргийг шүүхэд хэлэлцэх үед зөрчил гаргасны улмаас тогтоолыг хүчингүй болгож байгаа бол өөр бүрэлдэхүүнтэйгээр буюу өөр шүүхэд хэлэлцүүлэхээр хэргийг тогтоол гаргасан шүүхэд буцаана.

322.3. Урьд нь гэм буруутайд тооцогдож шүүхээр ял шийтгүүлж уг ялаа эдэлж байсан буюу эдэлж дууссан этгээдийн хэрэг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцсан бол уг хэргийг шүүхээр заавал дахин хэлэлцэж эцсийн шийдвэр гаргана.

322.4. Энэ хуулийн 322.3. нь шүүх хяналтын журмаар болон шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцсан хэргийг шийдвэрлэхэд нэгэн адил хамаарна.

323 дугаар зүйл. Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох

323.1. Давж заалдах журмаар хэргийг хянан хэлэлцэж байгаа шүүх дор дурдсан тохиолдолд шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно:

323.1.1. энэ хуулийн 24 дүгээр зүйлд дурдсан үндэслэл байвал;

323.1.2. шүүгдэгчид сонсгосон ял нь анхан шатны шүүхийн хэлэлцсэн нотлох баримтаар нотлогдоогүй бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийх буюу шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлгүй байвал.

324 дүгээр зүйл. Тогтоолыг өөрчлөх

324.1. Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй ял оногдуулсан нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх хөнгөн ялтай хууль хэрэглэх, эсхүл ялыг хөнгөрүүлэн өөрчилж болно.

324.2. Шүүх шүүгдэгчид оногдуулсан ялыг хэт хөнгөдсөн гэж үзвэл давж заалдах шатны шүүх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана.

324.3. Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхээр тогтоогдоогүй байдал буюу үгүйсгэгдсэн нотлох баримтыг үндэслэж тогтоолд өөрчлөлт оруулах эрхгүй.

325 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхийн магадлал

325.1. Давж заалдах шатны шүүхийн магадлалд дор дурдсан зүйлийг тусгана:

325.1.1. магадлалыг хэзээ, хаана

гаргасан;

325.1.2. магадлал гаргасан шүүх, шүүх бүрэлдэхүүн, давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон бусад хүмүүс;

325.1.3. анхан шатны шүүхийн шийдвэрийн товч агуулга;

325.1.4 давж заалдах гомдол, эсэргүүцэл бичсэн этгээд, гомдол, эсэргүүцлийн агуулга, товч үндэслэл;

325.1.5. давж заалдах шатны шүүхээс гомдол, эсэргүүцлийн талаар гаргасан шийдвэр, түүний үндэслэл.

326 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг биелүүлэх

326.1. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг уншиж сонсогмогц нэн даруй заавал биелүүлнэ.

326.2. Давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэрэгт хавсаргана.

ГУЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ
Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

327 дугаар зүйл. Шүүхийн тогтоолыг биелүүлэх

327.1. Энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй бол уг хугацаа дуусмагц шүүхийн тогтоолыг биелүүлнэ.

327.2. Энэ хуулийн 303 дугаар зүйлд заасан этгээд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан бол энэ хуулийн 326 дугаар зүйлд заасан үеэс эхлэн шүүхийн тогтоолыг биелүүлнэ.

328 дугаар зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хуулийн хүчин төгөлдөр болох ба тэдгээрийг биелүүлэх

328.1. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь түүнд гомдол, эсэргүүцэл бичих хугацаа дуусмагц биелэгдэнэ.

328.2. Давж заалдах гомдол гаргаж болохгүй шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь гармагц нэн даруй биелэгдэнэ.

329 дүгээр зүйл. Шүүхийн магадлал, тогтоол, шүүгчийн захирамжийг заавал биелүүлэх

329.1. Шүүхийн тогтоол, магадлал, шүүгчийн захирамжийг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

330 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоол, магадлалыг биелүүлэх

330.1.Энэ хуулийн 328 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болсон тогтоолын биелэлтийг дараахь байдлаар зохион байгуулна:

330.1.1. баривчлах, хорих ял шийтгүүлсэн бөгөөд цагдан хоригдож байгаа ялтны тогтоолыг цагдан хорих төв, эсхүл урьчилан хорих байрны захирагаанд 5 хоногийн дотор хүргүүлж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ;

330.1.2. баривчлах, хорих ял шийтгүүлсэн бөгөөд гадуур байгаа ялтны шийтгэх тогтоолыг хэрэг бүртгэсэн буюу мөрдсен албаны даргад 5 хоногийн дотор хүргүүлж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ;

330.1.3. торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх ял оногдуулсан шийтгэх тогтоолыг тухайн шийдвэрийг гүйцэтгэвэл зохих шийдвэр гүйцэтгэлийн албанд явуулж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ;

330.2.Энэ хуулийн 330.1.1-д заасны дагуу тогтоолыг хүлээн авсан байгууллага ялтныг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 72 цагийн дотор хүлээлгэж өгөх арга хэмжээ авна.

330.3.Энэ хуулийн 330.1.2-т заасан этгээдийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага тогтоолыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэж өгнө.

330.4. Энэ хуулийн 330.1.3-т заасан ялын хэрэгжилтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцаж зохион байгуулна.

330.5.Шийтгэх тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар гарсан заалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу биелүүлнэ.

330.6. Шийтгэх тогтоолын хэрэгжилтэд прокурор хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавина.

331 дүгээр зүйл. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийг төрөл садангийн хүнтэй нь уулзуулах

331.1. Цаазаар авах ял шийтгүүлсэн шүүгдэгчид шүүх хуралдаан дуусмагц төрөл

садангийн хүнтэйгээ нэг удаа уулзах боломж олгоно.

332 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

332.1. Дор дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болно:

332.1.1.шийтгүүлсэн этгээд ялаа эдлэхэд саад болох хүнд өвчнөөр өвчилсөн бол эдгэртэл нь;

332.1.2. шийтгүүлсэн этгээд жирэмсэн бол төрөхөөс өмнө 45 хоног, төрснөөс хойш 1 жилээс илүүгүйгээр;

332.1.3. байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, эсхүл гэр бүлийн доторхи хөдөлмөрийн чадвартай ганц хүн хүнд өвчнөөр өвчилсөн, бусад онцгой нөхцөл байдлаас болж ялыг эдлүүлэх боломжгүй бол 3 сараас хэтрүүлэхгүйгээр;

332.2. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдийн талаар гарсан тогтоол биелүүлэх явдлыг хойшлуулж болохгүй.

332.3. Шийтгүүлсэн этгээд торгуулийг богино хугацаанд төлөх бололцоогүй байвал 6 сар үртэл хойшлуулах буюу мөн хугацааны дотор эсэгчлэн төлүүлж болно.

333 дугаар зүйл. Өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлөх

333.1. Албадан ажил хийлгэх, аривчлах, хорих ял шийтгүүлсэн этгээд ял эдлэх угацаандаа сэтгэцийн буюу бусад хүнд өвчнөөр вчилсний улмаас түүнийг ял эдлүүлэх боломжгүй айдалд хүргэвэл прокурор тухайн төрлийн ял длүүлж байгаа байгууллагын саналыг үндэслэн урваас доошгүй их эмчийн бүрэлдэхүүнтэй комисс омилж дүгнэлт гаргуулна.

333.2.Энэ хуулийн 333.1-д заасны агуу томилогдсон комисс ял эдлүүлэх боломжгүй эсэн дүгнэлт гаргавал прокурорын саналыг ндэслэн шүүгч ялтанд эмнэлгийн чанартай лбадлагын арга хэмжээ хэрэглэж, сэтгэцийн эмгэг удлалын тусгай буюу бусад эмнэлэгт байлгах, схүл түүнийг цаашид ял эдлэхээс чөлөөлөх тухай ахирамж гаргана.

333.3. Ял эдэлж байгаа этгээд бие охтэндээ санаатайгаар гэмтэл учруулснаас вчилсөн бол ял эдлүүлэхээс чөлөөлөхгүй.

333.4.Өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх тухай шүүгчийн захирамж гарсан бол тухайн этгээдийг шүүх хуралдааны танхимаас нэн даруй суллана.

333.5. Өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх тухай шүүгчийн захирамжид давж заалдах гомдол гаргаж болохгүй ба харин прокурор эсэргүүцэл бичиж болно.

334 дүгээр зүйл. Ялаас хугацааны өмнө суллах, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих

334.1. Эрүүгийн хуулийн 74, 76, 77 дугаар зүйлд зааснаар ялаас хугацааны өмнө суллах, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

334.2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялаас хугацаанаас өмнө чөлөөлөх асуудлыг шийтгүүлсэн этгээдийн хүсэлт, түүний ажиллаж байгаа газрын тодорхойлолтыг үндэслэн шүүгч шийдвэрлэнэ.

334.3. Ялаас хугацааны өмнө суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол шүүгчийн захирамж гарсан өдрөөс хойш 6 сарын дотор уг асуудлыг шүүх дахин авч хэлэлцэхгүй.

334.4. Ялаас хугацааны өмнө суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай хүсэлтийг шийдвэрлэхдээ гэмт хэргийн хүнд, хөнгөн, шийтгүүлсэн этгээдийн хувийн байдал, зан төлөв, засрал хүмүүжил зэргийг харгалзан үзнэ.

334.5. Ялаас хугацааны өмнө суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай захирамж гарсан бол уг этгээдийг нэн даруй суллана.

334.6. Ялаас хугацааны өмнө суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай захирамжид давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд харин прокурор эсэргүүцэл бичиж болно.

335 дугаар зүйл. Гянданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорих ялаар солих

335.1. Эрүүгийн хуулийн 52.11-д зааснаар гянданд хорих ялыг зохих дэглэмийн хорих

ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

335.2. Гянданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр солих тухай саналыг хэрэгсэгчүй болгосон тухай захирамж гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор уг асуудлыг шүүх дахин авч хэлэлцэхгүй.

336 дугаар зүйл. Торгох ялыг хорих ялаар солих, хорих ял оногдуулсан гэтгоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх

336.1. Торгох ялыг хорих ялаар солих, хорих ял оногдуулсан гэтгоол биелүүлэхийг хойшлуулснын хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай асуудлыг тухайн төрийн ялыг эдлүүлэх буюу уг ажиллагаанд хэналт тавьж байгаа байгууллагын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

336.2. Энэ хуулийн 336.1-д заасан захирамжид ердийн жүрмаар давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болно.

337 дугаар зүйл. Эмнэлгийн байгууллагад байсан хугацаат ял эдэлсэн хугацааны оруулан тооцох

337.1. Хорих ял эдэлж байсан этгээдийг эмнэлгийн байгууллагад байлгаж байсан бол уг хугацаат ял эдэлсэн хугацааны оруулан тооцно.

337.2. Хорих ял эдэлж байгаа этгээд бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулах буюу гэмт хэрэг үйлдэж байхдаа гэмтсэн, түүнчлэн хуурамчаар өвчилсэн бол уг этгээдийн эмнэлгийн байгууллагад байсан хугацаат ял эдэлсэн хугацааны оруулж тооцохгүй.

338 дугаар зүйл. Гэтгоолыг биелэгдээгүй байгаа бусад гэтгоолтой нэгтгэж биелүүлэх

338.1. Шийтгүүлсэн этгээдийн талаар биелэгдээгүй хэд хэдэн гэтгоол байгаа ба түүнийг сүүлчийн гэтгоол гаргасан шүүх мэдээгүй бол тухайн буюу түүнтэй адил эрхтэй бөгөөд гэтгоолыг биелүүлбэл зохих шүүх Эрүүгийн хуулийн 57, 58 дугаар зүйлийг удирдлага болгон шийтгүүлсэн этгээдэд бүх гэтгоолоор оногдуулсан ялыг нэгтгэж хэрэглүүх тухай захирамж гаргах үүрэгтэй.

339 дүгээр зүйл. Гэтгоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх

339.1. Гэтгоол биелүүлэхийг хойшлуулах, торгох, албадан ажил хийлгэх ялыг өөр ялаар солих, түүнчлэн гэтгоол биелүүлэх үед гарсан ямар нэг тодорхой биш зүйлийг тодруулах асуудлыг уг гэтгоол гаргасан шүүхийн шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.

339.2. Гэтгоол нь түүнийг гаргасан шүүхийн нутаг дэвсгэрийн харъяалалд үл хамаарах өөр орон нутагт биелэгдэж байгаа бол дээр дурдсан асуудлыг гэтгоол биелүүлж байгаа газрын адил эрхтэй шүүх, хэрэв тийм шүүх байхгүй бол дээд шатны шүүх шийдвэрлэж, захирамжийг гэтгоол гаргасан шүүхэд явуулна.

339.3.Өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих ангид эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд эдлүүлэхээр солих асуудлыг уг гэтгоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр гэтгоол биелүүлж байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

340 дүгээр зүйл. Гэтгоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх журам

340.1.Гэтгоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шүүх хуралдаанаар прокурорыг оролцуулан шийдвэрлэнэ.

340.2. Ялтан, түүний өмгөөлөгч, хэрэв гэтгоол биелүүлэх асуудал ирсэний нэхэмжлэлд хамаарагдаж байгаа бол ирсэний нэхэмжлэгчийг шүүх хуралдаанд дуудаж болох бөгөөд уг этгээд ирээгүй нь хэргийг хэлэлцэхэд саад болохгүй.

340.3. Шүүх ялтныг өвчний учир хугацаанаас нь өмнө ял эдлэхээс чөлөөлөх буюу эмнэлгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ дүгнэлт гаргасан эмч нарын комиссын төлөөлөгчийг заавал байлцуулна.

340.4. Ялаас хугацааны өмнө суллах буюу ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих гянданд эдлэх ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр солих, зохих дэглэмийн хорих ангид эдлэх ялыг гянданд хорих ялаар солих тухай асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

340.5. Хэрэг хэлэлцэх ажиллагаа шүүгчийн мэдээллээр эхлэх бөгөөд шүүх хуралдаанд ирсэн хүмүүсийн санал бодлыг прокурорын дүгнэлтийг сонсож, улмаар шүүгч захирамж гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

341 дүгээр зүйл. Ялгүйд тооцох тухай хүсэлтийг хэлэлцэх

341.1. Эрүүгийн хуулийн 78.3-д зааснаар хугацаанаас өмнө ялгүйд тооцох тухай асуудлыг ялаа эдэлж дууссан этгээдийн оршин байгаа газрын шүүхийн шүүгч ял эдэлсэн этгээд, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

341.2. Энэ хуулийн 341.1-д заасан хүсэлтийг хэлэлцэхэд прокурор, өмгөөлөгч, холбогдох этгээд, хүсэлт гаргасан байгууллагын төлөөлөгчийг оролцуулж болох ба уг этгээд ирээгүй нь хүсэлтийг хэлэлцэхэд саад болохгүй.

341.3.Ялгүйд тооцох тухай хүсэлтийг хэлэлцэх ажиллагаа нь шүүгчийн мэдээллээр эхлэх бөгөөд прокурорын дүгнэлт, шүүхэд дуудагдсан хүмүүсийн саналыг сонсоно.

341.4. Ялгүйд тооцох хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, захирамж гаргасан бол 1 жилийн дотор уг хүсэлтийг шүүх дахин авч хэлэлцэхгүй.

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
Хяналтын шатны шүүхийн ажиллагаа

342 дугаар зүйл. Хяналтын журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих

342.1. Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 303, 304 дүгээр зүйлд заасны дагуу хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргах эрхтэй.

343 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих журам

343.1. Хяналтын шатны шүүхэд гаргаж байгаа гомдол, эсэргүүцлийг тогтоол, магадлал гаргасан шүүхээр дамжуулан гаргана.

344 дүгээр зүйл. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн тухай мэдэгдэх

344.1.Тогтоол, магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн тохиолдолд анхан шатны болон давж заалдах шатны шүүх энэ тухай талуудад мэдэгдэж, гомдол, эсэргүүцлийн талаар тайлбар өгөх эрхтэйг нь мэдэгдэнэ.

345 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэний холбогдол

345.1. Тогтоол, магадлалд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан тохиолдолд гэдгээр тогтоол, магадлалын биелэлт түдгэлзэнэ.

345.2. Гомдол, эсэргүүцэл бичсэн этгээд хяналтын шатны шүүхийн шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдол, эсэргүүцлээ буцаан авч болно.

346 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

346.1.Улсын дээд шүүх хяналтын шатны гомдол, эсэргүүцэлтэй хэргийг хүлээн авсны дараа Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнийг томилно.

346.2.Шүүх хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба хэргийн ээдрээ түвэгтэй байдлыг харгалзан энэ хугацааг Танхимын тэргүүн шүүгч 14 хоногийн хугацаагаар сунгаж болно.

346.3. Хяналтын шатны шүүх хуралдааны товыг шүүгч тогтоож, талуудад мэдэгдэнэ.

347 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

347.1.Хяналтын журмаар хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр байна.

347.2. Энэ хуулийн 347.1 -д заасан тогтоол хуульд харшилсан гэж үзсэн Улсын ерөнхий прокурор, эсхүл Улсын дээд шүүхийн шүүгчийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан тохиолдолд хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан хэлэлцэнэ.

348 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхээс хянавал зохих байдал

348.1. Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянана.

348.2.Анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бол хяналтын шатны шүүх тогтоол, магадлалыг хүчингүй болгох буюу өөрчилнө.

348.3.Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэдгийг энэ хуулийн 320, 321 дүгээр зүйлүүдэд заасан утгаар ойлгоно.

349 дүгээр зүйл. Хэригийг хяналтын шатны шүүхэд хянан шийдвэрлэх

349.1. Хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба уг эгэзэд энэ тухай хүсэлт гаргасан бол түүнийг заавал оролцуулна.

349.2. Энэ хуулийн 349.1-д зааснаас бусад тохиолдолд прокурор, өмгөөлөгч ирээгүй нь хэрэг хэлэлцэхэд саад болохгүй.

349.3.Хэргийг гомдол, эсэргүүцлийн дагуу хянасан шүүгч шүүх хуралдаанд илтгэнэ.

349.4.Илтгэгч хэргийн байдал, тогтоол, магадлал болон эсэргүүцлийн агуулгыг танилцуулж, дараа нь шүүгч илтгэгчид асуулт тавьж, улмаар прокурор, өмгөөлөгч тухайн хэргийн талаар санал хэлж болно.

349.5. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж тогтоол гаргах ба түүнийг шүүгчдийн олонхийн саналаар батална.

350 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэр

350.1. Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

350.1.1. тогтоол, магадлалыг хэвээр үлдээж гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох;

350.1.2. тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах;

350.1.3. тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах.

351 дүгээр зүйл. Тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах

351.1. Анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн нь тогтоогдвол хяналтын шатны шүүх хөнгөн ялтай хууль хэрэглэж, хэргийн зүйлчлэлийг өөрчилсөнтэй холбогдуулан ялыг хөнгөрүүлж болно.

351.2. Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр тогтоогдоогүй байдал, үүйсэгдсэн нотлох баримтыг үндэслэж тогтоол, магадлалд өөрчлөлт оруулах эрхгүй.

352 дугаар зүйл. Тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах

352.1. Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөнийг тогтоовол хяналтын шатны шүүх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаана.

353 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ

353.1. Шүүх хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхдээ хэргийн бүх ажиллагааг бүрэн хянаж үзэх үүрэгтэй.

353.2.Хэрэгт хэд хэдэн эгэзэд шийтгүүлсэн бөгөөд гомдол, эсэргүүцэл нь шийтгүүлсэн нэг буюу хэсэг эгэзэдийн талаар бичигдсэн байсан ч шүүх хэргийг бүх шийтгүүлэгчдийн талаар хянан хэлэлцэх үүрэгтэй.

353.3. Хяналтын шатны шүүхийн заалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхээр шинэчлэн хэлэлцэхэд заавал биелүүлнэ.

353.4.Хяналтын шатны журмаар хэрэг хянан хэлэлцэж байгаа шүүх анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлалаар тогтоогдоогүй буюу үүйсэгдсэн баримтыг тогтоох, түүнийг нотлогдсон гэж үзэх, ямар нэг нотлох баримтыг нөгөөгөөс нь ач холбогдолтойд тооцох, анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсгийг хэрэглэх, ямар ял оногдуулах тухай асуудлыг урьдчилан шийдвэрлэх эрхгүй.

354 дүгээр зүйл. Хяналтын шатны шүүхийн тогтоолын агуулга

354.1. Хяналтын шатны шүүхийн тогтоол энэ хуулийн 325 дугаар зүйлийн шаардлагад нийцсэн байна.

354.2. Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

355 дугаар зүйл. Тогтоол, магадлалыг хүчингүй болгосны дараа хэргийг дахин хэлэлцэх

355.1. Тогтоол, магадлалыг хүчингүй болгосны дараа хэргийг дахин шийдвэрлэхдээ ердийн журмаар хэлэлцэнэ.

355.2. Хэргийг дахин хэлэлцээд гаргасан шүүхийн тогтоолд ердийн журмаар гомдол гаргаж эсэргүүцэл бичиж болно.

356 дугаар зүйл. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хэргийг хяналтын шатны шүүхэд заавал хянан хэлэлцэх

356.1. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр гомдол, эсэргүүцэл гарсныг харгалзахгүйгээр заавал хянан хэлэлцэнэ.

ДӨЧДҮГЭЭР БҮЛЭГ
Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх

357 дугаар зүйл. Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх үндэслэл

357.1. Дор дурдсан нөхцөл байдал тогтоогдвол шинэ нөхцөл байдал гэж үзэж урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг сэргээн шалгаж болно:

357.1.1. гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт, орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, түүнчлэн хуурамч эд мөрийн баримт, төмдэглэл, баримт бичгийг үндэслэж тогтоол, магадлал гаргасан нь тогтоогдсон ;

357.1.2.хэрэг бүртэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь эрх хэмжээгээ хортойгоор урвуулан ашигласан нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоолоор тогтоогдсон ;

357.1.3.цагаатгагдсан буюу хэрэг нь хэрэгсэхгүй болгогдсон этгээд гэм буруутай болохыг нотлох, эсхүл гэм буруугүй этгээдэд ноогүйн хариуцлага оногдуулахад хүргэсэн, түүнчлэн урьд нь эрүүгийн хариуцлага үлээлгэснээс хөнгөн буюу хүнд ялтай зүйл, хэсэг, заалт хэрэглэх үндэслэл болох өмнө нь шүүх гэтгоол, магадлал гаргах үед мэдэгдээгүй байсан өхцөл байдал илэрсэн;

357.2. Хөвн хэлэлцүх хугацаа өнгөрсөн, ершөөл үзүүлэх тухай хууль гарсан, уучлал зүүлсэн, түүнчлэн яллагдагч нас барснаас шүүхийн гэтгоол гаргах бололцоогүй болсон бол энэ хуулийн 57.1-д дурдсан шинээр илэрсэн нөхцөл байдлыг эн хуулийн 360 дугаар зүйлд дурдсан журмаар ердэж тогтооно.

358 дугаар зүйл. Шинэ нөхцөл байдлын лмаас хэргийг сэргээх хугацаа

358.1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын лмаас цагаатгасан буюу хэргийг хэрэгсэхгүй олгосон тухай шүүхийн тогтоол, магадлалыг хянаж эх, түүнчлэн шийтгэгдсэн этгээдэд хүнд ялтай гүлийг хэрэглэх шаардлагатай болсон бол зөвхөн эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд заасан эрүүгийн ариуцлагад татаж болох хөнгөн хэлэлцэх хугацааны отор, шинэ нөхцөл байдал илэрснээс хойш 1 жил игэрөөгүй бол гүйцэтгэж болно.

358.2.Шинэ нөхцөл байдал илэрснээс шийтгэх тогтоолыг хянаж үзэх явдал нь шийтгэгдсэн этгээдэд ашигтай байвал хугацаагаар хязгаарлахгүй.

358.3. Шийтгэгдсэн этгээдийг цагаатгахын тулд хэргийг шинэ нөхцөл байдал илэрснээс сэргээхэд үг этгээд нас барсан нь саад болохгүй.

359 дүгээр зүйл. Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийн ажиллагаат үүсгэх

359.1.Шинэ нөхцөл байдал илэрсэн тухай гомдол, хүсэлтийг прокурорт явуулна.

359.2. Энэ хуулийн 357 дугаар зүйлд дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал прокурор шинэ нөхцөл байдал илэрснээс хэргийн ажиллагаат үүсгэх тухай тогтоол гаргаж, уг байдлыг мөрдөн шалгах, эсхүл энэ талаар хэрэг бүртэгч, мөрдөн байцаагчид даалгавар өгнө.

359.3.Шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгахад энэ хуулд заасан журмыг баримтлан шаардлагатай байцаан шийтэх ажиллагаат гүйцэтгэнэ.

359.4.Прокурор шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж, гомдол, хүсэлтийг хэрэгсэхгүй орхих ба түүнийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

359.5. Шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгах ажиллагаа эхэлмэгц хэргийн хугацааг шинээр тогтоож, хугацаа сунгахад энэ хуулд заасан журмыг баримтална.

360 дугаар зүйл. Шинэ нөхцөл байдлыг мөрдөж дуусмагц прокуророос гүйцэтгэх ажиллагаа

360.1. Шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгахад энэ хуулийн 357.1-д заасан үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол прокурор уг хэргийг мөрдсөн материал ба өөрийн дүгнэлтийн хамтаар энэ хуулийн 361 дугаар зүйлийг удирдлага болгон Улсын Дээд Шүүхэд хүргүүлнэ.

360.2.Хэргийг сэргээх үндэслэл тогтоогдоогүй бол прокурор үндэслэл бүхий тогтоол гаргаж, хэргийн ажиллагаат зогсоох ба энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

361 дүгээр зүйл. Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх тухай асуудлыг шүүх шийдвэрлэх

361.1.Энэ хуулийн 360 дугаар зүйлд заасны дагуу прокуророос шилжүүлсэн хэрэг, материалыг Улсын дээд шүүх хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.

362 дугаар зүйл. Прокурорын дүгнэлтийг хянаж үзэзд шүүхээс гаргах магадлал

362.1.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүх хэргийг хянаж хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана:

362.1.1. тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүрттэлт, мөрдөн байцаалт буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах;

362.1.2. тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох;

362.1.3.прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгох.

363 дугаар зүйл. Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээсний дараа гүйцэтгэх ажиллагаа

363.1. Шинэ нөхцөл байдлын улмаас тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг сэргээсний дараа хэрэг бүрттэлт, мөрдөн байцаалт явуулах, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, түүнчлэн шинээр гаргасан тогтоолд гомдол, эсэргүүцэл гаргахаа энэ хуулиар тогтоосон ердийн журмыг баримтална.

363.2. Шинэ нөхцөл байдлын улмаас түрүүчийн тогтоолыг хүчингүй болгосон бол анхан шатны шүүх уг хэргийг дахин шийдвэрлэхдээ өмнөх тогтоолын аливаа заалтыг удирдлага болгохгүй.

АРАВДУГААР ХЭСЭГ
ДӨЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журам

364 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журам

364.1. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа энэ хуульд заасан ердийнхөөс гадна энэ бүлэгт дурдсан тусгай журмыг удирдлага болгоно.

364.2. Энэ бүлэгт дурдсан журмыг гэмт хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй байсан этгээдийн үйлдсэн хэрэгт хэрэглэнэ.

365 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэргийн талаар нэмж тогтоовол зохих байдлууд

365.1. Насанд хүрээгүй этгээдийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах буюу шүүхээр хянан хэлэлцэхэд энэ хуулийн 80 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан байдлыг тодруулна:

365.1.1. төрсөн он, сар, өдөр, нас;

365.1.2. амьдралын нөхцөл байдал ба хүмүүжил;

365.1.3. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;

365.1.4.насанд хүрсэн хатагч ба бусад хамтран оролцогч байсан эсэх;

365.1.5.сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан саная нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрөөд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах.

365.2. Энэ зүйлд заасан байдлыг тогтоохын тулд насанд хүрээгүй этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургагч хүмүүжүүлэгч болон хэрэгт ач холбогдол бүхий зүйлийг мэдэж болох бусад хүмүүсийг байцаах, түүнчлэн хэрэгцээтэй баримт бичгийг шаардан авах буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхийн бусад ажиллагаа явуулна.

366 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдийг баривчлах ба цагдан хорих

366.1. Гагцхүү үйлдсэн хэрэг нь хүнд, онц хүнд ба энэ хуулийн 58, 62, 68 дугаар зүйлд заасан онцгой тохиолдолд насанд хүрээгүй этгээдийг баривчлах буюу цагдан хорьж болно.

366.2. Насанд хүрээгүй этгээдийг баривчилсан, цагдан хорьсон тухай түүний эцэг эх, хууль ёсны бусад төлөөлөгч, өмгөөлөгчид нь 12 цагийн дотор мэдэгдэнэ.

366.3. Баривчилсан ба цагдан хоригдсон насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн болон шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдээс тусгайд н

байлгана.

366.4.Насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндсэн хугацаа нэг сар байх бөгөөд хорьж мөрдөх хугацаа 18 сараас хэтэрч болохгүй.

367 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдийг хяналтад өгөх

367.1. Насанд хүрээгүй этгээдэд энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авахаас гадна түүнийг эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн хяналтад шилжүүлэн өгч болно.

367.2. Насанд хүрээгүй этгээдийг эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн хяналтад шилжүүлэхэд уг этгээд нь насанд хүрээгүй этгээдийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ба шүүхээс дуудсан цагт ирүүлж байх, түүнийг төлөв гомоотой байлгах үүргийг бичгээр өгнө.

367.3. Насанд хүрээгүй этгээдийг хяналтдаа авч байгаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид түүний сэрдэгдэж байгаа буюу яллагдах гэж байгаа хэргийн талаар мэдэгдэж, хүлээсэн үүргээ зөрчвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулна.

367.4.Насанд хүрээгүй этгээдийг хяналтдаа авсан этгээд хүлээсэн үүргээ зөрчвөл түүнд энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

368 дугаар зүйл. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг дуудах журам

368.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг тэдний эцэг, эх буюу хууль ёсны бусад төлөөлөгчөөр нь дамжуулан дуудах ба өвхөн хэргийн байдлаас шалтгаалж өөр журмаар ирүүлж болно.

368.2. Цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийг цагдан хорих байрны захиргаагаар дамжуулан дуудна.

369 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэргийг тусгаарлах

369.1.Насанд хүрээгүй этгээд насанд хүрсэн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд бололцоо байвал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэргийг нь тусгаарлана.

369.2. Насанд хүрээгүй этгээдийн хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитойгоор илрүүлэхэд ноцтой саад учруулахаар байвал тусгаарлахгүй байж болно.

370 дугаар зүйл. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаах журам

370.1. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг нэг удаа байцаахдаа 2 цаг, өдөрт 4 цагаас хэтрүүлж болохгүй ба 2 цагаас илүү байцаах тохиолдолд завсарлана.

371 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах

371.1.Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг байлцуулж болох ба оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзвэл сурган хүмүүжүүлэгчийг заавал байлцуулна.

371.2. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаахад байлцсан сурган хүмүүжүүлэгч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр сэжигтэн, яллагдагчид асуулт тавих эрхтэй.

371.3. Байцаалт дууссаны дараа түүнд байлцсан сурган хүмүүжүүлэгч тэмдэглэлтэй танилцах ба түүнд бичигдсэн зүйл бүрэн зөв болсон эсэх талаар саналаа бичгээр өгөх эрхтэй.

371.4.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч насанд хүрээгүй этгээдийг байцаахын өмнө сурган хүмүүжүүлэгчид түүний эрхийг тайлбарлан өгөх үүрэгтэй бөгөөд тэр тухайгаа тэмдэглэлд дурдана.

372 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хууль ёсны төлөөлөгч оролцох

372.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолоор насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоож, түүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад ямар эрхтэй оролцохыг тайлбарлана.

372.2. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч нь дор дурдсан эрхтэй:

372.2.1. насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг ямар хэрэгт сэрдэгдэж байгааг мэдэх;

372.2.2.ял сонсгоход байлцах;

372.2.3. байцаалт, сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгчийг байлцуулан хийж байгаа бусад ажиллагаанд мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр оролцох;

372.2.4. байлцсан ажиллагааны талаар саналаа бичгээр өгөх;

372.2.5. нотлох баримтын ач холбогдол бүхий зүйлийг шалгуулах хүсэлт тавих.

373 дугаар зүйл. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг хэргийн материалтай танилцуулах

373.1.Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчид хэргийн материалыг танилцуулахад түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулна.

373.2.Насанд хүрээгүй эгтээдийн сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь насанд хүрээгүй яллагдагчид хэргийн материалыг танилцуулахад түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулахгүй байж болно.

374 дүгээр зүйл. Шүүх хуралдаанд насанд хүрээгүй шүүгдэгчийн эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулах

374.1. Насанд хүрээгүй шүүгдэгчийн эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож нотлох баримт шинжлэхэд оролцох, нотлох баримтын ач холбогдол бүхий баримт, хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцогчийг татгалзан гаргах эрхтэй ба шүүх хуралдаан эхлэхэд тэдэнд энэ эрхийг тайлбарлаж өгнө.

374.2. Шүүгдэгчийн эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг гэрчээр байцаах шаардлагатай бол түүний мэдүүлгийг хохирогчийг байцаасны дараа сонсоно.

374.3.Шүүгдэгчийн эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгч шүүх хуралдааны ажиллагааны туршид байлцана.

374.4. Шүүх хуралдаанд эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгч оролцох нь насанд хүрээгүй шүүгдэгчийн сонирхолд хохирол учруулж болохуйц онцлох шалтгаан байвал шүүх тэр тухай үндэслэл бүхий тогтоол, шүүгч захирамж гаргаж эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг шүүх хуралдаанд оруулахгүй байх буюу шүүх хуралдааны аль нэгэн хэсэгт оролцохыг хязгаарлах эрхтэй.

374.5. Шүүгдэгчийн эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчийг оролцуулах нь зайлшгүй шаардлагатай гэж шүүх үзээгүй бол тэдний ирэхгүй нь үг хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулах шалтгаан болохгүй.

375 дугаар зүйл. Насанд хүрээгүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимаас гаргах

375.1. Насанд хүрээгүй эгтээдэд сөрөг нөлөөлж болох байдлыг шинжлэх үед шүүх нь шүүгдэгчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийн санал, прокурорын дүгнэлтийг сонсож, тогтоол захирамж гаргаж, түүнийг шүүх хуралдаанд танхимаас гаргах эрхтэй.

376 дугаар зүйл. Насанд хүрээгүй эгтээдэд хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулахтай холбогдсон ажиллагаа

376.1. Насанд хүрээгүй эгтээдэд хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулах асуудлыг хүүхдийн болон цагдаагийн байгууллагын хамтран гаргасан хүсэлтийг үндэслэн тухайн эгтээдийн оршин суугаа газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

376.2. Хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг Эрүүгийн хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгож, шийтгэгдсэн эгтээдэд ялыг биечлэн эдлүүлэх асуудлыг хохирогч хүүхдийн болон цагдаагийн байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн тухайн эгтээдийн оршин суугаа газрын шүүх шийдвэрлэнэ.

377 дугаар зүйл. Насанд хүрээгүй эгтээдийн үйлдсэн хэргийн талаар шийтгэх тогтоол гаргах үед шүүхээс шийдвэрлэх асуудал

377.1. Насанд хүрээгүй эгтээдийн үйлдсэн хэргийн талаар тогтоол гаргахдаа шүүх дордсан асуудлыг шийдвэрлэнэ:

377.1.1.хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуульд заасан үндэслэлээр хойшлуулах боломж байгаа эсэх;

377.1.2. хорихоос өөр төрлийн хөнгөн ял оногдуулах, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тохиолдолд уг эгтээдэд олон нийтийн хүмүүжүүлэх томилох шаардлагатай эсэх.

ДӨЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх ажиллагаа

378 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл

378.1. Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсөн бөгөөд үйлдсэн хэргийн шинж, өвчин байдлаараа уг эгтээд нийгэмд аюултай байвал шүү

үүнд Эрүүгийн хуулийн 65 дугаар зүйлд дурдсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ эрэглэнэ.

378.2. Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ энэ хуулийн ренхий үндэслэл болон энэ бүлэгт дурдсан журмыг аримтална.

379 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах журам

379.1. Энэ хуулийн 385 дугаар зүйлд заасан гээдийн үйлдсэн гэмт хэрэгт заавал мөрдөн байцаалт явуулах ба дараахь байдлыг нэмж эгтооно:

379.1.1. уг этгээд урьд нь сэтгэцийн эчнөөр өвчилж байсан эсэх, хэрэг үйлдэх буюу эрдэн шалгах үед уг өвчний байдал, явц, шинж лар байсан;

379.1.2.гэмт хэрэг үйлдэхийн өмнө олон дараа уг этгээдийн зан байдал ямар байсан.

379.2. Энэ хуулийн 379.1-д заасан этгээд мт хэрэг үйлдсэнийг нотлох гарцаагүй баримт ийгаа бөгөөд тэр үндэслэлээр эрүүгийн хэргийг гсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж ийгаа бол түүнд сэтгэцийн эмгэгийн шинжилгээ ийлгэнэ.

379.3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тгэцийнх нь өвчнөөс шалтгаалан хэрэг бүртгэлт, эрдэн байцаалтын ажиллагаанд оролцуулах ломжгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ кай тэмдэглэл үйлдэнэ.

380 дугаар зүйл. Өмгөөлөгчийг олцуулах

380.1. Энэ хуулийн 378 дугаар зүйлд заасан гээдийн хэрэгт өмгөөлөгчийг заавал оролцуулна.

381 дүгээр зүйл.Хэрэг бүртгэлт,мөрдөн йцаалтыг дуусгах

381.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн йцаалт явуулж дуусмагц дараахь шийдвэрийн аль нийг гаргана:

381.1.1. энэ хуулийн 208 дугаар йлд заасан үндэслэл тогтоогдвол хэргийг эгсэхгүй болгох;

381.1.2. гэмт хэрэг үйлдсэн ээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга ажээ хэрэглэх үндэслэл тогтоогдвол хэргийг үхэд шилжүүлэх тухай тогтоол үйлдэж, журорт шилжүүлнэ.

381.2.Тогтоолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар тогтоогдсон бүх байдал ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх болсон үндэслэлийг бичнэ.

381.3. Прокурор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах нь зөв гэж үзвэл тогтоолыг баталж, шүүхэд шилжүүлэх ба хэрэв зөвшөөрөхгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгох буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаана.

382 дугаар зүйл. Шүүх хуралдааныд бэлтгэх ажиллагаа

382.1. Шүүх хэргийг хүлээж авмагц түүнийг хэлэлцэх едрийг товлон шүүгчийн захирамж гаргаж, энэ тухай прокурор, өмгөөлөгч, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэж гэрч, хохирогч, шаардлагатай бол шинжээчийг дуудна.

382.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өвчний шинж байдлыг харгалзан түүнийг шүүх хуралдааныд оролцуулж болно.

383 дугаар зүйл. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх ажиллагаа

383.1. Энэ хуулийн 381 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүхэд шилжиж ирсэн хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй энэ хуулийн гучин нэгээс гучин тавдугаар бүлэгт дурдсан журмын дагуу иргэдийн төлөөлөгч, улсын яллагч, өмгөөлөгчийг заавал оролцуулан шүүх хуралдаанаар хэлэлцэнэ.

383.2. Шүүх хуралдаан уг этгээд гэмт хэрэг үйлдсэнийг нотолж байгаа буюу үгүйсгэж байгаа нотлох баримтыг шалгаж, түүний сэтгэцийн өвчний талаар гаргасан шинжээчийн дүгнэлтийг сонсож, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад байдлыг хянан үзнэ.

383.3. Шүүх нь шүүхийн хэлэлцүүлэг дуусмагц иргэдийн төлөөлөгч болон улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн үгийг сонсоно.

384 дүгээр зүйл. Шүүх хэргийг шийдвэрлэх

384.1. Шүүх хэргийг зөвлөлдөх тасалгаанд тогтоол гаргаж шийдвэрлэх ба дор дурдсан асуудлыг шийдвэрлэнэ:

384.1.1. Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг гарсан эсэх;

384.1.2. уг этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэн эсэх;

384.1.3.тухайн этгээд гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн өвчтэй байсан эсэх, эсүүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа тийм өвчнөөр

өвчилсний алин болох;

384.1.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай бол ямар арга хэмжээ хэрэглэх.

385 дугаар зүйл. Шүүхийн тогтоол

385.1. Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй үедээ гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсөн нь нотлогдвол шүүх уг эгтээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

385.2.Энэ хуулийн 385.1-д заасан этгээд нийгэмд аюулгүй болсон бөгөөд үйлдсэн хэрэг, түүнээс учирсан хохирол нь ноцтой биш бол эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгож, энэ тухай эмнэлгийн байгууллагад мэдэгдэж болно.

385.3. Сэтгэцийн өвчтэй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа тийм өвчнөөр өвчилсэн гэдэг нь тогтоогдоогүй, түүнчлэн уг этгээд өвчилсэн боловч ялаас чөлөөлөгдөх үндэслэлгүй гэж шүүх үзвэл уг хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах ба цаашид уг хэргийг ердийн журмаар шалгаж шийдвэрлэнэ.

385.4. Энэ хуулийн 385.1-д заасан этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй, эсхүл энэ хуулийн 24 дүгээр зүйлд дурдсан байдал тогтоогдвол түүний өвчилсэн эсэхийг үл харгалзан хэргийг хэрэгсэхгүй болгоно.

385.5. Шүүхийн тогтоолд энэ хуулийн 298 дугаар зүйлд заасан асуудлыг шийдвэрлэсэн байвал зохино.

386 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүчингүй болгох буюу өөрчлөх

386.1. Өвчин нь эдгэрсэн буюу эрүү мэндийн байдал нь сайжирсан бол уг этгээдий эмчилж байгаа эмнэлгийн байгууллагын хүсэлт, эм нарын комиссын дүгнэлтийг үндэслэн шүүг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хүчингүй болгох буюу өөрчлөх тухай асуудлыг эн хуулийн 340.1, 340.5- д заасан журмын дагу хэлэлцэнэ.

386.2. Эмнэлгийн чанартай албадлагы арга хэмжээг хүчингүй болгох буюу өөрчлөх туха хүсэлтийг уг эгтээдийн төрөл, садангийн сонирхо болон бусад этгээд гаргаж болох ба хэрэв ий хүсэлт гарвал шүүх уг эгтээдийн эрүүл мэндий байдлыг эмнэлгийн байгууллагаас лавлана.

386.3.Эмнэлгийн чанартай албадлагын ар хэмжээг хүчингүй болгох буюу өөрчлөх тух асуудлыг уг тогтоол гаргасан шүүгч, эсхүл тэр ар хэмжээг биелүүлж байгаа газрын шүүх прокурор заавал оролцуулан шийдвэрлэнэ.

387 дугаар зүйл. Эмнэлгийн чанарта албадлагын арга хэмжээ авагдсан этгээдий хэргийг сэргээх

387.1. Гэмт хэрэг үйлдсэнийхээ дар сэтгэцийн өвчнөөр өвчилж эмнэлгийн чанарт албадлагын арга хэмжээ авагдсан этгээд эдгэрс гэж эмч нарын комисс үзсэн бол шүүх энэ хуули 340 дүгээр зүйлд заасны дагуу уг арга хэмжэ хүчингүй болгож, уг этгээдийг хэрэг бүртгэ мөрдөн байцаалт явуулах байгууллага, эсх шүүхэд шилжүүлнэ.

387.2.Энэ хуулийн 387.1-д заасны даг шилжиж ирсэн этгээдийн хэрэгт ердийн журма хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах бу шүүхээр хэлэлцэн шийдвэрлэнэ.

387.3.Эмнэлгийн байгууллагад байс хугацаат хоригдсон хугацаанд оруулан тооцно.

АРВАН НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
БУСАД ЗҮЙЛ

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах

388 дугаар зүйл. Хохирол арилгуулах эрх

388.1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж ава орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөх сэргээлгэх эрхтэй.

389 дүгээр зүйл. Хохирлыг нөхөн төлүүл үндэслэл

389.1. Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, аривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр тудгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга эмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг ертэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бруу үл харгалзан төр хариуцан арилгана.

389.2. Дараахь тохиолдолд хохирол нөхөн олгүүлэх эрх үүснэ:

389.2.1. баривчлагдсан буюу цагдан оригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь отлогдоогүйгээс суллагдсан;

389.2.2. тухайн иргэнийг цагаатгасан үүхийн тогтоол гарсан;

389.2.3. тухайн хэрэг нь гэмт ргийн бүрэлдэхүүнгүй, эсхүл тухайн этгээд гэмт рэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг рэгсэхүй болгосон;

389.2.4. эмнэлгийн чанартай ибадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн уль бус тогтоолыг хүчингүй болгосон бол.

389.3. Өршөөлийн тухай хуулийн дагуу ял, үүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс лөөлсөн, хэрэг хянах ажиллагааг зогсоосон, члал үзүүлсэн, хөөн хэлэлцэх хугацаа дуусан, үүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй, хүл тухайн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага үл лээлгэх болон ялыг хөнгөрүүлсэн хууль тлагдсанаар хүчингүй болсон, өөрчлөгдсөн киолдолд энэ хуулийн 389.1 нь үйлчлэхгүй.

389.4. Хууль бус ажиллагаатай холбогдож осан шууд бус хохирлыг төр хариуцахгүй.

389.5. Хүнийг хууль бусаар хохироосон эг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор,шүүгчид үль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

389.6. Энэ хуулийн 389.5-д заасан албан. ааltан хүнийг хууль бусаар хохироосон үйлдэл, үйлдэхүй нь гэмт хэрэг болох нь зохих журмаар тоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай эдээр бүрэн төлүүлнэ.

390 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг өн төлөх

390.1. Дор дурдсан эд хөрөнгийн хохирлыг ӨН төлнө:

390.1.1.хууль бус ажиллагааны аас иргэний аваагүй дундаж цалин хөлс болон жиргааны нь үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлого;

390.1.2.хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсооссон тэтгэвэр, тэтгэмж.;

390.1.3.шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон, түүнчлэн хэрэг бүртэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын гаргуулсан эд хөрөнгө;

390.1.4. шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж гаргуулсан торгууль, иргэнээр төлүүлсэн байцаан шийтгэх ажиллагааны болон бусад зардал;

390.1.5. хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс.

390.2. Энэ хуулийн 390.1.1, 390.1.4, 390.1.5-д заасан хохирлыг улсын төсвөөс нөхөн олгоно.

390.3. Нөхөн төлөх эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоохдоо тухайн иргэн ял эдэлж байхдаа авсан цалин хөлс, эсхүл ажил, албан тушаалаас халагдсанаас хойшхи хугацаанд өөр ажил, албан тушаал эрхэлж авсан цалин хөлсийг хасч тооцно.

390.4.Ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр, тэтгэмжийг нийслэлийн даатгалын болон холбогдох бусад байгууллага нөхөн олгоно.

390.5. Энэ хуулийн 390.1.3-д заасан эд хөрөнгийг холбогдох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон прокурор,шүүхийн байгууллага биет байдлаар нь буцаж олгох боломжгүй бол анхны үнэлгээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

390.6. Эд хөрөнгийн үнийг түүнийг нөхөн төлүүлэх шийдвэр гарах үеийн үнэлгээгээр тодорхойлно.

390.7. Эд хөрөнгө гэмтсэн тохиолдолд учирсан хохирлыг бүрэн нөхөн төлнө.

391 дүгээр зүйл. Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах

391.1. Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуулиар заасан журмын дагуу нөхөн төлнө.

391.2. Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуулиар заасан журмаар тодорхойлно.

391.3.Сэтгэл санааны учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар заасан журмын дагуу гаргана.

392 дугаар зүйл. Цол, шагналыг сэргээх

392.1.Цэргийн болон бусад цол, шагналыг хууль бусаар хассаныг шүүх тогтоовол олгосон байгууллага нь шүүхийн шийдвэрийг үндэслэн сэргээж олгоно.

393 дугаар зүйл. Хуулийн этгээдэд хохирлыг нөхөн төлөх

393.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон прокурор, шүүхийн байгууллагын хууль бус ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан хохирлыг энэ бүлэгт заасан журмын дагуу төр хариуцна.

394 дүгээр зүйл. Хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагаа өгөх

394.1.Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүх, прокурор нь иргэнд зөрчигдсөн эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж өгөх, түүнчлэн иргэний хүсэлтийн дагуу 1 сарын дотор өөрийн гаргасан шийдвэрийн талаар түүний ажиллаж байгаа байгууллагад бичгээр лавлагаа өгөх үүрэгтэй.

394.2. Иргэнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлснээс дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хуулийн байгууллага тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан цагаатгасан тухай шийдвэрийн талаар 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй.

395 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах

395.1.Цагаатгах тогтоол, эсхүл эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон болон бусад хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчилсөн тухай тогтоолын хуулбарыг сонирхогч этгээдэд гардуулан өгөх буюу шуудангаар илгээнэ.

395.2.Энэ хуулийн 395.1-д заасан тогтоолтой хамт хохирлоо нөхөн төлүүлэх журмыг тайлбарласан хуудас хүргүүлэх бөгөөд түүнд хууль зөрчсөн ажиллагааны талаар нэхэмжлэл гаргах эрх, шүүхэд хандах хугацаа болон шүүхийн харъяаллын талаар дурдсан байвал зохино.

396 дугаар зүйл. Хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэл гаргах

396.1. Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг иргэн өөрөө буюу түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл тухайн иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүнчлэн өмгөөлөгч гаргаж болно.

396.2. Насанд хүрээгүй этгээдийн цагаатгасан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг түүний хууль ёсны төлөөлөгч гаргана.

396.3. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана.

396.4. Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласнаас хойш 1 жилийн дотор гаргаж болно.

396.5. Энэ хуулийн 396.3, 396.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол сонирхогч этгээдийн өргөдлөөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, эсхүл шүүх сэргээж болно.

396.6. Хохирогч нэхэмжлэлийг оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ шүүхэд гаргана.

396.7. Иргэн нас барсан тохиолдолд эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх эрх нь түүний өв залгамжлагчид, зогсоосон тэтгэвэр, тэтгэмж нь тэжээгчээ алдсны тэтгэвэр авах эрх бүхий гэр бүлийн гишүүнд тогтоосон журмын дагуу шилжинэ.

396.9. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон прокурор, шүүхийн байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг холбогдох байгууллага Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шүүхэд гаргана.

396.10. Энэ бүлэгт дурдсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргагч шүүхийн зардалд төлөхөөс чөлөөлөгдөнө.

397 дугаар зүйл. Хохирол арилгуулах тухай өргөдлийг хянан шийдвэрлэх

397.1. Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

ДӨЧИН ТАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүхийн байгууллага болон гадаад улсын холбогдох байгууллагын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа

398 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх

398.1. Гадаад улсын нутаг дэвсгэрт айцаалт, үзлэг, нэгжлэг, туршилт, эд хөрөнгө хураан вах болон энэ хуульд заасан хэрэг бүртгэлт, мөрдөн айцаалт, шүүхийн бусад ажиллагаа явуулах аардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа арилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад эрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

398.2. Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа вуулах даалгаврыг олон улсын гэрээ, хэлэлцээрт аасан байгууллагаар дамжуулан явуулна.

398.3. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй ол даалгаврыг явуулж байгаа улсын хэл дээр йлдэнэ.

399 дүгээр зүйл. Байцаан шийтгэх киллагааг явуулах тухай даалгаврын агуулга

399.1. Байцаан шийтгэх тодорхой ажиллагааг вуулах тухай даалгаврыг бичгээр үйлдэх ба түүнд араахь зүйлийг заана:

399.1.1. даалгавар өгч байгаа айгууллагын нэр;

399.1.2. даалгавар хүлээн авах айгууллагын нэр, хаяг;

399.1.3. даалгаврын утга ба хэргийн уулга;

399.1.4.даалгавартай холбоотой гээдийн иргэний харъяалал, эрхэлдэг ажил, оршин угаа буюу байрлаж байгаа газрын талаархи эдээлэл, хуулийн этгээдийн хувьд түүний нэр, хаяг;

399.1.5. эд мөрийн ба бусад нотлох римт;

399.1.6. зүйлчлэлийн тухай эдээлэл, шаардлагатай бол учирсан хохирлын мжээ.

399.2. Даалгавар, түүнд хавсаргаж байгаа римт бичиг, нотлох баримтыг хүлээн авах улсын бан ёсны хэл дээр орчуулж, эрх бүхий албан шаалтан гарын үсэг зурж, шаардлагатай бол тэмдэг рна.

400 дугаар зүйл. Гэрч, хохирогч, иргэний хэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, инжээчийг дуудах, байцаах

400.1. Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр агаагүй бол гадаад улсад байнга буюу түр хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дуудаж болно.

400.2. Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгч, шинжээчийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан дуудна.

400.3.Энэ хуулийн 400.1-д дурдсан гэрч, хохирогч болон бусад оролцогчийн хувьд дор дурдснаас бусад байцаан шийтгэх ажиллагааг энэ хуульд заасан журмыг баримтлан явуулна:

400.3.1. албадан ирүүлэх;

400.3.2. торгууль оногдуулах;

400.3.3. мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэх, дүгнэлт гаргахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх.

401 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааг явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын даалгаврыг биелүүлэх

401.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн байгууллага нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.

401.2. Даалгаврыг биелүүлэхэд тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

401.3. Олон улсын гэрээнд заасан бол даалгаврыг биелүүлэхэд гадаад улсын холбогдох байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

401.4.Даалгаврыг биелүүлэх боломжгүй бөгөөд олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Улсын ерөнхий прокурорын газар, эсхүл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан даалгавар өгсөн гадаадын байгууллагад биелүүлээгүй шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаана.

401.5. Даалгаврыг биелүүлэх нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд харшлах, эсхүл хууль тогтоомжийг зөрчихөд хүргэхээр байвал

түүнийг буцаана.

402 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хэргийн материалыг явуулах

402.1.Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсаас гарч явсан бол уг хэргийг шалгах явцад цугларсан бүх материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлнэ.

403 дугаар зүйл. Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх буюу эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлтийг биелүүлэх

403.1.Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг шалгах хүсэлт ирүүлсэн бол байцаан шийтгэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулна.

403.2. Энэ хуулийн 403.1-д заасан эттэздийн хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.

ДӨЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт эттэздийг шилжүүлэн өгөх

404 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт

404.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад тавина.

404.2. Хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

404.2.1. шилжүүлэн авах хүний овог, эцэг, эхийн болон өөрийнх нь нэр, төрсөн он, сар, өдөр;

404.2.2. иргэний харъяалал, гадаад төрх байдлын тодорхойлолт гэрэл зураг;

404.2.3. тухайн эттэздийн үйлдсэн хэргийн товч агуулга, хэрэглэх хуулийн заалт, шийтгүүлсэн бол шүүхээс оногдуулсан ял;

404.2.4. шийтгэх , эсхүл яллагдагчаар татах тухай тогтоол гаргасан он, сар, өдөр;

404.2.5.хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн батлагаат хуулбар .

405 дугаар зүйл. Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай шаардлагыг биелүүлэх

405.1. Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.

405.2. Энэ хуулийн 405.1-д заасан шилжүүлбэл зохих эттэзд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хорих ял эдэлж байгаа бол ялаа эдэлж дуустал, эсхүл ялаас чөлөөлөх хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

405.3.Шилжүүлэн өгөхийг хойшлуулбал хөөн хэлэлцэх хугацаа дуусах буюу гэмт хэргийг мөрдөхөд саад учруулахаар бол уг эттэздийг шилжүүлэн өгч болно.

406 дугаар зүйл. Шилжүүлэн өгөхөөс татгалзах

406.1. Дараахь тохиолдолд гэмт эттэздийг шилжүүлэн өгөхгүй:

406.1.1. Монгол Улсын иргэн;

406.1.2. гэмт эттэздэд Монгол Улсад орогнох эрх олгосон;

406.1.3. шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэслэл нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол;

406.1.4. шилжүүлбэл зохих эттэзд тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол;

406.1.5. Монгол Улсын хууль тогтоомжоор тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх буюу ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол.

407 дугаар зүйл. Давхар харъяалалтай болон харъяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх

407.1.Давхар харъяалалтай болон иргэнийг харъяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

408 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих

408.1.Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт эттэздийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчилж

шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ.

408.2. Энэ хуулийн 408.1-д заасны дагуу цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол прокурорын тогтоолоор уллана.

408.3. Энэ хуулийн 408.2-т заасны дагуу улласан этгээдийг шинээр хүсэлт тавьсан охиолдолд дахин цагдан хорьж болно.

409 дүгээр зүйл. Эд зүйл, бусад нотлох баримтыг шилжүүлэх

409.1. Энэ хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ.

409.2. Энэ хуулийн 409.1-д дурдсан нотлох баримтыг эрүүгийн өөр хэрэг шийдвэрлэхэд ашиглах шаардлагатай бол түүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.

409.3. Гадаад улсын холбогдох байгууллага хэргийг шийдвэрлэж дуусмагц энэ хуулийн 409. 1-д дурдсан эд зүйлийг буцааж өгөх тухай баталгаа гаргасан үед шилжүүлнэ.

ДӨЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Хорих ял шийтгүүлсэн этгээдийг харъяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх

410 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг харъяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх үндэслэл

410.1. Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харъяат улсад нь шилжүүлэн өгөх, түүнчлэн гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг Монгол Улсад шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гүйцэтгэнэ.

410.2. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх шийдвэрийг Улсын ерөнхий прокурор гаргаж, түүнийг шийдвэр гаргасан шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэнэ.

411 дүгээр зүйл. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг харъяат улсад нь шилжүүлэн өгөхөөс татгалзах

411.1. Дор дурдсан тохиолдолд Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харъяат улсад нь шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно:

411.1.1.уг этгээдэд ял оногдуулсан аль ч хэлдэл ялтныг харъяалах улсын хууль тогтоомжоор гэмт хэрэгт тооцогддоггүй бол;

411.1.2. ялтныг харъяалах улсын хууль тогтоомжоор хөөн хэлэлцэх хугацаа дууссан буюу улсад үндэслэлээр ялыг харъяалах улсад нь эдлүүлэх боломжгүй бол;

411.1.3. ялтан, эсхүл шилжүүлэн авах хүсэлт гаргасан улс шүүхийн шийтгэх тогтоолын иргэний хэмжлэлтэй холбогдолтой заалтыг биелүүлээгүй буюу тийм баталгаа өгөөгүй бол;

411.1.4. олон улсын гэрээнд заасан нөхцөлөөр ялтныг шилжүүлэн өгөх зөвшилцөлд хүрээгүй бол;

411.1.5. ялтан Монгол Улсад байнга оршин суугч байсан бол.

412 дугаар зүйл. Ял эдлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх

412.1. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг тухайн ялтан, түүний хууль ёсны төлөөлөгч буюу төрөл, садангийн хүн, түүнчлэн ялтны зөвшөөрснөөр тухайн улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллага Монгол Улсын ерөнхий прокурорт уламжилна.

412.2. Монгол Улсын ерөнхий прокурор хүсэлтийг хянаж, түүнийг хангах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

412.3.Монгол Улсын ерөнхий прокурор хүсэлтийг хангасан бол ялтныг тухайн улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу шилжүүлж авна.

413 дугаар зүйл. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон асуудлыг шүүхээр шийдвэрлэх журам

413.1.Энэ хуулийн 412 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлж авсан этгээд Монгол Улсад ял эдлэх асуудлыг Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс тогтоосон харьяалалын дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

413.2. Шүүгчийн захирамжид дараахь зүйлийг заасан байна:

413.1.1. гадаад улсын шүүхийн нэр, шийдвэр гаргасан газар, он, сар, өдөр;

413.1.2. Монгол Улсад хамгийн сүүлд байнга оршин сууж байсан болон ажиллаж байсан газар;

413.1.3. ялтны үйлдсэн гэмт хэрэг, гадаад улсын шүүхээс түүнд хэрэглэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт;

413.1.4. ялтны үйлдэлд хэрэглэх

Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт;

413.1.5. гадаад улсын шүүхээс ялтанд оногдуулсан ялын хугацаа, хорих ангийн төрөл, Монгол Улсад эдэлвэл зохих ялын хугацаа, хорих ангийн төрөл, хохирол нөхөн төлөх журам.

413.2. Гадаад улсын шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа нь Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох ялын дээд хэмжээнээс их байвал Монгол Улсад ял эдлэх хугацааг Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээгээр тогтооно.

413.3. Гадаад улсын шүүх хорих ял оногдуулсан боловч Монгол Улсын хуулиар уг хэрэгт хорих ял оногдуулж болохооргүй байвал шүүгч уг этгээдэд гадаад улсын шүүхээс оногдуулсан ялтай дүйцэхүйц төрөл, хугацааны өөр төрлийн ял эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

413.4. Гадаад улсын шүүх хэд хэдэн хэрэг үйлдсэн гэж үзэж ялтанд ял оногдуулсан боловч тэдгээр нь Монгол Улсын хуулиар гэмт хэрэгт тооцогддоггүй бол шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгож уг ялтныг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

413.5. Шүүгчийн захирамж нь гарсан үеэс хүчин төгөлдөр болох бөгөөд түүнд прокурор эсэргүүцэл бичиж болно.

413.6. Шүүгчийн захирамжийг прокурорт хүргүүлж гүйцэтгүүлнэ.

413.7. Гадаад улсаас шилжин ирж энэ зүйлд заасны дагуу Монгол Улсад ял эдлэхээр болсон этгээдийн ялыг хугацаанаас өмнө суллах, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, өршөөл, уучлал үзүүлэх зэрэг шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбоотой бүхий л асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

413.8. Гадаад улсад өршөөлийн хууль гарсан бол тэнд шийтгүүлээд шилжиж ирсэн этгээдийг уг өршөөлд хамруулах ба энэ тухай шийдвэрийг ял эдлүүлж байгаа газрыг харьяалах анхан шатны шүүхийн шүүгч гаргана.

ДӨЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

414 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

414.1. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах жүрмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 7 (244)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний хууль*
- *Хууль хүчингүй болсонд тооцох тухай*
- *Монгол Улсын Иргэний хуулийг дагаж мөрдөх журмын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны хоёрдугаар сарын 22 №7 (244)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

80. Иргэний хууль (2002-01-10-ны хууль) 257

81. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-01-10-ны хууль) 384

82. Монгол Улсын Иргэний хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2002-01-10-ны хууль) 384

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬ

I ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

I ДЭД ХЭСЭГ

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА, ХУУЛЬ ТОГТООМЖ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх шүүхээр хамгаалуулах зарчмыг үндэслэнэ.

1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татвар төсөв, санхүү зэрэг захиргааны хууль тогтоомжоор зохицуулах болон захиргааны талаар нэг этгээд

ЗАЛРУУЛГА

«Төрийн мэдээллэл» эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн Эрүүгийн хуулийн «ЦЭРГИЙН ГЭМТ ХЭРЭГ» гэсэн хэсгийн дугаарыг «АРАВДУГААР»; «ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХ ТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ» гэсэн хэсгийн дугаарыг «АРВАН НЭГДҮГЭЭР»; «БУСАД ЗҮЙЛ» гэсэн хэсгийн дугаарыг «АРВАН ХОЁРДУГААР» гэж,

-мөн эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн « ШҮҮХИЙН ӨМНӨХ БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА» гэсэн хэсгийн дугаарыг «ДОЛДУГААР», «Шүүх хуралдааныг эхлэх» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ГУРАВДУГААР»; «Шүүхийн хэлэлцүүлэг» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР»; «Шүүх хуралдааны шүүмжлэл, шүүгдэгчийн эцсийн үг» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ТАВДУГААР»; «Тогтоол гаргах» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ЗУРГАДУГААР»; «Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах,эсэргүүцэл бичих» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ДОЛДУГААР»; «Давж заалдах шатны шүүхийн ажиллагаа» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН НАЙМДУГААР»; «Шүүхийн шийдвэрийг биелүүлэх» гэсэн бүлгийн дугаарыг «ГУЧИН ЕСДУГЭЭР», «Хяналтын шатны шүүхийн ажиллагаа» гэсэн бүлгийн дугаарыг «ДӨЧДУГЭЭР»; «Шинэ нөхцөл байдлын улмаас хэрэгийг сэргээх» гэсэн бүлгийн дугаарыг «ДӨЧИН НЭГДҮГЭЭР» гэж, мөн хуулийн 27.1-ийн 303., 303.2/Хөлсний цэрэг ашиглах/ гэснийг 303.1, 303.2/Хөлсний цэрэг ашиглах/ гэж,

-мөн хуулийн «297.1.4»-ийг «297.1.3» гэж, «297.1.5»-ыг «297.1.4» гэж, «396.9»-ийг «396.8» гэж, «396.10»-ыг «396.9» гэж, «413.1.1, 413.1.2, 413.1.3, 413.1.4, 413.1.5»-ыг «413.2.1, 413.2.2, 413.2.3, 413.2.4, 413.2.5» гэж, «413.2, 413.3, 413.4, 413.5, 413.6, 413.7, 413.8»-ыг «413.3, 413.4, 413.5, 413.6, 413.7, 413.8, 413.9» гэж тус тус залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

нөгөөдөө захирагдах эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

2 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомж

2.1.Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг хэрэглэх

3.1. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн хуулийг шүүх хэрэглэхгүй.

3.2. Тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомж гаргах шаардлагатай гэж олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

3.3.Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.

3.4.Хуулийг хүчингүй болгох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө хүчингүй болгосон хуулийн үйлчлэл сэргэхгүй.

3.5.Хуульд заасан тохиолдолд Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны энэ хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг хэрэглэж болно.

3.6. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ.

3.7.Хуулийг мэдэхгүй буюу буруу ойлгосон нь хуулийг хэрэглэхгүй байх, хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4 дүгээр зүйл. Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх

4.1.Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.

4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна.

4.3.Тусгай харилцаат тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.

5 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх

5.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.

5.2.Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.

5.3.Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.

6 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцааны объект

6.1.Хуульд заасан үндэслэл, журмаар иргэний гүйлгээнээс хасагдаагүй, мөнгөөр үнэлж болох, эдийн болон эдийн бус баялаг иргэний эрх зүйн харилцааны объект байна.

6.2.Эдийн болон эдийн бус эрх, үйлдэл, эс үйлдэхүй, мэдээлэл иргэний эрх зүйн харилцааны объект байж болно.

7 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч

7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхүүл байгууллага байна.

7.2. Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

7.3.Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, хамгаалалт, иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх

8 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл

8.1.Иргэний эрх зүйн харилцаа дараахь үндэслэлээр үүснэ:

8.1.1.хуульд заасан буюу заагаагүй боловч аguулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл;

8.1.2.иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэр;

8.1.3.хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр;

8.1.4.оюуны үнэт зүйл бүтээх;

8.1.5.гэм хор учруулах;

8.1.6.үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших;

8.1.7.иргэний эрх зүйн харилцааг үүсгэсэн хууль зүйн үйл явдал бий болох;

8.1.8.иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд заасан бусад үндэслэл.

9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт

9.1.Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна.

9.2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрхээ хамгаалуулах эттэздийг хуульд заасны дагуу сонгох эрхтэй.

9.3.Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.

9.4.Иргэний эрхийг дараахь аргаар хамгаална:

9.4.1. эрхийг хүлээн зөвшөөрөх;

9.4.2. эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихээс өмнөх байдлыг сэргээх;

9.4.3. хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;

9.4.4. учруулсан хохирлыг арилгуулах;

9.4.5. эдийн бус гэм хорыг арилгуулах;

9.4.6. хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;

9.4.7. бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох;

9.4.8. иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох;

9.4.9. өөртөө туслах;

9.4.10. хуулиар тогтоосон бусад арга.

10 дугаар зүйл. Аргагүй хамгаалалт

10.1.Хууль бус халдлагаас өөрийгөө болон бусад этгээд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор үйлдсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцсэн үйлдлийг аргагүй хамгаалалт гэнэ.

10.2.Аргагүй хамгаалалтаас учруулсан гэм хорыг уг үйлдэл хийсэн иргэн хариуцан арилгах үүрэг хүлээхгүй.

11 дүгээр зүйл. Гарцаагүй байдлын улмаас хийсэн үйлдэл

11.1.Тухайн нөхцөл байдалд аюулыг өө арга замаар зайлуулах боломжгүй бол түүний таслан зогсоох, сэргийлэх зорилгоор хийсэн үйлдэ /эс үйлдэхүй/-ийг гарцаагүй байдлын улмаас хийсэ үйлдэл гэнэ.

11.2.Гарцаагүй байдалд учруулсан гэм хо нь учирч болох байсан гэм хороос бага байвал у үйлдэл хийсэн эттэзд гэм хорыг хариуцан арилга үүрэг хүлээхгүй.

11.3.Учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос илт их байвал үйлдэл хийсэн эттэзд хэтрүүлсэн тэр хэмжээгээр гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ.

11.4.Гэм хор учирсан бодит нөхцөл байдлы харгалзан шүүх эрх, хууль ёсны ашиг сонирхлын нь төөрөг үйлдэл хийгдсэн гуравдагч этгээдэд у гэм хорыг арилгах үүрэг хүлээлгэх, эсхүл гэм хо учруулагч буюу гуравдагч этгээдийг дээрх үүргээс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж болно.

11.5.Гарцаагүй байдлын улмаас үйлдэл хийсэн этгээд тухайн нөхцөл байдлыг өөрөө бий болгосон бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

12 дугаар зүйл. Өөртөө туслах

12.1.Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэж авах, устгах буюу эвдэх, эсхүл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдлийг хууль бус гэж үзэхгүй.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан үйлдлийг хийсэн этгээд эд юмсыг битүүмжлэх буюу үүрэг бүхий этгээдийг албадан саатуулахаар эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

12.3.Өөртөө туслах үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон хэр хэмжээнээс хэтэрч болохгүй.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан үйлдлийг эндүүрч хийсэн буюу хэр хэмжээнээс хэтрүүлсэн этгээд үйлдлийнхээ улмаас бусдад учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

13 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх

13.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч

хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.

13.2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хуулиар хориглоогүй буюу хуульд шууд заагаагүй эрх, үүргийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж болно.

13.3.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулсан, зах зээлийн харилцааны чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарласан, хууль ёсны давуу байдлаа хууль бусаар ашигласан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд хэрэв зөрчвөл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

II ДЭД ХЭСЭГ

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД ГУРАВДУГААР БҮЛЭГ

Иргэн

14 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадвар

14.1.Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно.

14.2. Иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглоно.

15 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн чадамж

15.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно.

15.2.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно.

15.3. Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон шүүхийн шийдвэрийг зохих үндэслэл байвал сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх хүчингүй болгож болно.

16 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж

16.1.Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна.

16.2.Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, харгалзан дэмжигч/-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ.

16.3.Насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр дараахь эрхээ бие даан хэрэгжүүлж болно:

16.3.1. өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах;

16.3.2. өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх;

16.3.3. энэ хуулийн 16.3.1-д заасан орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах.

16.4. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно.

17 дугаар зүйл. Иргэний эрх зүйн зарим чадамж

17.1. 7-гоос 14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай байна.

17.2. 7-гоос 14 хүртэлх насны этгээдийн хийсэн өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хийнэ.

18 дугаар зүйл. Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн

18.1. 7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна.

18.2.Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.

18.3.Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ.

18.4.Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон тохиолдолд шүүх тухайн этгээдийг иргэний эрх зүйн

чадамжгүйд тооцсон шийдвэрийг хүчингүй болгоно.

19 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах

19.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирохогч этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болно.

19.2.Иргэний эрх зүйн чадамжийг хэлцэл хийх замаар хязгаарлахыг хориглоно.

19.3.Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдаагүй чадамжийнхаа хүрээнд, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно.

19.4.Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон бол түхайн этгээдэд тогтоосон хязгаарлалтыг шүүх хүчингүй болгож, харгалзан дэмжигчийг үүргээс нь чөлөөлнө.

20 дугаар зүйл. Иргэний нэр

20.1.Иргэн өөрийн нэртэй байна.

20.2.Иргэний нэрийг бүртгэх, өөрчлөх журмыг хуулиар тогтооно.

20.3. Иргэний нэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ. Иргэний эрх, үүргийг иргэн өөрийн нэрээр олж авч хэрэжүүлнэ. Гагцхүү хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохиомол нэр хэрэглэж болно.

20.4.Иргэн нэрээ өөрчилсөн нь түүний өмнөх нэрээр олж авсан эрх, хүлээсэн үүргийг өөрчлөх буюу дуусгавар болгох үндэслэл болохгүй.

20.5.Нэрээ өөрчилсөн этгээд үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэчид энэ тухай мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс гарсан үр дагаврыг хариуцна.

21 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах

21.1.Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно.

21.2.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ.

21.4.Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл түхайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

21.6.Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагаань явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл түхайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй.

21.7.Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

21.8.Энэ хуулийн 21.7-д заасан тохиолдолд учирсан гэм хорыг эдийн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй.

21.9.Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу онцхрогч этгээдэд энэ хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан журмын дагуу арилгана.

22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар

22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.

22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудагүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл түхайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно.

22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.

23 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга олсонд тооцох

23.1.Оршин суугаа газраасаа алга болсноос ойш хоёр жилийн хугацаанд хаана байгаа нь эдэгдэхгүй, сураг чимээгүй болсон иргэнийг онирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх сураггүй алга олсонд тооцож болно.

23.2.Сураггүй алга болсонд тооцогдсон тгээдийн эд хөрөнгөд шүүхээс эрхлэн хамгаалалт огтоох бөгөөд тухайн этгээдийн асрамжид байсан үмүүсийг тэжээн тэтгэх, хуулиар тогтоосон урмын дагуу татвар, хураамж төлөх, бусдын өмнө үлээсэн үүргийн дагуу өр төлбөрийг төлж арагдуулах зэрэг хууль ёсоор гүйцэтгэвэл зохих үргийг уг эд хөрөнгөөс гүйцэтгэнэ.

23.3.Сураггүй алга болсонд тооцогдсон тгээдийн байгаа газар нь тогтоогдсон, тухайн тгээд эргэж ирсэн тохиолдолд шүүх шийдвэрээ үчингүй болгож, эд хөрөнгөд нь тогтоосон эрхлэн амгаалалтыг зогсооно.

23.4.Эргэж ирсэн этгээд нь сураггүй алга олсонд тооцогдсоноос хойш энэ хуулийн 23.2-т ааснаас өөр үндэслэлээр бусдад үнэ төлбөргүй шилжсэн бөгөөд бэлэн байгаа эд хөрөнгөө буцаан авахаар шаардах эрхтэй. Уг эд хөрөнгийг аж ахуйн ориулалтаар ашигласны үр дүнд олсон ашгийг нөхөн төлүүлэхээр шаардах эрхгүй.

23.5.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч нь бусдад худалдсан бол түүний үнийг, үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээсэн бол шүүх гэм буруугийн шинж байдлыг харгалзан уг эд хөрөнгийн үнийг бүрэн буюу хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.

23.6.Сураггүй алга болсонд тооцогдсон этгээд эргэж ирсэн бол эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч нь уг эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбогдон гарсан зардал, хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

24 дүгээр зүйл. Иргэнийг нас барсан гэж зарлах

24.1.Иргэн оршин суугаа газраасаа алга болсноос хойш таван жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй сураг чимээгүй болсон, эсхүл амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсноос хойш нэг жилийн турш амьд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх түүнийг нас барсан гэж зарлаж болно.

24.2.Байлдааны ажиллагаанд оролцож яваад сураггүй алга болсон этгээдийг уг ажиллагаа дууссан өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа шүүхээс нас барсан гэж зарлаж болно.

24.3.Иргэнийг нас барсанд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрийг уг этгээдийн нас барсан өдөр гэж үзнэ.

24.4.Амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсон иргэнийг нас барсан гэж зарласан бол шүүх түүний нас барсан байж болох өдрийг уг этгээдийн нас барсан өдөр гэж тооцож болно.

24.5.Нас барсан гэж зарлагдсан этгээдийн хөрөнгийг өвийн журмаар бусдад шилжүүлнэ.

24.6.Нас барсан гэж зарлагдсан этгээд эргэж ирэх буюу байгаа газар нь тогтоогдсон бол шүүх урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгоно.

24.7.Нас барсан гэж зарлагдаад эргэж ирсэн этгээд өвлөх болон бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжсэн бэлэн байгаа эд хөрөнгөө буцаан авахаар шаардах эрхтэй. Энэ журмаар төрийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгийг өмчлөгчид буцаан олгох боломжгүй бол үнийг нь нөхөн төлнө.

24.8.Нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчингүй болсон нь тухайн этгээдийн эхнэр, нөхрийн шинээр гэрлэсэн гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хуулийн этгээд

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

25 дугаар зүйл. Хуулийн этгээд

25.1.Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

25.2.Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.

25.3.Хуулийн этгээд нь нийтийн, хувийн,

холимог өмчийн байна.

25.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална.

25.5.Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар

26.1.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

26.2.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах журмыг хуулиар тогтооно.

26.3.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно.

26.4.Хуулийн этгээд удирдах байгууллагараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно.

26.5.Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

26.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулна.

26.7.Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.

26.8.Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ.

26.9.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана.

27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нэр

27.1.Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна.

27.2.Хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна.

27.3.Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдын төөрөгдүүлэхээр ижил, тесеетэй байж болохгүй.

27.4. Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хоригломо. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорын хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана.

27.5.Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

27.6.Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийн заалт нэгэн адил хамаарна.

28 дугаар зүйл. Хуулийн этгээдийн оршин байгаа газар

28.1.Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ.

28.2.Хуулийн этгээд нь оршин байх нэг газраа буюу хууль ёсны хаягтай байна.

29 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар

29.1.Хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан бол хуулийн этгээд өөрийн салбар, төлөөлөгчийн газраа тогтоосон журмын дагуу байгуулж болно.

29.2.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг салбар гэнэ.

29.3.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

29.4.Салбар, төлөөлөгчийн газрын эрх, үүргийг тухайн хуулийн этгээдийн дүрмээр тодорхойлно.

29.5.Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулна.

29.6.Хуулийн этгээдийн салбар,

төлөөлөгчийн газар хуулийн этгээдийн эрхгүй байна.

30 дугаар зүйл. Хуулийн этгээдийг байгуулах

30.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно.

30.2.Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг ханган зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно.

31 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах

31.1.Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

31.2.Хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нийлүүлэх гэнэ.

31.3.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэгтгэх гэнэ.

31.4.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ.

31.5.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ.

31.6.Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно.

32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах

32.1.Хуулийн этгээдийг дараахь үндэслэлээр татан буулгана:

32.1.1.өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан;

32.1.2.дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

32.1.3.үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан;

32.1.4.хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

32.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

32.2.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.

32.3.Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ.

32.4.Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зурган сараас ихгүй байна.

32.5.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар ханган:

32.5.1.бүсдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр ;

32.5.2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;

32.5.3.дампуурлын үед хариуцагчийг дахин өрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага;

32.5.4. хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;

32.5.5.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс;

32.5.6.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

32.6.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дараалалын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний

дараагийн дарааллын төлберийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

32.7.Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлберийг барагдуулж болно.

32.8.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхэд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлберийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дараалын дагуу харилцагчдад хуваарилна.

32.9.Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

32.10.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ.

32.11.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ.

Хоёрдугаар дэд бүлэг

Хуулийн этгээдийн төрөл

33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл

33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.

33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.

34 дүгээр зүйл. Компани

34.1.Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагдсан, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ.

34.2.Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

35 дугаар зүйл. Нөхөрлөл

35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

35.2.Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо

36.1.Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.

36.2.Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.

36.3.Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоно.

36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

36.5.Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.

36.6.Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө.

37 дугаар зүйл. Сангийн тусгай зохицуулалт

37.1.Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

37.2.Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно.

37.3.Сангийн гүйцэтгэх удирдлага сангийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрх барих байгууллагаараа хэлэлцүүлэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.

38 дугаар зүйл. Санг татан буулгах журам

38.1.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилогдсон татан буулгах комисс эрхлэнэ. Онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болох бөгөөд тэрээр татан буулгах комиссийн гишүүдийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.

38.2.Санг татан буулгахдаа өдөр тутмын ажил хэргийг зогсоож, бэлэн байгаа эд хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж, харилцагчидтай тооцоо хийнэ.

38.3.Энэ хуулийн 38.1-д заасны дагуу тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг татан буугдсан сангийн зорилго нэг бүюу ижил тестэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй тохиолдолд төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

III ДЭД ХЭСЭГ

ХЭЛЦЭЛ

ТАВДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

39 дүгээр зүйл. Хэлцэл

39.1.Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлцэл гэнэ.

39.2.Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж болно.

40 дүгээр зүйл. Хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр байх

40.1.Хүсэл зоригийн илэрхийлэл нь нөгөө тал түүнийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болно.

40.2.Нөгөө тал хүсэл зоригийн илэрхийллийг хүлээж авахаас урьдчилан буюу шууд татгалзсан бол хүсэл зоригийн илэрхийллийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

40.3.Хэлцэл хийснээс хойш нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон этгээдийн урьд нь хийсэн хэлцэл, илэрхийлсэн хүсэл зоригийн илэрхийлэл хүчин төгөлдөр хэвээр байна.

41 дүгээр зүйл. Хүсэл зоригийг тайлбарлах

41.1.Хүсэл зоригийн агуулгыг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарна.

41.2.Хүсэл зоригийн илэрхийллийн утга ойлгомжгүй бол хүсэл зоригоо илэрхийлэгчийн хэрэгцээ, шаардлага, үг болон үйлдэл, эс үйлдэхүй, бусад нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх замаар тайлбарлана.

42 дугаар зүйл. Хэлцлийн хэлбэр

42.1.Хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, хуульд заагаагүй бол талууд хэлэлцэн тохиролцож амаар буюу бичгээр хийнэ.

42.2.Энгийн хэлбэртэй бичгийн хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

42.3.Ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу техникийн хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсгийг түүний эхтэй адилтган үзэх болно.

42.4.Нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг хийхэд нотариат буюу хуульд заасан бусад этгээдээр гэрчлүүлнэ.

42.5.Нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг гэрчлэгүй байхад талуудын аль нэг үүргээ бүрэн буюу ихэнхийг нь гүйцэтгэсний дараа нөгөө тал үүнийг хүлээн зөвшөөрсөн боловч хэлцлийг нотариатаар гэрчлүүлэхээс татгалзвал үүргээ гүйцэтгэсэн талын нэхэмжлэлээр шүүх үг хэлцлийг хийсэнд тооцож болно.

42.6.Өвчин болон бичиг үсэг мэдэхгүйн улмаас гарын үсгээ өөрөө зурж чадахгүй этгээдийн итгэмжлэлээр өөр этгээд төлөөлөн хэлцэлд гарын үсэг зурж болно. Энэ тохиолдолд итгэмжлүүлсэн этгээдийн гарын үсгийг баталгаажуулсан байх бөгөөд өөр этгээдээр гарын үсэг зуруулах болсон шалтгааныг бичнэ.

42.7.Бичгээр хийсэн хэлцлийг хэд хэдэн хувь үйлдсэн бол талуудад үлдэх хувь дээр харилцан гарын үсгээ зурсан байвал хэлцэл хийсэн гэж үзнэ.

42.8.Талууд гол нөхцөлийн хувьд өөрийн хүсэл зоригоо бодит үйлдлээр илэрхийлж хэлцэл хийж болно.

42.9.Хууль буюу гэрээнд заасан тохиолдолд хэлцэл хийх тухай саналд хариу өгөхгүй байгаа

хэлцэл хийхээр хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

42.10.Бичгээр хийх хуулийн шаардлагыг биелүүлээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байхаар хуульд заасан бол хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд энэ тохиолдолд талууд хэлцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгнө.

42.11.Бичгээр хийх хуулийн шаардлагыг зөрчсөн хэлцлийн талаар талууд маргасан тохиолдолд энэ хуульд өөрөөр заагаагүй бол тэдгээр нь гэрчээр нотлох эрхээ алдах боловч нотолгооны бусад хэрэгслээр нотлож болно.

43 дугаар зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх

43.1. Амаар хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ:

43.1.1.хэлцлийн гол нөхцөлийн талаар талууд хэлэлцэн тохиролцсон;

43.1.2.хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэрэг хэрэглэж заншсан зүйлийг олгосон;

43.1.3.хууль буюу гэрээнд заасан бол хэлцэл хийх тухай саналд хариу өгөөгүй бөгөөд ийнхүү хариу өгөх тогтоосон хугацаа, эсхүл ердийн боломжит хугацаа өнгөрсөн.

43.2.Бичгээр хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ:

43.2.1.талууд хүсэл зоригоо илэрхийлсэн баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурсан;

43.2.2.хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал хүлээн авсан;

43.2.3.хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлэх зохих хэлцлийг ийнхүү бүртгүүлсэн буюу гэрчлүүлсэн.

43.3.Нэг талын хүсэл зоригийн илэрхийллийг нөгөө тал хүлээн авснаа өөрийн тодорхой үйлдлээр илэрхийлсэн бол уг хэлцлийг бодит үйлдлээр хийгдсэн гэж үзнэ.

43.4.Хэлцлийн агуулгыг тодорхойлох боломжгүй бол уг хэлцлийг хийгдээгүйд тооцно.

44 дүгээр зүйл. Болзол тавьж хийсэн хэлцэл

44.1.Тодорхойгүй байгаа ямар нэгэн үйл явдал бий болсон нөхцөлд хэлцлийг хэрэгжүүлэх эсхүл хэлцлийг дуусгавар болгохоор тохиролцож хийсэн хэлцлийг болзол тавьж хийсэн хэлцэл гэнэ.

44.2.Бий болох эсэх нь мэдэгдэхгүй, эсхүл нэгэнт бий болснаг нь хэлцэл хийгч талууд мэдээгүй байгаа үйл явдлаас шалтгаалан хэлцэлд заасан эрх үүрэг нь үүсэхээр тохиролцсон бол хойшлуулах болзлоор хийсэн хэлцэл гэнэ.

44.3.Бий болох эсэх нь мэдэгдэхгүй байгаа үйл явдал бий болсноор хэлцлийг дуусгавар болгохоор тохиролцсон бол өөрчлөгдөх болзлоор хийсэн хэлцэл гэнэ.

44.4.Үйл явдал ирээдүйд бий болох эсэх нь хэлцэл хийгч этгээдийн хүсэл зоригоос шалтгаалахаар байвал энэ зүйлийн зохицуулалт үйлчлэхгүй.

45 дугаар зүйл. Болзол тавьж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх

45.1.Болзол нь хуулийн шаардлагад нийцээгүй буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш эсхүл илтэд биелэгдэх боломжгүй бол хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

46 дугаар зүйл. Болзол хүчин төгөлдөр бус болох

46.1.Үйл явдал тодорхой хугацаанд бий болох болзол тавьж хэлцэл хийсэн нөхцөлд уг үйл явдал дурдсан хугацаанд болоогүй бол болзол хүчин төгөлдөр бус болно.

46.2.Тодорхой хугацаа заагаагүй болзол хэдийд ч хэрэгжиж болно.

46.3.Болзолд заасан үйл явдал хэзээ ч бий болохгүй нь илт болсон тохиолдолд болзол хүчин төгөлдөр бус болно.

47 дугаар зүйл. Болзол хангагдсан гэж үзэх

47.1.Үйл явдал тодорхой хугацаанд бий болохгүй гэсэн болзлоор хэлцэл хийсэн бөгөөд үйл явдал бий болохгүй нь тогтоосон хугацаа өнгөрхөөс өмнө тодорхой болсон бол болзол хангагдсан гэж үзнэ.

48 дугаар зүйл. Болзол тавьж хэлцэл хийсэн этгээдийн үүрэг

48.1.Болзол тавьж хэлцэл хийсэн этгээд болзолд заасан үйл явдал бий болохоос өмнө эсрэг тал үүргээ гүйцэтгэхэд саад болох үйлдэл хийх эрхгүй.

48.2.Болзол бий болсноор өөрт нь ашиггүй байх тал нь болзол бий болоход шударга бусаар саад болсон бол болзол бий болсонд тооцно.

48.3.Болзол бий болсноор өөрт нь ашиггай байх тал нь болзол бий болоход шударга бусаар нөлөөлсөн бол болзол бий болоогүй гэж үзнэ.

48.4.Болзол нь тодорхой хугацаанд бий болоход уг эртэнд энэ хуулийн 48.1-д заасан үйлдлийг нэгэнт хийчихсэн байсан бол түүнээс болж эсрэг талдаа учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

49 дүгээр зүйл. Биржийн хэлцэл

49.1.Биржийн гүйлгээнд оруулах эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх / эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт/-ээ харилцан шилжүүлэх тухай хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, биржид бүртгүүлнэ.

49.2.Хууль, тухайн төрлийн хэлцлийн шинж байдалд харшлахгүй бол биржийн хэлцэлд түүний агуулгад нийцүүлэн зохих гэрээ /худалдах-худалдан авах, комиссийн зэрэг/-ний журмыг хэрэглэж болно.

49.3.Талуудын худалдааны нууцыг агуулсан, тэдний эвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлно.

49.4.Биржийн хэлцэл байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийн талаар талууд шүүхэд гомдол гаргаж болно.

50 дугаар зүйл. Зөвшөөрөөр хийх хэлцэл

50.1. Хэлцэл хүчин төгөлдөр байх зайлшгүй нөхцөл болсон зөвшөөрөл олгох эрх, үүрэг бүхий гуравдагч этгээд уг зөвшөөрлийг олгосон буюу олгохоос татгалзсан тухайгаа хэлцлийн талуудад нэгэн адил мэдээлнэ.

50.2.Зөвшөөрлийг тухайн хэлцэлд баримтлах хэлбэрээр хийхийг шаардахгүй.

50.3.Хүчин төгөлдөр байх нь гуравдагч этгээдийн зөвшөөрлээс шалтгаалах хэлцлийг гуравдагч этгээдийн зөвшөөрлөөр хийсэн бол энэ хуулийн 54.5-д заасан журам нэгэн адил хамаарна.

51 дүгээр зүйл. Зөвшөөрлөө хүчингүй болгох

51.1.Хэрэв талууд нэгэнт олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хэлцэл хийх зорилгоор ямар нэгэн үр дагавар бий болгоогүй бол зөвшөөрөл олгосон этгээд урьдчилан олгосон зөвшөөрлөө хэлцэл хийхээс өмнө хүчингүй болгож болно. Зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай талуудад мэдэгдэнэ.

52 дугаар зүйл. Зөвшөөрлийг буцааж хэрэглэхгүй байх нөхцөл

52.1.Хэлцлийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн шийдвэрээр хожим дэмжин зөвшөөрөхөөс өмнө буюу албадан биелүүлэх журмаар, эсхүл дампуурлын хэрэг гүйцэтгэгчээс зд хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой хийсэн үйл ажиллагаа нь энэ хуулийн 42.1-42.3-т зааснаас үл хамааран хүчин төгөлдөр байна.

53 дугаар зүйл. Эрх олгогдоогүй этгээдийн үйлдэл хүчин төгөлдөр байх

53.1.Эрх олгогдоогүй этгээдийн хийсэн үйлдлийг бүрэн эрх бүхий этгээд хожим дэмжин зөвшөөрсөн бол уг үйлдлийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

54 дүгээр зүйл. Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл

54.1.Насанд хүрээгүй иргэнтэй хэлцэл хийгч этгээд уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл олгосноо нотлохыг хууль ёсны төлөөлөгчөөс хүсвэл тэрээр зөвшөөрөх эсэхээ 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөс насанд хүрээгүй этгээдэд урьд олгосон зөвшөөрөл буюу татгалзал хүчин төгөлдөр бус болно.

54.2.Энэ хуулийн 54.1-д заасан хугацааны хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.

54.3.Насанд хүрээгүй этгээд хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хэлцэл хийснээс хойш насанд хүрвэл хүсэл зоригийн илэрхийллээ хүчин төгөлдөр байлгах эсэхийг өөрөө шийднэ.

54.4.Насанд хүрээгүй этгээдтэй хэлцэл хийсэн этгээд нь түүний хууль ёсны төлөөлөгчөөс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг авахаас өмнө хэлцлээс татгалзах эрхтэй.

54.5.Хууль ёсны төлөөлөгч нь насанд хүрээгүй этгээдэд хэлцэл хийх зөвшөөрөл өгсөн боловч түүнийгээ нотолсон баримтыг негөө талд өгөөгүй бол хэлцэл хийгч негөө тал хэлцлээс татгалзах эрхтэй.

55 дугаар зүйл. Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны иргэний бие дааж хийх хэлцэл

55.1.Хууль ёсны төлөөлөгч буюу түүний зөвшөөрөлтэйгээр гуравдагч этгээдээс насанд хүрээгүй иргэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрх олгон шилжүүлсэн хөрөнгийн хувьд насанд хүрээгүй этгээд бие даан хэлцэл хийх эрхтэй.

55.2.Насанд хүрээгүй иргэн хийхийг хуулиар зөвшөөрснөөс бусад нэг талын хэлцэлд энэ хуулийн 55.1 хамаарахгүй.

ЗУРГА ДУГААР БҮЛЭГ

Хүчин төгөлдөр бус хэлцэл

56 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус байх хэлцэл

56.1.Дараахь хэлцэл хүчин төгөлдөр бус байна:

56.1.1.хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл;

56.1.2.дүр үзүүлэн хийсэн хэлцэл;

56.1.3.өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл;

56.1.4.үнэн санаанаасаа бус, хөнгөмсгөөр хандаж, түүнийгээ илэрхэ гэж урьдаас тооцож, тодорхой хүсэл зориг илэрхийлэн хийсэн хэлцэл;

56.1.5.эрх зүйн чадамжгүй этгээдийн хийсэн хэлцэл;

56.1.6.сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон иргэн эрх зүйн бүрэн чадамжгүй гэж албан ёсоор тооцогдоогүй байхдаа хийсэн хэлцэл;

56.1.7.эрх зүйн бүрэн чадамжтай этгээд үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгох чадваргүй болсон буюу сэтгэцийн түр зуурын сааталд орсон үедээ илэрхийлсэн хэлцэл;

56.1.8.хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн, хууль да аасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл;

56.1.9. хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг зөрчиж хийсэн хэлцэл;

56.1.10.дээр дурдсан хүчин төгөлдөр бус хэлцлийн үндсэн дээр хийсэн бусад хэлцэл.

56.2.Энэ хуулийн 56.1-д заасан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нөхцөлийг талууд хэлцэл хийснээс хойш мэдсэн бөгөөд уг хэлцэл нь өөр хэлцлийн шаардлагад нийцэж байгаа тохиолдолд талууд хүсвэл шаардлагад нийцэж байгаа хэлцлийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

56.3.Энэ хуулийн 56.1.2-56.1.4, 56.1.8-д заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хууль да заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинэ хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ.

56.4.Сонирхогч этгээд хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгуулахаар шаардаж болно.

56.5.Энэ хуулийн 56.1-д заасан хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

56.6.Хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн буруутай этгээд нь бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө.

57 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл

57.1.Шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

57.2.Шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцсон хэлцэл нь хийсэн үеэсээ хүчин төгөлдөр бус байна.

57.3.Гэрээгээр тохирсон хэлбэрийг зөрчсөн хэлцлийг шүүх сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

57.4.Хэлцэл хийгч этгээд нь хүсэл зоригоо бичгээр илэрхийлэх буюу тооцоо хийхдээ илэрхий алдаа гаргасан нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй бөгөөд ийм алдаа гаргасан этгээд түүнийгээ засах эрхтэй байна.

58 дугаар зүйл. Ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн хэлцэл

58.1.Ноцтой төөрөгдлийн үндсэн дээр хүсэл

зоригоо илэрхийлэн хийсэн хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

58.2.Дараахь тохиолдолд ноцтой төөрөгдөл гэж үзнэ:

58.2.1.хэлцэл хийгч этгээд хэлцэл хийхдээ хүссэн хэлцлээссэ өөр хэлцлийг зөвшөөрөн хийсэн;

58.2.2.хэлцэл хийгч этгээд хүссэн хэлцлийнхээ агуулгыг эндүүрсэн.

58.3.Дараахь тохиолдолд ноцтой төөрөгдөл гэж үзэж болно:

58.3.1.хэлцэл хийгч негөө тал болох этгээд, түүний хувийн шинж байдал нь хэлцэл хийх гол үндэслэл болсон бөгөөд энэ талаар төөрөгдсөн;

58.3.2.хэлцлийн зүйлийн үнийг тодорхойлоход ач холбогдол бүхий эд зүйлийн шинжийн талаар төөрөгдсөн;

58.3.3.хэлцэл хийх гол үндэслэл болсон эрхийн талаар төөрөгдсөн;

58.3.4.тохиролцооны зүйл байсан сэдэлтийн талаар төөрөгдсөн.

58.4.Төлөөлөгч буюу зуучлагч нь төлөөлүүлэгч буюу үйлчлүүлэгчийнхээ хүсэл зоригийн илэрхийллийг бүруу ташаа мэдээлснийүндсэн дээр хийсэн хэлцлийг энэ хуулийн 58.2-т хамаарууллж болно.

58.5.Хэлцэл хийгч негөө тал нь маргаж байгаа талын хүсэлтийн дагуу хэлцлийг биелүүлэхийг зөвшөөрсөн бол төөрөгдлийн улмаас хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

58.6.Төөрөгдлийн улмаас хэлцэл хийсэн этгээд төөрөгдсөн болохоо мэдмэгц негөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

58.7.Хэлцлийн нэг тал хайхрамжгүйгээс төөрөгдсөн, эсхүл энэ хуулийн 58.4-т заасан үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулсан бол гэм буруутай этгээд хэлцлийн негөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй. Иймхүү төөрөгдөж байгаагүй негөө тал нь мэдэж байсан, мэдээгүй боловч мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол түүнд учирсан гэм хорыг арилгах үүрэг үүсэхгүй.

59 дүгээр зүйл. Хууран мэхэлж хийсэн хэлцэл

59.1.Хэлцэл хийх зорилгоор бусдыг хууран мэхэлсэн бол мэхлэгдсэн этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй. Энэ тохиолдолд хууран мэхэлсэн этгээд ашиг хонжоо олох, эсхүл мэхлэгдсэн этгээдэд гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход нөлөөлөхгүй.

59.2.Хэлцэл хийхэд саад болох нөхцөл байдлыг хэлцэл хийгч нэг тал нь нүүн дарагдуулсныг негөө тал хожим мэдсэн бол хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй.

59.3.Гуравдагч этгээд хууран мэхэлсэн тохиолдолд уг хэлцлээс ашиг олж байгаа этгээд иймхүү хууран мэхэлснийг мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан бол мэхлүүлсэн этгээд хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардаж болно.

59.4. Сонирхогч этгээд энэ зүйлд заасан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах үндэслэл байгааг мэдсэнээс хойш нэг жилийн дотор негөө талдаа гомдлын шаардлага гаргах эрхтэй.

60 дугаар зүйл. Хүч хэрэглэж хийсэн хэлцэл

60.1.Негөө тал, эсхүл гуравдагч этгээдийн зүгээс хүч хэрэглэн буюу хүч хэрэглэхээр заналхийлэн хэлцэл хийлгэсэн бол хэлцэл хийгч этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй.

60.2.Хэлцэл хийгч этгээдэд өөрт нь буюу түүний гэр бүлийн гишүүд, садан төрөл, ойр дотны бусад этгээдэд, эсхүл тэдний эд хөрөнгөд нь аюул учирна гэж итгүүлж үнэмшүүлснийг хүч хэрэглэсэн гэж үзнэ.

60.3.Хүч хэрэглэн хэлцэл хийлгэсэн бол хэлцэл хийгч этгээд нь уг хэлцэл хийснээс хойш нэг жилийн дотор негөө талдаа гомдлын шаардлага гаргах эрхтэй.

61 дүгээр зүйл. Хэлцлийн зарим хэсэг хүчин төгөлдөр бус болох

61.1.Хэлцлийн зарим хэсэг хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон боловч үлдсэн хэсэг нь уг хэлцлийн зорилтыг ханган чадахуйц байвал хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

61.2.Энэ зүйлд энэ хуулийн 202.5 нэгэн адил хамаарна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Төлөөлөл

62 дугаар зүйл. Хэлцэлд төлөөлөх

62.1.Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно.

62.2.Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хуулиар хориглосон, эсхүл хэлцлийн шинж чанараас шалтгаалан хэлцэл хийгч заавал биечлэн хийвэл зохих хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болохгүй.

62.3.Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ.

62.4.Төлөөлөгч итгэмжлэлээр эрх олгосон үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

62.5.Итгэмжлэлд уг үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлж болохоор заасан, эсхүл итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал итгэмжлэлийг шилжүүлж болно.

62.6.Шилжүүлсэн итгэмжлэлийн хугацаа үндсэн итгэмжлэлийн хугацааанаас их байж болохгүй. Үндсэн итгэмжлэл дуусгавар болсноор шилжүүлсэн итгэмжлэл нэг адил дуусгавар болно.

62.7.Төлөөлөгч эрхээ бусдад шилжүүлсэн тухай болон итгэмжлэлийг шилжүүлэн авсан этгээдийн талаар төлөөлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол эрх шилжүүлэн авсан этгээдийн үйл ажиллагааанаас бий болох үр дагаврыг төлөөлөгч хариуцна.

63 дугаар зүйл. Төлөөлөгч

63.1.Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно.

63.2.Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд үр хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.

63.3.Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

63.4.Энэ хуулийн 63.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг төлөөлөгч хариуцан арилгах үүрэгтэй.

63.5.Хууль ёсны төлөөлөгчийнх нь зөвшөөрлийг авалгүйгээр иргэний эрх зүйн бүрэн бус буюу хязгаарлагдмал чадамжтай иргэнээр төлөөлүүлсэн этгээд нь ийнхүү төлөөлүүлснээс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцна.

64 дүгээр зүйл. Төлөөлөх бүрэн эрх

64.1.Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар буюу бичгээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.

64.2.Бичгээр олгосон итгэмжлэл нь дараахь шаардлагыг хангасан байвал зохино:

64.2.1.итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;

64.2.2.хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх;

64.2.3. олгосон он, сар, өдрийг заах;

64.2.4.хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;

64.2.5. итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацаа заах.

64.3.Энэ хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.

64.4.Цэргийн албан хаагчийн итгэмжлэлийг түүний алба хаагч байгаа анги, байгууллагын удирдлага, хоригдлын итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчилж болно.

64.5.Тодорхой хугацаагаар олгох итгэмжлэл гурван жилээс илүүгүй хугацаагаар, хугацаа заагаагүй итгэмжлэл олгосон өдрөөс хойш нэг жил хүчин төгөлдөр байна.

64.6.Хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчөөр дамжуулан хийх хэлцлийн хэлбэрт тавигдах шаардлага төлөөлүүлэх хүсэл зоригоо илэрхийлэхэд хамаарахгүй.

65 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх

65.1.Нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн

эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нэхцэл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй.

65.2.Төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн бол түүнтэй хэлцэл хийсэн этгээд бусдыг төлөөлж байгаа этгээдтэй хэлцэл хийж байгаагаа мэдэх ёстой байсан тохиолдолд төлөөлүүлэгчид хэлцлийн үр дагавар үүснэ.

65.3.Хэлцлийн нөгөө талд хэнтэй хэлцэл хийж байгаа нь ач холбогдолгүй байсан бол энэ хуулийн 65.2 нэгэн адил хамаарна.

66 дугаар зүйл. Төлөөлүүлэгчийн хүсэл зоригийн илэрхийллийн давуу байдал

66.1.Төлөөлөгч хүсэл зоригийг хангалттүй илэрхийлж, хүссэн үр дагаврыг бий болгож чадаагүйгээс хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах бол төлөөлүүлэгчийн хүсэл зоригийн илэрхийллийг илүү харгалзан үзнэ.

66.2.Хэрэв төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс итгэмжлэлээр олгосон бүрэн эрх, өгсөн зааврын дагуу хэлцэл хийсэн бол төлөөлүүлэгч өөрөө сайн мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан нөхцөл байдлын талаар төлөөлөгч мэдээгүй гэх үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхгүй.

67 дугаар зүйл. Төлөөлөл өөрчлөгдөх, дуусгавар болох

67.1.Төлөөлөх бүрэн эрх хүчингүй болсон буюу өөрчлөлт орсон бол энэ тухай анх бүрэн эрх олгосон тэр хэлбэрээр гуравдагч этгээдэд мэдэгдэнэ. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд уг өөрчлөлтийг гуравдагч этгээдийн хувьд хэлцэл хийх үед мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байснаас бусад тохиолдолд талууд ашиглахыг хоригдоно.

67.2.Төлөөлөл дараахь үндэслэлээр дуусгавар болно:

67.2.1.төлөөлөгч бүрэн эрхээсээ татгалзсан;

67.2.2.төлөөлүүлэгч нь өөрийн олгосон бүрэн эрхийг хүчингүй болгосон;

67.2.3.хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч буюу төлөөлөгч нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон;

67.2.4.итгэмжлэл олгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон;

67.2.5.бүрэн эрхийг хэрэгжүүлсэн;

67.2.6.бүрэн эрх хэрэгжүүлэх хугацаа дууссан;

67.2.7.хуулиар тогтоосон төлөөлүүлэх үндэслэл дуусгавар болсон бол хуульд заасан журмаар.

67.3.Хэдийд ч төлөөлүүлэгч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй. Энэ эрхийг эдлэхгүй гэж тохирсон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

67.4.Төлөөлөгч нь бүрэн эрх дуусгавар болсныг мэдмэгц итгэмжлэлийг төлөөлүүлэгчид буцааж өгөх үүрэгтэй.

67.5.Төлөөлүүлэгч нь итгэмжлэлийг хүчингүй болгосон тухай төлөөлөгч буюу гуравдагч этгээдэд шуудэ, эсхүл тэдэнд хүргэх боломжтой албан ёсны мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэнэ.

67.6.Итгэмжлэл дуусгавар болсныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байхдаа төлөөлөгчөөс бусад этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

68 дугаар зүйл. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл

68.1.Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална.

68.2.Хэрэв хэлцэл хийгч гуравдагч этгээд нь төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл олгохыг хүсвэл түүнд зөвшөөрөл олгож болно.

68.3.Зөвшөөрлийг 14 хоногийн дотор олгоно. Энэ хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.

68.4.Хэлцэл хийгч гуравдагч этгээд хэлцэл хийх үедээ төлөөлөгчийн бүрэн эрхгүй болохыг мэдэж байснаас бусад тохиолдолд төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг олгохоос өмнө хэлцлээсээ татгалзах эрхтэй.

69 дүгээр зүйл. Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хариуцлага

69.1.Төлөөлөгч бүрэн эрхээ нотолж

чадаагүй, төлөөлүүлсэн этгээд уг хэлцлийг дэмжсэн эвлэрлийг олгохоос татгалзсан бол дур мэдэн хэлцэл хийсэн этгээд хэлцлээр хүлээсэн үүргийг хэлцлийн нөгөө талын шаардлагаар биелүүлэх, эсхүл нөгөө талд учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

69.2.Гуравдагч этгээд нь төлөөлөх бүрэн эрхгүй этгээдтэй хэлцэл хийснээ мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан бол төлөөлөх бүрэн эрхгүй этгээд уг хэлцлээс бий болсон үр дагаврыг хариуцахгүй.

69.3.Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан буюу бүрэн бус чадамжтай төлөөлөгч нь хууль ёсны төлөөлөгчийн эвлэрлээгүй, эсхүл этгээд /төлөөлүүлэгч/-ийг төлөөлснээс бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

70 дугаар зүйл. Төлөөлөгч өөртэйгээ хэлцэл хийхгүй байх

70.1.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс өөртэйгөө, түүнтэй гуравдагч этгээдийн нэрээр өөрөө төлөөлүүлэгчтэй хэлцэл хийхийг хориглоно.

IY ДЭД ХЭСЭГ

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУГАЦАА

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хугацааг тодорхойлох, тоолох

71 дүгээр зүйл. Хугацаа тодорхойлох

71.1.Хууль, хэлцэл буюу шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацааг хуанлийн он, сар, өдөр, гаригаар буюу жил, улирал, сар, долоо хоног, хоног, цагаар тодорхойлно.

71.2.Хугацааг зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлж болно.

72 дугаар зүйл. Хугацаа тоолох журам

72.1.Хугацааг тоолохдоо тогтоосон он, сар, өдрөөс, эсхүл уул хугацаа улиран өнгөрсөн буюу үйл явдал болж өнгөрсний дараахь өдөр, цагаас эхлэн тоолно.

72.2.Тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

72.3.Хугацааг ямар нэгэн үүрэг гүйцэтгэхийн тулд тогтоосон бөгөөд хэлцэлд өөрөөр заагаагүй бол хугацааны эцсийн өдрийн хорин дэрвэн цагийн дотор уг үүргийг гүйцэтгэсэн байна.

72.4.Үүргийг ямар нэгэн байгууллагад гүйцэтгэх ёстой байсан бол зохих журмаар тогтоосон уг байгууллагын ажлын өдөр буюу үйлдвэрлэлийн ажиллагаа дуусах эцсийн цагийн дотор гүйцэтгэнэ.

72.5.Баримт бичгийг тогтоосон хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг хугацаанд нь гүйцэтгэсэн гэж үзнэ.

72.6.Цаг хугацаат тоолохдоо хуанлийн жилийг арван хоёр сараар, хагас жилийг зургаан сараар, улирлыг гурван сараар, хоногийг хорин дөрвөн цагаар тоолно.

72.7.Хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.

73 дугаар зүйл. Хугацаа тоолж дуусах

73.1.Жил, хагас жил, улирал, сараар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах сарын мөн өдөр дуусна. Хугацаа дуусах сарын мөн өдөр байхгүй бол уг хугацаа тухайн сарын эцсийн өдөр дуусна.

73.2.Хуанлийн жил нь нэгдүгээр сарын нэгний өдрөөс эхэлж арван хоёрдугаар дугаар сарын гучин нэгний өдрөөр дуусна.

73.3.Долоо хоног, хоногоор тогтоосон хугацаа уг хугацаа дуусах өдрийн мөн цагт дуусна.

73.4.Гаригаар тогтоосон хугацаа тухайн товлосон гариг дуусах эцсийн цагт дуусна.

73.5.Цагаар тогтоосон хугацаа уг хугацаа дуусах цагийн мөн хоромд дуусна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Хөөн хэлэлцэх хугацаа

74 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа хамаарах шаардах эрх

74.1.Хуульд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр зааснаас бусад тохиолдолд өөр

этгээдээс ямар нэг үйлдэл хийх буюу хийхгүй байхыг шаардах эрх хөөн хэлэлцэх хугацаатай байна.

74.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа эдийн бус хөрөнгөд хамаарахгүй.

74.3.Хуульд тусгайлан заасан бол эд хөрөнгийн зарим эрхэд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

75 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх ерөнхий болон тусгай хугацаа

75.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа арван жил байна.

75.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дараахь тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацаа үйлчилнэ:

75.2.1.гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил;

75.2.2.үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан жил;

75.2.3.тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил;

75.2.4.бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа таван жил.

75.3.Талуудын хүсэлтээр шүүх хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журмыг өөрчилж болно.

76 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг тоолох

76.1.Хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүссэн үеэс эхлэн тоолно.

76.2.Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ.

76.3.Тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүрэгтэй холбогдсон шаардлагад хөөн хэлэлцэх хугацааг уг шаардлага зөрчигдсөн үеэс эхлэн тоолно.

76.4.Шаардах эрх нь нэхэмжлэгчийн үйлдлээс шалтгаалах бол хөөн хэлэлцэх хугацааг нэхэмжлэгч уг үйлдлийг хийх ёстой байсан үеэс эхлэн тоолно.

76.5.Серег үүргийн хөөн хэлэлцэх хугацааг үндсэн үүргийг гүйцэтгэсэн үеэс эхлэн тоолно.

77 дугаар зүйл. Нэмэгдэл үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болох

77.1.Үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусснаар нэмэгдэл үүрэг /анз, барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаа зэрэг/-ийн хөөн хэлэлцэх хугацаа нэгэн зэрэг дуусна.

78 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох

78.1.Дараахь тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоно:

78.1.1.үүргийн гүйцэтгэлийг хойшлуулсан бол ийнхүү хойшлуулсан хугацаанд;

78.1.2.үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэхээс татгалзсаныг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн зөвшөөрсөн хугацаанд;

78.1.3.хөөн хэлэлцэх хугацаа дуусахын өмнөх зургаан сарын дотор гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас эрх бүхий этгээд шүүхэд хандах боломжгүй байсан, эсхүл шүүх үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон бол энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд;

78.1.4.гэрлэгчдийн хоорондын шаардлага нь гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд;

78.1.5.эцэг, эх, хүүхдийн хоорондын шаардлагын тухайд хүүхдийн насанд хүрэх хүртэл;

78.1.6.асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүний асрамжинд байгаа хүмүүсийн хоорондын шаардлага нь асран хамгаалалт, харгалзан дэмжилт хүчин төгөлдөр байгаа хугацаанд;

78.1.7.тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн актын үйлчлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд.

78.2.Энэ хуулийн 209 дүгээр зүйл энэ хуулийн 78.1.2-т хамаарахгүй.

78.3.Хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох нөхцөл байдал арилсан үеэс эхлэн хугацаа үргэлжлүүлэн тоолно. Хэрэв үлдсэн хугацаа гурван сараас бага бол гурван сар хүртэл, хөөн хэлэлцэх

хугацаа нь зургаан сараас бага бол үлдсэн хөөн хэлэлцэх хугацаагаар тус тус сунгана.

78.4.Хэрэв иргэний эрх зүйн чадамжгүй буюу бүрэн бус чадамжтай этгээдэд хууль ёсны төлөөлөгч байхгүй бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа нь тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол тухайн этгээд иргэний эрх зүйн чадамжтай болсон, эсхүл хууль ёсны төлөөлөгч томилогдсоноос хойш зургаан сарын дотор хөөн хэлэлцэх хугацаагаар тоолохгүй.

79 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах

79.1.Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан, эсхүл үүрэг хүлээсэн этгээд эрх бүхий этгээдэд урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

79.2.Шүүхэд нэхэмжлэл гаргасан бол хөөн хэлэлцэх хугацааны тасалдал нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагаа бусад хэлбэрээр дуусгавар болох хүртэл үргэлжилнэ.

79.3.Талууд эвлэрсэн, эсхүл хэрэг шийдвэрлэх ажиллагаог цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон бол талууд болон шүүхээс явуулсан сүүлийн ажиллагаа дуусгавар болсноор хөөн хэлэлцэх хугацааны тасалдал зогсоно.

79.4.Энэ хуулийн 79.3-т заасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг шинээр эхлэн тоолох боловч талуудын аль нэг нь хэрэг шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхээр бол шаардлага гаргасны нэгэн адил үзэх хөөн хэлэлцэх хугацаа дахин тасалдана.

79.5.Эрх бүхий этгээд гаргасан шаардлагаасаа татгалзсан буюу шүүхийн шийдвэрээр шаардлагыг хэрэгсэхгүй болгосон бол хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан гэж үзэхгүй.

79.6.Эрх бүхий этгээд зургаан сарын дотор шинэ нэхэмжлэл гаргавал анхны шаардлага гаргасан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцно. Энэ хугацаанд энэ хуулийн 78.1.3, 78.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

79.7.Хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол өмнө өнгөрсөн хугацааг тооцохгүй, хугацааг дахин шинээр эхлэн тоолно.

80 дугаар зүйл. Хуулийн хүчин төгөлдөр шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа

80.1.Тухайн шаардлагад хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа тогтоосон байсан ч шүүхийн шийдвэрийн үндэсэн дээр уг шаардлага хуулийн хүчин төгөлдөр бол түүний хөөн хэлэлцэх хугацаа арван жил байна.

80.2.Хуулийн хүчин төгөлдөр шаардлага нь дахин давтагдах, ирээдүйд хийгдэх үүрэгт хамааралтай бол тухайн үүрэгт тогтоогдсон хөөн хэлэлцэх богиносгосон хугацаа хуулийн хүчин төгөлдөр байна.

81 дүгээр зүйл. Эрх залгамжлал дахь хөөн хэлэлцэх хугацаа

81.1.Нэхэмжлэгдвэл зохих эд хөрөнгө нь эрх залгамжлалын журмаар гуравдагч этгээдэд шилжсэн бол өмнөх эзэмшигчийн эзэмшилд байх үеэс хөөн хэлэлцэх хугацаанд үргэлжлүүлэн тоолно.

82 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний үр дагавар

82.1.Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

82.2.Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг үүрэг гүйцэтгэгч мэдээгүй байхдаа үүргийн гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд үүргийн гүйцэтгэлээс татгалзах эрхгүй.

82.3.Үүрэг гүйцэтгэгч нь хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн болохыг мэдээгүй байхдаа үүргээ гүйцэтгэсэн бол гүйцэтгэсэн үүргээ буцааж шаардах эрхгүй.

82.4.Шүүх, арбитр хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл уг хугацааг сэргээж, зөрчигдсөн эрхийг хамгаалж болно.

Үдэд хэсэг

ЭДИЙН БОЛОН ЭДИЙН БУС БАЯЛГИЙН ЭРХ

АРАВ ДУГААР БҮЛЭГ

Эдийн болон эдийн бус баялаг

83 дугаар зүйл. Хөрөнгө

83.1.Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт

зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.

84 дүгээр зүйл. Эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө

84.1.Аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө гэнэ.

84.2.Эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна.

84.3.Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна.

84.4.Энэ хуулийн 84.3-т зааснаас бусад эд юмс хөдлөх эд хөрөнгөд хамаарна.

84.5.Эзэмшигч этгээдээс ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна.

85 дугаар зүйл. Эд юмсын бүрдэл хэсэг

85.1.Устгах буюу зориулалтыг нь алдагдуулахгүйгээр салгаж үл болох бүрдэл хэсэг нь хуульд заасан тохиолдолд иргэний эрх зүйн харилцааны бие даасан объект болно.

85.2.Түр зуурын хэрэгцээ хангах зорилгоор бус байгын зориулалттай, газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга, байгууламж болон бусад зүйл нь газрын үндсэн бүрдэл хэсэг байна.

86 дугаар зүйл. Эд юмсын дагалдах зүйл

86.1.Эд юмсын бүрдэл хэсэгт хамаарахгүй боловч, гол эд юмст үйлчлэн аж ахуйн нийтлэг зориулалтыг хангахад чиглэгдсэн, түүнтэй орон зайн хувьд хамаарал бүхий хөдлөх эд хөрөнгө нь дагалдах зүйл байна.

86.2.Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой, түүнд үйлчилдэг, өөрийн өртгийг алдагдуулахгүйгээр буюу ноцтой хохирол учруулахгүйгээр түүнээс салган хэрэглэж болох эд юмс нь мөн дагалдах зүйл байна.

86.3.Эд юмсыг аж ахуйн зориулалтаар хэрэглэхэд өөр эд юмсыг тур ашигласан нь түүнийг тухайн эд юмсын дагалдах зүйл болгохгүй.

86.4.Дагалдах зүйлийг тур хугацаагаар гол эд юмсаас салгасан нь түүний дагалдах зүйл болох шинжийг алдагдуулахгүй.

87 дугаар зүйл. Салгаж үл болох буюу хязгаарлагдмал эрх

87.1.Өөр эрхтэй салшгүй холбоотой, түүнгүйгээр бие даан хэрэгжих үл чадах эрхийг салгаж үл болох эрх гэнэ.

87.2.Илүү өргөн хүрээтэй эрхээс уламжлагдсан, тухайн эрхээр хязгаарлагдсан эрхийг хязгаарлагдмал эрх гэнэ.

88 дугаар зүйл. Эд юмс болон эрхийн үр шим

88.1.Эд юмсын төрөлх шинж чанарын дагуу шинээр бий болсон буюу эд юмсыг зориулалтын дагуу ашигласны үр дүнд гаргаж авсан бүтээгдэхүүн нь эд юмсын үр шим байна.

88.2.Эрхийг зориулалтын дагуу ашигласнаас бий болсон орлогыг тухайн эрхийн үр шим гэнэ.

88.3. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эд юмсын болон эрхийн үр шимийг тухайн эд юмс болон эрхийн хууль ёсны эзэмшигч олж авах эрхтэй.

88.4.Тухайн этгээд үр шимийг бүцааж өгөх үүрэгтэй бол аж ахуйн хэвийн үйл ажиллагааны явцад үр шимийг бий болгоход зарцуулсан зардлыг тухайн үр шимийн өртгөөс хэтрүүлэхгүй хэмжээгээр эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Эзэмшил

89 дүгээр зүйл. Эзэмшил үүсэх

89.1.Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ.

89.2.Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна.

89.3.Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна.

89.4.Нэг эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд хамтран эзэмшиж байвал тэдгээр нь хамтран эзэмшигч байна.

89.5.Нэг эд хөрөнгийн тодорхой хэсгүүдийг хэд хэдэн этгээд эзэмшиж байвал тэдгээр нь тус бүрдээ өөрт оногдох хэсгийн эзэмшигч байна.

90 дүгээр зүйл. Шударга эзэмшигч

90.1.Хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь тодорхой байгаа этгээдийг шударга эзэмшигч гэнэ.

90.2.Шударга эзэмшигч өөрийн эзэмшлээс алдсан эд хөрөнгөө гурван жилийн дотор шинэ эзэмшигчээс буцаан шаардах эрхтэй.

90.3.Хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар эд хөрөнгийг олж авснаас бусад тохиолдолд шинэ эзэмшигч тухайн эд хөрөнгийн хувьд өмнөх эзэмшигчээс илүү эрхтэй бол энэ хуулийн 90.2-т заасан журам үйлчлэхгүй.

91 дүгээр зүйл. Эд хөрөнгө эзэмшигчийг өмчлөгч гэж тооцох

91.1.Гуравдагч этгээдийн хувьд эд хөрөнгө эзэмшигч нь тухайн эд хөрөнгийн өмчлөгч гэж тооцогдоно.

91.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 91.1 дэх хэсэг хамаарахгүй:

91.2.1.эд хөрөнгийг өмчлөх эрх олсныг бүртгэлд үндэслэсэн бол;

91.2.2.мөнгө, мэдүүлгийн үнэт цааснаас бусад эд хөрөнгө нь өмнөх өмчлөгчийн хүсэл зоригоос үл хамаарах /гээгдүүлэх, хулгайд алдах гэх мэт/ үндэслэлээр эзэмшлээс нь гарсан бол өмнөх өмчлөгчийн хувьд.

92 дугаар зүйл. Эзэмших, ашиглах эрх хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг шаардах

92.1.Шударга эзэмшигчийн эд хөрөнгө түүний эзэмшилд нь байгаа болговч эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад болж байвал үүгээр арилгуулахаар өмчлөгчийн нэгэн адил шаардах эрхтэй.

93 дугаар зүйл. Хууль ёсны эзэмшигчийн эрх

93.1. Эд хөрөнгийг хууль ёсны эзэмшигчээс шаардаж болохгүй.

93.2.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хууль ёсны эзэмшигч эд хөрөнгийг эзэмшилдээ байлгах хугацаанд тухайн эд хөрөнгийн үр шимийг эзэмшинэ.

93.3.Шууд буюу шууд бус эзэмшигчдийн хооронд харицаанд энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

94 дүгээр зүйл. Шударга эзэмшигчийн эрх, үүрэг

94.1.Эд хөрөнгийг эзэмших эрхтэй буюу энэ эрхээ алдсан шударга эзэмшигч нь үг эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэгтэй.

94.2.Эрх бүхий этгээд эд хөрөнгийг буцааж авах хүртэл эд хөрөнгө болон эрхийн үр шим нь өмнөх эзэмшигчийнх байна.

94.3.Шударга эзэмшигч нь эд хөрөнгийг шударгаар эзэмшиж байхдаа түүнийг хадгалах, арчлах, засан сайжруулах зэрэгт зарцуулсан зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

94.4.Засан сайжруулалтын улмаас эд хөрөнгийн үнэ нэмэгдсэн бол уг эд хөрөнгийг буцааж өгөх үеийн засан сайжруулалтын үнэлгээгээр шаардлагын хэмжээг тодорхойлно. Энэ тохиолдолд шаардлагын үнийн дүн нь эд хөрөнгийн үнийн болон ашгийн нийлбэрээс хэтрэхгүй.

94.5.Шударга эзэмшигч өөрийн буруугаар эд хөрөнгийн үр шимийг олж авч чадаагүй бол олж авах байсан үр шимийн үнийн дүнгийн хэмжээгээр төлбөл зохих төлбөрийг хасч тооцно.

94.6.Шударга эзэмшигч, өөрийн шаардлага хангагдах хүртэл эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцааж өгсөөс татгалзах эрхтэй.

95 дугаар зүйл. Шударга бус эзэмшигчийн эрх, үүрэг

95.1.Шударга бус эзэмшигч нь эрх бүхий этгээдэд эд хөрөнгө, эсхүл эрхийн үр шимийг буцааж өгөх, хэрэв өөрийн буруугаар үр шимийг олж авч чадаагүй бол олох ёстой байсан үр шимийг нөхөн төлөх үүрэгтэй.

95.2.Шударга бус эзэмшигч эд хөрөнгийг хадгалах, арчлах, засан сайжруулахад зориулж гаргасан зардал нь эрх бүхий этгээдэд орох ашгийг нэмэгдүүлсэн тохиолдолд дээрх зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй. Энэхүү шаардлагын үнийн дүн нь эд хөрөнгийн үнэ болон ашгийн нийлбэрээс хэтрэхгүй байна.

96 дугаар зүйл. Эзэмшил дуусгавар болох

96.1.Эзэмшигч эзэмшлээсээ бүрмөсөн татгалзсан, эсхүл өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч өөр хэлбэрээр эд хөрөнгийг мэдэлдээ байлгах эрхээ бусдад алдсан бол эзэмшил дуусгавар болно.

96.2.Өвийн журмаар шилжих эзэмшил өвлүүлэгчид байсан хэмжээгээр өвлөгчид шилжинэ.

96.3.Өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч нь үндэслэл бүхий шаардлагыг эд хөрөнгө эзэмшигчид гаргаснаар эд хөрөнгө эзэмшигчийн эзэмшил дуусгавар болно.

97 дугаар зүйл. Эзэмшилд байх хугацаа тасалдах

97.1.Эзэмших эрхээ алдсан бол энэ хуулийн 104.1, 104.2-т заасан эзэмшилд байх хугацаа тасалдах бөгөөд ийнхүү тасалдсаны дараа эзэмшилд байх эрхийг сэргээн хэрэгжүүлэхэд өмнө өнгөрсөн хугацааг оруулахгүйгээр эзэмшилд байх хугацааг тасалдсан үеэс шинээр эхлэн тоолно.

97.2.Эзэмшигч өөрийн хүсэл зоригоос гадуур буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэлийн үндэсэн дээр эзэмших эрхээ алдсанаас хойш 1 жилийн дотор уг эрхээ буцааж олж авсан бол эзэмшилд байх хугацааг тасалдсан гэж үзэхгүй.

98 дугаар зүйл. Оюуны үнэт зүйл, эрхийг эзэмшилдээ авах

98.1.Оюуны үнэт зүйл, эрхийг эзэмшилдээ авахад энэ хуулийн 89-94 дүгээр зүйлийн холбогдох хэсэг, заалт нэгэн адил хамаарна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Өмч

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

99 дүгээр зүйл. Өмчийн төрөл, хэлбэр

99.1.Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна.

99.2.Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна.

99.3.Хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна.

99.4.Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно

100 дугаар зүйл. Өмчлөгч

100.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн болон хуулийн этгээд өмчлөгч байна.

101 дүгээр зүйл. Өмчлөх эрх

101.1.Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй.

101.2.Өмчлөгч бусдад гэм хор учруулах замаар өмчлөх эрхээ урвуулан ашиглахыг хоригломо. Харин ашиг сонирхлоо хамгаалахын тулд зайлшгүй шаардлагаар хийсэн түүний үйлдэл хууль ёсны болох нь тогтоогдсон бол эрхээ урвуулан ашигласан гэж үзэхгүй.

101.3.Мал, амьтан өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ мал, амьтан, байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлага, бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэгтэй.

101.4.Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглаж, арчлан хамгаалж, хадгалахгүй байгаа нь нийтийн ашиг сонирхолд харшлахаар бол өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглах, арчлан хамгаалах, хадгалах үүргийг өөрт нь даалгах буюу бусдаар зохих хөлс, шан харамжтайгаар гүйцэтгүүлэх үүргийг шүүх өмчлөгчид хүлээлгэж болно.

101.5.Эд хөрөнгө өмчлөх эрх тухайн эд хөрөнгийн бүрдэл хэсэгт нэгэн адил хамаарна.

101.6.Өмчлөгч энэ зүйлд заасан эрхээ бусдад шилжүүлж болох бөгөөд эрх шилжүүлэн авсан этгээд эд юмсыг өмчлөгчийн зөвшөөрсөн зориулалт, өөрийн үйл ажиллагааны зорилго, дүрмийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

101.7.Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өмчлөлийн зүйл, түүний үр төл, үр шим устсан, гэмтсэний эрсдлийг өмчлөгч хариуцна.

102 дугаар зүйл. Газар өмчлөх

102.1.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмчид байна.

102.2.Газар өмчлөгч эрхээ хэрэгжүүлэхдээ хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж

болохгүй.

102.3.Газар өмчлөгч өмчлөлийн газраа бусдад ашиглуулахдаа түүний зориулалтыг заана. Иймхүү тодорхой зориулалтаар олгосон газрыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

102.4.Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ хуульд заасан "газар өмчлөгч" гэснийг "төр " гэж ойлгоно.

102.5.Төрийн өмчийн газрыг хувьчлах, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

103 дугаар зүйл. Өмчлөгчийн эрхийг хязгаарлах

103.1.Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.

104 дүгээр зүйл. Эзэмшилд байх хугацаанаас шалтгаалж өмчлөх эрх олж авах

104.1.Эзэнгүй эд юмсыг илэрж, шударга аргаар олж авснаас хойш өөрийн өмчлөлийн зүйлийн адил 5 жил тасралтгүй илэрж эзэмшсэн этгээд тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг олж авна.

104.2.Хуульд өөрөөр заагаагүй бол эзэнгүй үл хөдлөх эд хөрөнгийг олж авсан өмчлөгч бус этгээд уг эд хөрөнгийн өмчлөгчөөр улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд уг эд хөрөнгийг өмчлөгчийн адил эзэмшиж байсан бол дээрх хугацаа дуусснаар уг этгээд өмчлөх эрхийг олж авна.

104.3.Эд хөрөнгийг шударга бусаар олж авсан, эсхүл энэ хуулийн 104.1, 104.2-т заасан хугацааны дотор хууль ёсны өмчлөгч нь тодорхой болсон бол эд юмсыг олж авсан этгээдэд өмчлөх эрх үүсэхгүй.

104.4.Энэ хуулийн 104.1, 104.2-т заасны дагуу олж авсан эд хөрөнгө эрх залгамжлалын үндсэн дээр гуравдагч этгээдэд шилжсэн бол өмнөх эзэмшигчийн эзэмшилд байсан хугацаа нь эрх залгамжлагчийн хувьд үргэлжлүүлэн тоологдоно.

104.5.Энэ хуулийн 104.1, 104.2-т заасан хугацаанаас өмнө өмчлөгч нь эд хөрөнгө олж авсан этгээдээс шаардлага гаргасан тохиолдолд уг хугацаа тасалдана.

105 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрхийг олж авах давуу эрх

105.1.Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг арав буюу түүнээс дээш жилийн турш хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байсан эзэмшигч уг эд хөрөнгийг өмчлөх эрхийг тэргүүн ээлжинд олж авах давуу эрхтэй байна.

106 дугаар зүйл. Өмчлөгчийн шаардах эрх

106.1.Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй.

106.2.Өмчлөгч өмчлөлийн зүйлээ эзэмшихтэй холбоогүй боловч өмчлөх эрх нь ямар нэгэн байдлаар зөрчигдсөн гэж үзвэл уг зөрчлийг арилгуулах, эсхүл өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг эрх зөрчигчээс шаардах эрхтэй.

106.3.Энэ хуулийн 106.1, 106.2-т заасан шаардлага гаргаснаас хойш эрх нь зөрчигдсөн хэвээр байвал, өмчлөгч шүүхэд нэхэмжлэл гаргаж зөрчигдсөн эрхээ хамгаалуулна.

106.4.Энэ хуулийн 106.2, 106.3 нь хууль ёсны эзэмшигчид нэгэн адил хамаарна.

107 дугаар зүйл. Үнэт цаасаар гэрчлэгдсэн зөрчигдсөн эрхийг сэргээх

107.1.Мэдүүлгийн болон зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн зөрчигдсөн эрхийг хуульд заасан журмын дагуу шүүх сэргээнэ.

107.2.Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн зөрчигдсөн эрхийг үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага сэргээнэ.

108 дугаар зүйл. Дундын өмч

108.1.Хуульд зааснаар, эсхүл хэлцлийн үндсэн дээр хоёр буюу түүнээс дээш этгээд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болно.

108.2.Дундаа өмчлөгч тус бүр бусад өмчлөгчийн эрх, хууль ёсны аших сонирхолд харшлахгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшлээс өмчлөлийн зүйлээ бүхэлд нь шаардах эрхтэй.

108.3.Дундаа хэсгээр өмчлөгч бүр ногдох хэсгээ бусдын өмчлөлд шилжүүлэх буюу өөр байдлаар захиран зарцуулах эрхтэй бөгөөд иймхүү захиран зарцуулахдаа хэсгээр өмчлөгч бусад өмчлөгчдөд мэдэгдэх үүрэгтэй.

108.4.Дундаа хамтран өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ бусад бүх этгээдийн зөвшөөрөлтэйгээр тэдгээрийн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлын үүднээс бусдад шилжүүлэх буюу өөр хэлбэрээр захиран зарцуулж болно.

108.5.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол дундын өмчлөлийн зүйлийг арчлан хамгаалах, хадгалахтай холбогдсон зардал, татвар, хураамж, бусад үүргийг дундаа хэсгээр өмчлөгчид нь өөрт ногдох хэсгээр хувь тэнцүүлэн, дундаа хамтран өмчлөгчид нь тэнцүү хэмжээгээр хариуцах дундын өмчлөлийн зүйлийг ашигласнаас олсон үр шимийг дээр дурдсан хувь хэмжээгээр хуваана.

108.6.Дундаа хэсгээр өмчлөгч нь дундын өмчлөлийн зүйлийн тодорхой хэсгийг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй байна.

108.7.Дундаа хэсгээр өмчлөгч нь дундын өмчлөлийн зүйлийн өөрт ногдох хэсгээ худалдах болон үнийн тухай бусад өмчлөгчдөд мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор тэдгээр нь хариу өгөөгүй бол өөрт ногдох хэсгээ бусад өмчлөгчдөд санал болгосноос багагүй үнээр гуравдагч этгээдэд худалдах эрхтэй.

108.8.Дундаа хэсгээр өмчлөгч дундын өмчлөлийн зүйлээс өөрт ногдох хэсгээ салгаж авах, ийнхүү салгахад үл өмчлөлийн зүйлийн зориулалт, иж бүрдэл , бусад чанар алдагдахаар бол ногдох хэсгийнхээ үнийг гаргуулахаар шаардах эрхтэй.

Хоёрдугаар дэд бүлэг

Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох

109 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх

109.1.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг эрхээ шилжүүлж байгаа болон үг эрхийг олж авч байгаа этгээдийн хэн нь ч гаргах эрхтэй.

109.2.Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичиг өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой заажнотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлүүлэгчээр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана.

109.3.Эрх шилжүүлэгч нь өмчлөгч бус этгээд байсан ч улсын бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлсэн бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн хувьд уг эрхийг шилжүүлж байгаа этгээд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч байх боловч өмчлөх эрх олж авч байгаа этгээд нь уг эрхийг шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг мэдэж байсан бол энэ заалт хамаарахгүй.

110 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх дуусгавар болох

110.1.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндэсн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно.

111 дүгээр зүйл. Хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх

111.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн зохих журмын дагуу тавьсан шаардлагаар түүний эзэмшилд тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно.

111.2.Дараахь тохиолдолд эд хөрөнгийг шилжүүлсэн гэж үзнэ:

111.2.1.өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн эзэмшилд шилжүүлснээр;

111.2.2.өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн эзэмшилд тухайн эд хөрөнгө байгаа болөмчлөх эрх шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар;

111.2.3.эд хөрөнгө нь гуравдагч этгээдийн эзэмшилд байвал өмчлөгч шаардах эрхээөмчлөх эрхийг олж авч байгаа этгээдэд шилжүүлсэнгэрээ байгуулснаар.

112 дугаар зүйл. Эд хөрөнгийн үнийг төлснөөр өмчлөх эрх шилжих

112.1.Талууд шилжүүлж байгаа эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр тухайн эд хөрөнгийгөмчлөх эрх шилжинэ гэж тохиролцсон бол ийнхүүүнийг бүрэн төлснөөр өмчлөх эрх шинэ өмчлөгчидшилжинэ.

112.2.Өмчлөх эрх олж авч байгаа этгээдэд хөрөнгийн үнийг хугацаанд нь төлөөгүй байхадөмчлөх эрхээ шилжүүлж байгаа этгээд гэрээнээсэзтатгалзвал үүрэг ёсоор талууд өмнө нь шилжүүлсэнбүх зүйлээ харилцан буцааж өгөх үүрэгтэй. Энтохиолдолд тухайн эд хөрөнгийг өмчлөгч нь ердийнэлэгдэл, хорогдлыг эс тооцон өөрт учирсан бодитхохирол, алдагдлаа нөхөн төлүүлэхээр үүргээбиелүүлэгч талаас шаардах эрхтэй.

113 дугаар зүйл. Үнэт цаас буюу дагалдах баримт бичгийг шилжүүлснээр өмчлөх эрх шилжих

113.1.Хууль буюу гэрээнд заасан бол эд хөрөнгийн дагалдах баримт бичиг буюу үнэт цаасыг шилжүүлснээр тухайн эд хөрөнгийг өмчлөх эрх шилжсэнд тооцно.

113.2.Зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдэх эрхийн өмчлөх эрх уг үнэт цаасанд бичилт хийснээр шилжинэ.

113.3.Мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг бусдад гардуулах замаар шилжүүлнэ.

113.4.Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтална.

113.5.Нэрийн үнэт цаасыг шилжүүлэгч нь түүний хүчин төгөлдөр байдлыг хариуцна. Харин эрх шилжүүлэх явдлыг хариуцахгүй.

113.6.Үнэт цаасыг өөр этгээдэд шилжүүлснээр түүгээр гэрчлэгдэж байгаа эрх бүхэлдээ шилжинэ.

113.7.Зөвшөөрлийн үнэт цаасыг шилжүүлж байгаа этгээд түүний хүчин төгөлдөр байдал болон эрх шилжүүлэхийг хариуцна.

114 дүгээр зүйл. Өмчлөх эрхийг шударгаар олж авах

114.1.Эд хөрөнгө шилжүүлж байгаа этгээд нь өмчлөгч биш болохыг өмчлөх эрх олж авч байгаа этгээд мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан бол түүнийг өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж тооцно. Харин эрхээ шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг тухайн үед мэдэж байсан буюу мэдэх ёстой буюу мэдэх боломжтой байсан бол өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж үзэхгүй.

115 дугаар зүйл. Эзэнгүй эд юмсыг олж авах

115.1.Өмчлөгчгүй, эсхүл өмчлөгч нь өмчлөх эрхээ дуусгавар болгох зорилгоор эзэмшлээсээ татгалзсан эд хөрөнгийг эзэнгүй эд юмс гэж үзнэ.

115.2. Эзэнгүй эд юмсыг хуулиар зориглоогүй аргаар олж авсан, эсхүл тухайн эд юмсыг олж авахдаа эрх бүхий этгээдийн эрхийг зөрчөөгүй бол эзэнгүй эд юмсыг олж авсан этгээд энэ хуулийн 104.1, 104.2-т заасны дагуу түүнийг өрийн эзэмшилдээ авч, өмчлөх эрхтэй.

115.3.Хуульд өөрөөр заагаагүй бол алдуул мал, тэжээвэр болон бусад амьтдыг олж авах, эзэмших, өмчлөхөд энэ зүйлд заасан журмыг баримталж болно.

116 дугаар зүйл. Гээгдэл эд хөрөнгө

116.1.Гээгдэл эд хөрөнгө олсон этгээд тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу шаардах эрх бүхий этгээдэд нэн даруй мэдэгдэж, хүлээлгэн өгөх үүрэгтэй. Хэрэв тийм этгээд байхгүй бол орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад мэдэгдэж, тухайн эд хөрөнгийг хадгалж хамгаалах, эсхүл тэдгээр байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

116.2.Энэ хуулийн 116.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагад мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор өмчлөгч буюу эрх бүхий этгээд нь тогтоогдоогүй бол тухайн эд хөрөнгийг олсон этгээд өмчлөх эрхтэй. Эд хөрөнгийг олсон этгээд өмчлөхөөс татгалзвал тухайн эд хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлнэ.

116.3.Гээгдэл эд хөрөнгийг олсон этгээд өмчлөгч буюу эрх бүхий этгээд, эсхүл орон нутгийн захиргааны зохих байгууллагаас шагнал авах, тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, эзнийг нь олохтой холбогдсон зардлаа нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

116.4.Шагналын хэмжээг талууд тохиролцож тогтоох бөгөөд хэрэв тохиролцож чадаагүй бол шагналын хэмжээ нь гээгдэл эд хөрөнгийн үнийн дүнгийн арван хувьтай тэнцүү байна.

116.5.Гээгдэл эд хөрөнгө нь амархан муудаж болох, эсхүл түүнийг хадгалах, хамгаалахтай холбогдон гарах зардал нь тухайн эд хөрөнгийн үнээс үлэмж илүү байвал түүнийг олсон этгээд нь энэ хуулийн 116.1-д заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр нийтийн худалдааны цэгээр дамжуулан худалдах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тухайн эд хөрөнгийг борлуулсны орлогыг гээгдэл эд хөрөнгө гэж тооцно.

116.6.Олон нийтийн газар, албан тасалгаа, нийтийн тээврийн хэрэгслээс гээгдэл эд хөрөнгө олсон этгээд түүнийг тухайн байгууллагын захиргаанд хүлээлгэн өгнө.

116.7.Энэ хуулийн 116.6-д заасан байгууллагын захиргаа нь гээгдэл эд хөрөнгийн тухай нийтэд мэдээлэх, бүрэн бүтэн байдлыг хангах, эсхүл энэ хуулийн 116.1-д заасан эрх бүхий байгууллагад шилжүүлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд энэ хуулийн 116.4-т заасан шагналыг гээгдэл эд хөрөнгө олсон этгээд болон олдсон байгууллага тэнцүү хэмжээгээр, холбогдох зардлыг бодит хэмжээгээр тус тус шаардах эрхтэй.

116.8.Энэ хуулийн 116.5 дахь хэсэг нь 116.6-д заасан эд хөрөнгөд нэгэн адил хамаарах бөгөөд харин өмчлөгч буюу эзэмшигч нь энэ хуулийн 116.2-т заасан хугацаанд тогтоогдоогүй бол гээгдэл эд хөрөнгө олдсон байгууллага нь түхайн эд хөрөнгийн өмчлөгч болно.

117 дугаар зүйл. Алдуул мал

117.1.Алдуул мал олсон этгээд нь энэ тухай орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад мэдэгдэж малын эзнийг тогтоох хүртэл өөрийн эзэмшилд байгаа маллах буюу орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

117.2.Алдуул малын талаар нийтэд мэдээлснээс хойш нэг жилийн дотор эзэн нь тогтоогдвол малыг үр төлийн хамт буцааж өгөх бөгөөд эзэн тогтоогдоогүй бол олсон этгээдийн өмчлөлд, үг этгээд татгалзвал орон нутгийн өмчлөлд шилжүүлнэ.

117.3.Алдуул мал олсон этгээд энэ хуулийн 116.3, 116.4-т заасны дагуу зардал, шагналаа шаардах эрхтэй.

118 дугаар зүйл. Дарагдмал үнэт зүйл

118.1.Хуульд өөрөөр заагаагүй бол өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй болтол удаан хугацаагаар газарт булагдсан, эсхүл дарагдаж орхигдсон үнэт зүйл /дарагдмал үнэт зүйл/ олдсон бол түүнийг олсон болон түхайн зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгч нар хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол тэнцүүү хэмжээгээр хуваажөмчлөх эрхтэй.

118.2.Дарагдмал үнэт зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгчийн эзэмшлээгүйгээр, дарагдмал үнэт зүйлийг олох зорилгоор эрэл хайгуул хийж түүнийг олсон бол түхайн үнэт зүйл нь уг үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгчид бүрэн хэмжээгээр шилжинэ.

118.3.Дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ тохиолдолд дарагдмал үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгоно.

118.4.Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа илрүүлсэн дарагдмал үнэт зүйлс, археологийн болон палентологийн олдворт энэ зүйлд заасан журам хамаарахгүй.

119 дүгээр зүйл. Эд хөрөнгө нийлэх, холилдох

119.1. Энэ хуулийн 85.2-т заасны дагуу эзэмшил газрын гол бүрдэл хэсэг болж түүнтэй холбогдсон хөдлөх эд хөрөнгө нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол түхайн эзэмшил газрын өмчлөгчийн өмч байна.

119.2.Хоёр буюу түүнээс дээш этгээдийн тус тусын өмчлөлийн зүйл болох хөдлөх эд хөрөнгө нийлсэн, холилдсоны үр дүнд салгах боломжгүй эд хөрөнгө шинээр бий болсон бол тэдгээр өмчлөгчид нь шинээр бий болсон эд хөрөнгийн хамтран өмчлөгч байна.

119.3.Энэ хуулийн 119.2-т заасны дагуу бий болсон эд хөрөнгийг өмчлөх эрхийн талаар маргаан гарвал эд хөрөнгө нийлэх, холилдохоос өмнө гол эсхүл ихэнх хэсгийг өмчилж байсан этгээд шинээр бий болсон эд хөрөнгийн өмчлөгч байх бөгөөд нөгөө этгээд өөрт учирсан хохирлыг арилгуулах эрхтэй боловч эд хөрөнгийг анхны байдалд буцаан оруулахыг шаардах эрхгүй.

120 дугаар зүйл. Эд хөрөнгийг дахин боловсруулах

120.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бусдын эд хөрөнгийг засан сайжруулах, дахин боловсруулах замаар шинэ хөдлөх эд хөрөнгө бий болгосон бол уг этгээд болон эд хөрөнгийн өмчлөгч шинээр бий болсон эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх бөгөөд тэдэнд ногдох хэсгийг материалын өртөг, үйлдвэрлэлийн зардалтай хувь тэнцүүлэн тодорхойлно.

120.2.Энэ зүйлд заасан талууд өмчлөх эрхийн талаар маргавал илүү хөрөнгө, эсхүл илүү хөдөлмөр зарцуулсан тал нь шинээр бий болсон эд хөрөнгийн өмчлөгч байх бөгөөд нөгөө тал нь өөрт учирсан хохирлыг арилгуулах эрхтэй боловч эд хөрөнгийг анхны байдалд буцаан оруулахыг шаардах эрхгүй.

121 дүгээр зүйл. Өмчлөх эрх шилжсэнээр бусдын эрх дуусгавар болох

121.1.Энэ хуулийн 119, 120 дугаар зүйлд заасны дагуу өмчлөх эрх шилжсэн бол бусад этгээдийн түхайн эд хөрөнгийн хувьд эдлэх аливаа эрх дуусгавар болно.

122 дугаар зүйл. Эдийн бус хөрөнгө өмчлөх эрх олж авах

122.1.Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны өмчид хамаарах оюуны үнэт зүйлийг бүтээсэн этгээдийн өмчлөх эрх үг зүйлийг бүтээсэн үеэ үүснэ.

122.2.Эрх буюу шаардах эрх ээмшигч нь уул эрхийг ээмшиж байсан хэмжээгээрээ өөр эгтээдийн өмчлөлд шилжүүлж болно.

122.3.Өмнөх ээмшигч нь тухайн эрх, шаардах эрхтэй холбогдсон бүх баримт бичиг, тэдгээр эрхийг ашиглахад шаардагдах аливаа мэдээллийг шинэ ээмшигчид өгөх, шинэ ээмшигч шаардвал дээрх эрхээ шилжүүлсэн тухай нотариатаар гэрчлүүлсэн баримтыг шилжүүлэх бөгөөд холбогдох зардлыг шинэ ээмшигч хариуцна.

123 дугаар зүйл. Шаардах эрхээ шилжүүлэх

123.1.Шаардах эрх шилжих тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх хүртэл үүрэг гүйцэтгэгч анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гэрээгээгээ хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ.

123.2.Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх ээмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн эвшээрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно.

123.3.Үүрэг гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөр бол шаардах эрх шилжүүлэхийг гэрээгээр хязгаарлаж болно.

123.4.Үүрэг гүйцэтгэгч нь шаардах эрх шилжих тухай мэдэгдэл хүлээн авах үеийн бүх гатгалзал, хариу шаардлагыг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах эрхтэй.

123.5.Үүрэг гүйцэтгэгч нь үүргийг гүйцэтгэснээр тооцох тухай шаардлагыг шаардах эрх шилжихээс өмнө анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж байсан бол энэхүү шаардлагаа шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болно.

123.6.Шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ.

123.7. Шаардах эрх бүхий этгээд уг эрхээ шилжүүлэхээр хэд хэдэн этгээдтэй хэлэлцэн тохирсон бол шаардах эрх ээмшигчтэй хамгийн түрүүнд хэлэлцэн тохирсон этгээд үүрэг гүйцэтгэгчийн өмнө шаардах бүрэн эрхтэй байна. Түрүүлж тохирсон этгээдийг тогтоох боломжгүй бол үүрэг гүйцэтгэгчид түрүүлж мэдэгдсэн этгээдэд шаардах эрх шилжсэн гэж үзнэ.

123.8.Хууль буюу гэрээнд заасан хэлбэрээр хийх хэлцлийн хувьд шаардах эрхийг шилжүүлэхдээ уг хэлцлийг хийсэн хэлбэрээр шилжүүлнэ.

123.9.Хуульд зааснаар буюу төрийн эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шаардах эрхээ шилжүүлэхэд энэ зүйлд заасан журам нэгэн адил хамаарна.

124 дүгээр зүйл. Өр шилжих

124.1.Шаардах эрхийг ээмшигчтэй нь тохиролцсоноор үүрэг гүйцэтгэгчийн өрийг гуравдагч этгээд өөртөө шилжүүлэн авч үүрэг гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн 123.8-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

124.2.Шаардах эрх ээмшигч, өмнөх үүрэг гүйцэтгэгчийн хоорондын харилцаанаас бий болох бүхий л хариу шаардлагыг шинэ үүрэг гүйцэтгэгч шаардах эрх ээмшигчид тавих эрхтэй.

124.3.Өрийг шилжүүлснээр батлан даагч болон барьцаалуулагч харилцаагаа үргэлжлүүлэхээс татгалзсан бол шаардлагыг хангахад чиглэгдсэн барьцаа, батлан даалт, баталгаа, банкны баталгаа дуусгавар болно.

Гуравдугаар дэд бүлэг

Гэр бүлийн хөрөнгийн эрх

125 дугаар зүйл. Гэр бүлийн хөрөнгө, түүний зохицуулалт

125.1.Гэр бүлийн хөрөнгө нь гэрлэсгдийн, эр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэнэ.

125.2.Гэрлэсгдийн хөрөнгийн эрхийн зарим арилцаат гэрээгээр зохицуулж болно.

126 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн амтран өмчлөх дундын хөрөнгө

126.1.Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарът хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн.

126.2.Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид дараахь хөрөнгө хамаарна:

126.2.1.гэрлэсгчид, гэр бүлийн бусад гишүүн болон тэдгээрийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон болон бусад орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө;

126.2.2.гэр бүлийн гишүүдийн

хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнге;

126.2.3.ногдол хувь, үнэт цаас;

126.2.4.гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө;

126.2.5.гэр бүлийн гишүүн өөрийн хувааръ хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал.

126.3.Гэр бүлийн гишүүний хувааръ эд хөрөнгийг гэр бүлийн бусад гишүүд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоноглосны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болгон тогтоож болно.

126.4.Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ.

127 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүний хувааръ хөрөнгө

127.1.Гэр бүлийн гишүүний дараахь хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй бол хувааръ хөрөнгөд хамаарна:

127.1.1.гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх;

127.1.2.өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө;

127.1.3.амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө;

127.1.4.оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал;

127.1.5.хувийн авъяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого;

127.1.6.хувааръ эд хөрөнгөөрөө олж авсан, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хөрөнгө, мөнгө.

127.2.Гэр бүлийн гишүүн хувааръ эд хөрөнгөө өөрийн үзэмжээр аэзмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй.

127.3.Гэр бүлийн гишүүд өөрөөр тохиролцоогүй бол тэдгээр нь хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хувааръ эд хөрөнгөөрөө хариуцна.

128 дугаар зүйл. Хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших,ашиглах, захиран зарцуулах

128.1.Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

128.2.Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн эвлүүлэгийг авна.

128.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-т заасны дагуу эвлүүлэгээр авааг үй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

128.4.Гэрлэснээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдаар шилжүүлсэн, олсон ашиг, орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй.

129 дүгээр зүйл. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох

129.1.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг дараахь тохиолдолд тодорхойлно:

129.1.1.гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарахад ногдох хэсгийн талаар маргавал;

129.1.2.гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хувааръ эд хөрөнгө хүрэлцэхгүй бол;

129.1.3.гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулбал;

129.1.4.гэр бүлийн гишүүн нас барснаар өв нээгдсэн бол.

129.2.Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна.

129.3.Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг учингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд ногдох д хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн ɔүүл мэндийн байдал, хүүхдийн ашиг сонирхлыг аргалзан шүүх өөрөөр тогтоож болно.

129.4.Энэ хуулийн 129.3-т зааснаас бусад р бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг дорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын д хөрөнгө бий болгоход оруулсан түүний дөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан агасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж олно.

129.5.Гэр бүлийн гишүүн нь цэргийн жинхэнэ аба хаах, сургуульд суралцах, удаан хугацаагаар члөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хамтран ичлөх дундын эд хөрөнгө бүрэлдэхэд дөлмөрөөр буюу хөрөнгөөрөө оролцож чадаагүй ол энэ хуулийн 129.4 дэх хэсэг хамаарахгүй.

129.6.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох лаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

129.7.Гэр бүлийн гишүүдийн хамтран олсон, хүл гэр бүлийн гишүүний хэн нэгний хүлээх ргийн дагуу олсон ашиг орлогыг гэр бүлийн эгцээнд ашигласан нь нотлогдсон бол гэр бүлийн шүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс лбөр гаргуулж болох бөгөөд уг эд хөрөнгө элцэхгүй бол гэр бүлийн гишүүний хуваарьт эд рөнгөөс гаргуулна.

129.8.Бусдад учруулсан хохирлыг нөхөн лөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус лдлээ халхавчлах үүднээс, олсон ашиг орлогоо бүлийн бусад гишүүдийн хуваарьт эд хөрөнгөд, хүл хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд лжүүлсэн нь нотлогдсон бол тэр хэмжээгээр уг хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

130 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн мтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах

130.1.Гэр бүлийн гишүүдийн хамтран члөх дундын эд хөрөнгийг гэрлэгчдийн хэн нэгний оу гэр бүлийн насанд хүрсэн бусад гишүүний ардлагаар гэрлэлт хүчин төгөлдөр байх ацаанд, гэрлэлт цуцалсны дараа, эсхүл гэр лийн гишүүн хэн нэгний нь хуваарьт эд хөрөнгө бөр гаргуулахад хүрэлцэхгүй бол нэхэмжлэгчийн ардлагаар хувааж болно.

130.2.Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дын эд хөрөнгөө харилцан тохиролцох журмаар ааж болно.

130.3.Маргаан гарсан тохиолдолд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хэсгийг шүүх тогтоох бөгөөд энэ нөхцөлд гэр бүлийн гишүүний хэнд нь ямар хөрөнгө шилжихийг тодорхойлж аль нэг гишүүнд шилжүүлсэн хөрөнгийн үнэ нь түүнд ногдох хэсгээс давсан бол үнийн зөрүүг бусдад нь олгож болно.

131 дүгээр зүйл. Гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах

131.1.Гэр бүлийн нэг буюу хэд хэдэн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарвал хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгээ авах боловч гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хөрөнгийг авах эрхгүй.

131.2.Ногдох хэсгийг эд хөрөнгөөр өгөх боломжгүй бол үнийг нь төлнө.

132 дугаар зүйл. Гэрлэгчид хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулах

132.1.Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно.

132.2.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

132.3.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө болон гэрлэсний дараа хэдийд ч байгуулж болно.

132.4.Гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө байгуулсан гэрээ гэрлэлтийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

132.5.Гэрлэгчид гэрээндээ хөрөнгийн бус харилцааг зохицуулсан, гэрлэгчдийн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эрхийн чадамжийг хязгаарласан нөхцөл тусгахыг хориглоно.

133 дугаар зүйл. Гэрээг өөрчлөх, цуцлах

133.1.Гэрлэгчдийн тохиролцсоноор, эсхүл эхнэр, нөхрийн аль нэгний шаардсаны дагуу шүүхийн шийдвэрээр гэрээг цуцалж болох бөгөөд гэрээг өөрчлөх, цуцлах тухай тохиролцоог анхны гэрээтэй адил хэлбэрээр хийнэ.

Дөрөвдүгээр дэд бүлэг
Хөршийн эрх

134 дүгээр зүйл. Хөрш залгаа эд хөрөнгө

134.1.Хоёр талаасаа харилцан нөлөөлж болох хил залгаа ээлшмэл газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийг хөрш залгаа эд хөрөнгө гэж үзнэ.

134.2.Хөрш залгаа эд хөрөнгө өмчлөгч буюу ээлшмэгч нь хуулиар тогтоосон эрх, үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд негөө талынхаа эрхийг харилцан хүндэтгэх үүрэгтэй.

135 дугаар зүйл. Хөршийн нөлөөллийг хориглон хязгаарлах буюу хориглон хязгаарлаж үл болох

135.1.Хөрш залгаа эд хөрөнгийн нэг талын өмчлөгч буюу ээлшмэгч нь өөрийн эд хөрөнгөө ашиглахад саад болохооргүй негөө талын зайлшгүй шаардлагатай нөлөөллийг хориглон хязгаарлаж болохгүй.

135.2.Нөлөөлөл нь ноцтой боловч негөө тал нь өөрийн эд хөрөнгөө аж ахуйн ердийн зориулалтаар ашиглах зайлшгүй шаардлагаар ийнхүү нөлөөлж байвал энэ хуулийн 135.1-д заасан журам нэгэн адил үйлчлэх бөгөөд хэрэв энэ нөлөөлөл нь ердийн ашиглалтын үед байж болох хэвийн хэмжээнээс хэтэрсэн гэж үзвэл негөө тал нь ийнхүү нөлөөлж байгаа талаас менгөн хэлбэрээр нөхөн төлбөр шаардах эрхтэй.

135.3.Хөрш залгаа газрыг ээлшмэгч нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой хохироож болох барилга байгууламжийг газар дээр буюу доор барих, ашиглахыг хориглон негөө талын өмчлөгч буюу ээлшмэгчээс эрх зөрчсөн үйлдлээ зогсоохыг шаардах эрхтэй.

135.4.Энэ хуулийн 135.3-т заасан барилга, байгууламж нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрш залгаа газрын тогтоосон хил хязгаараас гадагш баригдсан боловч негөө талын өмчлөгч буюу ээлшмэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илтэд харшилж байвал түүнийг буулгах буюу зайлуулахыг шаардах эрхтэй.

135.5.Хөрш залгаа газар дээрх барилга байгууламж нурж негөө талын ээлшмэл газарт унах аюул тулгарвал уг аюулыг зайлуулах бүхий л арга хэмжээ авахыг хөрш нь уг барилга байгууламжийн өмчлөгч буюу ээлшмэгчээс шаардах эрхтэй.

136 дугаар зүйл. Урсгал усыг ашиглах

136.1.Хэд хэдэн ээлшмэл газраар дамжин урсдаг, газрын гүнээс гардаг цэвэр ус болон хаягдал усны чиглэлийг өөрчлөх, бусад ээлшмэл газарт очих усны хэмжээг багасгах, чанарыг нь муутгах, урсгал болон газрын гүний цэвэр усыг бусдын хэрэгцээг хязгаарлах байдлаар ашиглахыг хориглоно.

136.2.Хуульд зааснаас бусад тохиолдолд голын байгалийн урсгалын чиглэлийг өөрчилж болохгүй.

137 дугаар зүйл. Хөршийн хил зөрчсөн үйлдлийг хүлээн зөвшөөрөх

137.1.Газар ээлшмэгч нь хөршийн зөвшөөрөлгүйгээр хил зөрчин барилга байгуулаж барьсан бөгөөд хөрш нь ийнхүү хил зөрчихээс өмнө буюу хил зөрчсөн үйлдэл эхэлсэн даруй түхайн ээлшмэгчид уг үйлдлээ зогсоох шаардлага гаргаагүй бол зөрчлийг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.

137.2.Ийнхүү хөршийн эрх зөрчсөн тал нь хөршид жил бүр менгөн хэлбэрээр нөхөн төлбөр төлөх бөгөөд түхайн жилийн төлбөрийг өмнөх жилд багтаан урьдчилан төлөх үүрэгтэй.

138 дугаар зүйл. Хөршийн газраар дамжин өнгөрөх зам, шугам хоолой барьж байгуулах

138.1.Ээлшмэл газар нь бусдын газраар хүрээлэгдсэн, нийтийн ашиглалтын замд хүрэх гарцгүй буюу цахилгаан, хий, усан хангамжийн нийтийн шугам ашиглах боломжгүй бол газар ээлшмэгч нь хөршийн газраар дамжин өнгөрөх дээрх цэгүүдтэй холбогдох зам, шугам хоолойг тавих, байрлуулах эрхтэй.

138.2.Энэ хуулийн 138.1-д заасан тохиолдолд хөрш нь зохих зөвшөөрөл олгох, зам, шугам, хоолой барьж байгуулж байгаа тал нь хөршийн шаардсанаар түүнтэй хэлэлцэн тохиролцож нэг удаагийн нөхөн төлбөр төлөх бөгөөд түүний хэмжээг талууд тохиролцон тогтоож чадахгүй бол шүүх шийдвэрлэнэ.

138.3.Өмнө нь ашиглагдаж байсан зам, шугам, хоолойг хөршийн зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, эсхүл ашиглалтгүй болгосон газар ээлшмэгч энэ хуулийн 138.1-д заасан эрхээ алдана.

138.4.Ээлшмэгч өөрийн ээлшмэл газрын нийтийн ашиглалтын зам, шугам, хоолойтой холбогдсон хэсгийг өөр эгтээдийн ээлшмэлд шилжүүлсэн бөгөөд ээлшмэл газрын үлдсэн хэсэг нь нийтийн ашиглалтын зам, шугам, хоолойд холбогдох шаардлагатай бол шинэ ээлшмэгч нь өөрийн газар дээгүүр дамжин өнгөрөх зам, шугам хоолой тавих, байрлуулах зөвшөөрөл олгох үүрэгтэй.

139 дүгээр зүйл. Хөршийн хилийн зааг тоох

139.1.Газар эзэмшигч нь хөрш залгаа газрын ıийн зааг тогтоосон байгууламжийг барих, эсхүл нө баригдсан байгууламжийг сэргээх, варлахад оролцохыг хөрш газар эзэмшигчээс ардах эрхтэй бөгөөд талууд өөрөөр иролцоогүй бол холбогдох зардлыг тэнцүү ıжээгээр хариуцна.

139.2.Хилийн заагийг нарийн тогтоох ıомжгүй бол хөршүүдийн эзэмшилд бодитой ıгаа талбайн хэмжээг харгалзан үзэх бөгөөд эв уг хэмжээг тогтоох боломжгүй бол маргаантай ıгаа хэсгийг талууд тэнцүү хувааж эзэмших буюу иролцож чадахгүй бол маргааныг шүүх йдвэрлэнэ.

140 дүгээр зүйл. Хөршийн хилийн заагийн ıгууламжийг дундаа ашиглах

140.1.Хөрш залгаа эзэмшил газрын хилийн г болон хоёр талаасаа нэгэн зэрэг ашиглагдаж гаа хашаа буюу бусад байгууламжийг хөршүүд тэгш эрхтэй ашиглах бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэхдээ нөгөө талынхаа газар ашиглах эрхэд саад болохгүй байх үүрэгтэй.

140.2.Хашаа, бусад байгууламжийг ашиглаж арчлан хамгаалахтай холбогдсон зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хариуцна.

140.3.Хилийн заагийг тодорхойлсон байгууламжийг нэг хөрш нь нөгөө хөршийнхөө зөвшөөрөлгүйгээр буулгах буюу өөрчилж болохгүй.

140.4.Хөрш залгаа эзэмшил газрын аль нэг талын өмчлөл буюу эзэмшилд байгаа барилгын бүрэлдэхүүн хэсэг болох хана нь хилийн заагийг тодорхойлж байвал энэ хуулийн 140.1-140.3-т заасан журам үйлчлэхгүй.

141 дүгээр зүйл. Хөршийн эрхэд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байх

141.1.Энэ хуулийн 135.3-135.5, 138.1, 138.4, 139.1, 139.2-т заасан шаардлагад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

Тавдугаар дэд бүлэг

Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрх

142 дугаар зүйл. Нийтийн зориулалттай ıн сууц өмчлөх

142.1.Нийтийн зориулалттай орон сууцны илгын доторхи сууц /өрөө/ болон дундын ıлөлийн зүйлд хамаарахгүй сууцны бус иулалттай талбайн хэсгийг дангаар өмчилж но.

142.2.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд аарахгүй орон сууцны барилга, байгууламж, эөрөмжийн хэсэг нь орон сууц өмчлөгчдийн дын өмчлөлд байна.

142.3.Дундын өмчлөлийн эд хөрөнгөөс орон ı өмчлөгчид ногдох хэсэг нь тэдгээрийн тус ıн өмчлөлд байгаа орон сууцны талбайн хэмжээ, талбайн харьцаагаар тодорхойлогдоно.

142.4.Дангаар өмчлөх өмчлөлд гагцхүү ıрхой хил хязгаар бүхий тусгаарлагдсан сууцны ı /сууц, өрөө/ болон барилгын тусгаарлагдсан ıд байгууламж хамаарна.

143 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн боо

143.1.Нийтийн зориулалттай орон сууцны нэг шинд хоёр буюу түүнээс дээш өрх сууц өмчлөгч ıон тохиолдолд дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоо /цаашид "холбоо" гэх/-г байгуулна.

143.2.Зэрэгцэн орших хэд хэдэн орон сууцны барилгад сууц өмчлөгчид нэгдэн нэг холбоо байгуулж болно.

143.3.Сууц өмчлөгчдийн холбоо хуулийн этгээдийн эрхгүй байна.

143.4.Орон сууцанд оршин суугаа сууц өмчлөгч бусад этгээд заавал тухайн холбооны гишүүн байна.

143.5.Орон сууцны бүрэлдэхүүнд төрийн болон орон нутгийн өмчийн сууц байгаа бол өмчлөгчийн эрх бүхий байгууллагаас томилсон төлөөлөгч холбооны гишүүн байна.

143.6.Сууц өмчлөгчдийн холбооны асуудлыг хуулиар зохицуулна.

144 дүгээр зүйл. Холбоог татан буулгах

144.1.Орон сууц болон бусад эд хөрөнгийн дийлэнх хэсэг нь устаж, гэмтсэн тохиолдолд эвдрэл хохирлыг даатгалаар буюу бусад аргаар арилгах боломжгүй бол сууц өмчлөгчид холбоог татан

буулгаж болно.

145 дугаар зүйл. Орон сууц дангаар өмчлөх эрх үүсэх, дуусгаваар болох

145.1. Орон сууцыг дангаар өмчлөх эрх хууль буюу хэлцлийн үндэсэн дээр үүснэ.

145.2.Орон сууц дангаар өмчлөх эрх үүсгэх хэлцлийг нотариатаар гэрчлүүлэн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

145.3.Өмчлөгч түс бүр дангаар өмчлөх өмчлөлийн зүйл болох өөрийн сууц /өрөө/ болон бусад талбайг хуульд заасан журмын дагуу үл хөдлөх зүй хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлэх эрхтэй.

146 дугаар зүйл. Орон сууцны дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйл

146.1.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд энэ хуулийн 142 дугаар зүйлд заасан талбай, түүнчлэн дундаа буюу дангаар өмчлөгч өөр этгээдийн эрхийг зөрчихөөргүй, эсхүл барилгын гадаад төрх байдлыг алдуулахгүйгээр өөрчилж, тусгаарлаж, нэмж сайжруулж болох түүний бүрдэл хэсэг хамаарна.

146.2.Дангаар өмчлөх талбайд байрлаж байгаа болоовч барилгын бат бэх чанар, аюулгүй байдлыг хангахад шаардагдах тэр хэсэг, мөн өмчлөгчийн дундын ашиглалтад байгаа байгууламж болон бусад төхөөрөмж дангаар өмчлөх өмчлөлийн зүйл болохгүй.

146.3.Орон сууц өмчлөгчид нь дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарах талбайн зарим хэсгийг дундаа өмчлөх талаар хэлэлцэн тохиролцож болно.

146.4.Дангаар өмчлөх сууцны зориулалттай хэсгийг дундын өмчийн онцгох хэсгийг оролцуулахгүйгээр бусдад худалдах, барьцаалах, өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөлд шилжүүлэхийг хориглоно. Дангаар өмчлөх сууцны бус зориулалттай хэсэг энд хамаарахгүй.

147 дугаар зүйл. Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах

147.1.Сууц өмчлөгч нь өөрийн өмчлөлд байгаа сууц болон сууцны бус зориулалттай хэсгийн халаалт, халуун, цэвэр, бохир ус, ариутгал, хог, цахилгаан, холбоо зэрэг ашиглалтын төлбөрийг эрх бүхий байгууллагад, дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг сууц өмчлөгчдийн холбоонд тус тус төлнө.

147.2.Орон сууцны цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын талбай болон тагт, сууцны доторх дундын ашиглалтын талбай, орцны хаалга, довжоо, цонх, хог зайлуулах хоолойн засвар үйлчилгээтэй холбогдсон, түүнчлэн өөр нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлходоо уг зардлыг тухайн орон сууцны нийт сууцны тоонд хуваана.

147.3.Орон сууцны дээвэр, доод хонгил, халаалт болон халуун, хүйтэн усны удирдах зангилааны анхны хаалт хүртэл, цахилгаан оролтын самбар хүртэл холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэл, шалны +0.00 тэмдэгтээс дээшхи бохир усны шугам сүлжээ, түхайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ, даатгал болон холбогдох бусад зайлшгүй зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчийн оролцох хэмжээг тодорхойлходоо сууц эзэмшигчийн дангаар өмчлөх талбайг, түхайн орон сууцны байшингийн дангаар өмчлөх өмчлөлд байгаа нийт талбайд харьцуулан гаргана.

147.4.Дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлходоо, сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалттай талбайн гуравны нэгийг нэмнэ.

147.5.Орон сууцны ашиглалтын хэвийн аюулгүй байдлыг хангах, урсгал засвар хийлгэхээс бусад асуудлаар санал өгөөгүй өмчлөгч уг асуудлыг хэрэжүүлэхтэй холбогдсон зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй бөгөөд энэ тохиолдолд түхайн этгээд уг арга хэмжээг хэрэжүүлснийг үр дүнд бий болсон зүйлийг ашиглахаар шаардах эрхтэй.

147.6.Орон сууц өмчлөгчидийн холбоо нь дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ, хэрэзний үндэсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гэрээний үүрэгтэй холбоотой бусдад учруулсан гэм хорыг холбооны дүрэм, сууц өмчлөгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 147.2, 147.3-т заасан журмын дагуу арилгана.

148 дугаар зүйл. Орон сууц өмчлөгчийн эрх, үүрэг

148.1.Орон сууц өмчлөгч нь дараахь эрх эдэлнэ:

148.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол дангаар өмчлөх өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах;

148.1.2.дундын өмчлөлийн зүйлсийг зориулалтын дагуу ашиглах;

148.1.3.дундын өмчлөлийн зүйлсийг ашиглах, захиран зарцуулахад өөрт ногдох хэсгээ саналын эрхтэй оролцох;

148.1.4.дундын өмчлөлийн зүйлд учирч болох гэм хорыг арилгах шаардлагатай арга хэмжээг бусад өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр авах, гарсан зайлшгүй зардлаа нөхөн төлүүлэхээр шаардах;

148.1.5.хуульд заасан бусад эрх.

148.2.Орон сууц өмчлөгч нь дараахь үүрэг хүлээнэ:

148.2.1.дангаар өмчлөх өмчлөлийн зүйлээ эзэмшиж, ашиглаж, хадгалж хамгаалахдаа бусад өмчлөгчийн хамтын аж байдлын хэв журмыг зөрчихгүй байх;

148.2.2.сууц, сууцны бус ориулалттай хэсгийг ашиглах, түүнд засвар өрчлөлт, шинэчлэл хийхдээ хууль тогтоомж, норм, стандартад заасан шаардлагыг сахин биелүүлэх, бусад өмчлөгчдийн эд юмсад хохирол учруулахгүй, хууль ёсны бусад эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

148.2.3.дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон болон бусад нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд тогтоосон хэмжээгээр оролцох;

148.2.4.дангаар өмчлөх хэсэгт байгаа дундын өмчлөлийн зүйлийн хэвийн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийх зорилгоор нэвтрэн орохыг зөвшөөрөх;

148.2.5.холбоо, хангамжийн шугам сүлжээг байрлуулахтай холбогдсон зайлшгүй арга хэмжээг хүлээн зөвшөөрөх;

148.2.6.дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйлийг бусад этгээдийн ашиглалтад шилжүүлсэн тохиолдолд тухайн этгээдээс энэ хуулийн 148.2.1-148.2.3-т заасан үүргийг биелүүлээгүйгээс үүсэх үүргийг хамтран хариуцах;

148.2.7.энэ хуулийн 148.2.4, 148.2.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдад учруулсан гэм хорыг арилгах.

148.3.Өмчлөгч дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйлийг ашиглаагүй буюу ашиглахаас татгалзсан нь түүнийг дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх үндэслэл болохгүй.

149 дүгээр зүйл. Орон сууц өмчлөгчдийн шаардах эрх

149.1.Дараахь зөрчил гаргасан сууц өмчлөгчийг бусад өмчлөгчид нь холбооны гишүүнээс гаргах, сууц өмчлөх эрхээ бусдад шилжүүлэхийг шаардах эрхтэй:

149.1.1.энэ хуулийн 148.2.1, 148.2.2, 148.2.6-д заасан үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчиж, түүнд холбооноос бичгээр сануулсаар байхад гурван сарын дотор уг зөрчлийг таслан зогсоож, арилгах арга хэмжээ аваагүй бол;

149.1.2.энэ хуулийн 148.2.3-т заасан үүргээ зургаан сарын турш биелүүлээгүй буюу төлбөл зохих төлбөр нь дангаар өмчлөх сууцны үнийн хорин хувиас хэтэрвэл;

149.1.3.хуульд заасан бусад үндэслэл.

149.2.Энэ хуулийн 149.1-т заасан шаардлагыг сууц өмчлөгч сайн дураар биелүүлэхгүй бол орон сууц өмчлөгчдийн холбоо өөрийн төлөөлөгчөөрөө дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Зургадугаар дэд бүлэг

Эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөх эрхийг хязгаарлах

150 дугаар зүйл. Бусдын газар дээр барилга, байгууламж барих эрх

150.1.Бусдын өмчийн газар дээр барилга, байгууламж барих эрх олж авсан этгээд уг эрхээ гравдагч этгээдэд өвлүүлэх, барьцаалах, худалдах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах эрхтэйгээр тухайн газрыг өөрийн эзэмшилд шилжүүлэн авна.

150.2.Газар өмчлөгч нь барилга, байгууламж барихад зайлшгүй шаардлагатай бус боловч тэдгээрийг илүү зохистой ашиглах боломж олгож байгаа газрыг барилга байгууламж барих эрх олж авч байгаа этгээдийн шаардлагаар түүний эзэмшилд шилжүүлэх үүрэгтэй.

150.3.Барилга, байгууламж барих эрх нь заавал тодорхой хугацаатай байх бөгөөд энэ хугацаа нь 99 жилээс хэтрэхгүй. Уг эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох болзол тавьсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

150.4.Энэ хуулийн 150.7-д зааснаас бусад

тохиолдолд барилга байгууламж барих эрхийг нэг талын санаачилгаар дуусгавар болгохыг хориглоно.

150.5.Барилга, байгууламж барих эрхийн үндсэн дээр баригдсан барилга, байгууламж нь тухайн эрхийн гол бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд барилга байгууламж нурсан, эвдэрсэн явдал нь уг эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

150.6.Барилга байгууламж барих эрхийг бусдад худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр захиран зарцуулахад газар өмчлөгчийн зөвшөөрлийг авах шаардлагатай бол өмчлөгч нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол ноцтойгоор зөрчигдөхөөс бусад тохиолдолд зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхгүй.

150.7.Гэрээнд өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж барих эрх олж авсан этгээд уг эрхийг үзэмшсэний төлбөрийг энэ хуулийн 137.2-т заасан журмын дагуу газар өмчлөгчид төлнө. Уг төлбөрийг хоёр жилийн турш төлөөгүй тохиолдолд газар өмчлөгч нь гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

150.8.Энэ хуулийн 150.7-д заасан төлбөрийн хэмжээг арван жил тутам шинэчлэн тогтоохоор талууд тохиролцож болно.

150.9.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж барих зориулалтаар олгосон газар үзэмших эрх дуусгавар болоход газар өмчлөгч нь тухайн барилга, байгууламжийн үнийг уг эрхийг үзэмшиж байсан этгээдэд нөхөн төлөх үүрэгтэй.

150.10.Газар өмчлөгч нь энэ хуулийн 150.9-т заасан нөхөн төлбөрийн оронд тухайн барилга, байгууламж оршин байх ердийн боломжит хугацаагаар барилга, байгууламж барих зориулалтаар олгосон газар үзэмшүүлэх эрхийн хугацааг сунгаж болно.

150.11.Барилга, байгууламж барих зориулалтаар газар үзэмшиж байсан этгээд энэ хуулийн 150.10-т зааснаар хугацааг сунгахаас татгалзвал нөхөн төлбөр шаардах эрхээ алдана.

150.12.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж барих зориулалтаар газар үзэмшиж байсан этгээд уг эрхийн хугацаа дуусгавар болоход тухайн газар дээр барьсан барилга, байгууламж болон түүний бүрэлдэхүүн хэсгийг салгаж авч явах эрхгүй.

150.13.Барилга, байгууламж барих эрхийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

150.14.Энэ хуулийн 150.9-т заасны дагуу нөхөн төлбөр шаардах эрх нь барилга, байгууламж барих эрхтэй ижил дараалаллаар хангагдах бөгөөд энэ дарааллыг талууд хэлэлцэн тохиролцож өөрчлөх эрхтэй.

150.15.Барилга, байгууламж барих эрхийн хугацаа дуусах үед уг эрх нь барьцаанд байгаа бол барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүрэгийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.

150.16.Барилга, байгууламж барих зориулалтаар газар үзэмших эрх дуусгавар болоход газар өмчлөгч нь барилга байгууламж барих эрхтэй байсан этгээдийн гуравдагч этгээдтэй байгуулсан хөлслөх, түрээслэх гэрээний оролцогч болно.

150.17.Барилга, байгууламж барих эрх үүсэх, уг эрхийг олж авахтай холбогдсон харилцаанд энэ хуульд заасан үл хөдлөх эд хөрөнгө олж авах журмын холбогдох хэсэг нөгөн адил хамаарна.

151 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх /сервитут/

151.1.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор өөр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг дараахь замаар хязгаарлах эрхтэй /цаашид "сервитут" гэх/:

151.1.1.хууль буюу гэрээнд заасан тохиолдолд бусдын үл хөдлөх эд хөрөнгийг тэрүүн ээлжинд хязгаартай ашиглах;

151.1.2.өмчлөх эрхэ хэрэгжүүлэхдээ өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусад өмчлөгчдөд даалгах;

151.1.3.сервитутаар эрх н хязгаарлагдсан өмчлөгчөөс сервитут бүхий талын үл хөдлөх эд хөрөнгийн хувьд зарим эр хэрэгжүүлэхийг хязгаарлах.

151.2.Эрх бүхий этгээд нь сервитутий хэрэгжүүлэхдээ тухайн үл хөдлөх эд хөрөнгий өмчлөгчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгү байх үүрэгтэй.

151.3.Талууд хэлэлцэн тохиролцсон бо сервитут бүхий тал нь зохих төлбөр, шагналыг эр нь хязгаарлагдсан талд тогтоосон хугацаан тогтмол төлнө.

151.4.Барилга, байгууламжийн хувь сервитут бүхий этгээд нь түүнийг бүрэн бүтэ байлгах, зохих ёсоор ашиглах үүрэгтэй бөгөө үүнтэй холбогдсон зардлыг эрх нь хязгаарлагдса тал дангаар буюу хэсэгчлэн хариуцахаар талуу тохиролцож болно.

151.5.Сервитут бүхий этгээдийн үзэмши

газар буюу бусад үл хөдлөх эд хөрөнгө нь хуваагдан хэд хэдэн этгээдийн өмчлөлд шилжсэн тохиолдолд сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчийн эрх дордохооргүй байвал тэдгээр өмчлөгч тус бүрд сервитут хэвээр хадгалагдана. Сервитут нь хуваагдсан газар буюу бусад үл хөдлөх эд хөрөнгийн аль нэг хэсэгт нь хамаарах байсан бол бусад хэсгийн сервитут дуусгавар болно.

151.6.Сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчийн эзэмшил газар нь хуваагдан хэд хэдэн этгээдэд шилжсэн тохиолдолд өмнө нь сервитутаар хязгаарлагдаж байснаас бусад газар эрхийн хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

151.7.Сервитут бүхий этгээд эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад учруулж байвал уг саадыг арилгахыг шаардах эрхтэй.

151.8.Өмчлөгч бус этгээд хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр ахуйн хэрэгцээгээ хангах зорилгоор сервитут бүхий этгээдийн адил сервитутийн эрхийг эдэлж болох бөгөөд энэ тохиолдолд уг этгээд нь сервитутийг бусдад шилжүүлэх эрхгүй.

151.9.Эрх бүхий этгээдээс сервитутаа хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учруулахааргүй байвал эрх нь хязгаарлагдсан өмчлөгч сервитутийг өөрийн эзэмшил газрын өөр хэсэгт шилжүүлэх эрхтэй . Энэ эрхийг хязгаарласан аливаа хэлцэл үүнийг тогтолдер бус байна.

151.10.Энэ хуулийн 151.9-т заасанаар сервитутийг шилжүүлэхтэй холбогдсон зардлыг эрх нь хязгаарлагдсан өмчлөгч хариуцна.

152 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх /узуфрукт/

152.1.Ур шимийг хүртэх, ашиг олох зорилгоор бусдын эд хөрөнгийг хязгаартай эзэмшиж, ашиглах эрхийг узуфрукт гэнэ.

152.2.Узуфрукт эзэмшигч нь гагцхүү уравдагч этгээдийн өмчлөлд бүрмөсөн шилжүүлэх замаар захиран зарцуулахаас бусдаар уг эд хөрөнгийг өмчлөгчийн нэгэн адил эзэмшиж, ашиглах эрхтэй бөгөөд харин гуравдагч этгээдэд уг эд хөрөнгийг барьцаалах, түрээслэх тохиолдолд өмчлөгчийн зөвшөөрлийг заавал авна.

152.3.Узуфрукт дуусгавар болоход тухайн эд хөрөнгийн өмчлөгч нь узуфрукт эзэмшигчийн урвадагч этгээдтэй байгуулсан гэрээний оролцогч болно.

152.4.Узуфруктийг олж авахад тухайн эрлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг олж авах алдар энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

152.5.Узуфруктийг хариу төлбөртэй буюу төлбөргүй, тодорхой буюу тодорхой бус хугацаагаар, эсхүл узуфрукт эзэмшигчийн бүх насаар тогтоож болно.

152.6.Узуфрукт нь дараахь үндэслэлээр дуусгавар болно:

152.6.1.узуфрукт эзэмшигч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан;

152.6.2.узуфрукт эзэмшигч болон өмчлөгч нь нэг этгээд болсон;

152.6.3.узуфруктийн хугацаа дууссан.

152.7.Энэ хуулийн 236-240 дүгээр зүйлд заасан үндэслэлээр узуфрукт дуусгавар болоход узуфрукт эзэмшигч тухайн эд хөрөнгийг өмчлөгчид нь шилжүүлэх үүрэгтэй.

152.8.Узуфрукт эзэмшигч нь өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр узуфруктийн зүйлийг болон түүний ашиглалтын зориулалтыг өөрчлөх болохгүй.

152.9.Эзэмшил газрын хувьд узуфрукт эзэмшигч нь тухайн газрын аж ахуйн зориулалтыг ноцтой өөрчлөхгүйгээр олборлох болон бусад зайлшгүй шаардлагатай байгууламжийг барих, тоног төхөөрөмжийг суурилуулах эрхтэй.

152.10.Талууд нь узуфруктийн зүйлийн тухайн байдлыг тодорхойлуулахаар өөрийн зардлаар шинжээч томилж болно.

152.11.Узуфруктийн зүйл нь эд юмсын цогцолбор байвал түүний жагсаалтыг гаргаж талууд уг жагсаалтад гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд аль нэг талын шаардлага, зардлаар эрх бүхий этгээдээр гэрчлүүлэх буюу уг асуудлыг эрхэлсэн зохих байгууллага, мэргэжилтнээр дээрх жагсаалтыг гаргуулж болно.

152.12.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол узуфрукт эзэмшигч нь бүрэн эрхийнхээ хугацаанд узуфруктийн зүйлийн урсгал засвар, аж ахуйн хэвийн байдлыг хангах болон түүний арчилгаатай холбогдсон зардал, холбогдох татвар, төлбөрийг хариуцан, узуфруктийн зүйлийг өөрийн эд хөрөнгөөр даатгуулах үүрэг хүлээх боловч узуфруктийн зүйлийн ашиглалтын ердийн элэгдэл хорогдлыг хариуцахгүй.

152.13.Даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд тухайн эд хөрөнгийн өмчлөгч нь узуфрукт эзэмшигчийн нэгэн адил даатгалын нөхөн төлбөрийг даатгагчаас шаардах эрхтэй.

152.14.Узуфруктийн зүйл устсан, гэмтсэн, эсхүл түүний бүрэн бүтэн байдлыг хангахад урьдчилан төлөвлөөгүй их хэмжээний зардал шаардагдсан, түүнчлэн тухайн зүйлийн хувьд гуравдагч этгээд мэдэж явсан нөхцөл байдлыг арилгахтай холбогдсон зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авахад узуфруктийн эзэмшигч татгалзах эрхтэй.

152.15.Узуфруктийн эзэмшигч нь өмчлөгчид урьдчилан мэдэгдэж энэ хуулийн 152.14-т заасан зайлшгүй арга хэмжээг өөрийн зардлаар авсан бол узуфруктийн дуусгавар болоход салгаж болох засвар, засан сайжруулалтыг салгаж авах бүрэн түүний үнийг төлүүлэхээр өмчлөгчөөс шаардах эрхтэй.

152.16.Узуфруктийн эзэмшигч тухайн эд хөрөнгийн зарим эд анги, хэсгийг засан сайжруулах зорилгоор шинэ эд анги, зүйлээр сольсон бол узуфрукт дуусгавар болоход хуучин эд анги, зүйлийн оронд орлуулсан зүйлийг өмчлөгчид шилжүүлнэ.

152.17.Узуфруктийн эзэмшигч нь аж ахуйн хэвийн ашиглалтаас гадуур буюу ердийнхөөс хэтэрсэн хэмжээгээр олж авсан үр шим, ашгийнхаа өмчлөгч болох боловч үүнтэй холбоотойгоор узуфруктийн зүйлд учирсан гэмтлийг өмчлөгчид нөхөн төлөх үүрэгтэй.

152.18.Узуфруктийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлж, түүнд давхар узуфрукт тогтоохыг хориглоно.

152.19.Узуфруктийн зүйл нь эрх байвал гагцхүү узуфрукт эзэмшигчийн зөвшөөрлөөр хэлцлийн үндсэн дээр үүрэх эрхийг өөрчилж, хүчингүй болгож болно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Барьцааны эрх

Нэгдүгээр дэд бүлэг

Барьцааны нийтлэг зохицуулалт

153 дугаар зүйл. Барьцаа

153.1. Үүрэг гүйцэтгэгч барьцаагаар хангагдсан үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд барьцааны зүйлийн үнээс шаардлагаа хангуулах эрхтэй.

153.2.Барьцааны эрх үүссэнээр тухайн этгээд үүргийн гүйцэтгэлийг шаардах давуу эрх эдэлнэ.

153.3.Барьцаа үүсэх үед тодорхойлж болох ирээдүйд бий болох, болзол тавьсан шаардлагыг хангахад барьцааг хэрэглэж болно.

153.4.Барьцааны эрх нь үндсэн шаардлага, түүнтэй холбоотой бусад дагалдах эрх болон энэ хуулийн 88 дугаар зүйлд заасан үр шимд нэгэн адил хамаарна.

154 дүгээр зүйл. Барьцааны зүйл

154.1.Хэдлэх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх барьцааны зүйл байна.

154.2.Барьцааны зүйл нь шаардах эрх байсан бөгөөд үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанаас өмнө гүйцэтгэсэн бол энэхүү гүйцэтгэл нь барьцааны зүйл болно.

154.3.Энэ хуульд заасан тохиолдолд барьцааны нэг зүйлийг хэд хэдэн этгээдэд барьцаалж болох бөгөөд энэ тохиолдолд шаардлагыг барьцааны гэрээг байгуулсан дараалаар хангана.

154.4.Тухайн хөрөнгийг эзэмшиж байсан боловч барьцаалах эрхгүй этгээд нь эзэмшил эрхийг гэрчилсэн баримт бичгийг шилжүүлэх замаар тухайн хөрөнгийг барьцаалуулсан тохиолдолд барьцаалагч нь барьцаалуулагчийн барьцаалах эрхгүй болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол барьцаалагчийг шударга эзэмшигч гэж үзнэ.

154.5.Энэ хуулийн 154.4-т заасан барьцаалагч нь шударга эзэмшигчийн хувьд бусад гуравдагч этгээдээс давуу эрхтэй байна.

154.6.Барьцааны зүйлийг солих зорилгоор барьцааны гэрээг талууд тохиролцон өөрчилж болно.

155 дугаар зүйл. Барьцааны эрхийг шилжүүлэх

155.1.Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд барьцааны эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ.

155.2.Хөрөнгө, бусдад шилжүүлж болох үнэт цаас, түүнчлэн эд хөрөнгийн эрхийг

шилжүүлэхэд тэдгээрийг олж авах журам нэгэн адил хэрэглэгдэнэ.

155.3.Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэх нь гуравдагч этгээдийн эрхийг өөрчөхөөр байвал тухайн гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах замаар барьцааны эрхийг өөртөө шилжүүлэн авч болно.

156 дугаар зүйл. Барьцааны гэрээ

156.1.Барьцааны гэрээг бичгээр байгуулна.

156.2.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрээг нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлд үртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин уугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана.

156.3.Энэ хуулийн 156.1, 156.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

156.4.Талуудын аль нэг нь хүсвэл хөдлөх д хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар эрчлүүлэх буюу бүртгэх байгуулагад бүртгүүлж олно.

157 дугаар зүйл. Барьцааны зүйлийн алаар талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

157.1.Барьцаалагч дараахь эрх эдэлнэ:

157.1.1.барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээнд барьцааны зүйлийн үр имийг олж авах;

157.1.2.барьцааны зүйлийг удалдсан үнийн дүнгээс өөрийн шаардлагыг бусад үрээ гүйцэтгүүлэгчээс тэргүүн ээлжинд хангуулах;

157.1.3.энэ хуулийн 157.2.2-т заасан угацаанд барьцаалуулагч шаардлагыг хангах өөр ога сонгох буюу өөр зүйл барьцаанд бариулаагүй ол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын агуу худалдах;

157.1.4.барьцаалуулагч энэ уулийн 157.6.1-д заасан үүрэгээ зохих ёсоор мелүүлэхгүй байна гэж үзвэл барьцааны зүйлийг өрийн эзэмшилд шилжүүлэхийг шаардах;

157.1.5.барьцааны зүйлийг эмшилдээ шилжүүлэн авсан бол түүний бүрэн үтэн байдлыг хангаж үүнтэй холбогдон гарсан йлшгүй зардлаа барьцаалуулагчаас шаардах.

157.2. Барьцаалагч дараахь үүрэг хүлээнэ:

157.2.1.өөрийн эзэмшилд авсан барьцааны зүйл устах, үнэ нь ихээхэн буурах бодит нөхцөл бий болсон бол барьцаалуулагчид нэн даруй мэдэгдэх;

157.2.2.энэ хуулийн 157.2.1-т заасан тохиолдолд, барьцаалуулагчид шаардлага хангах өөр арга сонгох буюу барьцаанд өөр зүйлийг бариулах боломжит хугацаа зааж өгөх;

157.2.3.энэ хуулийн 157.1.3-т заасны дагуу барьцааны зүйлийг худалдсанаас олсон мөнгийг барьцааны хугацаа дуустал хадгалах.

157.3.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах зорилгоор хэд хэдэн зүйлийг барьцаалсан тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагч нь шаардлагаа хангах барьцааны зүйлийг сонгох эрхтэй боловч энэ нь тухайн шаардлагыг хангахад шаардагдах тоо, хэмжээнээс хэтэрч болохгүй.

157.4.Барьцааны эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан нөхцөл байдал бий болсон тохиолдолд барьцаалагч нь энэ хуулийн 92 дугаар зүйлд заасан эрхийг эдэлнэ.

157.5.Барьцаалуулагч дараахь эрх эдэлнэ:

157.5.1.барьцааны зүйлийг ээмшилдээ байлгах хугацаанд түүний үр шимийг олж авах;

157.5.2.энэ хуулийн 157.2.1-д заасан нөхцөл байдал бий болсон бол барьцааны зүйлийг буцаан авахаар шаардаж барьцаалагчийн шаардлагыг хангах өөр арга санал болгох;

157.5.3.барьцаалагч энэ хуулийн 157.1.5-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байна гэж үзвэл барьцааны зүйлийг бүрэн бүтэн байлгаж чадах гуравдагч этгээдэд шилжүүлэхийг шаардах;

157.5.4.барьцааны зүйлийг дуудлага худалдаагаар худалдсанаас олсон орлогоос үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага, дуудлага худалдаа явуулахтай холбогдсон болон бусад зайлшгүй зардлыг хасаад үлдсэн хэсгийг өөртөө шилжүүлэхийг шаардах.

157.6.Барьцаалуулагч дараахь үүрэг хүлээнэ:

157.6.1.өөрийнхөө ээмшилд байгаа барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах;

157.6.2.барьцааны гэрээ байгуулах үед барьцаалах хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн шаардлага байгаа бол түүнд барьцааны эрх үүссэн тухай мэдэгдэх.

157.7.Барьцаагаар хангагдах шаардлагад барьцаалуулагч нь үүрэг гүйцэтгэгч биш бол үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж болох хариу шаардлагыг барьцаалуулагч гаргах эрхтэй.

157.8.Барьцаагаар хангагдах шаардлагыг үүрэг гүйцэтгэгч болон гуравдагч этгээд /барьцаалуулагч/-ийн хөрөнгөөр нэгэн зэрэг хангахаар бол уул шаардлагыг үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгөөр эхэлж хангуулах шаардлагыг барьцаалуулагч үүрэг гүйцэтгүүлэгчид тавих эрхтэй.

158 дугаар зүйл. Барьцаалагчийн шаардлагыг хангах

158.1.Шаардах эрх үүссэн буюу үүргийн гүйцэтгэлийг хангах хугацаа өнгөрсөн тохиолдолд барьцааны зүйлийг худалдах, бусад хэлбэрээр борлуулах замаар барьцаалагчийн шаардлагыг хангана.

158.2.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид зохих төлбөр хийснээр барьцаалагчийн шаардлагыг хангасан гэж үзнэ.

158.3.Мөнгөн төлбөрийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангах хугацаа болсон бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдан борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн шаардлагыг хангах тохиолдолд энэ эрхийг эдэлнэ.

158.4.Барьцаагаар хангагдах шаардлагыг хангахын тулд хууль зүйн ач холбогдолтой ямар нэгэн үйлдэл хийх зайлшгүй шаардлагатай бол барьцаалагч уг үйлдлийг хийхийг барьцаалуулагчаас шаардах эрхтэй бөгөөд барьцаалуулагч арван дөрөв хоногийн дотор энэ үйлдлийг хийгээгүй бол барьцаалагч барьцаалуулагчийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй энэ үйлдлийг хийж болно.

158.5.Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд үг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд үг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ.

159 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг худалдах

159.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.

159.2.Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.

159.3.Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд барьцааны зүйлийн өмчлөгч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.

159.4.Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдахыг дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино.

159.5.Барьцааны зүйлийг хууль ёсоор, шударгаар олж авсан этгээдэд барьцааны зүйл эрхийн хязгаарлалтгүйгээр шилжинэ.

160 дугаар зүйл. Барьцааны эрх дуусгавар болох

160.1.Дараахь тохиолдолд барьцааны эрх дуусгавар болно:

160.1.1.барьцаагаар хангагдах шаардлага дуусгавар болсон;

160.1.2.барьцаалагч барьцааны зүйлээс татгалзсан тухай барьцаалуулагч буюу өмчлөгчид мэдэгдсэн;

160.1.3.барьцаалагч эзэмшилдээ байсан барьцааны зүйлийг барьцаалуулагчид буцаасан;

160.1.4.барьцааны зүйлийг өмчлөх эрх барьцаалагчид шилжсэн;

160.1.5.барьцааны зүйл устаж үгүй болсон;

160.1.6.хуульд заасан бусад үндэслэл.

160.2.Энэ хуулийн 160.1.3-т заасан тохиолдолд гуравдагч этгээдийн хувьд барьцаагаар хангагдах шаардлага хэвээр байгаа бол барьцааны эрх дуусгавар болохгүй.

160.3.Энэ хуулийн 160.1.4, 160.1.5-д зааснаас бусад үндэслэлээр барьцааны эрх дуусгавар болсон бол барьцаалагч барьцааны зүйлийг барьцаалуулагч буюу өмчлөгчид буцаах өгөх үүрэгтэй.

Хоёрдугаар дэд бүлэг

Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тусгай зохицуулалт

161 дүгээр зүйл. Барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх

161.1.Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаа

барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно.

161.2.Хэрэв шаардлагыг шилжүүлэхэд барьцааны зүйлийг шилжүүлэх боломжгүй бол барьцааны эрх үүсэхгүй.

162 дугаар зүйл. Зөвшөөрөл авах

162.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол дараахь тохиолдолд барьцаалагч, барьцаалуулагч нь харилцан зөвшөөрөл авах үүрэгтэй:

162.1.1.барьцаалагч нь барьцааны зүйлийг барьцаалах бол барьцаалуулагчаас;

162.1.2.барьцаалуулагч нь барьцааны зүйлийн хувьд гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бол барьцаалагчаас.

163 дугаар зүйл. Хөдлөх эд хөрөнгө болон эрхийг худалдах

163.1.Хэрэв барьцааны зүйлийн биржийн буюу зах зээлийн үнэ тодорхой байвал барьцаалагч нь уг зүйлийг худалдааны тусгай байгууллагаар дамжуулан худалдахаар итгэмжилж болно.

163.2.Барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах болсон тухай болон худалдах үнийн тухай өмчлөгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Иймхүү мэдэгдсэнээс хойш арван дөрөв хоногийн дотор барьцааны зүйлийг худалдаж болохгүй.

164 дүгээр зүйл. Эрх барьцаалах

164.1.Эрх барьцаалахад энэ хуулийн 153-160 дугаар зүйлийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

Гуравдугаар дэд бүлэг

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/

165 дугаар зүйл. Ипотек

165.1.Бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс эргүүнээлжинд өөрийн шаардлагаа хангуулахаар үүрэг гүйцэтгүүлэгч тодорхой үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахыг ипотек гэнэ.

165.2.Үл хөдлөх эд хөрөнгөөс үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангаж болох үнийн үнэгийн дээд хэзээарыг тодорхойлж улсын бүртгэлд эмдэглүүлсэн байвал зохино.

165.3.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгүүлэгч нар харилцан тохиролцож ипотекоор хангагдах шаардлагыг өөр шаардлагаар солиж болох бөгөөд өөрчлөлтийг улсын бүртгэлд үртүүлнэ.

165.4.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага нь эд хэдэн үл хөдлөх эд хөрөнгийн ипотекоор хангагдахаар байвал үл хөдлөх эд хөрөнгө тус үрийг тухайн шаардлагыг бүхэлд нь хангахад шаглах бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч шаардлагаа энгуулахдаа аль нэгэн үл хөдлөх эд хөрөнгийг онгож болно.

165.5.Хэвийн бус аж ахуйн үйл ажиллагаагаар олж авсан, эсхүл аж ахуйн хэвийн үйл ажиллагаагаар олж авсан боловч бусдын өмчлөлд шилжээгүй байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үрдэл хэсэг, үр шимд ипотек нэгэн адил хамаарна.

165.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнээс ндсэн үүргээс гадна хүү, анз, хохирол болон үүхийн зардлыг гаргуулна.

166 дугаар зүйл. Ипотекийн бүртгэл

166.1.Ипотек нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

166.2.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нь ипотекоор хангагдах шаардлагын хэмжээ, түүний хүү, шаардлагыг биелүүлэх хугацаа зэргийг хамтран тодорхойлсон бичиг гаргаж үйлдэж үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болон үүрэг гүйцэтгүүлэгч хуульд заасан журмын дагуу ипотекийг бүртгүүлнэ.

167 дугаар зүйл. Баталгаат ипотек

167.1.Үүрэг гүйцэтгүүлэгч ипотекийн эрхийн бүртгэлийг нотолгоо болгохгүйгээр эвэхэн өөрийн шаардлагыг нотлох замаар ипотекийн эрхээ хангуулахаар хэлэлцэн тохиролцож болох бөгөөд уг ипотекийг улсын бүртгэлд баталгаат ипотек гэж бүртэнэ.

167.2.Мэдүүлгийн болон зөвшөөрлийн үнэт цаасны төлбөрийн үүрэгтэй холбоотой шаардлагын хувьд баталгаат ипотек тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд баталгаат ипотекийг бүртгүүлэх шаардлагагүй.

168 дугаар зүйл. Ипотек өмчлөгчид шилжих

168.1.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага дуусгавар болсон, эсхүл тэрээр шаардлагаасаа татгалзсан бол ипотек үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчид шилжинэ.

168.2.Энэ хуулийн 168.1-д заасан

тохиолдолд өмчлөгч ипотекийг дуусгавар болгож улсын бүртгэлээс хасуулах буюу бүртгүүлсэн дараалаллыг хэвээр хадгалж өөр этгээдэд шилжүүлж болно.

168.3.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч ипотекийг дуусгавар болгохоор гуравдагч этгээдийн өмнө үүрэг хүлээсэн, эсхүл үл хөдлөх эд хөрөнгө болон ипотек нэг этгээдэд шилжихээр бол энэ тухай улсын бүртгэлд урьдчилан тэмдэглүүлж болно.

168.4.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь барьцаалагчийн өмнө өөрийн биеэр үүрэг хүлээгээгүй бол өөрийн биеэр үүрэг хүлээсэн этгээдтэй нэгэн адил эрх эдлэх бөгөөд шаардлагыг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах буюу түүний хэмжээг бууруулах талаар хүсэлт гаргах эрхтэй.

169 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах

169.1.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах хугацаа болсон, эсхүл үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэх эрхтэй болсон үеэс үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах үүрэгтэй.

169.2.Өмчлөгч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангасан бол улсын бүртгэлд өөрчлөлт оруулах буюу ипотекийг дуусгавар болгоод шаардагдах баримт бичгийг үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардан авах эрхтэй.

169.3.Өмчлөгч нь өөрийн биеэр үүрэг хүлээгээгүй бол барьцаалагчийн зөвшөөрснөөр тухайн үүргийг гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн этгээдээс үүргийг өөртөө шилжүүлэн авч болно.

170 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчийн эрхийг хамгаалах

170.1.Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодитой тогтоолгох үүрэгтэй.

170.2. Үл хөдлөх эд хөрөнгөд аюул учрах бодит нөхцөл бий болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч нь өмчлөгчид уг аюулыг зайлуулах боломжийн хугацаа тогтоон өгч болно. Уг хугацаа дуусахад өмчлөгч аюулыг зайлуулах арга хэмжээ авааруй бол үүрэг гүйцэтгүүлэгч тухайн эд хөрөнгөөс өөрийн шаардлагыг нэн даруй хангуулах эрхтэй.

170.3. Үл хөдлөх эд хөрөнгийг даатгуулсан бол даатгалын тохиолдол бий болоход даатгагч энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдсэний дараа даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид олгох үүрэгтэй.

170.4. Тухайн эд хөрөнгийг сэргээн засварлахад даатгалын нөхөн төлбөрийг ашиглахгүй гэж үзэх үндэслэл байвал үүрэг гүйцэтгүүлэгч даатгалын төлбөрийг даатгуулагчид олгуулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авах эрхтэй.

170.5.Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа нь тогтоогдвол үүрэг гүйцэтгүүлэгч үл хөдлөх эд хөрөнгийг өөрийн өзэмшилд шилжүүлэхийг шаардах эрхтэй.

171 дүгээр зүйл. Өмчлөгчийн хэлцэл хийх эрхийг үл хязгаарлах

171.1.Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

171.2.Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.

171.3.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангагчий бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх түүнд шилжинэ гэж тохирсон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

172 дугаар зүйл. Ипотек болон шаардлага шилжих

172.1.Ипотек болон түүний үндэслэл болж байгаа шаардлага нь гагцхүү энэ хуулийн 87.1-д заасны дагуу өөр этгээдэд нэгэн зэрэг хамтдаа шилжиж болно.

172.2.Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид нотариатаар гэрчлүүлсэн ипотекийн баримт бичгийг шилжүүлж, түүнийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч гэж улсын бүртгэлд бүртгэсэн нөхцөлд шаардлага шилжсэн гэж үзнэ.

172.3.Шаардлага шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжсэний дараа үүрэг гүйцэтгэгч нь хуучин үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн бөгөөд иймхүү шаардлага шилжсэн тухай мэдээгүй байсан бол хуучин үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн үүргийн хэмжээгээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг гүйцэтгэнэ.

172.4.Ипотек болон шаардлага нь өмнө үүрэг гүйцэтгүүлэгчид байсан хэмжээгээр шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ.

172.5.Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид ипотекий

шилжүүлсэн тухай улсын бүртгэлд бүртгүүлсэн баримт үнэн зөв гэж тооцогдох бөгөөд түүний талаар үүрэг гүйцэтгэгч шаардлага гаргах эрхгүй, харин бүртгэлийг буруу хийснийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгч мэдэж байсан бол энэ журам хамаарахгүй.

172.6.Ипотекийн үр дүнд гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хохирсон бол тухайн этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангаж, ипотекийг өөртөө шилжүүлэн авах эрхтэй.

172.7.Гуравдагч этгээд энэ хуулийн 172.6-д заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангасан бол холбогдох баримт болон бүртгэлийг өөрийн нэр дээр шилжүүлэхийг шаардах эрхтэй.

172.8.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг энэ хуулийн 172.6-д заасны дагуу хангасан этгээдэд ипотек шилжсэн бол тэрээр өмчлөгчөөс учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

172.9.Шаардах эрх эдэлж байгаа үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнө адил хэмжээний үүрэг хүлээсэн бол тэдгээрийн шаардлага харилцан хангагдсанд тооцож болно.

173 дугаар зүйл. Ипотек болон шаардах эрхээс татгалзах

173.1.Үүрэг гүйцэтгүүлэгч шаардлага буюу ипотекоос татгалзаж, энэ тухай зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн бол ипотек тухайн эд хөрөнгийн өмчлөгчид шилжинэ.

173.2.Үүрэг гүйцэтгүүлэгч ипотекоос татгалзаж, шаардлагаа хэвээр үлдээсэн бол үүрэг гүйцэтгэгч нь ипотекоос учирсан хохирлыг нөхөн төлсөн хэмжээгээр үүргээс чөлөөлөгдөнө.

173.3.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч шаргах эрхтэй болсноор ипотекийг удаан хугацаагаар ашиглах боломжгүй болсон тохиолдолд өмчлөгч үүрэг гүйцэтгүүлэгчээс ипотекоос татгалзахыг шаардах эрхтэй .

174 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах

174.1.Ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй.

174.2.Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ.

175 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр барьцааны зүйлийг албадан худалдах

175.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 174 дүгээр зүйлд заасны дагуу шаардлага гаргасан боловч үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдана.

175.2. Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгүүлэгчийн хамтран гаргасан өргөдөл, тухайн зүйлийн талаар эд хөрөнгийн эрх бүхий талуудын саналыг харгалзан үл хөдлөх эд хөрөнгийг худалдах өөр хэлбэрийг шүүх тогтоож болно.

175.3.Үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, өмчлөгч дуудлага худалдаанд оролцох эрхтэй.

175.4.Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэгч уг эд хөрөнгийн үр шимийг өөртөө үлдээх эрхээ алдана.

175.5.Үүрэг гүйцэтгэгч ипотекийн зүйл болох байшин, эсхүл түүний тодорхой хэсэгт өөрөө буюу гэр бүлийн гишүүдийн хамт оршин сууж байгаа бол ипотекийн зүйлийг албадан худалдах тухай шүүхийн шийдвэр гарсан үеэс хөлслөгч болж, үүрэг гүйцэтгүүлэгчид орон сууц хөлсөлсний хөлсийг, тухайн үеийн ханшаар төлөх үүрэгтэй.

175.6.Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд, дуудлага худалдааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор явуулна.

175.7.Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд дуудлага худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

176 дугаар зүйл. Дуудлага худалдааг зогсоох, түр хойшлуулах

176.1.Дуудлага худалдаа явуулснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болох өмчлөгч буюу гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг урьдчилан хангасан тохиолдолд дуудлага худалдаа явуулахыг зогсоож болно.

176.2.Шүүх өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн, эд хөрөнгийн эрх бүхий талуудын саналыг харгалзан дараахь тохиолдолд дуудлага худалдаа явуулах ажиллагааг 6 сар хүртэл хугацаагаар түр хойшлуулж болно:

176.2.1.үүрэг гүйцэтгэгчийн төлбөл

зохих өрийн шинж чанараас шалтгаалан дуудлага худалдаагүй гэж хойшлуулах боломжтой бол;

176.2.2.өмчлөгчийн хувийн болон эдийн засгийн харилцаа холбоог харгалзан үзэх шаардлагатай бол.

176.3.Энэ хуулийн 176.2-т зааснаар дуудлага худалдаа явуулахыг түр хойшлуулах нь үүрэг гүйцэтгүүлэгчид илтэд сөрөг үр дагавар бий болгоно гэж шүүх үзвэл өмчлөгчийн гаргасан хүсэлтийг ханган хүлээн авах ба болно.

177 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах үеийн үнэ

177.1.Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоох бөгөөд хэрэв тохиролцохгүй бол дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд шинжээчийн саналыг үндэслэн тогтооно. Шинжээчийг дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд томилно.

177.2.Анхны дуудлага худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй буюу дуудлага худалдаанд хэн ч оролцоогүй бол хоёр дахь дуудлага худалдааг явуулна.

177.3.Хоёр дахь дуудлага худалдааг эхний дуудлага худалдаа явуулснаас хойш 30 хоногийн дотор явуулна. Дуудлага худалдааг хоёр дахь удаа явуулж байгаа тухай хуульд заасан журмаар нийтэд мэдээлнэ.

177.4.Хоёр дахь дуудлага худалдаанд оролцогчоос санал болгосон үнэ нь дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардал болон үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг ханган хүрэлцэхүйц байна. Энэ хэмжээнд хүрэхгүй бол дуудлага худалдаа явуулаагүй гэж үзнэ. Дуудлага худалдаатай холбогдсон зардлыг өмчлөгч хариуцна.

178 дугаар зүйл. Дуудлага худалдааны зүйлийг өмчлөх эрх үүсэх

178.1.Хамгийн өндөр үнэ амласан худалдан авагч албадан дуудлага худалдаа явуулж байгаа бүрэн эрх бүхий этгээдэд үнийг шилжүүлэх үүрэгтэй бөгөөд уг үнээс дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардлыг гаргуулна.

178.2.Дуудлага худалдаагаар худалдсан зүйлийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагч тухайн зүйлийн өмчлөгч болно.

178.3.Өмчлөх эрх шилжсэнээр үүрэг гүйцэтгүүлэгчийн албадан гүйцэтгүүлж байгаа ипотекоос хойш бүртгүүлсэн бусад ипотек болон тухайн хөрөнгийн хувьд хязгаарласан эд хөрөнгийн бүх эрх дуусгавар болно.

178.4.Харин тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд эдлэх бусад хязгаарлагдмал эрх хэвээр хадгалагдана.

178.5.Дуудлага худалдаагаар үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авсан шинэ өмчлөгч нь өмчлөх эрх шилжих үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хөлслөх, түрээслэх гэрээний тал болно.

179 дүгээр зүйл. Дуудлага худалдаанаас орсон орлогыг хуваарилах

179.1.Үүрэг гүйцэтгүүлэгч нь улсын бүртгэлд ипотекийн эрх бүхий цорын ганц этгээдээр бүртгэгдсэн, эсхүл дуудлага худалдаанаас орсон орлогоос түүнийг зохион байгуулсантай холбогдсон зардлыг төлөөд үлдсэн хэсэг нь бүх үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байвал уг худалдааг зохион байгуулсан эрх бүхий этгээд зардлыг тооцсоны дараа үлдсэн орлогыг үүрэг гүйцэтгүүлэгч нарт зохих дараалал, журмын дагуу хуваарилж, үлдэгдлийг эд хөрөнгө нь дуудлага худалдаанд орсон өмчлөгчид шилжүүлнэ.

179.2.Хэрэв үл хөдлөх эд хөрөнгийг худалдсан үнэ нь ипотекийн эрх бүхий бүх үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхүй байвал дуудлагын худалдаанд зохион байгуулсан эрх бүхий этгээд дуудлага худалдаа зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг хасаж, үлдсэн мөнгийг тусгай дансанд хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн дараалын дагуу үүрэг гүйцэтгүүлэгчдэд хуваарилна.

180 дугаар зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх хариуцлага

180.1.Дуудлага худалдаа зохион байгуулахаар томилогдсон бүрэн эрх бүхий этгээд нь үүргээ зохих ёсоор биелүүлж чадаагүйгээс бусдад гэм хор учруулсан бол хохирлыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу хариуцна.

181 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын удирдлагад шилжүүлэх

181.1.Ипотекийн шаардах эрх бүхий үүрэг гүйцэтгүүлэгчийн өргөдлийг үндэслэн шүүх үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар албадан худалдахын оронд бусдын удирдлагад албадан шилжүүлэхээр шийдвэрлэж болох бөгөөд энэ тохиолдолд шүүх үл хөдлөх эд хөрөнгийг удирдлагын хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилох буюу энэ үүргийг өмчлөгчид шилжүүлэ

юлно.

181.2.Шүүх энэ хуулийн 181.1-д заасан шийдвэрийг гаргахын өмнө ийнхүү үл хөдлөх эд өөрөнгийг бусдын удирдлагад албадан шилжүүлснээр эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зохирч болох, улсын бүртгэлд бүртгүүлсэн бүх тгээдийн саналыг сонсох үүрэгтэй.

181.3.Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын дирдлагад албадан шилжүүлснээр тухайн эд өөрөнгөөс олох орлого нь түүнийг удирдсантай олбогдсон зардлаас гагцхүү их байх нөхцөлд шүүх нэ хуулийн 181.1-д заасан шийдвэрийг гаргана.

181.4.Үүрэг гүйцэтгэгч нь өөрөө буюу гэр үлийн гишүүдийн хамт бусдын удирдлагад албадан шилжүүлсэн барилга буюу түүний хэсэгт оршин үүдаг бол орон сууц ашигласны хөлсийг тухайн эийн ханшаар төлөх үүрэгтэй.

181.5.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь тухайн эд хөрөнгийн үр шимийг авч, өөрийн болоовсруулж шүүхээр батлуулсан саналын дагуу тухайн эд хөрөнгийг эрхлэн хөтөлсний болон холбогдох бусад бүх зардлыг суутган, үлдэгдлийг оны эцэст хуваарилна.

181.6.Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангасан бол үл хөдлөх эд хөрөнгийн албадан удирдлагыг хэрэгжүүлж байгаа эрх бүхий этгээд тухайн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгчид нь шилжүүлнэ.

181.7.Албадан удирдсанаар үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах боломжгүй болох нь илт болсон бол албадан удирдлагыг дуусгавар болгож үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдана.

Дөрөвдүгээр дэд бүлэг

Улсын бүртгэл

182 дугаар зүйл. Улсын бүртгэлд үртгүүлэх эрх

182.1.Улсын бүртгэлд үл хөдлөх эд эрөөнгийн өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд эрөөнгийн бусад эрхийг бүртгүүлнэ.

182.2.Хууль буюу гэрээнд заасан эрхиолдолд хөдлөх эд хөрөнгө болон түүнтэй олбоотой эрхийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

182.3.Энэ зүйлд заасан эрхийг бүртгэх урмыг хуулиар зохицуулна.

183 дугаар зүйл. Улсын бүртгэлд ичигдсэн тэмдэглэл үнэн зөв байх

183.1.Эрх шилжүүлж байгаа этгээдийн нэр эр улсын бүртгэлд бүртгүүлсэн эрхийг хэлцлийн дсэн дээр олж авч байгаа этгээд улсын бүртгэлд ичигдсэн тэмдэглэлийг бууру ташаа болохыг эдэж байсан, эсхүл уг бүртгэлийг бууру ташаа гэж эргүүцсэнээс бусад тохиолдолд үнэн зөв гэж оцно.

183.2.Хэрэв бүртгэлийг бүртгүүлэх эрхүй гээдийн нэрээр хийлгэсэн бол энэхүү бүртгэлийн дүнд эрх болон эрх зүйн байдлын хувьд хохирч ийгаа этгээд бүртгэлд нэр нь байгаа этгээдээс үртгэлийн тэмдэглэлд өөрчлөлт оруулахыг эардаж болно.

183.3.Улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн ихэнх эзэмшигчийг үнэн зөв тогтоохын тулд улсын ртгэл бичигдсэн тэмдэглэл бууру, ташаа болох тухай өргөдлийг эрх нь зөрчигдөж байгаа этгээд бүртгэлийн байгууллагад гаргах эрхтэй.

184 дүгээр зүйл. Улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн дараалал

184.1.Улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн дараалал нь бүртгэлд бүртгүүлэхээр өргөдөл гаргасан дараалаар тодорхойлогдоно.

184.2.Дараалаа солилцож байгаа талуудын зөвшөөрлийн үндэсэн дээр дараалыг хожим өөрчилж болох бөгөөд улсын бүртгэлд уг өөрчлөлтийг бүртгүүлнэ.

184.3.Ямар нэгэн эрхийг бүртгүүлэхийн тулд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь аль нэгэн эрхийг негөө эрхийн өмнө бүртгүүлэх болзол тавьж болох бөгөөд энэхүү болзлыг улсын бүртгэлд тэмдэглүүлнэ.

185 дугаар зүйл. Улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх

185.1.Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг бүртгүүлэх тухай шаардлагыг хангахын тулд улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийж болно.

185.2.Энэ хуулийн 185.1-д заасан тэмдэглэлийг ирээдүйд бий болох буюу болзол тавьсан шаардлагыг хангахын тулд хийж болно.

185.3.Урьдчилсан тэмдэглэл хийгдсэний дараа хийх бүртгэл нь урьдчилсан тэмдэглэлээр эрхээ хамгаалуулсан этгээдийн шаардах эрхийг

дуусгавар болгох буюу хохироохгүй бол түүнд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

185.4.Урьдчилсан тэмдэглэлийг эрх эзэмшигчийг тогтоох зорилгоор, үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигчийн эвшөөрлөөр хийнэ.

185.5.Урьдчилсан тэмдэглэл хийлгэснээр удаан хугацааны турш эд хөрөнгөө ашиглах боломжийг алдахаар байвал эд хөрөнгийн эзэмшигч нь тэмдэглэл хийлгэсэн этгээдээс урьдчилсан тэмдэглэлийг хүчингүй болгуулахыг шаардах эрхтэй.

185.6.Урьдчилсан тэмдэглэл хийлгэсэн этгээдийн хувьд ямар нэгэн эрх олж авсан нь хүчин төгөлдөр бус байвал тухайн этгээд урьдчилсан тэмдэглэлээр хангагдах шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл хийлгэх эвшөөрөл олгохыг эд хөрөнгө эзэмшигчээс шаардах эрхтэй.

II ХЭСЭГ

ҮҮРЭГ

I ДЭД ХЭСЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ерөнхий үндэслэл

186 дугаар зүйл. Үүргийн харилцаа

186.1.Хууль буюу гэрээгээр үүрэг гүйцэтгэгчнь ямар нэгэн үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь түүнээс уг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

186.2.Үүргийн агуулга, шинж чанарыг харгалзан талуудын алинд ч негөө талын эрх, эд хөрөнгийн хувьд онцгой үүрэг ногдуулж болно.

187 дугаар зүйл. Үүрэг үүсэх үндэслэл

187.1.Үүрэг нь энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр үүснэ.

187.2.Гэрээ байгуулах бэлтгэл үе шатанд энэ хуулийн 186 дугаар зүйлд заасан үүрэг үүсч болно.

187.3.Хэлэлцээний явцад аль нэг талын хайхрамжгүй үйлдлээс болж гэрээг байгуулаагүй бол хэлэлцээ хийхтэй холбогдон гарсан зардлыг хайхрамжгүй хандсан тал негөө талд нөхөн төлөх үүрэг үүсч болно.

188 дугаар зүйл. Мэдээлэл өгөх үүрэг

188.1.Үүрэг нь ямар нэгэн мэдээлэл олж авах эрхийг аль нэг талд бий болгож болно.

188.2.Үүргийн агуулгыг тодорхойлохоо шаардлагатай мэдээллийг түүнийг эзэмшигч талнь өөрийн эрх, ашиг сонирхлыг хохироохгүйгээр өгөх боломжтой тохиолдолд негөө тал нь мэдээлэл авах эрхтэй.

188.3.Мэдээлэл өгөхтэй холбогдон гарсан зардлыг түүнийг хүлээн авагч тал негөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Гэрээний эрх зүй

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

189 дүгээр зүйл. Гэрээний талуудын чөлөөт байдал

189.1.Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.

189.2.Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндэсн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно.

189.3.Тусгай зөвшөөрлийн үндэсн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.

189.4.Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүү

ялдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэх талаар тухайн
их зөвлөд давамгайлж байгаа эгтээд энэхүү үйл
хиллагааны хүрээнд түүнд хандсан эгтээдтэй
рэх байгуулах үүрэгтэй бөгөөд негөө талдаа тэгш
/с нөхцөл түүнд санал тавих буюу гэрээ
йгуулахаас татгалзах эрхтэй.

189.5.Энэ хуулиар зохицуулаагүй, шууд
өрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж,
илбэрийг илэрхийлсэн өөрмөц агуулга бүхий
рээг нэрлэгдээгүй гэрээ гэнэ. Нөрлэгдээгүй
рээнд энэ хуулийн үүргийн тухай нийтлэг
дэслэл хамаарна.

**190 дүгээр зүйл. Ирээдүйд бий болох буюу
элэн байгаа эд хөрөнгийн хувьд хийх гэрээ**

190.1.Гэрээний нэг тал нь ирээдүйд бий
олох өөрийн бэлэн эд хөрөнгийг негөө талын
өчлөлд шилжүүлэх, эсхүл хязгаартайгаар
эмшүүлэх, ашиглуулах /үзүфрукт/-аар үүрэг
лээсэн гэрээ хүчин төгөлдөр бус байна.

190.2.Нэг тал нь өөрт бэлэн байгаа бүх эд
рөнгө буюу түүний хэсгийг негөө талын өмчлөлд
илжүүлэх, эсхүл хязгаартайгаар эзэмшүүлэх,
иглуулах /үзүфрукт/-аар үүрэг хүлээсэн гэрээг
тариатаар заавал гэрчлүүлнэ.

**191 дүгээр зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийн
лаар байгуулах гэрээ**

191.1.Иргэнд өвлөгдөх хөрөнгийн талаар
авдагч эгтээдийн хооронд байгуулсан гэрээ
ин төгөлдөр бус байна.

191.2.Өвлөгдөх хөрөнгөөс иргэнд заавал
дох хэсэг, түүнчлэн өвлүүлэгчийн гэрээслэлээр
тоосон хязгаарлалтын талаар гуравдагч
этгээдийн хооронд байгуулсан гэрээнд энэ хуулийн
191.1 нэгэн адил хамаарна.

191.3.Өвлөгдөх хөрөнгөөс ногдох хэсгийн
талаар хууль ёсны өвлөгчдийн хооронд байгуулсан
гэрээнд энэ хуулийн 191.1 хамаарахгүй.

**192 дугаар зүйл. Эд хөрөнгийн дагалдах
зүйлд үүрэг хамаарах**

192.1.Нэг тал эд хөрөнгөө негөө талын
өмчлөлд шилжүүлэх, хязгаартайгаар эзэмшүүлэх,
ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээсэн
тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг
тухайн эд хөрөнгийн дагалдах зүйлд нэгэн адил
хамаарна.

**193 дугаар зүйл. Үүргийн гүйцэтгэлийг
тодорхойлох**

193.1.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг
гэрээний аль нэг тал буюу гуравдагч этгээд
тодорхойлсон нь негөө талд буюу талуудад
эргэлзээ төрүүлэхээр бол шударга ёсны зарчимд
нийцүүлэн харилцан хүсэл зоригоо илэрхийлэх
замаар шийдвэрлэнэ.

193.2.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг
тодорхойлсон нь шударга ёсны зарчимд нийцээгүй,
эсхүл үүргийн гүйцэтгэлийг тодорхойлохыг хэт
удаашруулж байна гэж аль нэг тал нь үзвэл шүүхээр
шийдвэрлүүлэхээр хандах эрхтэй.

**194 дүгээр зүйл. Гэрээний бус үүрэгт
хамаарах журам**

194.1. Үүргийн шинж чанарт харшлахгүй бол
гэрээний бус үүргийн харилцаанд гэрээний үүргийн
холбогдох журмыг хэрэглэж болно.

Хоёрдугаар дэд бүлэг

Гэрээ байгуулах

195 дугаар зүйл. Гэрээ байгуулах санал

195.1. Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг
ээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд
тбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой
эдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор,
галттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг
ээ байгуулах санал гэнэ.

195.2.Гэрээ байгуулах саналд гэрээний гол
цөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан
ына.

195.3.Хуульд заасан буюу гэрээнд
лшгүй тусгавал зохих, түүнчлэн нэг талын
сэний дагуу негөө тал нь зөвшөөрсөн нөхцөлийг
гэрээний гол нөхцөл гэнэ.

195.4.Тодорхой бус этгээдүүдэд хандсан
хүсэл зоригийн илэрхийлэлд гэрээ байгуулах санал
болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах
дуудлага гэнэ.

195.5.Гэрээ байгуулах санал гаргасан тал
хууль, гэрээ, эсхүл саналд заасан хугацаанд
саналаасаа татгалзах эрхгүй.

195.6.Гэрээ байгуулах саналаас өөр
нөхцөлөөр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хариуг
гэрээ байгуулах тухай шинэ санал гэж үзнэ.

195.7.Гэрээ байгуулах санал илгээсэн тал

саналын хариуг хугацаа хожимдуулан хүлээн авсан бөгөөд энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдсэн бол хугацаа хожимдож ирсэн хариуг гэрээ байгуулах тухай шинэ санал гэж үзнэ.

196 дугаар зүйл. Гэрээг байгуулсанд тооцох

196.1.Дараахь үндэслэлээр гэрээг байгуулсанд тооцно:

196.1.1.эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах баримт бичгийг нөгөө тал хүлээн авснаар;

196.1.3.гэрээний саналыг хариу ирүүлэх хугацаатайгаар илгээсэн бөгөөд дурдсан хугацаанд нөгөө талаас зөвшөөрсөн хариу авсан;

196.1.4.гэрээний саналыг хариу ирүүлэх хугацаа заалгүй бичгээр илгээсэн бөгөөд түүнийг зөвшөөрсөн тухай хариуг ердийн боломжит хугацаанд хүлээн авсан;

196.1.5.нүүр тулан амаар гаргасан саналд тэр даруй зөвшөөрсөн хариу өгсөн;

196.1.6.гэрээ байгуулах саналыг хүлээн авсан тал зөвшөөрсөн хариуг хугацаанд нь илгээсэн боловч уг хариу хожимдож ирсэн учир гэрээг байгуулахгүй гэж нөгөө тал нь хариу илгээсэн талд нэн даруй мэдэгдэгүй;

196.1.7.ажил хэрчийн хүрээнд тогтсон заншил ёсоор саналд гаргагч талыг хүлээн зөвшөөрнө гэж үзээд санал хүлээн авагч тал нь саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахаар хариу илгээсэн тохиолдолд санал гаргагч татгалзсан тухайгаа нэн даруй мэдэгдээгүй.

196.2.Бусдад үйлчилгээ үзүүлэх аж ахуй эрхлэгч нь ажил төрлийн байнгын холбоо бүхий эттэздээс тухайн төрлийн үйл ажиллагаа гүйцэтгүүлэх тухай саналыг хүлээн авсан бол ердийн боломжит хугацааны дотор хариу явуулах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол түүнийг гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

196.3.Санал хүлээн авсан тал татгалзсан хариуг ердийн боломжит хугацааны дотор илгээсэн боловч санал гаргагч тал түүнийг мэдээгүйн улмаас саналд дурдсан үүрэг ёсоор бараа илгээсэн тохиолдолд санал хүлээн авсан тал үг бараанд учирч болох хохирлыг зайлуулах буюу багасгах зорилгоор бараог хүлээн авч хадгалах буюу гэмтээхгүй, муутгахгүй, үрэгдүүлэхгүй байх талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд гарсан зардлыг санал гаргагчаас шаардах эрхтэй.

197 дугаар зүйл. Үнэ хаялцуулах ажиллагаа

197.1. Үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулж болно.

197.2. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээг үнэ хаялцаж ялсан этгээдтэй байгуулна.

197.3. Үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулагч нь өмчлөгч буюу эрх зэмшигч, эсхүл эрх олгогдсон этгээд байж болно.

197.4.Эрх олгогдсон байгуллага өмчлөгч буюу эрх зэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн нэрийн өмнөөс, эсхүл өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

197.5.Эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг хуульдах гэрээг гагцхүү хуульд заасан бол үнэ хаялцуулах замаар байгуулна.

197.6.Үнэ хаялцуулах ажиллагааг дуудлага худалдаа буюу уралдааны хэлбэрээр явуулна.

197.7.Дуудлага худалдаагаар үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.

197.8.Уралдаанд ялагч нь уралдааны зохион байгуулах комиссоос урьдчилан тодорхойлсноор хамгийн сайн нөхцөлийг хангасан этгээд байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол үнэ хаялцуулах ажиллагааны хэлбэрийг уг эд хөрөнгийн өмчлөгч буюу эд хөрөнгийн эрх зэмшигч тогтооно.

197.9.Нэг этгээд оролцсон бол дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзнэ.

197.10.Дуудлага худалдаа буюу уралдааныг нээлттэй буюу хаалттай явуулж болно.

197.11.Нээлттэй дуудлага худалдаа уралдаанд ямар ч этгээд оролцож болно.

197.12.Хаалттай дуудлага худалдаа уралдаанд энэ зорилгоор тусгайлан урригдсан этгээд оролцоно.

197.13.Хуульд өөрөөр заагаагүй бол зохио байгуулагч нь зарыг үнэ хаялцуулах ажиллага

явуулахаас гучаас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд түүнд ажиллагаа явуулах хэлбэр, газар, хугацаа, гэрээний зүйл, анхны үнэ, оролцогчдыг бүртгэх, ялсан этгээдийг тогтоох журам болон бусад мэдээллийг тусгана. Гэрээний зүйл нь гэрээ байгуулах эрх бол гэрээ байгуулах хугацааг заана.

197.14.Хууль буюу зард өөрөөр заагаагүй бол нээлттэй дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч тэдгээрийг явуулахаас татгалзах эрхтэй. Гэхдээ дуудлага худалдаа явуулахаар овлон зарласан өдрөөс гурваас доошгүй хоногийн, уралдаан явуулахаар зарласан өдрөөс гучаас доошгүй хоногийн өмнө ийнхүү татгалзаж болно.

197.15.Энэ хуулийн 197.14-т заасан хугацааг өрчиж дуудлага худалдаа хийх буюу уралдаан явуулахаас татгалзсан зохион байгуулагч оролцогчдод учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

197.16.Хаалттай дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч нь түүнд уригдсан оролцогчдод учирсан хохирлыг ямар хугацаанд дуудлага худалдаа, уралдаан явуулахаас татгалзсанаас үл хамааран нөхөн төлөх үүрэгтэй.

197.17.Үнэ хаялцуулах ажиллагаанд оролцогч зард заасан хэмжээ, журмаар, заасан хугацаанд дэнчин тавина.

197.18.Үнэ хаялцуулах ажиллагааг явуулаагүй, түүнд оролцоогүй, эсхүл оролцсон оловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.

197.19.Ялсан этгээдтэй гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.

197.20.Үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээд болон ажиллагаа зохион байгуулагч дуудлага худалдаа, уралдааны үр дүнгийн тухай тэмдэглэлд явуулсан өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд энэ тэмдэглэл гэрээний адил хүчинтэй байна.

197.21.Ялсан этгээд тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл тавьсан дэнчингээ алдана.

197.22.Зохион байгуулагч тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл нөгөө талын тавьсан дэнчинг буцааж өгөхийн зэрэгцээ ажиллагаанд оролцсоноос учирсан хохирлыг дэнчингээс давсан хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй.

197.23.Үнэ хаялцуулах ажиллагааг гэрээ байгуулах эрх олж авах нөхцөлтэйгөөр явуулсан бол уг ажиллагааг явуулж дуусаад тэмдэглэл хилдсэнээс хойш хорь хоногийн дотор, эсхүл зард зурдсан хугацаанд талууд гэрээнд гарын үсэг зурна. Талуудын нэг нь гэрээ байгуулахаас зайлсхийвэл нөгөө тал нь гэрээг байгуулсанд тооцож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

197.24.Хуулиар тогтоосон журам зөрчиж явуулсан үнэ хаялцуулах ажиллагаа хүчин төгөлдөр бус байна.

197.25.Хүчин төгөлдөр бус үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээдтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

197.26.Энэ зүйлд заасан журам шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар явуулах дуудлага худалдаанд нэгэн адил хамаарна.

198 дугаар зүйл. Гэрээг тайлбарлах

198.1.Гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг анхаарна.

198.2.Гэрээний аль нэг нөхцөлийн утга нь ойлгомжгүй бол түүний агуулгыг бусад нөхцөл болон гэрээний ерөнхий агуулгатай харьцуулах замаар тодорхойлно.

198.3.Гэрээний зарим үг хэллэгийг нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр агуулгаар тайлбарлаж болохоор байвал гэрээ байгуулсан талуудын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар, талууд нь өөр өөр газар оршин суудаг бол гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн талын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар тайлбарлана.

198.4.Хоорондоо зөрчилтэй буюу олон утга санааг агуулсан үг хэллэг байвал гэрээний агуулгад илүү тохирсон утга санаагаар тайлбарлана.

198.5.Холимог гэрээний агуулгыг тайлбарлахдаа гэрээний гүйцэтгэлд илүү төсөөтэй тухайн төрлийн гэрээг зохицуулсан хуулийн хэм хэмжээг анхаарна.

198.6.Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

199 дүгээр зүйл. Хүлээн зөвшөөрснөөр гэрээ хүчин төгөлдөр болох

199.1.Нэгэнт үүссэн үүргийн харилцааг гэрчлэх гэрээг хүчин төгөлдөр гэж тооцоход үүрэг гүйцэтгэгч нь үүргийг хүлээн зөвшөөрсөн тухай

бичгээр мэдэгдсэн байвал зохино.

199.2.Хэлэлцэн тохирсон хэлбэрээр үүргийн харилцаа үүсэхэд гэрээг тохирсон хэлбэрээр байгуулсан байвал зохино.

199.3.Төлбөр гүйцэтгэснээр өрийг хүлээ зөвшөөрсөн буюу талууд хэлэлцэн тохиролцсон бо хуульд заасан тодорхой хэлбэрээр гэрээ хийхи шаардахгүй.

Гуравдугаар дэд бүлэг

Гэрээний стандарт нөхцөл

200 дугаар зүйл. Стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болох

200.1.Гэрээний нэг тал нь нөгөөдөө санал болгож байгаа, хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэнэ.

200.2.Талууд нэг бүрчлэн тохиролцож тогтоосон нөхцөлийг гэрээний стандарт нөхцөл гэж үзэхгүй.

200.3.Дараахь нөхцөл бүрдсэн тохиолдолд стандарт нөхцөл нь талуудын хооронд байгуулсан гэрээний салшгүй хэсэг болно:

200.3.1.санал гаргагч тал нь гэрээ байгуулж байгаа газарт стандарт нөхцөлийг ил тод харагдахаар бичиж энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн эгтээдтэй гэрээг байгуулахаар зассан бол;

200.3.2.нөгөө тал нь дээрх нөхцөлтэй танилцах боломжтой байсан бөгөөд уг нөхцөлийг зөвшөөрсөн бол.

200.4.Санал хүлээн авагч тал нь аж ахуй эрхлэгч эгтээд бөгөөд ажил хэргийн онцгоос хамаарч стандарт нөхцөлийг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болно.

200.5.Стандарт нөхцөлийг илэрхийлсэн гадаад нөхцөл нь хэвшсэн хэлбэрээс өөр байсан учир нөгөө тал нь түүнийг урьдчилан мэдэх боломжгүй байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болохгүй.

201 дүгээр зүйл. Стандарт нөхцөлийг тайлбарлах

201.1.Стандарт нөхцөлийг илэрхийлсэн үг хэллэгийн утга санаа ойлгомгүй бол түүнийг санал хүлээн авагч талд ашигтайгаар тайлбарлана.

202 дугаар зүйл. Стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байх

202.1.Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчим харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талд хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байн Энэ тохиолдолд стандарт нөхцөлийг гэрээнд тусга болсон нөхцөл байдал, талуудын ашиг сонирхо болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

202.2.Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэгч иргэнтэй гэрээ байгуулахаар санал гаргаж байга тал нь дараахь нөхцөлүүдийг гэрээний стандар нөхцөлд тусгасан бол тэдгээр нь хүчин төгөлдө бус байна:

202.2.1.саналыг хүлээн ава түүнээс татгалзах зэрэгт хэт урт буюу тодорхо бус хугацаа тогтоосон;

202.2.2.үүргээ гүйцэтгэхэд хэт у буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугац тогтоосон;

202.2.3.гэрээнд заагаагүй бөгө тодорхой үндэслэлгүйгээр гэрээг цуцлах эрхт байхаар заасан;

202.2.4.гэрээгээр нэгэнт тогтоос үүргээ нөгөө талын хуульд ёсны ашиг сонирхолд нийцэх байдлаар өөрчлөх буюу татгалзах эрхт байхаар заасан;

202.2.5.гаргасан зардлыг х өндрөөр буюу нэмэгдүүлэн тооцож шаардах эрхи өөртөө олгосон;

202.2.6.онцгой ач холбогдол бүх тайлбарыг нөгөө талд гаргасанд тооцохоор зааса

202.2.7.урт хугацаатай үүрги харилцаанд үнийг үндэслэлгүйгээр хэт боги хугацаанд огцом өсгөхөөр заасан;

202.2.8.нөгөө талын үүр гүйцэтгэх, эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах хуули олгогдсон эрхийг хязгаарласан буюу үгүйсгэсэ

202.2.9.нөгөө талдаа үүр гүйцэтгэхийг урьдчилан сануулах буюу үүр гүйцэтгэх боломжийн хугацаа олгох хуули тогтоосон үүргээс санал гаргагч талыг чөлөөлс

202.2.10.санал гаргагч тал нь өөрт чирсан бодит хохирлоос хэт давсан хэмжээний өхөн төлбөр шаардахаар тогтоосон;

202.2.11.санал гаргагч, түүний хууль сны төлөөлөгч зэрэг этгээдийн санаатай буюу хэт олгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг ариухайр үгүйсгэсэн буюу хязгаарласан;

202.2.12.үүргээ зөрчсөнөөс учирсан охирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын охийг хязгаарласан;

202.2.13.санал гаргагч тал нь үүргээ эсэгчлэн гүйцэтгэснээс нөгөө талын хууль ёсны шиг сонирхол хохирох тохиолдолд гэрээнээс атгалзах, гэрээгээ цуцалгаж, үүргээ гүйцэтгээгүйгээс чирсан хохирлыг бүхэлд нь шаардах эрхийг үйсгэсэн;

202.2.14.санал гаргагч талын элтгэн нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, йлчилгээний дутагдлын талаар хүлээх ариуцлагыг хуульд зааснаас бага хэмжээгээр гтоосон;

202.2.15.санал гаргагч тал хүлээсэн үргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор йцэтгээгүйгээс нөгөө тал гэрээг цуцалсан бол инал гаргагч талд анз төлөхөөр заасан.

202.3.Бараа бүтээгдэхүүн тогтмол йлчүүлэх буюу ажил, үйлчилгээ тогтмол явуулах хай гэрээний стандарт нөхцөлд дараахь нөхцөлийг тусгасан бол тэдгээр нөхцөл нь хүчин төгөлдөр бус байна:

202.3.1. нөгөө талд хоёроос илүү жилийн хугацаагаар үүрэг хүлээлгэж байгаа;

202.3.2. аль нэг тал нь гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг тухай бүр нэг жилээс урт хугацаагаар сунгасанд тооцохоор тогтоосон;

202.3.3. гэрээг цуцлах хугацаа нь гэрээг сунгасанд тооцох хугацаанаас гурван сараас илүү байхаар заасан нь нөгөө талын хууль ёсны ашиг сонирхолд үл нийцэхээр бол.

202.4.Дор дурдсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээд санал гаргагч талын оронд түүнтэй адил эрхтэйгээр тухайн гэрээний харилцаанд оролцохоор заасан буюу оролцох боломлоотой байхаар тогтоосон бол стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байна:

202.4.1. гуравдагч этгээдийг нэрээр нь заасан;

202.4.2. нөгөө талд дангаар гэрээг цуцлах эрх олгосон.

202.5.Гэрээний стандарт нөхцөлд хамаарах хэсгүүдийн аль нэг нь хүчин төгөлдөр бус байх, эсхүл гэрээний гол бус нөхцөл болсон тохиолдолд гэрээ бүхэлдээ хүчин төгөлдөр байна.

Дөрөвдүгээр дэд бүлэг
Гуравдагч этгээдэд ашигтай гэрээ

203 дугаар зүйл. Гуравдагч этгээдэд ашигтай гэрээний шаардах эрх

203.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, хүл үүргийн мөн чанарт харшлахгүй бол гуравдагч гээдэд ашигтай гэрээний үүрэг гүйцэтгүүлэгч, равдагч этгээдийн аль нь ч үүргийн гүйцэтгэлийг рэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

203.2.Гэрээнд тусгайлан заагаагүй бол равдагч этгээд бие даан шаардах эрхтэй эсэх, э эрх нь шууд, эсхүл урьдчилсан тодорхой нөхцөл рдсэнээр үүсэх, гуравдагч этгээдийн эшөөрөлгүйгээр гэрээ байгуулсан талууд түүний эрхийг өөрчлөх буюу дуусгавар болгох эрхтэй эсэхийг гэрээний агуулга, түүний зорилгоос тодорхойлно.

203.3.Гуравдагч этгээдэд ашигтай гэрээнд энэ хуулийн 203.2-т заасан эрх үүргийн талаар тусгайлсан нөхцөлийг гэрээнд тусгасан тал нь нөгөө талын зөвшөөрлөөс үл шалтгаалан гуравдагч этгээдийг орлох эрхтэй.

203.4.Гэрээнд өөрөөр заагаагүй буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол гуравдагч этгээд гэрээнд заасан эрхээсээ татгалзвал үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг шаардаж болно.

Тавдугаар дэд бүлэг
Гэрээнээс татгалзах

204 дүгээр зүйл. Гэрээнээс татгалзах эрам

204.1.Аль нэг тал нь гэрээнээс татгалзах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэнэ.

204.2.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээнээс татгалзах хугацаг татгалзах санал

гаргаагүй тал нь тогтооно. Энэ хугацаанд гэрээнээс татгалзаж байгаа тухай мөгөө талд дахин мэдэгдэгүй бол гэрээнээс татгалзах эрхээ алдана.

204.3.Гэрээний аль нэг буюу хоёр талд хэд хэдэн этгээд оролцож байгаа бол гэрээнээс хамтран татгалзана. Тэдний хэн нэг нь гэрээнээс татгалзах эрхээ алдвал бусад нь мөн адил гэрээнээс татгалзах эрхээ алдана.

204.4.Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гэрээнээс татгалзах эрхээ алдах болзолтойгоор гэрээ байгуулсан бол уг болзол бий болсон тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрхтэй.

204.5.Гэрээний аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй бол мөгөө тал нь гэрээнээс татгалзах эрхтэй байхаар гэрээ байгуулсан боловч үүрэг гүйцэтгэгч тал нь харилцан шаардлага бүхий үүргээ тооцож дуусгавар болгох эрхтэй байсан бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзсаны дараа үүрэг гүйцэтгэгч нь үүргийг тооцсон тухай нэн даруй мэдэгдсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчийн татгалзал хүчин төгөлдөр бус байна.

205 дугаар зүйл. Гэрээний аль нэг тал нь гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагавар

205.1.Хууль буюу гэрээнд заасны дагуу аль нэг тал нь гэрээнээс татгалзсан бол талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь, түүнчлэн гэрээ биелсэнээс олсон ашгийг харилцан буцааж өгөх үүрэгтэй.

205.2.Дараахь тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг биет байдлаар бус мөнгөөр мөхөн төлнө:

205.2.1.гүйцэтгэсэн үүргийн шинж чанараас шалтгаалан биет байдлаар эргүүлж өгөх боломжгүй;

205.2.2.үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тал нь түүнийг ашиглаж байгаа буюу бусдын өмчлөлд шилжүүлсэн, эсхүл бусдын эрхээр хэзээлсан, түүнчлэн түүнийг боловсруулах, дахин боловсруулах замаар өөрчилсөн;

205.2.3.үүргийн зүйлийг ердий элэгдэл, хорогдлоос гадуур гэмтээсэн, муутгасан дутаасан, устгасан.

205.3.Хэрэв үүрэг гүйцэтгэгч нь гэрээ ёсоо хариу ямар нэгэн үүрэг гүйцэтгэсэн бол мөнге төлберийн оронд хариу гүйцэтгэсэн үүргийг орлуул болно.

205.4.Дараахь тохиолдолд үүрэг гүйцэтгэ мөхөн төлбөр төлөхгүй:

205.4.1.гэрээгээр үүр гүйцэтгүүлэгчийн шилжүүлсэн зүйлийн чанарь доголдол нь үүрэг гүйцэтгэгч гэрээнээс татгалз үндэслэл болсон бөгөөд гэрээр гэрээний зүйли боловсруулах, дахин боловсруулах явцдаа энэх доголдлыг илрүүлсэн ;

205.4.2. гэрээний зүйл үүр гүйцэтгүүлэгчийн буруугаас гэмтсэн, муудса дутсан, устсан;

205.4.3.үүрэг гүйцэтгэгч гэрээн зүйлийг зохих ёсоор хадгалж, арчилж, хамгаалсаа байхад тэр нь муудсан, гэмтсэн, устсан. Э тохиолдолд гэрээний зүйлээс үлдсэнийг нь үүр гүйцэтгүүлэгчид буцааж өгнө.

205.5.Үүрэг гүйцэтгэгч үүргийн зүйли ашиглах журам зөрчсөнөөс олох ёстой байс ашгийг олж чадаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

205.6.Үүрэг гүйцэтгэгч үүр гүйцэтгүүлэгчид гэрээний зүйлийг буцааж өгсө үнийг нь төлөөн, эсхүл энэ хуулийн 205.4.1, 205.4.2 заасны дагуу гэрээний зүйлийг буцааж өгөх бү хохирол мөхөн төлөх шаардлага үүсэхгүй бол үүр гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэчид зайлшгүй зардл мөхөн төлөх үүрэгтэй. Бусад зардлыг үүр гүйцэтгэгч гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгчид оруулс ашгийн хэмжээгээр мөхөн төлнө.

205.7.Энэ хуулийн 205.1-д заасан үүрги гэрээний талууд биечлэн, мөгэн зэрэг гүйцэт үүрэгтэй.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Үүрэг гүйцэтгэх

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

206 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх зарчим

206.1.Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ.

207 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх газар

207.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаа үүргийн мөн чанарт харшлахгүй бол үүрэг гүйцэт

эрыг дараахь байдлаар тодорхойлно:

207.1.1.үл хөдлөх эд хөрөнгөтэй олбогдсон үүргийг тухайн үл хөдлөх эд хөрөнгө айгаа газарт;

207.1.2.эд хөрөнгө тээвэрлэх ргийг үүл эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч буюу рх бүхий этгээдэд хүргүүлэхээр анхны эвэрлэгчид хүлээлгэн өгсөн газар;

207.1.3.мөнгөн төлбөрийн үүргийг /рэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа /оршин байгаа/ газар, харин үүрэг гүйцэтгүүлэгч дээрх газраа эрчилсэн тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдсэн бол үний шинээр оршин суугаа /оршин байгаа/ газар;

207.1.4.бусад бүх үүргийг үүрэг йцэтгэгчийн оршин суугаа /оршин байгаа/ газар.

207.2.Энэ хуулийн 207.1.3-т заасан хиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа / ршин байгаа/ газрын хаягаар мөнгийг илгээхээр анк, түүнтэй адилтгах бусад байгууллагад илжүүлснээр үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэнд оцно.

207.3.Үүрэг гүйцэтгэхээс өмнө үүрэг йцэтгүүлэгч, эсхүл үүрэг гүйцэтгэгч оршин суугаа ршин байгаа/ газраа өөрчилсэн тухай мэдээ талдаа эдэгдэх үүрэгтэй байсан тохиолдолд шинэ газар рэг гүйцэтгэх буюу үүргийн гүйцэтгэлийг хүлээн ахтай холбогдон гарсан зардлыг шилжсэн тал нь хөн төлж, эрсдэлийг хариуцна.

208 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх хугацаа

208.1.Үүргийг хууль буюу гэрээнд заасан гацаанд гүйцэтгэнэ.

208.2.Үүрэг гүйцэтгэх хугацаа тогтоогоогүй юу болзол тавиагүй, үүргийн шинж чанараас алтгаалан түүнийг тодорхойлох боломжгүй бол рэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэдийд ч зардах эрхтэй, үүрэг гүйцэтгэгч нэн даруй йцэтгэх үүрэгтэй байна.

208.3.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй л үүргийн шинж чанараас шалтгаалан үүрэг йцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг шаардсанаас йш арав хоногийн дотор үүрэг гүйцэтгэгч үүргээ йцэтгэх үүрэгтэй.

208.4.Үүрэг гүйцэтгэх хугацаа хууль буюу эээгээр тогтоосон бол үүрэг гүйцэтгүүлэгч гацаанаас өмнө үүргийн гүйцэтгэлийг шаардах гүй.

208.5.Үүрэг гүйцэтгүүлэгч татгалзаагүй бол эг гүйцэтгэгч үүргээ хугацаанаас нь өмнө гүйцэтгэх эрхтэй.

208.6.Үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ хуулийн 208.4-т заасан хугацаанаас өмнө үүрэгээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах эрхтэй.

208.7.Болзол тавьж хийсэн хэлцлийн тухайд үүргийг үүл болзол бий болсны дараагийн өдрөөс гүйцэтгэнэ.

209 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгэхээс татгалзах

209.1.Хоёр талын гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нэг тал нөгөө талынхаа өмнө үүргээ эхлэн гүйцэтгэхээс бусад тохиолдолд нөгөө тал хариу үүрэг гүйцэтгэхээс өмнө үүргээ гүйцэтгэхээс татгалзаж болно.

210 дугаар зүйл. Гуравдагч этгээдээр үүрэг гүйцэтгүүлэх

210.1.Хууль буюу гэрээнд үүрэг гүйцэтгэгч үүргээ заавал биечлэн гүйцэтгэхээр заагаагүй буюу үүргийн шинж чанарт харшлахгүй бол үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно.

210.2.Үүрэг гүйцэтгэгч нь гуравдагч этгээдийн үүргийн гүйцэтгэлээс татгалзвал үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээж авахгүй байх эрхтэй.

210.3.Гуравдагч этгээд хариуцлага хүлээхээр хуульд заагаагүй бол түүний гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн хариуцлагыг үндсэн үүрэг гүйцэтгэгч хариуцна.

210.4.Үүрэг гүйцэтгэгчийн эд хөрөнгөөс үүргийг албадан гүйцэтгүүлэхээр бол тухайн эд хөрөнгийн хувьд эрхээ алдаж болзошгүй гэж үзсэн этгээд нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах эрхтэй. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрх үүргийн гүйцэтгэлийг хангасан гуравдагч этгээдэд шилжинэ.

211 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийг хүлээлгэн өгөх

211.1.Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүхийн шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө.

211.2.Үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах эрхтэй этгээдэд хүлээлгэн өгсөн бол гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч зөвшөөрсөн буюу ийнхүү

гүйцэтгэснээр үүрэг гүйцэтгүүлэгч ашиг олсон нөхцөлд уул үүргийг гүйцэтгэсэнд тооцно.

212 дугаар зүйл. Сонгох үүрэг

212.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл үүргийн мөн чанарт харшлахгүй бол хэд хэдэн үүргээс аль нэгийг нь сонгож гүйцэтгэх эрхийг үүрэг гүйцэтгэгч эдэлнэ.

212.2. Үүрэг гүйцэтгэгч гүйцэтгэвэл зохих хэд хэдэн үйлдлийн аль нэгээс татгалзах эрхтэй бол татгалзсан тохиолдолд үлдсэн үйлдлийг гүйцэтгэх үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна.

212.3.Энэ хуулийн 212.1-д заасан сонголт хийхдээ үүрэг гүйцэтгэгч энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

213 дугаар зүйл. Үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх

213.1.Гэрээнд заасан, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч зөвшөөрсөн бол үүрэг гүйцэтгэгч үүргээ хэсэгчлэн гүйцэтгэх эрхтэй.

213.2.Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд зааснаас өөр гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй. Үүргийн гүйцэтгэл нь зардал ихтэй байсан ч энэ журам нэгэн адил үйлчилнэ.

214 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийн чанар

214.1.Үүргийн гүйцэтгэлийн чанарын талаар гэрээнд тодорхой заагаагүй бол үүрэг гүйцэтгэгч нь ердийн шаардлагад нийцүүлэн үүргээ гүйцэтгэж, дундаас доошгүй чанарын эд хөрөнгө шилжүүл үүрэгтэй.

215 дугаар зүйл. Үүргийн гүйцэтгэлий саатуулах эрх

215.1.Үүрэг гүйцэтгүүлэгч хүлээсэн үүр биелүүлж үүрэг гүйцэтгэх боломж бүрдүүлэх хүрт үүрэг гүйцэтгэгч нь өөрөөр төлбөрийнхөөс бүс үүргийн гүйцэтгэлийг саатуулж болно.

215.2.Үүргийн зүйл нь төрлийн шинжээ тодорхойлогдох эд хөрөнгө байвал үүрэг гүйцэтгэ үүргээ ямар ч нөхцөлд биелүүлэх үүрэгтэй.

216 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх дараала

216.1.Үүрэг гүйцэтгэгч нь ижил төрлийн хэ хэдэн үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэгтэй бөгөө үүргийн гүйцэтгэл нь бүх ерийг төлөхө хүрэлцэхгүй бол үүрэг гүйцэтгэгч аль нэг үүрги сонгож гүйцэтгэх эрхтэй. Үүрэг гүйцэтгэгч ий сонголт хийгээгүй бол төлбөрийн хугацаа болсо ерийг тэргүүн ээлжинд төлүүлнэ.

216.2.Хэд хэдэн ерийг төлөх хугацаа нэгэ зэрэг болсон тохиолдолд гүйцэтгэхэд илүү хүн нөхцөлтэй шаардлагыг тэргүүн ээлжинд гүйцэтгэн

216.3.Шаардлагууд нь үүрэг гүйцэтгэгчий хувьд ижил нөхцөлтэй бол биелэх боломж багата үүргийг тэргүүн ээлжинд гүйцэтгэнэ.

216.4.Үүргийн гүйцэтгэл нь төлөх хугацаа болсон бүх ерийг төлөхөд хүрэлцэхгүй бол тэргүү ээлжинд шүүхийн зардал, дараа нь үндсэн үүрэ эцэст нь хүүг төлүүлнэ.

Хоёрдугаар дэд бүлэг

Мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх

217 дугаар зүйл. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт

217.1.Мөнгөн төлбөрийн үүргийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэнэ.

217.2.Хуулиар хориглоогүй бол талууд мөнгөн төлбөрийн үүргийг гадаадын мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэж болно.

218 дугаар зүйл. Төлбөр гүйцэтгэх мөнгөний ханш

218.1.Төлбөр гүйцэтгэх хугацаа болохоо өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсэ үеийн ханшаар тооцож төлбөрийг төлнө.

218.2.Мөнгөн тэмдэгтийн төрөл өөрчлөгдөө бол мөнгөн тэмдэгт өөрчлөгдсөн өдөр мөрдө байсан ханшаар тооцож төлбөрийг төлнө.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

Үүргийн гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал

Нэгдүгээр дэд бүлэг
Нийтлэг үндэслэл

219 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгэгчийн буруугаас үүрэг гүйцэтгэх боломжгүй болох

219.1.Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ өөрсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй.

219.2.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн бол үүрэг гүйцэтгүүлэгч түүнд үүргээ биелүүлэх нэмэлт хугацаа зааж болно. Энэ хугацаанд үүргээ дахин биелүүлэхгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй.

219.3.Нэмэлт хугацаа тогтоосноор ямар нэгэн үр дүнд хүрч чадахгүй нь тодорхой, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч учирсан гэм хорыг арилгуулахаар шаардах эрхээ хэрэгжүүлэх нь алуудын ашиг сонирхолд илүү нийцэхээр байвал энэлт хугацаа олгохгүй байж болно.

219.4.Үүрэг гүйцэтгэгч санаатайгаар үүргээ өрсөн тохиолдолд учирсан хохирлыг арилгах үргээс түүнийг чөлөөлөхөөр урьдчилан охиролцож болохгүй.

219.5.Хууль ёсны төлөөлөгч буюу бусад гээдээр үүргээ гүйцэтгүүлсэн үүрэг гүйцэтгэгч дгээрийн үйлдлийн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид нирсан хохирлыг бүрэн хэмжээгээр хариуцна.

219.6.Гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл үргийн мөн чанарт харшлахгүй бол үүргийн зүйлийг өр этгээдээс хүлээн авах ёстой байсан үүрэг йцэтгэгч түүнийгээ авч чадаагүйгээс үүрэг иелэгүй бол үүнээс үүдэн гарах хариуцлагыг эрөө хүлээнэ.

220 дугаар зүйл. Нөхцөл байдал өрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй олох

220.1.Гэрээ байгуулах үндэслэл болсон эхцөл байдал гэрээ байгуулсны дараа илтэд өрчлөгдсөн, ийнхүү өөрчлөгдөхийг талууд рьдчилан мэдэж байсан бөгөөд гэрээг айгуулахгүй байх буюу өөр агуулгаар байгуулах оломжтой байсан бол гэрээг өөрчлөгдсөн нөхцөл айдалд нийцүүлэхийг талууд харилцан шаардах рхтэй.

220.2.Гэрээ байгуулах үндэслэлийн талаар талуудын төсөөлөл буруу байсан бол түүнийг гэрээ байгуулах нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй адилтгаж үзнэ.

220.3.Талууд өөрчлөгдсөн нөхцөл байдалд гэрээг зохицуулах арга хэмжээг тэргүүн ээлжинд авах үүрэгтэй.

220.4.Гэрээг өөрчлөгдсөн нөхцөл байдалд зохицуулах боломжгүй, эсхүл нөгөө тал нь зөвшөөрөөгүй бол эрх ашиг нь хөндөгдсөн тал гэрээнээс татгалзах эрхтэй.

221 дүгээр зүйл. Хүндэтгэн үзэх үндэслэлээр талуудыг гэрээнээс татгалзах

221.1.Хүндэтгэн үзэх үндэслэл байвал урт хугацаатай гэрээний талууд гэрээ дуусгавар болох хугацаанаас харгалзахгүйгээр гэрээнээс татгалзаж болно.

221.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацаагүргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ.

221.3.Гэрээний үүргийг зөрчсөн нь түүнийг цуцлах үндэслэл болж байвал зөвхөн энэ хуулийн 219.3, 225.2-т заасан зөрчлийг арилгах буюу урьдчилан сануулах хугацаанд гэрээг цуцалж болно.

221.4.Эрх бүхий этгээд гэрээ цуцлах үндэслэл байгааг мэдсэнээс хойш ердийн боломжит хугацааны дотор гэрээнээс татгалзаж болно.

221.5.Гэрээг цуцалснаар өмнө гүйцэтгэсэн үүргийн гүйцэтгэл ач холбогдлоо алдвал түүнийг нэгэн адил цуцлана. Ийнхүү цуцлахад энэ хуулийн 205 дугаар зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

221.6.Хохирлыг арилгахтай холбогдсон шаардлагад энэ хуулийн 227 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

Хоёрдугаар дэд бүлэг

Хугацаа хэтрүүлснээс үүсэх үр дагавар

222 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэгч хугацаа трүүлэх

222.1.Дараахь тохиолдолд үүрэг гүйцэтгэгч гацаа хэтрүүлсэн гэж үзнэ:

222.1.1.үүргээ хугацаанд нь биелүүлээгүй л;

222.1.2.үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг үүрэг гүйцэтгүүлэгч сануулснаас хойш үүргээ биелүүлээгүй бол.

222.2.Хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдал нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй.

222.3.Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч аливаа болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ийн хариуцлагыг хүлээнэ.

222.4.Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна. Харин үүргийг хугацаанд нь гүйцэтгэсэн ч тохиолдох байсан тохиолдлын улмаас үүссэн хохирлыг хариуцахгүй.

222.5.Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй.

222.6.Хүүгээс анз тооцохгүй.

222.7.Үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлснээс учирсан хохирлыг арилгуулахаар үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхтэй.

222.8.Үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үүргээ хугацааанаас нь өмнө гүйцэтгэсэн бол хугацаа хэтрүүлсэнтэй адилтгаж үзнэ.

223 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хэтрүүлэх

223.1.Хугацаанд нь гүйцэтгэсэн үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээж авааг бол түүнийг хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ.

223.2.Үүрэг гүйцэтгэх нөхцөлий бүрдүүлэхийн тулд үүрэг гүйцэтгүүлэгч ямар нэгэ үйлдэл хийх ёстой байсан боловч түүний гүйцэтгээгүйгээс хугацаа хэтэрсэн бол үүрэ гүйцэтгүүлэгч хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ.

224 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгүүлэг хугацаа хэтрүүлснээс үүсэх үүрэг

224.1.Энэ хуулийн 223 дугаар зүйл, зааснаар хугацаа хэтрүүлсэн гэм буруутай үүрэ гүйцэтгүүлэгч ийнхүү хугацаа хэтрүүлснээс үүрэ гүйцэтгэчид учруулсан хохирлыг арилгах үүрэгтэй

224.2.Хугацаа хэтрүүлсэн үүрэ гүйцэтгүүлэгч гэм буруутай эсэхээс үл хамаара түүнд дараахь үүрэг, үр дагавар үүснэ:

224.2.1.гэрээний зүйлий хадгалсантай холбогдож үүрэг гүйцэтгэгчээс гарса нэмэлт зардлыг нөхөн төлөх;

224.2.2.гэрээний зүйл тохиолдлоор устах гэмтсэний эрсдлийг хүлээх;

224.2.3.мөнгөн төлбөрийн үүрэг ёсоор хү анз авах эрхээ алдах.

Гуравдугаар дэд бүлэг

Хоёр талын гэрээнд үүрэг зөрчих

225 дугаар зүйл. Үүрэг зөрчсөнөөс талууд гэрээнээс татгалзах

225.1.Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал гэрээнээс татгалзах эрхтэй.

225.2.Үүрэг гүйцэтгүүлэгч нэмэлт хугацаа тогтоож өгөөгүй боловч үүрэг гүйцэтгэхийг үүрэг гүйцэтгэгчид урьдчилан сануулсан бол нэмэлт хугацаа тогтоосонтой адилтгаж үзнэ.

225.3.Үүрэг гүйцэтгэгч үүргийн зарим хэсгийг зөрчсөн боловч үлдэх хэсгийг гүйцэтгэх нь үүрэг гүйцэтгүүлэгчид ашиггүй болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзаж болно.

225.4.Дараахь тохиолдолд талууд гэрээнээс татгалзаж болохгүй:

225.4.1.үүргийг ялимгүй зөрчсөн;

225.4.2.энэ хуулийн 186.2-т заасан шаардлагыг зөрчсөн боловч үүрэг гүйцэтгүүлэгч гэрээг хүчин төгөлдөр байлгахыг шаардах эрхтэ байвал;

225.4.3.үүрэг гүйцэтгэгч үүрэ зөрчсөн явдалд бүхэлд нь буюу ихэнх хэсэгт н үүрэг гүйцэтгүүлэгч өөрөө бууруатай;

225.4.4.үүрэг гүйцэтгүүлэ гэрээнээс татгалзахаас өмнө үүрэг гүйцэтгэгч хар шаардлага гаргасан, эсхүл үүрэг гүйцэтгүүлэ гэрээнээс татгалзсаны дараа хариу шаардлага нь даруй гаргах боломжтой бол.

225.5.Гэрээнээс татгалзах үндэсл ирээдүйд бий болох нь гарцаагүй, илт байвал үүр гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэх хугацаа болохо өмнө гэрээнээс татгалзах эрхтэй.

225.6.Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнэ татгалзах хугацааг үүрэг гүйцэтгэгч тогтоож болн

225.7.Энэ хуулийн 225.6-д заасан хугацаа үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрх эдлээгүй боловч үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтг нэмэлт буюу урьдчилсан сануулгын хугацаа

эрэг биелүүлэгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч
эрээнээс татгалзаж болно.

226 дугаар зүйл. Нэмэлт хугацаа тогтоох, рьдчилан сануулах шаардлагагүй нөхцөл айдал

226.1.Дараахь нөхцөл байдал байвал энэ
улийн 204.2, 219.2-т зааснаар үүрэг гүйцэтгэх
эмэлт хугацаа тогтоох буюу урьдчилан сануулах
аардлагагүй:

226.1.1.ямар нэгэн үр дүн гарахгүй болох
› илт бол;

226.1.2.үүрэг гүйцэтгэгч гэрээгээр
гтоосон хугацаанд үүргээ гүйцэтгээгүй, харин
эмэлт хугацаанд үүрэгээ гүйцэтгэсэн тохиолдолд
рээний харилцаа үргэлжлэх ёстой бол;

226.1.3.хоёр талын ашиг сонирхлын
үднээс онцгой үндэслэлээр гэрээг нэн даруй
үцлах шаардлагатай бол.

227 дугаар зүйл. Үүрэг зөрчсөнөөс үүсэх ариуцлага

227.1.Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй.

227.2.Нэг тал нь гэрээнээс татгалзсан явдалд нөгөө тал нь буруугүй бол энэ хуулийн 227.1-д заасан үндэслэл хамаарахгүй.

227.3.Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно.

227.4.Үүрэг гүйцэтгэгч тодорхой эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд шилжүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь уг эд хөрөнгийг өөртөө шилжүүлэх, учирсан хохирлоо арилгахыг шаардах эрхтэй.

227.5. Үүрэг гүйцэтгэгч тодорхой ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгээгүй, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийг өөрөө гүйцэтгэх буюу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, учирсан хохирлыг арилгахыг шаардах эрхтэй.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Гэм хорыг арилгах

228 дугаар зүйл. Гэм хорыг арилгуулах ›х

228.1.Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд
гөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас
нөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг
ргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал
эахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.

228.2.Хохирогч эрхээ сэргээлгэхээр гэм
рыг арилгах үүрэг бүхий этгээдэд тодорхой
гацаа тогтоож болох бөгөөд энэ хугацаанд үүргээ
йцэтгээгүй бол мөнгөөр гүйцэтгэхийг шаардаж
лно.

228.3.Эрүүл мэндийг хохироосноос хирогч хөдөлмөрийн чадвараа алдсан буюу дөлмөрийн чадвар нь бүрэн, эсхүл хэрэглээ рдал нь нэмэгдсэн бол гэм хорыг арилгах үүрэг хий этгээд хохирогчид сар тутам мөнгө /тэжээн ргэхтэй холбогдсон тэтгэлэг/ төлөх замаар гэм рыг арилгах үүрэгтэй.

228.4.Хохирогч эмчилгээний зайлшгүй рдлыг урьдчилан төлүүлэхээр гэм хорыг арилгах рэг бүхий этгээдээс шаардах эрхтэй.

228.5.Хохирогч мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд дахин мэргэжил эзэмших зайлшгүй шаардлагатай бол үүнтэй холбогдсон зардлыг нөхөн төлөхөд энэ журам нэгэн адил хамаарна.

228.6.Хүндэтгэн үзэх шалтгаан байвал хохирогч энэ хуулийн 228.3-т заасан сар тутмын менгөн төлбөрийн оронд нэг удаагийн нөхөн төлбөр авахаар шаардаж болно.

229 дүгээр зүйл. Гэм хорыг арилгах хэмжээ

229.1.Үүрэг бүхий этгээд нь гэм хорыг арилгахдаа эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй.

229.2.Гэм хорын хэмжээг тодорхойлходоо хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал, гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээг харгалзан үзнэ.

230 дугаар зүйл. Эдийн бус гэм хорыг арилгах

230.1.Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй.

230.2.Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.

230.3.Гэм хор учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан гэм хороос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчий буюу эрх бүхий этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй нөлөөлсөн бол гэм хорыг арилгах үүрэг болон түүни хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм бурууги хэмжээг харгалзана.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Үүргийн гүйцэтгэлийг хангах арга

231 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийг хангах арга

231.1.Үүргийн гүйцэтгэлийг дараахь аргаар хангана:

231.1.1. анз;
231.1.2. дэнчин;
231.1.3. баталгаа;
231.1.4. барьцаа;
231.1.5. батлан даалт;

231.1.6.үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/;

231.1.7. хуульд заасан бусад арга.

232 дугаар зүйл. Анз

232.1.Хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөрийг анз гэнэ.

232.2.Дэнчингийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд анзыг нэгэн адил хэрэглэж болно.

232.3.Анзын гэрээг бичгээр хийнэ.

232.4.Анз нь торгууль, алданги гэсэн төрөлтэй байна. Анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.

232.5.Үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал нь төлөхөөр хууль болон гэрээнд урьдчилан тодорхой хэмжээгээр заасан, эсхүл гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн тодорхой хувиар тогтоосон анзыг торгууль гэнэ.

232.6.Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.

232.7.Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд анз төлөхөөр гэрээнд заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч анз шаардах эрхгүй бөгөөд харин учирсан хохирлоо арилгуулахыг шаардах эрхтэй.

232.8.Анзын хэмжээ илт их байвал хэргий нөхцөл байдлыг харгалзан шүүх түүнийг багасга болно.

233 дугаар зүйл. Дэнчин

233.1.Гэрээнд оролцогч нэг тал нь гэрэ байгуулсны нотолгоо болгон нөгөө талдаа төлбө зохих төлберт оролцуулан урьдчилан өгсөн мөнги дэнчин гэнэ.

233.2.Гэрээг цуцалсан, эсхүл дэнчин тави тал нь үүргээ гүйцэтгэхдээ үүргийн гүйцэтгэ дэнчинг оролцуулаагүй бол үүрэг гүйцэтгэ дууссаны дараа дэнчин авсан тал нь дэнчи буцааж өгнө.

233.3.Дэнчин тавьсан этгээд үүр гүйцэтгээгүйгээс хариуцлага хүлээхээр байва дэнчинг дэнчин авсан этгээдэд үлдээнэ. Э тохиолдолд дэнчин авагчид учирсан хохирл төлөхдөө дэнчинг оролцуулан тооцно.

233.4.Дэнчин авсан этгээд үүр гүйцэтгээгүйгээс хариуцлага хүлээхээр байва дэнчинг тавьсан этгээдэд буцааж өгнө. Э тохиолдолд дэнчин тавьсан этгээд учирсан г хорыг арилгуулахаар шаардах эрхтэй.

234 дүгээр зүйл. Баталгаа

234.1.Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүрг гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээд үүр гүйцэтгүүлэгчид баталгаа гаргаж болно.

234.2.Баталгааны гэрээг бичгээр хийнэ.

234.3.Гэрээнд өөрөөр заагаагүй б баталгаа гаргагч нэг талын санаачилгаар гэрэ цуцалж болохгүй.

234.4.Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээ бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэл баталгаа гаргагчаас үл маргах жүрмаар шаарда

234.5.Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үү хүлээсэн баталгаа гаргагч үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй.

234.6.Банкны баталгаат энэ хуулийн 457 ‹гаар зүйлд заасан журмаар зохицуулна.

235 дугаар зүйл. Үүргийн гүйцэтгэлийг ангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх рэгсэл /фидуци/

235.1.Үүргийн гүйцэтгэлийг энгуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх рэгсэгээр /цаашид "фидуци" гэх/ үүрэг хүлээгч нь энэ төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах эрилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг йцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг лээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн ‹иолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг үнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.

235.2.Шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байхаар гэрээнд зааж болно.

235.3.Гэрээний дагуу шилжүүлсэн эд хөрөнгийг үндсэн үүргийг гүйцэтгэх хугацаа болохоос өмнө үүрэг гүйцэтгүүлэгч захиран зарцуулсан бол үүргээ гүйцэтгэсэн үүрэг хүлээгч учирсан хохирлоо шаардах эрхтэй.

235.4.Үүрэг хүлээгч мөнгө төлөх үүргээ хугацаанд нь биелүүлж, шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан авсан буюу ийнхүү үүргээ биелүүлээгүй бол өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитойгоор гаргуулан авснаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ дуусгавар болно.

235.5.Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Үүрэг дуусгавар болох

236 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэснээр үүрэг гусгавар болох

236.1.Үүрэг дараахь үндэслэлээр усгавар болно:

236.1.1.үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор йцэтгэсэн;

236.1.2.үүрэг гүйцэтгүүлэгч нь йцэтгэвэл зохих үүргийн гүйцэтгэлийн оронд өөр ргийн гүйцэтгэлийг хүлээн авсан;

236.1.3.талууд өмнөх үүргийг солихоор хиролцсон.

236.2.Энэ хуулийн 236.1.3-т заасан хиолдолд өмнөх үүргийн харилцаа дуусгавар лно.

236.3.Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн йцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн сныг гэрчлэх баримт бичгийг үүрэг гүйцэтгэгчийн ардлагаар олгох үүрэгтэй.

236.4.Өрийг хүлээн авсан тухай баримт чигт хүүгийн тухай заагаагүй бол хүүг төлсөн гэж эж менгэн төлбөрийн үүрэг бүхэлдээ дуусгавар лно.

236.5.Өрийг тодорхой хэсгээр, үе ittайгаар төлж байсан бол хамгийн сүүлийн гийг хүлээн авсан тухай баримт бичигт өөрөөр агаагүй бол өмнөх хэсгүүдийг бүрэн төлсөн гэж нэ.

236.6.Үүрэг гүйцэтгүүлэгч, эсхүл эрх бүхий гээдийн үйлдсэн үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тухай баримт бичигт өрийн төрөл, хэмжээ, үүрэг гүйцэтгэгчийн буюу өр төлсөн этгээдийн овог, эцгийн нэр, үүрэг гүйцэтгэсэн газар, хугацаа зэргийг заана.

236.7.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг нотлох бичиг өгсөн бол үүрэг гүйцэтгэсэн тухай баримт бичгийн хамт нотлох бичгийг буцаах буюу түүнийг хүчингүй болгуулахаар шаардах эрхтэй.

236.8.Үүрэг гүйцэтгүүлэгч нотлох бичгийг буцааж өгч чадахгүй бол үүрэг дуусгавар болсон тухай баримт хийж өгөхийг үүрэг гүйцэтгэгч шаардах эрхтэй.

236.9.Талууд өөрөөр тохиролцоогүй бол үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тухай баримт бичиг олгохтой холбогдсон зардлыг үүрэг гүйцэтгэгч, харин үүрэг гүйцэтгүүлэгч оршин суугаа /оршин байгаа/ газраа өөрчилсөн, эсхүл нас барсан бөгөөд өвлөгч нь өөр газар оршин суудаг /оршин байдаг/ бол үүрэг гүйцэтгүүлэгч буюу түүний өвлөгч тус тус хариуцна.

236.10.Дараахь үйлдэл хийхээс үүрэг гүйцэтгүүлэгч татгалзсан тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээлгэн өгөхөөс татгалзах эрхтэй:

236.10.1.үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тухай баримт бичиг олгох;

236.10.2.энэ хуулийн 236.7-д заасан нотлох бичгийг буцааж өгөх буюу түүнийг хүчингүй болгох;

236.10.3.үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тухай баримт бичигт нотлох бичгийг бүцааж өгөх боломжгүй болсон тухай тэмдэглэл хийх буюу үүрэг дуусгавар болсон баримт хийж өгөх.

236.11.Энэ хуулийн 236.10-т заасан тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ.

237 дугаар зүйл. Хадгалалтад шилжүүлснээр үүрэг дуусгавар болох

237.1.Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хугацааг хэтрүүлсэн, эсхүл түүний оршин суугаа /оршин байгаа/ газар нь тодорхой бус бол үүрэг гүйцэтгэгч нь үүргийн зүйлийг зүй үүргийг гүйцэтгэвэл зохих газрын нотариатад, мөнгө буюу үнэт цаасыг нотариатаар дамжуулан банкинд хадгалуулахаар шилжүүлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэнд тооцогдож, үүргээс чөлөөлөгдөнө.

237.2.Үүрэг гүйцэтгэгчийн шилжүүлсэн үүргийн зүйлийг нотариат үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй. Иймхүү шилжүүлэх хүртэл уг зүйлийг хадгалах этгээдийг өөрийн үзэмжээр сонгож хадгалуулах бөгөөд баримт бичгийг өөртөө хадгална.

237.3.Үүргийн зүйл нь хадгалалтын шаардлага хангасан байвал зохих бөгөөд тургэн мудах, чанар нь алдагдах зүйлийг хадгалалтад хүлээж авахгүй.

237.4.Нотариат үүргийн гүйцэтгэлийг хадгалалтад хүлээн авсан тухай үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэж, үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахыг түүнээс шаардана.

237.5.Үүргийн зүйлийг хадгалахтай холбогдсон зардлыг үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.

237.6.Үүрэг гүйцэтгэгч нотариатад хадгалуулахаар шилжүүлсэн зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэхээс өмнө бүцаан авахаар хэдийд ч шаардах эрхтэй. Бүцаан авсан тохиолдолд үүргийн зүйлийг хадгалалтад шилжүүлээгүй гэж үзнэ.

237.7.Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн зүйлийг хүлээн авахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 237.9-д заасан хугацаа өнгөрсөн бол үүрэг гүйцэтгэгч хадгалалтад шилжүүлсэн зүйлээ буцаан авч болно.

237.8.Энэ хуулийн 237.6, 237.7-д зааснаар хадгалалтад шилжүүлсэн зүйлээ буцааж авсан үүрэг гүйцэтгэгч хадгалахтай холбогдсон бүх зардлыг хариуцна.

237.9.Нотариат, өөртөө хадгалуулахаар шилжүүлсэн зүйлийг гурав хүртэл жил хадгалах бөгөөд энэ хугацаанд үүрэг гүйцэтгүүлэгч уг зүйлийг хүлээн авааг бол энэ тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэж хадгалуулсан зүйлээ буцааж авахыг түүнээс шаардана. Хэрэв тогтоосон хугацаанд уг зүйлийг буцааж авааг бол түүнийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

238 дугаар зүйл. Харилцан шаардлагын бүхий үүргийг тооцож дуусгавар болгох

238.1.Биелүүлэх хугацаа нь болсон, хоёр этгээдийн хооронд ижил төрлийн харилцан шаардлагын хооронд нь тооцож үүргийг дуусгавар болгож болно.

238.2.Аль нэг талын шаардлагыг биелүүлэх хугацаа болоогүй байхад шаардах эрх бүхий тал зөвшөөрсөн бол харилцан шаардлагыг тооцож үүргийг дуусгавар болгож болно.

238.3.Хөөн хэлэлцэх хугацаа дууссан шаардлагүдыг хооронд нь тооцож үүргийг дуусгавар болгож болно.

238.4.Хооронд нь тооцож дуусгавар болгох шаардлагуудын хэмжээ харилцан адилгүй байвал бага хэмжээний шаардлагыг бүрэн хэмжээгээр тооцох бөгөөд их хэмжээний шаардлагын нөгөө шаардлагаар нөхөгдөөгүй хэсэг хүчин төгөлдөр хэвээр байна.

238.5.Үүргийг тооцуулах тухай саналыг хүлээн авсан тал хэд хэдэн шаардлагыг биелүүлэх ёстой байвал энэ хуулийн 216.1-216.3-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

238.6.Нэг тал нь нөгөө талдаа үндсэн үүргийн зэрэгцээ хүү болон бусад зардал төлөх үүрэг хүлээсэн бол энэ хуулийн 216.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

238.7.Өөр өөр газар гүйцэтгэвэл зохих үүргийг талууд тохиролцон тооцож үүргийг дуусгавар болгож болно.

238.8.Дараахь тохиолдолд үүргийг харилцан тооцож дуусгавар болгож болохгүй:

238.8.1.талууд үүргийг харилцан тооцохгүй гэж урьдчилан тохиролцсон;

238.8.2.үүргийн зүйлийг төлбөрт авах болохгүй, эсхүл амьжиргааны эх үүсвэр болсон зүйл байсан;

238.8.3.хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон гэм хорыг арилгах үүрэг үүссэн;

238.8.4.хуульд заасан бусад тохиолдол.

239 дүгээр зүйл. Өрийг хүчингүй олгосноор үүрэг дуусгавар болох

239.1.Талууд хэлэлцэн тохиролцсоны дсэн дээр өрийг хүчингүй болговол энэхүү үүрэг усгавар болно.

239.2.Үүрэг гүйцэтгүүлэгч бусад үүрэг йцэтгэгчийн хувьд шаардах эрхээ хэвээр дгалснаас бусад тохиолдолд хамтран үүрэг йцэтгэгчидийн хэн нэг нь бүх өрийг дуусгавар олгосон бол бусад үүрэг гүйцэтгэгчийг үүргээс леөлнө.

239.3.Үүрэг гүйцэтгүүлэгч өрөөс леөлөгдсөн үүрэг гүйцэтгэгчид оногдох хэсгийг саад үлдсэн хэсгийн хувьд бусад үүрэг йцэтгэгчдэд тавих шаардлагаа нэгттэн гаргаж лно.

239.4.Үндсэн үүрэг гүйцэтгэгчийн өрийг чингүй болгосноор батлан даагч буюу баталгаа эгагч үүргээс чөлөөлөгдөнө.

239.5.Батлан даагч буюу баталгаа эгагчийг үүргээс чөлөөлсөн явдал нь үндсэн үүрэг йцэтгэгчийг үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

239.6.Хамтран батлан даагчийн аль нэгийг төлөхөөс чөлөөлснөөр бусад батлан даагчид эргээс чөлөөлөгдөнө.

239.7.Хоёр талын гэрээнд аль нэг тал нь шаардлагаасаа татгалзсанаар үүргийн харилцаа дуусгавар болохгүй. Энэ тохиолдолд шаардлагаасаа татгалзсан тал нь нөгөө тал шаардлагаасаа татгалзах хүртэл гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.

240 дүгээр зүйл. Үүрэг дуусгавар болох бусад үндэслэл

240.1.Үүрэг дараахь үндэслэлээр дуусгавар болно:

240.1.1.үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгч хоёр нэг этгээд болсон;

240.1.2.үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчийн хувийн байдалтай салшгүй холбоотой тохиолдолд үүрэг гүйцэтгэгч иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон, түүнчлэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан;

240.1.3.үүргийн гүйцэтгэл нь гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгчид хамааралтай тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон, түүнчлэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан;

240.1.4.хуулийн этгээд эрх залгамжлалгүйгээр татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан;

240.1.5.хууль буюу гэрээнд заасан бусад үндэслэл.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Үүрэгт олон этгээд оролцох

241 дүгээр зүйл. Хамтран үүрэг йцэтгүүлэгчид

241.1.Хэд хэдэн этгээд үүргийн йцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн үүрэг йцэтгэгчээс шаардах эрхтэй бөгөөд үүрэг йцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу эгчлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй бол тэдгээрийг эн эрх бүхий хамтран үүрэг гүйцэтгүүлэгчид гэнэ.

241.2.Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчийн эн эрх хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр, гүл үүргийн зүйлийн үл хуваагдах шинж чанартай эбогдож үүснэ.

241.3.Үүрэг гүйцэтгүүлэгчийн хэн нэг нь хуулийн 241.1-т заасан шаардлага гаргаагүй үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг өөрийн мжээр үүрэг гүйцэтгүүлэгчийн аль нэгд лжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд бусад эг гүйцэтгүүлэгчидийн өмнө хүлээх үүргээс чөлөөлөгдөнө.

241.4.Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчдийн хэн нэг нь шаардлагаасаа татгалзвал үүрэг гүйцэтгэгч тухайн үүрэг гүйцэтгүүлэгчид оногдох хэсгээр үүргээс чөлөөлөгдөнө.

241.5.Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчдийн хэн нэг нь хэд хэдэн өвлөгчтэй бол өвлөгч бүр өр шаардах эрхийн өөрт ногдох хэсгийг өвлөх эрхтэй.

241.6.Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчдийн хэн нэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь хүлээн авсан бол бусад үүрэг гүйцэтгүүлэгчид ногдох хэсгийг хүлээлгэн өгөх үүрэгтэй.

241.7.Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчид өөрөөр тохиролцоогүй бол тэдгээрийн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх тэнцүү байна.

242 дугаар зүйл. Хамтран үүрэг гүйцэтгэгчид

242.1.Үүрэг гүйцэтгэгчдийн хэн хэн нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээлгэн өгөх, үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн үүрэг гүйцэтгэгч тус бүрээс шаардах эрх бүхий байвал хамтран үүрэг гүйцэтгэгчид гэнэ.

242.2.Хамтран хүлээх үүрэг нь хууль буюу гэрээнд зааснаар, эсхүл үүргийн зүйлийн үл хуваагдах шинж чанартай холбоотой үүснэ.

242.3.Үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үзэмжээр аль ч үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардаж болох бөгөөд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хүлээсэн үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна.

242.4.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нь ч гэрээгээр тогтоосон буюу түүнд эрх олгосон, эсхүл хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хувьд нийтлэг аливаа харилцаанаас үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах эрхтэй.

242.5.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бүхэлд нь хүлээлгэн өгсөн бол бусад үүрэг гүйцэтгэгчид үүргээс чөлөөлөгдөнө.

242.6.Үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгч нэг этгээдэд шаардлага гаргаснаар бусад үүрэг гүйцэтгэгчдэд шаардлага гаргах эрхээ алдахгүй.

242.7.Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгч нэг этгээдээс үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хугацаа саатуулсан тохиолдолд үүсэх үр дагавар нь бусад үүрэг гүйцэтгэгчдэд нэгэн адил хамаарна.

242.8.Үүрэг гүйцэтгэгч нэг этгээд үүрэг гүйцэтгэх хугацаа зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагавар нь бусад үүрэг гүйцэтгэгчдэд хамаарахгүй.

242.9.Хамтран үүрэг гүйцэтгэгч нэг этгээд хэд хэдэн өвлөгчтэй бол тэдгээр нь тус бүрдээ өлгаамжлалаар өөрт ногдох өвтэй хувь тэнцүү хэмжээгээр үүрэг хүлээх боловч шаардлага нь үл хуваагдах шинжтэй бол энэ журам хамаарахгүй.

242.10.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэнгий ер нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагатай нэгдсэн бол уг үүрэг гүйцэтгэгчийн өрийн хэмжээгээр бусад үүрэг гүйцэтгэгчийн үүрэг дуусгавар болно.

242.11.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл үүрэг гүйцэтгэгч тус бүрийн хүлээх үүргийг тодорхойлох боломжгүй бол тэдгээрийн үүрэг тэнцүү байна.

242.12.Хамтран хүлээх үүргийг гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэгч нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг тус бүрд нь ногдох хэсгээр шаардах эрхтэй.

242.13.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэнгий нь төлбөрийн чадваргүй бол үүргийн түүнд ногдох хэсгийг төлбөрийн чадвартай бусад үүрэг гүйцэтгэгчид тэнцүүү хуваарилна.

242.14.Хамтран үүрэг гүйцэтгэгч нь этгээдийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа дууссан буюу түр зогссон нь бусад үүрэг гүйцэтгэгчдэд хамаарахгүй.

III ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ

I ДЭД ХЭСЭГ

БУСДЫН ӨМЧЛӨЛД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Худалдах-худалдан авах болон арилжаа

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

243 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээ

243.1.Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой бараг бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг

с хүлээнэ.

243.2.Худалдагч нь худалдаж байгаа эд рөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, дгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, талгаат болон эдэлгээний хугацаа, лдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн дээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

244 дүгээр зүйл. Худалдах-худалдан авах ээний үнэ

244.1.Худалдах-худалдан авах гэрээнд ийг шууд заагаагүй бол талууд үнэ тодорхойлох а хэрэгслийн тухай хэлэлцэн тохиролцож болно.

245 дугаар зүйл. Хөрөнгө шилжүүлэхтэй лбогдсон зардлыг хуваарилах

245.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол эд рөнгө шилжүүлэхтэй холбогдсон /жигнэх, савлах, глах гэх мэт/ зардлыг худалдагч, барааг далдагчийн байгаа газраас өөр газар хүргэх, зөөх, вэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг далдан авагч хариуцна.

245.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол үл лөх эд хөрөнгө худалдах-худалдан авахад гэрээ лон шаардагдах баримт бичиг бүрдүүлэх, баримт гийг нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлийн ар бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг худалдан гч хариуцна.

246 дугаар зүйл. Эд хөрөнгө илгээх талаар далдагчийн хүлээх үүрэг

246.1.Гэрээ ёсоор худалдагч эд хөрөнгийг вэрлэгчид шилжүүлсэн бөгөөд тухайн эд өнгөд ямар нэгэн таних тэмдэг буюу бусад эгслээр тэмдэглэл хийгээгүй бол түүнийг эсэн тухай худалдан авагчид мэдэгдэж, ачааны гэрэнгүй жагсаалтыг илгээх үүрэгтэй.

246.2.Хэрэв худалдагч эд хөрөнгийг илгээх эг хүлээсэн бол эд хөрөнгийг тохирсон газар гэхэд шаардагдах гэрээг тухайн төрлийн вэрлэлтийн ердийн нөхцөлөөр хийх үүрэгтэй.

246.3.Тээвэрлэлтийн явцад эд хөрөнгийг тгуулах үүрэг худалдагч хүлээгээгүй бол алдан авагчийн хүсэлтээр даатгалын гэрээ гуулахад шаардагдах, өөрт байгаа бүхий л ээллийг түүнд өгөх үүрэг хүлээнэ.

247 дугаар зүйл. Үр шим болон эрсдэл алдан авагчид шилжих

247.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол алдсан эд хөрөнгийг худалдан авагчид жүүлснээр тухайн эд хөрөнгийг ашигласны үр дүнд олсон үр шим болон уг эд хөрөнгө тохиолдлоор устаж, гэмтсэний эрсдэл худалдан авагчид шилжинэ.

247.2.Худалдагч худалдсан эд хөрөнгийг худалдан авагчийн хүсэлтээр гэрээнд зааснаас өөр газар хүргүүлэхээр илгээсэн бол тухайн эд хөрөнгийг тээвэрлэгчид, эсхүл эрх бүхий этгээдэд шилжүүлсэн үеэс худалдан авагчид үр шим, эрсдэл нь шилжинэ.

248 дугаар зүйл. Эд хөрөнгийг хүлээн авсанд тооцох

248.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө хүлээн авах нөхцөлийг гэрээгээр тодорхойлно.

248.2.Худалдан авагч эд хөрөнгийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг эд хөрөнгө хүлээн авсанд тооцно.

249 дүгээр зүйл. Гэрээний талууд үүргээсээ татгалзах

249.1.Гэрээ байгуулснаас хойш гэрээний аль нэг тал хүлээсэн үүргийнхээ дийлэнх хэсгийг биелүүлж чадахгүй бодит нөхцөл бий болсон бол нөгөө тал хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзаж болно.

249.2.Хэрэв нэг талын хүлээсэн үүргийн гүйцэтгэл нь хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар урьдчилан хангагдсан бол нөгөө тал үүргээсээ татгалзаж болохгүй.

249.3.Худалдсан эд хөрөнгийг хэсэг хэсгээр нийлүүлэх тохиолдолд нэг тал нь эд хөрөнгийг нийлүүлэх нэг удаагийн үүргээ биелүүлээгүйгээс дараагийн нийлүүлэлт биелэгдэхгүй байх бодит нөхцөл бий болсон бол нөгөө тал нь энэ хуулийн 204.2, 219.2-т заасан хугацаа өнгөрсний дараа гэрээний үүргээсээ татгалзаж болно.

250 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг эзэмшилдээ авах давуу эрх

250.1.Худалдагч нэг эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан бол уг эд хөрөнгийг хамгийн түрүүнд эзэмшилдээ авсан худалдан авагч, хэрэв эд хөрөнгө хэний ч эзэмшилд шилжээгүй байвал түрүүлж гэрээ хийсэн этгээд эзэмшилдээ шилжүүлэн авах давуу эрхтэй.

251 дүгээр зүйл. Худалдсан эд хөрөнгийн биет байдлын доголдол

251.1.Гэрээгээр тогтоосон тоо, хэмжээ, чанар бүхий эд хөрөнгийг биет байдлын хувьд доголдолгүй гэж үзнэ.

251.2.Хэрэв гэрээнд эд хөрөнгийн чанарын талаар заагаагүй бол гэрээнд заасан зориулалтаар ашиглах боломжтой эд хөрөнгийг биет байдлын доголдолгүй гэж үзнэ.

251.3.Үүргийн гүйцэтгэлд ноцтой нөлөө үзүүлэхээргүй бол эд хөрөнгийн зарим хэсгийг дутуу буюу гэрээнд зааснаас өөр бараг бага хэмжээгээр шилжүүлсэн, эсхүл эд хөрөнгийн нэг хэсэг нь доголдолтой байсан ч түүнийг бүхэлд нь доголдолтой гэж үзэхгүй.

252 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийн эрхийн доголдол

252.1.Худалдсан эд хөрөнгийн хувьд гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар худалдагчид гомдлын шаардлага гаргахаргүй бол эрхийн доголдолгүй эд хөрөнгө гэнэ.

252.2.Хүчин төгөлдөр бус эрхийг хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн бол түүнийг эрхийн доголдолтой гэнэ.

253 дугаар зүйл. Эд хөрөнгийн доголдлын талаархи худалдагчийн эрх, үүрэг

253.1.Худалдсан эд хөрөнгө нь доголдолтой бол худалдагч үг доголдлыг арилгах, хэрэв эд хөрөнгө нь төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө байвал тухайн төрлийн ижил эд хөрөнгөөр буюу тухайн цаг үед худалдан авагчид шаардлагатай өөр эд хөрөнгөөр сольж өгөх үүрэгтэй.

253.2.Энэ хуулийн 253.1-д зааснаар доголдлыг арилгахтай холбогдсон /ачих, тээвэрлэх, гүйцэтгэсэн ажлын хөлс, зарцуулсан материалын үнэ гэх мэт/ зардлыг худалдагч хариуцна.

253.3.Худалдагч нь доголдолтой эд хөрөнгийн оронд өөр доголдолгүй эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн бол өмнө нь шилжүүлсэн доголдолтой эд хөрөнгөө худалдан авагчаас буцаан авахаар шаардах эрхтэй.

254 дүгээр зүйл. Эд хөрөнгийн доголдлын талаархи худалдан авагчийн эрх, үүрэг

254.1.Худалдан авагч нь эд хөрөнгийн доголдлыг арилгуулах буюу доголдолгүй тухайн төрлийн эд хөрөнгөөр солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг цуцлах тухай шаардлага гаргах эрхтэй.

254.2.Худалдан авагч нь баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаанд энэ хуулийн 254.1-д заасан шаардлагыг гаргаагүй бол гэрээр доголдлыг арилгахад шаардлагатай мөнгөний хэмжээгээр анхны үнийг бууруулахаар шаардаж болно. Энэ тохиолдолд үнэлгээг гэрээ байгуулах үеийн үнээр тодорхойлно.

254.3.Энэ хуулийн 251.3-т зааснаас бусад тохиолдолд худалдагч нь гэрээнд заасан тоо хэмжээнээс дутуу эд хөрөнгө илгээсэн бол худалдан авагч үг эд хөрөнгийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

254.4.Худалдан авагч энэ хуулийн 254.3-т заасан эд хөрөнгийг хүлээн авсан бол худалдагч нь гэрээний үнэд хувь тэнцүүлэн дутуу эд хөрөнгийн үнийг буцааж төлнө.

254.5.Худалдагчийн шилжүүлсэн эд хөрөнгө нь гэрээнд заасан тоо хэмжээнээс их байвал худалдан авагч үг эд хөрөнгийг хүлээн авч, үнийн гэрээний үнэд хувь тэнцүүлэн төлөх буюу гэрээнд заасан хэмжээнээс илүү хэсгийг худалдагчийн зардлаар буцаана.

254.6.Худалдагч эд хөрөнгийн баталгаа хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг ёмчлох эрхийг шилжүүлэн авснаас хойш зургаан сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй.

254.7.Эд хөрөнгийн баталгаат хугацаа худалдан авагчид эрсдэл шилжсэн үеэс эхлэн тоолох бөгөөд хэрэв баталгаат хугацааны дотор гэр доголдлыг илрүүлсэн бол худалдан авагчид эрсдэл шилжих үед үг доголдол байсан гэж үзнэ.

255 дугаар зүйл. Худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдах

255.1. Дараахь тохиолдолд худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдана: .

255.1.1.эд хөрөнгө хүлээж авах үедээ үг эд хөрөнгийн доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээж авсан;

255.1.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь үг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэр даруй шалган авах үүргээ биелүүлээгүй;

255.1.3.тухайн эд хөрөнгийн доголдол нь худалдан авагч түүнийг тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зөрчсөнөөс, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн.

255.2.Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үед түүний доголдлыг мэдсээр байж нуусан дарагдуулсан бол энэ хуулийн 255.1 хамаарахгүй.

256 дугаар зүйл. Эд хөрөнгийн доголдолтой олбогдуулан гэрээг цуцлах

256.1.Эд хөрөнгийн доголдолтой олбогдуулан худалдагч, худалдан авагчийн аль ь ч гэрээг цуцлах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд удалдагч нь худалдан авагчид учирсан хохирол, ардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

256.2.Хэд хэдэн эд хөрөнгийг худалдсан охиолдолд тэдгээрийн зарим хэсэг нь доголдолтой ол гэрээг зөвхөн доголдолтой хэсгээр, хэрэв оголдолтой хэсэг нь бусад хэсэгтэйгээ нэгдмэл эриулалттай ашиглагдах бол гэрээг бүхэлд нь уцалж болно.

256.3.Гол эд хөрөнгө доголдолтой бол үхэлд нь, дагалдах эд хөрөнгө нь доголдолтой бол ягцхүү тэр хэсгээр нь гэрээг цуцалж болно.

257 дугаар зүйл. Хариуцлагыг хязгаарласан хэлцэл хүчин төгөлдөр бус байх

257.1.Ямар нэгэн доголдолтой эд хөрөнгийг удалдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх, эхүл хүлээх хариуцлагыг хязгаарлахаар талууд охиролцон гэрээнд заасан болох боловч худалдагч ь эд хөрөнгийн доголдлыг зориуд нуун арагдуулсан бол уул тохиролцоо хүчин төгөлдөр ус байна.

258 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг удалдах үүрэг

258.1.Худалдан авагч худалдан авсан эд эрөнгөө хугацаанд нь хүлээж аваагүй бол удалдагч уг эд хөрөнгийг хадгалах үүрэгтэй.

258.2.Худалдан авагч эд хөрөнгийн үнийг олөх, зохих зардлыг нөхөн төлөх хүртэл худалдагч ь хөрөнгийг өөртөө үлдээж саатуулах эрхтэй.

258.3.Худалдан авагч эд хөрөнгийг хүлээн ысан боловч эрхийнхээ дагуу буцааж өгөх хүсэлтэй ол түүнийг хадгалж, бүрэн бүтэн байдлыг хангах үрэгтэй бөгөөд худалдагч зохих зардлыг төлөх үртэл худалдан авагч уг эд хөрөнгийг өөртөө идээх эрхтэй.

258.4.Харьцангуй өндөр зардал ргахааргүй бол эд хөрөнгийг хадгалах үүрэг бүхий тал нь негөө талынхаа зардлаар гуравдагч этгээдийн агуулахад эд хөрөнгийг хадгалж болно.

259 дүгээр зүйл. Хадгалж байгаа эд хөрөнгийг худалдах

259.1.Гэрээний нэг тал эд хөрөнгийг хүлээж авахгүй удаасан буюу хадгалахтай холбогдсон зардлыг төлөхгүй бол эд хөрөнгийг хадгалж байгаа тал нь зохих жүрмын дагуу түүнийг худалдах эрхтэй. Эд хөрөнгийг худалдах тухай негөө талдаа долоо хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

259.2.Энэ хуулийн 259.1-д заасанаар эд хөрөнгийг худалдсан үнээс түүнийг хадгалах, худалдахтай холбогдсон зардлыг суутган тооцож үлдсэн мөнгийг негөө талдаа шилжүүлнэ.

259.3.Энэ хуулийн 258 дугаар зүйлд заасан тохиолдолд хадгалах эд хөрөнгө нь түргэн муудах буюу үнэ нь буурах, эсхүл түүнийг хадгалахад харьцангуй өндөр зардал шаардагдахаар бол хадгалах үүрэг бүхий тал нь энэ зүйлд заасан журмын дагуу түүнийг худалдах үүрэгтэй.

260 дугаар зүйл. Эрх, шаардлага, бусад хөрөнгө худалдах-худалдан авах

260.1.Үүргийн агуулгад харшлахгүй бол эрх, шаардлага, бусад хөрөнгө худалдах-худалдан авахад эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн заалтууд нэгэн адил хамаарна.

260.2.Эрх худалдахад худалдагч нь уг эрх хүчин төгөлдөр болох тухай үндэслэл гаргах, эрх шилжүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.

260.3.Эд хөрөнгө эзэмших боломж олгож байгаа эрхийг худалдсан тохиолдолд худалдагч тухайн эд хөрөнгийг худалдан авагчид биет байдлын болон эрхийн доголдолгүй шилжүүлэх үүрэгтэй.

261 дүгээр зүйл. Гэрээний талууд үүргээ зөрчсөнөөс учирсан гэм хорыг арилгах

261.1.Худалдах-худалдан авах гэрээний нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс негөө талдаа учруулсан хохирлыг гэм хор арилгах нийтлэг жүрмыг баримтлан арилгана.

Хоёрдугаар дэд бүлэг

Зээлээр худалдах-худалдан авах

262 дугаар зүйл. Зээлээр худалдах-худалдан авах гэрээ

262.1.Зээлээр худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь худалдан авагч үнийг төлөхөөс өмнө эд хөрөнгийг шилжүүлэх, худалдан авагч нь үнийг гэрээнд заасны дагуу тодорхой цаг

хугацааны дараа хэсэгчлэн буюу бүрэн, эсхүл тодорхой цаг хугацааны туршид хэсэгчлэн төлөх үүргийг тус тус хүлээнэ.

263 дугаар зүйл. Зээлээр худалдах-худалдан авах гэрээний хэлбэр

263.1.Зээлээр худалдах-худалдан авах гэрээг бичгээр хийнэ.

263.2.Гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгана:

263.2.1.бэлэн мөнгөөр төлөх төлберийн хэмжээ;

263.2.2.хэсэгчлэн хийх төлберийн хэмжээ, хугацаа;

263.2.3. төлбөл зохих хүүгийн хэмжээ;

263.2.4.үнэ, эсхүл үнийг тодорхойлох журам.

263.3.Худалдагч гэрээ болон дагалдах баримт бичгийн хувийг худалдан авагчид шилжүүлэ үүргэтэй.

263.4.Энэ зүйлд заасан журмыг зөрчи гэрээ байгуулсан бол энэ хуулийн 196.1.1-д зааснаар гэрээг байгуулсан гэж үзэх бөгөөд эн тохиолдолд худалдан авагч хүү төлөхгүй, гаргуу эд хөрөнгийн үнийг төлнө. Төлберийг гэрээнд зааса хугацааны дотор гүйцэтгэнэ.

264 дүгээр зүйл. Худалдагч гэрээнээ татгалзах

264.1.Зээлээр худалдах-худалдан ава гэрээгээр хүлээсэн үүргээ худалдан авагч биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй бо худалдагч гэрээнээс татгалзах эрхтэй. Талуу гэрээгээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгө үүргэтэй.

264.2.Энэ хуулийн 264.1-д зааса тохиолдолд худалдагч нь учирсан хохирол, зардла худалдан авагчаас шаардах эрхтэй.

Гуравдугаар дэд бүлэг

Эд хөрөнгө буцаан худалдан авах болзолтой хийсэн худалдах-худалдан авах гэрээ

265 дугаар зүйл. Эд хөрөнгө буцаан худалдан авах худалдагчийн эрх

265.1.Худалдах-худалдан авах гэрээнд заасан бол худалдагч нь худалдсан эд хөрөнгөө худалдан авагчаас буцаан худалдан авах эрхтэй бөгөөд худалдагчийн энэ эрх нь түүний хүсэл зоригоос хамааран хэрэгжинэ.

266 дугаар зүйл. Гэрээний үнэ

266.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн эд хөрөнгийг анх худалдсан үнээр буцаан худалдаж авна.

266.2.Эд хөрөнгийг засан сайжруулсны үр дүнд өртөг нь нэмэгдсэн бол түүнийг буцаан худалдаж байгаа тал нь нэмэгдүүлсэн өртгийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр нийт зардлаа шаардах эрхтэй.

267 дугаар зүйл. Эд хөрөнгийг буцаан худалдаж байгаа талын нүүлээх үүрэг

267.1.Эд хөрөнгийг буцаан худалдаж байгаа тал нь түүнийг дагалдах зүйлийн хамт худалда авагчид шилжүүлэх үүрэгтэй.

267.2.Энэ хуулийн 265 дугаар зүйлд зааса эрхээ худалдагч хэрэгжүүлэхээс өмнө эд хөрөнги буцаан худалдаж байгаа тал нь түүнийг гэмтээсэ үрэгдүүлсэн, өөр эд хөрөнгөөр орлуулса тохиолдолд түүнээс болж учирсан гэм хорыг өөр хариуцан арилгах үүрэгтэй.

267.3.Энэ хуулийн 265 дугаар зүйлд зааса эрхээ худалдагч хэрэгжүүлэхээс өмнө эд хөрөнги буцаан худалдаж байгаа тал нь түүнийг гуравда этгээдийн өмчлөлд шилжүүлж болохгүй. Э журмыг зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр б байна.

268 дугаар зүйл. Буцаан худалдан авах э хэрэгжүүлэх хугацаа

268.1.Эд хөрөнгийг буцаан худалдан ав эрх хэрэгжүүлэх хугацаа талууд тохиролц тогтоох боловч энэ хугацаа нь таван жилэ хэтрэхгүй.

Дөрөвдүгээр дэд бүлэг

Ирээдүйд эд хөрөнгө худалдах-худалдан авах /опцион/

269 дүгээр зүйл. Ирээдүйд эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээ

269.1.Тодорхой цаг хугацаа, эсхүл тодорхой
йл явдал болохоос өмнө ямар нэгэн зүйлийг
далдах, эсхүл худалдан авахаар гэрээний талууд
охиролцох буюу худалдан авагч талын
анаачилгаар тодорхой эд хөрөнгийг олж авах
эрхтэй байхаар гэрээ байгуулж болно.

269.2.Энэ хуулийн 269.1-д заасан гэрээнд худалдах-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

Тавдугаар дэд бүлэг

Худалдан авах давуу эрх

270 дугаар зүйл. Худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх

270.1.Худалдагч нь тухайн эд хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах тохиолдолд уг эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

270.2.Худалдагч тухайн эд хөрөнгийг худалдан авах давуу эрх бүхий этгээдэд эрхээ хэрэгжүүлэх хугацаа тогтоох бөгөөд энэ хугацаанд давуу эрх бүхий этгээд эрхээ хэрэгжүүлээгүй бол худалдагч гуравдагч этгээдэд худалдах-худалдан авах гэрээ байгуулж болно.

270.3.Худалдагч энэ хуулийн 270.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол худалдан авах давуу эрх бүхий этгээд нь худалдагчаас гуравдагч этгээдэд анал болгосон нөхцөлөөр худалдах-худалдан авах гээ байгуулахаар шаардах эрхтэй.

271 дүгээр зүйл. Худалдагчийн гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх

271.1.Худалдан авах давуу эрхийг үүргэжүүлэхгүй буюу уг эрхийг хэрэгжүүлэх хүчилд давуу эрх бүхий этгээдтэй хийсэн гэрээнээс татгалзахаар худалдагчийн гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

272 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн хүлээх нэмэгдэл үүрэг

272.1.Гуравдагч этгээд нь худалдагчтай байгуулсан гэрээ ёсоор нэмэгдэл ямар нэгэн үйлчилгээ үзүүлэх буюу үүрэг хүлээсэн бол худалдан авах давуу эрх бүхий этгээд уг үйлчилгээ буюу нэмэгдэл үүргийн үнийг төлнө.

272.2.Хэрэв нэмэгдэл үйлчилгээ буюу үүрэг нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжгүй бол худалдан авах давуу эрх хэрэгжихгүй.

272.3.Худалдан авах давуу эрхийг эдлүүлэхгүй байх зорилгоор гуравдагч этгээд нэмэгдэл үүрэг хүлээхээр худалдагчтай хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

273 дугаар зүйл. Худалдан авах давуу эрх үл шилжих

273.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдан авах давуу эрхийг бусдад шилжүүлж болохгүй.

Зургадугаар дэд бүлэг

Арилжаа

274 дүгээр зүйл. Арилжааны гэрээ

274.1.Арилжааны гэрээгээр талууд
дорхой хөрөнгийг харилцан өмчлөлд шилжүүлэх
ээ хүлээнэ.

274.2.Арилжааны гэрээгээр талууд нь
илжиж байгаа хөрөнгийн хувьд худалдагч,
илжин авч байгаа хөрөнгийн хувьд худалдан
агч болно.

274.3.Арилжааны гэрээнд худалдан-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

274.4.Төрийн өмчлөлийн мөнгө, үнэт цаасаар арилжаа хийх журмыг хуулиар тогтооно.

275 дугаар зүйл. Арилжих хөрөнгийн үнийн зөрүүг тооцох

275.1.Арилжааны гэрээгээр харилцан солилцож байгаа хөрөнгийн үнэ нь тэнцүү биш бол үнийн зөрүүг мөнгөөр тооцож болно.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бэлэглэл

276 дугаар зүйл. Бэлэглэлийн гэрээ

276.1.Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ.

276.2.Эд хөрөнгө шилжүүлснээр бэлэглэлийн гэрээг байгуулсанд тооцно.

276.3.Хуулиар тогтоосон хэлбэрээр гэрээ хийснээр өмчлөх эрх үүсдэг хөрөнгийн хувьд бэлэглэлийн гэрээг тухайн хэлбэрээр хийнэ.

276.4.Тодорхой хөрөнгө бэлэглэхээр амласан амлалтыг нотариатаар гэрчлүүлсэн бол үүрэг үүснэ.

276.5.Тодорхой хөрөнгийг тусгай зориулалтаар хандивын журмаар бэлэглэж болно.

276.6.Хандив хүлээн авагч нь хандивын хөрөнгийг зориулалтын дагуу ээлэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд энэ үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол бэлэглэгч хандивласан хөрөнгийг зориулалтын дагуу ээлэмшиж, ашиглаж, захиран зарцуулахыг шаардах эрхтэй.

277 дугаар зүйл. Бэлэглэгчийн эрхийг хязгаарлах

277.1.Бэлэглэгч нь өөрийн асрамжид байгаа этгээдэд амьжиргааны нэн тэргүүний хэрэгцээт хөрөнгийг бусдад бэлэглэх эрхгүй.

278 дугаар зүйл. Бэлэглэгчийн хүлээх хариуцлага

278.1.Бэлэглэгч нь бэлэглэсэн хөрөнгийн доголдлыг санаатай нуун дарагдуулсны улмаас бэлэг хүлээн авагчид учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

279 дүгээр зүйл. Тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээ

279.1.Ямар нэгэн болзол хангасан, эсхүл тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр болохоор талууд тохиролцо болно.

279.2.Энэ хуулийн 279.1-д заасан болзо буюу зорилго нь бүсдын, эсхүл нийтийн ашиг тусы тулд зориулагдаж болно. Энэ тохиолдолд уг болзол зорилгыг гүйцэтгэхийг бэлэглэгч болон сонирхог этгээд шаардах эрхтэй.

279.3.Бэлэг хүлээн авах эрх бүхий этгээ гэрээнд заасан болзол буюу зорилгыг биелүүлээгү бол бэлэглэгч гэрээнээс татгалзаж болно.

279.4. Тусгай зориулалттай хийсэ бэлэглэлийн гэрээг бичгээр хийнэ.

280 дугаар зүйл. Бэлэглэлийн гэрэ хүчингүй болгох

280.1.Бэлэглэгч, түүний өвлөгч дараах тохиолдолд бэлэглэлийг хүчингүй болгохоор бэл хүлээн авагчаас шаардах эрхтэй:

280.1.1.бэлэг хүлээн авагч н бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн;

280.1.2.бэлэг хүлээн авагч н бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрү мэнд, амь насыг санаатай хохироосон бую хохироохыг завдсан.

280.2.Бэлэглэлийн гэрээ хүчингүй болсо бол бэлэглэлийн зүйлийг бэлэглэгчид, эсхүл түүн өвлөгчид буцаан олгоно.

280.3.Бэлэглэлийг хүчингүй болгох шаард эрх үүссэнээс хойш 1 жил өнгөрсөн бол бэлэглэли хүчингүй болгож болохгүй.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Зээл

281 дүгээр зүйл. Зээлийн гэрээ

281.1.Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.

282 дугаар зүйл. Зээлийн гэрээний хүү

282.1.Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.

282.2.Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эр хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойг тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээли хүүг багасгаж болно.

282.3.Хүү тогтоосон бол зээлийн гэрэ бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол х авах эрхээ алдана.

282.4.Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгч шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулса тооцно.

283 дугаар зүйл. Зээлийн гэрээний хугац

283.1.Зээлийн гэрээгээр зээлийг буцааж элэх хугацаа тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн аардсанаар түүнийг буцааж төлөх бөгөөд ийнхүү аардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч үүргээ иелүүлнэ.

283.2.Зээлийн гэрээгээр хүү тогтоогоогүй ол зээлдэгч хугацаанаас нь өмнө зээлийг буцаан ч болно.

283.3.Зээлийн гэрээгээр хүү тогтоосон бол агцхүү талууд урьдчилан тохирсон буюу ээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд зээлийг үгийн хамт хугацаанаас өмнө буцаан өгч болно.

283.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлийн үг жил тутам төлнө.

284 дүгээр зүйл. Зээлийг нэн даруй буцаан аардах

284.1.Зээлдэгчийн эд хөрөнгийн байдал ойтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох өхцөл байдал бий болсон бол зээлдүүлэгч зээлийг н даруй буцаан шаардах эрхтэй.

284.2.Энэ хуулийн 284.1-д заасан нөхцөл йдал зээлийн гэрээ байгуулахаас өмнө бий болсон гөөд зээлдэгч энэ тухай гэрээ байгуулснь дараа одсон бол зээлийг нэн даруй буцаан шаардах эрх снэ.

285 дугаар зүйл. Зээл олгохоос татгалзах

285.1.Зээл авах гэж байгаа талын эд өнгийн байдал доройтсоны улмаас зээлийг цаан төлөх чадваргүй болох нөхцөл бий болохоор байвал зээл олгохоор амласан этгээд зээл олгохоос татгалзах эрхтэй.

286 дугаар зүйл. Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох

286.1.Барьцаалан зээлдэх газар нь зээлийн гэрээний үүргийг хангуулахаар зээлдэгчээс хөдлөх эд хөрөнгийг барьцаанд бариулахыг шаардах эрхтэй.

286.2.Барьцаалан зээлдэх газраас олгох зээлийн хүүг талууд тохиролцон тогтооно.

286.3.Зээлдэгч зээлсэн мөнгө болон түүний хүүг хугацаанд нь буцаан төлөөгүй тохиолдолд барьцаалан зээлдэх газар барьцаалагдсан хөрөнгийг худалдан борлуулах замаар үүргийг хангуулах тухай зээлдэгчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Иймхүү мэдэгдсэнээс хойш арав хоногийн дотор зээлдэгч үүргээ гүйцэтгээгүй бол барьцаалан зээлийг комиссийн буюу дуудлага худалдаагаар худалдаж, борлуулсан үнийн дүнгээс үүргийг хангуулж үлдсэн мөнгийг буцаан олгоно.

286.4.Барьцаалан зээлдэх газар нь гэрээний хугацаанд барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргэтэй, харин уг зүйлийг өмчлөх болон бусад хэлбэрээр захиран зарцуулах эрхгүй.

286.5.Барьцаалан зээлдэх газраас олгох зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

286.6.Барьцаалан зээлдэх газраас зээл олгоход энэ хуулийн 157.1.3, 157.2.1, 157.2.2, 157.3, 159.2, 159.5 дахь заалтууд нэгэн адил хамаарна.

II ДЭД ХЭСЭГ

БУСДЫН ӨӨСМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгө хөлслөх

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

287 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ

287.1.Эд хөрөнгө хөлслөх гэрээгээр слүүлэгч нь хөлслөгчийн өзэмшил, ашиглалтад дорхой эд хөрөнгийг түр хугацаагаар шилжүүлэх, слөгч нь эд хөрөнгө ашигласны хөлсийг төлөх гийг тус тус хүлээнэ.

288 дугаар зүйл. Хөлслүүлэгчийн эрх, үүрэг

288.1.Хөлслүүлэгч нь дараахь үүргээ хүлээнэ:

288.1.1.хөлслөх хугацааны турш гэрээнд заасны дагуу ашиглах боломжтой, ашиглалтын шаардлага хангасан, биет байдлын болон эрхийн доголдолгүй эд хөрөнгө хөлслөгчид шилжүүлэх ;

288.1.2.хууль буюу гэрээнд заасан бол хөлслөн авсан эд хөрөнгөтэй холбоотой зайлшгүй зардлыг хөлслөгчид нөхөн төлөх;

288.1.3.гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслүүлсэн эд хөрөнгөд засвар, үйлчилгээ хийх;

288.1.4.хууль буюу гэрээнд заасан бусад үүрэг.

288.2.Хөлслүүлэгч дараахь эрхтэй:

288.2.1.хөлслөн өгсөн эд хөрөнгөөс салгаж болох засан сайжруулалтыг салган авч үлдэх;

288.2.2.хөлслөгч энэ хуулийн 289.1.3, 289.1.4-т заасан үүрэгээ биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах;

288.2.3.хөлслөгчид урьдчилан сануулсаар байхад хөлслөн авсан эд хөрөнгийг муутгасан, гэмтээсэн буюу муутгах, гэмтээх бодит нөхцөл бий болгосон, эсхүл хөлслөгч гурван сарын турш хөлсөө төлөөгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах;

288.2.4.гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслөн авсан эд хөрөнгөд өөрийнх нь зөвшөөрөлгүй хийсэн салгаж үл болох засан сайжруулалтын үнийг хөлслөгчид төлөхөөс татгалзах;

288.2.5.хууль буюу гэрээнд заасан бусад эрх.

289 дүгээр зүйл. Хөлслөгчийн эрх, үүрэг

289.1.Хөлслөгч нь дараахь үүрэг хүлээнэ:

289.1.1.хөлслөн авсан эд хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл, зориулалтын дагуу ашиглах;

289.1.2.эд хөрөнгө ашигласны хөлсийг хугацаанд нь төлөх;

289.1.3.хөлслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгө болон түүний хийц, зохион байгуулалтыг өөрчлөх буюу засахгүй байх;

289.1.4.хөлслөн авсан эд хөрөнгийг ердийн болон гэрээгээр тохиролцсон элэгдлээс илүү муутгахгүй байх;

289.1.5.гэрээ дуусгавар болоход эд хөрөнгийг хөлслүүлэгчид бүрэн бүтэн буцааж өгөх;

289.1.6.хөлслөн авсан эд хөрөнгөд доголдол илэрсэн буюу гэнэтийн нөхцөл байдал бий болсноор эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зайлшгүй арга хэмжээ авах шаардлага гарсан бол энэ тухай хөлслүүлэгчид нэн даруй мэдэгдэх;

289.1.7.хууль буюу гэрээнд заасан бусад үүрэг.

289.2.Хөлслөгч нь дараахь эрхтэй:

289.2.1.хөлслөгчийн буруугүйгээр хөлслөн авсан эд хөрөнгө ашиглах боломжгүй болсон бол хөлс төлөхөөс татгалзах;

289.2.2.хөлслөн авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахтай холбогдсон зайлшгүй зардлыг хөлслүүлэгчээс шаардах;

289.2.3.хөлслөн авсан эд хөрөнгө нь бусдын амь бие, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц байдалд байвал энэ хуулийн 294.3-т заасан хугацаагаар харгалзахгүй гэрээг цуцлах;

289.2.4.гэрээний үлдсэн хугацаагаар эд хөрөнгийг хөлслөн авах хүсэлтэй төлберийн чадвартай хөлслүүлэгчийг санал болгон гэрээгээгүй цуцлах тухай хөлслүүлэгчид нэг сарын өмнө мэдэгдсэн бол хугацаанаас нь өмнө гэрээгээ цуцлах;

289.2.5.талууд өөрөөр тохиролцоогүй бол, хөлсөлж авсан эд хөрөнгийг хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр, өөрийн зардлаар засаж сайжруулахад гарсан зайлшгүй зардлыг гэрээ дуусгавар болсны дараа төлүүлэхээр хөлслүүлэгчээс шаардах;

289.2.6.хөлслөн авсан эд хөрөнгө салгаж болох засан сайжруулалт хийсэн бол гэрээ дуусгавар болоход түүнийгээ салгаж авах;

289.2.7.хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулан хөлслөх;

289.2.8.хууль буюу гэрээнд заасан бусад эрх.

289.3.Энэ хуулийн 289.2.7-д заасан тохиолдолд хөлслүүлэгч нь зөвшөөрөл олгохоос үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй.

289.4.Бий болох аюулыг гэрээ байгуулахдаа мэдэж, эсхүл мэдэх боломжтой байсан бол хөлслөгч гэрээг цуцлах эрхгүй.

289.5.Гэрээ байгуулах үед буюу хожим нь эд хөрөнгийн доголдол илэрсэн бөгөөд энэ доголдлыг арилгах үүргээ хөлслүүлэгч биелүүлэхгүй саатуулж байвал хөлслөгч хөлсний хэмжээг бууруулах, учирсан хохирлоо нөхө

өлүүлэхээр шаардах эрхтэй.

289.6.Энэ хуулийн 289.2.7-д зааснаар эд өрөнгийг дамжуулан хөлслөх гэрээний хугацаа ндсэн гэрээний хугацаанаас хэтэрч болохгүй.

289.7.Эд хөрөнгө хөлслөх гэрээний үүргийг охих ёсоор гүйцэтгэдэг хөлслөгч, гэрээний хугацаа уусахад уг эд хөрөнгийг хөлслөн авах шинэ гэрээг эргүүн эзлэхийг байгуулах давуу эрхтэй бөгөөд өлслүүлэгч үүнийг зөрчиж өөр этгээдтэй эд өрөнгө хөлслөх гэрээ шинээр байгуулсан байвал иинэ хөлслөгчийн эрх, үүргийг өөртөө шилжүүлэн ахыг шаардах эрхтэй.

290 дүгээр зүйл. Эд хөрөнгийн доголдол

290.1.Гэрээгээр тогтоосон тоо, хэмжээ, анар бүхий эд хөрөнгийг биет байдлын доголдолгүй нэ.

290.2.Гэрээнд эд хөрөнгийн шинж чанарын алаар заагаагүй бол гэрээнд заасан зориулалтаар шиглах боломжтой эд хөрөнгийг биет байдлын оголдолгүй гэж үзнэ.

290.3.Хөлслөгчийн хөлслөн авсан эд өрөнгийн талаар гуравдагч этгээд ямар нэгэн аардлага гаргах эрхгүй байвал түхайн эд хөрөнгийг охийн доголдолгүй гэнэ.

290.4.Хөлслөн өгсөн эд хөрөнгө нь гуравдагч гээдийн эрхээр хязгаарлагдсан байвал үр ангаврыг хөлслүүлэгч хариуцна.

290.5.Хөлслөн өгсөн эд хөрөнгийн оголдлоос болж эд хөрөнгийн ашиглалт буурсан эмжээгээр хөлслүүлэгчид төлөх хөлсийг уурулна.

290.6.Эд хөрөнгийн доголдлыг хөлслүүлэгч илгасан буюу доголдол нь түхайн эд хөрөнгийн вийн ашиглалтад саад болохооргүй, ялимгүй инжтэй бол энэ хуулийн 290.5-д заасан журам маарахгүй.

290.7.Хөлслүүлэгч эд хөрөнгийн доголдлыг илгах үүргээ биелүүлэхгүй байвал хөлслөгч уг оголдлыг арилгаж, холбогдох зардлыг лслүүлэгчээс шаардах эрхтэй.

290.8.Хөлслөгч гэрээ байгуулах үедээ эд өрөнгийн доголдлын талаар мэдэж байсан бол ульд зааснаас бусад тохиолдолд энэ талаар жим гомдол гаргах эрх түүнд үүсэхгүй.

291 дүгээр зүйл. Хөлслөгч хариуцлага пээхгүй байх үндэслэл

291.1.Хөлслөгч хөлслөн авсан эд хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл, зориулалтаар ашигласны үр дүнд тухайн эд хөрөнгө муудсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

292 дугаар зүйл. Хөлс төлөх журам

292.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслөгч нь гэрээний хугацаа дуусахад хөлсийг төлнө.

292.2.Хөлсийг тогтмол хугацаанд төлөхөөр тогтоосон бол уг хугацаанд төлнө.

292.3.Талууд тохиролцсон бол нэмэлт зардлын төлбөрийг нэгэн адил төлнө.

292.4.Хөлслөн авагч өөрийн буруугаар эд хөрөнгийг ашиглаж чадаагүй бол хөлс төлөхөөс чөлөөлөгдөхгүй.

292.5.Хөлслөгч хөлс төлөх шаардлагын эсрэг эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой, өөрийн шаардлагыг хангуулах буюу түүнийг тооцуулахаар шаардах эрхтэй бөгөөд энэхүү шаардах, тооцуулах эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл хүчин төгөлдөр бус байна.

293 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа

293.1.Эд хөрөнгө хөлслөх гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулж болно.

293.2.Эд хөрөнгө хөлслөх гэрээг арван жилээс дээш хугацаагаар байгуулсан бол арван жил өнгөрсний дараа энэ хуулийн 294.3-т заасан хугацааны дотор талуудын аль нь ч гэрээг цуцлах эрхтэй.

294 дүгээр зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ дуусгавар болох

294.1.Эд хөрөнгө хөлслөх гэрээ дараахь үндэслэлээр дуусгавар болно:

294.1.1.гэрээний хугацаа дууссан;

294.1.2.гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол гэрээ цуцлах тухай аль нэг тал нь мэдэгдэнээс хойш хууль буюу гэрээнд заасан хугацаа өнгөрсөн;

294.1.3.хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан;

294.2.Хүндэтгэн үзэх дараахь шалтгаанаар талууд гэрээг цуцалж болно:

294.2.1.нэг тал нь үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй гэм буруутай бол нөгөө талын санаачилгаар;

294.2.2.хөлслүүлсэн сууцны талбай хөлслүүлэгчид өөрт нь буюу түүний ойрын төрөл төрөгсдөд хэрэгцээтэй болсон;

294.2.3.хөлслүүлэгчийн санал болгосон зах хэзлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс хөлслөгч татгалзсан;

294.2.4.хуульд заасан бусад үндэслэл.

294.3.Гэрээнд өөрөөр заагаагүй, тодорхой нөхцөл байдлаас шалтгаалаагүй бол эд хөрөнгө хөлслөх гэрээг цуцлах хугацаа гурван сар байна. Энэ хугацааг гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдэл өгснөөс хойш тоолно.

294.4.Хэрэв эд хөрөнгө хөлслөх гэрээний зүйл нь тавилга бүхий сууцны зориулалттай байр бол хөлслүүлэгч гэрээг цуцлахдаа энэ хуулийн 294.3-т заасан хугацааг баримтлах үүрэгтэй.

294.5.Энэ хуулийн 294.4-т заасан журам зочид буудал, нийтийн байранд хамаарахгүй.

294.6.Орон сууц хөлслөх гэрээг цуцлах шаардлагаа хөлслүүлэгч бичгээр гаргана.

295 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ дуусгавар болсны үр дагавар

295.1.Эд хөрөнгө хөлслөх гэрээ дуусгавар болоход хөлслөгч эд хөрөнгийн ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцон тухайн эд хөрөнгийг хөлслүүлэгчид бүцаажөгнө.

295.2. Газар хөлслөгч нь өөрийн ямар нэг шаардлагыг хангуулах зорилгоор гэрээ дуусгавар болсны дараа газрыг саатуулан барьж болохгүй.

295.3.Хөлслөгч эд хөрөнгийг гуравдагч этгээдийн ашиглалтад шилжүүлсэн тохиолдолд хөлслүүлэгч үг гуравдагч этгээдтэй дамжуулан хөлслөх харилцаа тогтоогоогүй бол гэрээ дуусгавар болоход хөлслүүлэгч гуравдагч этгээдээс эд хөрөнгөө шаардаж болно.

295.4.Гэрээ дуусгавар болоход хөлслөгч эд хөрөнгийг бүцаажөгөх хугацааг хойшлуулсан бол хөлслүүлэгч өөрт учирсан хохирлоо хожимдуулсан хугацааны турш төлбөл зохих хөлсний хэмжээгээр шаардах эрхтэй.

296 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ үргэлжлэх буюу сунгах

296.1.Эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа дуусан болөвч хөлслөгч эд хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласаар байгаа хөлслүүлэгч татгалзаагүй бол гэрээг тодорхой бус хугацаагаар тухайн нөхцөлөөр сунгасанд тооцно.

296.2.Орон сууц хөлслөх гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол гэрээний хугацаа дуусахаас хоёр сарын өмнө хөлслөгч тодорхой буюу тодорхой бус хугацаагаар гэрээг сунгах тухай хүсэлтээ хөлслүүлэгчид бичгээр гаргаж болох бөгөөд энэ хуулийн 294.2-т заасан үндэслэл байхгүй бол хөлслүүлэгч гэрээг сунгаж болно.

297 дугаар зүйл. Эд хөрөнгө гуравдагч этгээдийн өмчлөлд шилжсэний үр дагавар

297.1.Эд хөрөнгө хөлслүүлэгч нь хөлслөгчийн ээмшилд байгаа эд хөрөнгөө гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлсэн бол хөлслүүлэгчийн бүх эрх, үүрэг нь гуравдагч этгээдийн буюу шинэ өмчлөгчид шилжинэ.

298 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээний талуудын шаардлагыг хангах хөөн хэлэлцэх хугацаа

298.1.Хөлслүүлэгч эд хөрөнгийг өөрчилсөн муутгаснаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр, хөлслөгч эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахтай холбогдон гаргасан зардлаа нөхөн төлүүлэхээр гэрээ дуусгавар болсноос хойш зургаан сарын дотор тус тус нэхэмжлэл гаргах эрхтэй.

298.2.Хөөн хэлэлцэх хугацааг энэ хуулийн 76 дугаар зүйлд заасан журмаар тооцно.

299 дүгээр зүйл. Хөлслөгч ээмшлээ хамгаалах эрх

299.1.Хөлслөгч нь хөлслөн авсан эд хөрөнгийн ээмшлийг өмчлөгчийн болон бусад халдлагаас хуульд заасан арга хэрэгслээр хамгаалах эрхтэй.

300 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ хүчин төгөлдөр бус байх

300.1.Эд хөрөнгө хөлслөхтэй холбоотой дараахь гэрээ буюу тохиролцоо хүчин төгөлдөр бус байна:

300.1.1.хөлслүүлэгч эд хөрөнгийн дөгөлдлын талаар мэдсээр байж сананатай дуугүй өнгөрсөн байхад түүнд эд хөрөнгийн дөгөлдлотой холбоотой хариуцлага хүлээлгэхгүй буюу хүлээх хариуцлагыг багасгах;

300.1.2.орон сууц хөлслөх гэрээгээр гэрээ цуцлах эрхийг хассан буюу хязгаарласан;

300.1.3.учруулсан гэм хороос илүү

эмжээгэр хохирлыг нөхөн төлөхийг хөлслөгчид /рэг болгосон;

300.1.4.энэ хуульд заасан бусад.

301 дүгээр зүйл. Хөлслүүлэгчийн ыатуулан барих эрх

301.1.Газар, байшин болон орон сууц элслүүлэгч нь эд хөрөнгө хөлслөх гэрээг гелүүлэхтэй холбоотой шаардлагаа хангуулах

зорилгоор тухайн газар, байшин орон сууцанд байгаа хөлслөгчийн эд хөрөнгийг саатуулан барих эрхтэй.

301.2.Хөлслүүлэгчийн барьцаалсан эд хөрөнгийг хөлслөгч нь аж ахуйн хэвийн үйл ажиллагаагаа хангахад ашиглах зориулалтаар, эсхүл амьдралын ердийн нөхцөлд тохирсон харилцааны улмаас буцаан авсан бол тухайн эд хөрөнгийн хувьд саатуулан барих эрх дуусгавар болно.

Хоёрдугаар дэд бүлэг

Орон сууц хөлслөх

302 дугаар зүйл. Орон сууц хөлслөх гэрээ

302.1.Орон сууц хөлслөх гэрээгээр лслүүлэгч нь суцны зориулалттай байшин, сууц, он сууцны өрөөг хөлслөгчийн эзэмшилд лжүүлэх, хөлслөгч нь хэлэлцэн тохирсон хөлс лөх үүргийг тус тус хүлээнэ.

302.2.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй л орон сууц хөлслөх гэрээний бие даасан зүйл лохгүй, орон сууцны дундын ашиглалтын талбай л тогооны болон ариун цэврийн өрөө, байшингийн ц, шат эзрэг/-г уг орон сууцанд сууж байгаа пслөгчид адил тэгш ашиглах эрхтэй.

302.3.Хөлслүүлэгч орон сууцны байшин, ц, өрөөний доторхи сайжруулалттай холбогдсон ялшгүй шаардлагатай арга хэмжээ авахдаа ердийн ломжит хугацаанд хөлслөгчид урьдчилан дэгдэх, хөлслөгч нь саад болохгүй байх үүрэгтэй.

302.4.Орон сууц хөлслөх гэрээнд энэ лийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

303 дугаар зүйл. Орон сууц хөлслөгчийн вуу эрх

303.1.Орон сууц хөлслөгч нь тухайн орон ґцыг сүүлийн гурван жил тасралтгүй эзэмшиж эгээ зохих ёсоор биелүүлж байсан бол элслөгчийн тавьсан нөхцөлөөр уг орон сууцыг ігүүн эзлэжид худалдан авах буюу орон сууц элслөх шинэ гэрээг тэргүүн эзлэжид байгуулах вуу эрхтэй.

304 дүгээр зүйл. Орон сууц хөлслөгч ээнээс татгалзах

304.1.Хөлслөн авсан орон сууцыг бүхэлд нь ру түүний хэсгийг хөлслөгчид хугацаанд нь ажүүлээгүйгээс уг гэрээ түүнд ашиггүй болсон, үл хөлслөгч хожим нь уг орон сууцыг ашиглах гүй болсон бол энэ хуулийн 294.3-т заасан ацаг үл харгалзан хөлслөгч гэрээг цуцлах

эрхтэй.

305 дугаар зүйл. Орон сууцыг дамжуулан хөлслөх

305.1.Хөлслөгч өөрийн хөлслөн авсан орон сууцыг хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр бүхэлд нь буюу түүний хэсгийг гуравдагч этгээдэд дамжуулан хөлслүүлэх эрхтэй.

305.2.Энэ хуулийн 305.1-д заасан тохиолдолд хөлслүүлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзах эрхгүй.

305.3.Дараахь үндэслэлийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэж болно:

305.3.1.дамжуулан хөлслөгчийн хувийн байдлаас шалтгаалсан, эсхүл татгалзах ноцтой үндэслэл хөлслүүлэгчид байвал;

305.3.2.орон сууцны талбайн ачаалал хэт ихэссэн;

305.3.3.хууль буюу гэрээнд заасан бусад шалтгаан.

305.4.Дамжуулан хөлслөх гэрээний хугацаат талууд тохиролцон тогтоох боловч орон сууц хөлслөх үндсэн гэрээний үлдсэн хугацаанаас хэтэрч болохгүй.

305.5.Дамжуулан хөлслөх гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд талууд гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй боловч энэ хуулийн 294.3-т заасан хугацааг баримтлах үүрэгтэй.

305.6.Орон сууцыг дамжуулан хөлсөлсөн бол орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болоход дамжуулан хөлслүүлэгчийн эрх, үүрэг хөлслүүлэгчид шилжинэ.

306 дугаар зүйл. Орон сууц хөлслөгчийн гэр бүлийн гишүүдийн эрх

306.1.Хөлслөгчтэй хамт амьдарч байгаа нөхөр буюу эхнэр, хүүхэд, эцэг, эхийг түүний гэр бүлийн гишүүн гэж үзнэ.

306.2.Энэ хуулийн 306.1-д заасан гэр бүлийн гишүүний төрөл садангийн бусад хүмүүс, түүнчлэн түүний асрамжид байгаа хөдөлмөрийн чадваргүй нэг жилээс доошгүй хугацаагаар хамт амьдарч, хамтын аж ахуй эрхэлж байгаа тэтгүүлэгч хүмүүсийг хөлслөгчийн гэр бүлийн гишүүнд тооцож болно.

306.3.Гэр бүлийн гишүүний талаарх маргааныг шүүх шийдвэрлэнэ.

306.4.Орон сууц хөлслөгчтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүн нь хууль буюу орон сууц хөлслөх гэрээний дагуу хөлслөгчийн бүх эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

306.5.Орон сууц хөлслөгч буюу түүний гэр бүлийн гишүүний хүсэлтээр орон сууц хөлслөх гэрээг гэр бүлийн аль нэг гишүүнтэй байгуулж болно.

306.6.Гэр бүлийн насанд хүрсэн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарахад орон сууц эзэмших, ашиглах эрхийн талаар гарсан маргааныг орон сууц хөлслөх гэрээг хэн байгуулсныг харгалзахгүйгээр шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

306.7.Орон сууц хөлслөгч нас барсан тохиолдолд түүнтэй хамт амьдарч, хамтын ахуй эрхэлж байсан гэр бүлийн гишүүдэд хөлслөгчийн эрх, үүрэг шилжих бөгөөд энэ тохиолдолд гэр бүлийн гишүүд нь энэ хуулийн 294.3-т заасан хугацаанд гэрээг цуцлах эрхтэй.

306.8.Гэрлэлтээ цуцлахдаа гэрлэгчид нь хөлслөн авсан орон сууцыг хэзээ ямар эрхийн талаар маргасан тохиолдолд маргааныг шүүх шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд шүүх хөлслөгч бус эхнэр буюу нөхөрт орон сууцыг хэзээ ямар эрхийн талаар маргасан тохиолдолд маргааныг шүүх шийдвэрлэсэн бол тэр нь орон сууц хөлслөгч болно.

307 дугаар зүйл. Түр суугч

307.1.Хөлслөгч, өөрийн хэзээ ямар ч байгаа орон сууцад гэрээ болон хөлслүүгээр түр суугчийг суулгаж болох бөгөөд түр суугч нь хөлслөгчийн анхны шаардлагаар уг орон сууцыг чөлөөлөх үүрэгтэй.

308 дугаар зүйл. Орон сууц өмчлөх эрх өөр өмчлөгчид шилжих

308.1.Бусдад хөлслүүлсэн орон сууцыг өмчлөх эрх өөр этгээдэд шилжихэд орон сууц хөлслөх гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

309 дүгээр зүйл. Орон сууцны байшин буулгахад орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болох

309.1.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр орон сууцны байшинг буулгахад орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болно.

309.2.Энэ хуулийн 309.1-д зааснаар гэрээ дуусгавар болсон тохиолдолд хөлслөгчид өөр орон сууц олгох буюу боломжгүй бол гарсан зардлыг байгуулагаас нөхөн төлнө.

309.3.Ашиглалтын шаардлага хангахгүй болсноос орон сууцны байшинг буулгахад энэ зүйлийн заалт хамаарахгүй.

310 дугаар зүйл. Ажил олгогчоос хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчтай хийсэн орон сууц хөлслөх гэрээ

310.1.Ажил олгогч нь өөрийн мэдлийн орон сууцыг хөлслүүлэхээр хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчтай тодорхой бус хугацаагаар гэрээ байгуулсан тохиолдолд тухайн ажиллагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон бол ажил олгогч орон сууц хөлслөх гэрээг цуцлах эрхтэй.

310.2.Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчтай орон сууц хөлслөх гэрээг тодорхой хугацаатай байгуулсан бөгөөд уг хугацаа болохоос өмнө ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон бол орон сууц хөлслөх гэрээ цуцлахад энэ хуулийн 294.2, 294.3-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

311 дүгээр зүйл. Албаны орон сууц

311.1.Албан тушаалын байдал, түүнчлэн хөнгөлөлт эдлэх эрхтэй нь холбогдуулж хуулийн заасан журмын дагуу тодорхой этгээдэд түр хугацаагаар шилжүүлсэн орон сууцыг албаны орон сууц гэнэ.

311.2.Энэ хуулийн 311.1-д заасан этгээдийн албан тушаалын, эсхүл хөнгөлөлт эдлэх эрх дуусгавар болсон бол уг орон сууцыг эрх бүхий этгээд буцаан авна.

311.3.Хуульд өөрөөр заагаагүй бол албаны орон сууц эзэмшихтэй холбогдсон харилцаанд хөрөнгө хөлслөх гэрээг зохицуулахтай холбогдуулан журам нэгэн адил хамаарна.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн түрээс /лизинг/

312 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн рээ

312.1.Санхүүгийн түрээсийн гэрээгээр рээслүүлэгч нь гэрээнд заасан хугацаагаар рээслэгчийн ашиглалтад эд хөрөнгө шилжүүлэх, рээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр лөх үүргийг тус тус хүлээнэ.

312.2.Түрээслүүлэгч нь түрээслэгчийн сэлт, зааврын дагуу гэрээний зүйл болох эд рөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч гээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл худалдан авах рэгтэй.

312.3.Түрээслэгч гэрээний хугацаа уссаны дараа гэрээний зүйл болох эд хөрөнгийг далдан авах буюу үргэлжлүүлэн түрээслэхээр нхүүгийн түрээсийн гэрээнд зааж болно.

312.4.Түрээслэгч гэрээний хугацаа усахад гэрээний зүйлийн элэгдэл, хорогдол болон йт өртгийг барагдуулсан бол санхүүгийн ээсийн гэрээний зүйлийг худалдан авах, эсхүл лслөх эрх, үүрэгтэй байж болно.

313 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн ээний хэлбэр, нөхцөл

313.1.Санхүүгийн түрээсийн гэрээг бичгээр йнэ.

313.2.Гэрээнд гэрээний нийт үнэ, түрээсийн лбөр, түүнийг төлөх журам, хугацаа, гэрээ ацаанаас өмнө дуусгавар болох тохиолдолд ээний үнийг төлж дуусах журмыг заана.

313.3.Энэ зүйлд заасан журмыг зөрчсөн нхүүгийн түрээсийн гэрээ хүчин төгөлдөр бус йна.

314 дүгээр зүйл. Түрээслүүлэгчийн хүлээх иуцлага

314.1.Түрээслүүлэгч нь гэрээний зүйл болох эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлээгүй, хугацаа хоцорч шилжүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй эд юмсыг шилжүүлсний хариуцлагыг эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг адил хүлээнэ.

314.2.Гэрээнд заасан бол түрээслэгч нь түрээслүүлэгчид гомдлын шаардлага тавихаас өмнө эд хөрөнгийг худалдагч буюу тээвэрлэгчээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардаж болно.

315 дугаар зүйл. Түрээслүүлэгчийн шаардлагын хэмжээг тодорхойлох

315.1.Түрээслэгчийн гэм буруугаар санхүүгийн түрээсийн гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд түрээслүүлэгчээс тавих шаардлагын хэмжээг тодорхойлохдоо түрээсэлсэн эд юмсын элэгдлийг тооцсон үнэ, төлөгдөөгүй төлбөр болон хэмнэгдсэн бусад зардлыг харгалзан үзнэ.

316 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн гэрээнд гуравдагч этгээдийн эрх, үүрэг

316.1.Гэрээнд заасан бол гуравдагч этгээд түрээслэгчийн захиалгаар гэрээний зүйл болох эд юмсыг үйлдвэрлэх буюу нийлүүлэх, түрээслүүлэгчээс зохих хөлс, зардлыг шаардах эрхтэй.

316.2.Гэрээнд заасан бол гуравдагч этгээд нь гэрээний зүйлд засвар үйлчилгээ хийх, түүнийг тохируулах, суурилуулах, ашиглахтай холбоотой үнэн зөв мэдээллийг түрээслэгчид өгөх үүрэгтэй.

317 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн гэрээнд хамаарах бусад зүйл

317.1.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний талаархи энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Түрээс

318 дугаар зүйл. Түрээсийн гэрээ

318.1.Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн ажиллагаа явуулах болон дүрэмд заасан илгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө лжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон ээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

318.2.Түрээслэгч нь гэрээнд заасан хугацааны туршид тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласны үр дүнд бий болсон үр шимийг олж авах эрх эдэлнэ.

318.3.Түрээсийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

318.4.Энэ хуулийн 318.3-т заасан шаардлагыг хангагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

318.5.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

319 дүгээр зүйл. Түрээсийн төлбөр

319.1.Түрээсийн төлберийг мөнгө, эсхүл өөр хэлбэрээр төлөхөөр тохиролцож болно.

319.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас түрээсэлсэн эд хөрөнгийн чанар байдал алдагдвал талууд харилцан тохиролцож түрээсийн төлберийн хэмжээг өөрчилж болно.

320 дугаар зүйл. Түрээсийн гэрээний хугацаа

320.1.Түрээсийн гэрээний хугацааг талууд тохиролцож тогтооно.

320.2.Түрээсийн гэрээг арваас дээш жилийн хугацаатай хийсэн бол арван жил өнгөрмөгц аль нэг талын санаачилгаар, хуульд заасан жүрмаар гэрээг цуцалж болно.

320.3.Газар буюу эрх түрээслэх гэрээний хугацаа талууд тогтоогоогүй бол гэрээг түрээсийн жилийн эцэст буюу түрээсийн жил дуусснаас хойш нэг сарын дотор цуцалж болно.

320.4.Түрээсийн гэрээг хугацаанаас өмнө цуцлахад энэ хуулийн 320.3-т заасан жүрмыг баримтална.

321 дүгээр зүйл. Газрыг хэрэглэгдэхүүний хамт түрээслэх

321.1.Газрыг хэрэглэгдэхүүний хамт түрээсэлсэн түрээслэгч хэрэглэгдэхүүн тус бүрийг арчлан хамгаалах үүрэгтэй.

321.2.Түрээслэгчээс үл хамаарах шалтгаанаар хэрэглэгдэхүүн устах буюу гэмтсэн бол түрээслүүлэгч сольж өгөх үүрэгтэй.

321.3.Газар түрээслэгч хэрэглэгдэхүүнийг түрээслэхдээ тус тусад нь үнэлж, түрээсийн гэрээ дуусгавар болоход түрээслүүлэгчид эргүүлэн өгөхөөр гэрээнд тохиролцсон бол гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлаас хэрэглэгдэхүүн устсан буюу гэмтсэний үр дагаврыг хариуцна.

321.4.Гэрээнд заасан бол түрээслэгч нь түрээсэлж байгаа хэрэглэгдэхүүний зарим хэсгийг аж ахуйн зориулалтаар нь захиран зарцуулж болно

321.5.Түрээслэгч түрээсэлсэн газрыг хэрэглэгдэхүүнийг аж ахуйн зориулалтаар ашигла шаардлагад нийцсэн хэмжээнд байлгах үүрэгтэй.

321.6.Түрээсийн гэрээ дуусснаы дараа түрээсэлсэн хэрэглэгдэхүүнд нийлүүлсэн салгах үл болох эд юмс түрээслүүлэгчийн өмчлөл шилжинэ.

321.7.Түрээсийн гэрээ дуусгавар болсноо түрээслэгч түрээсэлсэн хэрэглэгдэхүүний түрээслүүлэгчид буцаан өгөх үүрэгтэй.

321.8.Хэрэв хэрэглэгдэхүүний түрээслэгчид шилжүүлсэн үеийн үнэ, түрээслэгчээс түрээслүүлэгчид буцаан өгөх үеийн үнийн хоорондох зөрүү гарсан бол энэ зөрүүг түрээслэгч нөхөн төлнө Хэрэглэгдэхүүний үнийг түрээсийн гэрээ дуусгавар болох үеийн ханшаар тогтоно.

321.9.Түрээслүүлэгч нь түрээслэгчийн нийлүүлсэн, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд ашиглах холбогдолгүй, эсхүл хэт их үнэтэй хэрэглэгдэхүүнийг хүлээн авахгүй байх буюу төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй.

321.10.Түрээслэгч нь түрээсэлсэн газрын хэрэглэгдэхүүний талаар гаргасан шаардлага хангуулах үүднээс түрээсээр өгөмшиж байгаа газрын хэрэглэгдэхүүнээс барьцаалах эрхтэй Түрээслүүлэгч шаардлагыг өөр байдлаар хангах болсон бол түрээслэгч барьцаалах эрхээсээ татгалзах, харин шаардлагын зохих хэсгийг мөнгө хэлбэрээр хангасан бол түрээслэгч барьцаанд байгаа хэрэглэгдэхүүний аль нэг хэсгийг барьцаанаас чөлөөлнө.

322 дугаар зүйл. Үйлдвэр, аж ахуйн түрээслэх

322.1.Үйлдвэр, аж ахуйг хэрэглэгдэхүүний хамт түрээсэлж болно.

322.2.Хэрэглэгдэхүүнд хамаарах мал тэжээвэр амьтан устсан буюу гэмтсэн бол түрээслэгч аж ахуйн үйл ажиллагааг зохих ёсоор эрхэлсэн эсэхээс үл хамааран түрээслүүлэгч учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

322.3.Үйлдвэр, аж ахуйг түрээслэхэд энэ хуулийн 321 дүгээр зүйлд заасан жүрам нэгэн адил үйлчилнэ.

323 дугаар зүйл. Дамжуулан түрээслэх

323.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг гагцхүү түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр дамжуул

/рээсэлж болно.

323.2.Дамжуулан түрээслэсэн эд хөрөнгийг
нхны түрээслүүлэгчийн зөвшөөрснөөс өөрөөр
ошгосны үр дагаврыг дамжуулан түрээслэгч нь
нхны түрээслүүлэгчийн өмнө хариуцна. Энэ
эхиолдолд анхны түрээслүүлэгч дамжуулан
үрээслэгчийн ашиглах эрхийг дуусгавар болгохыг
аардах эрхтэй.

324 дүгээр зүйл. Түрээслэгч солигдох

324.1.Түрээслэгч нь түрээсийн гэрээний
үгацаа дуусахаас өмнө түрээсэлсэн эд хөрөнгийг
үрээслүүлэгчид буцаан өгсөн тохиолдолд гэрээний
үгацаа дуусах хүртэл түрээсийн төлбөрөөс
олөөлөгдөхгүй.

324.2.Түрээслэгч өөрийнхөө оронд
рээсийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн,
лбөрийн чадвар бүхий өөр түрээслэгчийг санал
олгосныг түрээслүүлэгч хүлээн зөвшөөрсөн
ихцелд түрээслэгч энэ хуулийн 324.1-д заасан
үргээс чөлөөлөгдөнө.

325 дүгээр зүйл. Түрээслэгч нас барсны
дараа түрээсийн гэрээ үргэлжлэх

325.1.Түрээслэгч нас барсан тохиолдолд
түүний өвлөгч буюу түрээслүүлэгч хуанлийн жилийн
тухайн улирал дууссанаас хойш 6 сарын дотор
түрээсийн гэрээг цуцалж болно.

325.2.Түрээслэгчийн өвлөгч өөрөө, эсхүл
гуравдагч этгээдээр дамжуулан түрээсэлсэн эд
хөрөнгийг аж ахуйн зориулалтаар ашиглаж чадна
гэж үзвэл түрээсийн гэрээг цуцлахаас татгалзаж,
гэрээг үргэлжлүүлэхээр түрээслүүлэгчээс
шаардаж болно.

326 дугаар зүйл. Түрээслэгчийн
хариуцлага

326.1.Түрээслэгч түрээсийн гэрээ
дуусгавар болсны дараа ердийн буюу гэрээгээр
тохиролцсон элэгдлийг тооцож түрээсэлсэн эд
хөрөнгийг буцаан өгөх үүрэгтэй.

326.2.Түрээслүүлэгч өөрт учирсан хохирол,
хэтэрсэн хугацааны түрээсийн төлбөрийг нөхөн
төлөхийг шаардаж болно.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Хөдөө аж ахуйн зориулалттай газрын түрээс

327 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн
риулалттай газрын түрээсийн гэрээ

327.1.Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг
зориулалтаар ашиглуулахаар суусны болон аж
уйн зориулалтаар ашиглагдах байгууламжийн
мт, эсхүл тийм байгууламжгүйгээр түрээсэлж
лно.

327.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол хөдөө
: ахуйн зориулалттай газрыг түрээслэхэд
рээсийн гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

328 дугаар зүйл. Гэрээгээр шилжүүлэх эд
рөнгө

328.1.Түрээслүүлэгч нь газрыг гэрээнд
асан зориулалтаар ашиглах шаардлага хангасан
хөрөнгийн хамтаар түрээслэгчид шилжүүлэх
эгтэй.

328.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол
ээслэгч түрээсээр шилжүүлсэн суусны болон аж
йн зориулалтай барилга байгууламж, зам, хашаа
эг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахтай
богдсон урсгал засварыг өөрийн зардлаар хийх,
ээсэлж авсан эд хөрөнгийг аж ахуйн
иулалтаар нь ашиглах үүрэг хүлээнэ.

328.3.Түрээсийн гэрээний харилцаа үүсэх,
дуусгавар болох үед талууд гэрээгээр шилжүүлбэл
зохих эд хөрөнгийн тоо хэмжээ, үнэ, шилжүүлэх
үеийн чанарын байдал зэргийг заасан жагсаалтыг
хамтран үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

329 дүгээр зүйл. Түрээслүүлэгчийн
барьцааны эрх

329.1.Түрээслүүлэгч нь түрээсийн
гэрээгээр түрээслэгчид гаргах шаардлагаа
хангуулахын тулд түрээслэгчийн түрээсэлж авсан
эд хөрөнгийг ашигласны үр дүнд олж авсан зүйлс,
үр шимийг барьцаалах эрхтэй.

330 дугаар зүйл. Гэрээний хугацаг сунгах

330.1.Хөдөө аж ахуйн зориулалттай газрын
түрээсийн гэрээг хоёр жилээс дээш хугацаагаар,
бичгээр хийх бөгөөд энэ журмыг баримтлагүй
байгуулсан гэрээг тодорхой бус хугацаагаар
байгуулсан гэж үзэж уг гэрээ үйлчилж эхэлснээс
хойш нэг жил өнгөрснөөр дуусгавар болгоно.

330.2.Гурван жилээс дээш хугацаагаар
байгуулсан гэрээг сунгах тухай гэрээний нэг талын
саналыг ирснээс хойш 3 сарын дотор нөгөө тал
татгалзаж байгаа тухай мэдэгдээгүй бол түүнийг
тодорхой бус хугацаагаар байгуулсанд тооцно.

330.3.Гэрээг сунгах тухай санал болон

татгалзлыг бичгээр үйлдэнэ.

331 дүгээр зүйл. Зайлшгүй зардал төлөх үүрэг

331.1.Түрээслүүлэгч түрээслэгчид түрээслэн авсан эд хөрөнгөтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

331.2.Энэ хуулийн 331.1-д зааснаас бусад зардлыг түрээслүүлэгч нөхөн төлөхөөр зөвшөөрсөн бол түрээсийн харилцаа дуусгавар болох үед төлнө.

332 дугаар зүйл. Гэрээ дуусгавар болох үеийн талуудын эрх, үүрэг

332.1.Аж ахуйн үйл ажиллагааг зохих ёсоор явуулсны үр дүнд бий болсон үргацаа хураан авааг үй байхад түрээсийн гэрээ дуусгавар болсон бол түрээслэгч түрээсийн гэрээг сунгахыг түрээслүүлэгчээс шаардах, эсхүл хураан авааг байгаа үргацын ертийг түрээслүүлэгч түрээслэгчи төлөх үүрэгтэй.

332.2.Хэдээ аж ахуйн зориулалттай газры түрээсийн хугацаа дуусахад түрээслэгч н түрээслүүлэгчид газар, барилга байгуулламж, тонг төхөөрөмжийг ердийн буюу гэрээгээр тохиролцсо элэгдлийг тооцож аж ахуйн хэвийн үйл ажиллагаа үргэлжлүүлэх шаардлагад тохирохоор бүрэн бүтэ хүлээлгэн өгөх үүрэгтэй.

332.3.Түрээслэгч нь түрээслэн авсан э хөрөнгийг анх хүлээн авах үеийнхээс илү чанаржуулан үлдээхээр бол түрээслүүлэгчээ нөхөн төлбөр шаардах эрхтэй.

332.4.Түрээсийн гэрээ дуусгавар болохо түрээслэгч нь салгаж болох засан сайжруулалть салгаж авах буюу түрээслүүлэгч нь зохих үни төлж өөртөө авч болно.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Франчайз

333 дугаар зүйл. Франчайзийн гэрээ

333.1.Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

334 дүгээр зүйл. Гэрээний талуудын үүрэг

334.1.Эрх шилжүүлэгч дараахь үүрэгтэй:

334.1.1.хамтын ажиллагааны хөтөлбөрийг гуравдагч этгээдийн оролцооноос хамгаалах;

334.1.2.хөтөлбөрийг байнга боловсронгуй болгох;

334.1.3.эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

334.1.4.эрх хүлээн авагчид техникийн туслалцаа үзүүлэх;

334.1.5.эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах.

334.2.Эрх хүлээн авагч дараахь үүрэгтэй:

334.2.1.гэрээгээр хүлээж авсан эр эд хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигта ашиглах;

334.2.2.зохих шагнал, хураам орлогын тодорхой хувийг тогтоосон хугацаанд төле

334.2.3.гэрээнд заасан бо шилжүүлэн авсан эрх, эд хөрөнгийг э шилжүүлэгчид ашигтайгаар даатгуулах;

334.2.4.эрх шилжүүлэгчий зөвшөөрөлгүйгээр лицэнз болон франчайзийн гэрэ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

334.2.5.гэрээнд заасан бол э шилжүүлэгчээс хэрэгжүүлж байгаа сургалт ажиллагсдыг хамруулах, холбогдох зардлыг төле

334.2.6.эрх шилжүүлэгчийн бараан болон ажил үйлчилгээний тэмдгийг хэрэглэхд лицензээр хэрэглэж байгаа тухай харилцагч болс үйлчүүлэгчид заавал мэдэгдэх.

334.3.Талууд гэрээ байгуулахд шаардлагатай бүхий л мэдээллийг шударга харилцан солилцох, гэрээ байгуулагдахгү тохиолдолд мэдээллийн нууцыг задруулахгүй ба үүрэгтэй.

335 дугаар зүйл. Франчайзийн гэрээнi

элбэр

335.1.Франчайзийн гэрээг бичгээр хийнэ.

335.2.Франчайзийн гэрээнд гэрээний
эгэлжээ хугацаа, гэрээ цуцлах, хугацаа сунгах
урам, талуудын хүлээх үүрэг бусад гол
эхцөлүүдийг заасын зэрэгцүүз франчайзийг
эрэгжүүлэх хөтөлбөрийг бүрэн тусгана.

336 дугаар зүйл. Франчайзийн гэрээний
угацаа

336.1.Франчайзийн гэрээний хугацааг тухайн
эраа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрэлт
эрэгцээ, борлуулалтын зах зээлээс шалтгаалан
алууд тохиролцон тогтооно.

336.2.Франчайзийн гэрээг арван жилээс
эөш хугацаагаар байгуулсан нөхцөлд 10 жил
гөрсний дараа, хугацааг гэрээгээр тодорхойлогуй
ол талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай нөгөө
лдаа мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор цуцалж
олно.

336.3.Гэрээнд заасан хугацаа дууссан
ловч аль нэг талын санаачилгаар талууд харилцан
гэлцэх, хамтран ажиллах зарчмыг удирдлага
олгон ажил хэргийн харилцаа дуусгавар болох
ртэл гэрээгээ тодорхой буюу тодорхой бус
гацаагаар тухайн буюу шинэчилсэн нөхцөлөөр
нгаж болно.

337 дугаар зүйл. Өрсөлдөөнийг хязгаарлах

337.1.Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээ
дуусгавар болсны дараа эрх хүлээн авагчийг
тодорхой нутаг дэвсгэрт өөртэйгээ өрсөлдөхийг нэг
жил хүртэл хугацаагаар хориглож эрхтэй.

337.2.Энэ хуулийн 337.1-д заасан хориг нь
эрх хүлээн авагчийн үндэсн үйл ажиллагаанд
ноцтой хохирол бий болгож байвал эрх шилжүүлэгч
түүнд зохих мөнгөн төлбөр төлөх үүрэгтэй.

338 дугаар зүйл.Талуудын хүлээх
хариуцлага

338.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн
гүйцэтгэл болон өгсөн мэдээллийн үнэн зөвийг
хариуцна.

338.2.Эрх хүлээн авагч франчайзийн
гэрээний үүрэгтэй холбоотой эрх шилжүүлэгчид
учруулсан хохирол, зардлыг түүнд нөхөн төлөх
үүрэгтэй.

338.3.Эрх шилжүүлэгч нь франчайзийн
гэрээний үр дүнд эрх хүлээн авагчийн олох орлогын
талаар баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй.

338.4.Эрх хүлээн авагчийн гэм буруутай үйл
ажиллагаанаас болж үйлчлүүлэгчид учирсан
хохирлыг эрх шилжүүлэгч хариуцахгүй.

ГУЧДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах

339 дүгээр зүйл. Эд хөрөнгө үнэ төлбөргүй
иглах гэрээ

339.1.Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах
эрээгээр нэг тал нь нөгөө талдаа нэг бүрийн
ижээр тодорхойлогдох тодорхой эд хөрөнгө үнэ
лбөргүй ашиглуулахаар шилжүүлэх, нөгөө тал нь
кайн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж,
ээ дуусгавар болоход бүрэн бүтэн буцааж өгөх
ийг тус тус хүлээнэ.

339.2.Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах
ээнд эд хөрөнгө хөлслөх гэрээг зохицуулсан энэ
улийн 289.1.3, 289.1.6, 289.2.6, 293, 295.3, 296,
7, 298 дугаар зүйлүүд нэгэн адил хамаарна.

340 дүгээр зүйл. Эд хөрөнгө үнэ төлбөргүй
иглаж байгаа этгээдийн үүрэг

340.1.Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглаж
йгаа этгээд нь дараахь үүрэг хүлээнэ:

340.1.1.эд хөрөнгийг гэрээнд заасны
уу зориулалтаар нь ашиглах, ердийн элэгдлээс
өөрөөр муутгахгүй байх;

340.1.2.шилжүүлсэн этгээдийн
зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгийг гуравдагч этгээдийн
эзэмшил, ашиглалтад шилжүүлэхгүй байх;

340.1.3.эд хөрөнгийн хэвийн
байдлыг хангахад шаардлагатай зайлшгүй зардлыг
хариуцах;

340.1.4.гэрээний хугацаа дуусахад
эд хөрөнгийг бүрэн бүтэн буцааж өгөх.

341 дүгээр зүйл. Эд хөрөнгөө үнэ
төлбөргүй ашиглуулах гэрээг цуцлах

341.1.Эд хөрөнгөө үнэ төлбөргүй
ашиглуулахаар шилжүүлсэн этгээд дараахь
тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй:

341.1.1.эд хөрөнгийг тодорхой
зорилгоор тодорхой бус хугацаагаар ашиглуулахаар
тохиролцсон бол тухайн зорилгоор ашиглахад
зайлшгүй шаардагдах хугацаа өнгөрсний дараа,

хэрэв зорилгыг нь тодорхойлоогүй бол хэдийд ч;

341.1.2.тухайн эд хөрөнгө өөрт нь зайлшгүй шаардлагатай болсон;

341.1.3.эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглаж байгаа тал нь энэ хуулийн 340.1.1-340.1.3-т заасан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол;

341.1.4.эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглаж байсан эзэнээ нас барсан.

341.2.Эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглаж байгаа этгээд тухайн эд хөрөнгийг хэдийд ч буцаан өгөх эрхтэй.

342 дугаар зүйл.Талуудын хүлээх хариуцлага

342.1.Эд хөрөнгөө үнэ төлбөргүй авиглуулахаар шилжүүлсэн этгээд түүний биет байдлын болон эрхийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулснаас болж учирсан хохирлыг тухайн эд хөрөнгийг авиглаж байсан этгээдэд нөхөн төлөх үүрэгтэй.

342.2.Эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглуулж байгаа этгээд нь гэм буруугийн хэлбэрээс үл шалтгаалан эд хөрөнгөд учирсан хохирлыг хариуцна.

342.3.Эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглуулж байгаа этгээд авиглалтын ердийн элэгдлээс илүүтэйгээр тухайн эд хөрөнгийг муутгасан гэмтээсэн, үрэгдүүлсэн, өөрчилснээс болж нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

342.4.Эд хөрөнгө үнэ төлбөргүй авиглуулж байгаа тал нь нөгөө талын зөвшөөрөлтэйгээр тухайн эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн гэсэн эд хөрөнгийг авиглуулахаар шилжүүлсэн талын өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

III ДЭД ХЭСЭГ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ажил гүйцэтгэх

343 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ

343.1.Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил захиалагчийн буюу өөрийн материалаар заасан ажил гүйцэтгэх, гүйцэтгэгч нь ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

343.2.Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь гүйцэтгэсэн ажлын үр дүн байна.

343.3.Ажил гүйцэтгэгч ямар нэгэн эд зүйлийг хийсэн бол түүнийг захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ.

343.4.Төрийн шинжээр тодорхойлогдох эд юмс хийж захиалагчийн өмчлөлд шилжүүлсэн бол худалдах-худалдан авах гэрээг зохицуулсан журам үйлчилнэ.

343.5.Ажил гүйцэтгэх зарим төрлийн гэрээний онцлог зохицуулалтыг тусгай хуулиар зохицуулж болно.

344 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэгчид төлөх хөлс

344.1.Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хэлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацаог талууд тохиролцож тодорхойлно.

344.2.Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас батлагдсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө.

345 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын төсөв

345.1.Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ажил гүйцэтгэгч төсөв зохиож болно.

345.2.Гэрээ байгуулах үед урьдчилсан төлөвлөх боломжгүй байснаас төсвийн хэмжээ нэмэгдэхээр байвал ажил гүйцэтгэгч энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

345.3.Төсвийн хэмжээ нэмэгдсэнээс захиалагч нь гэрээг дуусгавар болгохоос бусад шийдвэрлэсэн бол гүйцэтгэсэн ажлын хөлсийг ажил гүйцэтгэгчид төсөвт заасан хэмжээгээр төлөх үүрэгтэй.

345.4.Ажил гүйцэтгэгч төсөв зохиохдоо ундэслэлгүй өндөр үнэлгээ тогтоосон бол захиалагч хөлс төлөхөөс татгалзах эрхтэй.

346 дугаар зүйл. Хөлс төлөх хугацаа

346.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх үед хөлс төлнө.

346.2.Ажлыг тодорхой хэсгээр, үе шаттайгаар гүйцэтгэхээр тохиролцож, ажлын хөлсийг хэсэг тус бүрээр тогтоосон бол тухайн хэсгийн үр дүнг хүлээлгэн өгөх үед зохих хөлсийг төлнө.

347 дугаар зүйл. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч

347.1.Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд бусад этгээд /туслан гүйцэтгэгч/ гийг оролцуулж болно. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгч нь захиалагчийн хувьд ерөнхий ажил гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хувьд захиалагч болно.

347.2.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнг захиалагчийн өмнө хариуцна.

348 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа

348.1.Хуульд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэх гэрээний хугацааг талууд тохиролцон тодорхойлох бөгөөд ажлын онцлогийг харгалзан завсрын буюу тусгай хугацаа тогтоож болно.

348.2.Хуульд өөрөөр заагаагүй бол завсрын буюу тусгай хугацааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг талууд тохиролцон тодорхойлж болох боловч тэр нь үндсэн хугацааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагаас илүү байж болохгүй.

349 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэгчийн хариуцлагын талаар гомдлын шаардлага гаргах хугацаа

349.1.Ажил гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил хүлээн авснаас хойш зургаан сарын дотор, хэвийн байдлаар хүлээн авах үед илрүүлэх боломжгүй дутагдлын тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш нэг жилийн дотор гаргана. Барилга, байшингийн ийм дутагдлын талаар ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргаж болно.

349.2.Хууль буюу гэрээнд баталгаат хугацаа заасан бөгөөд уг хугацааны дотор ажлын дутагдлыг илрүүлсэн бол гомдлын шаардлага гаргах хугацааг дутагдал илрүүлсэн өдрөөс эхлэн тоолно.

349.3.Энэ зүйлд заасан гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

350 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгчийн үүрэг

350.1.Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

350.1.2.гүйцэтгэх ажлын мөн чанар, ажил гүйцэтгэгчийн хувийн байдалтай холбоотой биечлэн гүйцэтгэвэл зохих ажлыг биечлэн гүйцэтгэх;

350.1.3.дараахь тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэх:

а/ ажил гүйцэтгүүлэхээр захиалагчийн шилжүүлсэн материал, ажил гүйцэтгэх аргын талаар захиалагчийн өгсөн зааварчилга нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;

б/ ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.

350.1.4.ажил гүйцэтгүүлэхээр захиалагчаас олгосон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах;

350.1.5.ажил гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн захиалагчийн материалыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй ашиглаж, материалын зарцуулалтыг захиалагчид тайлагнах, материалыг ажил гүйцэтгэж дууссаны дараа захиалагчид шилжүүлэх;

350.1.6.захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх;

350.1.7.ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс г.м/ хариуцах;

350.1.8.өөрийн материалаар ажил гүйцэтгэх бол зохих чанарын материалаар гүйцэтгэх.

351 дүгээр зүйл. Захиалагчийн үүрэг

351.1.3.Захиалагч дараахь үүрэг хүлээнэ:

351.1.1.гэрээнд заасан хугацаанд, эсхүл ажлын үр дүнг хүлээн авмагц зохих журмын дагуу хөлс төлөх;

351.1.2.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах;

351.1.3.гэрээнд заасан бол ажил гүйцэтгэхэд шаардлагатай материал, багаж, тоног төхөөрөмж, ажлын байр гаргаж ажил гүйцэтгэгчид шилжүүлэх;

351.1.4.ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.

351.2.Захиалагч гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол түүнийг тухайн ажлын үр дүнг хүлээн авсан гэж тооцно.

352 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээний талуудын гаргах шаардлага

352.1.Ажил гүйцэтгэх гэрээгээр талууд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд энэ хуульд заасан нийтлэг журам үйлчилнэ.

352.2.Захиалагч дараахь шаардлага гаргах эрхтэй:

352.2.1.гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн саналаар түүний зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэх;

352.2.2.доголдлыг арилгуулахаар тогтоосон хугацаанд ажил гүйцэтгэгч ямар нэгэн арга хэмжээ авааг үл доголдлыг арилгаж, түүнтэй холбогдсон зардлаа нөхөн төлүүлэх;

352.2.3.доголдлын улмаас ажлын үр дүнгийн үнэ нь буурсан хэмжээнд хувь тэнцүүлэн ажил гүйцэтгэгчид төлбөл зохих хөлсийг бууруулах.

352.3.Доголдлыг арилгахад харьцангуй их зардал шаардагдахаас шалтгаалан ажил гүйцэтгэгч гэрээнээс татгалзсан бол энэ хуулийн 352.2.2-т заасан захиалагчийн эрх дуусгавар болно.

352.4.Ажлын үр дүнг хүлээж авах үед түүний доголдлыг захиалагч мэдэж байсан боловч ямар нэгэн гомдол гаргаагүй бол гэрээр энэ хуулийн 352.2-т заасан шаардлага гаргах эрхээ алдана.

352.5.Ажил гүйцэтгэгч дараахь шаардлага гаргах эрхтэй:

352.5.1.гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хүлээж авааг буюу ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах үйлдэл хийх энэ хуулийн 351.1-д заасан үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

352.5.2.ажлын үр дүнгийн доголдлыг арилгах зорилгоор ажлыг шинээр гүйцэтгэж шинэ үр дүнг захиалагчид шилжүүлсэн бол өмнө нь шилжүүлсэн зүйлээ буцаж авах;

352.5.3.захиалагч өөрийн буруугаар ажлын үр дүнг хүлээж аваагүй байвал гүйцэтгэсэн ажлын үр дүн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас устсан, гэмтсэн, эсхүл захиалагчийн буруугаар ажлыг хугацаанд нь гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ажлын хөлсөө төлүүлэх.

353 дугаар зүйл. Ажлын үр дүнгийн доголдол

353.1.Гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаар гуравдагч этгээд захиалагчид ямар нэгэн шаардлага гаргах эрхгүй бол уг ажлын үр дүнг эрхийн доголдолгүй гэнэ.

353.2.Гэрээнд заасан тоо, хэмжээ, чанар тохирч байвал ажлын үр дүнг биет байдлын доголдолгүй гэнэ.

353.3.Хэрэв гэрээнд ажлын үр дүнгийн тоо хэмжээ, чанарын талаар заагаагүй бол гэрээнд заасан зориулалтаар ашиглах боломжтой ажлын үр дүнг биет байдлын доголдолгүй гэнэ.

354 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэгчийн барьцааны эрх

354.1.Ажил гүйцэтгэгч өөрийн шаардлагыг хангах зорилгоор эзэмшилдээ байгаа, захиалагчийн захиалсан ажлын үр дүн болох хөдлөх эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

354.2.Хэрэв гэрээний зүйл нь барилга байгууламж буюу түүний тодорхой хэсэг байвал ажил гүйцэтгэгч өөрийн шаардлагыг хангуулахаар барилга байгууламж барих газрын хувьд баталгаат ипотекийн эрхтэй.

355 дугаар зүйл. Гэрээ цуцлах

355.1.Гэрээний аль нэг тал үүргээ ноцто

эрчсэн бол энэ хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу негөө тал гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

355.2.Ажил гүйцэтгэгч ажлыг бүрэн гүйцэтгэж дуусахаас өмнө захиалагч хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

355.3.Энэ хуулийн 226 дугаар зүйлд заасан тохиолдлоос гадна ажил гүйцэтгэгч доголдлыг арилгахтай холбогдсон нэмэлт үүргээ гүйцэтгээгүй бол нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй.

355.4. Захиалагчийн захиалгыг өөр байдлаар ханган боломжтой нөхцөлд ажил гүйцэтгэгч энэ хуулийн 355.2-т зааснаар гэрээг цуцлах эрхтэй.

355.5.Өөрөө гэм буруугүй, эсхүл хүндэтгэн үзэх онцгой нөхцөл байдал бий болсон бол ажил гүйцэтгэгч энэ хуулийн 355.4-т заасан нөхцөлийг харгалзахгүйгээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Энэ тохиолдолд захиалагчид учруулсан хохирлыг ажил гүйцэтгэгч нөхөн төлөх үүрэг хүлээхгүй, харин гэрээ цуцлахаас өмнө ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнд захиалагч ямар нэгэн ашиг сонирхолтой байвал ажил гүйцэтгэгч гүйцэтгэсэн ажлын хөлсөө шаардах эрхтэй.

355.6.Ажил дуусахаас өмнө захиалагч гэрээгээ цуцалсан бол гэрээ цуцлахаас өмнө ажил гүйцэтгэгчид орсон орлого, үр шимийг хасаж, учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

356 дугаар зүйл. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын үед эрсдлийг хуваарилах

356.1.Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагчид шилжүүлэхээс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдэлийг ажил гүйцэтгэгч хариуцна.

356.2.Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хугацаанд нь хүлээн аваагүй бол ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг захиалагч хариуцна.

356.3.Энэ хуулийн 356.1, 356.2-т заасан тохиолдолд ажил гүйцэтгэх материал устсан, гэмтсэн бол уг материалыг гаргасан тал нь эрсдэлийг хариуцна.

357 дугаар зүйл. Ажил гүйцэтгэхтэй холбогдсон хэлцэл хүчин төгөлдөр бус байх

357.1.Ажил гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөхөөр хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

358 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх тодорхой төрлийн гэрээний зохицуулалт

358.1.Ажил гүйцэтгэх тодорхой төрлийн бүх гэрээнд энэ бүлгийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөлсөөр ажиллах

359 дүгээр зүйл. Хөлсөөр ажиллах гэрээ

359.1.Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

359.2.Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно.

360 дугаар зүйл. Хөлсөөр ажиллах гэрээний хөлс

360.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэсний хөлсийг ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа төлнө.

360.2.Шаардлагатай бол хөлсийг эсэгчлэн, тодорхой хугацаанд төлөхөөр тохиролцож болно.

361 дүгээр зүйл. Ажиллагч үүргийг биечлэн гүйцэтгэх

361.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажиллагч нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг биечлэн гүйцэтгэх бөгөөд үүргийг бусдад шилжүүлж болохгүй.

362 дугаар зүйл. Ажил, үйлчилгээг хүлээн авахаас татгалзах

362.1.Ажиллуулагч нь ажил, үйлчилгээг хүлээн авах хугацаанд хойшлуулсан, хүлээн авахаас татгалзсан тохиолдолд ажиллагч нь цаашид хийх ажлаа гүйцэтгэхээс татгалзаж тохиролцсон хөлсийг шаардах эрхтэй.

363 дугаар зүйл. Ажиллагчийг ажил, үйлчилгээ явуулах нөхцөлөөр хангах

363.1.Ажиллуулагч нь ажиллагчийн эрүүл мэнд, амь насанд аюулгүй, гүйцэтгэх ажлын онцлог, шаардлагад нийцэхүйц байр, багаж, тоног төхөөрөмжөөр хангах үүрэгтэй.

364 дүгээр зүйл. Гэрээ дуусгавар болох

364.1.Хөлсөөр ажиллах гэрээ тохирсон хугацаа дуусснаар дуусгавар болно.

364.2.Гэрээнд хугацаа тогтоогоогүй буюу ажил, үйлчилгээний онцлог, зорилгоос шалтгаалан хугацаа заагаагүй бол гэрээний талууд тохиролцон хэдийд ч гэрээг дуусгавар болгож болно.

365 дугаар зүйл. Гэрээг цуцлах хугацаа

365.1.Хөлс төлөх хугацаанаас хамаарч гэрээг дараахь хугацаанд цуцална:

365.1.1.хөлсийг өдрөөр төлөхөөр тохиролцсон бол хөлс төлсөн сүүлчийн өдрийн дараа өдөр;

365.1.2.хөлсийг долоо хоногоор төлөхөөр тохиролцсон бол хөлсийг төлсний дараагийн долоо хоногийн эхний ажлын өдөр;

365.1.3.хөлсийг сараар төлөхөөр тохиролцсон бол хөлс төлсөн сарын арван тавны дотор;

365.1.4.хөлсийг улирлаар, эсхүл илүү урт хугацаагаар төлөхөөр тохиролцсон бол уг хугацаа дуусахаас гуч хоногийн өмнө хөлсийг өгч;

365.1.5.хөлс төлөх хугацаа тохиролцоогүй бол арван дөрөв хоногийн өмнө хөлсийг төлснөөр.

365.2.Хөлсөөр ажиллах гэрээг таваас дээш жилийн хугацаатай байгуулсан бол ажиллагч нь гэрээ байгуулснаас хойш таван жилийн дараа гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тухай зургаан сарын өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

366 дугаар зүйл. Гэрээг сунгасанд тооцох

366.1.Гэрээний хугацаа дууссаны ажиллагч нь нөгөө талдаа мэдэгдэн гэрээг үргэлжлүүлэхийг хүссэнийг ажиллуулагч эсэргүүцээгүй тохиолдолд гэрээг тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно.

367 дугаар зүйл. Гэрээ цуцлах хүндэтгэн үзэх үндэслэл

367.1.Энэ хуулийн 221 дүгээр зүйлд заасан хүндэтгэн үзэх үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд ажиллагч нь гэрээ цуцлах хүртэл хугацаанд гүйцэтгэсэн ажлынхаа хөлсийг шаардах эрхтэй.

367.2.Ажиллуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн үйл ажиллагаа явуулагүй, ажиллагч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу гэрээнд харш үйл ажиллагаа явуулсны улмаас гэрээг цуцалсан бол ажиллагч ажлын хөлс шаардах эрхээ алдана.

367.3.Ажиллагч ажлынхаа хөлсийг бүхэлд нь, эсхүл зарим хэсийг урьдчилан авсан үед гэрээ цуцлагдсан бол урьд олгосон хөлсийг буцаан төлүүлнэ.

367.4.Ажиллуулагч гэрээнд харш үйл ажиллагаа явуулснаас болж гэрээг цуцлахад хүргэсэн бол гэрээ цуцалснаас учирсан хохирлыг ажиллуулагч хариуцна.

368 дугаар зүйл. Хөлсөөр ажиллах байсныг нотлох баримт шаардах

368.1.Хөлсөөр ажиллах гэрээний харилцаа дуусгавар болгох үед ажиллагч нь ажиллуулагчаа хөлсөөр ажиллаж байсан тухай болон түүний үргэлжилсэн хугацааны талаар бичгээр тодорхойлолт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрлөх

369 дүгээр зүйл. Хөдөлмөрийн гэрээ

369.1.Иргэн нь иргэн болон хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж болно.

369.2.Хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

369.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн ерөнхий үндэслэлийг хэрэглэнэ.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Аялал жуулчлал

370 дугаар зүйл. Аялал жуулчлалын гэрээ

370.1.Аялал жуулчлалын гэрээгээр аялагч

жуулчлал зохион байгуулагч нь жуулчинд хэлэлцэн
гохиролцсон үйлчилгээ үзүүлэх, жуулчин нь ийнхүү
үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохирсон хөлс
төлөх үүргийг тус тус хүлээнэ.

**371 дүгээр зүйл. Аялал жуулчлалд
уравдагч этгээдийг оролцуулах**

371.1.Жуулчин өөрийнхөө оронд гуравдагч
этгээдийг аялалд оролцуулахаар аялал эхлэхээс
өмнө аялал жуулчлал зохион байгуулагчид хүсэлт
аргаж эрхтэй.

371.2.Энэ хуулийн 371.1-д заасан гуравдагч
этгээд нь аялал жуулчлал хийхэд шаардагдах
өхцөлд тохирохгүй гэж үзвэл түүнийг өөр этгээдээр
олихыг аялал жуулчлал эхлэхээс өмнө аялал
хуулчлал зохион байгуулагч нь жуулчнаас шаардах
рхтэй.

371.3.Аялал жуулчлал зохион байгуулагч нь
уравдагч этгээдийг аялалд оролцуулахтай
олбогдож гарсан нэмэлт зардлаа өөрөн
өлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй.

**372 дугаар зүйл. Доголдол гаргахгүй байх
үрэг**

372.1.Аялал жуулчлал зохион байгуулагч нь
эрээнд заасан аяллын ач холбогдлыг бууруулах
уюу үр ашигүй болгох аливаа доголдол
аргахгүйгээр аяллыг зохион байгуулах үүрэгтэй.

372.2.Аялал зохион байгуулагч энэ хуулийн
72.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол жуулчин
доголдлыг арилгахыг шаардах эрхтэй бөгөөд
йнхүү доголдлыг арилгахад харьцангуй их зардал
ирахаар бол аялал жуулчлал зохион байгуулагч
ь доголдлыг арилгахаас татгалзаж болно.

372.3.Жуулчны тогтоосон боломжийн
угацаанд аялал жуулчлал зохион байгуулагч
оголдлыг арилгахгүй бол жуулчин өөрөө уг
оголдлыг арилгаж, гарсан зардлыг аялал жуулчлал
охион байгуулагчаас нөхөн төлүүлэхээр шаардах
рхтэй.

372.4.Аялал жуулчлал зохион байгуулагч
оголдлыг арилгахаас шууд татгалзсан буюу
рилгах боломжгүй бол энэ хуулийн 372.3-т заасан
угацаат заавал тогтоох шаардлагагүй.

372.5.Аялал нь ямар нэгэн доголдолтой бол
хайн доголдлыг арилгасан хугацаог харгалзан
ллын үнийг бууруулж болно.

372.6.Жуулчин доголдлыг арилгуулах тухай
алал жуулчлал зохион байгуулагчид өөрийн
рүүгээс мэдэгдээгүй бол аяллын үнийг
үрүүлахгүй.

373 дугаар зүйл. Гэрээ дуусгавар болох

373.1.Дараахь үндэслэлээр гэрээг дуусгавар болгоно:

373.1.1.аяллын доголдлоос болж жуулчинд үлэмж хохирол учирсан;

373.1.2.жуулчин хүндэтгэн үзэх шалтгаанаар аялалд оролцох боломжгүй болсон тухай аялал зохион байгуулагчид мэдэгдсэн;

373.1.3.аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчны тогтоосон хугацаанд доголдлыг арилгаагүй.

373.2.Энэ хуулийн 373.1-д заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгосон бол аялал жуулчлал зохион байгуулагч нь хэлэлцэн тохиролцсон хөлс авах эрхээ алдана. Нэгэнт үзүүлсэн доголдолгүй үйлчилгээнийхээ хөлсийг шаардах эрхтэй.

373.3.Гэрээ дуусгавар болсны дараа аялал жуулчлал зохион байгуулагч жуулчныг буцааж хүргэх үүрэг гэрээгээр хүлээсэн бол энэ үүргээ гүйцэтгэх үүрэгтэй. Энэ тохиолдолд жуулчныг буцааж хүргэхтэй холбогдсон зардлыг аялал жуулчлал зохион байгуулагч хариуцна.

373.4.Гэрээ байгуулах үед урьдчилан мэдэх боломжгүй байсан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас аялал хийхэд ноцтой хүндрэл учирсан буюу жуулчинд хохирол учруулж болох өөр бусад нөхцөл бий болсон бол аялал жуулчлал зохион байгуулагч, жуулчны аль нь ч гэрээг дуусгавар болгох эрхтэй бөгөөд жуулчныг буцаахтай холбогдох зардыг талууд тэнцүү хэмжээгээр хариуцна.

374 дүгээр зүйл. Хохирол нөхөн төлөх

374.1.Аялал жуулчлал зохион байгуулагчийн гэм буруугаар доголдол бий болсон бол жуулчин хөлсийг бууруулах буюу гэрээг дуусгавар болгохын зэрэгцүү учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр аялал жуулчлал зохион байгуулагчаас шаардах эрхтэй.

374.2.Аялал болоогүй буюу түүнийг зохих ёсоор зохион байгуулаагүй бол жуулчин үр ашигүй өнгөрүүлсэн хугацааныхаа нөхөн төлбөрийг аялал жуулчлал зохион байгуулагчаас менгөн хэлбэрээр нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

**375 дугаар зүйл. Гомдлын шаардлага
гаргах хугацаа**

375.1.Жуулчин энэ хуулийн 372.3, 374 дүгээр зүйлд заасан шаардлагыг гэрээнд заасан

аяллын хугацаа дуусснаас хойш нэг сарын дотор аялал жуулчлал зохион байгуулагчид гаргаж болно.

375.2.Энэ хуулийн 375.1-д заасан хугацаа хэтэрсэн явдалд жуулчин гэм буруугүй бол дээрх хугацаа өнгөрснөөс хойш гомдол гаргаж болно.

376 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

376.1.Жуулчны шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан сар байна.

376.2.Хөөн хэлэлцэх хугацааг аялал жуулчлал зохион байгуулагч гомдлын шаардлагаас татгалзсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн тоолно.

377 дугаар зүйл. Хариуцлагыг хязгаарлах

377.1.Дараахь тохиолдолд аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчинтай зөвшилцөн үйлчилгээний хэлсийг гурав дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээгээр өөрийн хүлээх хариуцлагаа хязгаарлаж болно:

377.1.1.жуулчинд учирсан хохирол нь аялал жуулчлал зохион байгуулагчийн санаатай, болгоомжгүй үйлдлээс болоогүй;

377.1.2.аялал зохион байгуулахад оролцогч бусад үүрэг гүйцэтгэгчийн хэн нэгний гэм буруутай үйлдийн улмаас учирсан хохирлыг дангаараа бүрэн хариуцахаар аялал жуулчлал зохион байгуулагч үүрэг хүлээгээгүй.

378 дугаар зүйл. Гэрээнээс татгалзах эрх

378.1.Жуулчин аялал эхлэхээс өмнө хэдийд ч гэрээнээс татгалзаж болох бөгөөд энэ тохиолдолд аялал жуулчлал зохион байгуулагчгүйгээс хэмнэсэн зардал болон бусад үйлчилгээний төлөө аялал жуулчлал зохион байгуулагчид урьдчилан төлсөн төлбөрөө буцаан авах эрхтэй.

378.2.Энэ хуулийн 378.1-д заасан тохиолдолд аялал жуулчлал зохион байгуулагч гэрээгээр тохиролцсон хөлс авах эрхээ алдах боловч өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй.

379 дүгээр зүйл. Хуульд заасан журмыг өөрчилж үл болох

379.1.Талууд гэрээ байгуулахдаа энэ бүлэгт заасан журмыг жуулчинд хохиролтойгоор өөрчилж болохгүй.

ГУЧИН ТАВДУГААР БҮЛЭГ

Тээвэрлэлт

380 дугаар зүйл. Тээвэрлэлтийн гэрээ

380.1.Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хөлслэн төхирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

380.2.Зорчигч буюу ачаа, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд нийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрмээр тодорхойлогдоно.

381 дүгээр зүйл. Гэрээ байгуулах

381.1.Зорчигч буюу ачаа, тээш тээвэрлэхийг нийтэд санал болгож байгаа этгээд нь зайлшгүй татгалзах үндэслэл байхгүй бол тээвэрлэлтийн гэрээг заавал байгуулах үүрэгтэй.

382 дугаар зүйл. Зорчигч тээвэрлэлт

382.1.Зорчигч тээвэрлэлтийн гэрээг зорчих пайз, тасалбарыг зорчигчид гардуулснаар байгуулагдсан гэж үзнэ.

382.2.Зорчих пайз, тасалбарыг бусдад дамжуулахаар буюу үл дамжуулахаар үйлдэж болох бөгөөд бусдад дамжуулах боломж тээвэрлэлт эхлэхэд дуусна.

383 дугаар зүйл. Гэрээг цуцлах

383.1.Гэрээнд ямар нэгэн байдлаар саатал учруулахааргүй бол зорчигч нь тээвэрлэлтийн гэрээг хэдийд ч цуцлаж болох бөгөөд гэрээг цуцалснаас үүссэн хохирлыг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

383.2.Урьдчилан мэдэх боломжгүй байсан бөгөөд мэдсэн тохиолдолд гэрээг хийхгүй байх шалтгаан болохоор нөхцөл байдал тээвэрлэгчийн зүгээс илэрсэн, түүнчлэн гэрээнд заасан газарт хүрч очих болон замд явах хугацаа хожимдох магадлал байгаа тохиолдолд зорчигч гэрээг байгуулахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй.

384 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн хүлээх хариуцлага

384.1.Тээвэрлэлтийн явцад зорчигчид өөрт нь буюу түүний эд хөрөнгөд гэм хор учирсан, авч яваа зүйл нь алдагдсан, гэмтсэн бол тээвэрлэгч хууль болон тодорхой төрлийн тээврийн дүрэмд заасан хариуцлага хүлээнэ.

384.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний

шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл зорчигчийн буруугаас буюу түүний авч явсан зүйлээс шалтгаалж гэм хор учирсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй.

384.3.Тухайн төрлийн тээвэрийн хэрэгслийн жолооч болон бусад ажилтнуудын үйл ажиллагааны дутагдал, тээврийн хэрэгслийн бүрэн бус ажиллагаа, эвдрэл, эд материалын доголдол, дутагдал зэргээс зорчигчид хохирол учирсан нь тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

384.4.Тээвэрлэгчийн шууд санаатай буюу эгт болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй болон гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч нь сугацаа хожимдсоноос учирсан хохирлыг хариуцахгүй.

384.5.Тээвэрлэгчийн хариуцлагыг гэрээгээр згаарлах буюу чөлөөлж болохгүй.

385 дугаар зүйл. Зорчигчийн хүлээх хариуцлага

385.1.Зорчигч нь өөрийн буруутай үйл ажиллагаа, түүнчлэн авч яваа ачаа, тээш болон усад эд хөрөнгөөс шалтгаалж тээвэрлэгчид чирсан хохирлыг хариуцна.

385.2.Зорчигч нь ачаа тээвэрлэлтийн явцад баримтлах хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л өхцөл, журмыг чанд баримталсан бол хохирлыг ариуцахгүй.

386 дугаар зүйл. Ачаа тээвэрлэлтийн гэрээ

386.1.Ачаа тээвэрлэлтийн гэрээг дагалдах ичгийн хэлбэрээр байгуулна.

386.2.Дагалдах бичгийг гурван хувь үйлдэж, алуул гарын үсгээ зурж эхний хувийг ачаа лгээгчид үлдээж, хоёр дахь хувийг ачаанд авсаргаж, гурав дахь хувийг тээвэрлэгчид өгнө.

386.3.Ачааг хэд хэдэн тээврийн хэрэгслээр, схүл өөр өөр төрөл буюу тодорхой хэсэгт хуваж эвэрлэхээр бол тээвэрлэгч, ачаа илгээгч талууд чааны төрөл, тээврийн хэрэгслийн тоогоор агалдах бичиг үйлдэхийг шаардах эрхтэй.

386.4.Дагалдах бичиггүй, түүнийг утгадалтай үйлдсэн, эсхүл үрэгдүүлснээс үл амааран энэ бүлгийн холбогдох заалт эвэрлэлтийн гэрээний агуулга, хүчинтэй байх эхцөлд нэгэн адил хамаарна.

387 дугаар зүйл. Дагалдах бичгийн агуулга

387.1.Дагалдах бичигт дараахь зүйлийг усгасан байна:

387.1.1.дагалдах бичиг үйлдсэн газар, он, сар, өдөр;

387.1.2.ачаа илгээгчийн нэр, хаяг;

387.1.3.тээвэрлэгчийн нэр, хаяг;

387.1.4.ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр, газар болон хүргэх газар;

387.1.5.хүлээн авагчийн нэр, хаяг;

387.1.6.ачааны болон сав, баглаа, боодлын ердийн нэр, түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед түүний нийтээр хүлээн зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээ;

387.1.7.тээвэрлэх ачааны тоо, хэмжээ, тэмдэг, дугаар;

387.1.8.ачааны жин буюу хэмжээний талаархи бусад тэмдэглэл;

387.1.9.тээвэрлэлттэй холбогдсон зардал /тээврийн хөлс, нэмэлт зардал, гаалийн хураамж, гэрээ байгуулснаас ачааг хүргэх хүртэл гарах бусад зардал/;

387.1.10.хуульд заасан бусад нөхцөл.

387.2.Шаардлагатай гэж үзвэл талууд дагалдах бичигт дараахь зүйлийг тусгаж болно:

387.2.1.ачааг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэх, ачихыг хориглосон заалт;

387.2.2.тээвэрлүүлэгч хариуцах зардал;

387.2.3.ачаа илгээх үед төлөх нэмэгдэл үнийн хэмжээ;

387.2.4.ачааны өртөг, түүнийг дурдсан газарт хүргэх онцгой сонирхол;

387.2.5.тээвэрлүүлэгчээс ачааг даатгуулах тухай тээвэрлэгчид өгсөн заалт;

387.2.6.тээвэрлэлтийг дуусгахаар тохиролцсон хугацаа;

387.2.7.тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт.

388 дугаар зүйл. Тээвэрлэгчид ачааг хүлээлгэн өгөх

388.1.Тээвэрлэгч ачааг хүлээн авахдаа дараахь зүйлийг шалгах үүрэгтэй:

388.1.1.дагалдах бичигт заасан ачааны тоо, хэмжээ, тэмдэг үнэн зөв эсэх;

388.1.2.ачааны гадаад байдал, сав, баглаа, боодол.

388.2.Тээвэрлэгч энэ хуулийн 388.1.1-д заасан үүрэгээ гүйцэтгэх болололцоогүй бол энэ тухай болон ачааны гадаад байдал, сав, баглаа, боодлын талаар дагалдах бичигт тэмдэглэнэ.

388.3.Ачаа илгээгч нь ачааны жин болон бусад хэмжигдэхүүнээр тэмдэглэсэн түүний тоо, хэмжээ, түүнчлэн тээвэрлэх ачааны бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгаж, дагалдах бичигт тэмдэглэхийг тээвэрлэгчээс шаардаж болох бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг тээвэрлэгч хариуцна.

388.4.Тээвэрлэгч нь ачааг хүлээн авсан болон гэрээний агуулга эсрэгээр нотлогдох хүртэл дагалдах бичгийг гэрээ байгуулсны нотолгоо гэж үзнэ.

388.5.Ачааны дагалдах бичигт энэ хуулийн 388.2-д заасан тэмдэглэл ихгээгүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачааг хүлээн авахад түүний сав, баглаа боодлын гадаад байдал доголдолгүй, ачааны тоо хэмжээ, тэмдэг дугаар дагалдах бичигт заасантай тохирч байна гэж үзнэ.

388.6.Тээвэрлэгч ачааг хүлээн авах үед түүний илэрхий доголдлын талаар мэдэж байсан бөгөөд үүнтэй холбоотой ямар нэг болзол тавиагүйгээс бусад тохиолдолд ачааны сав, баглаа, боодлын улмаас бусдад учирсан хохирлыг ачаа илгээгч хариуцна.

388.7.Ачаа илгээгч нь ачааг зохих газарт хүргэхэд шаардагдах гаалийн болон бусад бүх баримт бичгийг дагалдах бичигт хавсаргах буюу тээвэрлэгчид өгч, тээвэрлэгчийг зохих мэдээллээр бүрэн хангах үүрэгтэй.

388.8.Тээвэрлэгч энэ хуулийн 388.7-д заасан баримт бичиг, мэдээллийн үнэн зөв болон хангалттай эсэхийг шалгах үүрэгтэй.

388.9.Тээвэрлэгчийн бруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд ачаа илгээгч нь баримт бичиг, мэдээллийн дутуу болон бруугаас учирсан гэм хорыг тээвэрлэгчийн өмнө хариуцна.

388.10.Дагалдах бичигт хавсаргасан буюу өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, бруугаар ашигласны хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ. Гэхдээ хариуцлагын хэмжээ нь ачааг үрэгдүүлснээс үүсэх хариуцлагаас ихгүй байна.

389 дүгээр зүйл. Ачааг захиран зарцуулах эрх

389.1.Ачаа илгээгч нь дагалдах бичигт дурдсанаас өөр газар буюу өөр этгээдэд ачааг хүргүүлэхгүй байх зорилгоор ачааг захиран зарцуулах, тээвэрлэлтийг зогсоох эрхтэй.

389.2.Тээвэрлэгч дагалдах бичгийн 2 дахь хувийг ачаа хүлээн авагчид өгснөөр ачаа илгээгчийн энэ хуулийн 389.1-д заасан эрх дуусгавар болох бөгөөд энэ үеэс тээвэрлэгч нь ачаа хүлээн авагчийн зааврыг биелүүлнэ.

389.3.Ачаа илгээгч нь дагалдах бичигт тусгай тэмдэглэл хийгээгүй бол ачаа хүлээн авагч нь дагалдах бичгийг хүлээн авсан үеэс эхлэн үг ачааг захиран зарцуулах эрхтэй болно.

389.4.Ачаа хүлээн авагч нь үг ачааг гуравдагч этгээдэд хүргүүлэхээр тээвэрлэгчид үүрэг хүлээлгэсэн бол гуравдагч этгээд нь ачаа хүлээн авагч өөр этгээдийг нэрлэх эрхгүй.

389.5.Ачааг захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэхэд дараахь жүрмыг баримтална:

389.5.1.ачаа илгээгч, эсхүл ачааг захиран зарцуулах эрхтэй хүлээн авагч нь тээвэрлэгчийг өгсөн шинэ зааврыг тусгасан дагалдах бичгийн эхний хувийг тээвэрлэгчид өгч, эдгээр зааврыг гүйцэтгэсний дараа түүнд учирсан зардал, хохирлыг нөхөн төлнө;

389.5.2.тээвэрлэгчид өгөх шинэ зааварнь хүлээн авмагц биелэгдэх боломжтой тээвэрлэгчийн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа болон ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн бусад ачаанд саад, гэм хор учруулахааргүй байвал зохино;

389.5.3.ачааг задлан хуваах зааварөгч болохгүй.

389.6.Ачааг задлан хуваах тухай зааврааболж түүнд өгсөн бусад зааврыг биелүүлэх боломжгүй бол тээвэрлэгч нь энэ тухайгаа зааварөгөгчид нэн даруй мэдэгдэнэ.

389.7.Тээвэрлэгч нь энэ зүйлд заасан журмын дагуу өгсөн зааврыг биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 389.5.1-д заасан дагалдах бичгийн эхний хувийг шаардалгүй этгээдэд зааврыгүйцэтгэснээс үүссэн гэм хорыг эрх бүхий этгээдийн өмнө хариуцна.

390 дүгээр зүйл. Хүлээн авагчид ачаа хүлээлгэн өгөх

390.1.Ачааг зохих газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь ачааг хүлээн авснбаталгаа болгож тээвэрлэгчээс дагалдах бичгийн 2 дахь хувийг шаардан авах эрхтэй.

390.2.Ачаа алдагдсан, дутсан буюу тохиролцсон хугацаандаа ирээгүй тохиолдолд ачаа хүлээн авагч нь гэрээнд заасан эрхийнхээ дагуу өөрийн нэрийн өмнөөс шаардлага гаргах эрхтэй.

390.3.Ачаа хүлээн авагч энэ хуулийн 390.2-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дагалдах бичгийн дагуу гарсан бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй бөгөөд энэ талаар маргаан гарсан тохиолдолд тээвэрлэгч өөрийн шаардлагыг хангах хүртэл ачааг хүлээн авагчид шилжүүлэхээс татгалзаж болно.

391 дүгээр зүйл.Тээвэрлэлтийг гэрээнд зааснаар гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал

391.1.Ачааг зохих газарт нь хүргэх, хүлээлгэн өгөхөөс өмнө тээвэрлэлтийн гэрээг дагалдах бичигт заасан нөхцөлөөр, эсхүл бүхэлд нь гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд тээвэрлэгч нь энэ хуулийн 389 дүгээр зүйлд заасны дагуу ачааг захиран зарцуулах эрхийг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

391.2.Нөхцөл байдал нь дагалдах бичигт зааснаас өөрөөр тээвэрлэхэд хүргэж, тээвэрлэгч нь эрх бүхий этгээдээс энэ хуулийн 389 дүгээр зүйлд заасан шинэ зааврыг зохих хугацаанд авч чадаагүй тохиолдолд тэрээр эрх бүхий этгээдийн ашиг сонирхолд илүү нийцэх арга хэмжээг авах үүрэгтэй.

391.3.Түргэн муудах ачаа, эсхүл ачааны нөхцөл байдал зайлшгүй шаардсан буюу хадгалалтын зардал нь ачааны өртгөөс давахаар бол тээвэрлэгч нь эрх бүхий этгээдийн зааврыг хүлээлгүйгээр ачааг худалдах шийдвэр гаргаж болно.

391.4.Ачааг энэ хуулийн 391.3-т заасны дагуу худалдсанаас олсон орлогоос ачаатай холбогдон гарах зардлыг хасаж, үлдсэнийг нь эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Ачаатай холбогдон гарах зардал ачааг худалдсан орлогоос давсан тохиолдолд тээвэрлэгч зөрүүг нөхөн төлүүлэхээр шаардаж болно.

391.5.Ачааг зохих газарт хүргэсний дараа түүнийг хүлээлгэн өгөхөд саад болох нөхцөл байдал үүсвэл тээвэрлэгч нь ачаа илгээгчээс зааварчилгаа шаардах эрхтэй.

391.6.Ачаа хүлээн авагч нь ачааг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд ачаа илгээгчээс өөр заавар өгөөгүй бол тээвэрлэгч нь ачааг хүлээн авахыг шаардаж болно.

391.7.Ачаа хүлээн авагч нь энэ хуулийн 389.4-т заасны дагуу ачааг гуравдагч этгээдэд хүлээлгэн өгөх заавар өгснөөс хойш ачааг хүлээлгэн өгөхөд саад болох нөхцөл байдал үүсч, энэ хуулийн 391.1, 391.2-т заасныг хэрэглэхэд хүлээн авагч нь ачаа илгээгчийн, 3 дахь этгээд нь хүлээн авагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

391.8. Энэ хуулийн 391.1, 391.3, 391.5-391.7-д заасан тохиолдолд тээвэрлэгч эрх бүхий этгээдийн зардлаар ачааг буулгаж болно. Энэ тохиолдолд тээвэрлэлтийг дууссанд тооцож тээвэрлэгч ачааг хадгалах буюу уг үүргийг гуравдагч этгээдэд даалгаж болно.

392 дугаар зүйл. Ачаа барьцаалах тээвэрлэгчийн эрх

392.1.Тээвэрлэлтийн зардлыг төлүүлэхийн тулд тээвэрлэгч нь ачааг захиран зарцуулах эрх үүсэх хүртэл ачааг барьцаалах эрхтэй.

393 дугаар зүйл. Тээвэрлэгчийн хариуцлага

393.1.Тээвэрлэгч ачааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хоцроосны хариуцлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцна.

393.2.Эрх бүхий этгээдийн буруугаас, эсхүл түүний зааварчилгыг биелүүлснээс ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн буюу тээвэрлэлтийн хугацаа хэтэрсэн, эсхүл дээрх нөхцөл байдал, түүний үр дагаврыг урьдчилан арилгах боломж тээвэрлэгчид байгаагүй бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

393.3.Тээвэрлэгч өөрийн буруугаас хохирол учруулсан бол түүний хүлээх хариуцлагыг хязгаарласан буюу нотлох үүргээс чөлөөлсөн энэ бүлэгт заасан журам хамаарахгүй.

393.4.Дараахь нөхцөл байдлын улмаас ачаа алдагдсан, дутсан буюу гэмтсэн бол тээвэрлэгч энэ хуулийн 393.6-393.8-д заасан хариуцлагаас чөлөөлөгдөнө:

393.4.1.талууд шууд тохиролцон, дагалдах бичигт тэмдэглэснээр задгай тээврийн хэрэгсэл ашигласан;

393.4.2.ачаа сав, баглаа, боодолгүй буюу түүний чанар муу байсан;

393.4.3.ачаа илгээгч, хүлээн авагч, эсхүл тэдгээрийг төлөөлөх гуравдагч этгээд ачаанд үзлэг хийж ачсан буюу буулгасан;

393.4.4.тодорхой төрлийн ачааны онцлогоос хамаарч эвдрэх, зэврэх, хатах, элэгдэх, хэвийн алдагдал гарах, асгарах болон мэрэгч амьтдын нөлөөлөл зэргээр хэсэгчлэн буюу бүрэн гэмтэх аюул байсан;

393.4.5.тээвэрлэх ачааны дугаар буюу тэмдэглэл шаардлага хангаагүй байсан;

393.4.6.амьтан тээвэрлэсэн.

393.5.Энэ хуулийн 393.4-т заасан нөхцөл байдал байсан боловч гэм хор учирсан шалтгаан нь дээрхээс өөр бол гэм хорыг тээвэрлэгч хариуна.

393.6.Энэ хуулийн 393.4-т заасан нэг буюу хэд хэдэн нөхцөлийн улмаас ачаа алдагдсан, дутсан буюу гэмтсэнд гэм бруруугй болохоо тээвэрлэгч нотолж чадвал хариуцлагаас чөлөөлөгдөнө.

393.7.Энэ хуулийн 393.4.1-д заасан тохиолдолд давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн бол энэ хуулийн 393.6 хамаарахгүй.

393.8.Энэ хуулийн 384.3-т заасан журам ачаа тээвэрлэгчид нэгэн адил хамаарна.

394 дүгээр зүйл. Гомдлын шаардлага гаргах

394.1.Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа тээвэрлэгчтэй хамт түүнийг шалгаагүй, эсхүл алдагдсан, дутсан ачааны болон учирсан хохирлын талаар ямар нэгэн шаардлага тээвэрлэгчид гаргаагүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачаа хүлээн авагч ачааг дагалдах бичигт заасан байдлаар хүлээн авсанд тооцно.

394.2.Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаархи шаардлагыг ачаа хүлээн авсан өдөр, харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачааг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор бичгээр тээвэрлэгчид гаргана.

394.3.Ачаа хүлээн авагч, тээвэрлэгч талууд ачааны байдлыг хамтран шалгасан боловч нуугдмал дутагдал, гэмтлийг тухайн үед илрүүлж чадаагүй бол ажлын 7 хоногийн дотор шалгасан үр дүнгийн талаар эсрэг нотолгоо гаргаж болно.

394.4. Ачаа хүлээн авагч хугацаа хэтэрсэнтэй холбоотой шаардлагаа ачаа хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор тээвэрлэгчид бичгээр гаргасан тохиолдолд хугацаа хэтэрснээс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

394.5.Энэ зүйлд заасан хугацааг тоолохдоо ачаа илгээсэн, шалгасан буюу хүлээлгэж өгсөн өдрийг оролцуулан тооцохгүй.

394.6.Тээвэрлэгч, ачаа хүлээн авагч талууд шаардлагатай шалгалт хийх, зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн хүчин зүйлүүдийг тогтооход бие биедээ харилцан туслах үүрэгтэй.

395 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

395.1.Тээвэрлэлтийн гэрээнээс үүсэх шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа нэг жил, санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол учирсан бол хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байна.

395.2.Дор дурдсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно:

395.2.1.ачаа алдагдсан, гэмтсэн өдрөөс буюу энэ тухай мэдсэн, мэдэх ёстой бол сүүлд өдрөөс, эсхүл хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн бол ачаа хүлээн авах байсан өдрөөс;

395.2.2.ачааны зарим хэсэг алдагдсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээгээр тохирсон ачаа хүлээлгэн өгөх хугацаа дуусснаас хойш 30 дахь өдрөөс, ийм хугацаа товлоогүй бол тээвэрлэгч ачаа хүлээн авснаас хойш 60 дахь өдрөөс;

395.2.3.бусад тохиолдолд гомдлын шаардлагын хариуг авсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс.

396 дугаар зүйл. Дамжуулан гүйцэтгэх тээвэрлэлт

396.1.Нэг гэрээгээр хэд хэдэн тээвэрлэгч тээвэрлэлтийг дамжуулан гүйцэтгэхээр байвал тээвэрлэгч бүр тээвэрлэлтийн үүргийг бүхэлд нь хариуцах бөгөөд дамжуулан тээвэрлэхээр ачаа хүлээн авч байгаа тээвэрлэгч ачаа болон дагалдах бичгийг хүлээн авснаар гэрээний тал болно.

396.2.Өмнөх тээвэрлэгчээс ачаар хүлээн авсан тээвэрлэгч түүнийг хүлээн авсан он, сар, өдрийг тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулсан, баримт бичгийг өмнөх тээвэрлэгчид өгөх үүрэгтэй бөгөөд дагалдах бичгийн 2 дахь хувь дээр өөрийн нэр, хаягийг заана.

396.3.Шаардлагатай тохиолдолд ачаа хүлээн авч байгаа тээвэрлэгч нь энэ хуулийн 388.2-т заасан тэмдэглэл болон ачаа хүлээн авсны гэрчлэх тэмдэглэлийг дагалдах бичгийн 2 дахь хувь дээр тусгаж болно.

396.4.Ачаа дамжуулан тээвэрлэхээд ачаа хүлээлгэн өгч байгаа болон хүлээн авч байгаа тээвэрлэгчидэд энэ хуулийн 388.4, 388.5 нэгэн адил хамаарна.

396.5.Ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн буюу хугацаа хэтэрснээс үүсэх гэм хорыг нөхөх төлүүлэх тухай шаардлагыг гаргахүү эхний болон

эцсийн тээвэрлэгчид, эсхүл ачаа үрэгдүүлж, гэмтээсэн буюу хугацаа хэтрүүлсэн тээвэрлэгчид гаргаж болох бөгөөд нэг шаардлагыг хэд хэдэн тээвэрлэгчид гаргах эрхтэй.

396.6.Тээвэрлэгч дараахь тохиолдолд сөрөг шаардлага гаргах эрхтэй:

396.6.1.ачаа алдсан, дутаасан буюу гэмтээсэн тээвэрлэгч хэд хэдэн тээвэрлэгчийн хамтран хариуцвал зохих гэм хорыг дангаар нөхөн төлсөн;

396.6.2.хэд хэдэн тээвэрлэгч ачааг алдсан, дутаасан, гэмтээсэн бол тус тусдаа өөрийн хүлээх хариуцлагад хувь тэнцүүлэн гэм хорыг нөхөн төлөх бөгөөд үүнийг тогтоох бололцоогүй тохиолдолд тээвэрлэгч тус бүр авсан хөлстэйгээ хувь тэнцүүлэн хариуцлага хүлээсэн;

396.6.3.тээвэрлэгчдийн хэн нь гэм хорыг нөхөн төлөхийг тогтоох бололцоогүйгээс энэ зүйлд заасны дагуу хувь тэнцүүлэн хариуцлага хүлээсэн.

396.7.Хэрэв тээвэрлэгчдийн хэн нэг нь төлбөрийн чадваргүй бол түүний төлөх ёстой байсан төлбөрийг бусад тээвэрлэгчид авсан хөлстэйгээ хувь тэнцүүлэн хариуцна.

396.8.Сөрөг шаардлага гаргаж байгаа тээвэрлэгч нь үндэслэлгүйгээр төлбөр гүйцэтгэсэн, эсхүл төлбөр нөхөн төлөх тухай шийдвэрийг шүүх гаргахдаа үүрэг бүхий этгээдэд зохих журмын дагуу урьдчилан мэдэгдсэн бөгөөд төрээр шүүх хуралдаанд оролцох боломжтой байгаад оролцоогүй бол сөрөг шаардлага гаргах буюу сөрөг шаардлагыг хангахаас татгалзах эрхгүй.

396.9.Ачаа дамжуулан тээвэрлэгчид нь энэ хуулийн 396.6, 396.7-д зааснаас бусад асуудлаар харилцан тохиролцож болно.

397 дугаар зүйл. Тээвэрлэлттэй холбоотой зарим хэлцэл хүчин төгөлдөр бус байх

397.1.Энэ хуулийн 396.9-д зааснаас бусад энэ бүлгийн заалтад харшилсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

397.2.Тээвэрлэгч ачааны даатгалаас үүсэх шаардлагаа, эсхүл нотлох үүргээ бусдад шилжүүлсэн аливаа хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

398 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх нэмэгдүүлсэн хариуцлага

398.1.Тээвэрлэгчид итгэмжлэн өгсөн ачаа нь онцгой ач холбогдолтой бол түүнийг алдсан буюу дутаасан тохиолдолд үнийг 2 нугалж төлүүлэхээр ачаа илгээгч буюу хүлээн авагч тал нь тээвэрлэгчтэй урьдчилан тохиролцож болно.

ГУЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даалгавар

399 дүгээр зүйл. Даалгаврын гэрээ

399.1.Даалгаврын гэрээгээр даалгавар үйлэтгэгч нь даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс, үүний зардлаар тодорхой үйлдэл хийх, хууль буюу эрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар өгөгч нь елс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

399.2.Даалгавар гүйцэтгэгчийн хийж байгаа ухайн үйлдэл зайлшгүй харуу төлбөрийн шинжтэй юл талууд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ.

399.3.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй ол даалгавар гүйцэтгэгч даалгаврыг биечлэн үйцэтгэх үүрэгтэй.

399.4.Ямар ч үед даалгавар өгөгч аалгавраа цуцлах, даалгавар гүйцэтгэгч аалгавраас татгалзах эрхтэй. Энэ эрхийг язгаарласан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

400 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгчийн үрэг

400.1.Даалгавар гүйцэтгэгч даалгаврыг даалгавар өгөгчийн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

400.2.Даалгавар өгөгчийн ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч зохих хугацаанд хариу авааргүй бол даалгавар гүйцэтгэгч уг зааврыг өөрчлөх эрхтэй.

400.3.Даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, даалгавар гүйцэтгэхэй холбогдуулан хүлээж авсан бүх зүйлийг даалгавар өгөгчид нэн даруй шилжүүлэх үүрэгтэй.

400.4.Даалгавар гүйцэтгэгч өгсөн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд түүнийг гүйцэтгэхэй холбогдуулан авсан зүйлийг гүйцэтгэгчийг даалгаврын хэмжээгээр даалгавар өгөгчид буцааж өгөх үүрэгтэй.

401 дүгээр зүйл. Даалгавар өгөгчийн үүрэг

401.1.Даалгавар өгөгч нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хүлээн авах, гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах зүйлийг даалгавар гүйцэтгэгчид олгох, даалгавар гүйцэтгэхтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг төлөх үүрэгтэй.

402 дугаар зүйл. Даалгаврын гэрээгээр хохирлыг нөхөн төлөх

402.1.Даалгаврыг бүрэн гүйцэтгээгүй байхад даалгавар өгөгч нь даалгавраа өөрчилсэн, эсхүл даалгавраа цуцалсан тохиолдолд даалгавар гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардал, учирсан хохирлыг даалгавар гүйцэтгэгчид төлөх бөгөөд хэлс төлөхөөр тохиролцсон бол гүйцэтгэсэн даалгаврын хэмжээгээр түүнийг төлөх үүрэгтэй.

402.2.Даалгавар өгөгчийн зааварчилгаар ажултай нөхцөл байдалд даалгавар гүйцэтгэснээс үүссэн хохиролд даалгавар гүйцэтгэгч буруугүй бол даалгавар өгөгч уг хохирлыг хариуцна.

403 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгч нас барах буюу хуулийн этгээд татан буугдах

403.1.Даалгавар гүйцэтгэгч иргэн нас барвал түүний өвлөгч гэрээ дуусгавар болсон тухай даалгавар өгөгчид мэдэгдэж, түүний эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

403.2.Даалгавар гүйцэтгэгч хуулийн этгээд татан буугдвал татан буулгах комисс, эсхүл татан буулгах ажлыг эрхлэн явуулж байгаа этгээд энэ тухай даалгавар өгөгчид мэдэгдэж, түүний эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

404 дүгээр зүйл. Даалгаврыг өөр этгээдэд шилжүүлэх

404.1.Гэрээнд заасан буюу даалгавар өгөгч эрх олгосон, эсхүл даалгаврыг биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон үед түүнийг өөр этгээдээр гүйцэтгүүлэх нь даалгавар өгөгчийн ашиг сонирхолд нийцэж байвал даалгавар гүйцэтгэгч нь түүнийг гүйцэтгүүлэхээр өөр этгээд /орлон гүйцэтгэгч/-д шилжүүлж болно.

404.2.Даалгаврыг бүрэн буюу түүний зарим хэсгийг орлон гүйцэтгэгчид шилжүүлсэн даалгавар гүйцэтгэгч энэ тухай даалгавар өгөгчид даруй мэдэгдэх бөгөөд орлон гүйцэтгэгчийн талаархи мэдээллээр даалгавар өгөгчийг хангах үүрэгтэй.

404.3.Даалгавар гүйцэтгэгч шаардлага хангахгүй этгээдийг орлон гүйцэтгэгчээр сонгон авснаас уг даалгаврыг гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл даалгавар гүйцэтгэгч нь энэ хуулийн 404.1, 404.2-т заасныг зөрчсөн бол орлон гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн үүргийн үр дагаврыг даалгавар гүйцэтгэгч хариуцна.

404.4.Даалгавар өгөгч нь даалгавар гүйцэтгэгчийн сонгон авсан орлон гүйцэтгэгчийг хэдийд ч өөрчлөх эрхтэй.

405 дугаар зүйл. Даалгаврын гэрээ дуусгавар болох

405.1.Даалгаврын гэрээ нь хууль буюу гэрээнд зааснаас гадна дараахь үндэслэлээр дуусгавар болно:

405.1.1.даалгавар өгөгч даалгаврыг цуцалсан;

405.1.2.даалгавар гүйцэтгэгч нь даалгавар биелүүлэхээс татгалзсан.

ГУЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө итгэмжлэх

406 дугаар зүйл. Хөрөнгө итгэмжлэх гэрээ

406.1.Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүрэг тус тус хүлээнэ.

406.2.Хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр хийнэ.

406.3.Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс, итгэмжлэгчийн зардал, эрсдлээр захиран зарцуулах үүрэгтэй.

406.4.Итгэмжлэгдсэн өмчлөгч гуравдагч этгээдтэй харилцаанд ороход өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь хариуцах бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

406.5.Гэрээнд өөрөөр заагаагүй бол итгэмжлэгдсэн өмчлөгч итгэмжилсэн хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулсны төлөө итгэмжлэгчээс хөлс авахгүй.

406.6.Итгэмжилсэн хөрөнгөөс олсон орлого үр шимийг итгэмжлэгч өмчилнө.

ГУЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Илгээмжийн гэрээ

407 дугаар зүйл. Илгээмжийн гэрээ

407.1.Илгээмжийн гэрээгээр илгээгч өөрийн нэрийн өмнөөс захиалагчийн зардлаар ачаа, илгээмжийг тээвэрлэхтэй холбоотой үйлдэл хийж, захиалагч гэрээнд заасан хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

407.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол илгээмжийн гэрээнд даалгаврын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

408 дугаар зүйл. Илгээгчийн эрх, үүрэг

408.1.Илгээгч нь илгээмжийн гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангахуйц байдлаар ачаа, илгээмжийг тээвэрлэх, тээвэрлэлтэд оролцох этгээдийг сонгох, захиалагчийн аливаа сонирхлын дагуу түүний өгсөн даалгаврыг биелүүлэх үүрэгтэй.

408.2.Захиалагч хүсвэл илгээгч илгээмжийг даатгуулах үүрэгтэй. Захиалагч хүсэлт гаргаагүй бол илгээгч ердийн нөхцөлийн дагуу илгээмжийг даатгуулж болно.

408.3.Захиалагч татгалзаж байгаагаа бичгээр тусгайлан илэрхийлээгүй бол илгээгч нь захиалагчийн зардлаар илгээгчийн үйлдлийн улмаас учирч болзошгүй гэм хорын даатгалын гэрээг өөрийн сонгосон даатгагчтай байгуулах бөгөөд энэ тухай захиалагчид мэдээлэх үүрэгтэй.

408.4.Энэ хуулийн 408.3-т заасан даатгалын гэрээг баримтлан захиалагч нь учирсан гэм хорын галаар илгээгчид нэн даруй мэдээлэх бөгөөд илгээгч уг мэдээллийг даатгагчид дамжуулна.

408.5.Илгээмж хүлээн авагч илгээмжийг хүлээн аваагүй, эсхүл бусад үндэслэлээр илгээмжийг хүлээн авах боломжгүй болсон бол илгээгчийн эрх, үүргийг тээвэрлэлтийн дүрмээр тодорхойлно.

408.6.Талуудын оролцоотойгоор илгээмжийг шалгах боломжгүй бол илгээмжийг хүлээн авагч нь ачаанд учирсан гэм хорыг олж огтоон илгээмжийг хүлээлгэн өгөгчид эдэгдсэнээс бусад тохиолдолд илгээмжийг бүрэн бүтэн, аливаа гэмтэлгүй болохыг хүлээн зөвшөөрч, хүлээж авсанд тооцно.

408.7.Хэрэв илгээмж илт дутагдсан, эсхүл эмтсэн байвал илгээмж хүлээн авагч энэ тухай илгээмжийг хүлээн авсан өдөрт нь багтааж илгээгчид мэдээлнэ.

408.8.Гэрээнд өөрөөр заагаагүй бол илгээгч илгээмжийг өөрийн зардал, хэрэгслээр тээвэрлэж болно. Энэ тохиолдолд илгээгч нь тээвэрлэгчтэй нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд энэ нь захиалагчийн эрх ашгийг үл хөндэнэ.

408.9.Илгээгч өөрөө, эсхүл түүний ажилтан гэм буруутай бол гэрээнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

408.10.Гуравдагч этгээд гэрээний талуудад гэм хор учруулсан бол илгээгч нь захиалагчийн эвшөөрснөөр түүний зардал, эрдэлээр шаардах эрх эдлэхээс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд шаардлага гаргах эрхийг захиалагчийн шаардсанаар түүнд шилжүүлэх үүрэгтэй.

408.11.Илгээгч, түүний ажилтан санаатай, эсхүл илт хайхрамжгүй хандаж захиалагчид гэм хор учруулсан бол тэдгээрийн хариуцлагыг хязгаарласан, эсхүл гэм буруу нотлох үүргийг бусдад ногдуулсан гэрээний заалтууд хүчин төгөлдөр бус байна.

409 дүгээр зүйл. Захиалагчийн эрх, үүрэг

409.1.Захиалагч илгээмжийн талаархи болон бусад шаардлагатай мэдээлэл, түүний тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг бүрдүүлж илгээгчид өгөх үүрэгтэй.

409.2.Захиалагч энэ хуулийн 409.1-д заасан мэдээллийг үнэн зөвийг нотлох баримтыг илгээгчид шилжүүлж өгөх үүрэгтэй.

409.3.Захиалагч тээвэрлүүлэхээр шилжүүлсэн илгээмжийн онцлог шинж чанар, учруулж болзошгүй аюул, аюулгүй ажиллагааны талаар илгээгчид мэдээлнэ.

409.4.Захиалагч энэ хуулийн 409.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол илгээгч түүний шилжүүлсэн илгээмжийг аль ч үед устгах, буулгах, эсхүл аюулыг нь арилгах арга хэмжээ авч болох бөгөөд үүний улмаас захиалагчид учирсан гэм хорыг нөхөн төлөхгүй.

409.5.Захиалагч илгээмжийг тээвэрлэлтийн шаардлагад нийцүүлэн баглах үүрэгтэй.

409.6.Илгээмжийг бусдаас ялгах шаардлагатай бол захиалагч илгээмжийг эрх бүхий этгээдэд хүргэхээс өмнө таних тэмдэг тавих үүрэгтэй.

409.7.Баглаа боодол, таних тэмдэггүй,

эсхүл тэдгээр нь дутуу буюу буруу байгааг илгээгч мэдсээр байж энэ талаар захиалагчид мэдээлээгүйгээс бусад тохиолдолд энэ хуулийн 409.5, 409.6-д заасан шаардлагыг биелүүлээгүйн улмаас учирсан гэм хорыг захиалагч хариуцна.

409.8.Захиалагч илгээмжийг нэг бүрчлэн шалгахыг илгээгчид даалгаж, нэмэлт хөлс төлж болно.

409.9.Захиалагч илгээмжийг илгээгчид шилжүүлсний дараа хөлсийг төлнө.

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Зуучлал

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

410 дугаар зүйл. Зуучлалын гэрээ

410.1.Зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх эгтээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүргийг тус тус хүлээнэ.

410.2.Хөлс, шагналын хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.

410.3.Хугацаа харилцан тохиролцоогүй бол зуучлалын гэрээг хэдийд ч дуусгавар болгож болно.

411 дүгээр зүйл. Зуучлах онцгой эрх

411.1.Зуучлах онцгой эрхийн гэрээгээр зуучлуулагч нь тодорхой хугацааны турш өөр зуучлагчийн үйлчилгээнээс татгалзах, зуучлагч энэ хугацаанд гэрээ байгуулахад туслалцаа үзүүлэх үүргийг тус тус хүлээнэ.

411.2.Зуучлуулагч энэ хуулийн 411.1-д заасан хугацаанд өөр зуучлагчаар үйлчлүүлэх гэрээ байгуулсан бол зуучлагч өөрт учирсан хохирлыг нотлогдсон хэмжээгээр нөхөн төлүүлэх эрхтэй. Худалдах-худалдан авах гэрээ байгуулахад зуучлах байсан бол нөхөн төлүүлэх хохирлын хэмжээ гэрээний үнийн хоёр хувиас хэтрэхгүй.

411.3.Зуучлуулагч нь зуучлагчийн тусламжгүйгээр гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд зуучлагчид хөлс, шагнал олгохоор тохиролцож болно. Худалдах-худалдан авах гэрээ байгуулахад зуучлах бол хөлс, шагналын хэмжээ гэрээний үнийн таван хувиас хэтрэхгүй.

411.4.Зуучлах онцгой эрхийн гэрээг бичгээр хийнэ.

411.5.Зуучлах онцгой эрхийн гэрээг зөвхөн онцгой нөхцөл байдал бий болсон үед цуцалж болно.

411.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зуучлах даалгаврыг өгснөөс хойш зургаан сар өнгөрвөл түүнийг хугацаа харгалзахгүйгээр цуцалж болно.

411.7.Зуучлагч гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний зүйл нь зуучлагчийн өмчлөлийн зүйл байсан бол зуучлуулагч нь зуучлагчид зуучлалын хөлс, шагнал болон зардлыг нөхөн төлөхгүй бөгөөд энэ журам хожим илэрсэн дараахь тохиолдолд нэгэн адил үйлчилнэ:

411.7.1.зуучлагч өөрөө гуравдагч этгээд байсан;

411.7.2.зуучлагч нь гуравдагч этгээдийн оролцдог хуулийн этгээд байсан;

411.7.3.гуравдагч этгээд нь зуучлагчийн оролцдог хуулийн этгээд байсан;

411.7.4.зуучлагч болон гуравдагч этгээд хоорондоо албан тушаалын болон хөдөлмөрийн харилцаатай байсан;

411.7.5.зуучлагч нь гуравдагч этгээдийн гэр бүлийн гишүүн байсан.

411.8.Зуучлагч гуравдагч этгээдтэй гэрээ байгуулахаас өмнө зуучлуулагчид энэ хуулийн 411.7-д заасан нөхцөл байдлыг урьдчилан мэдэгдсэн бол хөлс, шагнал авах буюу гаргасан зардлаа нөхөн төлүүлэх эрхтэй.

411.9.Зуучлагч гэрээг зөрчиж, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ажиллавал хөлс, шагнал авах буюу зардлаа нөхөн төлүүлэх эрхээ алдана.

411.10.Энэ хуулийн 411.7, 411.8-д заасан журмыг зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

412 дугаар зүйл. Зээлийн гэрээ байгуулахад зуучлах

412.1.Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээ байгуулахад зуучлахад зуучлалын гэрээний ерөнхий журам үйлчилнэ.

412.2.Зээлийн гэрээнд зуучлах гэрээг бичгээр хийнэ.

412.3.Гэрээнд зуучлалын хөлс, шагналын хэмжээ, зээлийн хэмжээ, хүү, төлөх хугацаа, төлбөрийн ханш, нэмэлт зардал, зээлдүүлэгчийн овог, нэр, хаяг зэргийг заана.

412.4.Зуучлуулагч зуучлалын дагуу зээл авсан тохиолдолд зээлийн зуучлагчид хөлс, шагнал төлнө.

Хоёрдугаар дэд бүлэг

Худалдааны зуучлагч, комисс

413 дугаар зүйл. Худалдааны зуучлагч

413.1.Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсхүл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

413.2.Энэ хуулийн 413.1-д зааснаас бусад хэлцэл болон үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийг худалдааны зуучлагчийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн тохиолдолд худалдааны зуучлагч гэж үзэхгүй.

413.3.Гэрээний талууд хориглоогүй буюу ухайн үүргээс чөлөөлөөгүй бол хэлцэл байгуулагдсаны дараа зуучлагч нь гэрээний талуудад хэлцлийн зүйл, нөхцөл, оролцогч тал, дараа, үнэт цаас худалдах худалдан авах гэрээ байсан бол тэдгээрийн төрөл, тоо, хэмжээ, гэрээний нэ, хугацаа зэргийг тусгасан баримтыг гарын үсэг урж олгоно.

413.4.Нэн даруй биелэгдэхээс бусад хэлцэлд энэ хуулийн 413.3-т заасан баримт бичигт талууд гарын үсэг зурна.

413.5.Хэрэв хэлцлийн нэг тал баримтад гарын үсэг зурах буюу эсхүл түүнийг хүлээн авахаас татгалзвал худалдааны зуучлагч нөгөө талд нэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

413.6.Нөгөө талыг заагаагүй худалдааны зуучлагчийн баримтыг талуудын аль нэг нь хүлээн авсан бөгөөд хожим мэдэгдсэн талын эсрэг үндэслэл бүхий гомдол гаргаагүй бол түүнтэй хэлцэл хийсэн гэж үзнэ.

413.7.Гэрээний нэг талыг зуучлагч ердийн эломжит буюу үүргийн шинж чанарт тохирсон хугацаанд нөгөө талд мэдэгдэх үүрэгтэй.

413.8.Гэрээний нэг тал нь нэрлэгдээгүй, эсхүл нэрлэгдсэн этгээдийн эсрэг үндэслэл бүхий гомдол гаргасан бол нөгөө тал нь гэрээ байгуулахтай холбогдсон үр дагаврыг шаардах эрхтэй.

413.9.Дээж авах замаар барааг худалдаж байвал худалдааны зуучлагч нь барааны дээжид тусгай тэмдэг тавих, дээжийг гэрээний талуудад олгох зорилгоор худалдан авагч барааны чанарт гомдол гаргалгүйгээр хүлээж авах хүртэл хадгалах үүрэгтэй.

413.10.Талууд хоорондын зуучлалын үр дүнд байгуулагдсан гэрээнээс худалдааны зуучлагч аливаа ашиг олох, эсхүл мөнгөн төлбөр авах эрхгүй.

413.11.Худалдааны зуучлагч өөрийн буруугаас үүссэн хохирлыг талуудын өмнө хариуцна.

413.12.Худалдааны зуучлагчид олгох зуучлалын хөлс, шагналыг хэн төлөх талаар тохиролцоогүй бол гэрээний талууд тогтоосон хөлс, шагналыг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй.

414 дүгээр зүйл. Худалдааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл

414.1.Худалдааны зуучлагч өдөр бүр дэс дараатай тэмдэглэл хөтөлж, түүнд байгуулсан бүх хэлцлээ бүртгэж, тухай бүр гарын үсэг зурна.

414.2.Худалдааны зуучлагч гэрээний талуудын шаардсан үед тэмдэглэлээс зуучлалын тусламжтайгаар байгуулсан хэлцлийн тухай мэдээллийг агуулсан өөрийн гарын үсэгтэй баримтыг олгох үүрэгтэй.

415 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч, комисс

415.1.Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх, үйлчилгээг борлуулахад зуучилж байгаа этгээдийг худалдааны төлөөлөгч гэнэ.

415.2.Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэнэ.

415.3.Худалдааны төлөөлөгч буюу комисс нь үйлчлүүлэгчийн заавраар түүний эрх ашиг,

ердийн шаардлагад нийцүүлэн үүргээ гүйцэтгэж, үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол улирал бүрийн сүүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс, шагналын тооцоо, комиссийн төлберийн дүн зэргийг агуулсан тайланг үйлчлүүлэгчид гаргаж өгнө.

415.4.Сар бүрийн эцэст үйлчлүүлэгч хөлс, шагналыг, комисс нь олсон ашгаа үйлчлүүлэгчид тус тус төлнө.

415.5.Үйлчлүүлэгч гэрээнд заасан нөхцөлийг биелүүлээгүй, эсхүл зуучлалын үндсэн дээр зохих хэлцэл байгуулаагүй бол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхтэй.

415.6.Хэрэв хэлцлийг үйлчлүүлэгчийн бус негөө талын бууруагаас байгуулаагүй бол хөлс, шагнал шаардах эрх үүсэхгүй.

415.7.Хэлцэл хийгч негөө тал үүргээ гүйцэтгэж чадахгүй болох нь тогтоогдвол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхээ алдаж, өмнө авсан хөлс, шагналыг үйлчлүүлэгчид буцаан өгнө.

415.8.Комисс нь бараг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд түүнд энэ тухай нэн даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч хариу өгөөгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно.

415.9.Барааг илүү ашигтайгаар худалдсан тохиолдолд олсон ашиг нь үйлчлүүлэгчид үлдэнэ.

416 дугаар зүйл. Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээ

416.1.Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг, хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.

416.2.Хөлс, шагналыг төлбөр төлөх талын төлберийн дүнгээс тооцох бөгөөд ингэхдээ төлберийг бэлэн мөнгөөр гүйцэтгэсний хөнгөлөлт, төлбөр тооцоо, савлалт, гаалийн хураамж, татвар төлөх зэргэтэй холбогдон үүссэн нэмэлт зардлыг хасаж бодно.

416.3.Нэмэлт зардлыг гуравдагч этгээд төлсөн тохиолдолд энэ хуулийн 416.2 хамаарахгүй.

416.4.Даатгалын гэрээнд даатгалын үнийн дүнгээс хөлс, шагналыг тооцох бөгөөд ийм үнийн дүн байхгүй бол даатгалын хураамжаас тооцно.

417 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч, комиссөт байгуулах гэрээний хугацаа

417.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол худалдааны төлөөлөгчтэй байгуулах гэрээ нэг жилийн хугацаатай байна. Гэрээний хугацаа дуусгавар болохоос гурван сарын өмнө түүнийг цуцлах тухай санал гаргагчийг гаргагчийг бол гэрээг нэг жилээр сунгасанд тооцно.

418 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгчид олгох нөхөн олговор

418.1.Худалдааны төлөөлөгч гэрээ дуусгавар болсны дараа үйлчлүүлэгчээс дараахь тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй:

418.1.1.үйлчлүүлэгч худалдааны төлөөлөгчийн зуучлалаар шинэ үйлчлүүлэгчтэй ажил хэргийн харилцаанд давуу эрх олж авсан;

418.2.1.шинээр хамрагдсан үйлчлүүлэгчтэй байгуулсан хэлцлийг сунгасныг хөлс, шагнал авах эрхээ алдсан.

418.2.Шинээр үйлчлүүлэгч хамруулсан гэдэгт үйлчлүүлэгч их хэмжээний ашиг олох боломжтой ажил хэргийн холбоо тогтоосныг ойлгоно.

418.3.Нөхөн олговор нь худалдааны төлөөлөгчийн үйл ажиллагааны сүүлийн таван жилд авч байсан, эсхүл нэг жилд олох хөлс, шагналын дундаж хэмжээнээс илүүгүй байна. Нэг жилээс доош хугацаатай байгуулсан гэрээнд худалдааны төлөөлөгчийн үйл ажиллагааны хугацаанд олж болох хөлс, шагналын дундаж дүнгээс тооцно.

418.4.Нөхөн олговор олгохыг шаардах эрхээс татгалзах, гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг урьдчилан олгохыг хориглоно.

418.5.Гомдол дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус байна:

418.5.1.үйлдвэрийн үйл ажиллагаань гэрээг цуцлах үндэслэл болсноос бусад тохиолдолд худалдааны төлөөлөгч өөрийн санаачилгаар гэрээг цуцалсан, эсхүл өндөр нас, өвчний улмаас үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон;

418.5.2.худалдааны төлөөлөгчийн бууруудаг үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгч гэрээг цуцалсан;

418.5.3.үйлчлүүлэгч, худалдааны төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу худалдааны төлөөлөгчийн оронд гэрээний харилцаанд гуравдагч этгээд оролцож байгаа.

418.6.Энэ хуулийн 418.5.3-т заасан хэлцлийг гэрээ дуусгавар болохоос өмнө байгуулж

үл болно.

418.7.Нөхөн олговор авах эрхийг гэрээ дуусгавар болсон үеэс эхлэн нэг жилийн дотор хэрэгжүүлнэ.

419 дүгээр зүйл. Хариуцлага

419.1.Бий болсон нөхцөл байдлаас шалтгаалж өөрийн бүрэн эрхээс татгалзах эрхгүй байсан комисс нь үйлчлүүлэгчийн өгсөн зааврыг зөрчин үйл ажиллагаа явуулсан, эсхүл үйл ажиллагаанаас орсон орлогыг бүрэн хэмжээгээр шилжүүлээгүйгээс үйлчлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлнө.

419.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал нөлөөлснээс бусад тохиолдолд өөрт нь хариуцуулсан эд хөрөнгийг алдсан, дутаасан, гэмтээсэн комисс нь учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

419.3.Комисс, худалдааны төлөөлөгч нь хэлцлийн тодорхой талууд байгаа тохиолдолд хэлцлээс үүсэх бүх үүргийг хариуцна гэж үйлчлүүлэгчид урьдчилан бичгээр баталгаа гаргаж тусгай шагнал авч болно.

419.4.Комисс, худалдааны төлөөлөгч нь үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өөр өрсөлдөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг төлөөлөхийг хориглох бөгөөд харин гэрээ байгуулах үед худалдааны төлөөлөгч, комисс нь өрсөлдөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг төлөөлж байгааг үйлчлүүлэгч мэдэж байсан бол зөвшөөрөл олгосон гэж үзнэ.

419.5.Худалдааны төлөөлөгч энэ хуулийн 419.4-ийг зөрчвөл үйлчлүүлэгч учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

419.6.Гэрээ дуусгавар болсны дараа өрсөлдөгч байгууллагад ажиллахыг хориглосон нөхцөлийг гэрээнд тусгасан бол энэ нь үйлчлүүлэгч нөхөн төлбөр хийж байгаа тохиолдолд хүчинтэй байх бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг энэ хуулийн 418 дугаар зүйлд заасан журмаар тооцно.

419.7.Гэрээ дуусгавар болсны дараа өрсөлдөгч байгууллагад ажиллахыг хориглосон нөхцөлтэй гэрээний хугацаа нэг жилээс илүүгүй байна.

ДӨЧДҮГЭЭР БҮЛЭГ

Шагнал олгохоор нийтэд амлах, уралдаант шалгаруулалт

420 дугаар зүйл. Шагнал олгохоор нийтэд амлах

420.1.Тодорхой үйлдэл хийсэн, эсхүл тодорхой үр дүн бий болгосон этгээдэд шагнал олгохоор амлаж нийтэд зарласан этгээд уг үйлдэл хийсэн буюу үр дүн бий болгосон этгээдэд шагнал олгох үүрэг хүлээнэ.

420.2.Энэ хуулийн 420.1-д заасан үйлдэл хийсэн буюу үр дүн бий болгосон этгээд түүнийг зарлалын дагуу гүйцэтгээгүй ч зарлалд заасан болзлыг хангасан бол шагнал авах эрхтэй.

420.3.Шагнал олгохоор амласан этгээд нийтэд зарласан үйлдлийг хийх буюу үр дүн бий болохоос өмнө зарласан арга, хэлбэр, журмаар, эсхүл тусгайлан мэдээлэх замаар уг амлалтыг хүчингүй болгож болно.

420.4.Зарласан хугацаанд болзлыг хангах нь эргэлзээтэй болсон тохиолдолд амлалтыг хүчингүйд тооцох тухай шагнал олгохоор нийтэд зарлахдаа зааж болно.

420.5.Шагнал олгох амлалтын болзлыг хэд хэдэн этгээд хангасан бол болзлыг хамгийн түрүүнд хангасан этгээд шагналыг авна.

420.6.Шагнал олгох амлалтын болзлыг хэд хэдэн этгээд нэгэн зэрэг хангасан бол шагналыг гүйцэтгэгч бүрт ижил хувь хэмжээгээр хуваж олгоно.

420.7.Шагнал нь үл хуваагдах шинжтэй буюу нийтэд зарласан амлалтын агуулгын дагуу гацхүү нэг этгээд авах бол шагнал авах этгээдийг сугалаагаар тогтооно.

421 дүгээр зүйл. Уралдаант шалгаруулалт

421.1.Ямар нэгэн ажлыг гүйцэтгэх тодорхой болзлыг хангаж шалгарсан этгээдэд шагнал буюу эрх олгохоор нийтэд зарласан иргэн, хуулийн этгээд нь зарласан болзол өсөор шалгарсан этгээдэд тухайн шагнал буюу эрхийг олгох үүрэг хүлээнэ.

421.2.Уралдаант шалгаруулалтын болзолд гүйцэтгэх ажил, түүний хугацаа, тодорхой эрх олгох нөхцөл, шагналын тоо, хэмжээ, гүйцэтгэсэн ажил буюу төслийг шалгаруулах журам, хугацааг тодорхой заах бөгөөд эдгээрээс бусад нөхцөлийг оруулж болно.

421.3.Нэгэнт зарласан уралдаант шалгаруулалтын болзлыг өөрийн хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар зайлшгүй өөрчлөх

шаардлагатай бол үг ажлыг гүйцэтгэн ирүүлэхээр тогтоосон хугацааны дотор өөрчилж болно.

421.4.Уралдаант шалгаруулалтад ирүүлбэл зохих ажлын талаар тавих шаардлага ихээхэн өөрчлөгдөхөөр байвал үг ажлыг гүйцэтгэн ирүүлэх хугацааг түүнд зохицуулан сунгана.

421.5.Уралдаант шалгаруулалтын болзолд орсон өөрчлөлтийг уралдаант шалгаруулалт зарласан журмаар зарлах бөгөөд ийнхүү зарлаагүй бол уралдаант шалгаруулалтын болзол өөрчлөгдсөн гэж үзэхгүй.

421.6.Уралдаант шалгаруулалт зарласан этгээд уралдаант шалгаруулалтад оролцогчоос түүнд оролцохыг зөвшөөрсөн харию буюу холбогдох материалыг хүлээн авснаас хойш саналаасаа татгалзах эрхгүй бөгөөд татгалзсан тохиолдолд болзол хангасан оролцогч зарласан шагналыг авахаар шаардах эрхтэй.

421.7.Уралдаант шалгаруулалт зарласан этгээд энэ зүйлд заасан журмыг зөрчсөн бол түүний улмаас оролцогчдод учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

421.8.Уралдаант шалгаруулалт зарласны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээл туурвисан бөгөөд үг бүтээл нь уралдаант шалгаруулалтын шагнал авсан бол уралдаант шалгаруулалт зарласан этгээд түүнийг уралдаант шалгаруулалтын болзолд дурдсан аргаар ашиглах эрхтэй бөгөөд болзолд өөрөөр заагаагүй бол энэхүү бүтээлийн зохиогч бүтээлээ ашиглуулсны хөлс, шагналыг авах эрхтэй.

421.9.Хууль болон болзолд өөрөөр заагаагүй бол уралдаант шалгаруулалтад шалгарч тодорхой шагнал буюу эрх авааг ажил, түүнчлэн шагналд орсон буюу эрх авсан боловч дараа нь ашиглахаар болзолд зарлаагүй ажлыг уралдаант шалгаруулалт дуусмагц даруй буцаан өгнө.

421.10.Уралдаант шалгаруулалтаар зарласан ажлыг хэд хэдэн этгээд гүйцэтгэсэн бол шагнал олгохд энэ хуулийн 420.5, 420.6-д заасан журмыг баримтална.

ДӨЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хадгалалт

422 дугаар зүйл. Хадгалалтын гэрээ

422.1.Хадгалалтын гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчаас шилжүүлэн өгсөн хөдлөх эд хөрөнгийг хадгалах үүрэг хүлээнэ.

422.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалалт төлбөргүй байх бөгөөд хэрэв хадгалагч хадгалалтыг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ.

422.3.Хадгалагч дараахь эрх, үүрэгтэй:

422.3.1.хадгалалтыг төлбөргүй гүйцэтгэж байгаа бол хадгалж байгаа эд хөрөнгийг өөрийн эд хөрөнгийн адил нөхцөлөөр хадгалах;

422.3.2. хадгалж байгаа эд хөрөнгийг хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

422.3.3.хадгалуулсан эд хөрөнгийг зайлшгүй ашиглах шаардлагатай болсноос бусад тохиолдолд хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг ашиглахгүй байх;

422.3.4.шаардлагатай тохиолдолд хадгалуулагчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр хадгалж байгаа эд хөрөнгийн хадгалалтын журмыг өөрчлөх;

422.3.5.хадгалж байгаа эд хөрөнгийн талаар гаргасан гуравдагч этгээдийн шаардлагыг хадгалуулагчид мэдэгдэх;

422.3.6.хадгалуулсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах;

422.3.7.хадгалалтын хугацаанд хадгалж байгаа эд хөрөнгөөс бий болсон үр шимийг хадгалуулагчид шилжүүлэх;

422.3.8.хадгалалтын хөлс, шагнал, хадгалалтаас үүссэн зардлыг төлөх хүртэл хадгалуулсан эд хөрөнгийг буцааж шилжүүлэхээс татгалзах.

422.4.Хадгалуулагч дараахь эрх, үүрэгтэй:

422.4.1.хадгалагчид эд хөрөнгө хадгалсны зайлшгүй зардлыг төлөх;

422.4.2.хадгалалт төлбөртэй бол хадгалалтын гэрээ дуусгавар болсон тохиолдолд хадгалагчид хөлсийг төлөх;

422.4.3.тухайн эд хөрөнгийн аюултай шинж чанарыг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байснаас бусад тохиолдолд хадгалуулж

йгаа эд хөрөнгээс үүссэн хохирлыг хадгалагчид
өхөн төлөх.

422.5.Хадгалагч нь хадгалагдаж байгаа эд
өрөнгийг хадгалуулагчийн зөвшөөрлөөр гуравдагч
гтгэзэд шилжүүлсэн тохиолдолд үр дагаврыг
адгалуулагч хариуцна.

422.6.Хадгалалтын гэрээний хугацаа
үүссэн эд хөрөнгийг хадгалуулагчид бүцаан өгөх
ед хадгалагч өөрийн санаатай буюу илтэд
олгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг
ариуцна.

422.7.Талууд өөрөөр тохиролцоогүй бол
адгалж байгаа эд хөрөнгийг гэрээнд заасан газар
уцаан шилжүүлэх бөгөөд тээвэрлэлтээс гарах
ардлыг хадгалуулагч хариуцна.

**423 дугаар зүйл. Хадгалалтын гэрээний
угацаа**

423.1.Хадгалалтын гэрээг тодорхой буюу
одорхой бус хугацаагаар байгуулж болно.

423.2.Тодорхой бус хугацаагаар байгуулсан
рээг талууд хэдийд ч дуусгавар болгох эрхтэй
оловч нөгөө талдаа үүрэг гүйцэтгэх боломжийн
угацаа олгоно.

**424 дүгээр зүйл. Хадгалалтын гэрээний
алуудын хариуцлага**

424.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол
одгалагч нь хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгийг
одсан, дутагдуулсан, гэмтэсэнээс хадгалуулагчид
ирсан хохирлыг төлнө.

424.2.Эд хөрөнгийг хадгалалтад шилжүүлэх
ед мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан
ынарын дутагдлын талаар хадгалуулагч нь
одгалагчид мэдэгдээгүй, эсхүл энэхүү дутагдлын
талаар хадгалагч, хадгалуулагчийн хэн аль нь
эдээгүй буюу мэдэх боломжгүй байснаас
алтгаалан хадгалагчид учирсан хохирлыг
дгалуулагч төлөх үүрэгтэй.

424.3.Хадгалалтын болон эд хөрөнгийг хадгалуулахаар шилжүүлэх хугацаат хэтрүүлсэн тохиолдолд анз төлөхөөр тохиролцсон бол буруутай тал нь гэрээнд заасан анзыг төлнө.

425 дугаар зүйл. Хадгалж байгаа эд хөрөнгийг бүцаан авахыг шаардах эрх

425.1.Хадгалалтын гэрээг тодорхой хугацаатай байгуулсан эсэхээс үл хамааран хадгалуулагч хадгалуулсан эд хөрөнгөө хэдийд ч бүцаан авахаар шаардах эрхтэй.

426 дугаар зүйл. Хадгалалтын онцгой гэрээ

426.1.Хадгалуулагч орлуулан сольж болох нэг төрлийн эд хөрөнгийг чанар, тоо ёсоор нь бүцаан авах нөхцөлтэйгөөр хадгалагчийн өмчлөлд шилжүүлэн хадгалуулсан гэрээнд зээлийн гэрээний журмыг баримтална.

427 дугаар зүйл. Зочид буудалд эд зүйл үлдээх

427.1.Зочид буудал, амралт, сувиллын газар болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь үйлчлүүлэгчид олгосон өрөө, тасалгаанд байгаа үйлчлүүлэгчийн тусгай жүрмаар хүлээлгэн өгөх ёстой мөнгө, үнэт эдлэлээс бусад эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ гүйцэтгээгүйгээс эд хөрөнгө алдагдсан, гэмтсэн, үгүй болсон бол үйлчлүүлэгчид учирсан хохирлыг хариуцна.

427.2.Энэ хуулийн 427.1-д заасан хохирол нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл тухайн үйлчлүүлэгч, түүнийг дагалдаж байгаа этгээдийн үйлдэл буюу үг эд хөрөнгийн өөрийн шинж чанараас шалтгаалан үүссэн бол зочид буудал, сувиллын газар хариуцлага хүлээхгүй.

427.3.Хохирлыг нөхөн төлөх үүрэг тээврийн хэрэгсэлд орхисон эд хөрөнгөд хамаарахгүй.

ДӨЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах

**428 дугаар зүйл. Барааны агуулахад эд
рөнгө хадгалуулах гэрээ**

428.1.Хуульд өөрөөр заагаагүй бол барааны
уулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний
дгалагч нь эд хөрөнгийг хүлээн авахад түүний
нар, төрөл, жин, хэмжээ, тоо болон бусад шинжийг
лгах үүрэг хүлээхгүй.

428.2.Хадгалагчид шилжүүлж байгаа эд хөрөнгө шилжүүлэлтийн үеийн гадаад үзэгээр гэмтсэн, эсхүл иж бүрдэл дутуу болох нь мэдэгдэж байвал хадгалагч хадгалуулагчид энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүйгээс хадгалуулагчид учирсан хохирлыг нөхөн төлнө.

428.3.Хадгалагч нь хадгалагдаж байгаа эд хөрөнгийг өөр агуулахад шилжүүлэх болон түүний шинж өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх аюул учирч байгаа талаар өөрийн мэдэж байгаа агуулахын баримтын сүүлчийн хэзээшигчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол хохирлыг хариуцна.

428.4.Хадгалагч нэг төрлийн эд хөрөнгийг гапцхүү өмчлөгчийн зөвшөөрөлтэйгээр түүнтэй ижил төрлийн эд хөрөнгөтэй нийлүүлж хадгалж болно. Ийнхүү нийлүүлснээс бий болсон эд хөрөнгө нь хадгалуулагчдын дундын өмч болох бөгөөд хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалуулсан эд хөрөнгийн хэмжээгээр тодорхойлно.

428.5.Хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалагч бусад хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр буцаан өгөх эрхтэй.

428.6.Хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгө нь өөрийн үнэ цэнийг алдахуйцаар гэмтэж өөрчлөгдсөнийг хадгалагч эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд иймхүү мэдэгдэх цаг хугацаа хүрэлцэхгүй бүюу мэдэгдэх боломжгүй бол түүнийг хүдалдах эрхтэй.

428.7.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээнд хадгалалтын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

429 дүгээр зүйл. Агуулахын баримт

429.1.Хадгалагч хадгалуулахаар шилжүүлж өгсөн эд хөрөнгийг хүлээн авахдаа хадгалуулагчид агуулахын баримт олгоно.

429.2.Агуулахын баримтад дараахь зүйлийг заавал тусгана:

429.2.1.агуулахын баримт олгосон огноо, бүртгэлийн дугаар;

429.2.2.гэрээний талуудын нэр, хаяг;

429.2.3.эд хөрөнгийг хадгалах газар;

429.2.4.хадгалах эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт;

429.2.5.хадгалалтын хөлс, бусад зайлшгүй зардлын хэмжээ;

429.2.6.хадгалах эд хөрөнгийг даатгуулах бол даатгалын үнэ;

429.2.7.гэрээний хугацаа;

429.2.8.хадгалагчийн гарын үсэг, тамга, тэмдэг.

429.3.Талууд энэ хуулийн 429.2-т заасна бусад нөхцөлийг агуулахын баримтад нэмж тусг болно.

429.4.Энэ хуулийн 429.2-т заасан нөхцөл агуулахын баримтад бүрэн тусгаагүй нь талууд хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

429.5.Агуулахын баримт эзэмшигч нь өө үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор эд хөрөнг агуулахаас гаргахгүй гэсэн баталгаа гарга агуулахад байгаа эд хөрөнгөө барьцаалж болно.

429.6.Хадгалагч зөвшөөрсөн б хадгалуулагч агуулахын баримтыг бичилт хи гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

429.7.Агуулахын баримтыг бичилтийн да шилжүүлсэн бол хадгалагч нь түүнд дурдс мэдээллийн үнэн зөвийг баримт эзэмшигчийн өм хариуцах бөгөөд харин уг мэдээллийг хадгалуула эсхүл гуравдагч этгээдийн өгсөн мэдээлли үндэслэсэн гэж уг баримтад тэмдэглэсэн б хадгалагч хариуцлага хүлээхгүй.

429.8.Хадгалагч мэдээлэл буруу таш гэдгийг мэдэж байсан бол баримтад тэмдэгл хийсэн ч энэ хуулийн 429.7-д заасан хариуцла хүлээнэ.

429.9.Эд хөрөнгийг нийлүүлж хадгало тохиолдолд хадгалагч энэ хуулийн 429.7-д заа тэмдэглэлийг хийх эрхтэй.

429.10.Агуулахын зөвшөөрлийн бари олгосон хадгалагч хадгалж байгаа эд хөрөнг гапцхүү агуулахын баримтын хууль ёс эзэмшигчид олгоно.

429.11.Агуулахын барьцааны бари олгосон бол хадгалагч түүнийг буцаан авах шаардах эрхтэй.

429.12.Хадгалагч бичилт хийн шилжүүл баримтын үнэн эсэхийг шалгах үүрэгтүй бөг шилжүүлэлт нь агуулахын баримт дахь зо тэмдэглэлээр баталгаажна.

429.13.Агуулахын баримт, эсхүл барьцаа баримтыг гээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд хү ёсны эзэмшигч нь үрэгдүүлсэн баримт бичг хүчингүйд тооцуулахаар шүүхэд өргөдөл гар болох бөгөөд хадгалагч шүүхийн шийдвэр үндэслэн агуулахын болон барьцааны баримтуу шинээр олгоно.

429.14.Агуулахад хадгалуулаха шилжүүлсэн эд хөрөнгийг барьцаалахад өмчлөг

барьцааны баримтад тусгай тэмдэглэл хийж түүнийг шилжүүлнэ.

429.15.Бичилт хийн шилжүүлсэн баримтад хадгалуулагч, зээлдүүлэгч болон тэдгээрийн үүргийн талаархи мэдээллийг тусгана.

429.16.Эд хөрөнгө хадгалуулсан баримтыг шилжүүлсэн тухай хадгалагчид мэдэгдэх бөгөөд хадгалагч зохих бичилтийг хийнэ.

429.17.Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

429.18.Агуулахын баримтыг бичилт хийн шилжүүлсэн бол шинэ эзэмшигчид барьцаалах эрх үүснэ.

430 дугаар зүйл. Хадгалалтын хугацаа дуусгавар болох

430.1.Хадгалалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, хугацаа тогтоогоогүй бол эд хөрөнгө хадгалуулахаар шилжүүлсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор хадгалагч эд хөрөнгөө буцаан авахыг хадгалуулагчаас шаардах эрхтэй.

430.2.Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын баримт эзэмшигч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд арван дөрөв хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй.

430.3.Эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хадгалалтын явцад гарсан зайлшгүй зардал, хөлсийг хасаж, үлдсэн хэсгийг агуулахын баримт эзэмшигчид шилжүүлнэ.

ДӨЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ
Даатгал

431 дүгээр зүйл. Даатгалын гэрээ

431.1.Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ.

431.2.Даатгалын зүйл нь эд хөрөнгө, ургэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол байна.

431.3.Даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

431.4.Даатгалын гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

431.4.1.даатгалын зүйл;

431.4.2.даатгалын эрсдэлийн өрөл;

431.4.3.даатгалын үнэлгээний эмжээ;

431.4.4.даатгалын хугацаа, түүнийг ахин сунгах нөхцөл;

431.4.5.даатгалын хураамжийн эмжээ, түүнийг төлөх хугацаа;

431.4.6.даатгагч, даатгуулагчийн эх, үүрэг, хариуцлага;

431.4.7.гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

432 дугаар зүйл. Даатгалын төрөл, хэлбэр

432.1.Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн төрөлтэй байна.

432.2.Заавал даатгах даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

432.3.Энэ хуулийн 432.2-т зааснаас бусад даатгал сайн дурын даатгалд хамаарна.

433 дугаар зүйл. Даатгалын баталгаа

433.1.Даатгагч нь гарын үсэг зурсан даатгалын баталгааг даатгуулагчид гардуулах үүрэгтэй.

433.2.Даатгалын баталгааг тодорхой этгээдэд нэр заасан буюу мэдүүлгийн баталгааны хэлбэрээр олгосон бол даатгагч нь анхны даатгуулагчид тавих бүх шаардлагыг баталгаа эзэмшигчид гаргаж болно. Даатгалын баталгаа эзэмшигч нь даатгалтай холбогдсон эрхээ шилжүүлж байгаагаа даатгагчид мэдэгдсэн бөгөөд эрх шилжүүлэгч шаардлагаа нэн даруй гаргасан бол энэ журам хамаарахгүй.

433.3.Даатгуулагч гагцхүү даатгалын баталгаа үзүүлсэн тохиолдолд даатгагч үүргээ гүйцэтгэхээр гэрээнд заасан бөгөөд баталгааг алдаж үрэгдүүлсэн бол тусгай журмын дагуу уг баталгаа хүчингүй болсон тухай зарлан мэдэгдсэн тохиолдолд л даатгуулагч гэрээний биелэлтийг

шаардах эрхтэй.

433.4.Даатгалын баталгааг алдаж үрэгдүүлсэн боловч энэ хуулийн 433.3-т заасны дагуу зарлуулсан бол даатгуулагч нь баталгааны хүүлбар олгохыг даатгагчаас шаардаж болох бөгөөд хуулбар олгохтой холбогдсон зардлыг даатгуулагч хариуцна.

434 дүгээр зүйл. Даатгалын гэрээ дуусгавар болох үндэслэл

434.1.Даатгалын гэрээний хугацааг даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож тогтооно.

434.2. Даатгалын гэрээ дараахь тохиолдолд дуусгавар болно:

434.2.1. хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

434.2.2. даатгагч, даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан;

434.2.3. шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

434.2.4. даатгуулсан эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураасан;

434.2.5. талууд тохиролцож гэрээг цуцалсан;

434.2.6. даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.

435 дугаар зүйл. Даатгалын гэрээг цуцлах

435.1.Даатгалын гэрээг 5 жилээс илүү хугацаагаар байгуулсан бол нэг тал нь гэрээ цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа цуцалж болно.

435.2.Даатгалын гэрээг нэг жилээс дээш хугацаагаар сунгах нөхцөлтэйгээр байгуулсан тохиолдолд талууд гэрээний хугацааг дуугүй хүлээн зөвшөөрөх замаар сунгах, даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахгүй байх тохиролцоо хүчин төгөлдөр бус байна. Даатгуулагч гэрээг цуцлахдаа энэ хуулийн 435.1-д заасан хугацааг баримтлах үүрэгтэй.

435.3.Даатгагч даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн тохиолдолд даатгуулагч нь 1 сарын дотор гэрээг цуцалж болно.

436 дугаар зүйл. Гэрээ цуцалж болох нөхцөл нөхцөл байдал

436.1.Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох нөхцөл нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаа хойш бий болсон ийм нөхцөл байдлын талаар даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

436.2.Даатгагч нь гэрээнээс татгалзах буюу гэрээний агуулгыг өөрчлөх шийдвэр гаргахад нөлөөлж болох, түүнчлэн даатгагч нь даатгуулагчаас тодорхой, хоёрдмол утгагүй санаагүйгээр шууд, бичгээр асуусан нөхцөл байдлын нөхцөлийг тооцно.

436.3.Даатгуулагч энэ хуулийн 436.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол даатгагч нь гэрээнээс татгалзах, эсхүл энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцлах буюу даатгалын хэрээмжийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийн шаардах эрхтэй. Харин даатгуулагч аюулын санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг хэдийч цуцалж болно.

436.4.Даатгуулагч энэ хуулийн 436.2-т заасан нөхцөл нөхцөл байдлын тухай мэдээлэх гэрээ байхад даатгагч санаатайгаар зайлсхийсэн, эсхүл даатгагч тухайн нөхцөл байдлын талаар мэдэж байсан бол энэ хуулийн 436.3-т заасан журам үйлчлэхгүй.

436.5.Нөхцөл нөхцөл байдлын тухай мэдээнд буруу ташаа баримт дурдсан бол даатгагч гэрээнээс татгалзаж болох бөгөөд даатгагч нь мэдээ баримтын буруу ташаар мэдэж байсан, эсхүл ийм мэдээ ирүүлсэнд даатгуулагч буруугүй бол гэрээнээс татгалзах эрхгүй.

436.6.Даатгуулагч аюул учрах нөхцөл байдлын тухай бичгээр мэдээлэх үүргээ санаатайгаар биелүүлээгүй бол даатгагч гэрээ цуцлах эрхтэй.

436.7.Даатгалын тохиолдол бий болсноо хойш даатгагч гэрээ цуцлахаар мэдэгдсэн бөгөөд даатгуулагч нөхцөл нөхцөл байдлын талаар даатгагчид мэдээлэх үүргээ биелүүлээгүй нь даатгалын тохиолдол бий болох болон даатгагчаас үүргээ биелүүлэхэд нөлөөлөөгүй бол даатгагч үүргээ чөлөөлөгдөхгүй.

437 дугаар зүйл. Даатгалын хураамж төлөх үүрэг

437.1.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол даатгагч хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацааг дахин хэтрүүлбэл үүсэх үр дагаврын даатгагч бичгээр мэдэгдэнэ.

437.2.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол

бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй.

437.3.Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй.

437.4.Даатгагчийн төлбөрийн чадвар үлэмж доройтож, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөл бий болсон бол даатгуулагч даатгалын хураамж төлөхөөс татгалзах эрхтэй.

438 дугаар зүйл. Даатгалын үнэлгээний хэмжээ

438.1.Даатгалын үнэлгээний хэмжээг талууд харилцан тохиролцож тодорхойлно.

438.2.Эд хөрөнгийг даатгах тохиолдолд даатгагч эд хөрөнгийг үзэж үнэлгээний хэмжээг тогтоох эрхтэй.

438.3.Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ түүний өртгөөс илүүгүй байна.

438.4.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс илүү байвал эд хөрөнгийн өртгөөс илүү гарсан хэсэгт нь гэрээ хүчин төгөлдөр бус байна.

438.5.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ эд хөрөнгийн өртгөөс бага байвал даатгалын тохиолдол бий болоход даатгагч даатгуулагчид учирсан хохирлыг даатгуулсан эд хөрөнгийн өртөгт даатгалын үнэлгээний хэмжээг хувь тэнцүүлэн бодож нөхөн төлбөр олгоно.

438.6.Даатгалын гэрээгээр энэ хуулийн 438.5-д зааснаас илүү хэмжээгээр нөхөн төлбөр төлөхөөр зааж болох боловч энэ нь даатгалын үнэлгээний хэмжээнээс хэтэрч болохгүй.

438.7.Даатгалын гэрээнд заасан бол даатгалын тохиолдол бий болсны улмаас олж надаагүй ашиг, орлогыг даатгалын үнэлгээний хэмжээнд хамааруулж болно.

438.8.Даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс үлэмж их болох нь тогтоогдвол даатгагч даатгалын үнэлгээний хэмжээг бууруулах, даатгуулагч хураамжийг багасгахыг тус тус шаардах эрхтэй.

438.9.Даатгуулагч даатгалын үнэлгээний хэмжээг зориуд өсгөсөн бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох бөгөөд энэ байдлыг даатгагч гэрээ байгуулах үедээ мэдээгүй байсан бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцохоос өмнө даатгуулагчийн төлсөн хураамж даатгагчид үлдэнэ.

439 дүгээр зүйл. Даатгалын тохиолдол бий болох үед даатгагч, даатгуулагчийн хүлээх үүрэг

439.1.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

439.2.Даатгалын тохиолдол бий болсон үед даатгагч даатгалын тохиолдол буюу нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг даатгуулагчаас шаардах эрхтэй.

439.3.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсныг мэдээлэх үүргээ биелүүлээгүй боловч энэ нь даатгагчийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулаагүй бол даатгагч үүргээс чөлөөлөгдөхгүй.

439.4.Даатгалын тохиолдол бий болж, даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа даатгагч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.

439.5.Даатгуулагч нь даатгалын тохиолдол бий болох үед аюулыг зайлуулах буюу хохирлыг багасгах арга хэмжээг даатгагчийн өгсөн зааврын дагуу авах бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч хариуцна.

440 дүгээр зүйл. Даатгалын төлөөлөгчийн эрх

440.1.Даатгалын төлөөлөгч даатгалын гэрээ байгуулах эрхтэй.

440.2.Даатгалын төлөөлөгчид даатгалын гэрээ байгуулах эрх олгосон бол гэрээний нөхцөлийг өөрчлөх, хугацааг сунгах буюу гэрээг цуцалж болно.

441 дүгээр зүйл. Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгал

441.1.Даатгуулагч өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд ашигтайгаар даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр үүсэх бүхий л эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд /цаашид "ашиг сонирхол бүхий этгээд"-гэх/ эдлэх боловч даатгалын баталгаа олгохыг гаргүүлэх даатгуулагч шаардах эрхтэй.

441.2.Ашиг сонирхол бүхий этгээд зөвхөн даатгалын баталгаат өөртөө авсан тохиолдолд даатгуулагчтай зөвшилцөхүйгээр гэрээнд заасан эрхээ эдлэх буюу иймхүү эрхээ хэрэгжүүлэхээр шүүхэд хандах эрхтэй.

441.3.Даатгагч даатгуулагчид даатгалын

баталгаа олгосон бол даатгуулагч ашиг сонирхол бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр гэрээ ёсоор эдлэх аливаа эрхийг эдлэх, гэрээнд заасанаар шагнал авах, эсхүл ашиг сонирхол бүхий этгээд даатгалын баталгаа авсан нөхцөлд түүнд эрхийг нь шилжүүлэх эрхтэй.

441.4.Ашиг сонирхол бүхий этгээд даатгалын гэрээг хүлээн зөвшөөрч байгааг даатгуулагч нотолсон тохиолдолд даатгагч ашиг сонирхол бүхий этгээдийн төлөө нөхөн төлбөр гүйцэтгэх үүрэгтэй.

442 дугаар зүйл. Нийгмийн даатгал

442.1.Нийгмийн даатгалын төрөл, хэлбэрийг хуулиар тогтооно.

442.2.Нийгмийн даатгалтай холбогдон үүсэх харилцааг хуулиар зохицуулна.

443 дугаар зүйл. Гэм хорын даатгал

443.1.Гэм хорын даатгалаар даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр менгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

443.2.Иж бүрдэл бүхий эд хөрөнгө даатгуулсан бол түүний бүрэлдэхүүнд багтах бүх эд хөрөнгөд даатгал нэгэн адил хамаарна.

443.3.Төлсөн даатгалын хураамж нь даатгалын тохиолдол бий болоход учирсан хохирлоос илүү эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид учирсан хохирлын хэмжээгээр нөхөн төлбөр төлнө.

443.4.Даатгуулагч нэг ашиг сонирхлыг хэд хэдэн даатгагчид нэгэн зэрэг даатгуулсан бол энэ тухай даатгагч бүрд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

443.5.Энэ хуулийн 443.4-т заасан тохиолдолд даатгалын үнэлгээний хэмжээ нь нийлбэр дүнгээрээ даатгуулсан эд хөрөнгийн өртөөс давсан бүүу өөр шалтгаанаар хохирлыг нөхөн төлөх хэлбэрээр олгох менгө нь нийлбэр дүнгээрээ хохирлын хэмжээнээс давж байвал даатгагчид хамтран үүргээ биелүүлнэ. Энэ тохиолдолд даатгуулагч хохирлын хэмжээнээс давсан нөхөн төлбөр шаардах эрхгүй.

443.6.Тусгай гэрээнд заасан тохиолдолд дайны үед учирсан гэм хорыг даатгагч хариуцна.

443.7.Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ. Харин даатгуулагч гуравдагч этгээдэд шаардлага гаргах буюу шаардлагыг хангуулах эрхээсээ татгалзсан бол тэр хэмжээгээр даатгагч гэм хорыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

443.8.Хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах даатгуулагчийн эрх нь түүнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүнд хамааралтай бол уг гишүүн санаатай хохирол учруулснаас бусад тохиолдолд түүний зөвшөөрөлгүйгээр шаардах эрхийг шилжүүлж болохгүй.

443.9.Даатгуулсан эд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлсэн бол даатгуулагчийн эрх шинэ өмчлөгчид шилжинэ. Эд хөрөнгө ийнхүү шилжсэнийг даатгуулагч болон шинэ өмчлөгч даатгагчид нэн даруй мэдэгдэнэ.

443.10.Даатгуулагч болон шинэ өмчлөгч энэ хуулийн 443.9-т заасан үүргээ биелүүлээгүй тухай даатгагч мэдвэл зохих байсан үеэс хойш 1 сар өнгөрсний дараа даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

443.11.Даатгагч гэрээг цуцлах 1 сарын хугацаагаар баримтлан эд хөрөнгийн шинэ өмчлөгчтэй даатгалын харилцаагаа дуусгавар болгох эрхтэй.

443.12.Энэ хуулийн 443.9-т заасанаар эд хөрөнгө өөр этгээдэд шилжсэнийг даатгагч мэдсэнээс хойш 1 сарын дотор шинэ өмчлөгчтэй даатгалын гэрээг дуусгавар болгох эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх хүчингүй болно.

443.13.Даатгалын эрх шилжүүлэн авсан этгээд нэн даруй буюу даатгалын тухайн үе дуусахад даатгалын гэрээг цуцлах эрхтэй.

443.14.Шинэ өмчлөгч эд хөрөнгө шилжүүлэ авахдаа даатгалын гэрээний тухай мэдээгүй бөгөөд энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээ цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх нь хүчингүй болно.

443.15.Гэрээг энэ хуулийн 443.11, 443.13-т заасан үндэслэлээр цуцалсан бол зөвхөн эрхээ шилжүүлсэн даатгуулагч даатгагчид даатгалын хураамж төлөх үүрэгтэй бөгөөд хураамж нь гэрээ цуцлах үеийг оролцуулан тооцсон гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байсан хугацаанд төлбөл зохих хэмжээнээс хэтрэхгүй. Энэ тохиолдолд эрх шилжүүлэн авсан этгээд даатгалын хураамж төлөх үүрэг хүлээхгүй.

443.16.Гуравдагч этгээдийн ашиг сонирхлы төлөө амь нас даатгах гэрээ байгуулах тохиолдол уг этгээд буюу түүний хууль ёсны төлөөлөгчий зөвшөөрлийг бичгээр авна.

443.17.Амь насаа даатгуулсан этгээд амиа хорлосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

443.18.Гуравдагч этгээдээд ашигтайгаар амь нас даатгасан тохиолдолд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий гуравдагч этгээдийн хууль бус үйлдлийн улмаас даатгагдсан этгээд нас барсан бол уг этгээд даатгалын нөхөн төлбөр авах эрхээ алдана.

443.19.Даатгалтай холбоотой шаардлагыг ханган шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж байгаа буюу даатгагч дампуурсантай холбоотой хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол даатгалын гэрээнд нэр заагдсан даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд даатгуулагчийн оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй. Даатгуулагч дампуурсантай холбоотойгоор даатгалын гэрээ цуцлагдсан нөхцөлд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд нь даатгагчаас шаардвал зохих мөнгөний хэмжээгээр дампуурлын үед даатгуулагчийн бусдад хуваарилагдах хөрөнгийг бүрдүүлэхэд оролцох үүрэгтэй.

443.20.Хэрэв даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд энэ хуулийн 443.19-д заасан эрхийг эдлэх сонирхолгүй буюу гэрээнд даатгалын нөхөн төлбөр авах этгээдийн нэрийг заагаагүй бол даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагч уг эрхийг эдэлж болно.

444 дүгээр зүйл. Хариуцлагын даатгал

444.1.Хариуцлагын даатгалаар даатгагч нь даатгалын хугацаанд үүсэх хариуцлагатай холбоотойгоор гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгуулагчийг чөлөөлөх үүрэгтэй.

444.2.Гуравдагч этгээд өөрт учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр даатгагчид шууд шаардлага гаргасан бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргийн хэмжээнд уг гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ.

444.3.Гуравдагч этгээдийн шаардлагаас өөрийгөө хамгаалах зорилгоор гаргасан шүүхийн болон шүүхийн бус бусад зардлыг хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй нөхөн төлөх шаардлагатай бол энэхүү зардал даатгалд нэгэн адил хамаарна.

444.4.Гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхэд хүргэсэн нөхцөл байдлыг даатгуулагч санаатай бий болгосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

444.5.Даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээсээ бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдсөн байсан ч заавал даатгах даатгалын хувьд даатгагчийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага хүчин төгөлдөр байна.

444.6.Энэ хуулийн 444.5-д заасан үүргийнхээ дагуу даатгагч нь гуравдагч этгээдийн шаардлагыг ханган бол гуравдагч этгээдээс даатгуулагчид гаргах шаардлага даатгагчид шилжинэ.

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Зээл тооцооны үүрэг

Нэгдүгээр дэд бүлэг

Төлбөр тооцоо

445 дугаар зүйл. Төлбөр тооцооны гэрээ

445.1.Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид "төлбөр тооцоо үйлчгэгч" гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид "харилцагч" гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

445.2.Хуульд өөрөөр заагаагүй бол бэлнээр хийх төлбөр тооцоог банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэж болно.

445.3.Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэж болно.

445.4.Төлбөр тооцоо гүйцэтгэгч нь харилцагчийн өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

445.5.Хуульд өөрөөр заагаагүй бол дансан дахь мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах харилцагчийн эрхийг төлбөр тооцоо гүйцэтгэгч хязгаарлах, хянах эрхгүй.

445.6.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь харилцагчийн төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгах эрхтэй.

445.7.Төлбөр тооцооны гэрээгээр талууд төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлс төлөхөөр тохиролцож болно.

445.8.Банк, төлбөр тооцоо хийх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хийх төлбөр тооцооны харилцааг хуулиар зохицуулна.

446 дугаар зүйл. Төлбөр тооцоо гүйцэтгэгчийн үүрэг

446.1.Төлбөр тооцоо гүйцэтгэгч дараахь үүрэгтэй:

446.1.1.бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;

446.1.2.гэрээнд заасан хугацаанд харилцагчид түүний дансны талаар мэдээлэл, дансны хуулга өгөх;

446.1.3.харилцагчийн данснаас түүний өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндэсн дээр гүйлгээ хийх;

446.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх;

446.1.5.алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, харилцагчийг хохиролгүй болгох;

446.1.6.харилцагчийн хэвийн үйл ажиллагаат алдагдуулахгүй байх;

446.1.7.хуульд заасан бусад үүрэг.

447 дугаар зүйл. Харилцагчийн эрх

447.1.Харилцагч дараахь эрхтэй:

447.1.1.өөрийн данс, гүйлгээний талаархи мэдээллийг хэдийд ч авах;

447.1.2.мөнгөн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах;

447.1.3.хуульд заасан бусад эрх.

447.2.Энэ хуулийн 447.1.2-т заасан тохиолдолд харилцагч нь төлбөр тооцоо гүйцэтгэчид нэн даруй мэдэгдэх бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэгч нь төлбөрийн даалгаварт заасан мөнгийг харилцагчийн дансанд буцаан оруулна.

448 дугаар зүйл. Төлбөр тооцооны гэрээг цуцлах

448.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд төлбөр тооцооны гэрээг хэдийд ч харилцан тохиролцож цуцалж болно.

449 дүгээр зүйл. Аккредитив

449.1.Аккредитив нээсэн банк нь үйлчлүүлэгчийн гаргасан хүсэлт, өгсөн үүрэг, зааврын дагуу гуравдагч этгээд /төлбөр авагч/-ээс тодорхой бичиг баримт хүлээн авч, харин нь түүнд буюу түүний заасан этгээдэд мөнгө шилжүүлэх, төлбөр авагчийн бичсэн шилжих вексельд заасан төлбөрийг төлөх буюу зөвшөөрөх, эсхүл уг гүйлгээг гүйцэтгэхийг өөр банкинд даалгах үүрэг хүлээнэ.

449.2.Үйлчлүүлэгч нь харилцан тохиролцсон хэлсийг банкинд төлнө.

449.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

450 дугаар зүйл. Инкасс

450.1.Инкассийн төлбөр тооцоогоор төлбөр тооцоо гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн өгсөн даалгаврын дагуу, түүний зардлаар, төлбөр хариуцагчаас төлбөрийг хүлээн авах буюу төлбөр хийх үүрэг хүлээнэ.

450.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

Хоёрдугаар дэд бүлэг

Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох

451 дүгээр зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ

451.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.

451.2.Зээлийн гэрээг бичгээр хийнэ.

451.3.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

452 дугаар зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүү

452.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно.

452.2. Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.

452.3.Зээлдүүлэгч зээлийн хүүгийнхээ хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

453 дугаар зүйл. Зээлдэгчийн хариуцлага

453.1.Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй.

453.2.Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дуусан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй.

Гуравдугаар дэд бүлэг

Мөнгөн хадгаламж

454 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээ

454.1.Мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн төмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.

454.2.Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс талуудын хүлээх хариуцлагыг тусгана.

454.3.Мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат болон хүүльд заасан бусад арга хэрэгслийг ашиглан бичгээр байгуулна.

454.4.Хадгалуулагч хэдийд ч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах эрхтэй.

454.5.Хуульд өөрөөр заагаагүй бол банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд хадгалуулагчийн мөнгөн хадгаламжийн хүүцыг хадгалах, холбогдох гүйлгээний талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

454.6.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийг даатгуулж болно.

454.7.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаагүйгээ хуулиар зохицуулна.

454.8. Мөнгөн хадгаламжийн гэрээгээр хадгалуулсан мөнгөө шаардахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

455 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа

455.1.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна.

455.2.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол хадгалагч нь хадгалуулагчийн хүссэн цагт түүний хадгалуулсан мөнгийг бүцаан өгч, хүүг төлөх үүрэгтэй.

455.3.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол банк үг хугацаа дуусаны дараа хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх бөгөөд гэрээнд заасан хугацаа дуусан болоч хадгалуулагч мөнгөө буцаан авах шаардлага тавиагүй бол уг гэрээг цаашид тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно.

455.4.Тодорхой хугацаагаар байгуулсан гэрээг банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нэг талын саналчилгаар өөрчлөх, хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй.

456 дугаар зүйл. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн мэдээлэл

456.1.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд санхүүгийн тайлан, мэдээллийг хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлэх үүрэгтэй.

456.2.Банк, мөнгөн хадгаламжийн үйл

ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд өөрийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдлын талаархи мэдээллийг хадгалуулагчид гаргаж өгөх үүрэгтэй.

456.3.Энэ хуулийн 456.2-т заасан мэдээллийг буруу, ташаа мэдээлсэн банк нөхөх хариуцлага хүлээнэ.

Дөрөвдүгээр дэд бүлэг

Банкны баталгаа

457 дугаар зүйл. Банкны баталгааны гэрээ

457.1.Банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

457.2.Баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүргээ үндэсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргээс үл хамааран гүйцэтгэнэ.

457.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол баталгаа гаргагч банк нь нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхгүй.

457.4. Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд өөрөөр заагаагүй бол банкны баталгааны талаархи шаардах эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

457.5.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн баталгаа бүхий үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь баталгаа гаргагч банкнаас мөнгөн төлбөр төлөхийг бичгээр шаардана.

457.6.Энэ хуулийн 457.5-д заасан шаардлагыг банкны баталгааны гэрээнд заасан хугацаанд гаргана.

457.7.Баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хүлээн авсан даруй үүрэг гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэж, үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага болон түүнд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг шилжүүлнэ.

457.8.Баталгаа гаргагч банк ердийн боломжит хугацааны дотор үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргасан шаардлага, түүнд хавсаргасан баримт бичиг нь гэрээний нөхцөл нийцэж байгаа эсэхийг тогтооно.

457.9.Үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргасан шаардлага, түүнд хавсаргасан баримт бичиг нь гэрээний нөхцөлд нийцээгүй, эсхүл гэрээнд заасан хугацаанд гаргаагүй бол баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ.

457.10.Банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас өмнө үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн, тухайн үүрэг бусад үндэслэлээр дуусгавар болсон, эсхүл хүчин төгөлдөр бус болсон бол баталгаа гаргагч банк энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ. Үүрэг гүйцэтгүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш баталгаа гаргагч банкнаас мөнгөн төлбөр төлөхийг дахин шаардвал банк шаардлагыг хангаж, гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.

457.11.Баталгаа гаргагч банкны хүлээх хариуцлага гэрээнд заасан хэмжээгээр хязгаарлагдана.

457.12.Банкны баталгааны гэрээнд өөрөөр заагаагүй бол баталгаа гаргагч банкны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас хүлээх хариуцлага энэ хуулийн 457.11-д заасан хэмжээнээс үл хамаарна.

457.13.Баталгаа гаргагч банкны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болно:

457.13.1.баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;

457.13.2.гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон;

457.13.3.үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд заасан шаардах эрхээсээ татгалзсан.

457.14.Баталгаа гаргагч банкны үүрэг энэ хуулийн 457.13-т заасны дагуу дуусгавар болсон бол банк энэ тухай нэн даруй үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

457.15.Банк, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж төлсөн мөнгийг үүрэг гүйцэтгэгчид сөрөг нэхэмжлэл гаргах замаар буцаан авах журмыг баталгаа гаргагч болон үүрэг гүйцэтгэгч гэрээгээр харилцан тохиролцоно.

457.16.Баталгаа гаргагч банк гэрээний нөхцөлийг зөрчиж үүрэг гүйцэтгүүлэгчид төлбөр төлсөн, эсхүл энэ хуулийн 457.12-т заасны дагуу хариуцлага хүлээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэгчээс дээрх мөнгийг шаардах эрхгүй.

457.17.Энэ хуулиар зохицуулаагүй банкны баталгаатай холбогдсон бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар зохицуулна.

ДӨЧИН ТАВДУГААР БҮЛЭГ

Батлан даалт

458 дугаар зүйл. Батлан даалтын гэрээ

458.1.Батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө батална, гүйцэтгэхгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээнэ.

458.2.Ирээдүйд бий болох, эсхүл болзол бүхий үүргийг хариуцаж батлан даалтын гэрээ байгуулж болно.

458.3.Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгтэй адилхан.

458.4.Үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсноор түүний гүйцэтгэлийг хангах тухай батлан даалтын гэрээ хүчин төгөлдөр бус болно.

458.5.Батлан даалтын гэрээг байгуулснаар үүрэг гүйцэтгэгчийн хийсэн хэлцлээс бий болох үр дагаврыг батлан даагч хариуцахгүй.

459 дүгээр зүйл.Батлан даалтын гэрээний хэлбэр

459.1.Батлан даалтын гэрээг бичгээр байгуулна.

459.2.Ажил үүргийнхээ хүрээнд батлан даалт гаргасан бол батлан даалтын гэрээг бичгээр байгуулахгүй байж болно.

459.3.Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд түүний өмнөөс батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг батлан даалтын гэрээнд тохиролцсон.

460 дугаар зүйл. Батлан даагчийн хариуцлага

460.1.Батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс нөхөх хариуцлага хүлээнэ.

460.2.Үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг батлан даагч үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцахаар гэрээнд заасан бол үүрэг гүйцэтгэгч өргөж хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт тодорхой байвал үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэхийг батлан даагчаас шаардах эрхтэй.

460.3.Хэд хэдэн этгээд батлан даагч байх тохиолдолд тэдгээр нь батлан даалтыг хамтран гаргасан эсэхээс үл хамааран үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хамтран хүлээнэ.

460.4.Батлан даагч батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

460.5.Батлан даагч нь энэ хуулийн 460.4-т заасан хэмжээний дотор дараахь төлбөрийг төлнө:

460.5.1.үндсэн өр;

460.5.2.гэрээнд заасан бол анз, учирсан гэм хор;

460.5.3.гэрээг дуусгавар болгохтой холбогдон гарсан зардал;

460.5.4.шүүхийн зардал;

460.5.5.гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэгчийн үндсэн гэрээний дагуу төлөх ёстой хүү.

461 дүгээр зүйл. Батлан даагчийн эрх, үүрэг

461.1.Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид шаардлага гаргавал үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох бүх татгалзлыг батлан даагч гаргах эрхтэй.

461.2.Үүрэг гүйцэтгэгч нас барсан тохиолдолд өвлөгч нь өвлөсөн хөрөнгийн хэмжээгээр үүргийн гүйцэтгэлийг хариуцах бөгөөд батлан даагч нь нөхөн төлөгдөөгүй хэсгээр хариуцлага хүлээнэ.

461.3.Үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох татгалзлаасаа үүрэг гүйцэтгэгч татгалзсан ч батлан даагч татгалзал гаргах эрхээ алдахгүй.

461.4.Үүрэг гүйцэтгэгч үндсэн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд хандах эрхтэй бол батлан даагч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас татгалзах эрхтэй.

462 дугаар зүйл. Үндсэн гэрээний тухай мэдээлэх үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг

462.1.Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ тухай

батлан даагчид мэдэгдэнэ.

462.2.Батлан даагч шаардсан бол үүрэг гүйцэтгүүлэгч үндсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн талаар түүнд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

462.3.Үүрэг гүйцэтгүүлэгч, энэ хуулийн 462.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол тэрээр үүрэг гүйцэтгэгчийн улмаас үүсэх хохирлын хэмжээгээр батлан даагчийн эсрэг шаардлага гаргах эрхээ алдана.

463 дугаар зүйл. Батлан даалтын гэрээг дуусгавар болгох

463.1.Батлан даалтын гэрээг тодорхой хугацаа заалгүй хийсэн бол батлан даагч нь гэрээг дуусгавар болгохоос гурваас доошгүй сарын өмнө мэдэгдэнэ.

463.2.Таван жилээс дээш хугацаатайгаар байгуулсан батлан даалтын гэрээг таван жил өнгөрсний дараа энэ хуулийн 463.1-д заасны дагуу дуусгавар болгож болно.

463.3.Батлан даагч нэг талын санаачилгаар батлан даалтын гэрээг цуцалсан бол иймхүү цуцлахаас өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

464 дүгээр зүйл. Батлан даагч үүргээсээ татгалзах

464.1.Батлан даагч үүрэг гүйцэтгэгчийн даалгавраар үүрэг хүлээсэн, эсхүл бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх журмын дагуу үүрэг гүйцэтгэгчийн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх тохиолдолд дараахь үндэслэлээр батлан даагчийн үүргээсээ татгалзах эрхтэй:

464.1.1.үүрэг гүйцэтгэгчийн эд хөрөнгийн байдал эрс муудсан;

464.1.2.үүрэг гүйцэтгэгч оршин суугаа /оршин байгаа/ газраа өөрчилснийг улмаас түүнээс үүргийн гүйцэтгэлийг шаардахад хүндрэлтэй болсон;

464.1.3.үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй.

464.2.Үүргээ гүйцэтгэх хугацаа болохоос өмнө үүрэг гүйцэтгэгч батлан даагчид үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг санал болгож болно.

465 дугаар зүйл. Батлан даагчид үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх эрх шилжих

465.1.Батлан даагч үүрэг гүйцэтгэсэн бол энэхүү үүргийн талаархи үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх эрх түүнд шилжих бөгөөд иймхүү эрх шилжих нь батлан даалттай холбогдолгүй үүрэг гүйцэтгүүлэгчийн бусад эрхийг хөндехгүй.

465.2.Үүрэг гүйцэтгэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх батлан даагчид шилжих үед үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах байсан бүх татгалзлаа батлан даагчид гаргах эрхтэй.

ДӨЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тооцоо нийлэх

466 дугаар зүйл. Тооцоо нийлэх гэрээ

466.1.Тооцоо нийлэх гэрээгээр талууд хоорондын ажил хэргийн харилцааныг үүссэн шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцох бөгөөд тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээнэ.

466.2.Тооцооны үлдэгдлийг гэрээнд заасан хугацаанд төлөх бөгөөд тооцоог хааснаар тооцооны үлдэгдлийг төлөхийг шаардах эрх үүснэ.

466.3.Тооцооноос үүссэн үлдэгдлийг төлснөөр тооцоо нийлэх гэрээний шаардлагыг хангасанд тооцно.

466.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол тооцоог жилд нэг удаа хаана.

466.5.Тооцоо нийлэх гэрээний дагуу төлөх төлбөрт хүү тооцож болно.

466.6.Тооцоо нийлэх гэрээний дагуу үүссэн шаардлагыг үүргийн гүйцэтгэлийг хангах аль нэг аргаар хангасан бол үүрэг гүйцэтгүүлэгч тооцоо нийлсний дараа иймхүү хангасан хэмжээгээр тооцооны үлдэгдлийг төлөхийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДӨЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг

467 дугаар зүйл.Үнэт цаас, түүний төрөл, хэлбэр

467.1.Үнэт цаас нь биет болон биет бус төрөлтэй байна.

467.2.Тогтоосон журмын дагуу хэвлэсэн үнэт цаасыг биет, түсгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тусгай бүртгэл/ердийн болон тооцоолох машин/-д байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаас гэнэ.

467.3.Үнэт цаас нь тогтоосон хэлбэр, бүрдүүлбэртэй байна.

467.4.Бүрдүүлбэр, гарын үсэг буруу үнэт цаасын хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

467.5.Үнэт цаас нь нэрийн, мэдүүлгийн, эвшөөрлийн гэсэн хэлбэртэй байна.

467.6.Тодорхой эзгээдэс зарим хэлбэрийн үнэт цаасыг гаргахыг хуулиар хориглож болно.

467.7.Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг дараахь эзгээд эдэлнэ:

467.7.1.мэдүүлгийн үнэт цаасаар эрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг хууль ёсоор олж авсан этгээд;

467.7.2.нэрийн үнэт цаасаар эрчлэгдсэн эрхийг гагцхүү түүнд нэр заасан этгээд;

467.7.3.зөвшөөрлийн үнэт цаасаар эрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийсэн этгээд;

467.8.Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна.

468 дугаар зүйл. Мэдүүлгийн үнэт цаас

468.1.Үнэт цаас гаргагчаас мөнгө төлөх үрэг хүлээснээ гэрчилж олгосон үнэт цаасыг эзмшигч мөнгө төлөхийг шаардах эрхтэй.

468.2.Үнэт цаасан дээрх гарын үсгийг оломжтой аливаа арга, хэрэгслийг ашиглан үйлдэж олно.

469 дүгээр зүйл. Үнэт цаас гаргагчийн эрх, үрэг

469.1.Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасыг эзмших эрхийг санаатай, илт хайрамгүй зэрэг гуль бус бусад замаар олж авсан бол түүнийг ударга бус эзэмшигч гэж үзнэ.

469.2.Үнэт цаас гаргагч нь үнэт цаастай олбоотой аливаа шаардлагыг үнэт цаас эмшигчид гаргаж болно.

469.3.Үнэт цаас гаргагч үнэт цаасан дээр гарын үсгээ техник хэрэгслийн тусламжтайгаар үйлдсэн бол үнэт цаас эзэмшигч нь гарын үсэг хуурамч болохыг мэдэж байсан, эсхүл хайхрамгүй хандсанаас бусад тохиолдолд үнэт цаас гаргагч нь тухайн техник хэрэгслийг ашиглах эрхгүй байсан гэсэн тайлбарыг үнэт цаас эзэмшигчид гаргах эрхгүй.

469.4.Үнэт цаасыг өөр этгээдийн өмчлөлд шилжүүлсэн бол үнэт цаас гаргагч нь түүнд санаатайгаар хохирол учруулснаас бусад тохиолдолд өмнөх эзэмшигчид шууд тавьж болох шаардлагыг дараагийн эзэмшигчид тавих эрхгүй.

469.5.Шууд тавьж үл болох татгалзлыг эвхэн бусдад санаатайгаар гэм хор учруулах, эсхүл илт хайхрамгүй хандах замаар үнэт цаасыг өмчлөлдөө шилжүүлэн авсан эзэмшигчид гаргаж болно.

469.6.Үнэт цаас гаргагч хүлээсэн үүргээ үнэт цаасыг түүнд шилжүүлэн өгсөн тохиолдолд биелүүлнэ.

470 дугаар зүйл.Үнэт цаасаар гэрчлэгдэж байгаа үүргийг гүйцэтгэх нөхцөл

470.1.Үнэт цаасыг гаргасан, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг болон үнэт цаасыг шилжүүлсэн бүх этгээд үнэт цаас өмчлөгчийн өмнө хууль тогтоомжид заасны дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

470.2.Үнэт цаас өмчлөгч үнэт цаас нь хуурамч буюу засварт болохыг нь илрүүлсэн бол энэ хуулийн 470.1-д заасан этгээдээс үүргэ зохих ёсоор гүйцэтгэх, учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхтэй.

471 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх

471.1.Үнэт цаас эзэмшигчийн өмнө үүргээ гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэгч санаатайгаар, эсхүл илт хайхрамгүйгээр хандаж үнэт цаас эзэмшигчийн шударга бус эзэмшигч болохыг нотолж чадаагүйгээс бусад тохиолдолд хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөнө.

472 дугаар зүйл. Үнэт цаасыг нэрийн үнэт цаас болгож өөрчлөх

472.1.Гагцхүү үнэт цаас гаргагч үнэт цаасыг нэрийн үнэт цаас болгон өөрчлөх эрхтэй.

472.2.Үнэт цаас гаргагч үнэт цаасны төрлийг өөрчлөх үүрэг хүлээхгүй.

473 дугаар зүйл. Үнэт цаас гэмтэх буюу устах

473.1.Мэдүүлгийн үнэт цаас гэмтсэний улмаас түүнийг эргэлтэд оруулах боломжгүй болсон бөгөөд агуулга, таних тэмдгийг нь ялгах боломжтой байвал оронд нь шинэ мэдүүлгийн үнэт цаас олгохыг үнэт цаас эзэмшигч шаардах эрхтэй бөгөөд ийнхүү солихтой холбоотой зардлыг эзэмшигч урьдчилан төлөх үүрэгтэй.

473.2.Үнэт цаасны дагуу гүйцэтгэх үүргийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгуулсан этгээд үнэт цаасаар гэрчлэгдсэн шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр бус болсонд тооцогдсон үнэт цаасны оронд үнэт цаас гаргагчаас шинэ мэдүүлгийн үнэт цаас олгохыг шаардах эрхтэй бөгөөд ийнхүү солихтой холбоотой зардлыг эзэмшигч урьдчилан төлөх үүрэгтэй.

474 дүгээр зүйл. Зөвшөөрлийн үнэт цаас

474.1.Зөвшөөрлийн үнэт цаасыг бичилт хийлгэж эзэмшилдээ авсан бол энэ хуулийн 469 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

474.2.Хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн нэр дээр холбогдох бичилтийг хийлгэж, зөвшөөрлийн үнэт цаасыг эзэмшсэн этгээд үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн дагуу мөнгө төлөхийг шаардах эрхтэй.

474.3.Зөвшөөрлийн үнэт цаасыг шударгаар эзэмшигчид мөнгө шилжүүлсэн үүрэг гүйцэтгэгчий санаатайгаар буюу илт хайхрамжгүй хандсанаа бусад тохиолдолд үүргээ гүйцэтгэсэнд тооцно.

474.4.Үнэт цаас эзэмшигчид мөнг шилжүүлэх үүргээ гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэг тухайн үнэт цаасыг өмчлөх эрхтэй.

475 дугаар зүйл. Нэрийн үнэт цаас

475.1.Тодорхой этгээдийн нэрээр гарса үнэт цаасыг үг үнэт цаасыг үүрэг гүйцэтгэчид өгсө тохиолдолд төлбөр хийх нөхцөлөөр гаргаж болно

475.2.Өөрөөр тодорхойлоогүй бол барим дээр дурдсан эрх энэхүү эрхийг шилжүүлэхээ тогтоосон журмын дагуу шилжинэ.

475.3.Нэрийн үнэт цаас устгагдсан буюу үрэгдсэн тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бо түүнийг хэрэг шийдвэрлэх онцгой ажиллагаан журмаар устгагдсан буюу үрэгдсэнд тооцно.

475.4.Тодорхой этгээдийн нэр дээ бичигдсэн үнэт цаас нь амласан төлбөрийг түүний үзүүлэгч аливаа этгээдэд хийх тухай заалт агуулса бол үүрэг гүйцэтгэгч болон үнэт цаас эзэмшигчий хооронд хийсэн аливаа хэлцэл үүрэг гүйцэтгэгч н санаатай, эсхүл илт хайхрамжгүй хандсанаас үү хамааран хүчин төгөлдөр байна.

ДӨЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Хамтран ажиллах

476 дугаар зүйл. Хамтран ажиллах гэрээ

476.1.Хамтран ажиллах гэрээгээр хоёр буюу түүнээс дээш этгээд хуулийн этгээд байгуулахгүйгээр, ашиг олох болон бусад тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

476.2.Хамтран ажиллах гэрээг бичгээр буюу амаар байгуулж болно.

476.3.Хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулах тохиолдолд дараахь зүйлийг тусгана:

476.3.1.гэрээний талуудын нэр, хаяг;

476.3.2.хамтын үйл ажиллагааны төрөл, зорилго;

476.3.3.талуудын эрх, үүрэг;

476.3.4.удирдлагын бүтэц, эрх, үүрэг;

476.3.5.ашиг, алдагдлыг хуваарила журам;

476.3.6.гэрээнээс гарах журам;

476.3.7.гэрээний хугацаа;

476.3.8.гэрээг дуусгавар болго үндэслэл, дундын эд хөрөнгийг хуваарилах журам

477 дугаар зүйл. Оролцогчдын хураамж хувь

477.1.Хамтран ажиллах гэрээний талуу гэрээнд заасны дагуу хураамж төлөх бөгөөд гэрээн хураамжийн хэмжээг тодорхойлоогүй бол тэнцү хэмжээгээр хариуцна.

477.2.Хураамжийг мөнгөн, эсхүл хөрөнгий түүнчлэн үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр төлж болн

477.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бо талуудын төлсөн хураамж нь тэдгээрийн дунд өмчлөх хөрөнгө байна.

477.4.Дундаа өмчлөх хөрөнгийн үр шим, түүнийг нэгтгэсэн, нийлүүлснээс бий болсон хөрөнгө талуудын дундаа өмчлөх хөрөнгө байна.

477.5.Талууд өөрт ногдох хувиа бусад талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглох бөгөөд гагцхүү зайлшгүй үндэстэн үзэх үндэслэл байвал зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болно.

477.6.Талууд гуравдагч этгээдэд шилжүүлэх хөрөнгийг тэргүүн ээлжинд авах давуу эрхтэй.

478 дугаар зүйл. Хамтын үйл ажиллагаа

478.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд хамтын үйл ажиллагаат хамтран хэрэгжүүлэх бөгөөд талууд аливаа хэлцэл хийхдээ харилцан зөвшөөрлийг авна.

478.2.Гэрээний талууд шийдвэрийг олонхийн саналаар гаргахаар гэрээнд заасан бол өлсөн хураамжийн хэмжээнээс үл хамааран оролцогч бүр нэг саналын эрхтэй байна.

478.3.Хамтын үйл ажиллагааг хэд хэдэн хэсэг бие даан эрхлэн явуулахаар тохиролцсон бол энэ тухай гэрээнд тусгах бөгөөд иймхүү зөвшилцөж гадаагүй бол гэрээ байгуулахыг хориглоно.

478.4.Хамтын үйл ажиллагааг аль нэг тал нь эрхлэн явуулахаар талууд тохиролцсон бол үүнийг талуудыг төлөөлж гэрээ хэлцэл хийх, нарагаан гаргал төлөөлөх эрхтэй гэж тооцно.

478.5.Хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн талыг санал нэгтэйгээр эрээнээс гаргаж болно.

478.6.Гэрээний аль ч тал хамтран ажиллах эрээг эрхлэн явуулахад оролцохоос татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай гэж зсэн мэдээлэл өгөхийг удирдлагаас шаардах эрхтэй.

478.7.Хамтран ажиллах гэрээнд өөрөөр заагаагүй бол удирдлагад ажиллах талын эрх, үүргийг даалгаврын гэрээний журамд нийцүүлэн одорхойлно.

478.8.Гэрээнд өөрөөр заагаагүй бол ашгийг алуудын төлсөн хураамжид хувь тэнцүүлэн уваарилна.

478.9.Гэрээний тал бүр аливаа оролцогч алаас гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардаж болно.

478.10.Гэрээнээс үүсэн гарах хоорондын шаардлагыг талууд гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

478.11.Хамтын үйл ажиллагааны үлмаас бий болсон алдагдлыг гэрээний талууд хамтран хариуцна.

478.12.Гэрээнд өөрөөр заагаагүй бол талуудын хоорондын хүлээх хариуцлагын хэмжээг гишүүний төлсөн хураамжид хувь тэнцүүлэн хуваарилна.

478.13.Хамтран ажиллах гэрээний оролцогчнь үүргээ биелүүлэх явцад олж авсан мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

479 дүгээр зүйл. Хамтран ажиллах гэрээнээс гарах

479.1.Гэрээнд хамтын үйл ажиллагааны үргэлжлэх хугацаат шууд заагаагүй тохиолдолд гэрээний талууд хамтын үйл ажиллагаанд хохирол учруулахаарүй бол хэдийд ч хамтран ажиллах гэрээнээс гарч болно.

479.2.Хамтын үйл ажиллагааны үргэлжлэх хугацаат гэрээнд заасан тохиолдолд, гагцхүү зайлшгүй үндэстэн үзэх шалтгаанаар хугацаанаас өмнө гэрээнээс гарч болно.

479.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол аль нэг тал гэрээнээс гарснаар хамтын үйл ажиллагаа дуусгавар болно.

479.4.Нэг тал гэрээнээс гарсан боловч үлдсэн талууд хамтын үйл ажиллагаат үргэлжлүүлэхээр тохиролцсон бол гэрээнээс гарсан талд ногдох хувийг менгөн хэлбэрээр эргүүлэн олгох боловч ингэхдээ түүний гарах үед биелүүлээгүй байсан хэлцлийг харгалзана.

479.5.Гэрээнээс гарахад талуудын дундын хөрөнгө тэдний хүлээсэн нийт үүргийг биелүүлэхэд хүрэлцэхгүй байвал гэрээнээс гарч байгаа тал өөрт ногдох хувьтай тэнцэх хэмжээний менгийг бусдад төлнө.

479.6.Гэрээнээс гарч байгаа талын үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэг хэвээр үлдэнэ.

479.7.Хамтран ажиллах гэрээнээс гарах эрхийг хориглосон, эсхүл хязгаарласан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

480 дугаар зүйл. Хамтран ажиллах гэрээ дуусгавар болох

480.1.Хамтран ажиллах гэрээ дараахь үндэслэлээр дуусгавар болно:

480.1.1.гэрээний хугацаа дууссан;

480.1.2.талууд шийдвэрлэсэн;

480.1.3.талуудын дундын өмчийн хөрөнгийг дампуурлын ажиллагааны дагуу төлбөрт гаргуулах хөрөнгөд оруулсан;

480.1.4.хамтын үйл ажиллагааны зорилгыг биелүүлэх боломжгүй болсон.

480.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хамтран ажиллах гэрээг дараахь үндэслэлийн аль нэг нь байвал дуусгавар болсонд тооцно:

480.2.1.гэрээг цуцалсан;

480.2.2.талуудын аль нэг нь дампуурсныг шүүхээс зарласан, татан буугдсан;

480.2.3.талуудын аль нэг нас барсан.

480.3.Хамтран ажиллах гэрээ дуусгавар болсноор биелүүлээгүй хэлцлийг дуусгавар болгож, үлдэх хөрөнгийн жагсаалтыг үйлдэж, талуудад хуваарилна.

480.4.Хөрөнгийг хуваарилахад хамтын үйл ажиллагааны явцад бий болсон үүргийг гүйцэтгэсэн байх бөгөөд хэрэв үгүй бол талууд өөрт ногдох хэсэгт хувь тэнцүүлэн үүргийг гүйцэтгэнэ.

481 дүгээр зүйл. Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл

481.1.Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлий хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллага явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсы бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалты гишүүд харилцан тохиролцож тодорхойлно.

481.2.Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл н иргэний эрх зүйн харилцаанд бүрэн эрх бүхи төлөөлөгч буюу гишүүдээр дамжин оролцоно.

482 дугаар зүйл. Бүртгэгдээгүй холбоо нөхөрлөлийн гишүүдийн дундын хөрөнгө

482.1.Холбооны гишүүдийн татвар, хандив үйл ажиллагааныхаа орлогоор олж авсан хөрөнг нь гишүүдийн дундын хөрөнгө байна.

482.2.Дундын хөрөнгөд оруулах татвар хуримтлалын хэмжээг гишүүд тохиролцон тогтоо бөгөөд тэдгээр нь мөнгө, эд хөрөнгө болон үй ажиллагаагаараа дундын хөрөнгийг бүрдүүлэхэ оролцож болно.

482.3.Дундын хөрөнгийг гишүүдээ томилогдсон эрх бүхий төлөөлөгч захира зарцуулна.

482.4.Нэхэмжлэгчдийн шаардлагы гишүүдийн дундын хөрөнгөөр хангана. Орон сууцн дундын өмчлөлийн зүйл энэ заалтад хамаарахгүй

482.5.Гишүүд өөрөөр тохиролцоогүй бо дундын хөрөнгө шаардлагыг хангахад хүрэлцэхгү тохиолдолд холбоо, нөхөрлөлийн нэрийн өмнөө үйл ажиллагаа явуулах бүрэн эрх бүхий этгээдүү ижил хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээнэ.

ДӨЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Асран тэтгэх

483 дугаар зүйл. Асран тэтгэх гэрээ

483.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол асран тэтгэх гэрээгээр асран тэтгэгч нь асруулагчийг тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ.

483.2.Мөнгөн, эсхүл биет хэлбэрээр /орон сууц, хоол, хувцсаар хангах г.м./ асран тэтгэж болно.

483.3.Талууд биет хэлбэр бүхий тэжээн тэтгэх үүргийг мөнгөн хэлбэрээр солихоор тохиролцож болно.

483.4.Асран тэтгэх гэрээг бичгээр байгуулна.

483.5.Тэжээн тэтгэх хугацааг түүний зорилго, шинж чанарыг харгалзан гэрээгээр тогтооно.

483.6.Асран тэтгэгч нь асруулагчий шилжүүлэн өгсөн хөрөнгийг түүни зөвшөөрөлгүйгээр худалдах, барьцаалах, буса хэлбэрээр шилжүүлэх эрхгүй.

483.7.Асран тэтгэгчийн бусдын өмн хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд энэ хуулийн 483.6- заасан хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно

483.8.Асруулагч асран тэтгэгчид үл хөдлө эд хөрөнгө шилжүүлж өгсөн бол асран тэтгэ шаардах эрхээ баталгаажуулах зорилгоор хөрөнгийн хувьд барьцааны эрх эдэлнэ.

483.9.Асран тэтгэгчид шилжүүлсэн хөрөн устсан, гэмтсэн нь асран тэтгэгчийг үүргэ

ıелөөлөх үндэслэл болохгүй.

484 дүгээр зүйл. Асран тэтгэх гэрээ уусгавар болох

484.1.Гэрээг зөрчсөний улмаас талуудын оорондын харьцаа эрс муудсан, эсхүл бусад оцтой үндэслэлээр гэрээг мөрдөх боломжгүй бол сран тэтгэгч, асруулагч аль нь ч гэрээг цуцлах рхтэй.

484.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээ уусгавар болоход иймхүү дуусгавар болгохоос мнө асран тэтгэгчийн гаргасан зардлыг нөхөн элэхгүй.

484.3.Асран тэтгэх гэрээ дуусгавар болсон тохиолдолд асруулагчид хөрөнгийг нь буцаан олгоно.

485 дугаар зүйл. Асран тэтгэгч нас барах

485.1.Асран тэтгэгч нас барсан тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг өвлөсөн этгээд асруулагчийг тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ.

485.2.Өвлөгч тэжээн тэтгэх үүргээс татгалзсан бол хөрөнгийг асруулагчид буцаан олгосноор гэрээ дуусгавар болно.

ТАВЬДУГААР БҮЛЭГ

Тоглоом, мөрий

486 дугаар зүйл. Тоглоом, мөрий

486.1.Тоглоом болон мөрий нь шаардах эхийг бий болгохгүй.

486.2.Тоглох, мөрий тавихад зориулан госон зээл, урьдчилгаа, түүнчлэн мөрийний инжийг агуулсан хөрөнгө нийлүүлэх тухай биржийн олон түүнтэй төстэй хэлцэлд энэ хуулийн 486.1-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

486.3.Хуулиар хориглосноос бусад тоглоом болон мөрийний дагуу төлсөн мөнгө, шилжүүлсэн хөрөнгө, бусад зүйлийг эргүүлэн шаардаж болохгүй.

486.4.Хонжворт сугалаа, түүнтэй төсөөтэй бусад тоглоом нь эдгэрийг төрөөс зөвшөөрсөн тохиолдолд л шаардах эрхийг бий болгоно.

ІҮ ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ БУС ҮҮРЭГ

І ДЭД ХЭСЭГ

ХУУЛЬД ЗААСНААР ҮҮСЭХ ҮҮРЭГ

ТАВИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа

Нэгдүгээр дэд бүлэг
Дундын өмчөөс үүсэх үүрэг

487 дугаар зүйл. Дундаа хэсгээр өмчлөх

487.1.Дундаа хэсгээр өмчлөгчид харилцан өөр тохиролцоогүй бол өмчлөгч бүр тэнцүү мжээгээр өмчлөх эрхтэй бөгөөд өөрт ногдох сэгт ногдох үр шимийг өмчлөх эрхтэй.

487.2.Хуульд өөрөөр заагаагүй бол дорхой эрхийг хэд хэдэн этгээд дундаа хэгээр ічилж байвал энэ бүлэгт заасан журмыг римтална.

488 дугаар зүйл. Дундын өмчийг ашиглах, ирдах

488.1.Дундаа хэсгээр өмчлөгдийн энхийн саналаар дундын өмчлөлийн зүйлийн иглалт, удирдлагын талаар шийдвэр гаргах бөгөөд саналыг өөрт ногдох хэсэгт хувь тэнцүүлэн тооцно.

488.2.Олонхийн шийдвэр буюу хэлцлээр өөрөөр тогтоогүй бол дундаа хэсгээр өмчлөгч бүр шударга ёсны дагуу бусад өмчлөгчидийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглалт болон удирдлагын талаар шаардлага гаргах эрхтэй.

488.3.Дундаа хэсгээр өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр, түүний ногдох хэсгээ ашиглах эрхийг хязгаарлаж үл болно.

488.4.Дундаа хэсгээр өмчлөгчид нь дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, удирдлагын журмыг тогтоосон бол уг журмыг эрх шилжүүлэн авсан этгээдүүд нэгэн адил мөрдөнө.

489 дүгээр зүйл. Дундын өмчийн эрхийг хүчингүй болгохыг шаардах

489.1.Дундаа хэсгээр өмчлөгчдийн хэн нь ч дундын өмчийн эрхийг хүчингүй болгохыг шаардах эрхтэй.

489.2.Энэ хуулийн 489.1-д заасан эрхийг гэрээгээр эдлэхгүй гэж өмчлөгчид тохирсон, эсхүл хугацаагаар хязгаарласан байсан ч хүндэтгэн үзэх шаардлага гарвал энэхүү эрхийг хэрэгжүүлж болно.

489.3.Энэ хуулийн 489.2-т зааснаас өөрөөр дундын өмчийн эрхийг хүчингүй болгохыг шаардах эрхийг хязгаарласан, эдлэхгүйгээр заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

489.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол дундаа хэсгээр өмчлөгчдийн дундын өмчийн эрхийг хүчингүй болгох эрхийг тодорхой хугацаанд эдлэхгүйгээр тохиролцсон хэлцэл аль нэг өмчлөгч нас барснаар хүчингүй болно.

489.5.Дундын өмчлөлийн зүйлийн үнэ, өртгийг бууруулахгүйгээр өмчлөгчдэд оногдох хэсгийн дагуу хуваах болохоор бол өмчлөлийн зүйлийг биет байдлаар хуваасан гэж үзэх дундын өмчийн эрхийг хүчингүй болгоно.

489.6.Дундын өмчлөлийн зүйлийг биет байдлаар хувааж болохгүй бол энэ хуулийн 159 дүгээр зүйлд заасан журмын дагуу худалдах, эдэлбэр газар болон үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулах, олсон ашгийг хуваарилах замаар дундын өмчийн эрхийг дуусгавар болгож болно.

489.7.Дундын өмчлөлийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлж болохгүй тохиолдолд дундаа хэсгээр өмчлөгчдийн дунд дуудлага худалдаа явуулж худалдана.

489.8.Дундын өмчлөлийн зүйлийг энэ хуулийн 489.6, 489.7-д зааснаар худалдаж чадаагүй бол дундаа хэсгээр өмчлөгч нь дуудлага худалдаа давтан явуулахыг шаардах эрхтэй. Хоёр дахь дуудлага худалдаа үр дүнгүй болбол дуудлага худалдаа давтан явуулахыг шаардсан этгээд дуудлага худалдаа явуулахтай холбогдон гарсан зардлыг хариуцна.

490 дүгээр зүйл. Дундаа хэсгээр өмчлөгчдийн үүргийн гүйцэтгэлийг хангах

490.1.Дундаа хэсгээр өмчлөгч нь өөрт оногдох хэсгээр үүргийн гүйцэтгэлийг хариуцах бол өмчлөгч бүр дундын өмчийн эрх дуусгавар болсон тохиолдолд түхайн нөгдох хэсгээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг шаардах эрхтэй.

490.2.Үүргийн гүйцэтгэлийг хангахад дундын өмчлөлийн зүйлийг зайлшгүй худалдаа шаардлагатай бол энэ хуулийн 489.6-489.8-д заасныг баримтална.

490.3.Дундаа хэсгээр өмчлөгчид нь харилцан хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахад энэ хуулийн 490.1, 490.2-т зааса журам нэгэн адил хамаарна.

490.4.Дундын өмчийн эрх дуусгава болсноор дундын өмчлөлийн зүйл дундаа хэсгэ өмчлөгчдийн хэн нэгэнд шилжсэн үед буса өмчлөгч нь өөрт ногдох хэсгийн дутагдлыг бара худалдагчийн нэгэн адил хариуцна.

490.5.Дундын өмчийн эрхийг хүчингү болгох шаардлагад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

Хоёрдугаар дэд бүлэг

Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх

491 дүгээр зүйл. Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх

491.1.Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэж байгаа этгээд түүнийг шударгаар гүйцэтгэх үүрэгтэй.

491.2.Бусдын эд хөрөнгө болон эрх ашигт учирч болзошгүй аюулыг урьдчилан зайлуулах зорилгоор үүрэг гүйцэтгэсэн этгээд зөвхөн сананатай буюу илтэд болгоомжгүй үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

491.3.Бусдын эд хөрөнгө болон эрх ашигт учирч болзошгүй аюулыг урьдчилан зайлуулах үйлдэл хийсэн этгээдэд хохирол учирсан бол энэхүү хохирлыг ашиг сонирхлоо хамгаалуулсан этгээд нөхөн төлөх бөгөөд талууд тохиролцоо чадаагүй бол хохирлын хэмжээг шүүх тогтооно.

491.4.Бусдын үүргийг даалгаваргүйгээ гүйцэтгэж байгаа этгээд боломж гармагц аш сонирхлоо хамгаалуулж байгаа этгээдэд мэдэгд үүрэгтэй бөгөөд ашиг сонирхлоо хамгаалуул байгаа этгээд өөрөө үүргийг гүйцэтгэж эхл буюу үүргээс татгалзах хүртэл үүргий гүйцэтгэнэ.

491.5.Бусдын үүргийг даалгаваргүйгээ гүйцэтгэж байгаа этгээд ашиг сонирхл хамгаалуулж байгаа этгээдэд гүйцэтгэлийн тайла гаргаж, үүргийн үр дүнгээс олсон бүх зүйлийг аш

онирхлоо хамгаалуулж байгаа эгэздэд
илжүүлэх үүрэгтэй.

491.6.Бусдын үүргийг даалгаваргүйгээр
үйцэтгэсэн этгээд үүрэг гүйцэтгэхтэй холбогдон
арсан зайлшгүй зардлыг нөхөн төлөхийг ашиг
онирхлоо хамгаалуулсан этгээдээс шаардах
рхтэй.

491.7.Үүргийн гүйцэтгэл ашиг сонирхлоо хамгаалуулсан этгээдийн хүсэл зориг, ашиг сонирхолд нийцэхгүй бол үйлдэл хийсэн этгээд зардлаа нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй бөгөөд хэрэв үйлдэл хийсэн этгээд үүнийг мэдэж байсан бол ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Гуравдугаар дэд бүлэг

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

492 дугаар зүйл. Бусдын хөрөнгийг ндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэнээс үсэх үүрэг

492.1.Бусдын өмнө хүлээсэн үүргээ үйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө илжүүлсэн этгээд үүрэг зүйлийг олж авсан этгээдээс ээрх хөрөнгөө дараахь тохиолдолд буцаан аардах эрхтэй:

492.1.1.хөрөнгө олж авсан этгээд олон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг /сэргүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон юу хүчин төгөлдөр бус болсон;

492.1.2.үүрэг гүйцэтгүүлэгч аардлага гаргаж болохооргүй үлэмж маргаантай.

492.2.Дараахь тохиолдолд бусдад илжүүлсэн хөрөнгийг буцаан шаардаж болохгүй:

492.2.1.үүрэг гүйцэтгэгч үүргээ йцэтгэсэн явдал нь нийтээр хүлээн зөвшөөрсөн н суртахууны хэм хэмжээнд нийцсэн;

492.2.2.шаардлага гаргах хөөн лэлцэх хугацаа өнгөрсөн;

492.2.3.хүчин төгөлдөр бус болсон ргийн хувьд өмнө нь гүйцэтгэсэн үүрэг ёсоор илжүүлсэн өр төлбөрийн гэрээг гүйцэтгэх үед рөнгөө буцаан шаардах шаардлага нь хуульд ршилж байвал;

492.2.4.хөөн хэлэлцэх хугацаа уссаныг мэдэлгүйгээр нэг тал нөгөөдөө үүргийн йцэтгэл болгон хөрөнгө шилжүүлсэн.

492.3.Үүрэг гүйцэтгүүлэхээр бус харин дорхой үйлдэл хийлгэх буюу үйлдэл хийхгүй йхаар хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн хиолдолд нөгөө этгээдийн үйлдэл буюу эс пдэхгүй хөрөнгө шилжүүлсэн этгээдийн хүсэл эигт нийцэхгүй бол шилжүүлсэн зүйлээ буцаан аардаж болно.

492.4.Дараахь тохиолдолдийнхүү илжүүлсэн хөрөнгөө буцаан шаардаж болохгүй:

492.4.1.анхнаасаа зорилгодоо хүрэх боломжгүй байсныг хөрөнгө шилжүүлсэн этгээд мэдэж байсан;

492.4.2.хөрөнгө шилжүүлсэн этгээд шударга бус хандаж нөгөө этгээдийнхээ үйлдэлд саад хийсэн.

492.5.Үүрэг гүйцэтгэхээр бус харин хүч хэрэглэсэн буюу заналхийлсэн үйлдлийн үндэсн дээр хэн нэгэн этгээд нөгөө этгээдэд хөрөнгө шилжүүлсэн бол хөрөнгө олж авсан этгээд түхайн хөрөнгийг өөрийн хэзмшилгд байлгах эрхтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө шилжүүлсэн этгээд нь түүнийг буцаан шаардах эрхтэй.

493 дугаар зүйл. Буцаан шаардах шаардлагад хамаарах зүйлс

493.1.Буцаан шаардах шаардлагад өөр этгээдэд шилжүүлсэн хөрөнгө, түүнээс олсон орлого, үр шим, түүнчлэн түхайн хөрөнгийг эвдсэн, устгасан, гэмтээсэн буюу хураалгасан бол нөхөн төлбөрт авах бүх зүйл хамаарна.

493.2.Үндэслэлгүй олж авсан зүйлийн чанар байдлын улмаас буюу өөр шалтгаанаар түүнийг буцаах өгөх боломжгүй бол олж авсан этгээд түүний үнийг төлнө.

493.3.Эд хөрөнгийг үндэслэлгүй олж авсан этгээд уг зүйлээ хэрэглэх, бусдад шилжүүлэх зэргээр ашиглахдаа, эсхүл түхайн зүйлийг урэгдүүлсэн, устгасан, чанарыг нь муудуулсан буюу бусад шалтгаанаар ямар нэгэн ашиг, орлого олоогүй бол олох байсан орлого, ашиг, үр шимийг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

493.4.Гэрээ хүчингүй болсны улмаас уг гэрээгээр олж авсан зүйлээ буцаах өгөх үүрэг бүхий тал нь биет байдлаар буюу мөнгөн хэлбэрээр буцаах өгөх бололцоогүй бол гэрээ хүчин төгөлдөр бус болсон үндэсэлэл, түүний үр дагаварт шууд хамааралтайгаас бусад тохиолдолд уг хөрөнгийг буцаан өгөх үүрэг үүсэхгүй.

493.5.Эд хөрөнгө олж авсан этгээд түхайн

хөрөнгийг бүрмөсөн өөрийн болгосон гэж бодсоны улмаас түүнтэй холбоотой зардал гаргасан бол зардал, хохирлоо нөхөн төлүүлж уг зүйлийг буцааж өгөх үүрэгтэй. Харин хөрөнгийн шинж байдлаас түүнийг бүрмөсөн өөрийн болгож авсан гэж бодох үндэслэлгүй нь илтэд байвал энэ журам үл хамаарна.

493.6.Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр, шударга бусаар олж авсан этгээд ийнхүү эд хөрөнгийг олж авсан үеэс, шударгаар олж авсан этгээд нь үндэслэлгүйгээр олж авсан гэдгээ мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс эхлэн уг хөрөнгөөс олсон буюу өөрийн буруугаас олж чадаагүй зайлшгүй олох ёстой байсан орлого үр шимийг хууль ёсны өмчлөгч буюу хэзмшигчид буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэг хүлээнэ.

493.7.Эд хөрөнгө олж авсан этгээд тухайн эд хөрөнгийг буцаан шилжүүлэх үед эвдэж гэмтээсэн буюу үрэгдүүлснээс үүссэн хохирлыг гаргүүй өөрөө гэм буруутай тохиолдолд нөхөн төлөх үүрэгтэй.

493.8.Даалгаваргүйгээр бусдын эрх ашгийн үүднээс үйлдэл хийсний үндсэн дээр хөрөнгө олж авсан этгээд уг хөрөнгөтэй холбогдож гаргасан зардлаа нөхөн төлөхийг шаардаж болно. Энэ тохиолдолд ашиг сонирхлоо хамгаалуулсан этгээд нь зайлшгүй зардлаас бусад зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

493.9.Буцаан шаардах шаардлагад энэ хуулийн 232 дугаар зүйл хамаарахгүй.

494 дүгээр зүйл. Хөрөнгийг буцаан шилжүүлэх гуравдагч этгээдийн үүрэг

494.1.Үндэслэлгүйгээр хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг гуравдагч этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлсэн тохиолдолд гуравдагч этгээд уг хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үүрэгтэй.

494.2.Энэ зүйлд энэ хуулийн 492, 493 дугаар зүйлийн холбогдох заалт нөгөн адил хамаарна.

495 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулснаас үүсэх үүрэг

495.1.Хууль ёсны өмчлөгч, хэзмшигчийн зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгийг ашиглах, өөр зүйлтэй холих, нийлүүлэх, нэгтгэх, дахин боловсруулах зэргээр захиран зарцуулж бусдын эрхийг зөрчсөн этгээд үүнээс учирсан хохирлыг эрх бүхий этгээдэд нөхөн төлөх үүрэгтэй.

495.2.Энэ хуулийн 495.1-д заасанаар бусдын эрхийг зөрчсөн тохиолдолд эрх бүхий этгээд нь хохирлыг нэн даруй нөхөн төлөхийг эрх зөрчигчөөс шаардах эрхтэй.

495.3.Эрх бүхий этгээдийн эд хөрөнгийг хариу төлбөртэйгээр захиран зарцуулсан бол түүнээс олсон орлогыг эрх бүхий этгээдэд учирсан хохиролд тооцно.

495.4.Бусдын эрхийг зөрчсөн этгээд илтэд болгоомжгүйн улмаас өөрийгөө эрхгүй болохыг мэдээгүй бөгөөд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх үндэслэл байхгүй тохиолдолд түүнийг хариуцлагаас чөлөөлж болно.

495.5.Бусдын эрхийг зөрчсөн этгээд хөрөнгийг ашиглах явцад зардал гаргасан нь түүний үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.

495.6.Бусдын эрхийг зөрчсөн этгээд нөгөө этгээдийнхээ эрхийг мэдэж байсан боловч санаатай зөрчсөн бол эрх бүхий этгээд эд хөрөнгийн хохирлоос давсан ашгийг нөхөн төлөхийг шаардаж болно.

495.7.Бусдын эрхийг зөрчсөн этгээд тухайн эд хөрөнгийг ашигласнаас олсон ашгийн талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

496 дугаар зүйл. Бусдын зардлаар болон өөрийн хөрөнгийг хэмнэх аргаар хөрөнгөжих

496.1.Хэн нэг этгээд өөр этгээдийн өр төлбөрийг сайн дураар өөрөө мэдэж буюу андуурч төлсөн бөгөөд иймхүү ерийг төлснөөр үүрэг бүхий этгээд үүргээсээ чөлөөлөгдсөн бол ерийг нь төлсөн этгээд тэр этгээдээр зардлаа нөхөн төлүүлэхээр шаардаж болно.

496.2.Хэн нэг этгээд өөр этгээдийн хөрөнгөд сайн дураараа өөрөө мэдэж буюу андуурч зардал гаргасан бөгөөд нөгөө этгээд үүний улмаас хөрөнгөжсөн бол зардал гаргасан этгээд түүнээс зардлаа нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

496.3.Дараахь тохиолдолд шаардлага гаргаж болохгүй:

496.3.1.шаардлага хариуцах этгээд өөрөө хариу шаардлага гаргах эрхтэй байсан бөгөөд түүнийгээ суутган авсан;

496.3.2.шаардлага гаргагч гаргасан зардлын тухай шаардлагаа хариуцагчид өөрийн бууруугаас ердийн боломжит хугацаанд мэдэгдээгүй;

496.3.3.шаардлага хариуцах этгээ зардлыг нөхөн төлөхөөс өмнө түүний талаа маргасан.

II ДЭД ХЭСЭГ
ЗӨРЧЛИЙН УЛМААС ҮҮСЭХ ҮҮРЭГ

ТАВИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас ариуцлага хүлээх үндэслэл

497.1.Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр эр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд ууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /с үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм орыг хариуцан арилгах үүрэгтэй.

497.2.Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм ор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг отолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм ор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө.

497.3.Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд ролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран ариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор чруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, эмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр үнг санаатай ашигласан этгээд нэгэн адил ариуцлага хүлээнэ.

498 дугаар зүйл. Байгууллага, албан ушаалтан бусдад гэм хор учруулсны хариуцлага

498.1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу лбан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх цад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ сдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг киллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.

498.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн лбан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай лдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор руулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа улийн этгээд буюу төр хариуцан арилгана

498.3.Хохирогч өөрөө санаатай буюу илтэд лгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид йцсэн арга хэрэгслээр үүсч болох хохирлоос ьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт гэм хор учирсан бол энэ хуулийн 498.1, 498.2-т асан байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болно.

498.4.Хууль бусаар яллагдагчаар татагдсан, шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан юу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, киргааны журмаар баривчлагдсан этгээдийн очигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд ирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, окурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл мааран төр хариуцан арилгана.

498.5.Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

499 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах

499.1.Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй.

499.2.Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол энэ хуулийн 499.1-д заасан үүрэг үүсэхгүй.

499.3.Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

499.4.Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.

500 дугаар зүйл. Барилга байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хорыг хариуцах

500.1.Зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байснаас бусад тохиолдолд байшин барилга бүтэн буюу хэсэгчлэн нурсны улмаас учирсан гэм хорыг тухайн барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.

500.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас байшингаас ямар нэг зүйл унасан, хаягдсан буюу асгарсны улмаас гэм хор учирсан бол тухайн байшин барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцлага хүлээхгүй.

501 дүгээр зүйл. Амьтны учруулсан гэм хорыг хариуцах

501.1.Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.

501.2.Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй.

502 дугаар зүйл. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хорыг хариуцах

502.1.Барилга байгууламжийн хийц, зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн, эсхүл түүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол уг гэм хорыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсхүл аюултай зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.

502.2.Онцгой аюул учруулж болох барилга байгууламж, эд хөрөнгийг өмчлөгч буюу эзэмшигч нь гэм буруутай байсан эсэхээс үл хамааран энэ хуулийн 502.1-д заасан гэм хорыг хариуцна.

502.3.Өмчлөгчийн эзэмшилд байгаа барилга байгууламж дотор буюу түүний эдлэн газрын хил хязгаарын дотор бусдад гэм хор учирсан боловч түүнд өмчлөгч буруугүй бол тэрээр хариуцлага хүлээхгүй.

503 дугаар зүйл. 7-14 хүртэлх насны, насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй иргэн гэм хор учруулсны хариуцлага

503.1. 7-14 хүртэлх насны болон эрх зүйн чадамжгүй иргэний бусдад учруулсан гэм хорыг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгана.

503.2. 7-14 хүртэлх насны иргэн сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгана.

503.3.Сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэний бусдад учруулсан гэм хорыг түүний асран хамгаалагч буюу түүнд байнгын хяналт тавих үүрэг бүхий этгээд хариуцан арилгана.

503.4.Эцэг, эх, асран хамгаалагч нь хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолж чадвал тэдгээрийг гэм хор арилгах үүргээс чөлөөлж болно.

503.5.Насанд хүрээгүй хүмүүс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцан арилгах бөгөөд түүний цалин хөлс, орлого, захиран зарцуулах эрхэд нь байгаа хөрөнгө гэм хорыг арилгахад хүрэлцэхгүй бол хүрэлцэхгүй байгаа тэр хэмжээгээр эцэг эх, харгалзан дэмжигч нь нөхөх хариуцлага хүлээнэ.

503.6.Энэ хуулийн 503.5-д заасан гэм хорыг арилгахад энэ хуулийн 503.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

504 дүгээр зүйл. Үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй буюу өөрийгөө зөв удирдах чадваргүй байхдаа учруулсан гэм хорыг хариуцах

504.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу зөв удирдах чадваргүй байхдаа бусдад учруулсан гэм хорыг хариуцахгүй.

504.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундааны зүйл хэрэглэж өөрийгөө тийм байдалд хүргэсэн этгээдэд энэ хуулийн 504.1 хамаарахгүй.

505 дугаар зүйл. Бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах

505.1.Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан асарч сувилах нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх сувиллын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй.

505.2.Гэм хор учруулах үед хохирогч цалин хөлс, орлогогүй байсан бол тэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах эрхтэй.

506 дугаар зүйл. Арван зургаан нас хүрээгүй хүмүүст учруулсан гэм хорыг арилгах

506.1.Арван зургаан нас хүрээгүй бөгөөд цалин, хөлс, орлогогүй иргэний эрүүл мэндэд гэм хор учруулсан бол гэм хор учруулсан этгээд нь ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан зардлыг энэ хуулийн 505.1-д зааснаар нөхөн төлнө.

506.2.Энэ хуулийн 506.1-д заасан хохирог

арван зургаан нас хүрсэн боловч эрүүл мэнд нь сайжраагүй бол хөдөлмөрийн чадвар алдсанаас учирсан хохирлыг хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр тооцож төлүүлэхээр түүний эцэг, эх, харгалзан дэмжигч шаардах эрхтэй.

506.3.Арван зургаан нас хүрээгүй иргэн эрүүл мэндэд нь гэм хор учруулах үед байнгын цалин, хөлс, орлогогүй байсан бол хохирлыг дутуу авсан цалин, хөлс, орлогын хэмжээгээр төлүүлнэ.

507 дугаар зүйл. Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх

507.1.Эрүүл мэндэд нь гэм хор учирснаас болж, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан иргэний хөдөлмөрийн чадвар нь цашид дордох буюу авч байгаа тэтгэврийн хэмжээ багасвал гэм хор учруулсны төлбөрийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг хариуцагчаас шаардах эрхтэй.

507.2.Хохирогчийн хөдөлмөрийн чадвар сайжирсантай холбоотойгоор авч байгаа цалин, хөлс, орлого болон тэтгэврийн хэмжээ нэмэгдвэл хариуцагч нь гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг багасгахыг шаардах эрхтэй.

508 дугаар зүйл. Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгах

508.1.Хохирогч нас барсан бол түүнийг хүмүүлахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй.

508.2.Гэм хор учруулсны төлбөрийг нас барсан хохирогчийн асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах эрхтэй байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд, хохирогчийг нас барсны дараа төрсөн хүүхэд тус тус, түүнчлэн нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг сран хүмүүжүүлж байгаа байнгын цалин хөлс ологогүй эцэг, эх, нөхөр /эхнэр/-ийн аль нэг нь авах эрхтэй.

508.3.Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо ас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан эдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй тгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн арын цалин хөлс, орлогын дүнджаар тогтооно. үүнүүлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн эмжээнээс тэжээгүүлэз алдсаны тэтгэврийг хасна.

508.4.Гэм хор учруулсны төлбөрийг дор урдсан хугацаанд нөхөн төлнө:

508.4.1.бага насны буюу насанд ргээгүй иргэнд арван зургаан нас хүртэл, харин ралцаж байгаа бол арван найман нас хүртэл;

508.4.2.тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд бүх насаар нь;

508.4.3.тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдсон хугацаанд;

508.4.4.нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин, хөлс, орлогогүй нас барагчийн эцэг, эх, нөхөр /эхнэр/-ийн аль нэгэнд түүний нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр уг хүүхдийг найман нас хүртэл.

509 дүгээр зүйл. Хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвар алдсантай холбогдуулан төлбөр төлөх

509.1.Хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдсон төлбөрийг сар тутам төлнө.

509.2.Гэм хор учруулсны төлбөр төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон бөгөөд түүний эрх залгамжлагч байхгүй бол хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдуулан уг хуулийн этгээдээс төлбөл зохих төлбөрт шаардагдах хэмжээний хөрөнгийг энэ хуулийн 32.5-д заасны дагуу тэргүүн ээлжинд хуримтлуулж, тогтоосон хугацаанд хохирогчид олгож байхын тулд нийгэм хангамжийн байгууллагад шилжүүлнэ.

509.3.Шүүх төлбөр авагчийн хүсэлтээр менгөний хаяшийн өөрчлөлтийг харгалзан төлбөрийн үнийн дүнг өөрчилж болно.

510 дугаар зүйл. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах

510.1.Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.

511 дүгээр зүйл. Эдийн бус гэм хорыг арилгах

511.1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

511.2.Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ,

хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд менгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

511.3.Энэ зүйлд энэ хуулийн 21.4, 21.5, 21.6-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.

512 дугаар зүйл. Бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорыг арилгах

512.1.Чанар муутай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь хохирогчтой гэрээний харилцаатай байсан эсэхээс үл хамааран уг бараа, бүтээгдэхүүний улмаас учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

512.2.Бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дараахь тохиолдолд энэ хуулийн 512.1-д заасан хариуцлагаас чөлөөлөгдөж болно:

512.2.1.уг бараа, бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор үйлдвэрлээгүй;

512.2.2.борлуулахаар үйлдвэрлэн гаргах үед тухайн бараа, бүтээгдэхүүн бусдад хохирол учруулахүйц байгаагүй гэдгийг баримтаар нотолсон;

512.2.3.бараа, бүтээгдэхүүн гэмтэл соготой боловч үйлдвэрлэн гаргах үед тухайн үеийн норм, стандартад тохирч байсан;

512.2.4.бараа, бүтээгдэхүүнийг борлуулахаар үйлдвэрлэн гаргах үеийн шинжлэх ухаан, техникийн түвшнээс шалтгаалан тэдгээрийн гэмтэл согогийг илрүүлэх боломжгүй байсан;

512.2.5.тухайн бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах журам зөрчсөний улмаас гэм хор учирсан болохыг түүнийг худалдсан буюу үйлдвэрлэсэн этгээд нотолсон.

512.3.Энэ хуулийн 512.2.5-д заасан зөрчлийн улмаас бусдад гэм хор учирсан бол уг зөрчил гаргасан этгээд гэм хорыг хариуцна.

512.4.Ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорыг хариуцахад энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

513 дугаар зүйл. Гэм хор учруулснаас төлсөн төлбөрийг буцаан нэхэмжлэх шаардлага

513.1.Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн буюу бусад хуулийн этгээд нь гэм буруутай иргэн болон хуулийн этгээдээс төлбөр, тусламжаа буцаан нэхэмжлэх эрхтэй.

513.2.Гэм хорыг хариуцвал зохих иргэн, хуулийн этгээд нь буцаан нэхэмжилсэн шаардлагын дагуу уг хуулийн этгээдийг хохиролгүй болгох үүрэгтэй.

513.3.Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээ нь энэ хуулийн 507 дугаар зүйлд заасан үндэслэлээр багасвал буцаан нэхэмжлэх шаардлагын дагуу хүлээх хариуцлагын хэмжээ нэгэн адил багасна.

514 дүгээр зүйл. Хохирогчийн гэм буруу, гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэх

514.1.Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно.

514.2.Санаатай гэмт хэргийн улмаас учруулснаас бусад гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоохдоо гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан шүүх багасгаж болно.

Үхэсэг

ӨВЛӨХ

ТАВИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

515 дугаар зүйл. Өвлөх үндэслэл

515.1.Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө.

515.2.Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.

515.3.Өв залгамжлалыг хуульд зааснаар буюу гэрээслэлээр гүйцэтгэнэ.

515.4.Хуульд заасан өв залгамжлалын гагцхүү өвлүүлэгч гэрээслэлээр өөрчлөх эрхтэй.

515.5.Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвлөгдөл зохих эд хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэг адил төрийн өмчлөлд шилжинэ.

515.6.Өвлүүлэгчийн эд хөрөнгийн зарим хэсэг нь гэрээслэгдсэн бөгөөд үлдсэн хэсгийг өвлөх

хууль ёсны өвлөгч байхгүй бол түүнийг төрийн өмчлөлд эзэнгүй эд хөрөнгийн нэг адил шилжүүлнэ.

516 дугаар зүйл. Оюуны үнэт зүйлийг өвлөх

516.1.Оюуны үнэт зүйлийг өвлөх эрх гагцхүү эд хөрөнгийн эрхэд хамаарна. Оюуны үнэт зүйлийг өвлөх эрхийг хуульд зааснаар буюу гэрээслэлээр олж авч болно.

516.2.Оюуны үнэт зүйлийг өвлөх эрх 50 жилийн хугацаанд хадгалагдана.

516.3.Энэ хуулийн 516.1-д зааснаас бусад амин хувийн эрх нь хуульд заасан үндэслэлээр төрд шилжинэ.

517 дугаар зүйл. Өвлөх эрхээ алдах

517.1.Өвлүүлэгчийг, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгчийг санаатайгаар алсан, түүнчлэн тэдгээрийн аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол уг гэм буруутай этгээд хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх эрхээ алдана.

517.2.Энэ хуулийн 517.1-д заасан гэмт хэргийн учир шалгагдаж байгаа этгээдэд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох буюу хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл эд хөрөнгийг өвлүүлж болохгүй бөгөөд өвлөгдөх эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг энэ хуулийн 537 дугаар зүйлд заасны дагуу хамгаалах арга хэмжээ авна.

518 дугаар зүйл. Өв нээгдэх үе

518.1.Өвлүүлэгч нас барсан өдрөөс, түүнчлэн иргэнийг нас барсан гэж зарласан бол энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан өдрөөс өв нээгдэнэ.

519 дүгээр зүйл. Өв нээгдэх газар

519.1.Өвлүүлэгчийн сүүлчийн оршин сууж байсан газар, тэр нь мэдэгдэхгүй бол өвлөгдөх эд хөрөнгө буюу түүний гол хэсэг нь байгаа газрыг өв нээгдсэн газар гэнэ.

ТАВИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хуульд зааснаар өвлөх

520 дугаар зүйл. Хууль ёсны өвлөгч

520.1.Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй.

520.1.1.нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх;

520.1.2.энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ;

520.2.Энэ хуулийн 520.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өв хүлээн авахаас татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол өвлүүлэгчийн ачинцар, зээнцэр нь эцэг, эхдээ хуульд зааснаар өвлөгдвөл зохих байсан эд хөрөнгийн хэсгийг хуваан өвлөнө.

520.3.Энэ хуулийн 520.1, 520.2-т дурдсан иргэнээс гадна өвлүүлэгч нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өвлөгчид тооцогдох бөгөөд өөр өвлөгч байвал энэхүү асрамжинд байсан этгээд нь тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө.

520.4.Гэрийн эд хогшил нь ээлж дараалал, эд хөрөнгийн өвлөгдөх хэсгийн шинж байдлаас үл шалтгаалан өвлүүлэгчийг нас барах үед түүнтэй хамт амьдарч байсан хууль ёсны өвлөгчид шилжинэ.

520.5.Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгийг энэ хуулийн 520.1-520.3-т зааснаар өвлөнө.

520.6.Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн гишүүнд оногдох хэсгийг гагцхүү энэ хуулийн 520.1.1-д заасан этгээд биет байдлаар буюу мөнгөн хэлбэрээр өвлөх эрхтэй.

521 дүгээр зүйл. Гэрээслээгүй үлдээсэн эд хөрөнгийг өвлөх

521.1.Эд хөрөнгийн зарим хэсэг нь гэрээслэлээр өвлөгчид шилжсэн бол үлдэх хэсэг нь хууль ёсны өвлөгчид шилжинэ.

ТАВИН ТАВДУГААР БҮЛЭГ

Гэрээслэлээр өвлөх

522 дугаар зүйл. Гэрээслэлийн агуулга

522.1.Иргэн нь хуульд зааснаар өвлөх

эрхтэй буюу эрхгүй нэг буюу хэд хэдэн иргэн, түүнчлэн төр буюу хуулийн этгээдэд өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь үзэмжээрээ хуваарилан гэрээсэлж болно.

522.2.Төр буюу хуулийн этгээдэд эд хөрөнгө гэрээслэгч нь түүний зориулалтыг зааж болно.

522.3.Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно.

522.4.Хуульд зааснаар өвлөх эрхтэй нэг буюу хэд хэдэн, эсхүл бүх этгээд өвлөх эрхээ хасуулсан тохиолдолд энэ хуулийн 522.3 хамаарахгүй.

522.5.Өв нээгдэхээс өмнө гэрээслэлд заасан өв залгамжлагч нас барсан буюу өвийг хүлээн авахаас татгалзсан бол гэрээслэгч нь өөр өв залгамжлагчийг томилж болно.

523 дугаар зүйл. Гэрээслэлийн хэлбэр, гэрээслэлийг гэрчлүүлэх

523.1.Гэрээслэлийг бичгээр хийж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар, гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ.

523.2. Дараахь тохиолдолд нотариатаар гэрчлүүлсний нэг адил үзнэ:

523.2.1.цэргийн албан хаагчийн гэрээслэлийг түүний алба хааж байгаа цэргийн ангийн удирдлага гэрчилсэн;

523.2.2.хорих газар хоригдож байгаа буюу ажиллаж байгаа иргэний гэрээслэлийг хорих ангийн дарга гэрчилсэн;

523.2.3.хөлөг онгоцонд зорчиж яваа иргэн болон багийн гишүүдийн гэрээслэлийг онгоцны ахмад гэрчилсэн.

523.3.Энэ хуулийн 523.1, 523.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээслэл хүчин төгөлдөр бус байна.

524 дүгээр зүйл. Гэрээслэлээр өвлөгчид даалгах үүрэг

524.1.Гэрээслэгч нь хууль ёсны өвлөгч буюу өөр этгээд, эсхүл нийтийн тусын тулд гэрээслэлээр өвлөгчид аливаа үүрэг хүлээлгэх эрхтэй.

524.2.Гэрээслэлээр өвлөгч нь гагцхүү түүнд өвлүүлсэн эд хөрөнгийн хэмжээнд даалгасан үүргийг гүйцэтгэнэ.

524.3.Гэрээслэлээр өвлөгч нас барсан буюу өвлөхөөс татгалзсан бол түүнд даалгасан үүрэг у өвийг хүлээн авсан бусад өвлөгчдөд шилжинэ.

525 дугаар зүйл. Гэрээслэлийг өөрчлөх цуцлах

525.1.Гэрээслэгч хэдийд ч гэрээслэлээ өөрчлөх буюу цуцлах эрхтэй.

525.2.Шинэ гэрээслэл хийсэн буюу түрүүчийн гэрээслэлийг цуцалсан тухай зохих баримт бичиг гаргаснаар гэрээслэл өөрчлөгдсөн буюу цуцлагдсанд тооцогдоно. Ийнхүү шинээр хийсэн гэрээслэл буюу гэрээслэлээ цуцалсан тухай баримт бичгийг энэ хуулийн 523 дугаар зүйлд заасны дагуу гэрчлүүлнэ.

526 дугаар зүйл. Гэрээслэлийг биелүүлэх

526.1.Гэрээслэл биелүүлэхийг гэрээслэлээр томилогдсон өвлөгчид даалгана.

526.2.Гэрээслэгч нь гэрээслэл биелүүлэгчээр өөр этгээдийг томилж болно.

526.3.Гэрээслэл биелүүлэгч нь даалгасан үүргийг биелүүлэхийг зөвшөөрснөө баталж гэрээслэлд гарын үсэг зурах буюу энэ тухай баримт бичиг үйлдэж, гэрээслэлд хавсаргаснаар у даалгаврыг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

526.4.Гэрээслэл биелүүлэгч гэрээслэлийг биелүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд түүнийг биелүүлэх, өвлөгдсөн эд хөрөнгийг эрхлэн удирдах, хамгаалахад гарсан зайлшгүй зардлаа өвлөгдөх хөрөнгөөс гаргуулан авах эрхтэй.

526.5.Гэрээслэл биелүүлэгч түүний биелүүлмэгц өвлөгчид тайлагнах үүрэгтэй.

ТАВИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Өв хүлээн авах, татгалзах

527 дугаар зүйл. Өв хүлээн авах

527.1.Өвлөгдөх эд хөрөнгийг өвлөгч хүлээн авснаар өв залгамжлалыг гүйцэтгэсэнд тооцно.

527.2.Өвлөгч ямар нэг нөхцөл заах буюу болзол тавьж өвлөгдөх эд хөрөнгийг түр хүлээн авах эрхтэй.

527.3.Өвлөгчийн хүлээн авсан эд хөрөнгийг, өв нээгдсэн өдрөөс эхлэн өвлөгчид шилжсэн гэж үзнэ.

528 дугаар зүйл. Өв хүлээн авах, хүлээн авахаас татгалзах журам

528.1.Өвлүүлэгчийг нас барах хүртэл үүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу сотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

528.2.Энэ хуулийн 528.1-д зааснаас бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг үзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл сотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүсч, өгсөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

528.3.Энэ хуулийн 528.1, 528.2-т заасан хугацаанд өвлөгч өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авааг буюу хүлээн авах тухай хүсэлтээ зохих байгууллага, этгээдэд гаргаагүй бол түүнийг өлгөөс татгалзсан гэж үзнэ.

528.4.Хүндэтгэн үзэх шалтгаан байвал өв хүлээн авах хугацааг шүүх сунгаж болно. Хугацаа сунгасан бол хугацаа хожимдуулсан өвлөгч нь бусад өвлөгчид буюу төрийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгөөс өөрт оногдох бөлэн байгаа эд хөрөнгө, түүхүү түүнийг борлуулсан үнийн зохих хэсгийг гаардан авах эрхтэй.

528.5.Өвлөгч өвлөх эрхээ өвлөвөл зохих бусад этгээдэд шилжүүлэхээр зааж, өв хүлээн авахаас татгалзах эрхтэй.

529 дүгээр зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авах эрх шилжих

529.1.Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өв нээгдсэний дараа уг өвийг хүлээн авч эдлэлүй нас барсан бол өвлөгдөх эд хөрөнгөөс үүнд оногдох хэсгийг хүлээн авах эрх түүний өвлөгчид шилжинэ.

529.2.Иймхүү шилжсэн эрх нь өв хүлээн авах хугацааны дотор нийтлэг журмын дагуу хэрэгжих боловч үлдсэн хугацаа нь эрх шилжих үед гурван сараас доош байсан бол гурван сарын дотор хэрэгжинэ.

530 дугаар зүйл. Өв залгамжлагч нь бусад өв залгамжлагчдыг ирэхээс өмнө өвлөгдөх эд хөрөнгийг авах

530.1.Өвлөгч нь өвлөгдөх эд хөрөнгийг бусад өвлөгчдийн ирэхийг хүлээхгүйгээр авч болох боловч өв нээгдсэн өдрөөс хойш нэг жил өнгөрөөгүй буюу өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүртэл уг эд хөрөнгийг худалдах, бэлэглэх буюу барьцаалах, гэрээслэх эрхгүй.

530.2.Энэ хуулийн 530.1-д заасны дагуу эд хөрөнгө хүлээн авсан өвлөгч тухайн эд хөрөнгөөс дараахь зардлыг гаргах эрхтэй:

530.2.1.өвлүүлэгчийг өвчтэй байхад асрах болон түүнийг оршуулахад гарсан зардал;

530.2.2.өвлүүлэгчийн асрамжид байсан буюу өвлүүлэгчээс тэтгэвэр авах эрхтэй этгээдийг асран тэтгэсний зардал;

530.2.3.хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад төлбөрийн шаардлагыг хангах зардал;

530.2.4.өвлөгдсөн эд хөрөнгийг хамгаалахад гарсан зардал.

531 дүгээр зүйл. Өвлөх эрхийн гэрчилгээ олгох

531.1.Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өвлөх эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргана.

531.2.Хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа олгоно.

531.3.Гэрчилгээ олгох тухай хүсэлт гаргасан буюу өвлөгдсөн эд хөрөнгийг авсан этгээдээс өөр өвлөгч байхгүй нь лавтай баримтаар нотлогдвол гэрчилгээг энэ хуулийн 531.2-т заасан хугацаанаас өмнө олгож болно.

531.4.Энэ хуулийн 522.3-т заасан өвлөх эрх бүхий этгээд байхгүй тохиолдолд гэрээслэлээр

өвлөх эрхийн гэрчилгээг өв нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өвлөгч гэрээслэлээ үзүүлснээр олгоно.

531.5.Эзэнгүй эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлэх гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жилийн дараа төрийн зохих байгууллагад олгоно.

532 дугаар зүйл. Өвлөгдсөн эд хөрөнгийг хуваарилах

532.1.Өвлөгдсөн эд хөрөнгийг өв залгамжлалд оролцсон бүх өвлөгчид хэлэлцэн зөвшөөрөлцөж, хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч бүрт оногдвол зохих хэмжээгээр хуваарилах бөгөөд энэ талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ.

532.2.Өвлүүлэгчийг амьд байхад олдсон бөгөөд төрөөгүй байгаа өвлөгчид оногдох хэсгийг тусгаарлан гаргана.

532.3.Төрөөгүй өвлөгчийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өвлөгдвөл зохих эд хөрөнгийг хуваарилахдаа асран хамгаалах байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

ТАВИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Өвлөх эд хөрөнгийн хэмжээ нэмэгдэх

533 дугаар зүйл. Өвлөх эд хөрөнгийн хэмжээ нэмэгдэх

533.1.Хууль ёсны өвлөгчдийн аль нэг нь өөрт оногдох хэсгийг хэнд олгохыг заалгүй өвлөхөөс татгалзсан, эсхүл өвлөх эрхээ алдсан бол түүнд оногдох хэсгийг хууль ёсны бусад өвлөгчдед тэгш хуваан олгоно.

533.2.Гэрээслэгч өөрийн бүх эд хөрөнгийг гэрээслэлээр тохиолдолд гэрээслэлээр өвлөгчдийн аль нэг нь өөрт оногдох хэсгийг, хэнд олгохыг заалгүйгээр өвлөхөөс татгалзсан, эсхүл өвлөх эрхээ алдсан бол түүнд оногдох хэсгийг энэ хуулийн 522.3-т заасан хууль ёсны өвлөгчдед тэгш хуваан олгоно.

533.3.Гэрээслэгч эд хөрөнгийнхөө зарим хэсгийг гэрээслэлээр бөгөөд гэрээслэлээр өвлөгчдийн аль нэг нь энэ хуулийн 533.2-т заасан үндэслэлээр өвлөгчдийн тооноос хасагдвал, түүнд оногдох хэсгийг хууль ёсны өвлөгчдед тэгш хуваан олгоно.

533.4.Энэ хуулийн 533.1-533.3-т заасан өвлөгдөх эд хөрөнгийн оногдох хэсгийг хүлээн авах өвлөгч байхгүй бол тухайн эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

534 дугаар зүйл. Гэрээслэлээр өвлөгчийн өөрчилсний үр дагавар

534.1.Гэрээслэлээр өвлөгч нь энэ хуулийн 517 дугаар зүйлд заасны дагуу өвлөх эрхээ алдсан тохиолдолд өвлүүлэгч нь түүний оронд өөр өвлөгчийг томилсон бол энэ хуулийн 533.2, 533.3 хамаарахгүй.

ТАВИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Өвлүүлэгчийн үүргийг өвлөгч хариуцах

535 дугаар зүйл. Өвлөгчийн хариуцлага гүйцэтгүүлэгч гомдлын шаардлага гаргах

535.1.Өв хүлээн авсан өвлөгч буюу энэ бүлэгт заасан журмаар эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ.

535.2.Хэд хэдэн өвлөгч байвал, тэдгээр нь энэ хуулийн 535.1-д заасан үүргийг тус тусын өвлөсөн эд хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн хүлээнэ.

536.1.Өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийн талаархи гомдлын шаардлагыг түүний үүрэг гүйцэтгүүлэгч өв нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өвлөгч буюу гэрээслэл биелүүлэгч, нотариат эсхүл эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллагад гаргана.

536.2.Үүрэг гүйцэтгүүлэгч энэ хуулийн 536.1-д заасны дагуу гомдлын шаардлага гаргасан бол түүний хариуг авсан, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусан өдрөөс хойш нэг жилийн дотор нэхэмжлэлээ шүүхэд гаргаж болно.

536 дугаар зүйл. Өвлүүлэгчийн үүрэг

ТАВИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах

537 дугаар зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах журам, хугацаа

537.1.Өв нээгдсэн газрын нотариат нотариатгүй газар баг, сумын Засаг дарга

шаардлагатай гэж үзвэл өвлөгч, өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч, түүнчлэн төрийн ашиг сонирхлын үүднээс өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна.

537.2.Өвлөгдөх эд хөрөнгийг бүх өвлөгч гүлээн авах буюу төрийн өмчлөлд шилжих хүртэл хамгаална.

538 дугаар зүйл. Өвлөгдөх эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоох

538.1.Өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч нэхэмжлэл гаргасан буюу шаардлагатай бусад тохиолдолд нутгийн захиргааны байгууллага өвлөгдөх эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтооно. Эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоохтой холбогдон гарсан зардлыг өвлөгдөх эд хөрөнгөөс гаргана.

YI ХЭСЭГ

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ

ЖАРДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

539 дүгээр зүйл. Олон улсын гэрээ

539.1.Монгол Улс олон улсын гэрээ гайгуулахдаа Монгол Улсын Иргэний хуулийн ийтлэг үндэслэлийг харгалзана.

539.2.Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын Иргэний хуульд зааснаас өөрөөр заасан бөгөөд энэ нь Монгол Улсын Үндэсэн хуулийн заалтад харшлаагүй бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

540 дүгээр зүйл. Гадаад улсын эрх зүйн эм хэмжээг хэрэглэх

540.1.Шаардлагатай бол шүүх иргэний эрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн үсэд харилцаанд зохицуулахад Монгол Улсын ндэсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон ГСЫН гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх үйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн ншлын хэм хэмжээг хэрэглэж болно.

540.2.Гадаад улсын хуульд Монгол Улсын гүлийг баримтлахаар заасан бол Монгол Улсын гуль тогтоомжийг хэрэглэнэ.

540.3.Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд марваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, хүл түүнийг өөр нэрийн дор ялгаатай агуулгаар одорхойлсон бөгөөд Монгол Улсын эрх зүйн эмжээг тайлбарлах аргаар тодорхойлж олохоогүй бол түүний эрх зүйн ангиллыг гтооход тухайн эрх зүйн харилцаа зохицуулсан даад улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзаж болно.

541 дүгээр зүйл. Гадаад улсын хуулийн агуулгыг тогтоох

541.1.Шүүх, арбитр гадаад улсын хуулийг хэрэглэхдээ түүний хэм хэмжээний агуулгыг тэдгээрийн албан ёсны тайлбар, хэрэглэдэг практикт нийцүүлэн тогтооно.

541.2.Гадаад улсын хуулийн хэм хэмжээний агуулгыг тогтоох зорилгоор шүүх, арбитр нь зохих дэмжлэг туслалцаа үзүүлэх, тайлбар хийхийг хүсч, тогтоосон журмын дагуу Монгол Улсын хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монгол Улсад буюу хилийн чанадад байгаа бусад эрх бүхий байгууллагад хандах буюу мэргэжилтэн урьж болно.

541.3.Талууд гадаад улсын хуулийн зохих хэм хэмжээний агуулгыг тодорхойлсон баримт бичгийг гаргаж өгөх эрхтэй.

541.4.Энэ зүйлд заасны дагуу зохих арга хэмжээ авсан боловч гадаад улсын хуулийн хэм хэмжээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

542 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

542.1.Хөөн хэлэлцэх хугацааг тухайн харилцаат зохицуулж байгаа Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

ЖАРАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид

543 дугаар зүйл. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадвар, чадамж

543.1.Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын

хуулиар хязгаарлаж болно.

543.2.Гадаад улсын иргэний иргэний эрх зүйн чадамжийг түүний харьяалагдаж байгаа улсын хуулиар тодорхойлно.

543.3.Харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг түүний байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно.

543.4.Дүрвэгчийн эрх зүйн байдлыг тухайн эгтээдийг оргонуулсан улсын хууль тогтоомжоор тодорхойлно.

543.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хэлцэл, гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаарх гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

543.6.Иргэнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцох буюу чадамжийг нь хязгаарлах асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

543.7.Монгол улсын нутаг дэвсгэр дээр аливаа эгтээдийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

544 дүгээр зүйл. Гадаад улсын хуулийн эгтээдийн иргэний эрх зүйн чадвар

544.1.Гадаад улсын хуулийн эгтээдийн иргэний эрх зүйн чадварыг харьяалсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн зөвшөөрнө.

544.2.Гадаад улсын хуулийн этгээд хэлцэл хийхдээ Монгол Улсын хуулиар тогтоогоогүй хязгаарлалтыг хэрэглэж болохгүй.

545 дугаар зүйл. Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр оролцогч болох нь

545.1.Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр нэг тал болон оролцож байгаа тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг хэрэглэнэ.

546 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах

546.1.Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн этгээд алга болохоосоо өмнө, амьд байгаа тухай хамгийн сүүлчийн мэдээ ирэх үед харьяалагдаж байсан улсын хуулийг баримтална.

546.2.Харьяалалгүй хүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн этгээдийн байнга оршин суудаг газрын хуулиар хэрэв байнгын оршин суух газар байхгүй бол Монгол Улсын хуулиар зохицуулна.

ЖАРАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Өмчийн болон үүргийн эрх зүй

547 дугаар зүйл. Өмчлөх эрх

547.1.Эд хөрөнгийг өмчлөх эрхийг даравхь байдлаар тодорхойлно:

547.1.1.эд хөрөнгийг өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгө байгаа улсын хуулиар;

547.1.2.бүртгэгдвэл зохих эд хөрөнгийг өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгийг бүртгэсэн улсын хуулиар;

547.1.3.Монгол Улсын хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох асуудал нь ийнхүү өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох үндэслэл болсон үйл баримт, бусад нөхцөл байдал үүсэх үед тухайн эд хөрөнгө байсан улсын хуулиар;

547.1.4.талууд өөрөөр тохиролцоогүй бол хэлцлийн зүйл болж байгаа эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох асуудал нь уг хэлцэлд хэрэглэгдэх хуулиар;

547.1.5.талууд өөрөөр тохиролцоогүй бол гадаад эдийн засгийн хэлцлээр замд яваа эд хөрөнгийг өмчлөх эрхийн асуудлыг у эд хөрөнгийг илгээсэн улсын хуулиар;

547.1.6.өмчлөх эрхээ хамгаалах тухай эд хөрөнгийн шаардлага гаргасан өмчлөгчий эрхийг түүний сонгосноор уг эд хөрөнгө байгаа буюу түүнийг бүртгэсэн улсын, эсхүл шүүхээд нэхэмжлэл гаргасан улсын аль нэгний нь хуулиар

547.1.7.эдийн бус баялаг холбогдох эрх нь тухайн эдийн бус баялгий ашиглаж байгаа улсын хуулиар.

548 дугаар зүйл. Хэлцэл

548.1.Хэлцэл хийх, хэлцэл буюу хэлцлий заалтыг хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох тухайн хэлцлийг хүчин төгөлдөр хийгдсэн гэ тооцохоо баримтлах хуулийг мөрдөнө.

548.2.Хэлцлийн хэлбэрийг түүнийг хийсэн буюу тухайн хэлцлийн зүйлээс хамаарч холбогдох улсы хуулиар тодорхойлно.

548.3.Хэлцэл хийж байгаа этгээдүүд өө өөр улсад оршин суудаг бөгөөд аль нэг улсын н

хуулиар тогтоосон хэлцлийн хэлбэрийг харилцан
тохиролцож баримталсан бол тухайн хэлцэл нь
хэлбэрийн хувьд хүчин төгөлдөр байна.

548.4.Монгол Улсын хуулийн шаардлагыг
хангасан бөгөөд гадаадад хийсэн хэлцлийг эвэхэн
хэлбэр эрчсэн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус
гэж тооцож болохгүй.

548.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр
байгаа үл хөдлөх эд хөрөнгетэй холбоотой хэлцлийн
хэлбэрийг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

548.6.Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан
хийсэн бөгөөд энэ хуулийн 548.2-т заасныг
баримтлах бол төлөөлөгчийн хэлцэл хийсэн улсын
хуулийг дагаж мөрдөнө.

548.7.Хэлцэл хийсэн газрыг тогтоох
суудлыг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

548.8.Итгэмжлэлийн хэлбэр, хугацааг
түүнийг олгосон улсын хуулиар тодорхойлох бөгөөд
итгэмжлэл нь Монгол Улсын хуулийн шаардлагыг
хангаж байвал эвэхэн хэлбэрийн талаарх
шаардлагыг зөрчсөн гэх үндэслэлээр хүчин
төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

549 дүгээр зүйл. Гэрээний талууд хуулийг сонгох

549.1.Гэрээний дагуу эдлэх эрх, үүрэг,
гэрээний агуулга, гэрээгээр хүлээсэн үүргээ
биелүүлэх, гэрээ дуусгавар болох бүрэн хүчин
төгөлдөр бус болох, гэрээний үүргээ гүйцэтгэхгүй
буюу зохих ёсоор гүйцэтгэхгүй байх зэрэг асуудлаас
гэсэн үр дагаврыг гэрээ байгуулагч талууд харилцан
тохиролцож тодорхойлсон улсын хуулиар
тохицуулна.

549.2.Тухайн гэрээний харилцааг аль улсын
хуулиар зохицуулах талаар талууд гэрээ
байгуулсныхаа дараа харилцан тохиролцож өөрчилж
болно.

549.3.Тухайн гэрээнд хэрэглэхээр заасан
улсын хууль тогтоомжийг бус өөр улсын хуулийг
баримталсан тохиолдолд түүнийг хүчингүйд тооцно.

549.4.Талууд энэ хуулийн 549.1-д заасны
дагуу хэрэглэх хуулийг сонгоогүй бол дор дурдсан
улсын оршин суугаа /оршин байгаа/ буюу үйл
ажиллагааныхаа голыг явуулдаг улсын хуулиар
тодорхойлно:

549.4.1.худалдах, худалдан авах
гээнд худалдагчийн;

549.4.2.эд хөрөнгө хөлслөх гэрээнд
хлүүлэгчийн;

549.4.3.хадгалалтын гэрээнд
адгалагчийн ;

549.4.4.комиссийн гэрээнд
комиссийн;

549.4.5.даалгаврын гэрээнд
даалгавар гүйцэтгэгчийн;

549.4.6.тээвэрлэлтийн гэрээнд
тээвэрлэгчийн;

549.4.7.даатгалын гэрээнд
даатгуулагчийн;

549.4.8.зээлийн гэрээнд
зээлдүүлэгчийн;

549.4.9.бэлэглэлийн гэрээнд
бэлэглэгчийн;

549.4.10.батлан даалтын гэрээнд
батлан даагчийн;

549.4.11.барьцааны гэрээнд
барьцаалуулагчийн.

549.5.Талууд өөрөөр тохиролцоогүй бол
үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа явуулах,
мэргэшүүлэх, хорших, их барилга барих, угсрах,
бусад ажил гүйцэтгэх гэрээнд нутаг дэвсгэр дээр
нь уг үйл ажиллагаог явуулж байгаа буюу гэрээний
үр дагавар бий болж байгаа улсын хуулийг
хэрэглэнэ.

549.6.Гадаад улсын хуулийн этгээд буюу
иргэн оролцсон хамтарсан үйлдвэр байгуулах тухай
гэрээнд тухайн хамтарсан үйлдвэрийн оршин байгаа
улсын хуулийг хэрэглэнэ.

549.7.Биржийн хэлцэл, үнэ хаялцуулах
ажиллагааны үр дүнд байгуулагдсан гэрээнд тухайн
биржийн хэлцэл хийсэн буюу үнэ хаялцуулах
ажиллагаа явуулсан улсын хуулийг хэрэглэнэ.

549.8.Энэ хуулийн 549.1-549.4-т заагаагүй
бусад гэрээний талуудын эрх, үүрэг нь тухайн
гэрээний агуулгад шийдвэрлэх ач холбогдол бүхий
үүргийг гүйцэтгэж байгаа талын оршин суугаа /оршин
байгаа/ буюу үйл ажиллагааныхаа голыг явуулдаг
улсын хуулиар тодорхойлогдоно.

549.9.Талууд өөрөөр тохиролцоогүй бол
үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахад хүлээн авч
байгаа улсын хуулийг харгалзан үзнэ.

550 дугаар зүйл. Шаардах эрх шилжих

550.1.Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шаардах
эрх шилжих нь хуучин үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг
гүйцэтгэгч нарын тухайн гэрээс байгуулахдаа
баримталсан улсын хуулиар тодорхойлогдоно.

550.2.Үүрэг гүйцэтгэгчийн хуучин болон
шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх эрх, үүрэг
нь шаардах эрх шилжүүлэхэд баримталсан улсын
хуулиар тодорхойлогдоно.

551 дүгээр зүйл. Гэм хор учруулсны улмаас үүсэх үүрэг

551.1.Гэм хор учруулсны улмаас үүсэх
үүргийн талуудын эрх, үүргийг нутаг дэвсгэр дээр

нь гэм хор учруулсан үйл баримт буюу гэм хор арилгуулах тухай шаардлага гаргах үндэслэл болсон бусад нөхцөл байдал бий болсон улсын хуулиар тодорхойлно.

551.2.Гэм хор учруулсны улмаас хилийн чанадад үүссэн үүргийн талууд нь Монгол Улсын иргэн буюу хуулийн этгээд байвал тэдгээрийн эрх, үүргийг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

ЖАРАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Өвлөх харилцаа

552 дугаар зүйл. Өвлөхөд хэрэглэгдэх хууль

552.1.Өвлөх харилцааг өвлүүлэгч хамгийн сүүлд нутаг дэвсгэр дээр нь байгаа амьдран сууж байсан улсын хуулиар зохицуулна.

552.2.Өвлүүлэгчийн иргэний эрх зүйн чадвар, гэрээслэлийн хэлбэр, гэрээслэл хийх, түүнийг өөрчлөх асуудлыг уг гэрээслэгчийг хийх болон түүнийг өөрчлөх үед гэрээслэгчийн байнга амьдран сууж байсан улсын хуулиар тодорхойлно.

552.3.Гэрээслэл хийх, өөрчлөх нь түүний хийгдсэн улсын хууль болон Монгол Улсын хуулийн шаардлагад тохирч байвал зөвхөн хэлбэрийг баримтлаагүй гэх үндэслэлээр гэрээслэл болон түүнийг өөрчилснийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

552.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгийг өвлүүлэх, гэрээслэх, түүнийг өөрчлөхөд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан Монгол Улсын Иргэний хууль /шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Иргэний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.

1.1.Монгол Улсын Иргэний хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүгэй.

2 дугаар зүйл.

2.1.Иргэний хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 25 дугаар зүйлийн 25.5, 26 дугаар зүйлийн 26.2, 27 дугаар зүйлийн 27.5, 34 дүгээр зүйлийн 34.2, 35 дугаар зүйлийн 35.2, 36 дугаар 36.3, 36.5, 143 дугаар зүйлийн 143.6, 182 дугаар зүйлийн 182.1, 182.3, 185 дүгээр зүйлийн 189.2, 432 дугаар зүйлийн 432.2, 445 дугаар зүйлийн 445.8, 451 дүгээр зүйлийн 451.3, 454 дүгээр зүйлийн 454.7 дахь хэсэгт заасан харилцаа тухайн харилцааг зохицуулсан шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уг харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж байсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эовлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (245)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны хоёрдугаар сарын 28 №8 (245)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

83. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (2002-01-10-ны хууль) 385
84. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-01-10-ны хууль) 426
85. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2002-01-10-ны хууль) 426
86. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-01-10-ны хууль) 471
87. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-01-10-ны хууль) 471
88. Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-01-10-ны хууль) 472

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

89. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 03 472

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

I ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хяна шийдвэрлэх хууль тогтоомж

2.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэ хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], эн хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хуул тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[1] *Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

2.2.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын ıэнэд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол эн улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Шүүхэд мэдүүлэх эрх

3.1.Монгол Улсын хууль, Монгол Улсын дэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, х чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн к үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ мгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу гухэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах лбөрээр мэдүүлэх эрхтэй.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан эрхийг мгаалах талаархи нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг гухээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг улиар тогтоож болно.

3.3.Хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх йн маргааныг энэ хуульд заасан журмын дагуу гүх хянан шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш йх

4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан ийдвэрлэх ажиллагаа /цаашид "хэрэг хянан ийдвэрлэх ажиллагаа" гэх/ нь хүний үндэс, угсаа, л, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, йдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан шаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол олон бусад байдал, хуулийн этгээдийг ёмчийн лбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш йх зарчимд үндэслэн явагдана.

5 дугаар зүйл.Шүүх эрх мэдлийг шүүх рэгжүүлэх, шүүгч хараат бус байх

5.1.Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу йгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

5.2.Шүүгч хараат бус байж гаргахүү хуульд ıхирагдах бөгөөд шүүгч хараат бус байх баталгаат үлиар тогтооно.

5.3.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их рлын ба Засгийн газрын гишүүн, төрийн болон рийн бус байгууллагын албан тушаалтан, иргэн эн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ рэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг ıригдоно.

5.4.Энэ хуулийн 3.1-д заасны дагуу гаргасан эхэмжлэл, хүсэлт, гомдлыг тухайн шүүхийн үүгчидийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу үүгчид урьдчилан хуваарилна.

5.5.Зохигч хэргийг энэ хуулийн 5.4-т заасан уваарийн дагуу шийдвэрлүүлэхийг шаардах эрхтэй.

6 дугаар зүйл.Мэтгэлцэх зарчим

6.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаат мэтгэлцэх үндэсэн дээр хэрэгжүүлнэ.

6.2.Мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ.

6.3.Зохигч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсэхийг нотлох буюу үгүйсгэх замаар мэтгэлцэнэ.

6.4.Зохигч шүүх хуралдааныг биеэр оролцож үг хэлэх, бичгээр тайлбар өгөх, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцоно.

6.5.Зохигч гагцхүү бодит байдалд нийцсэн тайлбар өгөх, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах үүрэгтэй.

6.6. Нэхэмжлэлийн шаардлагын талаархи тайлбарыг гагцхүү зохигч талууд гаргана. Энэ хуулийн 133 дугаар зүйлд заасан жүрмаар хянан шийдвэрлэх хэрэгт энэ заалт хамаарахгүй.

7 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг

7.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаат монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна. Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаат дүрс болон дууны бичлэгт буулгаж болно.

7.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч этгээд монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хэрэв хараагүй, хэлгүй, дүлий хэрэг шалтгааны улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар, мэдүүлэг өгөх, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх эрхтэй.

7.3.Шүүх энэ хуулийн 7.2-т заасан этгэдээс гаргасан тайлбар, мэдүүлэг, нотлох баримт, хэлсэн үгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай өйн этгэдэд орчуулагч, хэлмэрчээр дамжуулан танилцуулах үүрэгтэй.

7.4.Гадаад хэлээр бичигдсөн нотлох баримтыг албан ёсны эвшөөрөл бүхий орчуулагч, хэлмэрчээр монгол хэл дээр орчуулуулж нотариатчаар гэрчлүүлсэн байна.

8 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

8.1. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2.Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн бүюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

8.3.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан буюу мансуурсан, хэргийн оролцогч биш бол 18 насанд хүрээгүй эгтээдийг шүүх хуралдааны танхимд байлгаж болохгүй.

8.4.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулж болохгүй.

9 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах

9.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

9.2.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.

10 дугаар зүйл.Хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх

10.1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ.

10.2.Хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаа саналаа гаргана.

10.3.Улсын дээд шүүхийн хуралдаанаар эн хуулийн 10.2-т заасан саналыг хэлэлцэх үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлтийг мэдүүлэх тухай тогтоол гаргана. Хари үндэслэлгүй гэж үзвэл ердийн журмаар хянан шийдвэрлүүлэхээр санал гаргасан шүүхэд буцаана

10.4.Тухайн маргаантай харилцаа зохицуулсан хууль байхгүй бол шүүх тесөөтэй харилцаг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээ хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.

10.5.Монгол Улсын Үндсэн хууль харшлахгүй бол шүүх олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ төсөөтэй хэрэглэж болно.

10.6.Шүүх тухайн маргаантай харилцаа зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

10.7.Шүүх хуулиуд хоорондоо зөрчилтэй буюу хууль шударга бус, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш гэсэн үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзаж болохгүй.

11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх

11.1.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ.

11.2.Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, хэргийн харьяалал

12 дугаар зүйл.Иргэний хэрэг үүсгэх үндэслэл

12.1.Шүүх дараахь үндэслэлээр иргэний хэрэг /цаашид "хэрэг" гэх/ үүсгэж болно:

12.1.1.эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдөж тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл;

12.1.2.бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл;

12.1.3.онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт;

12.1.4.захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон эрх зүйн актын

алаар гаргасан гомдол;

12.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

13 дугаар зүйл. Хэргийн харьяалал

13.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан ндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол цаашид "нэхэмжлэл" гэх/-ыг шүүх харьяалан ийдвэрлэнэ.

13.2.Хууль, Монгол Улсын олон улсын эрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон ол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн аргааныг арбитр шийдвэрлэнэ.

13.3.Талууд байгуулсан гэрээндээ маргаан арвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу нэ талаар хэлэлцэн тохиролцоогүй, эсхүл Засгийн азар хоорондын хэлэлцээрээр маргааныг арбитраар ийдвэрлүүлэхээр заагаагүй бол нэхэмжлэлийг үүх шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг ариуцагчийн оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн харьяаллаар гаргах

14.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй ол нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа азрын шүүхэд гаргана.

14.2.Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд аргана.

14.3.Хариуцагчийн оршин суугаа газар мэдэгдэхгүй байвал нэхэмжлэлийг эд хөрөнгө нь байгаа газрын шүүхэд гаргаж болно.

14.4.Хариуцагчийн оршин суугаа газрын хаяг мэдэгдэхгүй байвал түүнийг эрэн сурвалжлуулахаар нэхэмжлэгч шүүхэд хүсэлт аргаж болно.

14.5.Хариуцагчийг эрэн сурвалжлах, түүний оршин суугаа газрыг тогтоох ажиллагааг шүүгчийн захирамжийн дагуу цагдаагийн байгууллага үйцэтгэнэ.

15 дугаар зүйл. Нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяалал

15.1.Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч, эсхүл нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

15.2.Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно.

15.3.Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн хариуцагчид холбогдох нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн үзэмжээр хариуцагчдын аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ газрын шүүхэд гаргана.

15.4.Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

16 дугаар зүйл. Шүүхийн онцгой харьяалал

16.1.Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой буюу эд хөрөнгийн битүүмжлэлийг нээлгэх тухай нэхэмжлэлийг тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргана.

16.2.Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл хариуцагчийн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргаж болно.

16.3.Өв залгамжлагч өвийг хүлээн авахаас өмнө өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгэгчээс гаргах нэхэмжлэлийг өвлөгдөх эд хөрөнгө бүхэлдээ буюу түүний гол хэсэг нь байгаа газрын шүүхэд гаргана.

16.4.Тэжээн тэтгэхтэй холбогдсон нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

17 дугаар зүйл. Хоорондоо холбоотой хэд хэдэн хэргийн шүүхийн харьяалал

17.1.Гэмт хэрэг үйлдэгдсэнээс үүссэн хохирлын талаархи нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэнэ.

17.2.Хэрэв эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлээгүй бол уг нэхэмжлэлийг хуульд заасан журам, харьяаллын дагуу гаргана.

17.3.Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг эрүүгийн хэрэг нь шийдвэрлэгдээгүй байхад иргэний журмаар хэлэлцэхгүй.

18 дугаар зүйл. Харьяаллыг өөрчлөх

18.1. Хэргийн нутаг дэвсгэрийн харьяаллыг зохиогч хэлэлцэн өөрчилж болно.

18.2. Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан

шүүхийн онцгой харьяаллыг зохигч хэлэлцэн өөрчилж болохгүй.

19 дүгээр зүйл. Хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

19.1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх иргэний бүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

19.2. Аймаг, нийслэлийн шүүх иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

19.3.Улсын дээд шүүх иргэний хэргийг энэ хуулийн 172.2-т заасан үндэслэлээр хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл. Хэрэг шилжүүлэх

20.1.Харьяаллын дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ. Харин талуудын тайлбарыг үндэслэн дараахь шалтгаанаар шүүх хуралдааны өмнө буюу шүүх хуралдааны явцад шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар өөр шүүхэд шилжүүлж болно:

20.1.1.хэргийг тал бүрээс нь бодитой, шуурхай хянан шийдвэрлэхийн тулд нотлох баримтын дийлэнх нь байгаа газрын шүүх: хянан шийдвэрлэх шаардлагатай гэж үзвэл;

20.1.2.нэхэмжлэлийг хүлээ авахдаа шүүхийн харьяаллыг зөрчсөн нь илэрвэ

20.1.3.энэ хуулийн 92 дугаар зүйл заасны дагуу тухайн шүүхийн бүх шүүгчий татгалзан гаргасан бол.

20.2.Энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр харьяалагдах хэрэг бол шүүх тогтоол, шүү захирамж гарган нэхэмжлэлийг нэхэмжлэгчи буцаана.

20.3.Шилжүүлсэн хэргийг хүлээн авса шүүх түүнийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Э хуулийн 20.1-д заасны дагуу шилжүүлсэн хэрги харьяаллын талаар шүүхүүд хоорондоо марга болохгүй.

21 дүгээр зүйл. Хэрэг шилжүүлэх журам

21.1.Хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэ шилжүүлэх тухай шүүхийн тогтоол, шүүгчий захирамжид гомдол гаргах хугацаа өнгөрөөгүй у хэргийг шилжүүлнэ. Хэрэв гомдол гарсан бол у гомдлыг хянан шийдвэрлэсэн тухайн шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хэргийг шилжүүлн

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

22 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

22.1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн энэ хуулийн 12.1.2-12.1.4-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг хэргийн оролцогч гэнэ.

23 дугаар зүйл.Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар

23.1.Хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар /иргэний эрх зүйн чадвар/- ыг бүх оролцогч тэгш эдэлнэ.

24 дүгээр зүйл.Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадамж

24.1.Шүүхэд эрхээ өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөр дамжуулан гүйцэтгүүлэх чадвары иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд эдэлнэ.

24.2.Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн өөрийн эрх, эрх чөлөө, хуулиа хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд хамгаала эрхтэй .

24.3.Шүүх энэ хуулийн 24.2-т заасан иргэн, хамаарагдах хэрэгт түүний эцэг, эх, харгалзаа дэмжигчийг татан оролцуулах үүрэгтэй. Хари насанд хүрээгүй иргэнтэй холбоотой хэргий Иргэний хуулийн[1] 16.3-т заасан үндэслэлээр хянаг шийдвэрлэхдээ түүний эцэг, эх, харгалзаа дэмжигчийг оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ

24.4.Иргэний эрх зүйн зарим чадамжтаг түүнчлэн сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүй чадамжгүй гэж тооцогдсон этгээдийн эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг тэдгээрий эцэг, эх, асран хамгаалагч шүүхэд хамгаална.

25 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн эрх үүрэг

25.1.Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь эрх эдэлнэ:

[1] *Монгол Улсын Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.*

25.1.1.эсрэг талын шаардлага, эйлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай анилцах, тэдгээрт тайлбар өгөх;

25.1.2.хэргийг шүүх хуралдаанаар элэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсны араа хэргийн материалтай танилцах, түүнээс эмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох;

25.1.3. гэрчээс мэдүүлэг вахуулах, шинжээч томилуулах болон энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгүүлэх, уурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, үглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох аримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд аасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт аргах;

25.1.4.энэ хуулийн 91 дүгээр зүйлд аасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, линжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах;

25.1.5.шүүх хуралдааны бусад ролцогчдод асуулт тавих;

25.1.6.шүүхийн шийдвэрт давж аалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах;

25.1.7. хуульд заасан бусад эрх.

25.2.Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь үүрэг үлээнэ:

25.2.1.шүүхэд хэргийн талаар үнэн юв тайлбар гаргах;

25.2.2.шүүхэд гаргасан эхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, атгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой аримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, аргаж өгөх;

25.2.3. шүүхийн дуудсанаар үрэлцэн ирэх;

25.2.4. шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

25.2.5.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;

25.2.6.шүүхийн шийдвэрийг биелүүлэх.

26 дугаар зүйл. Зохигч

26.1.Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна.

26.2.Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргач этгээдийг хэлнэ. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл болон нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх, багасгах, нэхэмжлэлээс татгалзах, эвлэрэх эрхтэй.

26.3.Хариуцагч гэж нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлэгүй гэж нэхэмжлэл дурдсан этгээдийг хэлнэ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх эрхтэй.

26.4.Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрх эдэлнэ.

27 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн зохигч оролцох

27.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн нэхэмжлэгч буюу хэд хэдэн хариуцагч хамтран оролцож болно.

27.2.Хамтран нэхэмжлэгч буюу хамтран хариуцагч нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн хэргийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулж болно.

27.3.Шаардлагатай гэж үзвэл шүүх шийдвэрээ гаргахаас өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр нэхэмжлэгч, хариуцагчийг татан оролцуулж болно.

28 дугаар зүйл. Нэхэмжлэгч, хариуцагчийг солих

28.1.Нэхэмжлэгч уг нэхэмжлэлийг гаргах эрхгүй, эсхүл хариуцагч уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар тогтоогдвол шүүх нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийг жинхэнэ нэхэмжлэгчээр, хариуцагч биш этгээдийг жинхэнэ хариуцагчаар тус тус сольж болно.

28.2.Жинхэнэ нэхэмжлэгчээр солихыг энэ хуулийн 28.1-д заасан нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд зөвшөөрөөгүй бол гуравдагч этгээдийн хувьд түүнийг шүүх оролцуулж болно.

28.3.Хариуцагчийг өөр этгээдээр солихыг нэхэмжлэгч зөвшөөрөгүй бол шүүх уг этгээдийг хоёр дахь хариуцагчаар татан оролцуулна.

28.4.Энэ хуулийн 28.1-д заасан байдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдвол нэхэмжлэгч, хариуцагчийг сольсны дараа шүүх хуралдааны ажиллагааг шинээр эхлэн явуулна.

29 дүгээр зүйл. Гуравдагч этгээд

29.1.Маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

29.2.Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд зохигчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

29.3.Шүүхээс гарах шийдвэр маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт муугаар нөлөөлөхөөр байвал шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийн өөрийнх нь, эсхүл шүүхийн санаачилгаар болон зохигчийн хүсэлтээр бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

29.4.Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан үндэслэл ба нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээс татгалзах, нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, эвлэрэхээс бусад зохигчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

30 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах

30.1.Маргаантай эрх зүйн харилцааны зохигчийн аль нэг нь уг эрх зүйн маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн/ бол шүүх тэрхүү зохигчийг сонирхогч этгээд буюу эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлан авах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гүйцэтгэгдэж болно.

30.2.Эрх залгамжлагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

31 дүгээр зүйл. Прокурор, бусдын эрхийг хамгаалж байгаа этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох

31.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.

31.2.Бусдын эрх, эрх чөлөө, хуулиа хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байга этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэ ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасн дагуу оролцож болно.

31.3.Энэ хуулийн 31.1,31.2-т заасан этгээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан оролцохоос, эсхүл гаргасан нэхэмжлэлээсэ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэ ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй.

32 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэ ажиллагаанд иргэнийг төлөөлөх

32.1.Иргэн өөрийн биеэр бую төлөөлегчөөрөө дамжуулан хэрэг хяна шийдвэрлэхэд оролцоно.

32.2.Төлөөлөл нь хуульд зааснаар, эсхү сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэ байна.

32.3.Иргэний эрх зүйн чадамжгүй, зарим буюу бүрэн бус чадамжтай, түүнчлэн сураггүй алг болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдса хүний Иргэний хуульд заасан төлөөлөгч нь бүрэ төлөөлнө.

32.4.Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сай дурарааа гэр бүлийн гишүүн, төрөл садангараа эсхүл гэрээний үндэсэн дээр өмгөөлөгчөө төлөөлүүлж болно.

33 дугаар зүйл. Иргэнийг хуульд заасна төлөөлөх

33.1.Эрх зүйн чадамжгүй, зарим буюу бүрэ бус чадамжтай хүний эрх, эрх чөлөө, хуулиа хамгаалагдсан ашиг сонирхлыг түүний хууль ёсны төлөөлөгч болох эцэг, эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нь шүүхэд төлөөлөх бөгөөд тэд өөрийн бүрэн эрхийг нотлох баримт бичгийг шүүхэд үзүүлнэ.

33.2.Сураггүй алга болсонд тооцогдсон хүн оролцвол зохих байсан хэрэгт эд хөрөнгийг нь эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүний төлөөлөн оролцоно.

33.3.Нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан хүний өв залгамжлагч оролцвол зохих байсан хэрэгт өв залгамжлагч нь уг өвийг хүлээж авааруй байвал өвлөгдөх эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүнийг төлөөлөн оролцоно.

33.4.Энэ хуулийн 33.1-д заасан хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн сонгон

сан төлөөлөгчийг оролцуулж болно.

34 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх хиллагаанд өмгөөлөгч оролцох, түүний эрх, үүрэг

34.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олцох өмгөөлөгчийн төлөөлөх эрх нь эрх зүйн слалцаа авч байгаа талын хүсэлтээр дорхойлогдоно.

34.2.Өмгөөлөгч гэрээний үндсэн дээр иргэн, улийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн ах, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг амгаалах зорилгоор хуульд заасан бүх арга мжээ авах бөгөөд ажиллагатай эрх зүйн туслалцаа үүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах рэгтэй.

34.3.Өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх хиллагаанд гэрээгээр оролцохдоо Өмгөөллийн хай хуулыг заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

34.4.Өмгөөлөгчийн эрх нь эрх бүхий йгууллагаас олгосон баримт бичгээр батлагдана.

35 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх киллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх

35.1.Хуулийн этгээд төлөөлөгчөөрөө амжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олцоно.

35.2.Хуулийн этгээдийг төлөөлж байгаа гээд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх ногдсоныг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд ъүүлнэ.

36 дугаар зүйл. Төлөөлөгчийн бүрэн эрх, элөөлөн оролцож болохгүй байдал

36.1.Төлөөлөгч төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.

36.2.Төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлүүлэгчээс бичгээр олгосон итгэмжлэл, бусад бичиг баримтаар тодорхойлно. Итгэмжлэлд зохигчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийн заримыг төлөөлөгчид эдлүүлэхгүй байхаар зааж болно. Итгэмжлэл нь Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна.

36.3.Төлөөлөгч өөрийн бүрэн эрхийг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ.

36.4.Төлөөлүүлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийг нь төлөөлж байгаа этгээдээс хэдийд ч татгалзаж болох бөгөөд энэ тухай шүүхэд бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэл шүүхэд ирснээр төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болно.

36.5.Дор дурдсан этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцохыг хориглоно:

36.5.1. 18 насанд хүрээгүй /хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд/;

36.5.2.эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй;

36.5.3.өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нотлох баримт

37 дугаар зүйл. Нотлох баримт

37.1.Хэргийн оролцогчоос өөрийн аардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх эргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, уульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит өхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа аримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

37.2.Хэргийн нотлох баримт нь зохигч, үүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч тгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба д мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

38 дүгаар зүйл. Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх

38.1.Зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах

Өмгөөллийн тухай хууль "Төрийн мэдээлэл" мхтэлийн 1995 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

үүрэгтэй.

38.2.Энэ хуулийн 38.1-д зааснаас бусад оролцогч нотлох баримт гаргаж болно.

38.3.Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болно.

38.4.Хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргах буюу түүнийг хууль бус аргаар цуглуулахыг хориглоно.

38.5.Нотлох баримтыг гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол тэдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

38.6.Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгуллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.

38.7.Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргаж өгнө.

38.8.Шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал татгалзсан ч эсрэг тал нь түүнийг иш татах эрхтэй.

38.9.Шүүх хуралдааны явцад шинэзэр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах буюу шаардан авахаас татгалзах эрхийг шүүх эдлэх бөгөөд эдгээр тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

38.10.Шүүхээс нотлох баримтыг бүрдүүлэх явцад гарсан зардлыг шүүхийн зардалд тооцно.

39 дүгээр зүйл. Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх

39.1.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол зохигчийн хүсэлтээр шүүх өөрөө, эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

39.2.Шүүхийн хүсэлтийг биелүүлэх жүрмыг тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр, ийм гэрээ байхгүй тохиолдолд дипломат шугамаар тохиролцоно.

40 дүгээр зүйл. Нотлох баримтыг үнэлэх

40.1.Шүүх хэргийн оролцогчийн гаргаса нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоо харьцуулан үзэсний үндэсн дээр нотлох баримты өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

40.2.Нотлох баримтыг тухайн хэрэг хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй талаас нь үнэлнэ.

40.3.Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэ тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй

40.4.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээ нэгэнт тогтоогдсон буюу ниітэд илэрхий үйл барим хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байва түүнийг дахин нотлохгүй.

40.5.Анхан шатны шүүхэд гаргаагүй нотло баримтыг давж заалдах болон хяналтын журмаа гаргасан тохиолдолд шүүх түүнийг үнэлэхгүй Харин шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаа шүүхийн шийдвэрийг дахин хянах гэж байгаа бо энэ заалт хамаарахгүй.

41 дүгээр зүйл. Шүүхийн даалгавар түүнийг биелүүлэх

41.1.Шийдвэрлэж байгаа хэргийн талаар өө орон нутгаас нотлох баримт бүрдүүлэх зайлшгү шаардлагатай байвал зохигчийн хүсэлтийг үндэслэ шүүгч захирамж гарган тодорхой ажиллага гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгана.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан захирамжи хэргийн товч агуулга, бүрдүүлбэл зохих нотло баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацаа тогтооно.

41.3.Шүүхийн даалгавар хүлээн авсан шүү түүнийг тогтоосон хугацаанд заавал биелүүлнэ.

41.4.Шүүхийн даалгавар биелүүлэхэд хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн бүх материалы хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд тогтоосо хугацаанд хүргүүлнэ.

42 дугаар зүйл. Зохигчийн тайлбар

42.1. Зохигчийн шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн байна.

42.2. Зохигч нэг талын гаргасан тайлбар, нотлох баримтын талаар эсрэг тал өөрийн тайлбараа холбогдох нотлох баримтын хамт гаргаж болно.

42.3. Энэ хуулийн 42.2-т заасан тайлбарыг зохигч тал гаргахдаа негөө талын гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн буюу түүний зарим хэсгийг хүлээн зөвшөөрч болно.

42.4. Нэг талын гаргасан тайлбарыг эсрэг л эсэргүүцээгүй, эсхүл_хуулиар тогтоосон гацаанд тайлбар өгөөгүй бол тайлбарыг хүлээн вшөөрсөнд тооцно.

43 дугаар зүйл. Гэрчийн мэдүүлэг

43.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач олбогдол бүхий байдлыг мэдэж байгаа хэн ч гэрч йж болно.

43.2.Гэрчийг шүүх хэргийн оролцогчийн үсэлтээр дуудаж мэдүүлэг авна.

43.3.Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд авал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үрэгтэй. Мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу йлсхийх, зориуд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн ульд[1] заасан хариуцлага хүлээлгэнэ.

43.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа ізарт нь очиж мэдүүлэг авч болно.

43.5.Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн эх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан рүүлэхийг шүүхээс цагдаагийн байгуулагад аалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар эгтоож болно.

43.6.Гэрчүүдийн мэдүүлэгтноцтой зөрүү айвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч олно. Шүүгч нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа эрчүүдээс бие биеэ таних эсэх, хоорондоо ямар арилцаатай болохыг асууна. Дараа нь тодруулах эж байгаа зүйлийн талаар гэрчүүдээс ээлжлэн эдүүлэг гаргуулна. Мэдүүлэг өгсний дараа шүүгч эрчүүдэд асуулт тавьж болно. Харилцан үүрэлдэж байгаа гэрчүүд бие биедээ асуулт тавьж олохгүй.

43.7.Зохигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, үүхдийг зөвхөн өөрсдийнх нь зөвшөөрснөөр гэрчээр эдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд тэд гэрчийн рх эдэлж, үүрэг хүлээнэ.

43.8. Дараахь хүнийг гэрчээр дуудах буюу эдүүлэг авч болохгүй:

43.8.1.үүргээ гүйцэтгэх замаар уг эргийн байдлыг мэдэх болсон зохигчийн төлөөлөгч буюу эрүүгийн хэргийн өмгөөлөгч;

43.8.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

44 дүгээр зүйл. Бичмэл нотлох баримт

44.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

44.2.Бичмэл нотлох баримтыг шүүхэд эхэлж нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Хуулбарыг өгсөн үед шаардлагатай гэж үзвэл шүүх жинхэнэ эхийг шаардан авах эрхтэй. Бичмэл нотлох баримтыг шаардан авахад бэрхшээлтэй байвал зохигчийн хүсэлтээр түүний хадгалагдаж байгаа газарт нь шүүх үзлэг явуулах ба шинжлэн судалж болно.

44.3.Шүүхийн шийдвэр гарсны дараа бичмэл баримтын эхийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг хэрэгт үлдээнэ.

45 дугаар зүйл. Эд мөрийн баримт

45.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоож чадах биет зүйлийг эд мөрийн баримт гэнэ.

45.2.Эд мөрийн баримтыг хэрэгт, эсхүл тусгай байр, савand тодорхой бүртгэлтэйгээр хадгална. Шүүхэд авчирч хадгалах боломжгүй эд мөрийн баримтыг түүний байгаа газарт нь үзлэг хийж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай бол уг эд мөрийн баримтын талаар гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг хийж бэхжүүлэн хэрэгт хавсаргах буюу түүнийг битүүмжилж болно. Хүнсний ба түргэн муудаж, гэмтэх бусад зүйлд үзлэгийг шүүхээс хэргийн оролцогчдод мэдэгдэж дарүй хийнэ. Үзлэг хийсний дараа уг зүйлийг хуульд өөрөөр заагаагүй бол гаргаж өгсөн этгээдэд буцаан олгоно.

45.3.Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл зохих баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.

45.4.Энэ хуулийн 120.2-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд эд мөрийн баримтыг хуульд өөрөөр заагаагүй бол эзэмшигчид буцаан олгоно. Харин эд мөрийн баримтын кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэгийг хэрэгт үлдээнэ.

46 дугаар зүйл. Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөх

46.1.Иргэн, хуулийн этгээд шүүхээс

[1] *Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" мхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн*

шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг шүүхээс заасан хугацаанд гаргаж өгнө. Хэрэв иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргаж өгөх боломжгүй бол энэ тухайгаа шаардсан шүүхэд мэдэгдэнэ.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй гэм буруутай албан тушаалтан, иргэнд зохих хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

46.3.Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай, төр, байгуллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр холбогдох иргэн, хуулийн этгээд түүний албан тушаалтан гаргаж өгөх үүрэгтэй.

46.4.Энэ хуулийн 46.3-т заасан нотлох баримтыг гаргаж өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзвал түүнийг албадан гаргуулна.

47 дугаар зүйл. Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт

47.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тоолгоо, тос бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүгч захирамж гарган шинжээчийг томилно.

47.2.Шинжээч нь мэргэжлийн байгуллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байна.

47.3.Шинжээч байгуллагаас томилогдсон бол тухайн байгуллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж түүний үнэн зөвийг хариуцна.

47.4.Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

47.5.Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.

47.6.Шинжээч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, тавьсан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй. Шинжээч саналтайгаар худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

47.7.Шинжээчид өгсөн материал дүгнэл гаргахад хангалтгүй буюу шинжээч онгосон үүрги биелүүлэхэд шаардагдах мэдлэг зээмшээгү байвал дүгнэлт гаргахаас татгалзаж болно.

47.8.Шинжээч шаардлагатай гэж үзвэ тухайн хэргийн материалтай танилцах, нэмэл материал гаргаж өгөхийг шүүхэд хүсэх эрхтэй.

47.9.Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргана Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэ дээр гаргасан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуулта өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ

47.10.Шинжээч хэрэгт ач холбогдол бүхи шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаа шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтдэ оруулах эрхтэй.

48 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа

48.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд а холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тул шүүх үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчийг байцаулна хэргийн оролцогчдыг оролцуулан хийх бөгөөд эн тухай тэмдэглэл үйлдэж, түүнд уг ажиллагаан, оролцогчдоор нарын үсэг зуруулна. Харин хэргий оролцогч ирээгүй нь уг ажиллагаа явуулахад саа болохгүй.

48.2.Хөндлөнгийн гэрчээр уг хэрэгт хувий болон албаны сонирхолгүй, эрх зүйн бүрэ чадамжтай иргэнийг оролцуулна. Хөндлөнгийн гэр түүнийг байцаулан хийсэн ажиллагааны явц агуулга, дүгнэ баталж өгөх үүрэгтэй. Хөндлөнгий гэрч тэмдэглэлд засвар оруулахаар санал гарга эрхтэй.

48.3.Хөндлөнгийн гэрч энэ хуулийн 48.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол түүнд хуулья заасан хариуцлага хүлээлгэнэ.

49 дүгээр зүйл. Орчуулагч,хэлмэрч

49.1.Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэллүй, дулий бол түүний хүсэлтээр орчуулагч,хэлмэрчийг шүүгч захирамж гарган томилно. Хэрэг хянан шийдвэрлэ ажиллагааны бусад оролцог орчуулагч,хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхий хориглоно.

49.2.Орчуулагч, хэлмэрч тухайн этгээдий нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг орчуулж хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай танилцахад

туслах үүрэгтэй.

49.3.Орчуулагч,хэлмэрч шүүхийн
үдсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв орчуулах,
ымэрчлэх үүрэгтэй.

49.4.Орчуулагч,хэлмэрч саналтайгаар
эуу орчуулж, хэлмэрчилбэл Эрүүгийн хууль
ысан хариуцлага хүлээлгэнэ.

**50 дугаар зүйл. Нотлох баримтыг
лгаалах**

50.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй
ардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах,
здад шилжүүлэх, нуун дарагдуулах зэргээр уг
эгийг хянан шийдвэрлэхэд саад учруулж болох
дэслэлтэй гэж үзвэл хэргийн оролцогч уг нотлох
эимтыг хамгаалуулахаар хэрэг хянан шийдвэрлэж
йгаа шүүхэд хүсэлт гаргаж болно.

50.2.Хүсэлтэд ямар нотлох баримтыг
мгаалах, хэргийн ямар байдлыг батлахад ач
лбогдолтой болон хамгаалах болсон шалтгааныг
эна.

50.3.Шүүгч уг хүсэлтийг үндэслэлтэй гэж
эвэл нотлох баримтыг хамгаалах тухай, хэрэв
дэслэлгүй гэж үзвэл татгалзах тухай захирамж
ргана.

50.4.Шүүгчийн захирамжид хаана, хэнд
йгаа, ямар нотлох баримтыг яаж хамгаалах
паар заана.

50.5.Энэ хуулийн 50.3-т заасан шүүгчийн
хирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх
йгуллага нэн даруй биелүүлнэ.

51 дүгээр зүйл. Тэмдэглэл

51.1.Анхан шатны шүүх хуралдаан болон
хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах,
хяналтын шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэнэ.

51.2.Үзлэг, туршилт хийх, таньж олуулах,
нүүрэлдүүлэн мэдүүлэг авах зэрэг хэрэг хянан
шийдвэрлэх бусад ажиллагаа гүйцэтгэхэд
тэмдэглэл үйлдэнэ.

51.3.Тэмдэглэлийг энэ хуулийн 7.1-д заасан
шаардлагад нийцүүлэн үйлдэнэ.

51.4.Тэмдэглэлийг шүүх хуралдааны үед
шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэрэг
хянан шийдвэрлэхэтэй холбогдсон бусад
ажиллагааны үед шүүгч, түүний даалгасаар
шүүгчийн туслах үйлдэнэ.

51.5.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн,
хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн ба дууссан
цаг, ажиллагаанд оролцсон буюу байлцсан хүн нэг
бүрийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, түүнчлэн
ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл
байдлыг бичнэ. Тэмдэглэлийг уг ажиллагаа
явуулахад оролцсон буюу байлцсан бүх хүн үншиж
танилцах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар
санал гаргах эрхтэйг тэдэнд тайлбарлаж өгнө.

51.6.Тэмдэглэлд уг ажиллагаа явуулсан
этгээд болон түүнд оролцсон буюу байлцсан бүх
хүн гарын үсэг зурна. Тэдгээр нь гарын үсэг зурахаас
татгалзах эрхгүй.

51.7.Тэмдэглэлд гэрэл зураг, зураглал, ул
мөрнөөс буулгаж авсан хэв болон хэрэг хянан
шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйлийг
хавсаргаж болох бөгөөд тэмдэглэлд энэ тухай
заана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж

52 дугаар зүйл. Шүүхийн зардал

52.1.Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй
лбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал
нэ.

52.2.Шүүхийн зардлыг улсын төвөрсөн
свөөс санхүүжүүлнэ.

**53 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн
рдал**

53.1.Шүүхээс гаргасан дараахь зардлыг
хигчоор нөхөн төлүүлнэ:

53.1.1.шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;

53.1.2.гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;

53.1.3.үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;

53.1.4. эд мөрийн баримт хадгалах зардал;

53.1.5.гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

54 дүгээр зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн

зардлын хэмжээг тодорхойлох

54.1.Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг дараахь журмаар тодорхойлно:

54.1.1.шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж буй албан томилолтын зардлын хэмжээгээр;

54.1.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр;

54.1.3. мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;

54.1.4. бусад зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр;

54.2. Зардлыг шүүхээс заасан улсын төвлөрсөн төсвийн дансанд тушаана.

55 дугаар зүйл. Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх

55.1.Зохиг төлберийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.

55.2.Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.

56 дугаар зүйл.Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах

56.1.Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.

56.2.Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваарилан хариуцуулна.

56.3.Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

56.4.Зохигч эвлэрэхдээ шүүхийн зардлыг өөрөөр хуваарилахаар тохиролцоогүй бол шүүх з зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

56.5.Нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөх төлөхгүй. Харин хариуцагч нэхэмжлэли шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөө биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргас нэхэмжлэлээсэз татгалзсан бол хариуцагчи төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.

57 дугаар зүйл. Улсын тэмдэгти хураамж

57.1.Шүүхээс эрх зүйн маргаан шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсн төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгө улсын тэмдэгтийн хураамж гэнэ. Улсын тэмдэгти хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүл нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагча төлүүлэн нэхэмжлэгчид буцаан олгоно. Улсы тэмдэгтийн хураамжийг энэ хууль заасны дагу төлнө.

57.2.Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхт холбогдуулж төлөх улсын тэмдэгтийн хураамжий хувь хэмжээг Төмдэгтийн хураамжийн тухя хуулиар[1] зохицуулна.

57.3.Хураамжийг буцаан олгох, нөхө төлүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Тэмдэгтий хураамжийн тухай хуулийн холбогдох заалт болс энэ хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасны дагу шийдвэрлэнэ.

58 дугаар зүйл. Улсын тэмдэгтий хураамжийг нөхөн төлүүлэх, хураамжаа чөлөөлөх

58.1.Нэхэмжлэл гаргах үед түүний үнийг шүү тогтооход бэрхшээлтэй байвал шүүгч улсы тэмдэгтийн хураамжийн хэмжээг урьдчила тогтоож, тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэхи дараа шүүхээс тогтоосон нэхэмжлэлийн үнэ тохируулан нөхөн төлүүлэх буюу урьд илү төлөгдсөн бол зөрүүг буцааж олгоно.

58.2.Нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжий нэхэмжлэлийн үнийг ихэсгэсэн хэмжээгээр нөхө төлүүлнэ.

58.3.Нэхэмжлэгч төлберийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаа тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөө шүүгчийн захирамжаар чөлөөлнө.

1Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 4 дүгээрт нийтлэгдсэн

58.4.Зохигчийн эд хөрөнгийн болон бусад йдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр улсын ıдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу ацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж ıно.

59 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн ɔаамжийг буцаах

59.1.Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас ггалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг ɔаасан хэмжээгээр нэхэмжлэгчид шүүгчийн ıирамжаар буцаан олгоно.

59.2.Давж заалдах буюу хяналтын журмаар ıдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө үнээсээ татгалзвал тухайн шатны шүүгч гомдлыг ɔгаагүйд тооцох, тухайн шатны шүүхэд гомдол ɔгахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг цаан олгох захирамж гаргана.

59.3.Хяналтын шатны шүүх зохигч, гуравдагч ɔэдийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд гомдол гаргагчаас тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тухайн шатны шүүгчийн захирамжаар буцаан олгоно.

59.4.Нэхэмжлэгч шаардлагаа багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

59.5.Энэ хуулийн 100. 2-т заасны дагуу нэхэмжлэлийг шүүх буцаасан бол улсын тэмдэгтийн хураамжийг улсын орлого болгоно.

60 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилах

60.1.Улсын тэмдэгтийн хураамжийг зохигчид хуваарилан хариуцуулах асуудлыг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны адилаар зохицуулна.

П ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙГ АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах

61 дүгээр зүйл. Нэхэмжлэлийн хэлбэр

61.1.Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах ıгөөд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан ıйдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын гээ зурсан байна.

62 дугаар зүйл. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

62.1. Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгасан ıйна:

62.1.1. нэхэмжлэлийг ямар шүүхэд ргаж байгаа;

62.1.2. нэхэмжлэгчийн овог, эцгийн ɔр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, ɔшин байгаа газар;

62.1.3. хариуцагчийн овог, эцгийн ɔр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, ɔшин байгаа газар;

62.1.4.нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, үүнийг нотлох баримт;

62.1.5. нэхэмжлэлийн үнэ;

62.1.6.хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

62.2.Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана.

62.3.Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

63 дугаар зүйл. Нэхэмжлэлийн үнийг тодорхойлох

63.1.Нэхэмжлэлийн үнийг дараахь байдлаар тодорхойлно:

63.1.1.мөнгө төлүүлэхээр шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа мөнгөний дүнгээр;

63.1.2.эд хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэлд нэхэмжилж байгаа эд хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн үнийн дүнгээр;

63.1.3.бие даасан хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд бичсэн бол бүх шаардлагын үнийн нийлбэрээр;

63.1.4.гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлд уг

гэрээ, хэлцлийн үнийн дүнгээр;

63.1.5.тогтмол хугацаанд төлөгдөх тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хохирол, нөхөн төлбөр шаардсан нэхэмжлэлд тэдгээрийн нэг жилийн хугацаанд төлбөл зохих дүнгээр;

63.1.6.үл хөдлөх эд хөрөнгө гаргуулах нэхэмжлэлд Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн үнийн дүнгээр;

63.1.7.нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг нэхэмжлэлд заасан үнийн дүнгээр;

63.1.8.үнэт цаастай холбогдох нэхэмжлэлд хөрөнгийн биржийн тухайн үеийн ханшаар;

63.1.9.тусгай зөвшөөрөл, тендертэй холбогдох нэхэмжлэлд тусгай зөвшөөрлийн, эсхүл тендерийн хураамжийн дүнгээр.

63.2.Гадаад валютын ханшийг тухайн үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар, эд хөрөнгийн үнийг нотлогдсон хэмжээгээр тус тус тооцно.

64 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авах

64.1.Нэхэмжлэлийг тухайн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч ийнхүү хүлээн авсан нэхэмжлэл, хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг, минутыг нэхэмжлэлд тэмдэглэн баталгаажуулна. Тэмдэглэн бичсэн дараалаар нэхэмжлэл буртгэх дэвтэрт бичнэ.

65 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах

65.1.Шүүгч дараахь тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана:

65.1.1.шүүхэд харьяалагдахгүй;

65.1.2.тухайн шүүхэд харьяалагдахгүй;

65.1.3.шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан жүрмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ жүрмыг хэрэглэх боломжтой байвал;

65.1.4.нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;

65.1.5.нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

65.1.6.нэхэмжлэлд дурдсан үй баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулий хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэ эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулий хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэ буюу шүүгчийн захирамж байгаа;

65.1.7.зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүү шийдвэрлэж байгаа;

65.1.8.уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;

65.1.9.хариуцагчийн хая тодорхойгүй;

65.1.10.зохигч болох хүн на барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэ нь эрх залгамжлагчид шилжээгүй;

65.1.11.энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал.

65.2.Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан захирамждаа уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө.

66 дугаар зүйл. Хэрэг үүсгэх

66.1.Шүүгч энэ хуулийн 13.2., 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

66.2.Нэхэмжлэгчийн хүсэлтээр улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн, түүнийг багасгасан, хэсэгчлэн төлүүлэх болон хойшлуулах тухай асуудлыг шүүх шийдвэрлэсэн бол энэ талаар хэрэг үүсгэсэн захирамждаа заана.

67 дугаар зүйл. Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

67.1.Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгч дараахь ажиллагааг явуулна:

67.1.1.зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдэд шаардлага татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж, эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх;

67.1.2.нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах;

67.1.3.шаардлагатай буюу энэ талаар эдэлт гаргасан бол энэ хуулийн 38.6-д заасан журмаагаар явуулах.

68 дугаар зүйл. Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах

68.1.Нэхэмжлэгч хоорондоо холбоотой хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд нэгтгэн гаргаж болно. Нэгтгэн гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарлан шийдвэрлэх нь зохистой гэж үзвэл дүгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

68.2.Хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан хэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарлан шийдвэрлэх нь зохистой гийвал тэдгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

68.3.Нэг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх шаардлагаанд адил төрлийн хэд хэдэн хэрэгт урьд өлцөж байсан зохиргоролцож байгаа, эсхүл нэг эмжлэгчээс өөр өөр хариуцагчид гаргасан хэмжлэлтэй буюу өөр өөр нэхэмжлэгчээс нэг риуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн ргийг нэг ажиллагаагаар хамтатган шийдвэрлэх уг хэргийг шуурхай, зөв хянан шийдвэрлэхэд ач олбогдолтой гэж үзвэл тэдгээрийг шүүгчийн хирамжаар нэгтгэн хянан шийдвэрлэж болно.

69 дүгээр зүйл. Шүүхээс гарах шийдвэрийн шаардлагатай баталгаажуулах

69.1.Шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг ндэслэн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг эталгаажуулах дараахь арга хэмжээг хэрэг гсэхдээ буюу үүгэсний дараа захирамж гарган ах эрхтэй:

69.1.1.хариуцагчийн эд хөрөнгө буюу энгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн мжээгээр битүүмжлэх;

69.1.2.хариуцагчаас эд хөрөнгөтэй олбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа зуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн мжээгээр хориглох ;

69.1.3.хариуцагчийн дансны зарлагын эделгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн мжээнд зогсоох;

69.1.4.нэхэмжлэлээр шаардсан эмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ансанд урьдчилан оруулах.

69.2. Шүүгч энэ хуулийн 69.1-д заасан хэд хэдэн арга хэмжээг нэгэн зэрэг авч болно.

69.3.Шүүгч шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахдаа энэ хуулийн 70.3-т заасныг нэхэмжлэгчид мэдэгдэнэ.

69.4.Шүүгч хариуцагчийн хүсэлтээр энэ хуулийн 69.1-д заасан нэг арга хэмжээг өөр арга хэмжээгээр солиж болно. Хариуцагч мөнгөн төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлтэй хэргийн талаар авсан арга хэмжээг солиулахын тулд нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд оруулж болно.

69.5.Шүүх энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээг авахдаа үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэж болохгүй.

70 дугаар зүйл. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг биелүүлэх, түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

70.1.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг гарсан өдрөөс нь эхлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ.

70.2.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ энэ хуулийн 120.2-т заасан хугацаа өнгөрөл буюу давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргасан бол түүнийг шийдвэрлэх хүртэлх хугацаанд хэвээр байна.

70.3.Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээнээс хариуцагчид учирсан хохирлыг нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.

71 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

71.1. Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

71.2.Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчидийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

71.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ хуулийн 71.1- д заасан хугацааны дотор шүүх тогтоож болно.

71.4.Хугацаа тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг хэрэглэнэ.

72 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

72.1.Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш хариуцагчид нэхэмжлэлийг нийслэлд 7 хоногийн, орон нутагт 14 хоногийн дотор тус тус гардуулна.

72.2.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

72.3.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүүлэгүй, түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсэнд тооцож энэ хуулийн 100.3-т заасныг түүний эсрүйд хэргийг шийдвэрлэнэ.

72.4.Энэ хуулийн 72.3-т заасан үр дагаварыг нэхэмжлэл, мэдэгдэх хуудсыг хариуцагчид гардуулах үед мэдэгдэнэ.

73 дугаар зүйл. Сөрөг нэхэмжлэл

73.1.Үндсэн нэхэмжлэлтэй хамшийдвэрлүүлэхийн тулд хэргийг шүүхаралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагсөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэнэн хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыхангасан байна.

73.2.Сөрөг нэхэмжлэлийн шаардлага үндсэнэхэмжлэлийн шаардлагатай тооцогдох байва.шүүх сөрөг нэхэмжлэлийг үндсэн нэхэмжлэлтэхамт шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд тэдгээрийхамтруулан шийдвэрлэх эсэхийг шүүгшийдвэрлэнэ.

73.3.Сөрөг нэхэмжлэл гаргах үед улсынтэмдэгтийн хураамжийг ердийн нэхэмжлэлийн адихэмжээгээр тогтоосон журмын дагуу урьдчилантөлсөн байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

74 дүгээр зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

74.1.Хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаанхүртэлх хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээтатгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыхүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч эвлэрсэн,нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэнбол хэргийг хялбаршуулсан журмаар хянаншийдвэрлэнэ.

74.2.Хэргийг хялбаршуулсан журмаар хянаншийдвэрлэх боломжтой гэж үзвэл шүүгчнэхэмжлэгчийн татгалзал, хариуцагчийн зөвшөөрөл,зохигч талуудын эвлэрэл, нэхэмжлэлийншаардлагыг хариуцагч биелүүлснийг баталсан тухайзахирамж гаргана.

74.3.Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээтатгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыгхүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч эвлэрсэн,нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэнтухай зохигч талууд бичгээр тохиролцож, гарын үсэгзурж баталгаажуулсан байна.

74.4.Хэргийг хялбаршуулсан журмаар хянаншийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах,хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээргомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатнышүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

74.5.Хялбаршуулсан журмаар хэрэг хянашийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийнхураамжийн хэмжээг тал хувиар бууруулж тогтоохба түүнийг энэ хуульд заасан журмын дагуугаргуулна.

74.6.Зохигч эвлэрсэн тохиолдолд зохигчталууд нэхэмжлэлийн нийт шаардлага буюутодорхой хэсгийн талаар тохиролцож шүүхийн өмнөэвлэрлийн гэрээ байгуулж болно. Гэрээний агуулгыгзохигч талууд бичгээр гарган түүнийг хоёр талхүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар эвлэрлийнгэрээ хүчин төгөлдөр болно. Эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийнхуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүйбайна.

75 дугаар зүйл.Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж

75.1.Хэргийг хялбаршуулсан журмаар хянаншийдвэрлэсэн шүүгчийн захирамж удиртгал,тодорхойлох, үндэслэх, захирамжлах хэсгээсбүрдэнэ.

75.2.Удиртгал хэсэгт захирамжийг хэзээ,

аана, ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, хэргийн эолцогчийг заана.

75.3.Тодорхойлох хэсэгт нэхэмжлэгч эхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч эхэмжлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, сэхүл зохигч талууд эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн тухай хэргийн ролцогчдын тайлбарын агуулгыг заана.

75.4.Үндэслэх хэсэгт хэргийг хялбаршуул ан жүрмаар хянан шийдвэрлэхэд үндэс болгосон отлох баримт, зохигч эвлэрсэн, нэхэмжлэгч эхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч эхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч иелүүлсэн тухай бичгээр баталгаажуулсан баримт, эвлэрлийн гэрээ зэргийг тусгана.

75.5. Захирамжлах хэсэгт хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, заалтыг тодорхой заажк, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч талууд эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлснийг баталсны аль нь болох, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг заана.

75.6.Энэхүү захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Шүүх хуралдааны бэлтгэл хангах

76 дугаар зүйл.Шүүх хуралдааны бэлтгэл ангах шүүгчийн ажиллагаа

76.1.Хэргийг шүүх хуралдаанаар элэлцүүлэхтэй холбогдуулан шүүгч дараахь іэлтгэл ажиллагаа явуулна:

76.1.1.хэрэг хянан шийдвэрлэхэд ч холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн эж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-д заасан гүгаа дуусан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бүсад тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх гуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлох;

76.1.2.хэргийн болон шүүх гуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, каана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэх.

76.2.Зохигч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүрэг хүлээнэ.

77 дугаар зүйл. Шүүхийн мэдэгдэх хуудас

77.1.Зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар гэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар мэдэгдэнэ. Хүрэлцэн ирээгүйгээс гарах үр дагавар болон энэ хуулийн 100 дугаар зүйлд заасанаар хэргийг хянан шийдвэрлэж болохыг шүүхийн мэдэгдэх хуудсанд заана.

77.2.Шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, факс, цахилгаан буюу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болно. Иймхүү мэдэгдсэнээ баримтжуулсан байна.

77.3.Мэдэгдэх хуудсыг шуудангаар хүргэсэн бол шүүх хүлээн авагчийн нэр , хаяг, явуулж буй он, сар, өдрийг тэмдэглэж, шүүхийн болон шуудангийн ажилтны гарын үсгийг зуруулна.

77.4.Газар нутгийн онцлогоос шалтгаалан шүүх мэдэгдэх хуудсыг биечлэн хүргэхийг өөр этгээдэд даалгаж болно.

77.5.Мэдэгдэх хуудсыг түүнд заасан хүлээн авагчид гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан огноо, цагийг тэмдэглэнэ. Хуулийн этгээдэд өгөх мэдэгдэх хуудсыг удирдах албан тушаалтан буюу холбогдох ажилтанд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан огноо, цагийг тэмдэглэнэ.

77.6.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих иргэн оршин суугаа газартаа буюу ажлынхаа газарт байхгүй бол үүх хуудсыг түүний хамт амьдардаг насанд хүрсэн иргэн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд буюу ажлын газрынх нь захиргаанд хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

77.7.Зохигч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхээд бүцаана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

77.8.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хэргийн оролцогч хаягаа

өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Хаягаа өөрчилснөө мэдэгдээгүй зохигч болон хэргийн оролцогчид мэдэгдэх хуудсыг түүний суулчийн хаягаар хүргүүлж, энэ хуулийн 77.6-д заасан иргэн, албан тушаалтанд хүлээлгэн өгөх бөгөөд түүнийг хүргэсэнд тооцно.

77.9.Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хэргийн оролцогч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгээр ирээгүй бол түүнийг зайлшгүй оролцуулах шаардлагатай тохиолдолд шүүгчийн захирамжаар албадан ирүүлж түүнд зохих хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

77.10.Шүүгчийн захирамжаар зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

78 дугаар зүйл. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох

78.1.Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг жил, хагас жил зэрэг тодорхой хугацаагаар тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс хуваарь гарган томилно.

78.2.Хуваарийн дагуу томилогдсон шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн тухайн шүүх хуралдаанд оролцож чадахгүй тохиолдолд түүнийг орлох шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг энэ хуулийн 78.1-д заасан журмаар томилно.

78.3.Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ. Шүүгчдийн зөвлөлгөөн тухайн шүүхийн шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцон тохиолдолд хүчинтэй байна. Шүүгч бүр тэгш эрхтэй оролцоно.

78.4.Ерөнхий шүүгч бусад шүүгчтэй адил энэ хуулийн 78.1-д заасан хуваарийн дагуу хэрэг хянан шийдвэрлэнэ.

78.5.Тухайн жилийн турш шүүгчийн ажлын ачаалал ихэссэн, ажиллах шүүгчдийн тоо нэмэгдсэн, хасагдсаны улмаас энэ хуулийн 78.1, 78.2-т заасны дагуу хянан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Ерөнхий шүүгч тухай бүр шүүгчдийн зөвлөлгөөнийг зарлан хуралдуулна.

79 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийг томилох

79.1.Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчи Шүүхийн тухай хуульд[1] заасны дагуу оролцуулн

79.2.Тухайн шүүх хуралдаанд оролцо иргэдийн төлөөлөгчийг энэ хуулийн 78 дугаар зүйл заасан шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосо хуваарийн дагуу томилно.

80 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэ ажиллагааг түдгэлзүүлэх

80.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллага дараахь тохиолдолд шүүхийн тогтоол, шүүгчи захирамжаар түдгэлзүүлнэ:

80.1.1.зохигч болох хүн нас барса хуулийн этгээд татан буугдсан үед маргаанта байгаа шаардлага буюу үүрэг эрх залгамжлагчи шилжих ёстой байвал;

80.1.2.зохигчид асран хамгаалал тогтоолгох шаардлагатай;

80.1.3.зохигч онц ба дайны байда зарласан нөхцөлд цэргийн алба хааж байгаа;

80.1.4.иргэний эсхүл эрүүгийн журмаа шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянаа шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэ боломжгүй;

80.1.5.зохигч хүнд өвчний учи эмчлүүлж байгаа;

80.1.6.хариуцагчийг эрэн сурвалжла шаардлага бий болсон;

80.1.7.хэрэг хянан шийдвэрлэхэ, хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцээгүй тухаа асуудлаар Улсын дээд шүүхэд санал оруулсан бол

80.2.Энэ хуулийн 80.1-д зааснаас бусад шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэхийг хориглоно.

80.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлсэн шалтгаан арилмагц хэргийн оролцогчийн хүсэлт буюу өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай шүүгч захирамж гаргах ба энэ өдрөөс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үргэлжлүүлэх тоолно.

---

[1] *Шүүхийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 2 дугаарт нийтлэгдсэн*

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам

81 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүн

81.1. Анхан шатны журмаар шүүгч дангаар ;янан шийдвэрлэхээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

82 дугаар зүйл. Шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргаан

82.1.Шүүгч дор дурдсан хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтад заасан хэрэг, эрх зүйн маргааныг дангаар хянан шийдвэрлэнэ:

82.1.1.Иргэний хуулийн 8.1. 1;8.1. 3; 8.1.4; 8.1.6-8.1.8 дахь заалт;

82.1.2.Хеделмөрийн тухай хуулийн[1] 128. 1- 128.4; 128.6-128.11 дэх заалт;

82.1.3. Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан;

82.1.4.Тэтгэврийн харилцаанаас үүссэн маргаан;

82.1.5 Тэтгэмжийн тухай хуулийн[2] 27 дугаар зүйл;

82.1.6.энэ хуулийн 74, 133 дугаар зүйл;

82.1.7.шүүх менгөн торгууль оногдуулахаар хуульд заасан;

82.1.8.бусад хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, эрх зүйн маргаан.

83 дугаар зүйл. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг өөрчилж үл болох

83.1.Шүүх хуралдааны явцад хэргийг гагцхүү нэг шүүгч буюу шүүхийн нэг бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ. Хэрэв шүүх бүрэлдэхүүний хэн нэг нь шүүх хуралдааны ажиллагаанд оролцох боломжгүй болсон бол түүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар энэ хуулийн 78 дугаар зүйлд заасан журмын дагуу өөр шүүх бүрэлдэхүүнээр сольж, уг хэргийг шинээр хянан шийдвэрлэнэ.

84 дүгээр зүйл. Иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

84.1.Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах, хяналтын журмаар дахин анхан шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

84.2.Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгчтэй төрөл, садангийн холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

85 дугаар зүйл. Шүүх хуралдааны оролцогч

85.1. Шүүх хуралдааны оролцогч гэдэгт хэргийн оролцогч, шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч хамаарна.

86 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг

86.1. Хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

86.2. Иргэдийн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэхэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

86.2.1. хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;

86.2.2. нотлох баримтыг шинжлэхэд оролцох;

86.2.3. зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих;

86.2.4.хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар бичгээр дүгнэлт гаргах;

86.2.5.шүүгчдийн зөвлөгөөнөөс хуваарилсан шүүх хуралдааныг таслахгүй байх;

86.2.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр,байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг задруулахгүй байх;

[1] *Монгол Улсын Хеделмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт,*
[2] *БНМАУ-ын Тэтгэмжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1991 оны 3 дугаарт нийтлэгдсэн*

86.2.7.энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.

86.3.Энэ хуулийн 86.2.4-т зааснаар хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

87 дугаар зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

87.1.Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдаан явуулах байр, танхимыг бэлтгэх, шүүх хуралдааны ирцийг бүртгэж шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, шүүх хуралдааны ажиллагаат тэмдэглэл үйлдэж баталгаажуулах, шүүхийн шийдвэрийг хүргүүлэх, гүйцэтгэх хуудас олгох, хүргүүлэх, хэргийг цэгцэлж үдэх, архивт шилжүүлэх ажиллагаат хийж гүйцэтгэнэ.

88 дугаар зүйл. Шүүх хуралдаан

88.1.Хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээс бусад тохиолдолд хэргийг гагцхүү шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

89 дүгээр зүйл. Шүүх хуралдаан даргалагч, түүний эрх, үүрэг

89.1.Хэргийг шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч, Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнд орж байгаа тохиолдолд Ерөнхий шүүгч, дангаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шүүх хуралдааныг тус тус даргална.

89.2. Шүүх хуралдаан даргалагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаат хуулийн дагуу явуулах, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг ханган, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээг авна.

90 дүгээр зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам

90.1.Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

90.2.Шүүх хуралдаанд оролцогч мэдүүлэг, тайлбар өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно. Хуралдаанд оролцогч өөрийн улмаас хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаараа үг хэлэх буюу мэтгэлцэхэд оролцож болно.

90.3.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.

90.4.Шүүх хуралдааны журам зөрчсө этгээдэд эхний удаа шүүх хуралдаан даргала урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргас этгээдийг шүүх хуралдаан даргалагч шү хуралдааны танхимаас гаргаж энэ тухай шү хуралдааны тэмдэглэлд тусгуулж, хуу тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

90.5.Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэр шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гарга тохиолдолд шүүх хуралдааныг хуралда даргалагчийн захирамжаар тодорхой хугацаага хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлги сонсохгүйгээр хэргийг хянан шийдвэрл боломжтой гэж шүүх хуралдаан даргалагч бүр шүүгч үзвэл үргэлжлүүлэн явуулна. Уг этгээ хүсвэл шүүх хуралдааны үйл ажиллагааны талаа тэмдэглэлээс танилцуулж болно.

91 дүгээр зүйл. Татгалзан гарах үндэслэл

91.1. Шүүгч дараахь үндэслэл байвал хэр хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй:

91.1.1.урьд нь уг хэргийг хяна шийдвэрлэхэд зохигч, гуравдагч этгээд, иргэдий төлөөлөгч, өмгөөлөгч, шүүх хуралдааны нарий бичгийн дарга, гэрч, шинжээ орчуулагч,хэлмэрчийн хувиар оролцон;

91.1.2.уг хэргийн болон шүү хуралдааны оролцогчийн төрөл, садан бол, эсхү шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл, садангий холбоотой хүмүүс орсон байвал;

91.1.3.хэргийн оролцогчтой хувий харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаа шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзэ байвал.

91.2.Энэ хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж у болно.

91.3.Энэ хуулийн 91.1-д заасан үндэслэ иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн ади хамаарна.

91.4.Шинжээч, орчуулагч,хэлмэрч эн хуулийн 91.1-д зааснаас гадна дараахь тохиолдол шүүх хуралдаанд оролцож болохгүй:

91.4.1.албан тушаалын буюу бусад байдлаар хэргийн оролцогч нь шинжээч орчуулагч,хэлмэрчид нөлөөлж болох байвал;

91.4.2.урьд түүний хийсэн шалгалтын материал уг хэргийн үндэс болсон бол

92 дугаар зүйл.Татгалзан гаргах үсэлт гаргах

92.1.Энэ хуулийн 91 дүгээр зүйлд заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн өлөөлөгч, шинжээч, орчуулагч,хэлмэрч, шүүх ууралдааны нарийн бичгийн дарга энэ тухайгаа шүүх ууралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах ндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол ухайн үед нь мэдэгдэж татгалзан гарах үүргэтэй.

92.2.Энэ хуулийн 91 дүгээр зүйлд заасан ндэслэлээр шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, рчуулагч,хэлмэрч, шүүх хуралдааны нарийн ичгийн дарга татгалзан гаргах тухай хүсэлтийг охигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн өлөөлөгч, гуравдагч этгээд гаргаж болно. Дээр үрдсан этгээд шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гаргах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэх үүрэгтэй.

92.3.Татгалзан гаргах тухай хүсэлт гарвал шүүх хэргийн оролцогчийн санал, түүнчлэн татгалзан гаргагдаж байгаа этгээд хүсвэл түүний айлбарыг сонсоно.

92.4.Татгалзан гаргах тухай асуудлыг хүлээн явах эсэхийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч өөлөлдөх татсалгаанд хэлэлцэж, тогтоол буюу ахирамж гаргаж шийдвэрлэнэ.

92.5.Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг үндэслэлтэй эсэхийг түүнийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ. Санал тэнцвэл шүүгчийг атгалзан гаргасанд тооцно.

92.6.Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэх захирамж гаргана.

92.7.Шинжээч, орчуулагч,хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга татгалзан гаргах тухай хүсэлтийг хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

92.8.Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн өөлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.

93 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргасны үр дагавар

93.1.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол хэргийг өөр шүүх бүрэлдэхүүн, шүүгч шийдвэрлэнэ.

93.2.Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныг урьд оролцож дахин оролцох боломжгүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд хэргийг адил шатны өөр шүүхээр шийдвэрлүүлэхээр тухайн шатны Ерөнхий шүүгч захирамж гаргах шилжүүлнэ.

93.3.Энэ хуулийн 93.2-т заасанаар хэрэг шилжиж ирсэн тохиолдолд зохих хуваарийн дагуу шүүгч хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

94 дүгээр зүйл. Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах

94.1.Бүх шатны шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.

94.2.Зөвлөлдөх тасалгаанд хэргийг хянан шийдвэрлэх талаар шүүх бүрэлдэхүүний гаргасан санал нууц байна.

95 дугаар зүйл. Санал хураах

95.1.Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

95.2.Шүүх хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчдийн дараа гаргана.

95.3.Хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч саналаа өгөхөөс татгалзах эрхгүй.

96 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

96.1.Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дуусан цаг, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын овог, эцгийн нэр, нэр, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын овог, эцгийн нэр, нэр, хаяг, тэдний ирц болон тэдэнд эрх, үүргийг тайлбарласан байдал, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын тайлбар, тэдгээрийн мэтгэлцээн, шинжээчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, нотлох баримтыг шинжилсэн байдал, шүүх бүрэлдэхүүн, шүүгчээс хэргийн талаар асуух тодруулсан байдал, шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журмыг тайлбарласан байдлыг бичнэ.

96.2.Шүүх хуралдаан дуусан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгоно. Тэмдэглэлд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

96.3. Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай бичигдсэн бол шүүх хуралдаан даргалагч буюу шүүх хуралдааны оролцогчийн хэн нэгний санал болгосноор түүнд 3 хоногийн дотор засвар хийж, энэ тухай тэмдэглэлд тусгаж, шүүгч гарын үсэг зурж

баталгаажуулна.

97 дугаар зүйл. Мөнгөн торгууль оногдуулах журам

97.1.Хуульд зааснаар торгууль оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гарган зөрчил гаргасан этгээдийг зуун мянга хүртэл төгрөгөөр торгоно.

97.2.Энэ хуулийн 97.1-д зааснаас бусад тохиолдолд торгууль оногдуулах асуудлыг шүүгч зөрчил гаргасан этгээдийг дуудан ирүүлэн шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээс түүнийг ирээгүй явдал шийтгэвэр гаргахад саад болохгүй.

АРАВДУГААР БҮЛЭГ

Анхан шатны шүүх хуралдааны дэг

98 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээх

98.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгааг зарлан мэдэгдэж, танхимд байгаа хүмүүст суулгаж зөвшөөрнө.

99 дүгээр зүйл. Шүүх хуралдааны ирц ба түүнд оролцох эрхийг шалгах

99.1.Шүүх хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй этгээдэд мэдэгдэх хуудсыг гардуулан өгсөн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг даргалагчид илтгэн танилцуулна.

99.2.Шүүх оролцогчтой нэг бүрчлэн танилцаж, төлөөлөгчийн бүрэн эрхийг шалгана.

100 дугаар зүйл. Зохигч, оролцогч шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдол

100.1.Нэхэмжлэгч өөрөө болон төлөөлөгч, өмгөөлөгчийнхөө эзгүйд шүүх хуралдааныг хийх талаар шүүхэд бичгээр хүсэлт ирүүлсэн бол тэдгээрийг оролцуулахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэж болно.

100.2.Харин нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг бүцаана. Нэхэмжлэлийг бүцаасан тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

100.3.Хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол нэхэмжлэгч хэргийг түүний эзгүйд хянан шийдвэрлэх талаар хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотлогоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэнэ.

100.4.Энэ хуулийн 100.2, 100.3-т зааснаар хэргийг зохигч талын эзгүйд хянан шийдвэрлэх тухай хүсэлтийг нэхэмжлэгч, хариуцагчийн аль аль нь гаргаагүй байсан ч хэргийг тухайн үед цугларсан нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан шүүх шийдвэрлэж болно. Ингэхдээ зохигч талуудаас урьд гаргасан тайлбарыг шүүх хуралдаан дээр гаргасантай адилтгаж үзнэ.

100.5.Зохигч талын аль аль нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол шүүх энэ хуулийн 100.4-т заасны дагуу шийдвэрлэж болно.

100.6.Хэргийг зохигч талын эзгүйд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр энэ хуулийн 120.1-д заасанаар хүчин төгөлдөр болох бөгөөд түүний ердийн журмаар биелүүлнэ.

100.7.Энэ зүйлд заасан зохигч оролцоогүй шүүхийн шийдвэрт ердийн журмаар гомдол гаргана.

100.8.Томилогдсон иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 76.1.2-т заасны дагуу мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

101 дүгээр зүйл. Орчуулагч,хэлмэрчийн үүргийг тайлбарлах

101.1.Шүүх хуралдаан даргалагч орчуулагч,хэлмэрчид түүний үүрэг, буруу орчуулж, хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

102 дугаар зүйл. Гэрчийг гаргах

102.1.Шүүх хуралдаанд дуудагдсан гэрчийг шүүх хуралдааны танхимаас түр гаргана.

102.2.Гэрчүүдийг хооронд нь харилцуулахгүй байлгах талаар шүүх хуралдаан даргалагч арга хэмжээ авна.

103 дугаар зүйл.Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг тайлбарлах

103.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх

ээлдэхүүнийг зарлан, шинжээч, чуулагч,хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх алдааны нарийн бичгийн даргыг танилцуулж, дгээрийг татгалзан гаргах эрхтэйг зохигч, авдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу гөөлөгчид тайлбарлан өгнө.

103.2.Татгалзан гаргах хүсэлт гарвал түүнийг э хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу йдвэрлэнэ.

104 дүгээр зүйл. Хэргийн оролцогчийн эрх, ргийг тайлбарлах

104.1.Шүүх хуралдаан даргалагч хэргийн олцогчдод хуульд заасан эрх, үүргийг нь йлбарлан өгнө.

105 дугаар зүйл. Хэргийн оролцогчоос ргасан хүсэлтийг шийдвэрлэх

105.1.Шинэ нотлох баримт бүрдүүлэх ба рэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад уудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан сэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц үүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.

105.2.Хэрэг хянан шийдвэрлэхтэй лбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг ьд нь гаргах буюу санал болгох бололцоотой йсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь ндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг лээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол үүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.

106 дугаар зүйл. Хэрэг хэлэлцэж эхлэх

106.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүх хуралдаан даргалагч буюу шүүгч хэргийн лаар танилцуулснаар эхэлнэ.

106.2.Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж йгаа эсэх, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг вшөөрч байгаа эсэх, зохигч эвлэрэх хүсэлтэй йгаа эсэхийг шүүх_хуралдаан даргалагч асууж друулна.

106.3.Нэхэмжлэгч нэхэмжлэлээ риуцагчийн зөвшөөрөлгүйгээр татан авч болно.

106.4.Хариуцагч шүүхийн шийдвэр гарах ртэл нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу рим хэсгийг хүлээн зөвшөөрөх буюу зохигч эвлэрч олно.

106.5.Энэ хуулийн 106.3, 106.4-т зааснаар эхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч эхэмжлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, охигч эвлэрсэн нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар амгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй, хуульд аршлаагүй бол шүүх хариуцагчийн зөвшөөрөл, нэхэмжлэгчийн татгалзал, зохигчийн эвлэрлийг баталсан шийдвэр гаргана.

106.6.Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол нэхэмжлэгч, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хариуцагч, зохигч эвлэрсэн бол нэхэмжлэгч, хариуцагчид хувааж хариуцуулахаар шүүхийн шийдвэрт заана.

107 дугаар зүйл. Зохигч, оролцогч мэтгэлцэх

107.1.Зохигч, хэргийн бусад оролцогч мэтгэлцэх, тайлбар гаргахын өмнө шүүх хуралдаан даргалагч тэдэнд эрх, үүрэг болон үнэн зөв тайлбар өгөхийг урьдчилан сануулна.

107.2.Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, нэхэмжлэгчийн талд оролцож буй гуравдагч этгээд нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэж байгаа үндэслэлээ нотолно.

107.3.Хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, хариуцагчийн талд оролцож буй гуравдагч этгээд нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримтыг татгалзаж буй үндэслэлээ нотолж, нотлох баримтаа гаргана.

107.4.Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй этгээд шүүх хуралдаанд тайлбар, нотлох баримтаа гаргана.

107.5.Талууд урьд бичгээр тайлбар гаргасан бол шүүх хуралдаан дээр тухайн тайлбараа танилцуулж болно.

108 дугаар зүйл. Нотлох баримтыг шинжлэх, асуулт тавих дараалал

108.1.Шүүх гэрч, шинжээчээс мэдүүлэг авах цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судлах, үзлэг хийх, бусад нотлох баримтыг шинжлэх дарааллыг тогтоож, эдгээр ажиллагааг энэ хуулийн 110-112 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.

108.2.Гэрч, зохигчийн тайлбар, шинжээчийн дүгнэлтээс шүүх хуралдаанд оролцогч дараахь дарааллаар асуулт тавина:

108.2.1.шүүх хуралдаан даргалагч;
108.2.2.шүүгч, иргэдийн төлөөлөгч;
108.2.3.нотлох баримт гаргаж буй этгээд;
108.2.4.нотлох баримтыг эсэргүүцэж

буй этгээд.

109 дүгээр зүйл. Гэрчийн мэдүүлэг сонсох

109.1.Шүүх хуралдаан даргалагч гэрчийг шүүх хуралдааны танхимд оруулж, түүний үүрэг, хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

109.2.Гэрч бүрийг тус тусад нь асууна. Мэдүүлэг өгч эхлээгүй байгаа гэрч шүүх хуралдааны ажиллагаа явагдаж байх үед шүүх хуралдааны танхимд байж болохгүй. Хэрэв мэдүүлэг өгсөн гэрчийг гарч явахыг шүүх хуралдаан даргалагч зөвшөөрөөгүй бол тэрээр шүүх хуралдаан дуустал танхимд байна.

109.3.Насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахдаа эцэг, эх, харгалзан дэмжигч, эсхүл сурган хүмүүжүүлэгчийг байлцуулна. Түүний мэдүүлгийг шүүх сонсохдоо үнэн зөв мэдүүлэг өгөхөд нь нөлөөлж болохоор оролцогчийг шүүх хуралдааны танхимаас түр гаргаж болно. Иймхүү гарсан этгээд шүүх хуралдааны танхимд буцаж ороход насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг түүнд танилцуулж, асуулт тавих боломж олгоно. Насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонссоны дараа түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргана.

109.4.Шүүгч гэрчээс мэдүүлгийг урьдчилан авах, эсхүл давтан асуух болно.

110 дугаар зүйл. Бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэх

110.1.Шүүх хэрэгт цугларсан эд мөрийн баримт болон баримт бичгийг судалж, шаардлагатай бол хэргийн оролцогч, гэрч, шинжээчийн хүсэлтээр бичмэл нотлох баримтыг шүүх хуралдааны үншиж сонсгон, эд мөрийн баримтыг танилцуулна.

110.2.Хуульд заасан тер, байгууллага, хувь хүний нууцтай холбогдсон баримтыг шүүх хуралдаанд танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр нээлттэй шүүх хуралдаанд үншин сонсгож болно. Хэрэв зөвшөөрөл авааргүй бол хувийн захидал, бичгийг үншин сонсгох ба шинжлэх явдлыг хаалттай шүүх хуралдаанаар гүйцэтгэнэ.

110.3.Хэрэгт байгаа бичмэл баримт хуурамч болох нь мэдэгдвэл тийнхүү хуурамч болохыг мэдсэн этгээд үг баримтыг нотлох баримтаас хасахыг шүүхээс хүсч болно. Бичмэл баримт хуурамч гэж мэдэгдсэн этгээд тэр тухайгаа нотлох үүрэгтэй. Бичмэл баримт хуурамч болох тухай мэдээллийг шалгахын тулд шүүх шинжилгээ хийлгэх буюу бусад нотлох баримт шаардан авч болно.

110.4.Бичмэл баримт хуурамч байсан н тогтоогдвол шүүх түүнийг нотлох баримтаас хас бөгөөд хэргийн оролцогч шаардлагатай гэж үзвэ эрх бүхий байгууллагад хуурамч бичиг баримтыг талаар гомдол гаргаж болно.

111 дүгээр зүйл. Шинжээчийн дүгнэл сонсгох

111.1.Шинжээчийн дүгнэлтийг шүү хуралдаанд үншиж сонсгоно.

111.2.Шинжээч шүүх хуралдаанд оролцо байгаа бол өөрийн дүгнэлтийг тайлбарлана. Дара нь шинжээчид асуулт тавьж болно.

111.3.Шүүх шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй тодорхой бус буюу үндэслэлгүй, эсхүл шинжээ зөрүүтэй дүгнэлт гаргасан бол шүүх өөр шинжээчээ дахин шинжилгээ хийлгэж болно.

112 дугаар зүйл. Хэргийн оролцогчоос нэмэ тодруулах

112.1.Нотлох баримт шинжлэн судалсны дараа шүүх хуралдаан даргалагч нэмж тодруула зүйл байгаа эсэхийг зохиг, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөс асууна.

113 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөг дүгнэлт гаргах

113.1.Иргэдийн төлөөлөгч маргааны үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлтээ бичгээр гаргана. Эрүүл мэндийн болон хүндэтгэ үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гарга боломжгүй бол энэ тухай шүүх хуралдаань тэмдэглэлд тэмдэглүүлэж, амаар дүгнэлт гаргаж болно.

113.2.Иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ шүүх хуралдаанд үншиж сонсгоно.

114 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох

114.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахын тулд зөвлөлдөх тасалгаанд орно.

114.2. Шүүх хуралдааны завсарлагаар зохигчийг гарч явахыг хориглоно.

114.3.Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байгаа бол олонхийн саналаар шийдвэр гаргана.

114.4.Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр

нан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал ргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Шийдвэр, түүнийг гаргах

115 дугаар зүйл.Шийдвэр

115.1.Анхан шатны шүүхээс хэрэг хянан йдвэрлэсэн гаргасан баримт бичгийг шийдвэр гэнэ.

115.2.Анхан шатны шүүх хэргийн талаар араахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

115.2.1.нэхэмжлэлийн шаардлагыг ангах;

115.2.2. нэхэмжлэлийн шаардлагын арим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй олгох;

115.2.3. нэхэмжлэлийг бүхэлд нь эрэгсэхгүй болгох.

116 дугаар зүйл. Монгол Улсын нэрийн инөөс шийдвэр гаргах

116.1.Шийдвэрийг Монгол Улсын нэрийн инөөс гаргана.

116.2.Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл үхий байна.

116.3.Шийдвэрийг анхан шатны шүүх уралдааныр хэлэлцэгдсэн нотлох баримтын ндсэн дээр гаргана.

117 дугаар зүйл. Хэргийг хэрэгсэхгүй болгох

117.1.Энэ хуулийн 65.1.1, 65.1.3-5.1.8,65.1.10-д заасан үндэслэл хэргийг шүүх уралдааныр хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг эрэгсэхгүй болгоно. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч ахирамж гаргана.

118 дугаар зүйл. Шийдвэрийн агуулга

118.1.Шийдвэр удиртгал, тодорхойлох, ндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ.

118.2.Удиртгал хэсэгт шийдвэрийг хэзээ, аана, ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн олон шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн арга, хэргийн оролцогч болон шүүх хуралдааны ролцогчдыг нэрлэн заана.

118.3.Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн заардлага, нэхэмжлэгчийн тайлбар, хариуцагчийн атгалзал, тайлбар, зохигчийн төлөөлөгч буюу уравдагч этгээдийн тайлбарын агуулгыг заана.

118.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана.

118.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд бариматлсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, мөн улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацааг заана.

118.6.Энэ хуулийн 118.5-д заасан тогтоох хэсэг захиран тушаах хэлбэртэй байна.

119 дүгээр зүйл. Шийдвэрийг сонсгох, шүүх хуралдааныг хаах

119.1.Шүүх хуралдаан даргалагч шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг сонсгож, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хаана.

119.2.Шийдвэрийг гаргаснаас хойш 7 хоногийн дотор бичгээр үйлдэж бүрэн эхээр зохигчид хүргүүлнэ.

119.3.Зохигчийн оролцоогүйгээр гаргасан шийдвэрийг тэдэнд энэ хуулийн 119.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

120 дугаар зүйл. Шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

120.1.Шийдвэр уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болно.

120.2.Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэр, магадлалыг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар хэргийг хянуулахаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно.

120.3.Хяналтын журмаар анхан шатны

шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлээд гарсан шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах эрхтүй.

120.4.Анхан шатны шүүхийн шийдвэрт зохиг гомдол гаргахдаа давж заалдах, эсхүл хяналтын журмаар гаргах эсэхээ сонгон гомдлыг хэрэг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ.

120.5.Зохиг ба хэргийн бусад оролцогч, түүнчлэн тэдгээрийн эрх залгамжлагч шүүхээр нэгэнт хянан шийдвэрлэгдсэн маргааны талаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргах буюу шүүхээс нэгэнт тогтоосон үйл баримт, эрх зүйн харилцаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагааны талаар маргах эрхгүй.

121 дүгээр зүйл. Шийдвэрийг тайлбарлах

121.1.Шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийн оролцогчийн хүсэлтээр гагцхүү уг шийдвэрийг биелүүлж эхлэхээс өмнө түүний хууль зүйн үндэслэлийг аман, эсхүл бичгийн хэлбэрээр тайлбарлаж болно.

122 дугаар зүйл. Давж заалдах болон хяналтын журмаар гомдол гарснаас үүсэх үр дагавар

122.1.Давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан бол тэдгээрийг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй.

122.2.Давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан бол хэрэг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасснаар урьд нь авсан шийдвэрийн биелэлтийг батлагаажуулах арга хэмжээ хүчинтэй хэвээ байна.

123 дугаар зүйл. Шүүхийн тогтоол шүүгчийн захирамж, тэдгээрийг гаргах

123.1.Хэрэг хянан шийдвэрлэж энэ хуулий 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргасна бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэ ажиллагаат явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохто холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирам гаргана.

123.2.Шүүхийн тогтоолыг шүү бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэж байга үед, харин захирамжийг шүүгч дангаар хэрэг хяна шийдвэрлэж байгаа үед буюу шүүх хуралдааны бу үед гаргана.

123.3.Шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэ хянан шийдвэрлэх ажиллагаат түдгэлзүүлэ сэргээн явуулах, татгалзан гаргах тухай хүсэлтий шийдвэрлэх болон шүүх хуралдааны бусад үе хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүхий тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана Бусад асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчий захирамжийг шүүх хуралдааны тэмдэглэлд тусга амаар гаргаж болно.

124 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол шүүгчийн захирамжийг хүчингүй болгох буюу өөрчлөх

124.1.Энэ хуулийн 123.1-д заасны дагу бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчий захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүхий тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болго буюу өөрчилж болно.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

125 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх

125.1.Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ.

126 дугаар зүйл. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл

126.1.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

126.2.Нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очихоо бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

126.3.Зохиг маргааныг хэний оршин суугаа газрын шүүхэд шийдвэрлүүлэхийг тохиролцон тогтоож болно.

126.4.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлд гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр, гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлуулах шалтгаан, насанд хүрээгүй хүүхэдтэй бол түүний нэр, төрсөн он, сар, өдөр, түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаархи хүсэлт, энэ талаар хоорондоо хэлэлцэн тохиролцсон гэрээ байгаа

эхийг зааж, холбогдох нотлох баримтыг всаргана.

127 дугаар зүйл. Тэтгэвэр гаргуулах ба рлэгчийн дундын эд хөрөнгө хуваах

127.1.Гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр ь хүнд өвчтэй, өдөлмөрийн чадваргүй, эдийн ісгийн хувьд зайлшгүй туслалцаа аардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран ічлэх дундын эд хөрөнгө хуваах, насанд хүрээгүй гүхдийг хэний асрамжинд үлдэх талаар гарсан аргааныг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт ийдвэрлэж болно.

128 дугаар зүйл. Гэрлэгчдийн эд хөрөнгийн уюу тэжээн тэтгэх гэрээг биелүүлэх тухай үүгчийн захирамж гаргах

128.1.Гэрлэгчид харилцан тохиролцож эд эрөнгийн болон тэжээн тэтгэх тухай гэрээг тус тус айгуулсан бөгөөд тэдгээрийг сайн дураар иелүүлээгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр дгээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч ахирамж гаргана.

129 дүгээр зүйл. Гэр бүлийн холбогдолтой эрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга эмжээ

129.1.Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр үлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ араахь арга хэмжээг урьдчилан авахаар захирамж ргаж болно:

129.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон өдөлмөрийн чадваргүй эцэг,эхийг тэжээн этгүүлэх;

129.1.2.насанд хүрээгүй хүүхдийг эцэг, хийн хэн нэг дээр байлгах;

129.1.3.гэрлэгчдийг тусдаа амьдрахыг аалгах;

129.1.4.гэрлэгч хэн нэгийг тэжээн этгүүлэх;

129.1.5.орон сууц болон хамтран мчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх рхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, ахиран зарцуулахыг хориглох;

129.1.6.шүүхийн зардлын зохих хувийг рьдчилгаа болгон төлүүлэх;

129.1.7.зохигчийг эвлэрэх талаар сугацаа заах.

130 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, дуусгавар болгох

130.1.Шүүгч энэ хуулийн 129 дүгээр зүйлд заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

130.2.Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ дараахь нөхцөлд дуусгавар болсонд тооцно:

130.2.1.гэрлэгчид эвлэрч шүүгч эвлэрлийг батална захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгосон;

130.2.2.гэрлэлт цуцлах, тэжээн тэтгэхтэй холбогдсон хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарсан.

131 дүгээр зүйл. Гэрлэгчид шүүх хуралдаанд ирэх

131.1.Зохигчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа үед гэсэн гэрлэгчид өөрсдөө шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй.

131.2.Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулж болно.

131.3.Гэрлэгчид хоёр дахь удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэргийг хариуцагчийн байхгүйд хянан шийдвэрлэж болно. Харин нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаана.

131.4.Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийгөө байхгүйд хэрэг хянан шийдвэрлэхийг хүсч энэ тухай бичгээр мэдэгдсэн бол нэхэмжлэгчийг оролцуулалгүй шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг хянан шийдвэрлэнэ.

132 дугаар зүйл. Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

132.1.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.

132.2.Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг эвэхэн нэг удаа хэрэглэнэ.

132.3.Гэрлэгчид эвлэрвэл шүүгч эвлэрлийг батална захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

132.4.Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хөгжилд нөлөөлөх аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцлаж болно.

132.5.Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана. Шүүгч гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхдийг цаашид хүмүүжүүлэх талаар гэрлэгчдийн хооронд хэлэлц тохирсон зүйл байхгүй бол хүүхдийг эцэг буюу эхи хэний нь асрамжид үлдээх, хамтран өмчлөх дунд өмчийг хуваах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах болг орон суцны маргааны асуудлыг нэхэмжлэли үндэслэн хянан шийдвэрлэнэ. Хуульд заасан б гэрлэлт цуцлахыг буртгэхэд хураах улсы тэмдэгтийн хураамжийн хэмжээг шүүх тодорхойл түүнийг гэрлэгчдийн хэн нь ямар хэмжээгээр төлбө зохихыг тогтооно.

132.6.Шүүх нэхэмжлэлийг хангавал гэрлэ цуцлах тухай шийдвэр гаргана.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа

133 дугаар зүйл. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд

133.1.Шүүх дараахь хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ:

133.1.1.эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;

133.1.2. хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;

133.1.3. сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансуурууллах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;

133.1.4. хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;

133.1.5.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох;

133.1.6.эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх;

133.1.7.иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох;

133.1.8.хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх;

133.1.9.нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах.

134 дүгээр зүйл. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх

134.1.Онцгой ажиллагааны журмаар шүү хянан шийдвэрлэх хэргийг бүсад хууль болон эн бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосо ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ.

134.2.Энэ хуулийн 133 дугаар зүйлд зааса хэргийг шүүх хүсэлт гаргасан этгээд, холбогдс хуулийн этгээд, иргэнд мэдэгдсэний үндэсн дээ тэдний хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэнэ.

134.3.Онцгой ажиллагааны журмаар хэрэ хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулий этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр н гуравдагч этгээдээр оролцож болно.

135 дугаар зүйл. Эрх зүйн ач холбогдо бүхий үйл явдал

135.1.Иргэн, хуулийн этгээдийн эдийн б эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ

135.2.Эрх зүйн ач холбогдол бүхий дараах үйл явдлыг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтооно:

135.2.1.садан, төрлийн холбоо;

135.2.2.бусдын асрамжинд байгаа эсэх

135.2.3.төрөлт,үрчлэлт, гэрлэлт гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал

135.2.4.эрх олгосон ямар нэгэн барим бичиг /иргэний үнэмлэх, гэр бүлийн байдлыг бүртгэ байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад/ -г дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд

ичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ
эмшигч нь мөн эсэх;

135.2.5.осол гэмтэл гарсан эсэх;
135.2.6.хүний ажиллаж байсан байдал;
135.2.7. хүүхдийн эцэг,эхийг тогтоох;
135.2.8. хүүхдээ тэжээн тэтгэх;
135.2.9. тэтгэлгийн хэмжээг өөрчлөн
гтоох;

135.2.10.гэрлэлтийг хүчин төгөлдөр
/с, гэрлэлт цуцлаптыг хүчин төгөлдөр бус гэж
юцох;

135.2.11. хүүхэд асран хүмүүжүүлэх
айгууллагад болон асран хүмүүжүүлэгчид
илжсэн хүүхэд, нийгмийн халамжийн
айгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн
эмгаалагчид хариуцуулах;

135.2.12.эцэг, эх байх эрхийг
эгаарлах, хасах, сэргээх;
135.2.13. нас тогтоох;
135.2.14.тогтоох жүрмыг нь хуульд
эагаагүй эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл
вдал.

135.3.Эдгээр үйл явдлыг батлах баримт
ичгийг өөр жүрмаар олж авах боломжгүй буюу
рэгдсэн баримт бичгийг сэргээх боломжгүй болсон
эхиолдолд шүүх хянан шийдвэрлэнэ.

136 дугаар зүйл. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлт гаргах

136.1.Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлтээ иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа / оршин байгаа/ газрын, сэхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд эргана.

136.2.Хорих ял эдэлж байгаа хүн эрх зүйн ач олбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай үсэлтээ ял эдэлж байгаа газрын нутаг дэвсгэрийн арьяалах шүүхэд гаргана.

136.3.Хүсэлтэд үг үйл явдлыг тогтоолгох гэж айгаа зорилгыг заажүг үйл явдлыг тогтооход ач олбогдол бүхий баримт бичгийг олж авах буюу рэгдсэн баримт бичгийг сэргээх боломжгүй болсныг ютлох баримтыг хавсаргана.

136.4.Энэ хуулийн 136.3-т заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шүүх хүсэлтийг хүлээн ивахаас татгалзана.

136.5.Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэг зорилготой хоорондоо олбоотой хэд хэдэн хүсэлтийг шүүх нэгтгэж болно.

136.6.Хэрэв хүсэлт гаргагчид өөр өөр газар оршин суугаа бол тэдний сонгосон газрын шүүхэд, эсхүл үйл явдал болсон газрын шүүхэд хүсэлтээ гаргана.

137 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт гаргах

137.1.Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлтийг үг иргэний суүлчийн оршин сууж байсан газрын шүүхэд, хэрэв суүлчийн оршин сууж байсан газар нь мэдэгдэхгүй бол суүлчийн ажиллаж байсан газрын харьяалах шүүхэд гаргана.

137.2.Сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулахыг хүсч байгаа зорилго, түүнчлэн иргэнийг сураггүй алга болсныг батлах байдал, эсхүл түүнийг нас барсан буюу амь үрэгдсэн гэж үзэх үндэслэлээ хүсэлтэд заажк, нотлох баримтыг хавсаргана.

138 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн үйл ажиллагаа

138.1.Хүсэлт хүлээн авсан шүүх алга болсон иргэний талаар мэдээ егч чадах ямар хүмүүс /төрөл садан, хамт ажиллаж, сурч байсан хүн/ байгааг тодруулж сураггүй алга болсон иргэний талаар түүний оршин сууж буюу ажиллаж байсан газрын зохих байгууллагад ямар мэдээ байгааг лавлана.

138.2.Шүүх шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагаар дамжуулан уг иргэнийг эрэн сурвалжлах арга хэмжээ авахуулах бөгөөд түүний эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоож болно.

139 дүгээр зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

139.1.Иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ хүсэлт гаргасан этгээдийг оролцуулна.

139.2.Шүүх иргэнийг сураггүй алга болсонд тооцож шийдвэртээ түүний эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоохоор заана.

139.3. Иргэнийг нас барсан гэж зарласан шийдвэр гарсны дараа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд зохих тэмдэглэл хийлгэхээр шийдвэр гаргасан шүүх байгаа газрын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн байгуулагад үг шийдвэрийг явуулна.

140 дүгээр зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцсон буюу нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

140.1.Сураггүй алга болсонд тооцогдсон буюу нас барсан гэж зарлагдсан иргэн хүрээлцэн ирэх буюу байгаа газар нь мэдэгдвэл тухайн шүүх шинээр шийдвэр гаргаж урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгоно.

140.2.Шинэ шийдвэрээр уг иргэний эд хөрөнгө тогтоосон эрхлэн хамгаалалтыг өөрчилж, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд тэмдэглэсэн тэмдэглэлийг хүчингүй болгон түүнийг биелүүлэхийг холбогдох байгууллагад даалгана.

141 дүгээр зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хүсэлт гаргах

141.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах тухай сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг уг иргэний гэр бүлийн гишүүн, эсхүл сонирхогч бусад этгээд /сонгуулийн хороо, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга/, асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргана.

141.2.Хүсэлтийг уг иргэний оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд гаргана.

141.3. Хүсэлтэд сэтгэцийн өвчний буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас уг иргэний өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох буюу өөрийгөө зөв удирдаж чадахгүй байгаа байдлыг тодорхой дурдаж холбогдох нотлох баримтыг хавсаргана.

142.дугаар зүйл. Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэх

142.1.Хүсэлт хүлээн авсан шүүх нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгэж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулна.

142.2.Шинжилгээ хийлгэхээс зайлсхийсэн этгээдэд шүүгчийн захирамжийн дагуу албадан шинжилгээ хийлгэж болно.

142.3.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ асран хамгаалах байгууллагын төлөөлөгч, харгалзан дэмжвэл буюу асран хамгаалбал зохих этгээдийг шүүх хуралдаанд оролцуулж болно.

143 дугаар зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай шийдвэр

143.1.Шүүх шинжээчийн дүгнэлт, бусад нөхцөл байдлыг үндэслэн тухайн иргэний хязгаарлагдмал чадамжтай, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож уг иргэнд харгалзан дэмжилт,асран хамгаалалтыг тогтоно.

143.2.Хязгаарлагдмал чадамжтай, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэн эдгэрэх буюу эрүүл мэнд нь мэдэгдэхүйц сайжирвал уг иргэн, түүний харгалзан дэмжигч,асран хамгаалагч, түүнчлэн энэ хуулийн 141.1-д заасан этгээдийн хүсэлтийн дагуу шүүх сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн уг иргэн эрх зүйн бүрэн чадамжтай болсон тухай шийдвэр гаргаж болно.

143.3.Энэ хуулийн 141.2-т заасан шийдвэр гарсны дараа уг хүнд тогтоосон харгалзан дэмжилт,асран хамгаалалтыг хүчингүй болсонд тооцсон шийдвэр гаргана.

144 дүгээр зүйл. Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаань шүүхийн зардал

144.1.Иргэнийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай, эсхүл сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах шүүхийн зардлыг төр хариуцна.

144.2.Сэтгэцийн талаар эрүүл гэдгийг мэдсээр байж иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах буюу хасуулахын тулд энэ хуулийн 141.1-д заасан хүсэлт гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна.

145 дугаар зүйл. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

145.1.Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

145.2. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтэд энэ тухай шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

145.3.Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хэргийг хянан хэлэлцэхдээ үрчлүүлэгч, үрчлэн авагч талуудыг шүүх

үралдаанд оролцуулна.

145.4.Талуудын хэн нэг нь хүндэтгэн үзэх алтгаангүйгээр ирээгүй явдал шүүх хуралдааныг эйшлуулах үндэслэл болохгүй.

145.5.Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон үүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах айгуулагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх киллагаанд оролцож болно.

145.6.Шүүх нэхэмжлэлийг хангавал хүүхэд эчилснийг хүчингүйд тооцох тухай шийдвэр ргана.

145.7.Шүүх энэ хуулийн 145.6-д зааснаар рчлэлтийг хүчингүй болгосон бол хүүхдийг эрүүлсэн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, ргалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч тэдгээр ь байхгүй бол хүүхэд асран хүмүүжүүлэх айгуулагад шилжүүлэхээр шийдвэрлэнэ.

145.8.Үрчлүүлэгчид үрчлүүлэн авагчийн уруугаас гэм хор учирсан бол хохирлыг нөхөн элүүлэх асуудлыг үрчлэлтийг хүчингүй болгох эрэгтэй нь хамт шийдвэрлэж болно.

146 дугаар зүйл.Асран хамгаалагч, аргалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд ооцуулах тухай хүсэлт гаргах түүнийг хянан ийдвэрлэх

146.1.Асран хамгаалагч, харгалзан эмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай үсэлтийг асран хамгаалуулагч, харгалзан эмжүүлэгчийн оршин суугаа газрын шүүхэд ргана.

146.2.Асран хамгаалуулагч, харгалзан эмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай үсэлтийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

146.3.Асран хамгаалагч, харгалзан эмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай үсэлтэд энэ тухай шалтгааныг тодорхой дурдаж, олбогдох нотлох баримтыг хавсаргана.

146.4.Шүүх хуралдаанд талуудыг оролцуулах ба тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй явдал шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

146.5.Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон ийгмийн халамжийн байгуулагын төлөөлөгч хэрэг янан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

146.6.Шүүх нэхэмжлэлийг хангавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана.

147 дугаар зүйл. Үрэгдсэн баримт бичгийг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоолгох тухай хүсэлт гаргах

147.1.Эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх олгосон баримт бичгийг үрэгдүүлж устгагдсанд тооцуулсан тохиолдолд уг баримт бичгийг эзэмших эрхийн талаар маргаан гарвал тухайн эрхийг сэргээн тогтоолгох тухай хүсэлтийг хуульд өөрөөр заагаагүй бол шүүхэд гаргана.

147.2.Хүсэлтийг уг баримт бичгийг олгосон байгууллагын оршин байгаа газрын шүүхэд гаргана.

147.3.Хүсэлтэд уг баримт бичгийг эзэмшиж байсан этгээд ямар эрхтэй болох тухайгаа үндэслэж, түүнийг нотлох баримтыг хавсаргана.

147.4.Хүсэлт гаргасан этгээд баримт бичиг эзэмшиж байгаа этгээдэд холбогдуулан энэ хуульд заасан ердийн журмаар нэхэмжлэл гаргах эрхтэйг шүүгч тайлбарлаж өгнө.

148 дугаар зүйл. Үрэгдсэн баримт бичгийг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоох тухай хэрэг хянан шийдвэрлэх

148.1.Үрэгдсэн баримт бичгийг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоох тухай хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ хүсэлт гаргасан этгээдийг оролцуулна.

148.2.Энэ хуулийн 148.1-д заасан этгээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй явдал нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

148.3.Шүүх хүсэлтийг хангавал үрэгдсэн баримт бичгийн оронд шинэ баримт бичиг олгохыг уг баримт бичгийг олгосон байгууллагад даалгасан шийдвэр гаргана.

149 дүгээр зүйл. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоолгох тухай хүсэлт гаргах

149.1.Эрхийн тухай маргаан байхгүй байхад иргэний бүртгэлийн байгууллага өөрийн бүртгэлд залруулга хийхээс татгалзсан тохиолдолд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоолгох тухай хүсэлтийг шүүхэд гаргана.

149.2.Энэ хуулийн 149.1-д заасан хүсэлтийг гаргагч өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

149.3.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд ямар зүйл буруу бичигдсэн, уг асуудлыг эрхлэх ямар байгууллага залруулга хийхээс хэдийд татгалзсаныг бичиж, холбогдох нотлох баримтыг

хавсаргана.

150 дугаар зүйл. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай хэрэг хянан шийдвэрлэх

150.1.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай хэргийг шүүх хуралтай гаргагчид мэдэгдэж хянан шийдвэрлэнэ.

150.2.Шүүх шаардлагатай гэж үзвэл иргэний бүртгэлийн байгууллагын төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулна.

150.3.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоосон шийдвэр гарсны дараа бүртгэлд зохих залруулга хийлгэхээр иргэний бүртгэлийн байгууллагад уг шийдвэрийг явуулна.

151 дүгээр зүйл. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх

151.1.Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн материал үрэгдсэн байвал хэргийн оролцогчийн хүсэлт, түүнчлэн шүүхийн санаачилгаар түүнийг бүрэн буюу зарим хэсгийг сэргээж болно.

152 дугаар зүйл. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хүсэлт гаргах

152.1.Хэргийн материалыг сэргээх тухай хүсэлтийг уг хэргийг хянан шийдвэрлэсэн, шийдвэр гүйцэтгэлийн материалыг сэргээх тухай хүсэлтийг уг шийдвэрийг гүйцэтгэвэл зохих газрын шүүхэд тус тус гаргана.

152.2.Хүсэлтэд хэрэг буюу шийдвэр гүйцэтгэлийн материалын талаар тодорхой дурдаж, тэдгээртэй холбогдолтой баримт бичиг буюу түүний хуулбарыг хавсаргана.

153 дугаар зүйл. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг хянан шийдвэрлэх

153.1.Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ үрэгдсэн хэрэг, шийдвэр гүйцэтгэлийн материалаас үлдсэн болон үрэгдэхийн өмнө ирсэн, хуулийн этгээдэд олгосон баримт бичиг, түүний хуулбар, ач холбогдол бүхий бусад баримт мэдээллийг ашиглана. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээ тухай хэргийг хянан шийдвэрлэх шүүх уг хэргий оролцогч, шаардлагатай бол хэргийг урьд хяна шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн болон шийдв гүйцэтгэсэн этгээдээс гэрчийн хувиар мэдүүлэг а болно.

153.2.Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэли үрэгдсэн материалыг сэргээх талаар цугларса нотлох баримт хангалтгүй байвал энэ туха хүсэлтийг шүүхийн тогтоол буюу шүүгчий захирамжаар хүлээн авахаас татгалзаж хэргий хэрэгсэхгүй болгоно. Ийнхүү хэрэг хэрэгсэхгү болгосон бол сонирхогч этгээд энэ хуульд зааса журмын дагуу нотлох баримтаа бүрдүүл нэхэмжлэл дахин гаргах эрхтэй.

154 дүгээр зүйл. Хэргийн буюу шийдвэ гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээхтэ холбогдсон зардал

154.1.Иргэний хэргийн буюу шийдвэ гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх туха хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гара зардлыг төр хариуцна.

154.2.Энэ хуулийн 152.1-д зааса үндэслэлгүй зориуд худал гаргасан нь тогтоогдво шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна

155 дугаар зүйл.Хариуцагчийг эрэ сурвалжлах

155.1.Иргэний эрх зүйн маргаан, хариуцагчаар оролцвол зохих этгээд оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол түүнийг эрэ сурвалжлуулах тухай хүсэлтийг шүүхэд гарга болно.

155.2.Энэ хуулийн 155.1-д заасан хүсэлтий гаргагч өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргана

155.3.Хүсэлтэд хариуцагчийг эрэ сурвалжлуулах үндэслэлийг тодорхойлж, түүни оршин байгаа газрыг олж тогтооход ач холбогдо бүхий бичиг баримтыг боломжтой бол хавсаргана Шүүх хүсэлтийг хүлээн авч эрэн сурвалжлах тухай шийдвэр гаргана.

155.4.Хариуцагчийг эрэн сурвалжлах, түүни оршин суугаа газрыг тогтоох ажиллагаа шүүхий шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

156 дугаар зүйл. Шүүх гомдлоор авч хэлэлцэх хэрэг

156.1. Шүүх дараахь хэргийг гомдлоор авч хэлэлцэнэ:

156.1.1.төрийн захиргаа, шүүх, прокурор, эрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад аж ахуйн эгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны ийдвэр, үйл ажиллагаанд хуульд заасны дагуу ргасан гомдол;

156.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн өрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний йцэтгэгч сонгох журмын тухай хуульд заасны агуу тендерийн хорооны шийдвэр, үйл жиллагаанд гаргасан гомдол;

156.1.3.шүүх шийдвэрлэхээр хуульд заасан усад гомдол.

156.2. Гомдлоор авч хэлэлцэх хэргийг шүүх нэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар эгтоосон ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ.

157 дугаар зүйл. Гомдол гаргах

157.1.Энэ хуулийн 156.1-д заасан гомдлыг уулиар өөр харьяалал тогтоогоогүй бол шийдвэр ргасан буюу үйл ажиллагаа явуулсан аж ахуйн эгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны ршин байгаа газрын шүүхэд гаргана.

157.2.Гомдолд ямар аж ахуйн нэгж, айгууллага тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, йл ажиллагаанд гомдол гаргаж байгаа, тухайн ийдвэр, үйл ажиллагаа ямар хууль тогтоомжид аршилж байгаа, түүнийг хууль бус гэж үзсэн ндэслэл, нотолгоог заана.

157.3.Гомдлыг шүүхээс гадуур урьдчилан ийдвэрлүүлэхээр хуульд заасан бол үг аардлагыг ханагасан нөхцөлд шүүх түүнийг хүлээн ıвч хэлэлцэнэ.

158 дугаар зүйл. Тендерийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтийг үдгэлзүүлэх

158.1.Шаардлагатай гэж үзвэл шүүх хэргийг хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд тендерийн хорооны шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтийг түдгэлзүүлж болно.

159 дүгээр зүйл. Гомдлыг хэлэлцэх

159.1.Гомдлоор хэрэг хэлэлцэхдээ шүүх гомдол гаргагч болон холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

159.2.Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол гомдлыг буцаах тухай шүүгчийн захирамж гаргана. Шүүх хуралдаанд аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч ирээгүй явдал хэргийг хэлэлцэхэд саад болохгүй.

159.3.Гомдол гаргагч гомдлын хууль зүйн үндэслэл, нотолгоог гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч гомдлыг эвшөөрч байгаа эсэх, хэрэв эвшөөрөхгүй байвал татгалзал, түүний хууль зүйн үндэслэлийг нотлох зэрэг мэтгэлцэнэ.

159.4.Шүүх аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэх, шийдвэрийг эрх бүхий этгээд гаргасан, гомдол үндэслэлтэй эсэхийг тогтооно.

160 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр

160.1.Шүүх гомдлыг хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

160.1.1.хуульд заасан тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаог хүчингүй болгох эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах буюу зогсоохыг үүрэг болгох, шийдвэр, үйл ажиллагаанаас үүрсан хохирлыг гомдол гаргагчид нөхөн олгох;

160.1.2.гомдлыг хэрэгсэхгүй болгох.

Ш ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

161 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах этгээд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

161.1.Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэд гаргасан шүүхийн шийдвэрт зохигч, гэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч

161.2.Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдлыг зохигч аль нэг тал гаргасан нь эсрэг талын хяналтын журмаар гомдол гаргасэрхийг

үл хязгаарлана.

161.3.Зохигч талын нэг нь давж заалдах, эсрэг тал нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана.

161.4.Хамтран нэхэмжлэгч, эсхүл хамтран хариуцагчийн аль нэг нь давж заалдах, нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан бол энэ хуулийн 161. 3-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

161.5.Давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр шийдвэрлээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

162 дугаар зүйл. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга

162.1.Давж заалдах гомдлыг бичгээр гаргана.

162.2.Давж заалдах гомдолд дараахь зүйлийг заана:

162.2.1.гомдлыг ямар шүүхэд гаргаж байгаа;

162.2.2.гомдол гаргаж буй этгээдийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, эсхүл албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;

162.2.3.аль шүүхийн, ямар шийдвэрийг давж заалдаж байгаа;

162.2.4.шийдвэрийн чухам аль нотлох баримтыг зөвшөөрөхгүй байгаа, түүний үндэслэл;

162.2.5.гомдол гаргаж буй этгээдийн хүсэлт.

162.3.Давж заалдах гомдолд түүнийг гаргасан этгээд гарын үсгээ зурна.

162.4.Давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1-д заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.

163 дугаар зүйл.Давж заалдах гомдлыг хүлээн авах

163.1.Давж заалдах гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүгч буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулна.

163.2.Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд гомдлын талаар тайлбараа өгөх эрхтэй.

163.3.Анхан шатны шүүх давж заалдах гомдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хариуцагч, гуравдагч этгээдээс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт гомдлыг хүлээн авс өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шат шүүхэд хүргүүлнэ.

164 дүгээр зүйл. Давж заалдах гомдло татгалзах

164.1.Давж заалдах гомдол гаргасан этгэ давж заалдах шатны шүүх хуралдаанаас өм гомдлоосоо татгалзвал шүүх түүнийг гомдо гаргаагүйд тооцно.

164.2.Энэ хуулийн 164.1-д заасан тохиолдо улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох туха шүүгч захирамж гаргана.

164.3.Давж заалдах гомдол гаргахад эн хуульд заасан журмыг баримтлаагүй бол дав заалдах шатны шүүх гомдлыг хүлээн авахгү бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.

165 дугаар зүйл. Шүүх хуралдаанд биечлэ оролцох

165.1.Зохигч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохыг бичгээр хүсвэл шүү давж заалдах шатны шүүх хуралдаан хэзээ, хаан болохыг мэдэгдэх үүрэгтэй.

165.2.Энэ хуулийн 165.1-д заасан этгээд шүү хуралдаанд ирэхгүй явдал давж заалдах журмаа хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

166 дугаар зүйл. Давж заалдах журмаа хэрэг хянан шийдвэрлэх

166.1.Давж заалдах журмаар хэргийг шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ

166.2.Давж заалдах гомдол гарсан хэргий шүүх хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаа хянан шийдвэрлэнэ.

166.3.Давж заалдах журмаар хэрэг хянаг шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгчдий зөвлөгөөнөөс томилсон шүүгч даргална.

166.4.Давж заалдах журмаар хэрэг хянаг шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдса үндэслэлээр хязгаарлагдах хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

166.5.Шүүх хуралдаанд хэргийг нэг шүүгч илтгэнэ. Дараа нь зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд тайлбар гаргах харилцан асуулт тавих бөгөөд хэргийн материалы судалснаар шүүх хуралдаан завсарлан шүүгч бүрэлдэхүүн зөвлөлдөнө.

166.6.Шүүх хуралдаанд нотлох баримтын лаархи мэдүүлгийг үнших, эсхүл бичлэгээс нилцуулж болно.

167 дугаар зүйл. Шүүхийн магадлал

167.1.Давж заалдах журмаар хэрэг хэлэлцсэн үүх дараахь байдлаар хянан шийдвэрлэж агадлал гаргана:

167.1.1.давж заалдах гомдлыг хүлээж ıах боломжгүй буюу үндэслэлгүй бол түүнийг ıнгахгүй орхиж анхан шатны шүүхийн шийдвэрийг ıвээр үлдээх;

167.1.2.анхан шатны шүүхийн шийдвэрт эмэлт, өөрчлөлт оруулах;

167.1.3.анхан шатны шүүхийн ийдвэрийн зарим хэсийг хүчингүй болгож бусад эсгийг хэвээр үлдэх буюу өөрчлөх;

167.1.4.анхан шатны шүүхийн ийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй олгож хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй олгох;

167.1.5.энэ хуульд заасан хэрэг хянан ийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн ж үзвэл шийдвэрийг хүчингүй болгож дахин ийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах.

167.2.Магадлалд анхан шатны шүүхийн ийдвэрийн тогтоох хэсгийн агуулга, давж заалдах эмдлын товч үндэслэлийг тусгана.

167.3.Магадлал үншиж сонсгомогц хуулийн үчин төгөлдөр болно.

167.4. Магадлалыг гарснаас хойш 7 хоногийн отор зохигчид хүргүүлнэ.

167.5.Давж заалдах шатны шүүх магадлал ргахдаа хууль заасан хэрэг хянан шийдвэрлэх жиллагааны журам зөрчсөн, хууль бруу эрэглэсэн гэж зохигч, эсхүл гуравдагч этгээд үзвэл нэ хуулийн 120.2-т заасан хугацаанд хяналтын :ургаар гомдол гаргаж болно.

168 дугаар зүйл.Анхан шатны шүүхийн ийдвэрийг хүчингүй болгох

168.1.Давж заалдах журмаар хэрэг хянан элэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

168.1.1.шүүх өөр хуулийг, эсхүл уулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба ийдвэрийг өөрчлөх боломжгүй;

168.1.2.зохигч, тэдгээрийн төлөөлөгч ıюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн ıролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн;

168.1.3.хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн;

168.1.4.хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;

168.1.5.шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан;

168.1.6.хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн;

168.1.7.энэ хуулийн 38. 6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн.

168.2.Давж заалдах гомдол гаргасны дараа зохигч эвлэрэн хэлэлцсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсөн бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

168.3.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол давж заалдах журмаар хянан хэлэлцсэн шүүх тухайн хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана.

169 дүгээр зүйл.Хэргийг хянан шийдвэрлэхэд баримтлах журам

169.1.Давж заалдах шатанд хэргийг хянан шийдвэрлэхэд хуульд өөрөөр заагаагүй бол анхан шатны шүүх хуралдааны журмыг нэгэн адил баримтлана.

170 дугаар зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах

170.1.Энэ хуулийн 20.1;65.1.4,65.1.5;69.1;80 дугаар зүйл, 92.4; 97.1; 100.2; 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно.

170.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэж тогтоол гаргана.

170.3. Энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.1-65.1.3; 65.1.6-65.1.10 дахь заалт; 74, 75, 76 дугаар зүйл, 106. 5; 129, 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй.

170.4. Шүүх шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулалгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

171 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх

171.1. Шүүх шүүхийн тогтоол, шүүгчий захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг эн хуулийн 170 дугаар зүйлд заасан журмаар хянах хэлэлцээд дараахь байдлаар шийдвэрлэх магадлал гаргана:

171.1.1.тогтоол, захирамж, шийтгэври хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орших;

171.1.2. тогтоол, захирамж шийтгэврийг хүчингүй болгох.

171.2.Энэ хуулийн 171.1-д заасан шийдвэр н эцсийн шийдвэр болно.

IY ХЭСЭГ
ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

172 дугаар зүйл. Хяналтын журмаар гомдол гаргах

172.1.Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэр буюу энэ хуулийн 167 дугаар зүйлд заасан магадлалд зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

172.2.Хяналтын журмаар дараахь үндэслэлээр гомдол гаргана:

172.2.1.шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн;

172.2.2.хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн.

172.3.Дор дурдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэж үзнэ:

172.3.1.шүүх хуралдаанд зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй;

172.3.2.хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;

172.3.3.хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн.

173 дугаар зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах

173.1.Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авна.

173.2.Гомдол хүлээж авсан шүүх хэрэг улсын төмдэгтийн хураамж төлсөн баримт зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авса едрээс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө оро нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэ хүргүүлнэ.

173.3.Хяналтын журмаар гомдол гарга байгаа этгээдээс энэ хуулийн 57.1-д заасны дагу улсын төмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ

174 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

174.1.Хэргийг хүлээн авснаас хойш 30 хоног багтаан хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

175 дугаар зүйл. Хэргийн оролцогчид мэдэгдэх

175.1. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын шүүх хуралдаанд оролцохы хүсвэл шүүх хуралдаан хэзээ, хаана болохы мэдэгдэнэ.

175.2. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирэхгүй явдал хэргий хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

175.3. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй.

176 дугаар зүйл. Хяналтын шатны шүүх хуралдаан

176.1. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын 5 шүүгчийн

/рэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

176.2.Танхимын шүүх хуралдааныг тогтоол /ргана. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, ттэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан атны болон давж заалдах журмаар хэргийг хянан ийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын үүлга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын дэслэлийг тусгана.

176.3.Танхимын шүүх хуралдааны тогтоолыг эмдол гаргагч эттээд хүлээж авснаас хойш 30 эногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын ээд шүүхэд гомдол гаргаж болно. Улсын дээд үүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж эвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд үүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ.

176.4.Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд гомдлын ндэслэл, хэрэг шийдвэрлэсэн байдал, хууль зөрчсөн гэсэн үндэслэлийг тусгасан байна.

176.5.Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын ээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү уралдаанаас тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн ийдвэр болно.

176.6.Танхимын шүүх хуралдааны тогтоолд эргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар янан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч хэргийн хамт лсын дээд шүүхэд ирүүлнэ.

177 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх

177.1.Улсын дээд шүүх энэ хуулийн 176.5-д аасны дагуу Улсын дээд шүүхийн хуралдаанаар эргийг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

177.2.Энэ хуулийн 177.1-д заасан шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл дүгнэлтийг хүлээн авааргүй тооцно.

178 дугаар зүйл. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол

178.1.Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх дараахь байдлаар хэргийг хянан шийдвэрлэж, тогтоол гаргана:

178.1.1.шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

178.1.2.шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

178.1.3.шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

178.1.4.шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;

178.1.5.шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд буцаах.

178.2.Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол гармагц хуулийн хүчин төгөлдөр болно.

178.3.Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тогтоол эцсийн шийдвэр болно.

Үхэсэг
ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХ ЖУРАМ

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах

179 дүгээр зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл

179.1. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр / нхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон ияналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараахь үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно:

179.1.1.шүүхийн шийдвэр гарах үед эргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл;

179.1.2.шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч,хэлмэрч, хэргийн оролцогчийн үг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

179.1.3.шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон .

180 дугаар зүйл. Шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах

180.1.Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг тийнхүү хянах үндэслэл байгааг мэдсэнээс хойш

30 хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч уг шийдвэрт давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргаагүй бол анхан шатны, гомдол гаргасан бол тухайн шатны шүүхэд гаргана.

180.2.Хүсэлтийг бичгээр гаргаж түүнд шинээр илэрсэн нөхцөл байдлын талаархи баримтыг хавсаргана.

181 дүгээр зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх

181.1.Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

181.2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянахад анхны шийдвэр гаргасан шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн дахин оролцохгүй.

181.3.Хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх ба ийнхүү хүсэлт гаргасан этгээд хүрэлцэн ирээгүй явдал хүсэлтийг шийдвэрлэхэд саад болохгүй.

181.4.Шүүх хуралдаанаар шинээр илэрсэ нөхцөл байдлыг баталж байгаа шинэ нотло баримтыг үндэслэн шинээр илэрсэн нөхцөл байдлы тогтоох, уг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргаха хэрхэн нөлөөлсөн, шинээр илэрсэн нөхцөл байдлы улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хуул ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ.

181.5.Шүүх хүсэлтийг шүүх хуралдаанаа хянан шийдвэрлээд түүнийг хангах, эсхүл хангахаа татгалзах тухай тогтоол гаргана.

181.6. Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлы тогтоосон нөхцөлд хэргийг ердийн журмаар хяна шийдвэрлэнэ.

182 дугаар зүйл.Биелэгдсэн шийдвэрий цуцлах

182.1.Биелэгдсэн шийдвэрийг шинээ илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хяна шийдвэрлэсэн шүүх хүчингүй болгож байгаа бо биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлы тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхээ шийдвэрлүүлэхээр шилжүүлэх үүрэгтэй.

ҮІ ХЭСЭГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

183 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл

183.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна.

184 дүгээр зүйл. Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэврийн гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулах

184.1.Эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр шийдвэрлэсэн, талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн болон захиргааны шийтгэврийг албадан гүйцэтгүүлэхээр бол уг арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр шүүхээр баталгаажсан байна.

184.2.Шийдвэрийг гүйцэтгүүлэхийг сонирхож байгаа тал арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэврийн гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

184.3.Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэврий биелүүлэх боломжийг нь шүүх хянан үзэж ирүүлсэ өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна. Шүүгч ийнхүү захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

185 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрий гүйцэтгэх

185.1.Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолы дараахь тохиолдолд албадан гүйцэтгүүлэхээр шүүгч захирамж гаргана:

185.1.1.төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан;

185.1.2.шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн.

185.2.Шүүгчийн туслах энэ хуулийн 185.1-д заасан шүүгчийн захирамж гарснаас хойш 7 хоногийн дотор уг захирамж, шүүхийн шийдвэр, шаардлагатай бусад материалыг хавсарган шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ.

186 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх

мүүс Монгол Улсын шүүхэд үл харьяалагдана.

194 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэрийг йцэтгэх

194.1. Монгол Улсын шүүхийн болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

195 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр олох

195.1. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

195.2. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэргийг тухайн шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

002 оны 01 дүгээр ырын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны 5 дугаар сарын 9-ний дрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

002 оны 01 дүгээр арын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

I ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын тогтолцоо, зохион айгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа цашид "шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу огтоол гүйцэтгэх ажиллагаа" гэх/-ны эрх зүйн ндэс, журмыг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ухай хууль тогтоомж

2.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим

3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны

Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" мхтэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл

4.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.

5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний тогтолцоо

5.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

5.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана.

5.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /шийдвэр гүйцэтгэх төв байгууллага/, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ.

5.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар /цаашид "шийдвэр гүйцэтгэх газар" гэх/, эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар /цаашид "тогтоол гүйцэтгэх газар" гэх/ тус тус байна.

6 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын чиг үүрэг

6.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулах, албан хаагчийг сургах бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

6.1.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, тэдгээрт цэргийн цол олгох, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн[2] 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 4,5 дахь заалтад заасан үндэслэлээр цол бууруулах, хураан авах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэ ажиллагаанд дагаж мөрдөх журмыг энэ хууль болс бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.4.шийдвэр гүйцэтгэ байгууллагыг зэвсэг техник, тусгай хэрэгсэл хувцас, бусад материалаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

6.1.5.шийдвэр гүйцэтгэ байгууллагыг төлөөлж дотоод, гадаады байгууллагатай харилцах.

7 дугаар зүйл.Шийдвэр гүйцэтгэх газрын чи үүрэг

7.1.Шийдвэр гүйцэтгэх газар дараахь чи үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.аймаг, нийслэлийн шийдвэ гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах үйл ажиллагаанд нь хяналт тавих;

7.1.2.албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

7.1.3. шүүхийн зарим төрлий шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагаат мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөж хяналт тавих;

7.1.4.шийдвэр гүйцэтгэх ажиллагаань талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх

7.1.5.аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны талаар гарсан гомдлы шийдвэрлэх.

7.2.Шийдвэр гүйцэтгэх газрын дарга нь Улсы ерөнхий шийдвэр гүйцэтгэгч байх бөгөөд улсын байцаагчийн эрхтэй байна.

7.3.Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны /цаашид "шийдвэр гүйцэтгэх алба" гэх/ дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.3.1.иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, түүнчлэн эрүүгийн хэргийн талаар гарсан торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

[2] *Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 3 дугаарт нийтлэгдсэн.*

эргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;

7.3.2.тодорхой албан тушаал эрхлэх, ял ажиллагаа явуулах эрхийг хасах ял, түүнчлэн ибадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн ийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг эргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;

7.3.3.Монгол Улсын олон улсын рээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын эбитрын байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх киллагаанг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт ивих;

7.3.4.үл хөдлөх эд хөрөнгийн албадан гудлага худалдааг явуулах;

7.3.5.энэ хуулийн 7.3.1-7.3.3-т заасан ийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон шийдвэр йцэтгэгчийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх;

7.3.6.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд этэй эттээдийнх бүртгэл хөтлөх.

7.4.Шийдвэр гүйцэтгэх албанд ахлах шийдвэр гйцэтгэгч /цаашид "ахлах шийдвэр гүйцэтгэгч" гэх/ жиллах бөгөөд улсын байцаагчийн эрхтэй байна.

7.5.Энэ хуулийн 7.3.1-7.3.3-т заасан шийдвэр гйцэтгэх ажиллагааг явуулах анхан шатны нэгж нь эгтоосон тойрог байна.

7.6.Шийдвэр гүйцэтгэлийн тойргийг Шүүхийн ийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын саналыг ндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн азрын гишүүн тогтооно.

7.7.Шийдвэр гүйцэтгэлийн нэг тойрогт нэг ийдвэр гүйцэтгэгч ажиллана.

8 дугаар зүйл.Тогтоол гүйцэтгэх газрын чиг үрэг

8.1.Тогтоол гүйцэтгэх газар дараахь чиг үргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.сэжигтэн, яллагдагчийг аривчлах, цагдан хорих тухай шүүгчийн шийдвэрийг үйцэтгэх, түүнчлэн баривчлах, хорих ял ногдуулсан шүүхийн шийтэх тогтоолыг гүйцэтгэх жиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

8.1.2.хорих байгууллагыг зохион айгууллагын удирдлагаар хангах;

8.1.3.энэ хуулийн 8.1.1-д заасан ажиллагааны хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл этлөх;

8.1.4. цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэргийн талаархи шүүхийн зарим төрлийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх хяналт тавих.

8.2. Баривчлах, хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1. баривчлах болон хорих ялыг албадан эдлүүлэх;

8.2.2.ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг жүрмыг сахиулах, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

8.2.3.ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх;

8.2.4.ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох;

8.2.5.насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох;

8.2.6.ялтны эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаат хангах;

8.2.7.нийгэмд аюултай халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтой ялтныг албадан эмчлэх;

8.2.8.гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлберийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх;

8.2.9.хууль заасан бусад үүрэг.

8.3.Хорих байгууллага нь шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан баривчлах, хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд хуулийн этгээдийн эрх эдэлнэ. Хорих байгууллагын дотоод журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

8.4.Хорих ангид дарга, хорих ангийн албан хаагч ажиллана.

8.5.Хорих анги ялтныг хөдөлмөрт татан оролцуулах зорилгоор үйлдвэрлэлийн салбар, нэгжтэй байж болно.

9 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын санхүүжилт

9.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

улсын төлөрсөн төсөөс санхүүжинэ.

9.2.Шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 83 дугаа зүйлд заасан урамшууллаас санхүүжүүлнэ.

II ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААРХИ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх

10 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичиг

10.1.Гүйцэтгэх баримт бичигт дараахь баримт бичиг багтана:

10.1.1.иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, түүний дотор эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас;

10.1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын арбитрын байгуулагын шийдвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас;

10.1.3.шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, тэдгээрийн үндсэн дээр шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас;

10.1.4.эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан болон хөрөнгө гаргуулах заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас;

10.1.5.үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар эрх шилжүүлсэн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр.

10.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглоно.

10.3.Гүйцэтгэх баримт бичиг үрэгдсэн тохиолдолд уг гүйцэтгэх баримт бичгийг хуульд заасан журмын дагуу дахин олгоно.

11 дүгээр зүйл. Гүйцэтгэх баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага, үр дагавар

11.1.Гүйцэтгэх баримт бичигт дараахь зүйлийг заана:

11.1.1.гүйцэтгэх баримт бичгийг олгосон шүүх, бусад байгуулагын нэр;

11.1.2.шүүх, бусад байгуулагаас шийдвэр гаргасан огноо, дугаар;

11.1.3. тухайн гүйцэтгэх баримт бичгий олгосон үндэслэл;

11.1.4.төлбөр авагч-хуулийн этгээд болон төлбөр төлөгч-хуулийн этгээдийн овоосо нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг төлбөр авагч-иргэн, төлбөр төлөгч-иргэний овог эцгийн нэр, нэр, оршин суугаа газрын болон ажлы газрын хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх регистрийн дугаар;

11.1.5.төлбөр авагчид олговол зохи төлбөрийн төрөл, хэмжээ;

11.1.6.шүүх, бусад байгуулагаас гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр болсо хугацаа.

11.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэ баримт бичиг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагы хангаагүй бол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тогтоол гарган шийдвэр гаргасан шүүхэд, эсхүл гүйцэтгэх баримт бичгийг ирүүлсэ бусад байгуулагад буцаана.

11.3.Гүйцэтгэх баримт бичгийг буцаах тухай тогтоолд гүйцэтгэх баримт бичгийг буцаасан шалтгааныг заана.

12 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх

12.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 11.2-т заасан үндэслэл байхгүй бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

12.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг түүнийг гарсан өдрөөс хойш 3 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч, шүүх болон гүйцэтгэх баримт бичиг олгосон бусад

айгууллагад явуулна.

12.3.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх ухай тогтоолд гүйцэтгэх баримт бичиг, хөрөнгө итүүмжилсэн буюу хураасан акт, нэхэмжлэлийн нийн дүнтэй тэнцэх хэмжээгээр иргэн, хуулийн тгэдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны арлагын гүйлгээг хаасан баримт бичиг, одорхойлолт зэргийг хавсаргана.

12.4.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн олон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийг үйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын талаар ууж, бусад байгууллагад гомдол гаргахгүй.

13 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал

13.1.Төлбөр төлөгч нь иргэн бол шийдвэр үйцэтгэх ажиллагааг түүний оршин суугаа нутаг эвсэгрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.2.Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түүний ажил хэргээ байнга явуулдаг,эсхүл удирдах байгууллага нь байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр үйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.3.Төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газар нь мэдэгдэхгүй бол түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр үйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.3.Тодорхой үйл ажиллагаа үйцэтгүүлэхээр хариуцагчид даалгасан шийдвэрийг үл үйл ажиллагаа гүйцэтгэх этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.4.Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулснь хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг төлбөр төлөгч, төлбөр авагчийн алинь нь ч оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэж болно.

13.5.Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн төлбөр төлөгчид холбогдох шийдвэрийг төлбөр авагчийн саналаар төлбөр төлөгчдийн аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.6.Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.7.Тэжээн тэтгэхтэй холбогдсон шүүхийн шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

13.8.Шийдвэр гүйцэтгэх явцад төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын хаяг өөрчлөгдсөн, эд хөрөнгө байхгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь энэ талаар тэмдэглэл үйлдэж ахлах шийдвэр гүйцэтгэгч болон төлбөр авагчид мэдэгдэнэ.

13.9.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 13.8-д заасан тэмдэглэлийг гүйцэтгэх баримт бичгийн хамт төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ буюу түүний ажилтай байгаа, эсхүл түүний эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд явуулж, энэ тухай төлбөр авагч болон гүйцэтгэх баримт бичиг үйлдсэн бусад байгууллагад мэдэгдэнэ.

13.10.Гүйцэтгэх баримт бичгийг хүлээж авсан шийдвэр гүйцэтгэх алба түүнийг үл маргалдах журмаар гүйцэтгэнэ.

14 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах хугацаа

14.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг орон нутгийн цагаар 06.00 цагаас 22.00 цагийн хооронд явуулах ба тодорхой цагийг шийдвэр гүйцэтгэгч өөрөө тогтооно.

14.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ажлын бус өдөр, эсхүл орон нутгийн цагаар 22.00 цагаас 06.00 цагийн хооронд явуулах шаардлагатай бол ахлах шийдвэр гүйцэтгэгчээс зөвшөөрөл авч ажиллагаа явуулсан тэмдэглэлд энэ тухай тусгана. Хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас ийнхүү шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан тохиолдолд 24 цагийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх

15.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараахь үндэслэл, хугацаагаар шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ:

15.1.1.дампуурлын хэрэг үүсгэсэн, эсхүл битүүмжилсэн эд хөрөнгийг челеенлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд тус тус гаргасан бол асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл;

15.1.2. төлбөрт хураагдсан эд хөрөнгийн талаар бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гартал;

15.1.3.шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гарсан бол түүнийг дахин шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарах хүртэл;

15.1.4.гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөрт хураан авах эд хөрөнгийн жагсаалтаас тухайн эд хөрөнгийг хасуулах тухай, эд хөрөнгийн үнэлгээний талаар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэтэй холбогдсон, энэ хуулийн 34.4, 87.3-д заасан үндэслэлээр шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарах хүртэл.

15.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараахь үндэслэл, хугацаагаар шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор түдгэлзүүлнэ:

15.2.1.төлбөр төлөгч, эсхүл төлбөр авагч иргэн нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч болон иргэний эрх зүйн чадамжгүй төлбөр төлөгчид асран хамгаалагчийг тус тус тогтоох хүртэл;

15.2.2.төлбөр төлөгчийн хаягийг тодруулах буюу эрэн сурвалжилж байгаа бол хаягийг олж тогтоох хүртэл;

15.2.3.төлбөр төлөгчөөс хураасан эд хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан үед төлбөрийн шаардлага хангахуйц эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулах хүртэл;

15.2.4.эрүүгийн журмаар хэргийг шалгаж байгаа бол асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл;

15.2.5.төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, эсхүл орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний эд хөрөнгө, эсхүл орлогыг албадан гаргах боломжгүй бол эд хөрөнгөтэй болтол;

15.2.6. барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг нүүн гарч байгаа этгээдийн амьдралын нөхцлийг харгалзан өвлийн улиралд тодорхой хугацаагаар;

15.2.7.шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон гүйцэтгэх баримт бичгийн талаар гомдол гаргасан нь үндэслэлтэй бол гомдлыг шийдвэрлэх хүртэл.

15.3.Энэ хуулийн 15.1,15.2-т зааснаас бусад үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

15.4.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулий 15.1,15.2-т заасан үндэслэл илэрсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор шүүхэд, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх ба эрх бүхий этгээ түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

15.5.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай төлбөр төлөгч төлбөр авагч, шүүх болон гүйцэтгэх баримт бичи үйлдсэн бусад байгууллагад мэдэгдэнэ.

15.6.Энэ хуулийн 15.1,15.2-т заасан үндэслэ арилмагц төлбөр авагчийн буюу шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтэнд шүүгч захирамж, ахла шийдвэр гүйцэтгэгч тогтоол гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээнэ.

16 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох

16.1.Шийдвэр гүйцэтгэгч дараахь үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсонд тооцож, шийдвэр гарган гүйцэтгэх баримт бичгийг хаана:

16.1.1.төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал түүний хүсэлтээр;

16.1.2.төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлсөн;

16.1.3.төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор;

16.1.4.төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр авагч-иргэн нас барсан гэж зарлагдсан буюу төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан үед тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй;

16.1.5.төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэж явуулсан татан буулгах ажиллагаа дуусгавар болоход эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхүй байгаа нь шүүхээр тогтоогдсон;

16.1.6.гүйцэтгэх баримт бичиг хүчингүй болсонд тооцогдсон.

16.2.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагч болон төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсон тухай шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

16.3.Энэ хуулийн 16.1.3-т заасны дагуу төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрсэн бол шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд энэ үндэслэлээр гомдол гаргах эрхгүй.

17 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичгийг өлбөр авагчид буцаах

17.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа вагдаагүй, эсхүл хэсэгчлэн явагдсан бол гүйцэтгэх аримт бичгийг дараахь үндэслэлээр төлбөр вагчид буцаана:

17.1.1.төлбөр авагч хүсэлт гаргасан;

17.1.2.төлбөр авагч шүүхийн шийдвэрт аасан, эсхүл төлбөрт гаргуулсан боловч худалдан орлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас атгалзсан;

17.1.3.төлбөр авагч өөрийн үйлдэл, /эс үйлдэхүй/-гээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад саад учруулж байгаа.

17.2.Энэ хуулийн 17.1.2-т заасан үндэслэлээр төлбөрийг гаргуулах боломжгүй нь гогтоогдсон бол шийдвэр гүйцэтгэгч энэ тухай гэмдэглэл үйлдэж, гүйцэтгэх баримт бичиг болон бусад материалыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид ирүүлнэ.

17.3.Гүйцэтгэх баримт бичгийг буцаах үндэслэлтэй гэж үзвэл ахлах шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг зохих ёсоор битүүмжилсэн, хураасан, худалдан борлуулсан эсэх, нуусан эд хөрөнгийг олж илрүүлэх талаар бүхий л арга хэмжээ авсан эсэхийг хянан үзэж гогтоол гаргана.

17.4.Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1.2-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.

17.5.Гүйцэтгэх баримт бичгийг энэ хуулийн 17.1.1,17.1.3-т заасан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин шийдвэр гүйцэтгүүлэхээр ирүүлэх эрхгүй.

18 дугаар зүйл. Төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах

18.1.Төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч нь иргэний буртгэл мэдээллийн, татварын, зохих нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авах, тухайн хүний төрөл, садангийн хүнийг дуудан ирүүлж тайлбар гаргуулах замаар хаягийг тодруулна.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан ажиллагаа явуулсан боловч олдохгүй байгаа төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийг буюу төлбөр төлөгчийн эд хөрөнгийг төлбөр авагч эрэн сурвалжилж болно.

19 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэл

19.1.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх бүх ажиллагааны явцад тэмдэглэл хөтөлнө.

19.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

19.2.1.тэмдэглэл үйлдсэн газар,огноо;

19.2.2.шийдвэр гүйцэтгэх тодорхой ажиллагааны товч утга;

19.2.3.шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчийн овог, эцгийн нэр, нэр;

19.2.4.шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч болон шийдвэр гүйцэтгэгчийн гарын үсэг.

19.3.Энэ хуулийн 19.2.4-т заасан гарын үсэг зураагүй бол шалтгааныг заажтусгайлан тэмдэглэнэ.

20 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдэгдэх хуудас

20.1.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, холбогдох бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж асуух, тэдгээрээс баримт бичиг гаргуулан авч болно.

20.2.Энэ хуулийн 20.1-д зааснаас гадна шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөхийг шаардах буюу тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах, хөдөлмөрийн хөлс, орлогоос суутгал хийх тухай хугацаатай мэдэгдэх хуудас өгнө.

20.3.Мэдэгдэх хуудсыг дуудан ирүүлж гардуулах, биечлэн хүргүүлэх буюу баталгаат шуудангаар хүргүүлж болно.

20.4.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[3] 77 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

---

[3] *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.*

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч

21 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд

21.1.Төлбөр төлөгч, төлбөр авагчийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд гэнэ.

21.2.Төлбөр авагч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэх түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

21.3.Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

21.4.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэд хэдэн төлбөр авагч, төлбөр төлөгч оролцож байгаа бол тэдгээр нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй.

21.5.Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож болно.

22 дугаар зүйл. Талуудын эрх, үүрэг

22.1.Төлбөр төлөгч, төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах үед байлцах, холбогдох тэмдэглэл, бусад баримт бичиггэй танилцах, тэдгээрийн хуулбарыг авах, нэмэлт баримт бичиг гарган өгөх, амаар болон бичгээр тайлбар гаргах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн ямар ч асуудлаар саналаа илэрхийллэх, шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргах эрх эдэлнэ.

22.2.Төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх, эсхүл түүнээс татгалзах, эд хөрөнгө болон мөнгийг шилжүүлэх, гүйцэтгэх баримт бичигт заасан бусад үүрэг хүлээнэ.

23 дугаар зүйл.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчийн иргэний эрх зүйн чадамж

23.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эрхээ өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөрөө дамжуулан гүйцэтгүүлнэ.

23.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг тэдгээрийн эцэг, эх, асран хамаалагч, харгалзан дэмжигч хамгаалж оролцоно.

23.3.Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай этгээд Иргэний хуулийн[4] 15.3-т заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бие даан оролцож болно.

24 дүгээр зүйл.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эрх залгамжлагч оролцох

24.1.Талуудын аль нэг нь байхгүй /сураггүй алга болсон,нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, шаардлага бүрэн үүргээ бусдад шилжүүлсэн/ бол төлбөр авагч, төлбөр төлөгчийн хүсэлтээр уг этгээдийг эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан эрх залгамжлагч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухайн этгээдтэй холбоотой эрх эдэлж, үүргийг хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд талуудын төлөөлөгч оролцох

25.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэн өөрийн биеэр, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоно.

25.2.Төлөөлөл хуульд зааснаар, сайн дураар буюу гэрээгээр гэсэн хэлбэртэй байна.

25.3.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн нь гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садангийн хүн, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэхээ сайн дураар сонгох эрхтэй.

25.4.Гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөр гүйцэтгүүлэхээр заасан үүргийг төлөөлөгчөөр төлөөлүүлэн гүйцэтгэхийг хориглоно.

25.5.Хуулийн этгээдийг хууль тогтоомж, эсхүл үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу эрх олгогдсон албан тушаалтан төлөөлнө.

25.6.Хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичигтэй байна.

[4] *Монгол Улсын Иргэний хууль "Төрийн мэдээллэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.*

26 дугаар зүйл. Иргэнийг хуульд зааснаар элөөлөх

26.1.Иргэний эрх зүйн чадамжгүй, зарим үюу бүрэн бус чадамжтай иргэний эрх, эрх чөлөө, үүлиар хамгаалагдсан аливаа сонирхлыг эцэг, эх, сран хамгаалагч, харгалзан дэмжигч шийдвэр ийцэтгэх ажиллагаанд төлөөлөх бөгөөд тэдгээр ь эрхээ нотлох баримт бичгийг шийдвэр ийцэтгэгчид үзүүлнэ.

26.2.Сураггүй алга болсонд тооцогдсон ргэн оролцвол зохих ажиллагаанд зөхөнгийг нь рхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд түүнийг өлөөлөн оролцоно.

26.3.Нас барсан буюу нас барсан гэж арлагдсан иргэний өв залгамжлагч оролцвол зохих жиллагаанд өв залгамжлагч нь уг өвийг хүлээж ваагүй байвал өвлегдэх эд хөрөнгийг эрхлэн амгаалагчаар томилогдсон этгээд түүнийг өлөөлөн оролцоно.

26.4.Энэ хуулийн 26.1-д заасан иргэний эцэг, х, асран хамгаалагч, харгалзан дэмжигч шийдвэр үйцэтгэх ажиллагаанд өөрийн сонгон авсан өлөөлөгчийг оролцуулж болно.

27 дугаар зүйл. Төлөөлөгчийн бүрэн эрх

27.1.Төлөөлөгчийн бүрэн эрхийг өлөөлүүлэгчээс бичгээр олгосон итгэмжлэл, эрх олгосон бусад баримт бичгээр тодорхойлно.

27.2.Итгэмжлэл Иргэний хуулийн 56.2-т заасан шаардлагыг хангасан байна.

27.3. Итгэмжлэлд талуудын эдлэх эрхийн варимыг төлөөлөгчид эдлүүлэхгүй байхаар заааж болно.

27.4.Төлөөлөгч энэ хуулийн 27.3-т зааснаас бусад бүх ажиллагаанд төлөөлүүлэгчийн нэрийн эмнөөс оролцох бөгөөд түүний эрх, эрх чөлөө, суулиар хамгаалагдсан аливаа сонирхлыг хуулийн хүрээнд хамгаална.

27.5.Итгэмжлэлд төлөөлөгчийн дараахь бүрэн эрхийг заана:

27.5.1.гүйцэтгэх баримт бичиг буцааж авах;

27.5.2.эрхээ бусдад шилжүүлэх;

27.5.3.шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гомдол гаргах;

27.5.4.төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэхээр шийдвэрт заасан тодорхой зд хөрөнгө, бэлэн мөнгө авах.

28 дугаар зүйл. Төлөөлөгчөөр оролцож болохгүй этгээд

28.1.Дараахь этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцож болохгүй:

28.1.1.18 насанд хүрээгүй /хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд/;

28.1.2.иргэний эрх зүйн чадамжгүй;

28.1.3.өөрөө иргэнийхээ хувьд, түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу өөрийн ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч;

28.1.4.ялгүйд тооцогдоогүй этгээд.

29 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд орчуулагч,хэлмэрч оролцох

29.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч монгол хэл мэддэггүй, хэлгүй, дүлий бол орчуулагч, хэлмэрч авч болно.

29.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхийг хориглоно.

29.3.Орчуулагч, хэлмэрч нь иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн, хэлмэрчлэх, орчуулга хийхэд зайлшгүй шаардлагатай хэлний болон тусгай мэдлэг зээмшсэн хүн байна.

29.4.Энэ хуулийн 29.1-д заасан этгээдэд орчуулагч, хэлмэрч авах хугацаа тогтоож, хэрэв энэ хугацаанд уг этгээд орчуулагч, хэлмэрч аваагүй бол шийдвэр гүйцэтгэгч орчуулагч, хэлмэрчийг томилж болно.

29.5.Орчуулагч, хэлмэрч тухайн этгээдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцыг үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх, шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх үүрэгтэй.

29.6.Орчуулагч, хэлмэрчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг орчуулуулсан, хэлмэрчлүүлсэн этгээд төлнө.

29.7.Санаатайгаар буруу орчуулах буюу хэлмэрчилбэл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээхийг орчуулагч, хэлмэрчид урьдчилан сануулна.

30 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгийн гэрч оролцох

30.1.Төлбөр төлөгчийн орон байр, зд хөрөнгө

байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хөндлөнгийн хөрөөс доошгүй гэрчийн оролцоотой явуулна.

30.2.Бусад тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч өөрийн үзэмжээр хөндлөнгийн гэрчийг оролцуулж болно.

30.3.Хөндлөнгийн гэрчээр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар хувийн сонирхолгүй, түүнчлэн өөр хоорондоо болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогчтой төрөл, садангийн, эсхүл захирах захирагдах ёсны холбоогүй хүнийг оролцуулж болно.

30.4.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлэхийн өмнө шийдвэр гүйцэтгэгч хөндлөнгийн гэрчид түүний эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

30.5.Хөндлөнгийн гэрч ямар ажиллагаанд оролцох гэж байгаагаа, ямар баримт бичгийг үндэслэж уг ажиллагаа явагдаж байгаа тухай мэдэх, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар саналаа гаргах эрхтэй.

30.6.Хөндлөнгийн гэрчээс гаргасан саналыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд тусгана. Хөндлөнгийн гэрч хүсвэл саналаа бичгээр гарган өгч болно.

30.7.Хөндлөнгийн гэрч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд өөрийнхөө оролцсон ажиллагааны үйл баримт, явц, агуулга, түүний үр дүнгийн талаар бичих, эсхүл танилцан тухайгаа баталгаажуулан гарын үсэг зурах үүрэгтэй.

31 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох

31.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн туслэг мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулахаар шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл оролцогч талын хүсэлтээр шинжээч оролцуулж болно.

31.2.Шинжээч нь мэргэжлийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил зэзмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байна.

31.3.Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс бичгээр дүгнэлт гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна.

31.4.Энэ хуулийн 31.3-т заасан дүгнэлтэ ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарса дүгнэлт, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан асуулта өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ.

31.5.Шаардлагатай тохиолдолд шийдвэ гүйцэтгэгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томил болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэ дүгнэлт, санал нийлэхгүй байвал тус тусдаа дүгнэл гаргаж гарын үсэг зурна.

31.6.Шинжээч шийдвэр гүйцэтгэгчий дуудсанаар хүрэлцэн ирэх, тухайн асуудлаар үнэ зөв дүгнэлт гаргах, гүйцэтгэсэн ажлынхаа талаа тайлбар өгөх үүрэгтэй.

31.7.Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын хөлсий шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас гаргана

31.8.Дүгнэлт өгөхөөс татгалзах, зайлсхийх эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргасан бо Захиргааны хариуцлагын тухай[5] болон Эрүүгий хуулийн[6] дагуу хариуцлага хүлээлгэхий шинжээчид урьдчилан сануулна.

32 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгч ба цагдаагийн байгууллагын харилцан ажиллагаа

32.1. Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, олж тогтооход өөрт байгаа мэдээлэл өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаат явуулахад саад учруулж байгаа, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн амь бие эрүүл мэндэд заналхийлсэн бол цагдаагий байгууллага туслалцаа үзүүлж болно.

33 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэ ажиллагаанаас татгалзан гарах

33.1.Шийдвэр гүйцэтгэгч дараахь үндэслэ байвал шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас өөрөө татгалзан гарах үүрэгтэй:

33.1.1.урьд нь уг хэргийг шалгаг шийдвэрлэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцсон;

33.1.2.төлбөр авагч, төлбөр төлөгч, эсхүл тэдний төлөөлөгчийн хэн нэгэнтэй төрөл, садангийн холбоотой байвал;

[5] Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

[6] Монгол Улсын Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

33.1.3.шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг ажиллагааны үр дүнд хувийн сонирхолтой, ударгаар үүргээ гүйцэтгэх талаар үндэслэл бүхий ргэлзээ байвал.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан үндэслэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож буй рчуулагч, хэлмэрч, үл хөдлөх эд хөрөнгийн лбадан дуудлага худалдааны эрхлэн өтлөгч,тэмдэглэл хөтлөгчид нэгэн адил хамаарна.

33.3.Энэ хуулийн 33.1-д зааснаас бусад ндэслэлээр шийдвэр гүйцэтгэгч нь татагдан гарч гл болно.

33.4.Шинжээч энэ хуулийн 33.1-д зааснаас адна дараахь тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцохыг хоригдоно:

33.4.1.албан тушаалын буюу бусад байдлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч шинжээчид нөлөөлж болох байвал;

33.4.2.урьд нь хийсэн шинжилгээ, гүүний үндсэн дээр гарсан дүгнэлт уг ажиллагааны ндэс болсон байвал.

33.5.Энэ хуулийн 33.1-д заасан татагдан гарах үндэслэл байвал шийдвэр гүйцэтгэгч, рчуулагч, хэлмэрч, шинжээч, үл хөдлөх эд өрөнгийн албадан дуудлага худалдааны эрхлэн хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч энэ тухайгаа шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлэхээс өмнө, хэрэв уг үндэслэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэж татагдан гарах үүргэтэй.

33.6.Энэ хуулийн 33.1,33.4-т заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийг татагдан гарах хүсэлтийг хөтлөгчийг татагдан гарах асуудлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, тэмдэглэл хөтлөгчийг татагдан гаргах асуудлыг шийдвэр гүйцэтгэгч тус тус шийдвэрлэнэ.

33.7.Шийдвэр гүйцэтгэгч, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийг татагдан гаргах асуудлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, тэмдэглэл хөтлөгчийг татагдан гаргах асуудлыг шийдвэр гүйцэтгэгч тус тус шийдвэрлэнэ.

33.8.Шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан тохиолдолд түүний гүйцэтгэхээр авсан гүйцэтгэх баримт бичгийг ахлах шийдвэр гүйцэтгэгч өөр шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

33.9.Шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргахыг зөвшөөрөхгүй тухай ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргасан бол энэхүү тогтоолын талаар 3 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

ДӨРӨВДУГЭЭР БҮЛЭГ

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах үйл ажиллагаа

34 дүгээр зүйл.Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа

34.1.Шийдвэр гүйцэтгэгч дараахь үйл ажиллагаа явуулж болно:

34.1.1.төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах,төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах /цаашид "барьцаалах" гэх/, хураах, худалдан борлуулах;

34.1.2.төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, уг мэдүүлгийг албадан өгүүлэх зорилгоор түр саатуулахаар шүүхэд хандах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;

34.1.3.төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

34.1.4.төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах;

34.1.5.шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх;

34.1.6.хуульд заасан бусад үйл ажиллагаа.

34.2.Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн бол уг эд хөрөнгө хэний эзэмшилд шилжсэнийг үл харгалзан түүнээс төлбөр гаргуулна.

34.3.Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэрлэж тогтоол гаргана. Энэ тогтоолыг зөвшөөрөхгүй бол гомдлоо шүүхэд гаргаж болно.

34.4.Энэ хуулийн 34.3-т заасан гомдлыг хянах ажиллагаа эвэхэн төлберт гаргуулсан эд хөрөнгийн үнэлгээ хэмжээ, эсхүл гуравдахь этгээдийн эрх хөндөгдсөн асуудлаар хязгаарлагдана.

35 дугаар зүйл. Үзлэг, нэгжлэг хийх

35.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор өөрт нь болон бусдын зээмшилд байгаа түүний өмчлөлийн эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийнэ.

35.2.Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, битүүмжлэх, барьцаалах, хураах явцад түүний биедээ буюу ямар нэг газар, эсхүл бусад этгээдэд нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор биед болон тухайн эд хөрөнгийг нуусан газарт нэгжлэг хийж болно.

35.3.Төлбөр төлөгчийн биед болон эд хөрөнгөд нэгжлэг хийх үед бэлэн мөнгө олдсон бол төлбөрийн хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авна.

35.4.Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг явуулахад энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

35.5.Энэ хуулийн 35.4-т заасан ажиллагааг явуулахад төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын ажилтныг байлцуулна.

35.6.Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн төлөөлөгчийг байлцуулна.

35.7.Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх үйл ажиллагааг явуулахдаа энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу тэмдэглэл хөтөлнө.

36 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах

36.1.Дараахь үндэслэлээр төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх буюу барьцаална:

36.1.1.эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл худалдан борлуулах, эд хөрөнгийг хамгаалах;

36.1.2.төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх;

36.1.3.төлбөр төлөгчийн болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг хураах тухай шийдвэрийг гүйцэтгэх.

36.2.Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах шийдвэрийг эд хөрөнгийн жагсаалт гарган данслах, шийдвэр гүйцэтгэгч хувийн дугаартай тэмдэг дарж уг эд хөрөнгийг хамгаалалтандаа авах, эсхүл авахгүйгээр тухайн эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглох, шаардлагатай бол эд хөрөнгийг ашиглах эрхийг хязгаарлах зэргээр гүйцэтгэнэ. Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгө ашиглах эрхийг хязгаарлах хугацааг тогтоосон шийдвэр гаргана.

36.3.Энэ хуулийн 36.2-т заасан эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг ашиглах эрхийг хязгаарлах тухай шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг төлбөр төлөгч зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

36.4.Битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авах хугацааг шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

36.5.Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг хураан авна.

36.6.Тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн бол шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг битүүмжилсэн, барьцаалсан шийдвэрээ хүчингүй болгоно.

36.7.Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалахын хамт тухайн эд хөрөнгө болон түүний зарим бүрдэл хэсгийг хураан авч болно.

36.8.Гадаад валют, Монгол Улсын мөнгөн тэмдэгт, үнэт металл, эрдэнийн чулуу,тэдгээрээр хийсэн гоёл чимэглэл, түүх, соёлын хосгүй болон бусад үнэт дурсгалт зүйлийг заавал хураан авна.

36.9.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг энэ хуулийн 59 дүгээр зүйлд заасан дараалаар битүүмжлэх буюу барьцаална.

37 дугаар зүйл.Эд хөрөнгө үнэлэх

37.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийнханшаар үнэлж, энэ тухай оролцогч талуудад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлнө.

37.2.Дараахь тохиолдолд эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ:

37.2.1.эдийн бус хөрөнгө;

37.2.2.үл хөдлөх эд хөрөнгө;

37.2.3.үнэт зүйл;

37.2.4.тухайн эд хөрөнгийг үнэлэхэд үндрэл учирсан бол;

37.2.5.шийдвэр гүйцэтгэгчээс огтоосон үнэлгээг төлбөр төлөгч зөвшөөрөхгүй айгаа.

37.3.Төлбөр төлөгч, төлбөр авагч эд өрөнгийн үнэлгээний талаархи гомдлоо үнэлгээ огтоосон өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд аргаж болно.

38 дугаар зүйл.Эд хөрөнгө хадгалах

38.1.Шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, арьцаалсан эд хөрөнгийг төлбөр төлөгч болон усад этгээдэд хадгалуулж болно.

38.2.Хадгалагч эд хөрөнгийг хадгалж, түүний үрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

38.3.Хадгалагч нь төлбөр төлөгч буюу түүний эр бүлийн гишүүн биш бол хадгалсны хөлсийг охиролцсоны дагуу авна.

38.4.Мал, гэрийн тэжээвэр амьтан болон усад эд хөрөнгө хадгалуулсны хөлсийг тэдгээрийг адгалахад зарцуулсан зардлыг тооцож, тухайн эд өрөнгөнөөс бий болсон үр шимийг хасч олгоно.

38.5.Хадгалагч хадгалуулагчийн өвшөөрөлгүйгээр хадгалуулсан эд хөрөнгийг уравдагч этгээдэд шилжүүлсэн, сольсон, рэгдүүлсэн, нуусан, эд хөрөнгийн хэвийн байдлыг өөрчилсөн бол учирсан хохирлыг бүрэн хариуцна.

38.6.Төлбөр төлөгчөөс хураасан үнэт зүйл, нэт металл,эрдэнийн чулуу, гадаад валютыг анкинд хадгалуулна.

39 дүгээр зүйл. Эд хөрөнгө худалдан борлуулах

39.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 39.5-д зааснаас бусад эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг түүнийг хураан авснаас хойш 2 сарын дотор гүйцэтгэнэ.

39.2.Хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг нэн даруй худалдана.

39.3.Хураагдсан хөдлөх эд хөрөнгийг үнэ хаялцуулах албадан дуудлага худалдаагаар, үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуульд заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар тус тус худалдан борлуулна.

39.4.Үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааг Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд заасан журмаар явуулна.

39.5.Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйлс, химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрлөөр олж авах зүйлийг шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад худалдах буюу шилжүүлнэ.

39.6.Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдлоо гаргана.

39.7.Энэ хуулийн 39.1-д заасан хугацаанд худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид мэдэгдэн үнэ хямдруулан худалдаж болно. Үнэ хямдруулан худалдан борлуулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

39.8.Энэ хуулийн 39.7-д заасны дагуу худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг хасаж төлбөртөө тооцон авахыг санал болгоно. Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид тус тус буцаана.

39.9.Энэ зүйлд заасны дагуу худалдан борлуулсан эд хөрөнгийн гэмтэл, согогтой холбогдон гарсан гомдлыг хүлээн авахгүй.

39.10.Үнэт цаас худалдах журмыг хуулиар тогтооно.

39.11.Индоссанментээр шилжүүлэгдэж болох вексель буюу бусад төлбөрийн хэрэгслийг худалдах ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч уг төлбөрийн хэрэгсэлийг эзэмшилдээ авснаар гүйцэтгэгдэнэ.

40 дүгээр зүйл. Эд хөрөнгийн тухай мэдүүлэг

40.1.Шийдвэр гүйцэтгэгч санаачилгаараа буюу төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн дараахь тохиолдолд төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлгийг авна:

40.1.1.төлбөр төлөгч хөрөнгөгүй нь тогтоогдсон, эсхүл байгаа эд хөрөнгө нь төлбөр төлж хүрэлцэхгүй бол;

40.1.2.төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө бусдын эзэмшилд байгаа, эсхүл ирээдүйд буй болох бусад эд хөрөнгийн тухай;

40.1.3.төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй.

40.2.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах хугацааг товлож,

энэ тухай төлбөр төлөгч, төлбөр авагчид мэдэгдэнэ. Төлбөр авагч ирэгүй нь уг мэдүүлгийг авахад саад болохгүй.

40.3.Төлбөр авагчийн шаардлагыг 6 сарын дотор хангаж чадахаа төлбөр төлөгч нотолсон бөгөөд төлбөр авагч төлбөрийг хэсэгчлэн төлүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч уг мэдүүлэг авах ажиллагааг дээр дурдсан хугацаагаар хойшлуулж, эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах едрийг товлон тогтооно.

40.4.Эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахаар товлосон едөр төлбөр төлөгч төлбөрийн дөрөвний гурвыг төлсөн байвал төлбөр төлөгчийн хүсэлтээр энэ хуулийн 40.3-т заасан хугацааг шийдвэр гүйцэтгэгч дахин 2 сараар сунгаж болно.

40.5.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 40.1-д заасан мэдүүлгийг үндэслэн төлбөр төлөгчийг өртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлж, төлбөр авагчид хуулбарыг хүргүүлнэ.

40.6. Өртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлснээс хойш төлбөр төлөгч эд хөрөнгөтэй болсон, эсхүл көдөлмөрийн харилцаа нь өөрчлөгдсөн бол төлбөр авагчийн хүсэлтээр эд хөрөнгийн тухай дахин мэдүүлэг өгнө.

41 дүгээр зүйл. Түр саатуулах шийдвэр, түүнийг гүйцэтгэх

41.1.Төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эд хөрөнгө нуусан, төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд шүүх түр саатуулах шийдвэр гаргана.

41.2.Түр саатуулах хугацаа 3 сараас хэтрэхгүй байна.

41.3.Түр саатуулах жүрмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

/Энэ зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хуулийн энэ зүйл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно/.

42 дугаар зүйл. Өртэй этгээдийн бүртгэл

42.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь улсын, шийдвэр гүйцэтгэх алба нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд шүүхийн шийдвэрий биелүүлээгүй этгээдийн талаархи мэдээллий цахим тоолуурт оруулж, өртэй этгээдийн бүртгэ хөтлөнө.

42.2.Өртэй этгээдийн бүртгэл хөтлө журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгий газрын гишүүн тогтооно.

42.3.Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэ едрөөс хойш 7 хоногийн дараа тухайн этгээдий талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээ мэдээлнэ.

42.4.Энэ хуулийн 42.1-д заасан байгууллага өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээдий талаархи мэдээллийг дараахь тохиолдолд бүсда өгч болно:

42.4.1.шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх;

42.4.2.санхүү, эдийн засгийн хувьд найдвартай эсэхийг шалгуулах;

42.4.3.зээл өгөх, авах гэж байгаа;

42.4.4.эрүүгийн гэмт хэрэг илрүүлэх.

42.5. Энэ хуулийн 42.1-д заасан байгууллага дараахь үндэслэлээр өртэй этгээдийн бүртгэлээс хасна:

42.5.1.эд хөрөнгийн тухай мэдүүлгээ өгсөн;

42.5.2. түр саатуулагдснаас хойш 3 жил өнгөрсөн бол;

42.5.3.төлбөр авагчийн шаардлага хангагдаж,энэ хуулийн 82.1-д заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлсөн бол.

42.6.Шүүх, эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр тогтоосон төлбөрийг төлөөгүй бол өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, түүнээс мэдээлэл авахтай холбогдсон гомдлыг шүүх авч хэлэлцэхгүй.

42.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар энэ хуулийн 42.1-д заасан өртэй этгээдийн бүртгэлд,бүртгэгдсэн төрийн захиргааны албан хаагч уг албанд болон сонгуульд нэр дэвшигчийн талаар Төрийн захиргааны албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус мэдэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ
Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа

43 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа

43.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа /цаашид "албадан дуудлага худалдаа" гэх/-г шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө байгаа аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба зохион

:айгуулна.

43.2. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан
:дуулага худалдааг Иргэний хууль болон энэ
:хуульд заасан журмаар явуулна.

43.3.Шийдвэр гүйцэтгэгч албадан дуудлага
:худалдаа явуулах тухай ахлах шийдвэр
гүйцэтгэгчийн тогтоолыг Үл хөдлөх эд хөрөнгийн
бүртгэлийн газарт болон төлбөр төлөгчид хүргүүлнэ.

43.4.Үл хөдлөх эд хөрөнгөөс салгаж үл
болох бүрдэл хэсэг, эсхүл бусдын өмчлөлд
шилжээгүй иргэний эд хөдлөх эд хөрөнгөтэй хамт байгаа
хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгөтэй хамт
албадан дуудлага худалдаагаар худалдана.

43.5.Албадан дуудлага худалдааг эрхлэн
хөтлөгчийг аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх
албанаас томилно.

43.6.Албадан дуудлага худалдааг эрхлэн
хөтлөгч энэ чиглэлээр мэргэшсэн хүн байна.

44 дүгээр зүйл. Албадан дуудлага худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшлуулах, төлбөр авагч өргөдлөө буцаах

44.1.Төлбөр авагч төлбөр төлөгчийн хувийн болон санхүүгийн байдал, эсхүл гэм буруутай эсэхийг харгалзан, албадан дуудлага худалдааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулахыг зөвшөөрсөн өргөдлөө ахлах шийдвэр гүйцэтгэчид гаргаж болно.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан хугацаа өнгөрсний дараа төлбөр авагч албадан дуудлага худалдааг үргэлжлүүлэн явуулах тухай өргөдөл гаргагүй, эсхүл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай өргөдөл гаргасан тохиолдолд албадан дуудлага худалдааг явуулахгүй.

44.3.Энэ хуулийн 44.2-т заасан тохиолдолд албадан дуудлага худалдаа явуулах тухай тэмдэглэлийг хасуулах хүсэлтийг төлбөр авагч Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт гаргана.

44.4.Албадан дуудлага худалдааг энэ хуулийн 44.2-т заасны дагуу төлбөр авагчийн хүсэлтээр явуулагүй бол өргөдөл болон гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана.

45 дугаар зүйл. Албадан дуудлага худалдаа явуулах хугацаа

45.1.Албадан дуудлага худалдааг битүүмжилж, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийг хураан авсны дараа явуулна.

45.2.Албадан дуудлага худалдаа явуулах шийдвэр гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 45.1-д заасан худалдааг явуулна.

46 дугаар зүйл.Албадан дуудлага худалдаа явуулах шийдвэрийн агуулга

46.1.Албадан дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон ахлах шийдвэр гүйцэтгэчийн тогтоолд дараахь зүйлийг заана:

46.1.1.үл хөдлөх эд хөрөнгийн нэр, хэмжээ, зориулалт, байршил болон анхны үнэ, өмчлөгчийн тухай;

46.1.2.албадан дуудлага худалдаа явуулах огноо, цаг, хаяг;

46.1.3.уг дуудлага худалдаа нь албадан дуудлага худалдаа гэсэн тодотгол;

46.1.4.үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;

46.1.5.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

47 дугаар зүйл.Албадан дуудлага худалдааг нийтэд мэдээлэх,албадан дуудлага худалдааны оролцогч, албадан дуудлага худалдааны дэнчин

47.1.Албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч уг худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ тухай нийтэд мэдээлнэ.

47.2.Албадан дуудлага худалдаанд төлбөр төлөгч, төлбөр авагчаас гадна дараахь этгээд оролцож болно:

47.2.1.албадан дуудлага худалдаа эхлэх үед бүртгэгдсэн этгээд;

47.2.2.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд бие даасан шаардлага гаргах эрхтэй өмчлөгч, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэх эрхтэй бөгөөд түүнийгээ нотлож чадах гуравдагч этгээд;

47.2.3.бусад этгээд.

47.3.Албадан дуудлага худалдаанд оролцогч урьдчилан тогтоосон хугацаа, хэмжээ, журмын дагуу дэнчин төлнө. Дэнчин төлсөн тохиолдолд албадан дуудлага худалдаанд оролцуулна.

47.4.Албадан дуудлага худалдаа явуулах тухай хүсэлт гаргасан этгээдийг хүндэтгэн үзэх шалтгаанаар дэнчин төлөхөөс чөлөөлж болно.

48 дугаар зүйл. Албадан дуудлага худалдаа зохион байгуулах

48.1.Албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч албадан дуудлага худалдаа явуулахаар өргөдөл гаргасан төлбөр авагчийн нэр, төлбөрийн хэмжээ, үл хөдлөх эд хөрөнгийн танилцуулга, түүнийг битүүмжилсэн, барьцаалсан, хураасан огноо, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг танилцуулна.

48.2.Анхны санал гарснаар албадан дуудлага худалдааг эхэлсэнд тооцно.

48.3.Сүүлийн үнэ хэлэхийг зарлана. Сүүлийн үнэ хэлэхийг зарласан үе, сүүлийн үнийн санал хоёрын хооронд 30 минут байна. Тухайн үнийн саналыг албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч хүлээж авааруй бол саналыг хүчингүйд тооцно.

48.4.Албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч нь сүүлийн үнэ зарлаж 3 удаа дуудсаны дараа албадан дуудлага худалдаа дуусгавар болно.

48.5.Үл хөдлөх эд хөрөнгө борлогдсон бол төлбөрийн шаардлагыг хангах хэмжээний мөнгө болон албадан дуудлага худалдааны зардыг тооцон авч шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд оруулна.

48.6.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үеийн үнийг тогтоох, бууруулах, албадан дуудлага худалдааг зохион байгуулахдаа Иргэний хуулийн 175,177 дугаар зүйлийг баримтална.

48.7.Албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй үл хөдлөх эд хөрөнгийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг хасаж төлбөртөө тооцон авахыг төлбөр авагчид санал болгоно. Төлбөр авагч татгалзвал үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид тус тус буцаана.

48.8. Албадан дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсэн эсэх тухай албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгчийн шийдвэрийг тухайн албадан дуудлага худалдааны үед, эсхүл товлон тогтоосон өөр хугацаанд танилцуулна.Энэ хугацаань 2 долоо хоногоос хэтрэхгүй байна.

48.9. Энэ хуулийн 48.8-д заасан шийдвэрт үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн авагчийн тухай, үнийн санал, дуудлага худалдааны болзол зэргийг тусгасан байна. Өмчлөх эрх шилжүүлэх тухай шийдвэр нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийг орон байрнаас нүүлгэн гаргуулах ажиллагааны үндэс болно.

48.10.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй бол худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.

48.11.Үл хөдлөх эд хөрөнгөтэй хамт албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдсон эд зүйлс худалдан авагчийн өмчлөлд нэгэн адил шилжинэ.

48.12.Төлбөр төлөгчийн шаардлагыг хангаж, өмчлөх эрх шилжүүлсний дараа худалдан авагч Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт өмчлөгчийн хувиар бүртгүүлэх эрх эдэлнэ.

48.13.Албадан дуудлага худалдааны явцын талаар тэмдэглэл хөтлөж, албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч болон тэмдэглэл хөтлөгч, шийдвэр гүйцэтгэгч гарын үсэг зурна. Албадан дуудлага худалдааны ролцогч тэмдэглэлтэй танилцаж санал гаргах эрх эдэлнэ.

49 дүгээр зүйл.Албадан дуудлага худалдааны орлого хуваарилах

49.1.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсний дараа албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч орлого хуваарилах өдөр, цагийг товлож төлбөр авагч, төлбөр төлөгч болон ипотекийн эрхтэй этгээдэд мэдэгдэнэ.

49.2.Товлосон өдреес өмнө албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч энэ хуулийн 49.1-д заасан этгээдээс авлагын тооцоо гаргаж өгэхийг шаардаж болно.

49.3.Орлогыг дараахь дараалаар хуваарилна:

49.3.1.албадан дуудлага худалдаа явуулсан зардал;

49.3.2.өмчлөх эрх шилжих хүртэл эрхлэн хамгаалагч үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалсан, засварласан зардал;

49.3.3.тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох тогтмол төлөгдөх төлбөр;

49.3.4.ипотекийн эрхтэй этгээдэд төлөх төлбөр.

49.4.Тогтмол төлөгдөх төлбөрт зээлийн хүү, захиргааны зардлыг оруулан тооцно.

49.5.Энэ хуулийн 49.3-т заасан зардлыг гаргуулсны дараа уг орлогоос төлбөр авагчийн шаардлагыг хангана.

49.6.Гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангасны дараа үлдсэн орлогыг төлбөр төлөгчид олгоно.

50 дугаар зүйл. Төлбөр авагчийн

шаардлагыг хангах дараалал

50.1.Албадан дуудлага худалдаагаар удалдан борлогдсон үл хөдлөх эд хөрөнгө нь хэд эдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг ангахад хүрэлцэхгүй бол энэ хуулийн 77 дугаар үйлд заасан жүрмыг баримтална.

51 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны талаар гомдол гаргах

51.1.Албадан дуудлага худалдааны зөвхөн үнэлгээтэй холбогдсон гомдлыг дуудлага худалдаа явуулснаас хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.

52 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлэх

52.1.Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар уг үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлэхээр шийдвэрлэж болно.

52.2.Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлснээр түүнийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардлаас их байх тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 52.1-д заасан шийдвэрийг гаргана.

52.3.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 52.1-д заасан шийдвэрийг гаргахын өмнө үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлснээр эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болох, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн бүх этгээдэд мэдэгдэж саналыг нь авна.

52.4.Төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлсэн барилга буюу түүний тодорхой хэсэгт төлбөр төлөгч өөрөө оршин суудаг бол орон сууц ашигласны хөлсийг тухайн үеийн ханшаар төлбөр авагчид төлөх үүрэгтэй.

52.5.Төлбөр авагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшиж, ашигласнаас бий болох үр шимийг авч, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдон гарах бүх зардлыг төлнө.

52.6.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн шаардлагыг бүрэн хангасан, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлснээр төлбөрийн шаардлагыг хангах боломжгүй болох нь илт болсон бол энэ хуулийн 52.1-д заасан шийдвэрээ хүчингүй болгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах онцлог

53 дугаар зүйл. Төлбөр төлөгч-иргэний мөнгөн болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

53.1.Төлберийг төлбөр төлөгч-иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох түүний банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс гаргуулна.

53.2.Төлбөр төлөгч ямар эд хөрөнгөө төлберт өгөх тухай хүсэлтээ тавих эрх эдэлнэ. Шийдвэр гүйцэтгэхэд саад болохгүй бол энэ хүсэлтийг харгалзан үзэж болно.

53.3.Гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс төлберийг гаргуулна.

53.4.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг зохих банк, банкны бус санхүүгийн байгууллагад хүргүүлэх бөгөөд түүнийг үндэслэн тухайн банк, банкны бус санхүүгийн байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлберийг гаргаж 3 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ. Нэхэмжлэлийн шаардлага хангах хэмжээний мөнгөн хөрөнгө төлбөр төлөгчийн хадгаламжийн болон харилцах дансанд байхгүйн улмаас мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй талаар мэдэгдэнэ.

53.5.Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлого нь банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд ордог бол энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан орлогыг хасаж төлбөрийг шилжүүлнэ.

53.6.Энэ хуулийн 53.1-д заасан эд хөрөнгө байхгүй, эсхүл төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн өмчлөлийн бусад эд хөрөнгөөс

төлбөрийг гаргуулна.

53.7.Энэ хуулийн 53.3, 53.6-д заасан эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулна.

53.8.Өвлөгч өвлүүлсэн эд хөрөнгийг хүлээн авсны дараа өртэйгээ холбогдсон төлбөрийг уг эд хөрөнгөөс гаргуулж болно.

53.9.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө, мөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

53.10.Төлбөр төлөгчийн өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

53.11.Төлбөр төлөгчийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, бэлэн мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөрийг гаргуулж болно.

54 дүгээр зүйл. Барьцаалагдсан эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

54.1.Төлбөр төлөгчийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний өмчлөлийн бусдад барьцаалсан эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

54.2.Энэ хуулийн 54.1-д заасан барьцаалагч тэргүүн ээлжинд хохирлоо арилгуулах эрх эдэлнэ. Барьцаалагч бусад үүрэг гүйцэтгүүлэгчдийн төлбөрийг барагдуулах үүрэг хүлээнэ.

55 дугаар зүйл. Төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө

55.1.Төлбөр төлөгч-иргэний зайлшгүй хэрэгцээт дараахь эд хөрөнгийг төлбөрт хураан авч болохгүй:

55.1.1.зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, гал тогооны хэрэгсэл;

55.1.2.төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улиралд бүрийн нэг ээлжийн хувцас;

55.1.3.хүйтний улиралд хэрэглэх түлээ, түлш;

55.1.4.мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг бол амьжиргааны наад захын хэрэгцээг хангах тооны мал, тариалах үр;

55.1.5.төлбөр төлөгч-иргэн мэргэжлийнхээ ажил, үйлдвэрлэл явуулахад зайлшгүй шаардагдах эд юмс.

55.2.Энэ хуулийн 55.1.5-д заасан эд юмсын үнэ нь гүйцэтгэх баримт бичигт дурдсан төлбөрийн хэмжээнээс өндөр байвал уг эд юмсыг орлуулах үнэ хямд зүйлээр сольж болно.

56 дугаар зүйл. Төлбөр гаргуулж болохгүй орлого

56.1.Төлбөр төлөгч иргэний дараахь орлогоос төлбөр гаргуулж болохгүй:

56.1.1.байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж буй тусламж, хандив;

56.1.2.илүү цагийн хөлс, нэг удаагийн урамшил, ажлаас халагдсаны тэтгэмж;

56.1.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,тэтгэмжийн тухай хуулийн[7] дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж;

56.1.4.донор болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговрын мөнгө;

56.1.5.нэмэгдэл хоол, амралт, сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд зориулан олгосон зардал;

56.1.6.тахир дутуугийн тэтгэвэр;

56.1.7.хүүхдийн тэтгэлгийн мөнгө.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах онцлог

57 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах

57.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь

[7] *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.*

:адгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч тухайн банк, банкны бус санхүүгийн байгууллагад хүргүүлэх бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гарган, 3 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ. Энэхэмжлэлийн шаардлага хангах хэмжээний мөнгөн хөрөнгө төлбөр төлөгчийн дансанд байхгүйн улмаас мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй гэлаар мэдэгдэнэ.

57.2.Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэмж тусгахыг шаардана.

57.3.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх явцад бэлнээр хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө илэрвэл түүнийг хураан авна.

57.4.Төлбөрт гаргуулсан бэлэн мөнгийг тэр өдөрт нь төлбөрийн шаардлагын хэмжээгээр, шийдвэр гүйцэтгэх ажилтарааны зардлыг тооцон авч төлбөр авагчид шилжүүлнэ.

57.5.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бэлнээр хадгалагдаж байгаа буюу банк, банкны бус санхүүгийн байгууллагад дансанд байгаа мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан журмаар битүүмжлэх арга хэмжээ авч болно.

57.6.Төлбөр төлөгч нь банк байх тохиолдолд тухайн арилжааны банкны Монголбанк дахь харилцах данснаас хасалт хийх буюу төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.

58 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

58.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс хассан буюу гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад эд хөрөнгөөс төлбөрийг гаргуулна. Энэ тохиолдолд тухайн эд хөрөнгө хаана, юунд ашиглагдаж байгаа нь үл хамаарна.

59 дүгээр зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүмжлэх дараалал

59.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг дараахь дараалаар битүүмжилнэ:

59.1.1.үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй эд хөрөнгө /үнэт цаас, хуулийн этгээдийн хадгаламжинд буюу бусад тооцооны бүй мөнгөн хөрөнгө, валют болон түүнтэй адилтгах бусад хөрөнгө/;

59.1.2.бэлэн бүтээгдэхүүн, бусад материал, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй материал;

59.1.3.үл хөдлөх эд хөрөнгө, түүхий эд материал, үйлдвэрлэлийн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэг материал;

59.1.5.тусгай зөвшөөрөл.

60 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах

60.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн мөнгөн болон бусад эд хөрөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

60.2.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.

61 дүгээр зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх

61.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу битүүмжилснээс хойш 3 хоногийн дотор үүг байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн тухай мэдэгдлийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт хүргүүлнэ.

61.2.Мэдэгдэлд уг үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, тоо хэмжээ, байршил, төлбөр авагчийн шаардсан мөнгөн дүнгийн тухай мэдээг хавсаргана.

61.3.Мэдэгдлийн хуулбарыг татварын байгууллагад явуулна.

62 дугаар зүйл.Төлбөр төлөгч-хуулийн этгээд өөрчлөгдөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах журам

62.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний

хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

63 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах

63.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагаагүй нь зогсоох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

63.2.Татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль болон Дампуурлын тухай хуульд[1] заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ.

63.3.Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэн төлбөрийн чадвартай болсон болговч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигг шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос төлбөр гаргуулах

64 дүгээр зүйл. Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос төлбөр гаргуулах, суутгал тооцох

64.1.Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах бусад орлогоос дараахь тохиолдолд төлбөр гаргуулна:

64.1.1.тогтмол төлөгдөх төлбөрийг гаргуулах;

64.1.2.гүйцэтгэх баримт бичигт дурдсан төлбөр гаргуулах мөнгөний дүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй;

64.1.3.төлбөр төлөгч эд хөрөнгөгүй нь тогтоогдсон, эсхүл байгаа эд хөрөнгө төлбөрийг төлөхэд хүрэлцэхгүй.

64.2.Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэл болон татварт ногдох хэсгийг хассан үнийн дүнгээс тооцно.

64.3.Энэ хуулийн 64.1-д заасан орлогод ирээдүйд олгогдох цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлого нэгэн адил хамаарна.

64.4.Төлбөр төлөгч хэд хэдэн газраас цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах бусад орлого, эсхүл эд хөрөнгөөр хөлс авдаг бол тэдгээрийг нийлүүлэн тооцно.

64.5.Шүүх, эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр тогтоосон төлбөрийг төлөөгүй бол цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос төлбөр гаргуулах, суутгал хийхтэй холбогдсон гомдлыг шүүх авч хэлэлцэхгүй.

64.6.Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичигийн дагуу төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос гаргуулах төлбөрийн хэмжээ цалингийн 50 хувиас хэтэрч болохгүй.

65 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах журам

65.1.Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос гаргуулах төлбөрийн хувь хэмжээг төлбөр авагч болон төлбөр төлөгчийн төлбөрийн чадвар, бусад байдлыг харгалзан шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

65.2.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх мэдэгдлийг түүний ажиллаж байгаа буюу тэтгэвэр, тэтгэмж олгож байгаа иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хүргүүлнэ.

65.3.Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан шийдвэр гүйцэтгэчийн мэдэгдлийг хүлээн авмагц төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос сар тутам хийх суутгалын хувааръ гаргаж үүний дагуу суутгасан орлогыг суутгал хийсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор мэдэгдэл олгосон шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

[1] *Дампуурлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

65.4.Төлбөр төлөгч ажлаас халагдсан бол энэ хуулийн 65.2-т заасан мэдэгдэл хүлээн авагч 7 хоногийн дотор түүнээс төлбөрт суутгасан орлогын тооцоог гаргаж төлбөр төлөгч хаана ямар ажилд шилжсэнийг мэдэгдэлд тэмдэглэж шийдвэр гүйцэтгэгчид буцаана.

66 дугаар зүйл. Хүүхдийн тэтгэлгийг гаргуулах, хорих ял эдэлж байгаа төлбөр төлөгчийн хөдөлмөрийн хөлснөөс төлбөр гаргуулах

66.1.Хүүхдийн тэтгэлэг гаргуулах журмыг Гэр бүлийн тухай хуулиар[8] тогтооно.

66.2. Хорих ял эдэлж байгаа ялтны төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр ялтны ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд гүйцэтгэх баримт бичиг явуулна.

66.3. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан хорих ангийн захиргаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх

67 дугаар зүйл. Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх

67.1.Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх зэрэг тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг хариуцагч шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

67.2.Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэх тухай мэдэгдлийг хариуцагчид хүргүүлнэ.

67.3.Мэдэгдлийг хүлээн авсан хариуцагч урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгож, тухайн ажилтныг урьдах ажилд нь эгүүлэн тогтоосноор шийдвэр биелэгдсэнд тооцно.

67.4.Энэ хуулийн 67.2, 67.3-т заасан шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, хөдөлмөрийн хөлс буюу бага цалин, хөдөлмөрийн хөлстэй ажил хийж байсны зөрүүг шийдвэр гарсан өдрөөс түүнийг гүйцэтгэх өдөр хүртэл хугацаанд шийдвэр гүйцэтгэгчийн бүрүүтай албан тушаалтнаас албадан гаргуулах арга хэмжээ авна.

67.5.Хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөгдөн байгуулагдсаны улмаас энэ хуулийн 67.2-т заасан шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухайн баримт бичгийг шүүх болон түүнийг олгосон бусад байгууллагад буцаах тухай шийдвэр гаргаж ахлах шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

67.6.Энэ хуулийн 67.5-д зааснаас бусад ажилтны урьд ажилласан байсан ажлын байр, албан тушаал нь цомхотгогдсон бол ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндэсэн дээр урьдахь ажил, албан тушаалтай дүйцэх өөр ажил, албан тушаалд ажиллуулах үүрэгтэй.

67.7.Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

68 дугаар зүйл. Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах

68.1.Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг хариуцагч шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

68.2.Нүүлгэн гаргах гэдэгт гүйцэтгэх баримт бичигт заасан барилга, орон байрыг нүүн гарах этгээд, түүнтэй хамтран амьдарч байгаа гэр бүлийн гишүүн, тэдгээрийн эд хөрөнгө, гэрийн тэжээвэр амьтдаас чөлөөлж, нүүн гарсан этгээдэд чөлөөлөгдсөн барилга, орон байрыг ашиглахыг хориглох ажиллагаа хамаарна.

68.3.Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай хугацаатай мэдэгдлийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан нүүлгэх өдөр, цагийг тогтоосон мэдэгдлийг нүүн гарвал зохих этгээдэд өгөх ба тухайн этгээд байхгүй байгаа нь шийдвэрийг

[8] *Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.*

биелүүлэхэд саад болохгүй.

68.4.Нүүлгэн гаргах ажиллагааг нүүн гарч байгаа этгээд, хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан, шаардлагатай бол орон сууц ашиглалтын байгууллагын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэнэ.

68.5.Нүүн гарах этгээд албадан нүүлгэх мэдэгдэлд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барилга, орон байранд байхгүй байвал түүний эзгүйд эд хөрөнгийг нь битүүмжлэн, зохих этгээдэд хадгалуулахаар хүлээлгэн өгч, барилга, орон байрыг чөлөөлнө.

68.6.Жилийн аль ч улиралд албадан нүүлгэх ажиллагааг гүйцэтгэж болох бөгөөд энэ хуулийн 15.2.6-д заасан үндэслэлийн дагуу энэ ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болно.

68.7.Шийдвэр гүйцэтгэгч нүүлгэн гаргах шийдвэрийг биелүүлсэн тухай тэмдэглэл үйлдэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах, төлбөр авагчийн шаардлагыг хангах дараалал

69 дүгээр зүйл. Гүйцэтгэх баримт бичигт заасан эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх

69.1.Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс хураан авч, төлбөр авагчид шилжүүлж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

70 дугаар зүйл. Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах

70.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулан авсан /үүний дотор төлбөр төлөгчийн эд хөрөнгийг худалдан борлуулснаас бий болгосон/ мөнгөн хөрөнгөөс шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахад гарсан зардлыг эхний ээлжинд төлүүлж бусад мөнгөн хөрөнгийг төлбөр авагчид өгнө.

70.2.Гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангасны дараа үлдсэн мөнгөн хөрөнгийг төлбөр төлөгчид буцааж олгоно.

70.3.Үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах дарааллыг энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.

71 дүгээр зүйл.Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээдийн худалдан борлуулсан эд хөрөнгөтэй холбогдсон эрх

71.1.Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу худалдан борлуулсан эд хөрөнгөөс шаардлагаа хангуулахаар тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гомдлоо гаргана.

72 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгч бэлэн мөнгө хүлээн авах, олгох

72.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөрт бэлэн мөнгө хүлээн авах, түүнийг төлбөр авагчид олгохдоо энэ тухай баримтыг 2 хувь үйлдэж, үйлдсэн огноог бичиж, гарын үсэг зуруулан, төлбөр төлөгчид 1 хувийг өгч, 1 хувийг нь хувийн хэрэгт хавсаргана.

72.2.Бэлэн мөнгө хүлээн авах баримт нь нэгдсэн дугаартай, хэвлэмэл маягт байна.

72.3. Бэлэн мөнгө хүлээн авсан баримт нь ямар нэгэн засваргүй байна.

72.4.Шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цагийн, хөдөө орон нутагт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлнэ.

72.5.Гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлно.

73 дугаар зүйл. Гаргуулсан төлбөрийг олгох журам

73.1.Шийдвэр гүйцэтгэгч нь гаргуулсан төлбөрийг төлбөр авагч иргэн, хуулийн этгээдийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь дансанд бэлэн буюу бэлэн бусаар хийх ба дансны дугаар мэдэгдэхгүй бол уг мөнгийг шийдвэр гүйцэтгэх албаны дансанд оруулна.

73.2.Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөрт бэлнээр гаргуулсан мөнгийг хуулиар тогтоосон хугацааны дотор төлбөр авагчид бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд шилжүүлнэ. Хэрэв төлбөр авагч ирэхгүй буюу хадгаламжийн данс нь мэдэгдэхгүй бол бэлэн мөнгийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дараа шийдвэр гүйцэтгэх албаны дансанд оруулна.

73.3.Гадаадад оршин суугаа /оршин байгаа/ төлбөр авагчид төлбөрийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх албаны данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгох ба ийнхүү

шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран тогтооно.

74 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх албаны данснаас мөнгө олгох

74.1.Шийдвэр гүйцэтгэх албаны дансанд мөнгө шилжих ирсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчид мэдэгдэх, мөнгийг олгох ажиллагаат 14 хоногийн дотор гүйцэтгэх бөгөөд төлбөр авагчийн овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа /оршин байгаа/ хаяг тодорхойгүй бүюу буруу хаягаар шилжих ирсэн бол тодруулах ажиллагаа хийнэ.

74.2.Дансанд мөнгө шилжүүлэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог, эцгийн нэр, нэр, хаягийг үнэн зөв, тодорхой бичих үүрэгтэй ба хаягийг буруу бичсэнээс гарсан нэмэгдэл зардлыг бууруулах зэтээд хариуцна.

75 дугаар зүйл. Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгох

75.1.Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараахь журмаар олгоно:

75.1.1.тэтгэлэг төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийсэн иргэн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох буюу хадгаламжид нь шилжүүлэх;

75.1.2.шийдвэр гүйцэтгэх албаны дансанд орж ирсэн тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан тэтгэлэг авагчид бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан дансанд шилжүүлэх.

75.2.Хүүхдийн тэтгэлгийн мөнгөнд тооцон хариуцагчаас гаргуулан авсан эд хөрөнгийг энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу шилжүүлнэ.

76 дугаар зүйл. Төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэх талаар тохиролцох

76.1.Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй байгаа тохиолдолд төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэж болно.

77 дугаар зүйл. Хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг хангах дараалал

77.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй бол төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн олгоно.

77.2.Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжинд олгоно.

78 дугаар зүйл. Төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцох

78.1.Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгийг төлбөр авагчид хуульд заасан журмаар бүрэн олгосон бол төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцож, төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэсэн тухай, төлбөр авагчид зохих хөрөнгө, мөнгө, эрхийг шилжүүлсэн тухай бичиг бичигийг тус тус гардуулж, гүйцэтгэх баримт бичгийг хаана.

79 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх албаны дансанд мөнгө хадгалах

79.1.Төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс олгогдоогүй мөнгийг шийдвэр гүйцэтгэх албаны дансанд нийтэд зарласнаас хойш дараахь хугацаанд хадгална:

79.1.1.иргэнд олгох бол 3 жил;

79.1.2.хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил.

79.2.Шийдвэр гүйцэтгэх байгуллагын дансанд байгаа мөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хоригломо.

79.3.Энэ хуулийн 79.1-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд мөнгийг улсын төсвийн орлогод шилжүүлнэ.

79.4.Төлбөр авагчийн хаяг буюу дансны дугаар тодорхой болбол энэ хуулийн 79.3-т зааснаар улсын орлогод оруулсан мөнгийг хадгаламжийн хүүгийн хамт хугацаа харгалзахгүйгээр буцааж олгоно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон гадаадын байгууллагатай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

80 дугаар зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон гадаадын байгууллагатай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаат гүйцэтгэх

80.1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон гадаадын байгууллагатай холбоотой шүүхийн, эсхүл бусад байгууллагын шийдвэрийг гүйцэтгэхэд энэ хуулийг баримтална.

81 дүгээр зүйл. Гадаад улсын шүүх, арбитрын байгууллагын шийдвэр гүйцэтгэх

81.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаад улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно.

81.2.Гадаад улсын шүүхийн шийдвэрийн үндсэн дээр Монгол Улсын шүүхээс олгосон гүйцэтгэх хуудсыг гүйцэтгүүлэх хөөн хэлэлцэх хугацаа тухайн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил байна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшуулал, гүйцэтгэгдсэн шийдвэрийг цуцлах

82 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал

82.1.Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаат хэрэгжүүлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гэнэ.

82.2.Дараахь зардал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд хамаарна:

82.2.1.төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах зардал;

82.2.2.төлбөр төлөгч болон түүний нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлах, илрүүлэх зардал;

82.2.3.шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаат хэрэгжүүлэхэд тогтоосон журмын дагуу оролцсон, шинжээчийн ажлын хөлс;

82.2.4. илгээмж, шуудан, холбооны зардал;

82.2.5. шийдвэр гүйцэтгэх бусад ажиллагааны зардал.

82.3.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлнэ.

82.4.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, төлбөр авагчид олгоно.

82.5.Төлбөрийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тэр хэмжээгээр төлбөр авагч, төлбөр төлөгч хуваан төлнө.

82.6.Гүйцэтгэх баримт бичигт зааснаар хэд хэдэн төлбөр авагч, төлбөр төлөгч байгаа бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тэдгээс хуваан гаргуулна.

82.7.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

83 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах

83.1.Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэлх хувиар урамшуулна.

83.2.Энэ хуулийн 83.1-д заасан урамшуулыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна.

83.3.Энэ хуулийн 83.1, 83.2-т заасан урамшуулал олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

84 дүгээр зүйл. Гүйцэтгэгдсэн шийдвэрийг цуцлах

84.1.Гүйцэтгэгдсэн шийдвэр хүчингүй болсон бол уг шийдвэрээр төлбөр авагчид олгогдсон бүх зүйлийг гаргуулж төлбөр төлөгчид буцаан олгох буюу тийм боломжгүй бол буцаан олгох үеийн ханшаар үнийг төлнө.

84.2.Торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, ял шийтгэгдсэн этгээдийг цагаатгах тогтоол гарсан бол хөдөлмөрийн хөлснөөс хийсэн суутгал, торгуулийн мөнгө, хураасан эд хөрөнгө буюу түүний үнийг тухайн үеийн ханшаар тооцож буцаан олгоно.

84.3.Гүйцэтгэх баримт бичиг нь хүчингүй болсонд тооцогдсоны улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсны зардлыг улсын төсвөөс гаргана.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийг биелүүлэгчийн хариуцлага, шийдвэр гүйцэтгэчийн үйл ажиллагаанд гомдол гаргах

85 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичгийг болон шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэгчийн хариуцлага

85.1.Гүйцэтгэх баримт бичгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа гүйцэтгэгүй бол бууруулах иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх тухай хүсэлтээ шийдвэр гүйцэтгэгч ахлах шийдвэр гүйцэтгэгч, холбогдох бусад байгууллагад гаргана.

85.2.Шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг санаатайгаар биелүүлэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй нь тогтоогдсон бол гэмт бууруулах этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

86 дугаар зүйл.Банк, банкны бус санхүүгийн байгууллага гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэгчийн хариуцлага

86.1.Банк, банкны бус санхүүгийн байгууллагад төлбөр төлөгчийн мөнгөн болон бусад эд хөрөнгө байсан атал төлбөр гаргуулах тухай шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэгүй тохиолдолд банк, банкны бус санхүүгийн байгууллагад төлбөл зохих төлбөрийн үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг ахлах шийдвэр гүйцэтгэгч оногдуулна.

87 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгчээс бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

87.1.Шийдвэр гүйцэтгэгчээс иргэн, байгууллагад учруулсан хохирлыг хуульд заасан журмыг баримтлан барагдуулна.

87.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг үрэгдүүлсэн бууруулах этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

87.3.Төлбөр авагч, төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол ажиллагаа явагдсан өдрөөс, уг ажиллагаа хэзээ, хаана явагдсаныг мэдээгүй бол өөрт мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор гомдлоо хуульд өөрөөр заагаагүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолыг эс зөвшөөрвөл шүүхэд гаргана.

87.4.Төлбөр төлөгдөөгүй байсан бол шүүх зөвхөн эд хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэнэ.

88 дугаар зүйл. Хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн дагуу цаг хугацаанд нь суутгал хийгээгүй үед төлбөр авагчийн эрхийг хамгаалах

88.1.Тухайн хуулийн этгээдийн бууруугаас шалтгаалан суутгал хийгээгүй бол шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх албаны улсын байцаагч гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд[10] заасан захиргааны шийтгэл оногдуулна.

89 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусад этгээдийн эрхийг хамгаалах

89.1.Төлбөр гаргуулахаар хураагдсан эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбогдсон маргаан үүссэн тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд тухайн эд хөрөнгийг битүүмжлэх эд хөрөнгийн жагсаалтаас хасах, чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлээ шүүхэд гаргаж болно.

90 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэчийн шаардлагыг заавал биелүүлэх

90.1.Шүүх, бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг энэ хуульд заасны дагуу гүйцэтгэх талаар шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлнэ.

90.2.Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, энэ зорилгоор хуурамч гэрээ хийж эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн, нуун дарагдуулсан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн, төлбөр төлөгчийн хөдөлмөрийн хөлс,цалин, орлогоос суутгал хийгээгүй буюу дутуу суутгасан, эсхүл суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олгоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хууль тогтоомжид заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

[10] *Захиргааны хариуцлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.*

Ш ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

91 дүгээр зүйл. Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

91.1.Торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа нь энэ хуулийн П хэсэгт заасан иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны дагуу гүйцэтгэгдэнэ.

91.2.Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш ялтан 7 хоногийн дотор шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй.

91.3.Ялтан энэ хуулийн 91.2-д заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлнэ.

91.4.Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 12.1-т заасны дагуу тогтоосон тойргийн шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн шийдвэрийг хуваарилна.

91.5.Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулна.

91.6.Ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушаасныар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

92 дугаар зүйл.Торгох ялыг гүйцэтгэх

92.1.Ялтан энэ хуулийн 91.5-д заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөөс албадан гаргуулна.

93 дугаар зүйл. Торгох ялыг хорих ялаар солих санал гаргах

93.1.Ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс,цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр эл эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг хорих ялаар солих тухай саналыг прокурорт гаргана.

93.2.Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд[1] заасны дагуу торгох ялыг хорих ялаар сольж болно.

94 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

94.1.Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтэх тогтоолыг, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлнэ.

94.2.Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 12.1-т заасны дагуу тогтоосон тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

94.3.Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгө хураах ялыг гүйцэтгэхдээ гүйцэтгэх бариmт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ хуулийн П хэсэгт заасан журмын дагуу эд хөрөнгийг битүүмжилж, бусад ажиллагааг 30 хоногийн дотор дуусгавар болгоно.

94.4.Дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгөөөс тодорхой эд хөрөнгийг хураахаар шүүхийн шийтгэх тогтоолд нэрлэн заасан бол энэ хуульд заасан журмын дагуу хураана.

94.5.Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хураж, улсын орлогод оруулснаар эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх бариmт бичгийг хааж, тогтоол гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

95 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг

[1] *Монгол Улсын Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.*

үйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

95.1.Шүүхийн шийтгэх тогтоолд хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

95.2.Энэ хуулийн 95.1-д заасан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгийг хураах боломжгүй болсон бол түүний үнийг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлнэ.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

96 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

96.1.Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүчин төгөлдөр болмогц 7 хоногийн дотор шүүх шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ.

96.2.Шийдвэр гүйцэтгэх алба нь шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн сум, дүүргийн Засаг даргад танилцуулж аль байгууллагад албадан ажил хийлгэхийг тогтоолгож ялтны ял эдлэх ажиллагаанд хяналт тавина.

96.3.Албадан ажил хийлгэх ялыг шүүхээс тогтоосон хугацаанд эдлүүлэх бөгөөд нэг өдөрт албадан ажил хийлгэх хугацаа 3-12 цаг байна.

96.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ялтныг албадан ажил хийлгэх ажил олох, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

96.5.Энэ хуулийн 96.4-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ сум, дүүргийн Засаг дарга дараахь хэлбэрээр ажиллана:

96.5.1.албадан ажил хийх тухай нийтэд мэдээлэх;

96.5.2.орон нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.

96.6.Албадан ажил хийж буй ялтны цалин хөлсийг гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхөд суутгана.

96.7.Ялтан өр төлбөргүй бол албадан ажил хийсэн ялтны цалин хөлсийг улсын төсөвт оруулна.

96.8.Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль_зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

97 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх ял эдлэх хугацааг тооцох тухай

97.1.Албадан ажил хийлгэх ял эдлэх хугацааг ялтан ажил хийж эхэлсэн цагаас тооцно.

97.2.Ялтан шүүхээс оногдуулсан ялын хугацаанд ногдох ажлын цагт ажилласан байна. Ажиллаагүй цагийг энэ хуульд зааснаар ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй бөгөөд дутуу ажлын цагийг нөхөн ажиллуулна.

97.3.Ял эдлэх хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хуурамчаар өвчлөх, бие эрхтэн, эрүүл мэнддээ санаатайгаар гэмтэл учруулах, захиргааны журмаар баривчлагдах, цагдан хоригдох зэргээр ажиллаагүй хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй.

97.4.Албадан ажил хийлгэх ял эдлэх хугацаа дууссан бол тухайн өдрөөс, хуульд заасан бусад үндэслэлээр ялаас чөлөөлсөн бол уг шийдвэрийг хүлээн авмагц шийдвэр гүйцэтгэх газар ял эдэлж дууссан тухай цагаатгах тогтоол гаргах ба энэ өдрөөс эхлэн ялтны эрхийн хязгаарлалтыг зогсооно.

98 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн ялаар солих

98.1.Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа ялтан хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдсан бол албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай саналыг шийдвэр гүйцэтгэх газар шүүхэд гаргана.

98.2.Ялтан ажлаа дур мэдэн орхих, ажил олгогч, шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, зөрчих зэргээр ял эдлэхээс ноцтой зайлсхийвэл ажил хийлгэж байгаа байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд шийдвэр гүйцэтгэх газар зохих шалгалт хийж албадан ажил хийлгэх ялыг хорих ялаар солих тухай саналаа холбогдох баримт бичгийн хамт шүүхэд ирүүлнэ.

98.3.Шийдвэр гүйцэтгэх газрын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд заасны дагуу албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар, эсхүл хорих ялаар солих асуудлыг шийдвэрлэнэ.

99 дүгээр зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

99.1.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол үндсэн ялыг эдэлж дууссан өдрөөс эхлэн, харин уг ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан түүнчлэн албадан ажил хийлгэх, торгох ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор уг шийдвэрийн хувийг шүүх тухайн этгээдийг ажил, албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

99.2.Энэ хуулийн 99.1-д заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоол хүлээн авсан байгууллага ялтныг тухайн албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон шийдвэрээ хүчингүй болгож, шаардлагатай бол мэргэжлийн үнэмлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон бичмэл бичиг нь хураан авч, энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

99.3.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хорих анги ялтныг суллагдмагц шүүхийн шийтгэх тогтоолын хувь, шаардлагатай бол хувийн бичиг баримтыг ялтны оршин суух газрын шийдвэр гүйцэтгэх албанд суллагдсанаас хойш 3 хоногийн дотор хүргүүлнэ.

99.4.Шийдвэр гүйцэтгэх албаа нь энэ хуулийн 99.2, 99.3-т заасны дагуу ирүүлсэн мэдэгдэл, шүүхийн шийтгэх тогтоол, баримт бичгийг хүлээн авмагц ялтныг дуудан ирүүлж ялын хугацаанд шүүхээс хориглосон албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулж болохгүй түүнд анхааруулж, ял эдлэх ажиллагаанд хяналт тавина.

99.5.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдэлж байгаа этгээд ял эдлэх хугацаанд өөр ажил, албан тушаалд шинээр орох, тодорхой үйл ажиллагаа эрхлэх бол шийдвэр гүйцэтгэх албанд мэдэгдэж зөвшөөрөл авна.

99.6. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокуророй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

99.7.Шийдвэр гүйцэтгэх албаа энэ зүйлд заасан ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын талаар тоо бүртгэл хөтөлж, түүний биелэлтэд хяналт тавихдаа цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

100 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

100.1.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлээгүй этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Албадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

101 дүгээр зүйл.Сэтгэцийн өвчтэй буюу согтуурах, мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

101.1.Өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахаарүй сэтгэцийн өвчтэй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хэрэг үйлдсэнийхээ дараа тийм өвчнөөр өвчилсөн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн соггуурах, мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх уг этгээдийг албадлагын аль төрлийн эмнэлэгт байлгахыг тогтоолдоо заана.

101.2.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийтгэх тогтоол гармагц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг цагдаагийн, хэрэв уг этгээд баривчлах, хорих ял эдэлж байгаа бол ял эдлүүлж байсан баривчлах байр, хорих анги нь тус тус хүлээх бөгөөд шүүхийн шийтгэх тогтоол, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад бичиг баримтыг хамтад нь хүргүүлнэ.

101.3.Энэ хуулийн 101.1-д заасан этгээдийн эмчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

101.4.Албадан эмчлүүлж байгаа этгээд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эмнэлгийн болон цагдаагийн байгууллага хамтран авна.

101.5.Албадан эмчлэх байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

101.5.1.албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийж, эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичих;

101.5.2.эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг этгээдийг цаашид албадан эмчлэх шаардлагатай эсэхийг сэтгүүдэн эмгэг судлалын болон холбогдох мэргэжлийн эмч нарын зөвлөлгөөнөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах, уг арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа шүүхэд нэн даруй мэдэгдэх.

101.6.Албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэсэн эмнэлгийн дүгнэлт гарвал прокурорын саналыг үндэслэн шүүх урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгож албадан эмчлэгдэж байсан этгээдийн ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхээр баривчлах байр, хорих ангид шилжүүлэх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид нь хүлээлгэн өгөх асуудлыг Эрүүгийн хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

101.7.Албадан эмчлүүлж байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө энэ хуулийн 101.5. 2-т заасан дүгнэлтийг гаргуулж болно.

101.8.Албадан эмчлэх нөхцөл, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн тус тус тогтооно.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

Эрүүгийн хэргийн талаархи зарим төрлийн шүүхийн шийтгэх тогтоолыг цагдаагийн байгууллага гүйцэтгэх

102 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, ялтныг хянан харгалзах

102.1.Шүүх насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол тогтоолын хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

102.2.Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах талаар цагдаагийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

102.2.1.тогтоолын хувийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан хяналтын хувийн хэрэг нээж ялтан, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, эсхүл хуулийн этгээдийн төлөөлөгчийг дуудан уулзаж тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

102.2.2.ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээд үүргээ гүйцэтгэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

102.2.3.ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийх;

102.2.4.шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай шүүх болон ял шийтүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

102.3.Сум, дүүргийн Засаг дарга ялтанд боловсрол, мэргэжил эзэмшихэд нь зохих туслалцаа үзүүлж, ялтны сахилга, шүүхээс даалгасан үүргийн биелэлт, засрал хүмүүжлийн байдлыг шалган танилцаж, шаардлагатай бол цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

102.4.Ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээд түүний засрал хүмүүжлийн байдлыг харицуан, эрх зүйн хүмүүжил олгох, иргэнийхээ үүргийг шударгаар биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

103 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх

103.1.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд ялтан засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга ханддагаараа харуулбал түүнийг ялаас чөлөөлөх тухай саналыг сум, дүүргийн Засаг дарга, эсхүл цагдаагийн байгууллага шүүхэд гаргаж болно.

103.2.Ялтан шүүхээс даалгасан болон энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийн итгэл хүлээсэн хөсөрдүүлсэн, эсхүл нийгмийн хэв журам зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан бол хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллага саналаа; аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн хүсэлтээ шүүхэд гаргана.

103.3.Хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлт, цагдаагийн байгууллага, Засаг даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн насанд хүрээгүй ялтныг ялаас чөлөөлөх, эсхүл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг шүүх хүчингүй болгож, шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

103.4.Энэ зүйлд заасан санал, хүсэлт, дүгнэлт нь бичгийн хэлбэртэй байна.

104 дүгээр зүйл. Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтанд хяналт тавих

104.1.Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд энэ хуулийн 101, 102 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

104.2.Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Баривчлах, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

105 дугаар зүйл. Хорих байгууллага

105.1.Хорих байгууллага нь баривчлах байр, насанд хүрээгүйчүүдийн болон насанд хүрэгсдийн хорих анги, гяндан /цаашид "хорих анги" гэх/ тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагаас бүрдэнэ.

105.2.Баривчлах байр нь жирийн дэглэмтэй хорих ангитай адил дэглэмтэй байна.

105.3. Хорих анги нь төвлөрсөн бүтэцтэй байна.

106 дугаар зүйл. Хорих анги шинээр байгуулах, татан буулгах, хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршил

106.1.Хорих анги шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг өөрчлөх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

106.2.Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, ажлын байрны асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан Засгийн газар шийдвэрлэнэ.

107 дугаар зүйл. Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги

107.1.Баривчлах байранд ялтныг ганцаарчлан байлгаж баривчлах ялыг эдлүүлнэ.

107.2.Баривчлах ял эдэлж байгаа этгээдэд энэ хуулийн 107.4-107.7-д заасан зааллт нөгөн адил хамаарна.

107.3.Жирийн дэглэмтэй хорих ангид насанд хүрэгсдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих ангиуд хамаарагдана.

107.4. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд жилд найман удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

107.5.Энэ хуулийн 119.1-д заасан төрөл, садангийнх нь хүн хүндээр өвчилсөн буюу нас барсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул

тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд 7 хүртэл хоногийн чөлөө олгож болно.

107.6.Чөлөөг энэ хуулийн 107.5-т заасан нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, дүүргийн Засаг даргын болон эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ял эдлүүлж байгаа баривчлах байр, хорих ангийн дарга шийдвэрлэнэ.

107.7.Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан өөрийн зардлаар таксофон ашиглах эрхтэй.

108 дугаар зүйл.Чанга, онцгой дэглэмтэй хорих анги

108.1.Чанга дэглэмтэй хорих ангийн ялтан нь 2 сард нэг удаа түр, 3 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

108.2.Онцгой дэглэмтэй хорих ангийн ялтан жилд 3 удаа түр, 2 удаа удаан хугацааны уулзалт хийж, жилд 3 удаа илгээмж авч, сард 2 удаа захидал явуулж болох бөгөөд ялынхаа тал хувийг эдэлсний дараа жилд 3 удаагийн нэмэлт илгээмж авч болно.

109 дүгээр зүйл.Гяндан

109.1.Гяндангийн ялтныг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөж, гяндангийн ялтныг нийтийн тасалгаанд хорьж болно.

109.2.Гяндангийн ялтныг тусгай төхөөрөмжлөгдсөн газарт, зохих хяналт хамгаалалтын дор өдөрт нэг цагаас доошгүй хугацаатай гадаалуулах ба журам зөрчвөл гадаалахыг даруй зогсооно.

109.3.Гяндангийн ялтныг зөвхөн гяндангийн байранд хөдөлмөрлүүлж болно.

109.4.Жирийн дэглэмтэй гяндангийн ялтан жилд 2 удаа түр уулзалт хийж, 1 сард нэг удаа захидал явуулж болно.

109.5.Чанга дэглэмтэй гяндангийн ялтан жилд нэг удаа түр хугацааны уулзалт хийж, 2 сард нэг удаа захидал явуулж болно.

110 дугаар зүйл. Насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх

110.1.Насанд хүрээгүй ялтны ялыг зөвхөн насанд хүрээгүйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.

110.2.Насанд хүрээгүй ялтныг хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр ажиллуулж болно.

110.3.Насанд хүрээгүй ялтан 18 нас хүрмэгц ялыг нь эдлүүлэхээр насанд хүрэгсдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг хорих ангийн даргын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

110.4.Энэ хуулийн 110.3-т заасан ялтны хувийн байдал, ял эдэлсэн хугацааг харгалзан хорих ангийн даргын шийдвэрээр түүнийг насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 2 жил хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

110.5.Насанд хүрээгүй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд жилд 8-аас дээшгүй удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

110.6.Насанд хүрээгүй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

111 дүгээр зүйл. Эмэгтэй ялтныг ял эдлүүлэх

111.1.Эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.

111.2.Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.

111.3.Эмэгтэй ялтан сард нэг удаа түр, жилд 8-аас дээшгүй удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

111.4.Эмэгтэй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард нэг удаа илгээмж авч болно.

111.5.Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно.

112 дугаар зүйл.Хорих ангийн хамгаалалтын бүс

112.1.Жирийн дэглэмтэй хорих анги нь үндсэн хашааны эргэн тойронд хоёроос доошгүй хамгаалалтын бүстэй байна.

112.2.Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан хамгаалалтын дараахь бүстэй байна:

112.2.1.дотоодын хориотой бүс;
112.2.2. телекамер;
112.2.3.үндсэн хашаа;
112.2.4. цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс;
112.2.5.өнгөлөн далдлах хашаа.

112.3.Хорих байгууллага дахь хяналт, харуул хамгаалалтад хэт богино долгионы радио станц, телекамерийн тоног төхөөрөмж ашиглаж болно.

112.4.Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн амьдралын болон үйлдвэрлэлийн бүсийн гаднах дохиолол, харуул хамгаалалтыг хорих байгууллагын ажилтны хүчээр хариуцан гүйцэтгэнэ.

112.5.Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

113 дугаар зүйл.Оргосон ялтныг эрэн сурвалжлах

113.1.Баривчлах байр, хорих ангийн харуул хамгаалалтыг зохион байгуулах, оргосон ялтныг мөрдөн хөөх, баривчлахад албаны нохой ашиглаж болох бөгөөд үүнийг зохих алба хариуцан гүйцэтгэнэ.

113.2.Оргосон ялтныг мөрдөн хөөх, баривчлах ажиллагаар эрэн сурвалжлах хэсэг гүйцэтгэнэ.

113.3.Онц аюултай буюу зэвсэгслэсэн ялтныг мөрдөн хөөх, баривчлах, түүнчлэн ялтны дунд гарсан эмх замбараагүй байдлыг өөрийн хүчээр таслан зогсоох боломжгүй болсон тохиолдолд зохих байгууллагаас нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, хүн хүч, тусгай тоног төхөөрөмжийн тусламцаа авах болон бусад шаардагдах арга хэмжээг нэгдсэн журмаар авч хэрэгжүүлэх ба энэ журмыг Засгийн газраас тогтооно.

114 дүгээр зүйл.Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлэг, дамжин өнгөрүүлэх анги

114.1.Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлэг дараахь үүрэгтэй:

114.1.1.ялтныг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхтэй холбогдсон нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

114.1.2.баривчлах байр, хорих ангийн эмнэлгийн салбарыг мэргэжлийн удирдлагаар хангах;

114.1.3.тахир дутуугийн зэрэгт оруулах шаардлагатай ялтны тодорхойлолтыг эрүүл мэндийн зохих байгууллагад гаргах;

114.1.4.өвчний учир ялтныг ялаас чөлөөлүүлэх тухай тодорхойлолт, саналыг ял эдлүүлж байгаа баривчлах байр, хорих ангийн захиргаанд гаргах.

114.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн эмнэлгийг мэргэжил, арга зүйн удирдлага, боловсон хүчнээр хангана.

114.3.Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

114.4.Дамжин өнгөрүүлэх анги нь ялтныг ял эдлэх ангид нь хүргэхийн өмнө болон шаардлагатай бусад тохиолдолд түр хорих байгууллага мөн.

114.5.Нэгдсэн эмнэлэг, Дамжин өнгөрүүлэх ангийн дэглэм, харуул, хамгаалалт чанга дэглэмтэй хорих ангийнхтай адил байна.

114.6.Дамжин өнгөрүүлэх анги, нэгдсэн эмнэлэгт мөрдөх дэглэм, харуул хамгаалалтын журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

115 дугаар зүйл. Ялтны эрх, үүрэг

115.1.Ялтан дараахь эрх эдэлнэ:

115.1.1.шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах;

115.1.2.өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;

115.1.3.өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;

115.1.4.холбогдох зардлаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;

115.1.5.тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн хувцас, байраар хангагдах, эмнэлгийн тусламж авах;

115.1.6.энэ хуульд заасны дагуу төрөл, садантайгаа удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, утас, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах;

115.1.7.сонин, сэтгүүл захиалах,

хорих байгууллага дахь номын санг ашиглах;

115.1.8.урьд тогтоолгосон өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах.

115.2. Ялтан дараахь үүрэг хүлээнэ:

115.2.1.баривчлах байр, хорих ангид мөрдөх хууль тогтоомж, байгууллага, ажилтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

115.2.2.эрх бухий албан тушаалтнаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих;

115.2.3.тогтоосон журмын дагуу зохиож байгаа хөдөлмөрийн дадлага олгох болон ерөнхий сургалтад хамрагдах;

115.2.4.эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөлгөө шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх;

115.2.5.ээзмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид хайр гамтай хандах.

115.3.Гадаад улсын харъяат ялтан энэ зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийн зэрэгцээ гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжээр дамжуулан өөрийнхөө орны дипломат төлөөлөгчийн газрын ажилтантай уулзаж, харилцах эрхтэй.

116 дугаар зүйл. Хорих ял эдлүүлэх дэглэм

116.1.Ялтны хорих ял эдлэх ангийн төрөл, дэглэмийг шүүх тогтооно.

116.2.Насанд хүрээгүй болон эмэгтэй ялтны ялыг жирийн, чанга дэглэмтэй хорих анги, насанд хүрсэн эрэгтэй ялтны ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд тус тус эдлүүлнэ.

116.3.Гянданд ял эдлүүлэхээр шийтгүүлсэн ялтны ялыг жирийн, чанга дэглэмтэй гянданд эдлүүлнэ.

117 дугаар зүйл. Ялтныг хүргэх, хүлээн авах

117.1.Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон едреес хойш 10 хоногийн дотор аймаг, нийслэл дэх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтныг шууд, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд ял эдлэх ялтныг Дамжин өнгөрүүлэх ангид хүргэнэ.

117.2.Энэ хуулийн 117.1-д заасны дагуу дамжин өнгөрүүлэх ангид ирсэн ялтан чухам аль ангид ял эдлэхийг Тогтоол гүйцэтгэх газар шийдвэрлэх ба ийнхүү гаргасан хуваарийн дагуу түүнийг ял эдлэх хорих ангид нь хүргэх асуудлыг Дамжин өнгөрүүлэх анги хариуцан гүйцэтгэнэ.

117.3.Энэ хуулийн 117.2-т заасны дагуу хуваарилагдаж ирсэн ялтныг хүлээн авах ажиллагаанд тухайн хорих ангийн дарга хариуцан зохион байгуулна.

118 дугаар зүйл. Ялтныг тусад нь ял эдлүүлэх

118.1.Насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ.

118.2.Ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, дархлалын олдмол хомсдол өвчнөөр халдварласан, өвчилсөн ялтныг бусад ялтнаас тусгаарлан ял эдлүүлнэ.

118.3.Ижил дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ.

119 дүгээр зүйл.Ялтан бусадтай уулзах, харилцах

119.1.Ялтан зохих хэналт, хамгаалалтын дор төрөл, садан /эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг ач, зээ/-тай удаан, бусад хүнтэй түр хугацааны уулзалт хийж болно.

119.2.Түр хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 3 цагаас дээшгүй, удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 72 цагаас дээшгүй байх бөгөөд холбогдох зардлыг хорих анги хариуцахгүй.

119.3.Ялтантай удаан хугацаагаар уулзах хүн түүний төрөл, садан мөн болохыг нотолсон хууль ёсны бичиг баримт, эсхүл харъяалах сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолттой байна.

119.4.Хорих ангийн болон ялтны аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан ялтны захидлыг задлан үзэж, түүнд ирсэн илгээмжид үзлэг хийнэ.

120 дугаар зүйл. Ялтны хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл

120.1.Ялтны хөдөлмөрийг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна.

120.2.Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь Хөдөлмөрийн тухай хуульд[1,2] нийцсэн байна.

120.3.Ялтнаар ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах боловч мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

120.4.Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хязгаалттайгаар хөдөлмөрлүүлж болно.

120.5.Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.

120.6.Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.

120.7.Төрийн нууц, цэрэг стратегийн холбогдолтой зэрэг тусгай дэглэм бүхий онцгой объектод ялтан ажиллуулахыг хориглоно.

121 дүгээр зүйл.Ялтны хөдөлмөрийн хөлс

121.1.Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.

121.2.Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ.

121.3.Хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон энэ хуулийн 121.2-т заасны дагуу шилжих ирсэн цалин хөлсөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ.

121.4.Энэ хуулийн 121.3-т заасны дагуу төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан өөр тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгоно.

121.5.Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.

121.6.Хорих анги, эсхүл ажил олгогч нь ялтны хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн үнэлгээ, ханшаар тооцно.

122 дугаар зүйл. Ялтныг харуул хамгаалалттүй ажиллуулах

122.1.Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн, ялын тал хувийг эдэлсэн ялтныг засрал, хүмүүжил, хувийн байдал, ажлын онцлогийг нь харгалзан хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн харуул хамгаалалттүй ажиллуулах тухай шийдвэр гаргаж болно.

123 дугаар зүйл Хүмүүжлийн ажил

123.1.Гэмт хэрэг, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангахын тулд ялтны дунд хүмүүжлийн ажил явуулна.

123.2.Хүмүүжлийн ажлыг ялтны үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна.

124 дүгээр зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

124.1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна.

124.2.Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, бүяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно.

124.3.Ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.

125 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт

125.1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ.

125.2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.

---

[2] Хөдөлмөрийн хууль "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

125.3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.

125.4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.

126 дугаар зүйл. Ялтныг урамшуулах

126.1.Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна;

126.1.1.хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх;

126.1.2.урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах;

126.1.3.энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.

126.2.Ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана.

126.3.Ялын талаас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж урамшуулагдаж байсан ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах тухай саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана.

126.4.Энэ хуулийн 126.2, 126.3-т заасны дагуу гаргасан саналыг прокурорын дүгнэлтийг үндэслэн хууль тогтоомжийн дагуу шүүх шийдвэрлэнэ.

127 дугаар зүйл. Ялтанд хүлээлгэх сахилгын шийтгэл

127.1.Ялтан хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

127.1.1.ээлжийн бус ажил хийлгэх;

127.1.2.хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх;

127.1.3.сахилгын байранд хорих;

127.1.4.тухайн улирал, эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах.

127.2.Насанд хүрсэн эрэгтэй ялтныг 30 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэй ялтныг 60 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 30 хүртэл хоног сахилгын байранд хорино.

127.3.Хорих ангийн ажуулгүй байдлыг хангах, ялтан гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангийн жижүүрийн шийдвэрээр түүнийг 72 цаг хүртэл хугацаагаар тусгаарлах тасалгаанд түр шилжүүлж болно.

127.4.Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, жүрмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөж хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоно.

127.5.Сахилгын байранд хорьсон, тусгаарлах тасалгаанд шилжүүлсэн ялтны эрүүл мэндэд эмч хяналт тавина.

127.6.Жилд хоёроос дээш удаа сахилгын шийтгэл хүлээсэн ялтан дахин ноцтой зөрчил гаргавал хорих ял эдлүүлэх дэглэмийг чангаруулах тухай саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

127.7.Сахилгын байранд хоригдсон, тусгаарлах тасалгаанд шилжсэн ялтны эзлэхит түр болон урт хугацааны уялзалтыг хасахыг хоригломо.

127.8.Сахилгын нэг зөрчил гаргасан ялтанд энэ хуулийн 127.1-д заасан шийтгэлийг давхардуулан оногдуулахыг хориглоно.

128 дугаар зүйл. Ялтны ахуйн нөхцөл

128.1.Ялтныг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлөөр хангана.

128.2.Хорих анги нь ялтныг ор, хөнжил, гудас, цагаан хэрэглэл болон хүйтэн, дулааны улирлын зориулалттай нэг загварын гадуур хувцаар хангах ба ялтан хувиасаа дотуур хувцас, дулаан хантааз, цамц, бээлий, өвөл, зуны гутал өмсөхийг зөвшөөрнө.

128.3.Ялтны хоолны илчлэгийн хэмжээг хорих ангийн төрөл, ялтны ажлын нөхцлийг харгалзан ялгамжтай тогтооно.

128.4.Эмнэлгийн комиссын дүгнэлтийг харгалзан жирэмсэн болон өвчтэй ялтныг нөхцлийг нь сайжруулсан байранд байлгаж, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

128.5.Хортой, хүнд нөхцөлд ажиллаж байгаа ялтанд хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хоол

олгоно.

128.6.Хорих байрны эрүүл ахуйн шаардлага, ялтанд олгох хоолны илчлэгийн хэмжээ, хувцасны тоо, эдлэх хугацаат холбогдох байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

128.7.Хорих ял эдэлж байхдаа нас барсан ялтны тухай ар гэрт нь мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор хариу ирээгүй бол хорих анги өөрийн зардлаар оршуулна.

129 дүгээр зүйл. Ялтныг суллах үндэслэл

129.1.Ялтныг дараахь үндэслэлээр суллана:

129.1.1.шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацаа дуусан;

129.1.2.ершөөл, уучлал үзүүлсэн;

129.1.3.шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;

129.1.4.ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу өвчний үчир хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эсхүл хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай шүүхийн тогтоол гарсан;

129.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

130 дугаар зүйл. Ялтныг суллах журам

130.1.Ялтныг ялын хугацаа дууссан бол тухайн өдөрт, бусад үндэслэлээр уг ялтныг суллах тухай шийдвэрийг хүлээн авсан өдөрт нь, хэрэв ажлын цаг дууссаны дараа хүлээн авсан бол дараагийн өдөрт, амралт, баяр ёслолын өдөр байвал өмнөх өдөр нь суллана.

130.2.Ялтныг суллах тухай шийдвэр гаргах эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг баривчлах байр, хорих ангид хүргүүлэх хугацааг харгалзсан байна.

130.3.Суллагдсан хүнд хувийн бичиг баримт, эд зүйл болон суллагдсан тухай албан бичиг олгож, ялтны хувийн хэрэгт зохих тэмдэглэл хийнэ.

130.4.Шаардлагатай бол суллагдаж байгаа ялтанд тухайн үлирлын хувцас, байнга оршин суух газартаа очих үналга, хоолны зардлыг хорих ангиас олгож болох ба үналгын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцно.

130.5.Гянданд ял эдэлж байсан буюу гэмт хэрэг санаатай үйлдэж хоёроос дээш удаа хорих ял шийтгүүлж байсан ялтан суллагдвал энэ тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

130.6.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис болон согтуурууллах ундаа байгаа хэрэглэдэг, түүнчлэн ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй болон дархлалын олдмол хомсдол өвчнөөр халдварласан буюу өвчилсөн ялтан суллагдвал энэ тухай эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Цаазаар авах ялыг гүйцэтгэх

131 дүгээр зүйл. Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

131.1.Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар батална гэсэн тогтоолыг ялтанд 10 хоногийн дотор мэдэгдэж, иймхүү мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтан амь үүчлахыг хүссэн өргөдөл гаргах эсэхийг тодруулж, хэрэв гаргавал түүнийг, хүсэлтгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж Улсын дээд шүүхэд ирүүлнэ.

131.2.Улсын дээд шүүх өргөдөл буюу тэмдэглэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор материалыг хэргийн хамт Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

131.3.Монгол Улсын Ерөнхийлөгч хэргийг хүлээн авснаас хойш 30, зайлшгүй шаардлагатай бол 60 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

131.4.Ялтанд уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг прокуророор дамжуулан өгнө.

131.5.Монгол Улсын Ерөнхийлөгч ялтанд уучлал үзүүлээгүй бол ялыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

131.6.Цаазаар авах ялыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батална.

131.7.Уучлалын асуудлыг шийдвэрлэх хүртэл цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэхийг түдгэлзүүлнэ.

IY ХЭСЭГ

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН ХОРЬДУГААР БҮЛЭГ

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн байдал

132 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан

132.1.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ.

132.2.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан төрийн төлөөлөгч мөн.

132.3.Шийдвэр гүйцэтгэгч нь Улсын ерөнхий гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ.

132.4.Шийдвэр гүйцэтгэгч нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байна.

132.5.Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

132.6.Хорих байгууллагын албан хаагч нь 18 насанд хүрсэн, ял шийтгэлгүй, зохих мэргэжлийн сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн байна.

132.7.Хорих байгууллагад ажиллах иргэний эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.

133 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх

133.1.Шийдвэр гүйцэтгэгч нь дараахь бүрэн эрх эдэлнэ:

133.1.1.гүйцэтгэх баримт бичгийг хугацаанд нь бүрэн гүйцэтгэх;

133.1.2.хуульд заасан журмын дагуу төлбөр төлөгч хуулийн этгээд, төлбөр төлөгч-иргэний, эсхүл бусад этгээдийн орон байр, агуулахад нэвтрэн орох, биед болон эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх;

133.1.3.эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах, нуугдмал хөрөнгө илрүүлэх, хураагдсан эд хөрөнгийг худалдан борлуулах;

133.1.4.гүйцэтгэх баримт бичигт заасан үнийн дүнгийн хэмжээгээр банк, банкны бус санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, бусад үнэт зүйлийг битүүмжлэх;

133.1.5.гүйцэтгэх баримт бичиг нь тодорхой бус байгаа тохиолдолд түүнийг тодруулахаар шүүхэд хүсэлт гаргах;

133.1.6.шийдвэр гүйцэтгэхтэй холбогдуулан иргэн, албан тушаалтныг дуудан ирүүлэх;

133.1.7.холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтнаас баримт, тайлбар, танилцуулга гаргуулан авах;

133.1.8.шийдвэр гүйцэтгэх явцад эрүүгийн хэргийн шинж бүхий баримт илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх;

133.1.9.шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар талуудаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

133.1.10.шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн сонирхолтой, эсхүл шударгаар ажиллахад эргэлзээ байгаа бол шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас татгалзан гарах.

133.2.Шийдвэр гүйцэтгэгчийн талаархи гомдлыг аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд гаргана.

133.3.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 133.1-д зааснаас гадна дор дурдсан эрх эдэлнэ:

133.3.1.шийдвэр гүйцэтгэгчийн

шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

133.3.2.шийдвэр гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдлагаар хангах;

133.3.3.шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн гүйцэтгэлийг хугацаанд нь биелүүлэхэд хяналт тавих;

133.3.4.гүйцэтгэх баримт бичгийн болон өртэй этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэн хуульд заасан журмын дагуу гаргах;

133.4.Улсын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 133.2, 133.3-т зааснаас гадна дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

133.4.1.шийдвэр гүйцэтгэх албаны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган хяналт тавих;

133.4.2. ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

133.4.3.ахлах шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гомдлыг хянан шийдвэрлэх.

133.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Тогтоол гүйцэтгэх газрыг өдөр тутмын шуурхай удирдлагаар хангана.

133.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга улсын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрх эдэлнэ.

134 дүгээр зүйл.Хорих ангийн дарга, албан хаагчийн бүрэн эрх

134.1.Хорих ангийн албан хаагч дараахь бүрэн эрх эдэлнэ:

134.1.1.оргосон ялтан байгаа, эсхүл энэ талаар лавтай сэжиг байвал хуульд заасан журмын дагуу тухайн байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох, орон байр, тээврийн хэрэгсэл, түүнчлэн оргодолд туслалцаа үзүүлсэн буюу туслалцаа үзүүлсэн гэж үзэх лавтай сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, биед үзлэг хийх, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

134.1.2.оргосон ялтныг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах үед зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түр дайчлах, холбоо, мэдээллийн хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх. Харин дипломат төлөөлөгчийн болон албан тушаалын, түүнчлэн үүргээ гүйцэтгэж яваа түргэн тусламжийн, гал унтраах албаны, техникийн ослын дуудлагын автомашиныг дайчилж болохгүй.

134.1.3.хуульд заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах;

134.1.4.ялтанд хяналт тавихдаа ялтны бие, байранд үзлэг, нэгжлэг тогтмол хийж зэвсэг, хутга, мэс, зэвсгийн чанартай бусад зүйл, мансууруулах болон хордуулах үйлчилгээний эм тариа, өвс ургамал, согтууруулах ундаа, хориглосон тоглоом, зөвшөөрөгдсөнөөс бусад зүйлийг хураан авах, эсхүл устгах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү тергер, валют, үнэт зүйлсийг хураан авч акт тогтоон хадгалах, хорих ангийн аюулгүй байдал түүнд мөрдөгдөх дэг журмыг сахиулах зорилгоор ялтанд байнгын хяналт тавих;

134.1.5.хорих ангийн байр, үйлдвэрлэлийн талбайд орж, гарч байгаа тээврийн хэрэгсэлд үзлэг хийх.

134.2.Хорих ангийн дарга нь энэ хуулийн 134.1-д зааснаас гадна дараахь эрх эдэлнэ:

134.2.1.ялтан оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон гарсан гэмт хэрэгийг илрүүлэх зорилгоор ялтнуудын дотор, түүнчлэн оргосон ялтныг баривчлахын тулд хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;

134.2.2.ялтны ял эдэлж байгаа дэглэмийг өөрчлөх тухай санал шүүхэд гаргах;

134.2.3.ялтныг хорих ялаас

хугацаанаас өмнө суллах, хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих болон эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн өвчний учир ялаас чөлөөлүүлэх тухай санал шүүхэд гаргах;

134.2.4.энэ хуульд заасны дагуу ялтанд чөлөө олгох;

134.2.5.ногдсон ажлаа чанартай сайн гүйцэтгэсэн бөгөөд сахилгын зөрчил гаргаагүй ялтанд улиралд 30 хүртэл шагналын хоног өгөх;

134.2.6.хуурамчаар болон санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ саналтайгаар гэмтэл учруулж эмчлүүлсэн, дур мэдэн ажилд гараагүй, чөлөөнөөс хоцорсон, оргосон хугацааг ял эдэлсэн хугацаанаас хасаж тооцох.

134.3.Хорих байгууллагын албан хаагч энэ хуулийн 134.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цагдаагийн байгууллагаас туслалцаа авч, хамтран ажиллана.

134.4.Энэ хуулийн 134.1.3-т заасны дагуу тээвэр, холбоо, мэдээллийн хэрэгсэл ашигласны хөлс, зардлыг тухайн үеийн үнэлгээгээр тооцож, зохих иргэн, хуулийн этгээдэд олгоно.

135 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны тангараг, дүрэмт хувцас, цол

135.1.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан төрийн сүлдэнд: "Монгол Улсын иргэн би Шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаахдаа хуулийг дээдлэн биелүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлж ажиллахаа батлан тангараглая. Би тангаргаасаа няцвааc төрийн хуулийн цээрлэл хүлээнэ" гэж тангараг өргөнө.

135.2.Хорих байгууллагын албан хаагч нь цэргийн цол, дотоодын цэргийн дүрэмт хувцастай байна.

135.3.Шийдвэр гүйцэтгэгч нь хувийн дугаар бүхий тэмдэг, таних тэмдэгттэй байна.

136 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах

136.1.Шийдвэр гүйцэтгэгчид зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

136.1.1.сануулах;

136.1.2.шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгох.

136.2.Хорих байгууллагын албан хаагчид дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

136.2.1.сануулах;

136.2.2.сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

136.2.3. цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах;

136.2.4.цол бууруулах буюу хураан авах;

136.2.5.ажлаас халах.

136.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилгын дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

137 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа

137.1.Хорих байгууллагын албан хаагч дараахь эрх зүйн баталгаагаар хангагдана:

137.1.1.албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авах;

137.1.2.албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох;

137.1.3.албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр

хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгох ба хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс авах;

137.1.4.жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар байгууллагын зардлаар хооллох;

137.1.5.шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон ачаа тээшийг байгууллагын тээврийн хэрэгслээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох;

137.1.6.офицер, ахлагч эзлэжийн амралтаараа өөрийн бүүр захэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох.

137.2.Хорих байгууллагын албан хаагчид үндсэн цалингаас гадна, хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцлийн болон тусгай албаны, цэргийн цол, зэрэг дэвийн нэмэгдэл олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

137.3.Шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 137.1.4, 137.1.5, 137.2-т зааснаас бусад баталгааг эдэлнэ.

137.4.Хорих байгууллагад ажилласан хугацааг тооцоход цагдан хорих байр, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан болон сүрьеэг эмчлэх ангид 1 жил ажилласан хугацаа 1 жил 3 сар, насанд хүрэгсдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 1 жил ажилласан хугацаа 1 жил 2 сар ажилласанд тооцно.

137.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр халагдах болон амины сууц барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон жүрмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно.

137.6.Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, нотариатын үйлдэл хийхийг хууль бусаар шаардах, заналхийлэхийг хориглоно.

137.7.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх ба биелүүлэхгүй бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

137.8.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.

137.9.Бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

137.10.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдана.

138 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын данс

138.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба нь банкинд данстай байна.

138.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар банкинд гадаад төлбөр тооцооны данстай байна.

138.3.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын данс, бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль[13] болон хууль тогтоомжийн дагуу гаргасан жүрмын дагуу хөтөлнө.

138.4.Шийдвэр гүйцэтгэх ажлын онцлогийг тусгасан данс, бүртгэл, тайлан тэнцлийн тухай жүрмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

[13] Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

139 дүгээр зүйл. Тусгай хэрэгсэл

139.1.Шийдвэр гүйцэтгэгч дараахь тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

139.1.1.резинэн ба хуванцар сумтай буу;

139.1.2.нулимс асгаруулагч.

139.2. Хорих байгууллага дараахь тусгай хэрэгсэл ашиглана:

139.2.1.гар, хөл, хурууны гав;

139.2.2.хүлэг, ороох цамц;

139.2.3.резинэн, цахилгаан бороохой;

139.2.4.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу;

139.2.5.резинэн ба хуванцар сумтай буу.

139.3.Ялтан хорих ангид мөрдөх журмыг биелүүлээгүй, хорих ангийн ажилтны хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, эсхүл биелүүлээгүй дараахь тохиолдолд тусгай хэрэгсэл ашиглаж болно:

139.3.1.ялтан хорих байгууллагын ажилтанд хүч хэрэглэн халдсан;

139.3.2.хорих ангиас оргосон ялтныг баривчлах үед;

139.3.3.бусад ялтны болон хорих байгууллагын аюулгүй байдалд хохирол учруулж болохоор үймээн гарсан;

139.3.4.энэ хуулийн 140.1-д заасан нөхцөл байдал бий болсон.

140 дүгээр зүйл. Галт зэвсэг

140.1.Хорих байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ амьдралын болон үйлдвэрлэлийн бүсээс бусад нөхцөлд галт зэвсэг биедээ авч явах эрхтэй бөгөөд гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

140.1.1.ялтны дайран довтолсон үйлдэл нь бусдын амь бие, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах нь илт байвал;

140.1.2.ялтан оргон зугтсан буюу оргохыг завдсан;

140.1.3.зэвсэглэсэн оргодол баривчлах үед;

140.1.4.баривчлах байр, хорих анги, түүний харуул хамгаалалт, ажилтанд гаднаас хүч хэрэглэн довтолсон;

140.1.5.хуяглан хүргэж байгаа ялтныг суллахаар зэвсэг хэрэглэсэн, эсхүл бүлэглэн довтолсон;

140.1.6.баривчлах байр,хорих ангид эмх замбараагүй байдал, үймээн гарснаас хүний амь бие, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит нөхцөл бий болсон;

140.1.7.бусдыг барьцаанд авсан.

140.2.Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

140.3.Энэ хуулийн 140.1.1, 140.1.3-т заасан, түүнчлэн бүлэглэн довтолсон буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед дотор нь ялгах боломжгүй онцгой тохиолдлоос бусад үед хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүний эсрэг тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

140.4.Галт зэвсэг хэрэглэсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт мэдэгдэнэ.

140.5.Тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

141 дүгээр зүйл. Тоо бүртгэл

141.1.Шийдвэр гүйцэтгэх газар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд энэ хуулийн 7.1.2, 7.1.3-д заасны дагуу тоо бүртгэл хөтөлнө.

141.2.Тогтоол гүйцэтгэх газар нь энэ хуулийн 8.1.3-д заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд тоо бүртгэл хөтөлнө.

141.3.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай бичгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

142 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт

142.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

142.2.Баривчлах, хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэлээр,журмын дагуу явагдаж байгаа эсэхэд Улсын Ерөнхий прокурор, түүний харьяа прокурор хяналт тавина.

143 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

143.1.Энэ хуулийн дагуу гаргасан шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны шийдвэр, үйл ажиллагааны тухай гомдлыг холбогдох этгээд уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор дээд шатны албан тушаалтанд гаргана.

143.2.Дээд шатны албан тушаалтан гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацааны дотор шалгаж шийдвэрлэнэ.

143.3.Дээд шатны албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргаж болно.

143.4.Зөрчил гаргасан шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

144 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

144.1.Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдсөн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгээс "цагдан хорих", "албадан саатуулах" гэсэн үгийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 01 дүгээр сарын 10–ны өдөр **Улаанбаатар хот**

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ АЛБАДАН СААТУУЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 41.1-ийн "Дараахь" гэсний өмнө "хорих байрны ажилтан", 41.1.1-ийн "хорих байрны" гэсний өмнө "Хоригдсон этгээдээс" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 12.1, 41.1.5-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1/12.1.Нийслэл дэх цагдан хорих төвийн гадуур болон дотуур харуул хамгаалалтыг хорих байгууллагын ажилтны хүчээр хариуцан гүйцэтгэнэ. Бусад хорих байрыг хорих байгууллагын албан хаагчид хамгаална.

2/41.1.5.хорих байгууллагын ажилтан болон бусдын эсрэг хүч хэрэглэн довтолж, зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа этгээдийг баривчлахад;"

3 дугаар зүйл. Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн нэр болон хуульд "албадан саатуулах" гэснийг "баривчлах", 6.2; 7.1;42.1; 42.3-ыг "цагдаагийн төв байгууллагын" гэснийг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын"; 10.2-ын "цагдаагийн" гэснийг "шүүхийн шийдвэр гүйцэтгэх"; 11.1-ийн "аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагын" гэснийг "аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны"; 6.2-ын "цагдаагийн байгууллагын" гэснийг "шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны"; 12.3-ын "Цагдаагийн байгууллагын тухай хуульд" гэснийг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд"; 23.1-ийн "2200" гэснийг "3400"; 40 дүгээр зүйлийн гарчгийг "Тусгай хэрэгсэл, түүнийг хэрэглэх журам" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль гарсан өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 01 дүгээр сарын 10–ны өдөр **Дугаар 03** **Улаанбаатар хот**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.13.-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулыд заасан дүрэм, журмыг боловсруулан батлуулах;

2/шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

4/шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (246)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *"Олимп цогцолбор" байгуулах хөдөлгөөнийг дэмжих тухай*
- *Морин хуураа дээдлэн, дэлгэрүүлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай*
- *"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны гуравдугаар сарын 8 №9 (246)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

90. Элчин сайдыг чөлөөлөх тухай Дугаар 07 470
91. Элчин сайдыг томилох тухай Дугаар 08 470
92. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 09 470
93. Х. Цэсмаа шүүгч, ерөнхий шүүгчээс чөлөөлөх тухай Дугаар 10 470
94. "Олимп цогцолбор" байгуулах хөдөлгөөнийг дэмжих тухай Дугаар 11 471
95. Пунцагийн Рэнжин, Дангаагийн Байгал нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 12 471
96. Шаравын Чоймаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 13 471
97. Бямбасүрэнгийн Шаравт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 14 471
98. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 15 472
99. Батрагчаагийн Ганзоригийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 16 476
100. Морин хуурааа дээдлэн, дэлгэрүүлэх тухай Дугаар 17 476
101. Япон Улсын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 20 476
102. Марохито Ханадаг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 21 476
103. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 22 477

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

104. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай Дугаар 286 477
105. Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Дугаар 287 477
106. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай Дугаар 288 480

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

107. Нийгмийн халамжтай холбогдсон хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Дугаар 448 496

ЗАЛРУУЛГА

«Төрийн мэдээлэл» эмхтгэлийн 2001 оны 27 дугаарт нийтлэгдсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.3-ын хоёр дахь өгүүлбэрийг «Байнгын хорооны дарга зэрүүд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга захирамжаар томилсон нэг гишүүн үүргийг нь түр орлон гүйцэтгэнэ.» гэж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 01 дүгээр сарын 18–ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот

Элчин сайдыг чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин уравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Тойтогийн Төмөрхүлэгийг Монгол Улсаас Камбожийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 01 дүгээр сарын 18–ны өдөр | Дугаар 08 | Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямсүрэнгийн Алиасүрэнг тохоон томилсугай.

Монгол Улсаас Камбожийн Вант Улсад суух

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 01 дүгээр сарын 30–ны өдөр | Дугаар 09 | Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндашийн Цолмонг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 01–ний өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

Х. Цэсмаагийн шүүгч, ерөнхий шүүгчээс чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Шүүгчийн мэргэшлийн хороо дүгнэлт гаргасантай холбогдуулан Хайдавын Цэсмаагаар Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 01–ний өдөр — Дугаар 11 — Улаанбаатар хот

"Олимп цогцолбор" байгуулах хөдөлгөөнийг дэмжих тухай

Биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, хүн амыг эрүүлжүүлж, чийрэгжүүлэх, их спортод хүч сорих ирээдүйтэй залуусыг бэлтгэхэд спортын иж бүрэн цогцолбор шаардлагатай байгааг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3, 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг тус тус баримталж ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Олимп цогцолбор" байгуулах тухай Монголын үндэсний олимпийн хорооны үриалгыг дэмжсүгэй.

2. Үриалгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэ явцын талаар мэдээлж байхыг Ерөнхийлөгчий Тамгын газрын дарга Б. Батхишиг, Ерөнхийлөгчий нийгмийн бодлогын зөвлөх Л. Лхагва нар даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 07–ны өдөр — Дугаар 12 — Улаанбаатар хот

Пунцагийн Рэнжин, Дангаагийн Байгалнарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд багш, захирлаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж удирдсан сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын мэдлэг мэргэжил, заах аргыг дээшлүүлэн өсвөр, залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн ажилчин залуучуудын зөвлөхийн сургуулийн зөвлөх багш Пунцагийн Рэнжин, 2 дугаар дунд сургуулийн захирал Дангаагийн Байгалнарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 07–ны өдөр — Дугаар 13 — Улаанбаатар хот

Шаравын Чоймаад Монгол улсын гавьяат багш цол хүртээх тухай

Монгол Улсын Их сургуульд багш, тэнхмийн эрхлэгчээр олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үндэсний бичиг соёлоо заажсургах, ард түмэнд түгээн дэлгэрүүлж хөгжүүлэх, залуу үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн тэнхмийн эрхлэгч Шаравын Чоймаадг Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 07–ны өдөр — Дугаар 14 — Улаанбаатар хот

Бямбасүрэнгийн Шаравт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж олон симфони, удиртгал, магтуу, бүжгийн жүжгийн болон киноны хөгжим, нийтийн дууны аяа зохиож, монголын орчин цагийн хөгжмийн урлагийг хөгжүүлэх болон дэлхийн улс орнуудад сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар Улаанбаатар
сарын 07–ны өдөр Дугаар 15 хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, банк, соёл урлаг, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Шадравын Бадарч - Нийслэлийн "Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн монтёр-жолооч
2. Очирын Гэрэл - ШУТИС-ийн Геологийн сургуулийн геологи, минералогийн тэнхмийн эрхлэгч
3. Аюулгүйн Дамдинсүрэн - Эрүүл мэндийн улсын хяналтын албаны орлогч дарга
4. Довчинбуугийн Магвансүрэн - Орхон аймаг дахь Монголбанкны салбарын захирал
5. Хандын Магсаржав - Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн албаны дарга
6. Отгоны Нарьяахүү - Клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлгийн рентген оношлогооны их эмч
7. Балсангийн Норгил - Нийслэлийн "Амгалан орчлон" эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч
8. Ёндонгийн Очирсүх - Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн харьяа нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн эмнэлгийн эвэлбэр эмч
9. Өвгөегийн Хандаа - Нийслэлийн "Меркури" худалдааны төвийн худалдагч
10. Ёндонгийн Хойлог - Нийслэлийн "Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн ахлах инженер
11. Нанзадын Цэвээн - Нийслэлийн 1 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Цэндийн Банди - Гал түймэртэй тэмцэх газрын захиргааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Галсановын Алтанцэцэг - Нийслэлийн "Хөдөлмөрийн зам" ХХК-ийн "Цэнхэр-Од" дэлгүүрийн эрхлэгч
2. Жүгнээгийн Амарсанаа - Үндсэн хуулийн цэцийн гишүүн
3. Лувсанцэрэнгийн Аюушжав - "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн холбооны байгууламжийн ашиглалтын газрын ахлах техникч
4. Жамбалдоржийн Базар - "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн хяналтын инженер
5. Даваажавын Бавуудорж - Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн дэд захирал
6. Жаргалын Балжинням - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Таван-Анд" ХХК-ийн гүйцэтгэх захирал
7. Гэндэнгийн Батсуурь - Архангай аймгийн Эрдэнэмандал сумын дунд сургуулийн математикийн багш
8. Цэрэнгийн Баттулга - Хөвд аймгийн Цэцэг сумын малчин
9. Доржийн Батчулуун - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн математикийн багш
10. Цэрэнсономын Бираадамба - Архангай аймгийн Булган сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
11. Балдангийн Бямбасүрэн - Архангай аймгийн Батцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч
12. Ишгэндэнгийн Галбаатар - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын дунд сургуулийн биеийн тамирын багш
13. Пүрэвийн Ганбаатар - Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн хиам, консервын үйлдвэрийн ачигч
14. Эрдэнэдалайн Гүргэмжав - МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн маркетинг, олон улсын тэнхмийн эрхлэгч
15. Бямбын Даваанам - Булган аймгийн Сэлэнгэ сумын дунд сургуулийн монгол хэл,уран зохиолын багш
16. Довчингийн Дагва - Булган аймгийн Бугат сумын дунд сургуулийн бага ангийн багш
17. Пүрэвийн Дагвадорж - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 45 дугаар дунд сургуулийн физикийн багш
18. Цэдэнноровын Дагвадорж - ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи,дизайны сургуулийн үйлдвэрлэлийн дизайны тэнхмийн эрхлэгч

19. Балжинхүүгийн Дамдинсүрэн	- Засгийн газрын 3 дугаар байрны дарга
20. Бэгзийн Дамдинсүрэн	- Дорнод аймгийн Хэрлэн сумын "Баасай" ББН-ийн эзэн
21. Даваагийн Дашдэлэг	- Нийслэлийн Баянгол дүүргийн 47 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
22. Даваагийн Дондол	- Орхон аймгийн Баян-Өндөр сумын 5 дугаар дунд сургуулийн захирал
23. Даваагийн Доржгочоо	- ШУТИС-ийн харьяа уул уурхайн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
24. Ичинхорлоогийн Дуламсүрэн	- УБИС-ийн ахлах номын санч
25. Раднаагийн Дуламсүрэн	- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
26. Билгээгийн Жавзмаа	- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Тэнүүн хангай" ХЭАА-н эзэн
27. Лувсанцэрэнгийн Ихбаяр	- Нийслэлийн "UBS" телевизийн зураглаач
28. Цэрэнжавын Ишдорж	- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Газар холдинг" ХХК-ийн санхүү эрхэлсэн дэд захирал
29. Сүхбаатарын Лочинлхам	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
30. Мажаагийн Лхагвадорж	- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн гагнуурчин
31. Лувсанбатын Лхагвасүрэн	- Улаанбаатар хотын Нефть хангамжийн газрын 6 дугаар шатахуун түгээх станцын эрхлэгч
32. Дайвхүүгийн Лхамрагчаа	- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш
33. Самдангийн Лхамтогмид	- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спорт сургалтын төвийн захирал
34. Баасанжавын Мөнхөө	- Дорноговь аймгийн Сайншанд сумын "Загийн говь" хоршооны эзэн
35. Ёндонбалын Мягмаа	- Нийслэлийн 48 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
36. Алтангэрэлийн Мягмаржав	- Монголын радиогийн "Хүрд" агентлагийн захирал
37. Довдонгийн Мяхлайш	- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
38. Төмөр-Очирын Намжил	- Хүмүүнлэгийн ухааных их сургуулийн соёл иргэншлийн тэнхмийн эрхлэгч
39. Намсрайжав Намсрайжав	- Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны үндраа" цогцолбор сургуулийн математикийн багш
40. Найдангийн Намхай	- "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн захирал
41. Намсрайн Нанжид	- Хэнтий аймгийн Хэрлэн сумын худалдаа, үйлчилгээний "Өндөрхаан-Уул" ХХК-ийн захирал
42. Лувсанбазарын Нарантуяа	- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал
43. Мятавын Ойдов	- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн хиам, консервын үйлдвэрийн инженер
44. Чимэдийн Оюунцэцэг	- УБИС-ийн Химийн тэнхмийн эрхлэгч
45. Доржпаламын Пүрэвхүү	- Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн "Баянгол өргөө" компанийн мэргэжилтэн
46. Батдоржийн Сийлэгмаа	- Улсын ардын дуу, бүжгийн чуулган гоцлол дуучин
47. Гончигийн Сонин	- Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш
48. Аюушдоржийн Сосорбурам	- Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Сүү вит" ХХК-ийн менежер
49. Махминийн Сүхбат	- Увс аймгийн Улаангом сумын "Өгөөмөр" ХЭАА-н эзэн
50. Тэрбишийн Сэлэнгэ	- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Бөөний худалдаа" ХК-ийн худалдагч
51. Тогоохүүгийн Сэнгэдорж	- ҮХЯ-ны Геологи, эрдэс баялгийн бодлогын зохицуулалтын газрын мэргэжилтэн
52. Сэрээнэнгийн Тогмид	- УБИС-ийн ректор
53. Лхагважавын Төмөрчөдөр	- Орхон аймгийн "Эрдэнэт" цогцолборын 1 дүгээр дунд сургуулийн захирал
54. Нацагийн Хавх	- МУИС-ийн философийн тэнхмийн багш
55. Жамбалсүрэнгийн Халзанхүү	- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
56. Дүгэржавын Хандаа	- Нийслэлийн 58 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
57. Өлзийн Хашхүү	- Гэмтэл согог сэргээн засах клиникийн эмнэлгийн гавал тархи, нуруу нугасны гэмтлийн тасгийн эрхлэгч
58. Равдангийн Цагаан	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 41 дүгээр дунд сургуулийн бага ангийн хичээлийн эрхлэгч
59. Ядамсүрэнгийн Цогтоо	- ШУТИС-ийн мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн тэнхмийн багш
60. Гөлгөөгийн Цэвэгмид	- Буянт-Ухаа боомт дахь хилийн эрүүл ахуй, халдвар судлалын

хяналтын товчооны дарга

31. Данзангийн Цэвээндорж - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Өргөн жим" ХК-ийн автогрейдерчин
32. Наваансодовын Цэнд - Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тэргүүн дэд захирал
33. Чимэддоржийн Цэндсүрэн - "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн холбооны үйлчилгээний газрын няттлан бодогч
34. Санжаарайн Цэрэндорж - Нийслэлийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн химийн багш
35. Дэлгэрийн Цэрэндулам - Нийслэлийн "Монгени" цогцолбор сургуулийн бага ангийн багш
36. Чойнжуурын Цэрэн-Очир - Нийслэлийн "Ярагайт эх" ХХК-ийн ерөнхий захирал
37. Лхачингийн Чойжоованчиг - УБИС-ийн программчлалын тэнхмийн багш
38. Гаадангийн Шархүү - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Уулс импекс" ХХК-ийн дэд захирал
39. Даржаагийн Юмсүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн хятад хэл, компьютерийн сургалттай "Сэн-Лизэ" бага сургуулийн хичээлийн эрхлэгч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Доржбатын Баасанхүү - Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх албаны жолооч, ахлах ахлагч
2. Шагдарын Лхагвасүрэн - Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа
3. Жамбалын Сүхбаатар - Нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 14 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
4. Агваанданзангийн Сэр-Од - Төрийн ордны галын хэсгийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа
5. Гомбожавын Чулуунбаатар - Булган аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн жолооч, ахлах ахлагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ойдовын Алтангэрэл - Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн ажилчин
2. Цэдэвийн Баатаржав - Нийслэлийн "Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн инженер
3. Дамдинлын Батаа - Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажилтан
4. Цэгмидийн Батбаяр - Нийслэлийн худалдаа, зуучлал, үйлчилгээний "БОСА" ХХК-ийн ерөнхий захирал
5. Насанбуянгийн Баянсүрэн - Нийслэлийн "Баярсонтракшн" ХХК-ийн харьяа "Диана" дунд сургуулийн захирал
6. Махзанын Буниа - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Таван тэнгэр" ХХК-ийн захирал
7. Пүрэвийн Буяндалай - Нийслэлийн "Эрэл барилга" ХХК-ийн ерөлгчин
8. Лувсангомбын Бямбажав - "Төвийн бусийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн монтёрч
9. Магваны Бэлэгт - Нийслэлийн худалдаа, зуучлалын "Ачлал трейд" ХХК-ийн дэд захирал
10. Бадамдоржийн Ганбаатар - Булган аймгийн Бугат сумын дунд сургуулийн орос хэлний багш
11. Сономын Ганбат - Архангай аймгийн Булган сумынд дунд сургуулийн хими, биологийн багш
12. Гэндэнгийн Галя - Нийслэлийн Баянгол дүүргийн 47 дугаар дунд сургуулийн орос хэлний багш
13. Дугарын Даваадорж - "Монгол шуудан" банкны Хөвсгөл аймаг дахь 110 дугаар салбарын захирал
14. Жигмэдийн Даниа - Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн татварын улсын байцаагч
15. Чүлтэмсүрэнгийн Дэлгэрмаа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 45 дугаар дунд сургуулийн математикийн багш
16. Жамбалдоржийн Дэндэвдулам - Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны үндраа" цогцолбор сургуулийн газар зүйн багш
17. Азымханы Жазира - Нийслэлийн Баянгол дүүргийн 47 дугаар дунд сургуулийн биологийн багш
18. Маххайн Ирина - Орхон аймгийн Баян-Өндөр сумын 5 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
19. Бямбадашийн Ичинхорлоо - Клиникийн 1 дүгээр амаржих газрын эх баригч
20. Дашдэлгэрийн Лхагваням - Булган аймгийн Булган сумын 2 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
21. Рэнчингийн Маам - Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн татварын улсын байцаагч
22. Дарамбазарын Маналсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дотрын их эмч
23. Довчингийн Махбал - Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч

24. Дашдэндэвийн Мөнхчулуун	- Нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 10 дугаар ангийн багны мастер, ахлах ахлагч
25. Цэдэнгийн Мэндхүү	- Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын"Алтан шигтгээ"хоршооны дар
26. Содномын Нааяа	- Хавдар судлалын төвийн гэрлийн их эмч
27. Сандагжавын Намжилжамц	- Улсын нөөцийн газрын 3дугаар объектын жолооч
28. Ядамын Намсрай	- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн монгол хэл,уран зохиолын багш
29. Ичинхоролын Нарангэрэл	- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Соёлын төвийн эрхлэгч
30. Гүрийн Нацагдорж	- ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
31. Бавуужавын Нотоо	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн 41 дүгээр дунд сургуулийн хөдөлмөрийн баг
32. Ядамжавын Нямаа	- ХААН банкны Хөвсгөл аймаг дахь 603 дугаар салбарын захирал
33. Буянтогтохын Нямсүрэн	- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн ачигч
34. Магсарын Нямсүрэн	- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн дулааны станцын оролгч дарга
35. Санжжавын Оюун	- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн багш ангийн багш
36. Содномпэлжээгийн Оюунбилэг	- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 135 дугаар цэцэрлэгийн багш
37. Очирын Оюунгэрэл	- Орхон аймгийн Баян-Өндөр сумын 5 дугаар дунд сургуулийн биологийн багш
38. Хорлоогийн Оюунцэцэг	- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагч
39. Дүгэрнямаагийн Оюунчимэг	- БСШУЯ-ны харьяа Албан бус боловсролын зайны сургалтын "Сурч амьдаръя" төслийн ажилтан
40. Балхаагийн Пагжийбуу	- "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн жолооч
41. Должавын Сайнбуян	- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэрийн дулааны станцын зуухны машинч
42. Нямжавын Сандуйжав	- Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн жолооч, ахлах ахлагч
43. Намхайноровын Санжаадансан	- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Өргөн жим" ХК-ийн жолооч
44. Мижидийн Содномжамц	- Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа
45. Лхагвын Сольхүү	- Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын татварын хэлтсийн тасгийн дарга
46. Содномын Төмөрбаатар	- Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн багны мастер, ахлах ахлагч
47. Довдонгийн Уртнасан	- Нийслэлийн 2 дугаар амаржих газрын мэс заслын сувилагч
48. Содномын Хажид	- Нийслэлийн Хянан шалгах хорооны хянан байцаагч
49. Нацагийн Хорлоо	- Өмнөговь аймгийн Төв номын сангийн үйлчлэгч
50. Ыдрышийн Хурмет	- Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал сөнөөгч, ахлах ахлагч
51. Дашбалбарын Цог	- Нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 29 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа
52. Баатарын Цэнд	- Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал сөнөөгч, ахлах ахлагч
53. Самбуугийн Цэцгээ	- Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Эрдэм" цогцолбор сургуулийн зохион бүтээх, хөдөлмөрийн багш
54. Намбарын Цэцэгмаа	- Хавдар судлалын төвийн мэс заслын тасгийн ахлах сувилагч
55. Натарын Цэцэгээ	- ХААН банкны Баянхонгор аймаг дахь салбарын захирал
56. Явшингийн Цэрэнханд	- Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч
57. Дашжамцын Чимэг	- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн орчуулга судлалын тэнхмийн багш
58. Пунцагийн Шооногой	- Увс аймгийн Өндөрханбогд сумын дунд сургуулийн математикийн багш
59. Гэвэийн Энхтуяа	- Архангай аймгийн Булган сумын номын сангийн номын санч
60. Цэдэнгийн Эрдэнэбаатар	- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн ажилчин
61. Ламаачигийн Эрдэнэбилэг	- Нийслэлийн гал түймэртэй тэмцэх хэлтсийн байцаагч, дэд хурандаа
62. Довчинсамбуугийн Эрдэнэчимэг	- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Бадачи трейд" ХХК-ийн дэд захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 02 дугаар
арын 07–ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

Батрагчаагийн Ганзоригийг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган, галын юулаас хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр өртэй биелүүлсэн "Гандантэгчинлэн" хийдийн огооч Батрагчаагийн Ганзоригийг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

002 оны 02 дугаар
арын 11–ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Морин хуураа дээдлэн, дэлгэрүүлэх тухай

Монгол иргэншил, соёл, урлаг, оюун сэтгэлгээний нандин өв уламжлалыг хадгалан хамгаалах, сэргээн дэлгэрүүлэх, баяжуулан хөгжүүлэх, туурвин бүтээх, судлан сурталчлах замаар ард иргэдийг үндэсний соёлоо эрхэмлэн дээлэх, түүгээрээ бахархах мэдлэг, мэдрэмж, хүмүүжил заншилтай болгож, ард түмнийхээ үндэсний ухамсар, оюуны дархлааг бататгах нь монгол төрийн соёлын бодлогын нэг үндсэн зорилт билээ.

Манай ард түмний арга билгийн шүтэн барилдлагын гүн сэтгэлгээ, аман домог, утга соёл, дуу хөгжим, ёс заншил, бэлгэдэл хүндэтгэлийн нэгдмэл цогцлол болсон монгол оюун соёлын хосгүй сод үзэгдэл-эгшиглэнт хос чавхдаст Морин хуур нь манай үндэсний соёлын маргашгүй өв мөн.

Үндэсний бахархал, үнэт өв болсон морин хуураа төрийн хамгаалалтад байлгаж, дээдлэн дэлгэрүүлэх олон нийтийн хүсэл эрмэлзэл, үүсгэл санаачлагыг дэмжиж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг болон 9 дүгээр зүйлийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Морин хуураа дээдлэн залж, сурч эзэмших, морин хуур судлал, урлалыг хөгжүүлэх, гадаад улсад сурталчлах хөдөлгөөн өрнүүлэхийг нийт ард иргэд, айл өрх болон төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн урлагийн ажилтан, зүтгэлтэн, ивээн тэтгэгчдэд уриалсугай.

2. Монгол улсынхаа сүр хүч, айл өрх бүрийн түвшин жаргал, хүн бүрийн цог хийморийг бэлгэдэн бадрааж жил бүрийн Цагаан сараар Төрийн их хан хуурын сүлд аялгууг эгшиглүүлэхийн хамт морин хуурын хүндэтгэлийн тоглолтыг радио, телевизээр улс орон даяар нэвтрүүлж байхаар төрийн ёслолын журамд нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар
сарын 15–ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Япон Улсын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон Улсын Гадаад хэргийн сайд асан Накаяма Тарог "Алтан гадас" одонгоор, Элчин сайд асан Кубота Шинжи, Боловсролын яамны хүүхэд залуучуудын компанийн ерөнхийлөгч Оно Шигео нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар
сарын 21–ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Марохито Ханадаг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Марохито Ханадаг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 22 Улаанбаата хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1.Монгол Улсаас Катар Улс, Бахрейн Улс, Оманы Султаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадерын Сайрааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Катар Улс, Бахрейн Ул Оманы Султаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эр Элчин сайдаар Чойжилжавын Болдыг томилсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 286 Улаанбаата хот

Үндэсний хорооны бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хорооны бүрэлдэхүүнд Нийслэлийн Засаг даргын орлогчийг нэмж оруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 287 Улаанбаатар хот

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1 Монгол Улсын байгууллага, аж ахуйн нэгжид 2002 онд хөдөлмөр эрхлүүлэхээр гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг хавсралт ёсоор батлсугай.

2. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд энэ тогтоолын хавсралтад заасан хувийг баримталж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувиар тогтоосугай.

4. Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хамаарах 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад гадаадаас авах ажиллах хүч мэргэжилтний эзлэх хувийг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэх эрхийг хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагад олгосугай.

5. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, улсын хэмжээний зам, барилга байгууламж барихад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтэнтэй холбоотой асуудлыг энэ тогтоолын дагуу шийдвэрлэх боломжгүй бол тухай бүрт Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

2002 ОНД МОНГОЛ УЛСЫН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИД ХӨДӨЛМӨР ЭРХЛҮҮЛЭХЭЭР ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ЗЭЛГЭХ ХУВЬ

/Тухайн байгууллагын нийт ажиллагчдад эзлэх хувийн жингээр /

Салбар дэд салбар	Бүлэг, дэд бүлэг	Хөрөнгө оруулалт дүрмийн сангийн хэмжээ / сая төгрөг/	50 хүртэл			50-100			100-500			500 ба дээш		
		Нийт ажилласан тоо	100 хүрэл	100-500 хүртэл	500-аас дээш	100 хүртэл	100-500 хүртэл	500-аас дээш	100 хүртэл	100-500 хүртэл	500-аас дээш	100 хүртэл	100-500 хүртэл	500-аас дээш
A01		Хөдөө аж ахуй	5	6	7	5	7	8	6	7	8	6	8	10
	011	1. Газар тариалан	6	7	8	7	8	9	8	9	10	9	10	11
	012	2. Эрчимжсэн мал аж ахуй												
C		Үүп үүрхай, олборлох үйлдвэр	6	7	8	7	8	9	8	9	10	9	10	11
C10		1.Нүүрс олборлолт	100	100		100	100		100	100		100	100	
C11		2.Газрын тос, шатдаг хийн хайгуул												
C13	1310	3.Төмрийн хүдэр олборлолт	6	7	8	7	8	10	15	20	25	20	25	30
C13	1320	4. Алт болон бусад үнэт металлын эрэл хайгуул, олборлолт	6	7	8	7	8	10	15	20	25	20	25	30
C14		5. Чулуу, элс, шороо, давс, химийн болон бордооны эрдэс бодис олборлолт	6	7	8	7	8	9	8	9	10	9	10	11
D		БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР												
D15	151, 152, 153	1.Хүнсний бүтээгдэхүүн	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10
155	1554	2. Ундаа үйлдвэрлэл	5	5.5	6	6	6.5	7	6	7	8	7	8	9
D17,18, 19		3. Нэхмэл, өдөр, арьс шир боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10

D20	201, 202	4. Мод, модон эдлэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	6	7.5	9	7	8.5	10	8	10	12
D21	210	5. Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6	7	8	7	8	9	8	10	12	10	15	20
D24	241, 242, 243	6. Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6	7	8	7	8	9	8	10	12	10	15	20
D25	2510, 2520	7. Резинэн болон хуванцар эдлэлийн үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10
D27, D28		8. Төмрийн үйлдвэрлэл, төмөр эдлэлийн үйлдвэрлэл	5	5.5	6	6	6.5	7	6	7.5	8	7.5	9	12
	269, 4520	9. Барилгын материалын үйлдвэрлэл, барилга-угсралт	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10
D37	3720	10. Төмрөөс бусад хоёрдогч түүхий эд бэлтгэх, боловсруулах	5	5.5	6	6	6.5	7	6	7	8	7	8	10
D30 D31		11. Цахилгаан машин, радио, телевизор, холбооны хэрэгслийн үйлдвэрлэл	5	5.5	6	6	6.5	7	6	7.5	8	7.5	9	11
D36	3610	Мебель тавилга, үйлдвэрлэл	5	5.5	6	6	6.5	7	6	7	8	7	8	9
	369	Боловсруулах аж үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	5.5	6	6	6.5	7	6	7.5	8	7.5	9	12
E40, E41		Эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ус хангамж	6	7	8	7	8	9	8	9	10	10	15	20
		АВТО ЗАМ	6	6.5	7	6.5	7	7.5	7	8	9	8	10	15
G	5020, 5040, 5260	Автомашин, мотоцикл, гэр ахуйн цахилгаан барааны засвар үйлчилгээ	5	6	7	6	6.5	7.5	7	8	9	8	9	10
H60		ТЭЭВЭР, АГУУЛАХЫН АЖ АХУЙ, ХОЛБОО	5	5.5	6	6	6.5	7	6	7	8	7	9	10

Тайлбар: 20 хүртэл ажилтантай байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд 1 хүн, 1,1–ээс дээш хүн ногдох тохиолдолд 2 хүнээр тооцох журмаар гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоог тодорхойлно

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

02 оны 12 дугаар
рын 28–ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар
хот

"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт
:, нялхсын эндэгдлийг бууруулах талаар
эвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор
онгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний
өтөлбөрийг 1 дүгээр, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх
эга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт
оор тус тус батлсугай.

2. Үндэсний хөтөлберт тусгагдсан арга
эмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах
өрөнгийг 2002 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг,
ийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт
ухицуулан тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн
йд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа,
ймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Эрүүл мэндийн болон Иргэний эрүүл
эндийн даатгалын хуулиудад нийцүүлэн
элбергүй үзүүлэх жирэмсэн, төрөх, төрсний
дараахь үеийн эмчилгээ, үйлчилгээ, үзлэг,
шинжилгээний зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх,
тооцох журам боловсруулж мөрдүүлэхийг Санхүү,
эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд
П.Нямдаваа нарт даалгасугай.

4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц,
үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт
мэдээлж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад
даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан
"Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр
батлах тухай" Засгийн газрын 1997 оны 5 дугаар
сарын 21-ний өдрийн 126 дугаар тогтоолыг хүчингүй
болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2001 оны 288 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нөхөн үржихүйн эрүүл мэнд /цаашид НҮЭМ
өнэ/ нь хүний үржихүйн эрхтэн тогтолцоо эрүүл
айх тэдийгүй хүн бие бялдар, оюун санаа,
ийгмийн талаар бүрэн төгс байх тухай цогц
йлголт юм. 1994 оны Каирын "Хүн ам ба хөгжил"
лон улсын Бага хурлаас батлсан үйл
жиллагааны мөрийн хөтөлбөрийг Монгол Улс
айшаан дэмжиж 1997-2001 онд НҮЭМ Үндэсний
өтөлбөрийг хэрэгжүүлсэн нь зөвхөн гэр бүл
өлөвлөлтөөр хязгаарлагдаж байсан асуудлыг
үний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн, чөлөөт
онголтыг дэмжсэн НҮЭМ-ийн бодлогын хүрээнд
,огцолбороор авч үзэх шинэ хандлагыг
өлөвшүүлэх эхлэл болсон юм.

Өнгөрсөн хугацаанд манай орны эдийн
асаг, нийгмийн болон хүн амын НҮЭМ-ийн
айдалд гарсан өөрчлөлт, тулгамдсан асуудлууд
ь Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах
эрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Нэг.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд

1.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн өнөөгийн байдал

"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд 210000 эх амаржиж, эхүүд амрах 299 байрыг сэргээн ажиллуулж, НҮЭМ-ийн иж бүрдэл үйлчилгээтэй загвар эмнэлэг Нийслэл болон Налайх дүүрэг, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгуудад байгуулагдсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлберт НҮЭМ-ийн хичээл шинээр орох болж, уг хичээлийг заах багш нар бэлтгэгдлээ.

Хөтөлбөрийг дэмжсэн олон улсын байгууллагуудын болон аймаг, орон нутгийн дэд

хөтөлбөр, төслүүд хэрэгжиж, түүнд оролцогдын хүрээ тэлж байна.

НҮБ-ын Хүн амын сангийн тусламжаар эмэгтэйчүүдийн үрэвсэлт болон бэлгийн замын халдварт өвчин (цаашид БЗХӨ гэнэ)-ийг эмчлэх нэн шаардлагатай эм, жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслээр улс даяар тасралтгүй хангагдаж, амаржих газар, аймаг, сумын эмнэлгүүдэд эх барихын тусламж, үйлчилгээний шаардлагатай багаж, тоног төхөөрөмж олгогдлоо.

Хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалууд, "НҮЭМ", "Үерхэл" улиралтутмын сонин хэвлэгдэж, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "Эсэн мэнд амаржихуй" радио, телевизийн цуврал хичээл, нэвтрүүлэг хийгдэж байна.

НҮЭМ-ийн асуудлаархи мэдээллийг дээд болон дунд түвшний шийдвэр гаргагчдад хүргэж, тэдний дэмжлэгийг бүй болгоход чиглэсэн үндэсний болон орон нутгийн хэмжээний бага хурал, сургалт зохиогдлоо.

НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад хандивлагчдын дэмжлэгтэйгээр НҮЭМ-ийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэгч баг, сум, өрхийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын 90 орчим хувийг сургалтад хамруулах арга хэмжээ авлаа.

НҮЭМ-ийн өнөөгийн байдлыг үнэлэх, дүгнэх, тодорхойлох гол хэрэглэхүүн болж байгаа 4 чиглэлийн судалгаа хийгдлээ.

Эдгээрээс үзэхэд манай улсын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 99 хувь нь гэр бүл төлөвлөлтийн талаар ойлголт, мэдээлэлтэй бөгөөд 50 хувь нь жирэмслэлтээ зохицуулах ямар нэг аргыг хэрэглэж байна.[1]

Гэвч хөтөлбөрт дэвшүүлсэн НҮЭМ-ийн байдлын үндэсн үзүүлэлтүүд биелэгдээгүйн дотор БЗХӨ-ний тархалт, эхийн эндэгдэл туушталт буурсангүй. Хөтөлберийн хэрэгжилтийг удирд зохицуулах салбарын дотоодын болон салб хоорондын,төв,орон нутгийн байгууллагуудын үү ажиллагааны уялдаа холбоог хангах, санхүүгий найдвартай эх үүсвэр бий болгох, шаардлагат мэдээлэл цуглуулах, хянах, үнэлэх, дүгнэ тогтолцоо бүрдүүлэх талаар дорвитой өөрчлө гарсангүй.

1.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тулгамдса асуудлууд

1.2.1. Эхийн эндэгдэл туушталт буурахгүй байна

Эхийн эндэгдэл сүүлийн 3 жилд 100 00 амьд төрөлтөд дунджаар 163 байгаа нь хүрэхээ зорьсон түвшнээс өндөр байна. Жирэмслэх, төр байгаа эхчүүдийн 29 хувийг малчид эзэлж байгаа эндсэн эхчүүдийн 49.3 хувь нь малчид, 43.3 хув нь багт, 36.9 хувь нь сумын төвд амьдардаг эхчүүд байна. Сүүлийн 3 жилд нас барсан эхчүүдийн 40.5 хувь нь сум, багийн эмнэлэг энджээ. Энэ нь сум, багийн түвшинд эсэн мэн амаржихуйн тусламжийн чанар, хүртээмж нэ хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн 40 хувь н архаг цус багадалттай, 33.1 хувь нь эрхтэ тогтолцооны сууль эмгэгтэй[2] байна.

1.2.2. Үр хөндөлтийн тоо өндө байна.

1000 амьд төрөлтөд 230 үр хөндөлт ногдо байна.[4] Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хийгдэ байгаа үр хөндөлтийн тоог бүрэн мэдээлэх, эрүү мэндийн үндэсний дүн бүртгэлд тусгах асууда төгс шийдэгдээгүй байна.

Архидалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэ нийгмийн сөрөг үзэгдлүүд нь хүсээгүй жирэмслэлт үр хөндөлтийн өсөлтөд шууд нөлөөлж байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүд хотод хөдөөгийнхөөс 2.3 дахин илүү байна.

1.2.3. НҮЭМ-ийн байдал бүс нутаг, хүн амын амьжиргааны түвшин, нийгмийн бүлгүүдээс

[1] НҮЭМ-ийн түүвэр судалгаа.ҮСГ. 1998 он
[2] Эхийн эндэгдлийн судалгаа.ЭНЭШТ.2000 он
[3] Эхийн эндэгдлийг бууруулах стратеги.ЭМЯ. 2001 он
[4] ЭМЯ-ны сайдын 2001 оны 39 дүгээр тушаалын 1-р хавсралт.

маарч ялгаатай байна.

Дэд бүтцийн тэгш биш хөгжил нь ıслагдсан нутгийн хүн амд НҮЭМ-ийн ɔдээлэл,зөвлөлгөө,үйлчилгээ хүргэхэд рхшээл учруулсан хэвээр байна. Хотын захын рооллын эмээг бүлгийн хүн ам, түүний дотор төвд ıлжин суурьшигчдын нэлээд хэсэг НҮЭМ-ийн лчилгээг бүрэн авч чадахгүй байна.

Баруун бүс нутагт төрөлт, эхийн болон аг, нярайн эндэгдэл өндөр, жирэмслэхээс мгаалах хэрэгслийн хэрэглээ, жирэмсний эрт налтын болон мэргэжлийн эмчийн тусламж авч йгаа хувь доогуур, төрөлт хоорондын зай богино йна.

Хүн амын 36 хувь нь ядуу, нэн ядуу ьдарч байгаагаас хүүхэд төрүүлсний тэтгэмж ахын тулд амьжиргааны түвшин доогуур болон имаг настай зэрэг өндөр эрсдэлтэй эмэгтэйчүүд ıрэмслэж, төрөх нь нэмэгдэнээр эх, нялхсын дэгдэлд эмээг бүлгийнхэн илүүтэй өртөж байна.

1.2.4.Охидын жирэмслэлт мэгдсээр байна.

Өсвөр үеийнхний төрөлт сүүлийн 10 жилд сен байна. 1998 оны байдлаар 15-19 насны идын 9 орчим хувь нь хүүхэд төрүүлжээ. Өсвөр сандаа хүүхэд төрүүлсэн эхчүүдийн эзлэх хувь дөөд хотынхоос хоёр дахин их байгаа ба өмнөд с нутагт хамгийн өндөр буюу 26 хувь байна.[5]

Эрүүл мэндийн яамны тайлан мэдээгээр ıл тутам БЗХӨ-өөр өвчлөгдийн 48-52 хувь нь хүртэлх насны хүүхэд, залуучууд байна.

Өсвөр үеийнхний нас бие, сэтгэхүйн цлогт тохирсон НҮЭМ-ийн үйлчилгээ үзүүлдэг ɔн тооны байгууллага ажиллаж байгаа нь өсөн мэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй йна.

1.2.5. НҮЭМ-ийн асуудалд эрэгтэйчүүдийн ɔолцоог нэмэгдүүлэх, жендерийн тэгш байдлыг ıнгах нь тулгамдсан асуудал хэвээр байна.

НҮЭМ-ийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь тэдний боловсролын болон НҮЭМ-ийн талаархи ойлголт, мэдлэгийнтүвшнээс шалтгаалж байгаа бөгөөд энэ талын зарим сөрөг хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулахад байгын бэрхшээл тохиолдож байна.

Жендерийн тэгш байдлыг хангах, үр хөндөлт, гэр бүл төлөвлөлт, гэр бүлд үзүүлэх ниймгмийн халамж, хамгаалалын асуудлаар ниймгмийн болон улс төрийн зөвшилд хүрч чадаагүй байгаа нь НҮЭМ-ийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоход зохих саад учруулж,НҮЭМ-ийн хөтөлбөр,төслүүдийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

1.2.6. БЗХӨ нэмэгдсээр байна

Сүүлийн жилүүдэд БЗХӨ эрс нэмэгдэх хандлагатай боллоо. Эрүүл мэндийн дүн буртгэлээс үзэхэд 1998 онд тэмбүү, заг хүйтэн, трихомониаз өвчүүд нийт халдварт өвчний 35.9 хувийг эзэлж байсан бол энэ үзүүлэлт 2000 онд 42.2 хувь болж нэмэгдэжээ. 1997 онд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 9 буртгэгдэж байсан бол 1998 онд 24, 2000 онд 43 болж өссөн байна.

БЗХӨ-ний тархалт нэмэгдэж байгаа нь хүний дархлал хомсдлын вирус /цаашид ХДХВ гэнэ/-ийн халдвар, дархлалын олдмол хомсдол / цаашид ДОХ гэнэ/ өвчин ихсэх нөхцөлийг бүрдүүлж байна. 2001 оны байдлаар ХДХВ-ийн халдвар авсан 3 хүн буртгэгдсэнээс 2 нь ДОХ-оор өвчилж, нас барсан байна.

Хүн амын шаардлагатай хэсэг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ, тандалтад бүрэн хамрагдаагүй байгаа нь халдвар авсан иргэдийг илрүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Сумын эмнэлгийн түвшинд БЗХӨ-ийг найдвартай оношлох, эмчлэх нөхцөл бүрдээгүй байна.

Хөөр: Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

-Монгол Улсын Засгийн газрын үйл

ıҮЭМ-ийн судалгаа.УСГ.1998 он

ажиллагааны хөтөлбөрт эх, нялхсын эндэгдлийг бууруулахаар дэвшүүлсэн зорилтыг хангах таатай орчинг бүрдүүлэхийн тулд;

-1999 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хорин нэгдүгээр тусгай чуулганаар батлагдсан "Хүн ам ба хөгжил" олон улсын Бага хурлын "Үйл ажиллагааны хөтөлбөрийн дараагийн шатны үндсэн арга хэмжээнүүд" баримт бичигт тодорхойлогдож, орон бүрийн Засгийн гаргуудад зөвлөмж болгосон жендерийн мэдрэмжтэй, нөхөн үржихүйн эрхийг дэмжэлсэн бодлого явуулах, шийдвэр гаргагчдын идэвхитэй дэмжлэгийг буй болгох, эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг шинэ үзэл санаагаар одоогийн хөтөлбөрийг баяжуулах шаардлагыг үндэслэн;

-эхийн эндэгдэл,БЗХӨ, үр хөндөлт, охидын жирэмслэлтийн байдалд олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн судалгаануудын дүгнэлт, үр дүнг хөтөлбөрт тусган боловсронгуй болгох хэрэгцээг харгалзан;

-хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдал ба тэдний энэ талаархи мэдлэг, зан үйлийн харилцан хамаарлыг үндэс болгон байгын сургалт, сурталчилгаа, мэдээллийг хүн амын эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн түгээх асуудалд түлхүү анхааран;

-1997-2001 онд хэрэгжүүлсэн өмнөх хөтөлбөрийн туршлага, сургамжид тулгуурлан;

- НҮЭМ-ийн Үндэсний гуравдугаар бага хурлаас сайшаасан үндэсний зөвшлийн үзэл санаат хэрэгжүүлэх зорилгоор НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

3.1. ЗОРИЛГО:

Монгол улсын хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдлыг сайжруулснаар хүн амын тогтвортой өсөлт, эрүүл мэндийг дэмжих нь энэхүү хөтөлбөрийн зорилго болно.

3.2. ЗОРИЛТ:

3.2.1. НҮЭМ-ийн үйлчилгээ, түүний дотор эсэн мэнд амаржихуйн үйлчилгээ хүртээмжтэ чанартай, үйлчлүүлэгчийг дээдэлсэ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, өсвөр үеийнхний эрэ хэрэгцээнд нийцсэн байх;

3.2.2. Гэр бүл, хувь хүмүүсийг хүсээг жирэмслэлт, БЗХӨ, ХДХВ-ийн халдвар, ДОХ-оо урьдчилан сэргийлэх мэдлэг, зан үйлий төлөвшилтэй болгох;

3.2.3. Өсвөр үеийнхнийг НҮЭМ-ий мэдлэгтэй, бэлгийн аюулгүй зан төлөвий зээмшсэн, нөхөн үржихүйн асуудлаа хариуцлагатай зөв шийдвэр гаргах, сонголт хий чадвартай болгох;

3.2.4. НҮЭМ-ийн хөтөлбөрий хэрэгжүүлэгч, оролцогч байгууллагуудын ажлы уялдаа холбоог нягт хангах замаар хөтөлбөрий удирдлага, зохицуулалтын нэгдсэн тогтолцоо бэхжүүлж, үндэсний чадавхийг нэмэгдүүлэх;

3.2.5. Бүх шатны шийдвэр гаргагчид, ул төрийн удирдагчид, бодлого боловсруулагчид хэвлэл мэдээллийн болон төрийн бу байгууллагын удирдах ажилтнуудын дэмжлэгий нэмэгдүүлэх зорилго бүхий хүний нөхөн үржихүйн эрх, жендерийн тэгш байдал, эрэгтэйчүүдий оролцооны талаархи мэдээлэл, ухуулга, сургалт сурталчилгаанд тэднийг өргөнөөр хамруулснаа НҮЭМ-ийн байдал тогтвортой дээшлэх эрх зүй эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх.

3.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:

НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөр 2002-200 онуудад хэрэгжинэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд:

4.1.1. НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөрийн эсэн мэнд амаржихуйн асуудлын хүрээнд эхийн эндэгдлийг бууруулах стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.2. Эх барихын нэн шаардлагатай болон эралтай тусламжийн удирдамж, НҮЭМ-ийн усламжийн жишгийг эмнэлгийн тусламжийн атлал бүрт жигд хэрэгжүүлэх ажлыг зохион айгуулах;

4.1.3. Үйлчлүүлэгчдийг ээдэлсэн,хүртээмжтэй, чанартай НҮЭМ-ийн эвлелгее өгөх, тусламж үзүүлэх мэдлэг чадвар эмшсэн эмч, мэргэжилтнээр хангах бодлогын үрээнд эх барих, эмэгтэйчүүдийн нарийн эргэжлийн тусламжийн мэргэшсэн эмч нарыг элтгэх сургалтын төвийг Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд, НҮЭМ-ийн анхан шатны эвлелгее, тусламж үзүүлэх ерхийн болон сумын мч, багийн багa эмч, эх баригч нарыг сургаж, адлагажуулах чадавхи бүхий сургалтын төвийг ймгийн төвүүдэд тус тус байгуулах;

4.1.4. Эрэгтэйчүүд,хөвгүүд, цэвэршилтийн асны хүмүүст НҮЭМ-ийн үйлчилгээ, зөвлөлгөө, усламж үзүүлдэг эмч, мэргэжилтэнг сургаж элтгэх;

4.1.5. Орон нутгийн захиалгаар эх барих, мэгтэйчүүдийн эмч нарыг бэлтгэх, мэргэшлийг ээшлүүлэх арга хэмжээ авах;

4.1.6. Сум, аймгийн төв, Улаанбаатар хотын арим дүүргүүд, төрөлжсөн амаржих газар, Эх ялхсын эрдэм шинжилгээний төвийн дэргэдэх Эхчүүд амрах байрыг эх, нялхаст ээлтэй, ндэдэлэл, тусламж, үйлчилгээний болон эсэн мэнд амаржихуйн төв байхуйцаар тохижуулж, амаржих газраас алс амьдардаг малчид, нарийн эргэжлийн тусламж авахаар ирсэн эхчүүдийг бүрэн хамруулж үйлчлэх;

4.1.7. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд НҮЭМ, эсэн мэнд амаржихуй, гэр бүл төлөвлелт, БЗХӨ, өсвөр үе, эрэгтэйчүүдийн болон ахмадын асуудлаар эвлелгее авах, шаардлагатай шинжилгээ хийлгэх боломж бүхий бүх насныханд нээлттэй нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлэх;

4.1.8. Эсэн мэнд амаржихуйн эвлелгее, тусламж болон эх, нярайн бүрдмэл тусламж үзүүлдэг эмнэлэг, эвлелгее өгөх газар, кабинетуудыг шаардлагатай багаж, тоног төхөөремж, эмээр тасралтгүй хангах арга хэмжээ авах;

4.1.9. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтний ур чадвар, ажлын ачаалал, ур дүнд тохирсон хөдөлмөрийн үнэлгээ бий болгох асуудлыг холбогдох байгууллагууд судалж шийдвэрлэх;

4.1.10. НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг боловсронгуй болгох, жирэмслэлт, төрөлт, төрсний дараахь үед эх, нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, аймаг, дүүрэг, сумын төсөвт тусгайлан тусгаж, хөрөнгийн найдвартай эх үүсвэрээр хангах арга хэмжээ авах;

4.1.11. Үр хөндөлт, үргүйдлийн шалтгааныг судлан тодруулж, бууруулах арга хэмжээ авах;

4.1.12. Үр хөндөх ажилбарыг холбогдох эвлшеерел бүхий эмнэлэгт, халдваргүй орчинд, орчин үеийн аргаар, мэдээ алдуулалттайгаар хийх, тохиолдол бүрийг мэдээлэх, үр хөнделтийн дараахь эвлелгеегеер заавал хангах асуудлаар тусгай журам гаргаж мөрдүүлэх;

4.1.13. БЗХӨ-ийг лабораторийн аргаар болон хам шинжээр эрт илрүүлэх ажлыг өргежүүлэх, нэр хэлгүй эмчилгээг чөлеетэй болгох арга хэмжээ авах;

4.1.14. Жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн эм, хэрэгслийг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд үндэслэсэн захиалгын дагуу баг, сум, өрхийн эмнэлгээр төлбөргүйгээр хангах, нийтийн зах зээлд өргенеер нийлүүлж түгээх арга хэмжээ авах;

4.1.15. Алслагдсан нутгийн хүн ам, ялангуяа малчид, залуучууд, сургууль завсардсан өсвөр үеийнхэн, шилжиж ирэгсэд, ядуу болон орон гэргүй хүмүүс, хотын захын хороололын оршин суугчад НҮЭМ-ийн мэдээлэл түгээх, эвлелгее өгөх, үйлчилгээ үзүүлэх зэрэг сонирхогч төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх;

4.1.16. Орон нутгийн захиргааны байгууллагаас дэвсгэр нутагтаа байнга болон түр оршин суугч иргэдийн бүртгэл, хөдөлгөөний хөтлөлтийг сайжруулах, эмнэлгийн яаралтай

тусламж саадгүй авах нөхцөл бий болгох зорилгоор гэр хорооллын гудамж, хашаа тодорхой хаягтай болгон жигдрүүлэх арга хэмжээ авах;

4.1.17. Отор нүүдэл хийж яваа болон байгалийн гамшигт нэрвэгдсэн хүн ам, түүний дотор жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, бага насны хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг зохион байгуулах талаар журам гаргаж мөрдүүлэх;

4.1.18. Халамжийн эмнэлгээр үйлчлүүлэгчид болон асрамжийн газар, орон гэрээсээ дайжсан хүүхдүүдийг түр саатуулах цэг, асрах байранд оршин суугчдад үзүүлэх НҮЭМ-ийн төлбөргүй үйлчилгээний тухай журам гаргаж хэрэгжүүлэх.

4.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

4.2.1. Хүн амын НҮЭМ-ийн боловсролын байдал, зан үйлийн төлөвшилтийн байдалд НҮБ-ын Хүн амын сан болон бусад хандивлагчдын туслалцаатайгаар хийсэн судалгаанд үндэслэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

4.2.2. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийг хүн амын дунд НҮЭМ-ийн мэдээлэл,сургалт,сурталчилгаа явуулах чадавхи бүхий тэргүүлэх байгууллага болгон өргөжүүлэн хөгжүүлэх;

4.2.3. НҮЭМ-ийн мэдээлэл, сурталчилгааны санг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийг түшиглэн зохион байгуулах, энэ асуудлаар салбар хоорондын үйл ажиллагаат зохицуулах зөвлөл ажиллуулах;

4.2.4. Хүн амд НҮЭМ-ийн хэрэглээний мэдлэг олгох, зөрөг зан үйл төлөвшүүлэх стратегийн бодлогод нийцүүлэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалын сонголтыг сайжруулах, зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээнд тохируулан үзэмжтэй, хүрэлцээтэй хэвлэж тараах, радио, телевизийн байгныи нэвтрүүлэг,тогтмол сонинтой болох арга хэмжээ авах;

4.2.5. Нийтлэлийн бодлого нь НҮЭМ-ийн асуудалд чиглэсэн хэвлэл мэдээллийн байгууллагуудын сүлжээ бий болгох, НҮЭМ-ийн асуудлаар мэргэшсэн сэтгүүлчдийг бэлтгэх талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

4.3. Гуравдугаар зорилтын хүрээнд:

4.3.1. Өсвөр үеийнхэнд НҮЭМ-ийн боловсрол олгох, бэлгийн хүмүүжил төлөвшүүлэх ажлын сурган хүмүүжүүлэх арга зүйг судлан боловсруулж хэрэгжүүлэх;

4.3.2. Боловсролын байгууллагын удирдах бүрэлдэхүүний болон ерөнхий боловсролын сургуулийн захирлуудын өсвөр үеийнхний НҮЭМ-ийн асуудлаархи мэдлэгийг дээшлүүлэх, тэдний дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

4.3.3. Албан бус сургалтын хөтөлбөрт НҮЭМ-ийн асуудлыг тусгаж хэрэгжүүлэх;

4.3.4. Багш,эмч бэлтгэдэг их,дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт НҮЭМ-ийн асуудлыг тусгаж, сургалтыг зохион байгуулах;

4.3.5. НҮЭМ-ийн үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг ЕБС-иудад зохион байгуулах;

4.3.6. Бүх шатны сургуулиудад эрэгтэй сурилцагсдын тоо нэмэгдүүлэх, тэдний мэдлэг, боловсролын түвшинг ахиулахад чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

4.3.7. Аймгийн төв болон нийслэлийн дүүргүүдэд хөвгүүд, охидод НҮЭМ-ийн зөвлөлгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх цэг байгуулах, итгэлтэй утас ажиллуулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын санаачилгыг өрнүүлэх, төрөөс дэмжлэг үзүүлэх.

4.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.4.1. НҮЭМ-ийн асуудлаар үндэсний түвшинд судалгаа, сургалт, хангамж, үйлчилгээ үзүүлэх тэргүүлэх байгууллагаар Эрүүл мэндийн яамны харьяа Эх, нялхсын эрдэм шинжилгээний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Анагаах ухааны их сургууль, Монголэмимпэкс концернийг сонгон авч, чадавхийг нь дээшлүүлэх;

4.4.2. Тэргүүлэх байгуулагуудад НҮЭМ

ндэсний хөтөлбөрийн арга хэмжээнүүд болон ҮБ-ын Хүн амын сангийн НҮЭМ-ийн дэд өтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийг ариуцуулан гүйцэтгүүлэх, үндэсний мэргэжилтэнг ргаж дадлагажуулах, шаардлагатай техник эрэгслээр хангах арга хэмжээ авах;

4.4.3. НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөр эрэгжүүлэхэд сонирхогч бүх талуудын оролцоог ангах, ялангуяа төрийн бус байгууллагуудын үйл жиллагааг бүх талаар дэмжиж, хөтөлбөрийн эрэгжилтэд тавих хяналт, үнэлгээний бүх үвшинд тэднийг оролцуулах;

4.4.4. Аймаг,сум, дүүргийн хэмжээнд НҮЭМ-ийн чиглэлээр сургалтад хамрагдагсдаас үрдсэн баг байгуулж, тэднийг аймаг, сум, үүргийн НҮЭМ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эмжих, олон нийтийн хяналтыг буй болгох иглэлээр ажиллуулах;

4.4.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн НҮЭМ-ийн дэд хөтөлбөрийг ИТХ-ын чуулганаар аталж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт усгай заалт болгон тусгаж, гүйцэтгэлийг нь тухайн шатны Засаг дарга, түүний Тамгын газар хариуцан, эрэгжилтийг жил тутам зөвлөлийн хурлаар элэлцэж шаардлагатай арга хэмжээ авч байх;

4.4.6. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон бусад хандивлагчдаас НҮЭМ-ийн чиглэлээр ангаж байгаа эм, хэрэгслийн хангалтыг цаашид Монгол Улс өөрөө хариуцахад бэлтгэх арга хэмжээ авах;

4.4.7. Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүү, эдийн засгийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам зэрэг төрийн захиргааны төв байгууллагуудаас НҮЭМ-ийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтэд нь хяналт, үнэлгээ хийх чиглэлээр ажилтнуудыг сургаж бэлтгэх, шаардлагатай техникийн нөхцөл хангах арга хэмжээг НҮБ-ын Хүн амын сан ба бусад хандивлагчдын туслалцаатайгаар авч хэрэгжүүлэх;

4.4.8. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон Олон улсын байгууллага, хандивлагчтай НҮЭМ-ийн үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, түүний явц, үр дүнг хамтрагч талуудад тогтмол мэдээлж, тайлагнаж байх.

4.5. Тавдугаар зорилтын хүрээнд:

4.5.1. Монгол Улсын хүн амын ба хөгжлийн бодлогод НҮЭМ-ийн талаар баримтлах чиглэлийг тодотгон тусгаж, түүний эрх зүй, эдийн засаг, нийгмийн орчинг боловсронгуй болгох, энэ зорилгоор ойрын жилүүдэд эрх зүйн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлаар ухуулга, сурталчилгаа явуулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

4.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүний нөхөн үржихүйн эрхийг дээдлэх, жендерийн тэгш байдлыг хүндэтгэх зарчмыг мөрдлөг болгох,ХДХВ-ийн халдвар авсан болон ДОХ-оор өвчилсөн хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг шинээр гарч ирж буй асуудлаар шаардлагатай эрх зүйн зохицуулалт хийх;

4.5.3. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт болон БЗХӨ-ийг эмчлэхтэй холбогдсон зарим зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас гаргаж байх асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;

4.5.4. Нөхөн үржихүйн эрх, жендер, эрэгтэйчүүдийн оролцооны асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад тусгасан байдлыг судалсан судалгааны дүнг УИХ-ын гишүүд, хуульчдад хүргэх, эдгээр шинэлэг асуудлаар үндэсний хэмжээний хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулах зэргээр НҮЭМ-ийн асуудлаар үндэсний зөвшил буй болгоход дэмжлэг үзүүлэх;

4.5.5. Дунд болон дээд түвшний шийдвэр гаргагчдад НҮЭМ-ийн асуудлаар мэдээлэл өгөх, төрийн бус байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг ухуулга, сурталчилгаа хийх орчин үеийн арга барил эзэмшүүлэх сургалтад хамруулах үйл ажиллагааг өргөжүүлэх;

4.5.6. НҮЭМ-ийн чиглэлээрх судалгааны дүн, тоо баримт, мэдээллийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах зориулалтаар шинэчлэн

боловсруулж, холбогдох хүмүүст хэвлэж түгээх;

4.5.7. Жирэмслэлт, төрөлт, төрсний дараахь эмнэлгийн тусламжийг төр хариуцах хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, энэ зорилгоор эмч нарын эвлөлгөөнөөр аймаг, бүс, улсын шатлалын эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж авах шаардлагатай нь тогтоогдсон жирэмсэн эмэгтэйчүүдийн унаанаы болон эмнэлгийн хоолны зардлыг гэр бүлээс нь гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах.

Тав. НҮБ-ын Хүн амын сан ба бусад хандивлагчидтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. НҮЭМ-ийн анхны Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол хандивлагч байсан үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, НҮБ-ын Хүн амын сан энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тал бүрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллахаа илэрхийлсэн нь хөтөлбөрийн зорилтууд бодитой хэрэгжих үндэсн нөхцөл болж байна. НҮБ-ын Хүн амын сангаас Монголыг дэмжих гуравдахь хөтөлбөрийн хүрээнд 2002-2006 онд НҮЭМ-ийн шинэ үзэл баримтлал, чиглэлүүдийг хэрэгжүүлэх болон үндэсний чадавхийг нэмэгдүүлэх талаар туслалцаа дэмжлэг үзүүлнэ. Энэ арга хэмжээний хүрээнд бүх аймгийн түвшинд ижил үйл ажиллагаа хэрэгжүүлэх бөгөөд сум, багийн түвшинд эхийн эндэгдэл ихтэй Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Баянхонгор аймгуудыг сонгож ажиллана.

5.2. Засгийн газартай зөвшилцөн тохироцсоны дагуу НҮБ-ын Хүн амын сангийн гуравдахь хөтөлбөр нь НҮЭМ-ийн Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхийг төв болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх, ухуулга болон зан үйлийг өөрчлөх сурталчилгааны үндэсний стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах дээд түвшний болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагын удирдлагын нөхөн үржихүйн эрх, жендерийн тэгш байдал, эрэгтэйчүүдийн оролцооны тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж тэдний дэмжлэгийг бий болгох, эсэн мэнд аморжихуйн нэн яаралтай эм бэлдмэл, жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслээр улсын хэмжээнд хангах зорилт өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлнэ.

5.3. НҮБ-ын Хүүхдийн сан "Эрүүл мэнд-хоол тэжээл" хөтөлбөрийн стратегийн дагуу "Эсэн мэнд аморжихуй" теслийн хүрээнд орон нутагт нийгмийн суурь үйлчилгээ, түүний дотор эсэн мэнд аморжихуйн тусламж, үйлчилгээг чанаржуулж, энэ үйлст хамт олны оролцоог нэмэгдүүлснээр "Эхэд эөлтэй орчин бүрдүүлэх" чиглэлээр Хэнтий, Дорнод, Дорноговь, Увс, Өмнөговь аймаг, Нийслэлийн Багануур, Баянгол дүүргүүдэд цаашид хамтран ажиллана.

5.4.Монгол Улсын Эрүүл мэндийн яам, ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн НҮЭМ-ийн салбарт дэмжлэг үзүүлэх төсөл НҮЭМ-ийн үйлчилгээг сайжруулах талаар Сэлэнгэ, Өмнөговь, Төв аймаг, Нийслэлийн Налайх дүүргэгт өнгөрсөн хугацаанд явуулсан тодорхой үйл ажиллагаагаа үргэжлүүлэхээс гадна Сүхбаатар, Завхан аймаг, клиникийн Iамаржих газрыг теслийн үйл ажиллагаанд шинээр хамруулна.

5.5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх "НҮЭМ" төслөөр эсэн мэнд аморжихуйн тусламжийн чадавхийг бэхжүүлэх талаар техникийн туслалцаа авна.

5.6. Олон улсын түншлэлийн байгуулагын шугамаар "Тед Теннерийн сан"-гаас санхүүжүүлж байгаа өсвөр үеийнхний НҮЭМ-ийг сайжруулах теслийг Архангай, Хөвсгөл аймаг, Нийслэлийн зарим дүүргэт хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

6.1. Удирдлага, зохион байгуулалт

6.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, түншлэлийг хөгжүүлэх, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг Засгийн газарт тайлагнах, шаардлагатай асуудлаар холбогдох газарт санал оруулах үүрэг бүхий НҮЭМ-ийн Үндэсний дэд хороо Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн бүтцэд байгуулагдаж ажиллана.

Уг дэд хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл

атална. Аймаг, нийслэлд НҮЭМ-ийн салбар ороодыг байгуулан ажиллуулна.

6.1.2. Хөтөлберийн хэрэгжилтийг мэргэжлийн дирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг рүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн ахиргааны төв байгууллага хүлээнэ.

6.2. Санхүүжилт.

6.2.1.Хөтөлберийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн дотоод эх үүсвэрийг "Эрүүл эндийн тухай", "Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай" хуулиудад заасны дагуу жил бүрийн улсын төвлөрсөн ба орон нутгийн төсөв, даатгалын сангаас санхүүжүүлнэ.

Нэмэлт хөрөнгийн эх үүсвэр олох ажлыг Үндэсний дэд болон орон нутгийн салбар хороод санаачилж хэрэгжүүлнэ.

6.2.2. НҮБ-ын Хүн амын сан ба олон улсын байгууллага, хандивлагдаас НҮЭМ-ийн Үндэсний хөтөлберийн хэрэгжилтийг дэмжин оруулах хөрөнгө нэмэлт эх үүсвэр болно.

Долоо. Хөтөлберийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ.

7.1. Хөтөлберийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, НҮЭМ-ийн Үндэсний дэд хороо, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НҮЭМ-ийн салбар хороод гүйцэтгэнэ.

7.2. НҮЭМ-ийн улсын хэмжээний түүвэр судалгааг 2003 онд хийж, хөтөлберийн дунд хугацааны тайланг 2004 онд гаргах ба шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3. Хөтөлберийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлэж дүгнэнэ.

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

№	Үзүүлэлт	2000 оны түвшин	2006 оны түвшин	Үзүүлэлтийн үнэлгээ
зорилт-1				
1	100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	158	110	Эрүүл мэндийн статистик
2	Жирэмсний эрт үеийн хяналт /хувь/	56,4	70,0	Эрүүл мэндийн статистик
3	Жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш удаа үзүүлсэн жирэмсэн эмэгтэйчүүд /хувь/	-	75,0	Эрүүл мэндийн статистик
4	Эхийн амрах байранд амарсан жирэмсэн эмэгтэйчүүд /хувь/	49,0	65,0	Эрүүл мэндийн статистик
5	Жирэмсний цус багадалт /хувь/	40,0	25,0	Эрүүл мэндийн статистик
6	Төрсний дараахь 42 хоногийн дотор идэвхитэй үзлэгт хамрагдагсад /хувь/	-	60,0	Эрүүл мэндийн статистик
7	10000 жирэмсэн эмэгтэйд ногдох тэмбүүгийн өвчлөл	61	45-аас доош	Эрүүл мэндийн статистик
8	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл	31.2	27.0	Эрүүл мэндийн статистик
Зорилт-2				
9	Жирэмслэхээс хамгаалах орчин үеийн аргын хэрэглээ /хувь/	33,4	45	түүвэр судалгаа
10	Хугацаат цэргийн албан хаагчдаас НҮЭМ-ийн сургалтад хамрагдагсад /хувь/	-	70-аас доошгүй	түүвэр судалгаа
11	1000 амьд төрөлтөд ногдох эрт үеийн үр хөндөлт	230	200 түү-нээс доош	Эрүүл мэндийн статистик

Зорилт-3				
12	15-19 насны охидын төрөлт /хүнь/	9,0	8,0	Эрүүл мэндийн статистик
13	Ерөнхий боловсролын сургуу-лиудад "НҮЭМ/бэлгийн боловс-рол" сэдвээр хичээл заах бэлтгэгдсэн багш /хүнь/	-	80,0	БСШУЯ-ны статистик
Зорилт-4				
14	НҮЭМ-ийн тэргүүлэх үйл ажиллагаа явуулах чадавхи бүрдсэн байгууллагуудын тоо	-	6	Тайлан
Зорилт-5				
15	НҮЭМ-ийн зөвлөлгөө, тусламж үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн өсөлт	Тусад нь тесөвлө-деггүй байсан	Тусад нь тооцох ба өсөлт гарна	төсвийн тайлан

Найм. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөрийн хүлээгдэж байгаа үр дүн

Хөтөлбөр хэрэгжэнээр дараахь үр дүн гарна гэж тооцож байна:

8.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд:

8.1.1. Баг, сум, аймаг, үндэсний түвшинд эсэн мэнд амаржихуйн бүрдмэл үйлчилгээ зохих стандартын дагуу явагдаж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжаар баталгаажсан байна.

8.1.2. Бэлгийн замын халдварт болон бэлгийн замын үрэвсэлт өвчний илрүүлэлт, эмчилгээ, гэр бүл төлөвлөлт, үр хөндөлтийн үйлчилгээ, үргүйдлийн эмчилгээнд орчин үеийн аргыг өргөнөөр нэвтрүүлж, үйлчлүүлэгчийн нэр төр, нууцыг чанд хадгалсан, нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн цогц үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.

8.1.3. Алслагдсан нутгийн хүн ам, сургууль завсардсан охид, хөвгүүд, хот, аймгийн төвийн захын хороолл ын оршин суугчид, ядуу болон орон гэргүй хүмүүс зэрэг нийгмийн бүлгүүдэд НҮЭМ-ийн мэдээлэл, зөвлөлгөө, хангамж, тусламж, үйлчилгээ хүргэх арга хэрэгсэл шийдвэрлэгдсэн байна.

8.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

8.2.1. Хүн амын зорилтот бүлгүүдэд зориулсан НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны стратеги боловсрогдон хэрэгжсэн байна.

8.2.2. Хүн амын зорилтот бүлгүүдийн онцлогт тохирсон НҮЭМ-ийн талаархи зөвлөлгөө, мэдээлэл, сургалт, сурталчилгаа тогтмолжиж, бүх сувгаар хүртээмжтэй явагддаг болсон байна.

8.3.Гуравдугаар зорилтын хүрээнд:

8.3.1. Өсвөр үеийнхэнд НҮЭМ-ийн мэдлэг олгох албан ба албан бус сургалтын тогтолцоо бүрдэж, сургалтын арга зүй боловсрогдон, багш,сургалтын материалаар хангагдсан байна.

8.3.2. НҮЭМ-ийн мэргэжлийн түвшинд тусламж, үйлчилгээ үзүүлдэг хөвгүүд, охидын кабинетүүд аймаг, хотуудад ажилладаг болсон байна.

8.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

8.4.1. НҮЭМ-ийн үйлчилгээ, хангамж, судалгааны ажлыг эрхлэн гүйцэтгэх тэргүүлэх байгууллагууд бэхжиж, чадавхи нь дээшилсэн байна.

8.4.2.НҮЭМ-ийн асуудлыг хариуцдаг төрийн захиргааны төв байгууллагуудын энэ асуудлыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан үнэлэх чадавхи бүрдсэн байна.

8.5. Тавдугаар зорилтын хүрээнд:

8.5.1. НҮЭМ-ийн ухуулга, сурталчилгааны стратеги боловсрогдон хэрэгжсэн байна.

8.5.2. НҮЭМ-ийг дэмжсэн эрх зүйн орчин бүрэлдэж боловсронгуй болсон байна.

НҮЭМ-ИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран оролцох байгууллага
I үр дүн: Баг, сум, аймаг, үндэсний түвшинд эсэн мэнд амаржихуйн бүрдмэл үйлчилгээ зохих стандартын дагуу явагдаж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжаар баталгаажсан байна.			
1.1 Эхийн эндэгдлийг бууруулах стратегийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах	2002-2004	ЭМЯ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар /цаашид ЭМГ гэнэ/, Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэг
1.2 НҮЭМ-ийн анхан шатны зөвлөлгөө, тусламж үзүүлэгч ерх, сумын эмч, багийн бага эмч, эх баригч нарыг сургаж дадлагажуулах сургалтын төвийг аймгийн төвүүдэд байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2002-2005	ЭМЯ, аймгийн Засаг даргын Тамгын газар	ЭНЭШТ, аймгийн ЭМГ, НҮБ-ын Хүн амын сан /цаашид ХАС гэнэ/, Монгол-Германы НҮЭМ-ийн хамтарсан төсөл
1.3 НҮЭМ/Эсэн мэнд амаржихуйн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэгч нарыг сургаж дадлагажуулах төв болон хөдөө орон нутагт мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх багийг ЭНЭШТ-д шинээр байгуулж чадавхийг бүрдүүлэн ажиллуулах	2002	ЭМЯ	НҮБ –ын ХАС , ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, ЭНЭШТ, АУИС
1.4. Бүх аймаг, нийслэлийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч нар болон бага эмч нарыг давтан сургалтад хамруулах	2002-2004	ЭМЯ	АУИС, ЭНЭШТ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Герман-Монголын НҮЭМ-ийн хамтарсан төсөл
1.5.Эсэн мэнд амаржихуйн зөвлөлгөө тусламж болон эх нярайн бүрдмэл тусламж үзүүлдэг эмнэлэг, зөвлөлгөө өгөх газар, кабинетуудыг шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эмзэр тасралтгүй хангах арга хэмжээ авах	жил бүр	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Монголэмимпекс концерн, НҮБ-ын ХАС, Герман-Монголын НҮЭМ-ийн хамтарсан төсөл

1.6. Эрэгтэйчүүд, хөвгүүд, цэвэршилтийн насны хүмүүст нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөлгөөг, тусламж үзүүлдэг эмч мэргэжилтэнг сургаж бэлтгэх	2003 оны эцэст	ЭМЯ	АУИС, ЭНЭШТ, ДЭМБ, НҮБ ын ХАС
1.7. Жирэмслэлт, төрөлт, төрсний дараахь үед эх, нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний шаардагдах хөрөнгийг иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу нийслэл, аймаг, сумын төсөвт жил бүр нэр заан тусгаж байх, санхүүжилтийг цаг тухайд нь олгох арга хэмжээ авах	2002-2006 онд	СӨЗЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн ИТХТ-ийн дарга	Аймаг, нийслэл, сумын Засаг дарга
1.8. "Эхчүүд амрах байр"-ыг мэдээлэл, зөвлөлгөө, тусламж, үйлчилгээний төв болгон тохижуулж, амаржих газраас алс амьдардаг малчид болон нарийн мэргэжлийн тусламж авахаар ирсэн эхчүүдийг бүрэн хамарч үйлчлэх	2002-2006 онд	ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар.	Аймаг, нийслэлийн ЭМГ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн Сан, Герман-Монголын НҮЭМ-ийн хамтарсан төсөл
1.9. Архаг цус багадах өвчтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг төмрийн бэлдмэл, фолийн хүчлээр эмчлэх арга хэмжээг орон даяар хэрэгжүүлэх	жил бүр	ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан
1.10. Монголын хөдөө орон нутгийн онцлогийг харгалзан Анагаах ухааны коллежүүдэд эх баригч, бага эмчийг орон нутгийн захиалгаар бэлтгэх ажлыг сэргээх арга хэмжээ авах	2002-2006	ЭМЯ, БСШУЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ
II үр дүн. Бэлгийн замын халдварт болон бэлгийн замын үрэвсэлт өвчний илрүүлэлт, эмчилгээ, гэр бүл төлөвлөлт, үр хөндөлтийн үйлчилгээ, үргүйдлийн эмчилгээнд орчин үеийн аргыг нэвтрүүлж, үйлчлүүлэгчийн нэр төр, нууцыг чанд хадгалсан, нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн цогц үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.			
2.1. Үргүйдлийг эмчлэх эмчилгээний зарим шинэ аргыг практикт нэвтрүүлэх	2002-2006	ЭМЯ	ЭНЭШТ, ДЭМБ, НҮБ-ын ХАС
2.2. БЗХӨ-ийг хам шинжээр болон лабораторийн аргаар эрт илрүүлэн нэр хаяггүй эмчлэх аргыг нэвтрүүлэх	2002 оноос	ЭМЯ	Халдварт өвчин судлалын үндэсний төв / цаашид ХӨСҮТ гэнэ/, нийслэл, аймгийн ЭМГ, ДЭМБ, Герман-Монголын хамтарсан НҮЭМ-ийн төсөл

2.3. Эх барихын болон жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн эм хэрэгслийг баг, сум, аймаг, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд үнэ төлбөргүйгээр болон нийтийн зах зээлээр хангах арга хэмжээ авах	2002-2006	ЭМЯ	Монголэмимпэкс концерн, нийслэл, аймгийн ЭМГ, НҮБ-ын ХАС, Герман-Монголын хамтарсан НҮЭМ-ийн төсөл
2.4. Хугацаат цэргийн албан хаагчдын албан сургалтад НҮЭМ-ийн хичээл оруулах	2002 оноос	ЭМЯ, БХЯ, ХЗДХЯ	ХЦУГ, НҮБ-ын ХАС, Герман-Монголын хамтарсан НҮЭМ-ийн төсөл
III үр дүн: Алслагдсан нутгийн хүн ам, сургууль завсардсан охид, хөвгүүд, хот, аймгийн төвийн захын хорооллын оршин суугчид, ядуу болон орон гэргүй хүмүүс зэрэг нийгмийн бүлгүүдэд НҮЭМ- ийн мэдээлэл, зөвлөлгөө, хангамж, тусламж, үйлчилгээг хүргэдэг арга механизм шийдвэрлэгдсэн байна.			
3.1. Хүн амын эмзэг бүлгүүдийн дунд НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт,сурталчилгааны болон тусламж үйлчилгээний чиглэлээр ажиллахыг сонирхогч төрийн бус байгууллагуудыг сонгон шалгаруулалтаар шалгаруулж хамтран ажиллах	2002-2006	ЭМЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, төрийн бус байгууллага /цаашид ТББ гэнэ/
3.2.Отор нүүдэл хийж яваа болон байгалийн гамшигт нэрвэгдсэн хүн ам, түүний дотор жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, бага насны хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг зохион байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх	2002 оноос	ЭМЯ, ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Аймаг, нийслэлийн ЭМГ, сумын ЗДТГ
3.3. Халамжийн эмнэлэг, асрамжийн газар, орон гэрээс дайжсан хүүхдүүдийг түр саатуулах цэг, асрах байрууд зэрэг газруудад НҮЭМ-ийн төлбөргүй үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх	2002 оноос	ЭМЯ, НХХЯ, Хүүхдийн төлөө үндэсний хороо	ЦЕГ , аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ
IV үр дүн: Хүн амын зорилтот бүлгүүдэд зориулсан НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт,сурталчилгааны стратеги боловсрогдон хэрэгжсэн байна.			
4.1 Хүн амын НҮЭМ-ийн боловсролыг дээшлүүлэх, зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр явуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны стратеги боловсруулж хэрэгжүүлэх	2002 оноос	ЭМЯ	ЭМХҮТ, РТХЭГ,аймаг,нийслэлийн ЗДТГ, ЭМГ

4.2 Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийг хүн амын дунд НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, чадавхийг нь бэхжүүлэх арга хэмжээ авах	2002-2004	ЭМЯ	НҮБ-ын ХАС
4.3. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд НҮЭМ-ийн мэдээлэл, сурталчилгааны сан байгуулах	2002 оноос	ЭМЯ	ЭМХҮТ,НҮБ-ын ХАС
Үр дүн: Хүн амын зорилтот бүлгүүдийн онцлогт тохирсон НҮЭМ-ийн талаархи зөвлөлгөө, мэдээлэл, сургалт, сурталчилгаа орон даяар тогтмолжиж, бүх сувгаар хүртээмжтэй явагдаг болсон байна.			
5.1.НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны бодлого, салбар хоорондын үйл ажиллагаа зохицуулах зөвлөлийг ЭМХҮТ-ийн дэргэд байгуулж ажиллуулах	2002	ЭМЯ,БСШУЯ,НХХЯ	ЭМХҮТ, НҮБ-ын ХАС
5.2.НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалын сонголтыг сайжруулж хүртэмжтэй хэвлэж тараах	2002-2004	ЭМХҮТ	НҮБ-ын ХАС
5.3. Телевиз, радиогийн байнгын нэвтрүүлэг явуулах, "Уерхэл", "НҮЭМ" тогтмол сонин гаргах зэргээр хүн амыг хэрэгцээт мэдээллээр хангах арга хэмжээ авах	Жил бүр	ЭМХҮТ	НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, Герман-Монголын хамтарсан НҮЭМ-ийн төсөл
5.4.НҮЭМ-ийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдийг бэлтгэх	2003 оноос	ЭМХҮТ	Монголын хэвлэлийн хүрээлэн, НҮБ-ын ХАС, ТББ
YI үр дүн: Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох албан ба албан бус сургалтын тогтолцоо бүрдэж, заах арга зүй нь боловсрогдон, бэлтгэгдсэн багш, сургалтын материалаар хангагдсан байна.			
6.1. Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, бэлгийн хүмүүжил төлөвшүүлэх ажлын сурган хүмүүжүүлэх арга зүйг судлан нэвтрүүлэх	2004	БСШУЯ, ЭМЯ	НҮБ-ын ХАС, ЭМХҮТ, Боловсролын хүрээлэн
6.2. Ерөнхий боловсролын сургуулиудад эрүүл мэндийн болон НҮЭМ-ийн хичээлийг заах багш нарыг бэлтгэж, сургалтын материалаар хангах арга хэмжээ авах	2004	БСШУЯ, ЭМЯ	Аймаг,нийслэлийн боловсролын төв, НҮБ-ын ХАС, Герман-Монголын хамтарсан НҮЭМ-ийн төсөл
6.3. Албан бус сургалтын хөтөлберт НҮЭМ-ийн асуудлыг тусгаж хэрэгжүүлэх	2002-2006	БСШУЯ, ЭМЯ	Аймаг, нийслэлийн боловсролын төв, ЭМГ, НҮБ-ын ХАС, ТББ
6.4. Багш, эмч бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлберт НҮЭМ-ийн хичээл оруулж, заах арга хэмжээ авах	2003 оноос	БСШУЯ, ЭМЯ	НҮБ -ын ХАС, Их, дээд сургууль, коллежийн захиргаа

ҮП үр дүн: Мэргэжлийн түвшинд НҮЭМ-ийн үйлчилгээ үзүүлдэг хөвгүүд, охидын кабинетүүд аймагт болон нийслэлийн дүүргүүдэд ажилладаг болсон байна.			
7.1. Аймгийн төв, нийслэлийн дүүргүүдэд хөвгүүд, охидод НҮЭМ-ийн зөвлөлгөө өгч, үйлчилгээ үзүүлдэг нэгж байгуулж, мэргэжлийн эмчээр хангаж ажиллуулах	2004	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ДЭМБ, НҮБ -ын ХАС,
7.2. Ерөнхий боловсролын сургуулиудад НҮЭМ-ийн мэдээлэл тараах, сургалт явуулах кабинетүүдийг байгуулж, үе тэнгийн сургагч бэлтгэн ажиллуулах, сургалт, сурталчилгааны материалаар хангах арга хэмжээ авах	2004	БСШУЯ, ЭМЯ	Аймаг, нийслэлийн боловсролын төв, ЭМГ, НҮБ-ын ХАС
7.3. Хөвгүүд, охидод зөвлөлгөө өгөх итгэлтэй утсыг бүх аймаг, дүүрэгт ажиллуулах	2002 оноос	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Аймаг,нийслэлийн боловсролын төв,ЭМГ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, ЭМХҮТ
ҮШ үр дүн: Орон нутагт НҮЭМ-ийн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж, НҮЭМ-ийн үйлчилгээ, хангамж, судалгааны ажлыг эрхлэх тэргүүлэх байгууллагууд бэхжиж, чадавхи нь бүрдсэн байна.			
8.1. НҮЭМ-ийн асуудлаар тэргүүлэх байгууллагыг сонгон авч, сургагч багш нарыг бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах	2002-2004	ЭМЯ	НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Монгол-Германы хамтарсан НҮЭМ-ийн төсөл
8.2. НҮЭМ-ийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг бүх талаар дэмжих, тэдгээрийн сүлжээ байгуулах	2002-2006	ЭМЯ	НҮБ-ын ХАС, Тэргүүлэх болон ТББ
8.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн НҮЭМ-ийн дэд хөтөлбөрийг ИТХ-ын чуулганаар баталж, шаардагдах хөрөнгийг жил бүр төлөвлөж, хэрэгжилтийг салбар хорооны хурлаар хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээ авч байх	Жил бүр	Аймаг, нийслэлийн ИТХТ, Засаг дарга	СЭЗЯ,ЭМЯ
8.4. НҮЭМ-ийн мэргэшсэн судлаачдыг бэлтгэх	2003	ЭМЯ, БСШУЯ	НЭМХ, АУИС, ЭНЭШТ, НҮБ-ын ХАС, ДЭМБ, Монгол-Германы хамтарсан НҮЭМ-ийн төсөл
IX үр дүн: НҮЭМ-ийн асуудлыг хариуцдаг төрийн захиргааны төв байгууллагуудын энэ асуудлыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан үнэлэх чадавхи бүрдсэн байна.			
9.1.Үндэсний болон аймаг, нийслэлийн НҮЭМ-ийн дэд хороог байгуулж бүтэц, үйл ажиллагааг нь тодорхойлж ажиллуулах	2002 оноос	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл	ЭМЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ

9.2. ЭМЯ, БСШУЯ, СЭЗЯ, НХХЯ, ХЗДХЯ, ГХЯ зэрэг төрийн захиргааны төв байгууллагуудын удирдах ажилтнуудыг НҮЭМ-ийн чиглэлээр гадаад, дотоодын сургалт, танилцах аялал, хуралд оролцуулах	2002 оноос	ЭМЯ	НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Монгол-Германы хамтарсан НҮЭМ-ийн төсөл
X үр дүн: НҮЭМ-ийн ухуулга сурталчилгааны стратеги боловсргодон хэрэгжсэн байна.			
10.1. НҮЭМ-ийн талаар баримтлах бодлогыг тодотгон боловсруулж, холбогдох хууль тогтоомжид тусгах асуудлаар ухуулга (адвокси) , сурталчилгаа явуулах стратеги гаргаж хэрэгжүүлэх	2003	ЭМЯ	ХЗДХЯ,СЭЗЯ, НҮЭМ-ийн үндэсний дэд хороо, ЭМХҮТ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хүүхдийн сан
10.2. Дүнд болон дээд түвшний шийдвэр гаргагчдад зориулан судалгааны дүн, тоо мэдээ, баримтыг боловсруулж, хэвлэж түгээх, тэднийг НҮЭМ-ийн сургалтад хамруулах	2002 оноос	ЭМЯ	ЭМХҮТ, НҮБ-ын ХАС, НҮЭМ-ийн Үндэсний дэд хороо
XI үр дүн: НҮЭМ-ийг дэмжсэн эрх зүйн орчин бүрэлдэж боловсронгуй болсон байна.			
11.1. Эмч нарын зөвлөлгөөнөөр дээд шатлалын эмнэлэгт нарийн мэргэжлийн тусламж авах шаардлагатай нь тогтоогдсон жирэмсэн эмэгтэйчүүдийн замын болон сум, аймгийн төв, ЭНЭШТ-ийн эхчүүд амрах байранд байрлах үеийн хоолны зардлыг хувь хүн, гэр бүлээс нь гаргуулдаг байдлыг өөрчилж, холбогдох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2003 оноос	СЭЗЯ, ЭМЯ	ЭНЭШТ, аймаг, сумын засаг даргын Тамгын газар
11.2. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад нөхөн үржихүйн эрх, жендер, эрэгтэйчүүдийн оролцооны асуудал хэрхэн тусгагдсан талаар судалгаа явуулж, дүнг УИХ-ын гишүүд, хуульчдад хүргэх, эдгээр асуудлаар үндэсний хэмжээний хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах	2002 оноос	ЭМЯ	ЭМХҮТ, НҮБ-ын ХАС,НҮЭМ-ийн үндэсний дэд хороо
11.3. НҮЭМ-ийн шаардлагатай асуудлаар эрх зүйн зохицуулалт хийж, НҮЭМ-д таатай эрх зүйн орчин бүрдүүлэх арга хэмжээ авах	2003 оноос	ХЗДХЯ	ЭМЯ, НХХЯ
11.4. НҮЭМ, нөхөн үржихүйн эрх, жендер, эрэгтэйчүүдийн оролцоог идэвхижүүлэх асуудлаар УИХ, Засгийн газрын гишүүд, аймаг,нийслэлийн Засаг дарга нар, эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн удирдах ажилтнуудад зориулсан сургалт явуулж, 50-иас доошгүй хувийг хамруулах	2002-2006	ЭМЯ	ЭМХҮТ, НЭМХ, ЭНЭШТ, НҮБ-ын ХАС,

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

001 оны 12 дугаар
арын 5–ны өдөр

Дугаар 448

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛИУДЫН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

"Нийгмийн халамжийн тухай", "Ахмад астан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний ухай" Монгол Улсын хуулиудын зарим зүйл, хэсэг, аалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах орилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар үйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь эсгийн 6 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.6 дахь заалтын хүнд нөхцөлд байгаа хүүхэд ..." гэдгийг "Бүтэн энчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ" гэсэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай адилтган ойлгож хэрэгжүүлнэ.

2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1-ийн "бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, тахир дутуу бөгөөд дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоогүй нь тогтоогдсон, ..." гэсэн заалтын "дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоогүй" гэдгийг тэжээн тэтгэх үүрэг бүхий үр хүүхэд, төрөл садан нь өөрөө нян ядуу амьдралтай болон олон хүүхэдтэй өрх толгойлсон ядуу, эсхүл хорих ял биечлэн эдэлж байгаа, мөн хугацаат цэргийн алба хааж байгаа зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгааны улмаас эцэг эх, гэр бүл, үр хүүхэд,төрөл саднаа тэжээн тэтгэх үүргээ биечлэн гүйцэтгэх боломжгүй байдлыг ойлгоно.

"Дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоогүй" гэх байдал нь засаг захиргаа,хорих зэрэг эрх бүхий байгууллагын шийдвэр /тодорхойлолт, албан бичиг/ -ээр тогтоогдсон байвал зохино.

3. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.8-ын"нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон,4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 насанд хүрсэн эх/50 насанд хүрсэн эцэг/" гэсэн заалтын"4 ба түүнээс дээш хүүхэд" гэдэгт хуулийн энэ хэсэгт зааснаар халамжийн тэтгэвэр авах эрхтэй /байж болохуйц/ этгээдийн өөрийнх нь асрамж дахь зөвхөн 16хүртэлх / суралцаж байгаа бол19 хүртэл/ насны 4 ба түүнээс дээш хүүхэд хамаарна. Харин уг этгээдийн насанд хүрсэн эсхүл хууль ёсоор бусдад үрчлүүлсэн хүүхдийг нь 4 ба түүнээс дээш хүүхдийн тоонд оруулан тооцохгүй гэж ойлговол зохино.

4. Нийгмийн халамжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.1 дэх заалтын "дөрвөн хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлж байгаа эх /эцэг/-д олгох нэг удаагийн тэтгэмж"-д мөн зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу тэтгэмж авч байсан этгээдийн төрүүлж, өсгөн хүмүүжүүлж байгаа 16 хүртэл насны 5 ба түүнээс дээш хүүхдийн зарим нь 16 нас хүрч хасагдан уг этгээд 4 хүүхэдтэй болсон тохиолдол хамаарна. Харин уг этгээд 4 хүүхэдтэй байхдаа нэг удаагийн тэтгэмжийг өмнө нь авсан бол энэ заалт хамаарахгүй гэж ойлгож хэрэгжүүлнэ.

5. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.5 дахь заалтын "... хүссэн хугацаандаа" гэснийг энэ хуульд заасан хүүхэд асарсны тэтгэмж авах эрх бүхий этгээд тэтгэмж тогтоолгох өргөдөл, энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан баримт бичгийг жирэмсний болон амаржсаны амралтаа эдэлж дууссан үеэс төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 1 нас /ихэр бол 3 нас/ хүртэл асрах хугацааны дотор буюу уг хугацааны аль ч үед халамжийн байгууллагад гаргана гэж ойлгоно.

6. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан "хөнгөлөлт" нь нэг гэр бүлд хамтран амьдарч байгаа /1951 оноос өмнө гэр бүл болсон эсхүл хууль ёсны баталгаатай/ хоёулаа ахмад настан гавьяат цолтон эхнэр нөхрийн хэн алинд нь хамаарна гэж ойлгоно.

7. Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 5-д заасан "бусад ахмад настан, эхнэр нөхөр"-т энэ тогтоолын 6 дахь заалтыг нэгэн адил хамааруулж хэрэглэвэл зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч. ГАНБАТ
ШҮҮГЧ П. ЦЭЦГЭЭ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487